

МОНГОЛ УЛСЫН ИХ СУГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

ПОЛИТОЛОГИ

№ XI

МУИС ПРЕСС ХЭВЛЭЛИЙН ГАЗАР

АГУУЛГА

Өмнөх үг.....	8
---------------	---

УЛС ТӨРИЙН ОНОЛ, ҮЗЭЛ СУРТАЛ

Макс Веберийн “Улс төр бол хувь зохиол ба мэргэжил мөн” зохиолын улс төрийн үзэл санаа.....	9
<i>Ж.Жаргал</i>	
Монгол дахь социал демократ үзэл суртлын өнөөгийн байдал, цаашдын хандлага.....	22
<i>Ц.Ганболд, Ц.Батболд</i>	
Улс төрийн маркетингийн тухай онолын хураангуй.....	35
<i>С.Базарпүрэв, Б.Нандин-Эрдэнэ</i>	
Монголчуудын улс төрийн философи: Уламжлалт үзэл санаа.....	42
<i>Д.Болд-Эрдэнэ</i>	
Феминизм ба эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэл.....	51
<i>Ё.Довчин, Б.Одгэрэл</i>	
Монгол төрийн түшмэл.....	57
<i>Ц.Ганболд</i>	

АРДЧИЛЛЫН ОНОЛ, ПРАКТИК

Орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны чухал асуудал: Ардчиллын чанар.....	60
<i>Б.Эрдэнэдалай</i>	
Хөгжилд хүрсэн туршлага ба Монголын ардчилал.....	75
<i>Ч.Өлзийсайхан, Д.Ундрах</i>	
Орчин үеийн улс төрийн намын хөгжлийн хандлага: Партизаны улс төрөөс альтернатив коммуникаци тийш.....	84
<i>Ж.Төртогтох</i>	
Улс төрийн намуудын нийгэм – улс төрийн харилцаан дахь үүрэг, түүний эрх зүйн үндэс.....	90
<i>С.Зульфикар</i>	
Монгол дахь парламентын сонгуулийн үйл явц, тулгамдсан асуудлууд.....	99
<i>Д.Оюунчимэг</i>	
Монголын сонгогчдын улс төрийн үйл байдал ба намууд.....	111
<i>С.Мөнхбат</i>	
Иргэдийн улс төрийн оролцоо: Монгол дахь иргэний хөдөлгөөний улс төрийн чиг хандлага.....	123
<i>Ц.Батболд, Б.Батбаатар</i>	

Иргэд төрийн үйлд оролцох асуудалд.....	137
<i>С.Базарпүрэв, Б.Энхболд</i>	
Улс төрийн орчин дахь имижийн нөлөөлөл.....	143
<i>С.Базарпүрэв, У.Батцэрэн</i>	
Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн судалгааны тайлан.....	148
<i>Ц.Ганболд</i>	

ДЭЛХИЙН УЛС ТӨРИЙН БОДЛОГО

Геополитикийн онол ба Монгол улсын өнөөгийн байдлыг задлан шинжлэх нь.....	172
<i>Н.Галиймаа</i>	
Дэлхийн улсуудын хөгжлийн бодлого, төлөвлөлт ба Монгол улс.....	178
<i>С.Мөнхбат, Г.Цэнд-Аюуш</i>	
Эрчим хүчний бодлогын талаарх олон улсын харилцааны онол, үзэл хандлага.....	
<i>Ж.Төртогтох, С.Мягмарсүрэн</i>	
Япон улсын засгийн газраас явуулж байгаа Монголд чиглэсэн гадаад бодлого.....	199
<i>Икеда Сого</i>	
Energy security and role of hegemon.....	203
<i>Пак Жон Хү, Ж.Төртогтох</i>	
Тайваний улс төр, эдийн засгийн хөгжил.....	209
<i>Э.Саранцэцэг</i>	
Ази – Номхон далайн орнуудын хамтын ажиллагааны байгууллагын хөгжил, төлөв /АПЕК/.....	215
<i>Р.Давааням</i>	

ХАРЬЦУУЛСАН УЛС ТӨР

Women's participation in political decision-making: A comparative analyse (Mongolian and Korean cases).....	223
<i>Б.Одгэрэл</i>	
Япон улсын улс төрийн үйл ажиллагааны санхүүжилтийн эрх зүйн орчны тойм судалгаа.....	229
<i>Д.Бумдарь</i>	
Япон улсын улс төрийн өнөөгийн байдал, зарим тулгамдсан асуудал (Парламентын 2013 оны сонгууль, түүний үр дүн).....	238
<i>Миюра Нобуюки, Орчуулсан Д.Бумдарь</i>	
Оросын Холбоот улсын улс төрийн систем.....	242
<i>Ё.Довчин</i>	

CONTENT

Foreword.....	8
---------------	---

POLITICAL THEORIES AND IDEOLOGIES

Political Idea of “Politics as a Vocation” (Politik als Beruf) by Max Weber.....	9
<i>Jargal J.</i>	
Social-democratism in Mongolia: Today and Tomorrow.....	22
<i>Ganbold Ts., Batbold Ts.</i>	
A Theoretical Review of Political Marketing.....	35
<i>Bazarpurev S., Nandin-Erdene B.</i>	
Political Philosophy of the Mongols: Traditional Ideas.....	42
<i>Bold-Erdene D.</i>	
Feminism and the Struggle for Women’s Rights.....	51
<i>Dovchin Yo., Odgerel B.</i>	
The State-man in Mongolia.....	57
<i>Ganbold Ts.</i>	

THEORY AND PRACTICE OF DEMOCRACY

An Important Focus on Contemporary Political Science: Quality of Democracy.....	60
<i>Erdenedalai B.</i>	
Developmental Experiences and Mongolia’s Democracy.....	75
<i>Ulziisaikhan Ch., Undrakh D.</i>	
Contemporary Political Party Development Tendencies: From Partisan Politics to Alternative Communications.....	84
<i>Turtogtokh J.</i>	
Political Party’s Functions in Social and Political Relations, and its Legal Basis.....	90
<i>Zulifikar S.</i>	
Parliamentary Election Process and Faced Problems in Mongolia.....	99
<i>Oyunchimeg D.</i>	
Political Behavior of Mongolian Voters and the Parties.....	111
<i>Munkhbat S.</i>	
Citizens’ Political Participation: Political Approach of Civic Movements in Mongolia....	123
<i>Batbold Ts., Batbaatar B.</i>	
An Issue of Citizens’ Participation in Government Deal.....	137
<i>Bazarpurev S., Enkhbold B.</i>	
Image Influence on Political Environment.....	143
<i>Bazarpurev S., Enkhbold B.</i>	
Research Report on Presidential Election of Mongolia.....	148

Ganbold Ts.

GLOBAL POLITICS

Geopolitical Theory and An Analysis of Current Statement in Mongolia.....	172
<i>Galiimaa N.</i>	
Developmental Policies and Planning of World Countries and Mongolia.....	178
<i>Munkhbat S., Tsend-Ayush G.</i>	
International Relations Theory, Idea and Approach on Energy Politics.....	1
<i>Turtohtokh J., Myagmarsuren S.</i>	
Japanese Government's Foreign Policy on Mongolia.....	199
<i>Ikeda Sogo, Bumdari.D</i>	
Energy security and role of hegemon.....	
<i>Park Jung Hoo. Turtohtokh.J</i>	
Taiwanese Political and Economic Development.....	209
<i>Sarantsetseg E.</i>	
APEC: Development and Statement.....	215
<i>Davaanyam R.</i>	

COMPARATIVE POLITICS

Women's participation in political decision-making: A comparative analyse (Mongolian and Korean cases).....	223
<i>Odgerel B.</i>	
A Review Study of Legal Environment of Political Funding in Japan.....	229
<i>Bumdari D.</i>	
Japanese Politics: Current Statement and Problems (The 2013 Parliamentary Election, and Results).....	238
<i>Miura Nobuyuki</i>	
Political System of Russian Federation.....	242
<i>Dovchin Yo.</i>	

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг “Политологи” эрдэм шинжилгээний сэтгүүлийн ээлжит дугаар эрхэм уншигч та бүхний гар дээр очиж байна. Сэтгүүлийн маань энэхүү дугаар нь өмнө гарсан цувралуудын ололт, амжилт, туршлага дээр суурилсан болно.

Дэлхий дахины улс орнуудын харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр улс төрийн мөн чанар, агуулга улам бүр гүнзгийрч түүний үүрэг роль өсөн нэмэгдсээр байгаа билээ. Улс төрийн үүрэг роль өсөн нэмэгдэхийн хэрээр түүнийг ойлгон таниулах, энэ талаарх зөв үнэлэлт дүгнэлтийг өгөхөд улс төрийн мэдлэг, энэхүү мэдлэгийг бий болгодог улс төрийн шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг их юм. Эдүгээ улс төрийн шинжлэх ухааны онол-арга зүй, судалгааны арга хэрэгсэл, улам нарийсан хөгжиж онолын болон эмпирик судалгаа шинжилгээний мэдлэгүүд даяаршиж байна.

Улс төрийн мэдлэгийн даяарших үйл явц нь дэлхий дахин, бүс нутаг, улс орнуудад ардчилсан хөгжлийн ололт амжилтыг баталгаажуулах, түүнийг хөгжлийн шинэ шатанд гаргахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид ч гүйцэтгэсээр байх болно.

Монголд шинээр үүсэн төлөвшиж буй улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд энэ салбарын эрдэмтэн судлаачид ихээхэн хүчин чармайлт гаргаж байдгийн тодорхой нэг илрэл нь энэхүү сэтгүүл юм. Сэтгүүлийн эл дугаарт улс төрийн түүх онол, үзэл баримтлал, улс төрийн институт, байгууллага судлал, ардчиллын хөгжил, төрийн гадаад бодлого, олон улсын харилцаа, геополитик, гадаад орнуудын улс төрийн систем, харьцуулсан судалгаа зэрэг улс төрийн шинжлэх ухааны олон чухал сэдвүүдээр эрдэмтэн судлаачдын бичсэн өгүүллүүдийг нийтэллээ.

Манай сэтгүүл олон улсын эрх авсанаас хойш хоёр дахь дугаараа гаргаж буй бөгөөд нийтлэгдэж буй өгүүллийн чанарт цаашид бид анхаарч ажиллах болно.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

МАКС ВЕБЕРИЙН “УЛС ТӨР БОЛ ХУВЬ ЗОХИОЛ БА МЭРГЭЖИЛ МӨН” ЗОХИОЛЫН УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ САНАА

Ж.ЖАРГАЛ

МУБИС-ийн багш, доктор.

Түлхүүр үг: Улс төрийн шинжлэх ухаан, эх зохиол, улс төр, улс төрийн бодлого, мэргэжил, улс төрийн ноёрхол, улс төрийн нам, улс төрийн ёс зүй.

ABSTRACT: One of Weber's most influential contributions is his Politics as a Vocation essay. Therein, Weber unveils the definition of the state as that entity which possesses a delegatable monopoly on the legitimate use of physical force. Also Weber distinguished three ideal types of political leadership.

ТОВЧ ХУРААНГУЙ: Энэхүү өгүүлэлд Германы нэрт социологч М.Веберийн “Улс төр бол хувь зохиол ба мэргэжил мөн” зохиолын агуулгын дагуу түүний улс төрийн үзэл санааг нь авч үзсэн болно.

I

Манай оронд улс төрийн шинжлэх ухаан төлөвшин хөгжиж түүнийг их, дээд сургуульд нийтлэг чанартай хичээл болгон үзэж байгаагийн дотор дэлхий нийтийн улс төрийн сэтгэлгээний түүхийн асуудал зохих байр суурь эзэлж байна. Түүнийг судлан эзэмшихдээ эртнээс эдүгээ хүртэлх үеийн томоохон сэтгэгч мэргэдийн эх зохиолыг биечлэн уншиж судлах явдал нэн чухал болно.

Тэдгээр эх зохиол түүхийн янз бүрийн үед, эдүгээгээс ихээхэн өөр түүхэн нөхцөлд, үг хэллэг, нэр томьёо, хэл найруулга, ухагдахуун, ойлголтын хувьд өвөрмөц онцлогтойгоор бичигдсэн байдаг тул тэдгээрийг өнөөгийн бид ганц нэг удаа уншаад ойлгох, эзэмшихэд ихээхэн бэрхшээл тохиолдоно. Тиймээс туршлагатай эрдэмтэн багш нараас улс төрийн сэтгэлгээний эх зохиолуудын үзэл санаа, утга агуулгыг оюутан, сонирхон уншигчдад тайлбарлан таниулсан өгүүлэл, гарын авлага бичиж нийтлүүлэх хэрэгтэй юм.

Агуу их гүн ухаантан Гегель “Хэн хийсвэр сэтгэнэ вэ ?” гэсэн бэсрэг өгүүлэлдээ “соён гэгээрсэн нийгмийн боловсролтой иргэдэд ямар нэг юмыг тайлбарлах нь тун базаахгүй ярианы шинж гэгддэг юм” гэж сануулан бичсэн байдаг. Гэвч гүн ухаантны энэ сануулгын жинг бид даахгүй тул тус өгүүлэлд герман төдийгүй дэлхийн хэмжээний том социологич, улс төрийн сэтгэгч М.Веберээс улс төрийн асуудлаар туурвисан нэгэн чухал бүтээл болох “Улс төр бол хувь зохиол ба мэргэжил мөн” зохиолын үзэл санаа, агуулгыг зориуд авч үзэж тайлбарлах зорилт тавив. Учир нь энэхүү зохиол хэмжээгээрээ том биш боловч утга агуулгаараа жирийн уншигч байтугай мэргэжлийн хүмүүс ч ганц нэг удаа уншаад ойлгоход бэрхшээлтэй, утга санаа, өгүүлэмжийн логик, үг хэллэг, ойлголт, нэр томьёо нь нарийн ээдрээтэй тул түүнийг уншиж судлахад эхэндээ ямар нэг хэмжээний тайлбар шаардагдна.

II

М.Вебер бол XIX зууны эцэс, XX зууны эхэн үеийн социологийн гарамгай сэтгэгч эрдэмтэн байсан бөгөөд тэрбээр суурь чанартай бүтээлүүддээ нийгэм, аж ахуй, эдийн засаг, улс төр, эрх зүй, шашин, шинжлэх ухаан зэрэг нийгмийн үзэгдэл, асуудлыг түүхийн болон социологийн үүднээс хослуулан судалж боловсруулжээ. Сэтгэгчийн улс

төрийн социологи, ер улс төрийн онол нь “Ромын газар эзэмшлийн түүх, төрийн ба хувийн эрх зүйд түүний ач холбогдол” (1891 он), “Үндэсний төр ба эдийн засгийн бодлого” (1895 он, илтгэл), “Протестант ёс зүй ба капитализмын үзэл санаа” (1904 он), “Орос улс дахь хөрөнгөтний ардчиллын байдлын тухайд”, “Орос улс хуурмаг үндсэн хуульт ёсонд шилжиж байгаа нь” (Өгүүллүүд, 1906 он), “Шинэчлэгдсэн Герман дахь парламент ба засгийн газар” (1917 он, өгүүллүүдийн эмхтгэл), “Социализмын тухай” (1918 он, илтгэл) “Улс төр бол хувь зохиол ба мэргэжил мөн” (1918 он, лекц), “Аж ахуй ба нийгэм” (1921 онд хэвлэгдсэн) гэх зэрэг зохиолд нь ямар нэг хэмжээгээр тусгалаа олж боловсрогджээ.

“Улс төр бол хувь зохиол ба мэргэжил мөн” зохиол нь М.Веберээс 1918 онд Мюнхены их сургуульд уншсан лекцийн үндсэн дээр 1919 онд тусгай дэвтэр болж хэвлэгдсэн, хэмжээгээрээ бэсрэг товхимол байгаа боловч сэтгэгчийн улс төрийн онолын гол үзэл санааг агуулсан чухал бүтээл хэмээн судлагч эрдэмтэд үздэг. Түүнийг гадаадын олон хэлэнд хөрвүүлэн нийтэлсний дотор манай нэрт орчуулагч, ахмад философич Ү.Нямдорж бээр 2000 онд орос хэвлэлээс монголчилж хэвлүүлсний дээр Ө.Дашлхүндэв 2010 онд мөн оросоос орчуулж нийтлүүлжээ. Энэ нь манай оюутан, сонирхон уншигчид тус зохиолыг эх хэлээрээ уншиж судлахад ач тустай үйл хэрэг болж байна.

Бид тус зохиолыг Ү.Нямдоржийн орчуулсан эхээр авч үзэж иш татсан болно. Дурдсан хоёр орчуулагчийн хэн нь ч профессия гэсэн үгийг мэргэшил гэж орчуулжээ. Гэтэл манайд тогтсон нэр томъёоны практикт профессия – г мэргэжил, квалификация – г – мэргэжил гэж орчуулан хэвшсэн байдаг. Бид мэргэжил гэдгээр нь хэрэглэв.

III

М.Вебер бүтээлийнхээ эхэнд өмнөө тавьсан гол зорилго, авч үзэх үндсэн асуудлаа тодорхойлохдоо тухайн цаг үеийн улс төрийн амьдралын тулгамдсан асуудал улс төрийн ямар бодлого явуулбал зохих, улс төрийн үйл ажиллагааг ямар агуулгатай болговол зохих тухай тодорхой асуудлыг биш, харин улс төр бол мэргэжил мөн болох тухай ерөнхий асуудлыг авч үзэх болно гэдгээ урьдчилан хэлжээ (2,5). Сэтгэгч тэр ёсоор бүтээлдээ улс төр, улс төрийн бодлого, төр, засаг, хүчирхийлэл, ноёрхол, хүнд суртал, улс төрийн нам, мэргэжлийн улс төрч, улс төр ба сэтгүүл зүй, улс төрийн ёс зүйн асуудлыг авч үзэж, үзэл баримтлалаа томъёолон гаргасан байна.

М.Вебер бодрол эрэгцүүлээ улс төрийн бодлого гэж юу вэ гэдгээс эхэлж “эл ойлголт үлэмжхэн өргөн утгатай бөгөөд бие даасан удирдлагын талаарх үйл ажиллагааны бүх төрөл зүйлийг багтаана” (2,5). Улс төр, улс төрийн бодлого нь төр, засаглал, эрх мэдэлтэй салшгүй холбоотой бөгөөд “...<<улс төр>> гэдэг нь засаглалд оролцох, засаглалыг хуваарилахад нөлөөлөх эрмэлзэл юм”, “Улс төр эрхэлж буй хүн эрх мэдлийг эрмэлзэж байдаг” гэжээ (2, 9-10).

Энд нэр томъёоны хоёр тайлбар хийх хэрэгтэй байна. Politics – политика гэсэн нэр томъёог монголоор тухайн контекстээс шалтгаалж улс төр, улс төрийн бодлого гэж хоёр янзаар орчуулж ойлгодог. Улс төр гэдэг нь нийгмийн амьдралын бие даасан, ахуйлаг хүрээ, том үзэгдэл бөгөөд харин улс төрийн бодлого нь тэрхүү хүрээн дэх зорилго чиглэлтэй үйл ажиллагаа юм. Орос хэлний власть гэсэн үгийг мөн тодорхой контекстээс шалтгаалж засаг, эрх мэдэл гэж хоёр янзаар орчуулж хэрэглэдэг.

М.Вебер төрийг тодорхойлохдоо түүний хэрэглэж буй хэрэгсэл бүхий биет хүчирхийллийг эш үндэс болгосон байна. Тэр ёсоор “төр бол тодорхой салбарын дотор ... хууль ёсны биет хүчирхийллийн онц эрхийг (амжилттай) эрмэлзэгч хүмүүсийн холбоо мөн” (2,9), “төр нь ... хэрэгслийн хувьд хууль ёсны гэж тооцогддог хүчирхийлэл дээр тулгуурласан хүмүүс нь бусад хүмүүсийг ноёрхох харилцаа мөн болно. Ингэхлээр төр оршин тогтнохын тулд тухайн ноёрхол дор байгаа хүмүүс нь одоогоор ноёрхогчдын эрмэлзэж буй нэр хүндэд захирагдах шаардлагатай” (2,10) гэж бичжээ. Социологич энд хүчирхийллийн тухайд тодотгол хийж “Мэдээж хэрэг, хүчирхийлэл бол төрийн хэвийн

(ердийн) эсвэл цорын ганц хэрэгсэл биш, энэ тухай ярих ч явдалгүй, гэхдээ тэр нь төрийн өвөрмөц хэрэгсэл юм. ... Хүчирхийлэх “эрхийн” цорын ганц эх булаг нь төр юм” гэжээ (2, 8-9).

М.Вебер “төр” гэдэг ойлголтын зэрэгцээ “улс төрийн холбоо” гэсэн нэр томъёог хэрэглэж түүгээр төр үүсэхээс өмнөх үеийн улс төрийн үзэгдэл буюу нэг ёсондоо төрийн анхны хэлбэр бүхий бүрдлийг тэмдэглэн ойлгожээ. Энэ нь сэтгэгч: “төр бол түүнээс түүхэн ёсоор түрүүлсэн улс төрийн холбоодын адил ...” (2,10), “... улс төрийн холбоо буюу өөрөөр хэлбэл, манай үеийн төр ... “(2,8) гэж бичсэнээс ажиглагдаж байна.

IV

Сэтгэгч үүний дараа хүмүүс хэдийд, яагаад бусдын нэр хүндэд захирагддаг вэ, өөрөөр хэлбэл хүмүүсийн нэг хэсэг нь нөгөөгөө хэрхэн яаж ноёрхдог вэ, тэрхүү ноёрхлын дотоод үндэслэл хийгээд тулгуур нь болж буй гадаад хүчин зүйл нь юу байна вэ ? гэсэн асуулт тавьж тэдгээрийн дагуу ноёрхол, түүний хэв маягийн тухай үзэл баримтлалаа томъёолон гаргажээ.

М.Вебер, ноёрхлыг зөвтгөж хууль ёсны болгодог гурван янзын дотоод зөвтгөл буюу үндэслэгээ бий бөгөөд тэдгээрийн нэг дэх нь нэр хүнд, тухайлбал ёс заншлын нэр хүнд юм гэжээ. Тэр нь тогтож хэвшсэн, ёсчлон биелүүлэх дадал зуршлаар нөхцөлдсөн байдаг, түүнд тулгуурласан ноёрхол нь “уламжлалт” ноёрхол ажээ. Түүнийг хуучны маягийн патриарх, патримониал (ивээх ёсны) тайж нар хэрэгжүүлж байсан гэжээ (2,10).

Ноёрхлын хоёр дахь дотоод зөвтгөл, үндэслэгээ бол ноёрхогч этгээдийн хувийн ер бусын авьяасын (харизмын) нэр хүнд, бусдыг бишрүүлэх увдис юм. Түүнд тулгуурласан ноёрхол нь харизматик буюу бишрүүлэгч ноёрхол болно. Түүнийг хэрэгжүүлэгч нь шашны зөнч мэргэн, сонгодог жанжин тайж, бүх нийтийн санал асуулгаар дэвшсэн засгийн эрх баригч, гарамгай амлагч (демагог), намын улс төрийн удирдагч гэжээ.

Ноёрхлын гурав дахь дотоод зөвтгөл, үндэс нь хууль ёс, эрх зүй, албаны зүй зохистой, нарийн чанд дүрэмд ухамсартай захирагдах нь зайлашгүй гэдэгт итгэх явдал ажээ. Ийм үндэслэлд тулгуурласан ноёрхлыг М.Вебер хууль ёсны ноёрхол гэж нэрлэжээ. (Легальное господство гэсэн нэр томъёог манайд хуулиар зөвшөөрөгдсөн ноёрхол, ил ноёрхол гэх мэтээр янз бүрээр орчуулжээ. Эл үг латин хэлний *legalis* – хууль ёсны (законный) гэсэн утгатай үгнээс гаралтайг анхаарвал зохино. – Ж.Ж).

Социологч ноёрхлын эдгээр гурван хэв маягийг “цэвэр” хэв маягууд хэмээн нэрлээд тэдгээр нь бодит байдал дээр ховор тохиолддог гэжээ.

М.Вебер эдгээрийн дотроос харизматик ноёрхол нь жолоодогч, жолоодогчийн үзэлтэй нягт холбоотойг авч үзсэн байна. Түүний үзлээр жолоодогч (вождь) гэдэг нь байгалиас заяасан хувийн онцгой авьяас, чадвар, бусдыг бишрүүлэх увдистай, нэг ёсондоо хошуучлагч этгээд юм. Харин жолоодогчийн үзэл (вождизм – жолоодогчийг шүтэх ёс гэвэл илүү оновчтой байх болов уу. Ж.Ж) гэдэг нь жолоодогч ба түүнийг аялдан дагагчдын хооронд үүсдэг засаглалын харилцааны өвөрмөц хэв маяг ажээ. Социологч жолоодогчийн үзэл ба улс төрийн жолоодогчийн үзэл хоёр хоорондоо ялгаатай бөгөөд эхнийх нь нэгд, шидтэн, зөнч мэргэн (пророк), хоёрт, сонгогдсон жанжин тайж, дээрэмчдийн толгойлогч, кондотьер (итали хэлний *condottiere* – хөлсний цэрэг) буюу хөлсний цэргийн толгойлогч гэсэн хоёр төрлийн дүрээр түүхийн бүх үед, бүх бүс нутагт тохиолдож байсан гэжээ. Улс төрийн жолоодогчийн үзэл нь чухамдаа өрнөдийн онцлогтой үзэгдэл болж анхандаа Газар дундын тэнгисийн хот улсын (эртний грекийн) соёлын хөрсөн дээр бий болсон чөлөөт “амлагчийн” (демагог – грек хэлний ард түмний жолоодогч гэсэн утгатай үг Ж.Ж) дүрээр, хожим нь өрнөдийн орнуудад үүссэн үндсэн хуульт төр улсын хөрсөн дээр өндийсэн парламентын “намын жолоодогчийн” дүрээр дэвшин гарчээ (2,12).

V

М.Веберийн дэлгэрэнгүй авч үзсэн дараагийн чухал асуудал бол улс төрийн ноёрхлын штаб ба биет хэрэгслийн тухай асуудал юм. Улс төрийн ноёрхол бий болоход түүний дотоод үндэслэл, улс төрийн жолоодогч, улс төрчид чухал үүрэгтэй байх боловч уг ноёрхлыг тухайн төр улсад тогтоон барих, бэхжүүлэхэд хүрэлцээтэй биш ажээ. Тиймээс улс төрийн ноёрхлыг хангаж байдаг байнгын удирдлагын штаб ба материаллаг хэрэгсэл хоёр зайлшгүй шаардлагатай болно (2, 12). Удирдлагын штаб нь гадаад илрэлээрээ улс төрийн ноёрхлын үйлдвэрлэл бөгөөд жолоодогч, эзэн захирагч нарт хоёр янзын хэрэгслийн хүч нөлөөгөөр захирагдсан байдаг. Тэдгээр хэрэгсэл бол удирдлагын штабт ажиллагсдын хувийн ашиг сонирхлыг шууд нөхцөлдүүлсэн, тэдэнд эзний зүгээс хүртээх материаллаг (биет) шан харамж ба нийгмийн нэр хүнд юм. Материаллаг шан харамж нь албан тушаалын орлого, цалин, мөнгөн шагналаас, нийгмийн нэр хүнд нь рыцарын нэр төр, язгуурын эрх дарх, түшмэдийн нэр төрөөс бүрэлдэнэ. Штабын ажилтнууд эдгээрийг алдахаас айхын эрхээр эзэн захирагчтай эв санааны нэгдэлтэй байна.

Хүчирхийлэлд тулгуурласан ноёрхлыг хадгалахад зайлшгүй хэрэгтэй байдаг удирдлагын биет хэрэгсэл бол мөнгө, барилга байшин, нөөц, цэргийн техник, багаж хэрэгсэл, автомашины парк, унаа хөсөг, агт морьд юм.

М.Вебер энд нэг талаас удирдлагын штаб ба хэрэгслийн хоорондын холбоо хамаарал, нөгөөтэйгүүр энэ хоёр нь эзэн захирагчид хэрхэн захирагддагийг ноёрхлын дээрхи хэв маягуудын түүхэн хувьслын үүднээс задлан авч үзжээ. Удирдлагын штаб ба хэрэгсэл нь хоорондоо хоёр янзын холбоо хамааралтай байдгийн эхнийх нь штаб нь хэрэгслийг өмчлөгч эзэн байх, хоёр дахь нь штаб нь хэрэгслээс “тусгаарлагдсан” байх явдал болно. Эдгээр хувилбар нь эзэн захирагч удирдлагын штаб ба материаллаг хэрэгслийг ямар аргаар захирч ноёрхлоо тогтоохоос шалтгаална.

Түүхэнд эзэн захирагчийн хувийн захиргаа дангаараа оршиж байсныг хамгийн эртний улс төрийн байгууллагаас ч олж үзэж болно. Түүний жишээ бол эзэн захирагч нь өөрийн боолчууд, гэрийн албаныхан, зарц нар, дотно хүмүүст өөрийн хөрөнгөнөөс биет болон мөнгөн шан харамж олгож өөрөөсөө шууд хараат болгох, түүгээр дамжуулж удирдлага, засаглалын зардлыг ч өөрөө төлөх, мөн түүнчлэн зөвхөн өөрөөс нь хараат цэрэг байгуулах замаар удирдлагын штаб ба биет хэрэгслийг өөрийн хөрөнгө хүчээр бүрдүүлэн засаглаж байсан явдал гэж М.Вебер үзжээ.

Социологич удирдлагын биет хэрэгсэл нь нэг талаар эзэн захирагчаас хараат байдаг, нөгөөтэйгүүр штабын мэдэлд бүрэн, эсвэл хагас захирагдсан улс төрийн холбоо байдгийг авч үзээд түүнийг “язгуураар” хуваагдсан холбоо гэж нэрлэжээ (2,14). Үүний жишээ бол вассалын холбоо бөгөөд түүнд вассал нь өөрийн тойргийн удирдлага ба шүүхийн зардлыг хувийн хөрөнгөөр нөхөж, дайны үед зэвсэг, хүнсийг мөн өөрөө бэлдэж байсан явдал болно. Энэ нь сеньорын хүчин чадалд үр ашигтай байжээ. “Язгуурын” холбоонд сеньор нь бие даасан “язгууртны” тусламжаар ноёрхлоо хэрэгжүүлдэг, өөрөөр хэлбэл ноёрхлоо тэдэнтэй хуваалцдаг, мөн ноёрхохдоо эд хөрөнгөгүй, нийгмийн нэр төрөө алдсан, засгийн төлөө өрсөлдөх чадваргүй, тиймээс ч өөрөөс нь бүрэн хараат давхраа болох борчууд, плебей нарт тулгуурлаж байжээ. Патриархын болон үе залгамжилсан тайжийн ноёрхол, султаны зоргоор захирах ёс, төрийн хүнд суртлын байгуулал зэрэг бүх хэлбэр энэ хэв маягт багтана гэж М.Вебер заажээ (2,15).

Орчин үеийн төр бүрэлдэн хөгжих түүхэн явцад удирдлагын штаб удирдлагын биет хэрэгслээс “тусгаарлагдах” үйл явц хэрэгжсээр иржээ. Үүний эхлэл нь төр улсыг толгойлсон тайж нь удирдах засгийн тодорхой шатны бие даасан эрх мэдэлтнүүдээс засаглах эрх мэдлийг нь болон мөн тэдний зүгээс улс төрийн зорилгоор хэрэглэж болох зэвсэгт хүч, санхүүгийн хэрэгсэл ба бусад эд хөрөнгийг нь албадан хураах болсноор тавигджээ. Эл үйл явц бие даан үйлдвэрлэгчдээс эд хөрөнгө, хэрэгслийг нь аажим албадан хураасан капиталист үйлдвэрийн газрын хөгжилтэй, өөрөөр хэлбэл капитализм

бүрэлдэн тогтох үйл явцтай зэрэгцэн явагдсан байна. Ингэснээр орчин үеийн төр улсад улс төрийн “үйлдвэрлэлийн” бүх хэрэгсэл зөвхөн дээд шатны мэдэлд шилжин хуримтлагджээ. Энэ нь удирдлагын штаб, түүний түшмэд, албан хаагчдыг удирдлагын биет хэрэгслээс тусгаарлан салгах явдал орчин үеийн төрд бүрэн хэрэгжсний илрэл болсон байна (2,15).

Гэтэл улс төрийн бүх хэрэгсэл засаг төрийн дээд шатад тийнхүү шилжин төвлөрснийг XX зууны эхэн биед илэрхийгээр дахин албадан хураах болсноор засгийн эрхийг гартаа албадан оруулах оролдлого бүхий шинэ хандлага гарах болжээ (2,15). Үүний илрэл нь хувьсгал байсан бөгөөд түүгээр өмнө нь томилогдон тавигдсан дарга нарын оронд хууль бус үйлдлээр, эсвэл сонгуулиар засгийн эрхийг эзэрхэн авсан, улс төрийн штаб, түүний ажилтнууд хийгээд биет хэрэгслийн аппаратыг захиран ашиглах боломжтой болсон жолоодогч нар гарч ирснийг М.Вебер тэмдэглэжээ (2,15).

Сэтгэгч төрийн удирдлагын штаб ба биет хэрэгсэл, тэдгээрийг захиран засаглах эрх мэдэл, харилцааны түүхэн хувьслын үр дүнг дээрх байдлаар авч үзэж нэгтгэн дүгнэх үндсэн дээр орчин үеийн төрийн дэлгэрэнгүй тодорхойлолтыг томъёолон гаргасан байна. Тэр тодорхойлолт ёсоор: “Орчин үеийн төр бол албан газрын маягаар зохион байгуулагдсан ноёрхлын холбоо мөн бөгөөд тэгэхдээ ноёрхлын хэрэгсэл болох биет, хууль ёсны хүчирхийллийг монополчилоход (хүчирхийллийг хэрэглэх онц эрхтэй болоход – Ж.Ж) тодорхой хүрээний дотор амжилт олсон, энэ зорилгоор үйлдвэрийн газрын биет хэрэгслийг удирдагчдынхаа гарт нэгтгэж, урьд нь түүний (биет хэрэгслийг) өөрсдийн зоргоор захиран зарцуулж байсан язгуурын үүрэг гүйцэтгэгчдийг (функционеруудыг) эрх мэдэлтэй нь хамт албадан хурааж тэдний оронд хамгийн дээд байр суурийг өөрөө эзэлсэн холбоо мөн болно” (2,16).

VI

М.Веберийн зохиолын гол сэдэв бүхий авч үзсэн үндсэн асуудал бол улс төр нь мэргэжил болох тухай, өөрөөр хэлбэл мэргэжлийн улс төрчдийн тухай асуудал юм. Социологич түүний гарал үүсэл, төлөвшил, хэв маяг, ангилал, оршихуйн аргыг задлан шинжилж дэлгэрэнгүй авч үзжээ. Сэтгэгч зохиолдоо мэргэжлийн улс төрч гэж хэн бэ гэдгийг авч үзэхийн өмнө тэдний оршихуйн аргыг авч үзсэн байна. Гэвч бид энд уншигчдад ойлгомжтой, хялбар дөхөм болгох үүднээс тэдгээр асуудлыг зохиолд авч үзсэн логик дэс дарааг сольж мэргэжлийн улс төрчид, тэдний түүхэн хэв маягийн талаарх социологчийн үзэл санааг эхлээд тайлбарлая.

Мэргэжлийн улс төрчдийн анхны категори буюу анги нь дэлхийн янз бүрийн оронд явагдсан улс төрийн албадан хураалтын явцад бүрэлдэн бий болжээ. Тэд чухам хэн, ямар хүмүүс байсан бэ гэвэл анхандаа улс төрийн албадан хураалт явуулсан тайж нарт алба хааж зүтгэсэн, бас улс төрийн ноёдын албанд орсон, гэхдээ өөрсдөө ноёд болохыг хүсээгүй боловч тэдний бодлогыг явуулахыг өөртөө ашиг орлоготой ажил, амьдралаа тэтгэх эх үүсвэр болгосон хүмүүс байжээ (2,16). Зөвхөн ноёдод төдийгүй, бас бусад хүчний албанд зүтгэсэн мэргэжлийн улс төрчдийн энэхүү анги нь гагцхүү Өрнөдөд, тухайлбал Европт XV зууны үед хөдөлмөрийн хуваарийн үндсэн дээр, мэргэжлийн түшмэдийн байдлаар, Италийн хотууд болон сеньорийн суурин, хаант улсуудын дотроос Норманы байлдан эзлэгчдийн төр улсад анх түрүүн бий болжээ.

Цэрэг дайны техник хөгжснөөр эл салбарт мэргэжлийн офицер, улмаар хууль ёс, шүүхийг боловсронгуй болгож хөгжүүлэх явцад мэргэжлийн сурамгай хуульчид төрөн гарчээ. Тийнхүү тайжийн засаг захиргааны удирдлага, цэргийн техник, шүүх гэсэн гурван салбарт мэргэжлийн түшмэд XVI зуунд хөгжингүй төр улсуудад төгс ялжээ. Тайж нь язгуурыг ялж захирах болсноор нэг талаас түүний хэмжээгүй эрхт засаг бэхжиж дээшилсэн, нөгөөтэйгүүр түүнтэй зэрэгцэж тайжийн хаанчлал мэргэжлийн түшмэдэд аажим шилжжээ. Гол нь тайж нар, тэдэнд алба хаагч язгуур хоёрын хоорондын тэмцлийн явцад мэргэжсэн улс төрчид гарч ирж төлөвшснийг М.Вебер онцлон заажээ (2,29).

Сурамгай, сахилгажсан түшмэд бэхжин дээшилсэнтэй зэрэгцэж тайж нарт зөвлөх үүрэгтэй “удирдагч улс төрчид” хэмээх мэргэжлийн өөр нэг шинэ улс төрчид бий болжээ. Гэхдээ ийм төрлийн тэргүүлэгч зөвлөхүүд дэлхийн орнуудад эртнээс нааш ямар нэг байдлаар байсаар иржээ. Тухайлбал Дорно дахинд султан нь улс орныг амжилттай захирч удирдах, тэгэхдээ үүний төлөө биечилж хариуцлага үүрэх явдлаас түүнийг чөлөөлөх хэрэгцээ шаардлагаар “их сайд”-ын албан тушаал бий болсон бол Өрнөдөд Макиавеллийн үед дипломатчид удирдагч улс төрчийн байр сууринд тавигдах болжээ (2,25).

М.Вебер “Удирдагч улс төрч”-дийн цаашдын төлөвшил, хөгжлийн явцыг чухалчлан авч үзсний логикийг хураангуйлж өгүүлье. Өрнөдийн орнуудын улс төрийн амьдралын хөгжлийн явцад Үндсэн хуульт ёс бий болж улс төр нь бүхэл бүтэн үйлдвэрлэл болж хувирсны ачаар улс төрийг төрийн нэгэн удирдах зүтгэлтэн нэгдмэлээр эрхлэн явуулах хэрэгцээ шаардлага чухал болж энэ нь удирдагч улс төрчийн хэв маяг төлөвшин хөгжихөд нөлөөлжээ. Нэгэнт бий болсон төрийн дээд удирдагчид тохирсон улс төрийн удирдлагын нэгдмэл дээд байгууллага мөн адил бий болсны анхны хэлбэр нь хамтын удирдлагын дээд байгууллага байв. Түүнийг эхэндээ ван удирдаж байв. Тэрхүү хамтын системээр дамжиж албан ёсны дээд удирдах байгууллагын зэрэгцээ вангийн хувийн байдалд нь нийцсэн, түүнд итгэлтэй хүмүүсийн нэгдэл бүхий “танхим” бий болжээ. Ван төрийн хэргийг тэрхүү “танхим”-аар дамжуулж удирдах явцад ажил хэргийн мөн чанараас улам бүр хөндийрч дилетант буюу сонирхолоор өнгөц захирагчийн байдалд оржээ. Тэгэхдээ ван удирдлагын аппаратад ажилладаг өндөр мэргэжлийн туршлагатай түшмэдийн өсөн нэмэгдэж буй нөлөөнөөс ангид байхын тулд төрийн дээд удирдлагыг гартаа атгаж хадгалахыг хичээх болсноор вангийн эзэрхэн захирах ёс ба мэргэжсэн түшмэдийн хооронд далд тэмцэл хаа сайгүй явагджээ. Үүнийг намжааж зогсооход парламент бий болсон явдал багагүй тус болсон байна. Гэвч улс орнуудад байдал өөр өөр байв. Жишээлбэл Германд засгийн эрхийг удам залгасан хаад барьж байсан тул вангийн эрх ашиг түшмэдийнхтэй нийцэж тэд нийлж парламентын эсрэг зогсож байв. Түшмэд ямар зорилго, эрх ашигтай байсан вэ гэвэл тэдний дотроос хэн нэг нь сайдын суудалд суухыг хүсч байв. Эзэн хаан ч гэсэн сайдыг түшмэдийн дотроос өөрийн үзэмжээр тавих сонирхолтой байв. Тийнхүү эзэн хаан ба түшмэд нийлж парламентыг сөрж зогсох болжээ. Энэ нь хамтын удирдлагын системийг халж оронд нь танхимын тэргүүн бүхий ерөнхий сайд бий болоход хүргэжээ. Энэ нь эзэн хаан улс төрийн намуудын тэмцэл, өөрт нь чиглэсэн довтолгооноос ангид байх, нөгөөтэйгүүр парламентын өмнө хариуцлага хүлээсэн, бас парламентад сөрж зогсох, намуудтай хэлэлцээ хийх онцгой албан тушаалтан эзэн хаанд хэрэгтэй болсны бодит биелэл байжээ. Харин Англид парламентаар сонгогдсон сайдуудын систем бүхий танхим бүрэлдэн тогтож хэвшжээ.

Улс төр нэг ёсондоо томоохон үйлдвэрлэл болж хөгжсөн явдал намууд засгийн эрхийн төлөө тэмцэлд сурч дадлагажих, түүний арга ухааныг эзэмших хэрэгцээ шаардлага нь нийгмийн ажилтнууд мэргэжилтэн түшмэл, улс төрийн түшмэл гэсэн хоёр ангилалд хуваагдахад нөлөөлсөн байна. Улс төрийн түшмэлүүд аль ч тохиолдолоор ажлаасаа өөрчлөгдөх, халагдах, эсвэл өөр мэдэлд шилждэг онцлогтой бол мэргэжилтэн түшмэлүүд засаг захиргааны аппаратад тогтвор суурьшилтай ажиллаж дотоод удирдлагыг хангах, улс оронд оршин буй ноёрхлын харилцаа, дэг журмыг хангаж хадгалах зорилготой байв. Тийнхүү түшмэл мэргэжилтэн нь өдөр тутмын бүхий л ажлыг хариуцан гүйцэтгэдгийн хувьд хамгийн хүчирхэг нь болж байв гэж М.Вебер бичжээ (2,28).

VII

Социологич зохиолдоо түүхэнд байсан “мэргэжсэн улс төрч”-ийн үндсэн хэв маягуудыг тодорхой авч үзсний нэг дэх нь лам нар юм. Тайж нь язгууртай тэмцэхдээ

язгуур бус, тэгэхдээ улс төрийн талаар хэрэгтэй давхраад тулгуурлажээ. Тэр нь Өмнөд Энэтхэг, Энэтхэг-Хятад, буддын шашинт Хятад ба Япон, шарын шашинт Монгол, дундад зууны үеийн христын шашинт бүс нутагт лам нар байв (2,29). М.Вебер тийнхүү монголын эрдэм номтой лам нарыг мэргэжсэн улс төрчдийн эгнээнд оруулан дурджээ.

Лам нар улс төрд хоёр зүйлийн шинж чанараараа хэрэгтэй байсны нэг нь тэд бичиг үсэгтэй байсан явдал юм. Тэднийг эзэн хаан, тайж нар язгууртны эсрэг тэмцэхдээ улс төрийн зөвлөх болгон ашиглаж алба хаалгаж байжээ. Хоёрдугаарт, лам хүн нэн чухал нь эхнэр авахгүй, түүний дотор сахил хүртсэн лам нь эхнэр, үр хүүхдээ бодсон эдийн засгийн хувийн ашиг сонирхлын хөл үймээнээс ангид байдаг учираас эзэн захирагчийнхаа удирдлагын хэрэгслээс тусгаарлагдсан байдаг гэж М.Вебер өгүүлжээ.

Түүхэн дэх мэргэжсэн улс төрчдийн хоёр дахь маягийг хүмүүнлэг боловсролтой хэлзүйчид бүрдүүлж байжээ. Тайжийн улс төрийн зөвлөх нь юуны өмнө түүний улс төрийн меморандум зэрэг албан баримт бичиг боловсруулан зохиогч болохын тулд латин илтгэл, грек шүлэг бичиж сурах хэрэгтэй байжээ. Энэ шаардлагаар тайж нар “яруу найргийн” тэнхим байгуулж байв. Ийм байдал нэн ялангуяа Дорнод Ази, тэр дотор Хятад оронд гоц гойд илэрч байжээ. Хятадын түшмэлүүд угаасаа Европын Сэргэн мандалтын үеийн хүмүүнлэг үзэлтэн шиг байсан бөгөөд хүмүүнлэгийн боловсролтой, хятадын эртнээс наашх утга зохиолыг мэддэг, хичээнгүй сайн бичээч нар байв. Хятад дахь мэргэжлийн түшмэдийн эл давхраа тийнхүү хятад орны эрт цагийн түүх, соёл, уламжлалаар нөхцөлдөн бэлтгэгдэж, улс орныхоо хувь заяаг тодорхойлж байжээ.

Мэргэжлийн улс төрчдийн гурав дахь давхраа бүхий маяг бол ордны сурвалжтанууд байв. Вангууд тэднийг ордонд ойртуулж улс төрийн болон дипломат албанд ашиглах болжээ. Тийнхүү вангуудын албанд урьдын хүмүүнлэг үзэлтэн хэлзүйчдийн оронд ордны сурвалжтаны дундаас төрж гарсан мэргэжлийн улс төрчид хүчин зүтгэсэн байна.

Мэргэжлийн улс төрчдийн дөрөв дэх анги бүхий маяг нь дан ганц Англи оронд үүсэж бий болсон онцлогтой бөгөөд тэр нь жижиг язгууртан ба хотын рантье, патрициат хэмээх эрх дархтай баячуудыг эгнээндээ багтаасан давхраа байв. Вангууд тэднийг эхэндээ бароны эсрэг тэмцэлдээ татан оруулж улмаар нутгийн өөрөө удирдах захиргааны албан тушаалд дэвшүүлжээ. Тэд энэ завшааныг ашиглаж, бас уг албанд үнэ төлбөр, цалин хөлсгүй орсон учраас нийгмийн талаар хүчин чадалтай болох зорилгоор тэдгээр албан тушаал, эрх мэдлийг хадгалан атгасаар байв. Үүний улмаас эзэн захирагч ван яваандаа патрициатаас хараат болоход хүрчээ. Тэгэхдээ энэ байдал хожим нь Англи орныг хүнд сурталжихаас аварсан байна (2,31).

Мэргэжлийн улс төрчдийн тав дахь түүхэн маяг бүхий давхраа нь их сургуулийн боловсрол эзэмшсэн хуульчид байжээ. Тэд Өрнө дахинд, түүний дотор Европын эх газрын орнуудад бүрэлдэн төлөвшиж, тэдгээр орны улс төрийн бүтцэд шийдвэрлэгч ач холбогдолтой болжээ. Үүнд ромын эрх зүй чухал нөлөөтэй байсан гэж М.Вебер заажээ. Ромын эрх зүй тухайн үедээ Ромын хожмын хүнд сурталт төрийг хувирган өөрчилсөн шигээ XVI-XVIII зуунд Европын орнуудын улс төрийн үйлдвэрлэлийг хувьсгалжуулж тэр нь рационал төрд хүрэх хандлага болсон байна. Эдгээр үйл явцын тээгч нь хууль зүйн рационализмын төлөөлөгчид бүхий Итали, Франц, Нидерланд зэрэг Европын орнуудын мэргэжсэн хуульчид байжээ.

Европт парламент, улс төрийн нам, ардчилал үүсэж бүрэлдэхэд хуульчид, ялангуяа өмгөөлөгчид чухал үүрэг гүйцэтгэжээ. М.Вебер өмгөөлөгч юу хийж чаддагийг дурдаж: “Улс төрийн үйлдвэрлэлийг намууд эрхэлдэг, өөрөөр хэлбэл тэр нь сонирхсон талуудын ажил юм. ... Ямар нэгэн үйл хэргийг сонирхсон талуудад зориулж үр ашигтай эрхлэн бүтээх нь мэргэжсэн өмгөөлөгчийн хийж чадах урлал болно. Энд тэрбээр ... ямар ч түшмэлээс давна. Тухайлбал, өмгөөлөгч логикийн талаар сулхан үндэслэсэн, өөрөөр хэлбэл энэ талаараа “муу” хэргийг амжилттай буюу техникийн талаар “сайн” хөтлөн

явуулж чадна. Харин түшмэл нь улс төрч болохын хувьд үүний эсрэгээр “сайн” хэргийг техникийн талаар “муу”, “олхиогүй” болгоно” гэж бичжээ (2,34).

VIII

М.Вебер мэргэжлийн улс төрчдийн дээрхи таван маяг, давхраанд “сүржин яригч”(демагог), сэтгүүлч, намын түшмэлийг улс төрчийн маяг болгон нэмж авч үзсэн байна. “Сүржин яригч” бол Өрнөдөд үндсэн хуульт төр үүссэн цагаас, бүрэн хэмжээгээрээ ардчилал хөгжсөн цагаас бий болж гарч ирсэн улс төрч жолоодогчийн маяг ажээ. Түүний онцлог шинж нь олон түмнийг өөртөө татах, сонгуулиар саналыг нь авч улс төрийн тавцанд гарах зорилгоор сүржин ярьж амлах явдал юм.

Улс төрд тийм ам үг зохих үр ашигтай байдаг бол бичсэнүг түүнээс ч илүү их үр ашигтай ажээ. Эдүгээ хэвлэлийн энэхүү төрөл зүйлийн нэн гол төлөөлөгч нь улс төрийн нийтлэлч, юуны өмнө сэтгүүлч юм гэж М.Вебер заагаад сэтгүүл зүй, сэтгүүлчийн улс төрийн үүрэг, байр суурийг авч үзсэн байна. Сэтгүүл зүй, сэтгүүлчийн ажил мэргэжил нь улс төрд зайлшгүй хэрэгтэй, учир нь улс төрч тэдгээрээр дамжуулж олон түмний санаа бодол, үйл байдалд багагүй нөлөөлнө.

Өмнөх үетэй харьцуулахад хөрөнгөтний намууд улс төрийн эрх мэдэл өөд дэвших боломж бүхэлдээ доройтсон, тиймээс нэр нөлөө бүхий улс төрч нь олон түмэнд нөлөөлөх үр ашигтай хэрэгсэл болох хэвлэлтэй холбоо тогтоох хэрэгтэй болжээ (2,37). Сэтгүүлч, ялангуяа улс төрийн сэтгүүл зүй (политическая журналистика) улс төрийн амьдралд чухал байдгийн гол шалтгааны нэг нь энэ юм. Гэвч хэвлэлийнхний эгнээнээс намын жолоодогч төрөн гарах нь бүтэшгүй зүйл юм. Учир нь улс төрд сэтгүүлчийн хэрэгцээ шаардлага хэдийгээр өссөн ч тэрбээр хөрөнгө чинээгүйн улмаас мэргэжилдээ байнгын уяатай байх шаардлагатай. Чухам тэгж байж сэтгүүлчийн ажил нь нэг ёсны “үйлдвэрлэл” болж эрчтэй, хэрэгцээ шаардлагатайгаар хөгжиж чадна.

Уг нь сэтгүүлчдийн доторх зан төрхөөрөө удирдагч баймаар төрсөн хүмүүс өдөр тутмын, эсвэл долоо хоног тутмын бичсэн өгүүллээрээ мөнгө олж амьдралаа залгуулах зайлашгүй шаардлагаар улс төрд бөхөлзөж эрх мэдэл нь дэвжин дээшлэхгүй, нэг сууринд удаан хүлээтэй байх тохиолдол олон гардаг. Өнөөгийн улс гүрнүүдэд хаа сайгүй ажилтан сэтгүүлчийн улс төрийн нөлөө улам бүр багасч, харин хэвлэл эзэмшсэн том хөрөнгөтний улс төрийн нөлөө улам өсч байна гэж М.Вебер бичжээ (2,38). Гэвч ямар ч нөхцөлд сэтгүүлчийн ажил нь мэргэжлийн улс төрийн үйл ажиллагааны нэгэн чухал зам хэвээр үлдэх ажээ. Тэгэхдээ энэ зам хүн болгонд таарч тохирохгүй, тэгэх тусмаа сул, буурай хүмүүст, ялангуяа дотоод тэнцвэрээ зөвхөн ямар нэгэн тогтвортой язгуур байдлаас олж авдаг хүмүүст бүрч тохирохгүй (2,39). Ер нь олон сэтгүүлч хүн л юм болохоор “ханш буурч” замаас гардаг боловч чухам сэтгүүлчдийн давхраа нь нэн үнэ цэнэтэй, жинхэнэ бодь хүмүүсийг эгнээндээ багтааж байдаг нь гайхалтай гэж М.Вебер бичжээ (2,40).

IX

Хэрэв сэтгүүлч нь мэргэжсэн улс төрчийн хэв маяг болж нэлээд дээр үеэс оршиж байгаа бол намын түшмэл нь сүүлчийн арваад жилийн, зарим талаар бүр сүүлийн хэдхэн жилийн хандлагатай холбогдон гарч ирсэн, тиймээс түүхэн хөгжилд эл этгээдийн эзлэх байр суурийг тодруулан ойлгохын тулд намын гарал үүсэл, систем, зохион байгуулалтыг авч үзэх ёстой гэж М.Вебер үзжээ. Энэ талаархи социологичийн зарим чухал үзэл санааг тоймлон дурдъя.

Хөдөөгийн жижиг тойрог, тосгоны цар хэмжээ, шийдвэрлэх асуудал, зорилтоос давсан илүү өргөн, том хүрээтэй улс төрийн холбоодод ээлжит сонгуулиар бий болох улс төрийн байгууллага хэрэгтэй бөгөөд тэр нь өрсөлдөгчдийн байгууллага байх шаардлагатай. Үүний тулд улс төрд оролцох сонирхолтой хүмүүс чөлөөт элсүүлэлтийн замаар бараа болж дагагчдыг бий болгож өөрсдийгөө, эсвэл өөрсдийн ивээлд багтдаг хүмүүсээ сонгуульд нэр дэвшүүлж, мөнгөн хөрөнгө цуглуулж, санал олж авах ажилд

орно. Энэ нь хэрэг дээрээ сонгуулийн эрхтэй иргэдийг улс төрийн идэвхтэй ба идэвхгүй хэсэгт хуваахад хүргэх ба сонгогчдын өөрсдийн нь сайн дурын үндсэн дээр явагдах учир ямар ч хүч албадлагаар өөрчлөгдөхгүй. Жолоодогчид ба тэдэнд бараа болж дагагчид нь чөлөөт элсүүлэлтийн идэвхтэй элемент болохын хувьд бараа бологчдоор дамжуулж сонгогчдын идэвхгүй олныг жолоодогчоо сонгоход оролцуулах нь аль ч намын амин чухал зайлшгүй элемент болно гэж М.Вебер үзжээ (2,41). Нэг үгээр хэлбэл социологич улс төрийн намуудын үүсэл нь янз бүрийн шатны ардчилсан сонгуультай нягт холбоотойг заажээ.

Социологич цааш дэлхийн орнуудад нам үүсч, хөгжиж ирсэн түүхэн замнал, бүтэц, зохион байгуулалт янз бүр байсан, харин Английн хоёр нам (либерал ба консерватив) язгууртнуудын котерий буюу дугуйлан, улс төрийн клуб, олон түмнийг хамарсан нам гэсэн ийм гурван үе шаттай хэлбэрийг туулсан гэжээ.

Улс төрийн намууд төлөвшин хөгжиж, парламентын сонгуульд оролцох, суудал эзэлж үйл ажиллагаа нь өргөжих явцад намын удирдлагын аппарат, түүнд байнга ажиллах намын мэргэжсэн улс төрч ажилтан төрөн гарч, үүрэг, нөлөө нь ихээхэн өсчээ. Тийм ажилтнаас намын хэвийн оршин тогтнол, үйл ажиллагаа, санхүүжилт шалтгаалах болсон төдийгүй тухайн намаас нэр дэвшиж сонгогдсон парламентын гишүүд ч тодорхой хэмжээгээр хараат байх болжээ. Ийм нөхцөлд намын байнгын үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлж байдаг намын удирдлагын аппарат буюу англичуудын нэрлэдгээр намын “машин”-ыг захирч удирддаг хүн тухайн намын жолоодогч болж тодрох болсон байна. Намын удирдагчид нэр дэвшиж өрсөлдсөн хүн ялалт байгуулахад тухайн аппаратын ажилтан буюу намын түшмэл чухал үүрэгтэй болсон учир нэр дэвшигч хэрэв ялалт байгуулбал түүнд хүчин зүтгэсэн намын түшмэд нь албан тушаалтай болох, дэвших, мөн бусад урамшуулал, давуу эрх олж авдаг болжээ. Эдгээрийн нөлөөгөөр АНУ, Германд намын амьдрал, сонгуульд үзүүлэх амжилт, ялалтад тухайн намын удирдагчийн хувийн шинж, харизматик чанар чухал үүрэгтэй болжээ. Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тийм удирдагчгүй нам удаа дараалан ялагдах болсон байна. Гэхдээ намын амьдралд түүний удирдлагын аппарат, түүнд байнга ажилладаг намын түшмэд ихээхэн үүрэг нөлөөтэй болсныг зарим социал-демократууд “улс төрийн намууд намын бюрократуудын гарт орж олзлогдлоо” гэх болсныг М.Вебер дурджээ (2,46). Тийнхүү намын удирдлагын аппарат бүхий “машин”, түүний түшмэдийн үүрэг нөлөө өссөнөөр парламент хэрэг дээрээ тэдгээрт захирагдаж парламентын гишүүд нэг ёсны санал өгөгч “сүрэг” болж хувирахад хүрчээ. М.Вебер үүнийг: “Ийнхүү <<машин>> ашиглаж хойноосоо олон түмнийг дагуулсан, парламентын гишүүдийг өөрийн бараа бологч, улс төрийн сул цалин авагч болгосон плебисцитар дарангуйлагч парламентын дээр сүндэрлэх болжээ” гэж тэмдэглэн бичжээ (2,51).

Социологич АНУ, Англи, Герман, Франц, Испани, Швейцарт сонгуульд ялалт байгуулсан өндөр албан тушаалтан өөрт нь хүчин зүтгэж тусалсан дагагчдаа төрийн байгууллагын ажилтан, сонины эрхлэгч, ажилтан, түүгээр ч үл барам эмнэлгийн касс, шуудан зөөгчийн ажлыг хүртэл албан тушаал, урамшууллын хэлбэрээр хариу бэлэг, шан болгож барьдаг гажуу үзэгдэл дэлгэрсэн (2,22-24), түүнчлэн ард нийтээр сонгох намын машины системтэй нягт холбоотойгоор сонгуульд ялалт байгуулах явдлыг хууль бус элдэв аргаар мөнгө олж санхүүжүүлдэг “босс” буюу улс төрийн капиталист үйлдвэрийн эзэн гарч ирсэн зэрэг үзэгдлийг авч үзэж тэдгээрийн нийгэм, улс төр, эдийн засгийн утга агуулгыг дэлгэн тавьсан байна (2,46-57).

Энэ байдлаар сонгуулийн ялалтын дараа засаг захиргааны удирдлагад мэргэжсэн улс төрч биш, харин удирдагчдаа үнэнчээр зүтгэсэн мэргэжлийн бус сонирхогчид (дилетантууд) удирдагчаасаа шан харамж болгож албан тушаал хүртэн ажилладаг болжээ. Гэвч ийм явдал цаашдаа тэвчихийн аргагүй болж тэдний оронд төрийн иргэний албаны шинэчлэлийн ачаар насаараа алба хааж тэтгэвэр авах эрхтэй, их сургуулийн

боловсролтой ажлаа сайн мэддэг, хахуульд автдаггүй түшмэд бэлтгэгдэн гарч ажиллах болсон байна. Энэ нь яваандаа намын удирдлагын арга барил өөрчлөгдөхөд нөлөөлөх болно, гэхдээ чухам яаж өөрчлөгдөхийг бид одоогоор мэдэхгүй юм гэж М.Вебер өгүүлжээ (2,58).

Х

М.Вебер улс төр хийнэ гэдэг бол улс төрийн байгууллагуудын хооронд, бас тэдгээрийн дотор засгийн эрх мэдэл хуваарилахад нөлөөлөхийг оролдох явдал юм гэж үзээд хүмүүс үндсэндээ хоёр янзаар, нэгд, “тохиолдлоор”, хоёрт, хавсаргаар, эсвэл үндсэн мэргэжил болгож улс төр хийдэг гэжээ (2,17). Эхнийхээр бол хүн бүхэн “тохиолдлын” улс төрч болдог, тэр нь сонгуулиар саналын хуудсаа хайрцагт хийх, “улс төрийн” хурал дээр алга таших, эсвэл эсэргүүцэл илэрхийлэх, “улс төрийн” үг хэлэх гэх мэтээр илэрдэг бөгөөд үүгээр олонхи хүмүүсийн улс төр хийх нь хязгаарлагддаг. “Хавсарга” улс төрчид бол бүх итгэмжлэгдсэн хүмүүс, нам, улс төрийн холбоодын захиргааны ажилтнууд юм. Тэд зөвхөн шаардлагатай тохиолдолд улс төрийн үйл ажиллагаа явуулах ба энэ ажил тэдний хувьд материаллаг болоод санаалаг талаасаа эн тэргүүний “амьдралын үйл хэрэг” болдоггүй. Түүнчлэн зөвхөн шаардлага гарсан үед л үйл ажиллагаа нь эхэлдэг төрийн зөвлөлүүд ба түүнтэй адилтгах зөвлөлдөх байгууллагын гишүүд, бас чуулганы үед л улс төрөөр “ажилладаг” парламентчдын өргөн давхраа нь улс төрд хавсаргаар оролцдог гэж М.Вебер өгүүлжээ (2,17).

Эдгээр улс төрчдөөс “зонхилон мэргэжсэн” улс төрчид үндсээрээ ялгаатай болохыг социологич чухалчлан авч үзсэн байна. Тэр ёсоор бол улс төрийг мэргэжлээ болгох хоёр арга байдгийн нэг нь улс төрийн “төлөө” амьдрах, нөгөө нь улс төрийн “хишиг ивээлээр”, “улс төрөөр” амьдрах явдал ажээ (2,18). Гэхдээ энэ хоёр нь туйлын эсрэг тэсрэг биш, тус бүртээ огт хөдөлшгүй зүйл ч биш бөгөөд хоорондоо оюун санааны хувьд бага зэрэг, харин материаллаг талаараа илүү давхацдаг байна. Улс төрийн, төлөө амьдарч байгаа хүн ямар нэгэн дотоод утгаараа “түүнээс амьдралаа” бүтээж, эсвэл эрх мэдэл эдэлж байгаадаа сэтгэл ханаж байдаг, эсвэл “үйл хэрэгт” хүчин зүтгэж байгаагаа ухамсарласнаас өөрийн дотоод түвшин байдал болон үнэ хүндийн мэдрэмжээ олж авч түүгээрээ амьдралаа утга учиртай болгодог. Чухам ийм дотоод гүн утгаараа ямар нэгэн үйл хэргийн төлөө амьдарч буй аливаа хүн тухайн үйл хэргээр амьдардаг ажээ.

Улс төрийг мэргэжлээ болгож, түүний “хишиг ивээлээр” амьдардаг хүн түүнийг байнгын орлогын эх үүсвэр болгохыг хичээдэг бол улс төрийн “төлөө” амьдарч мэргэжлээ болгосон хүн үүнээс огт өөр зорилготой байдаг. Хувийн өмчийн дэг журам ноёрхож буй нөхцөлд хэн нэг хүн улс төрийн “төлөө” амьдрах болбол түүнд нь эдийн засгийн утгаар хэд хэдэн утгвар нөхцөл бүрэлдсэн байх хэрэгтэй болно. Тухайлбал, тухайн хүн хэвийн нөхцөлд улс төрөөс олж болох орлогоос эдийн засгийн хувьд хараат бус байх хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл тэрбээр ердөө л чинээлэг хүн, эсвэл байнгын хангалттай орлоготой хувийн өмчтөн байвал зохино.

Гэвч энэ байдлаас сөрөг үр дагавар гарч болохыг М.Вебер сануулан авч үзжээ. Тэр бол төр ба намыг хэрэв зөвхөн улс төрийн төлөө амьдардаг баян хүмүүс удирдах болбол улс төрийн удирдах давхаргад “баячуудын”(плутократчууд) ноёрхол тогтох болно, түүгээр ч үл барам тэд улмаар улс төрийн ноёрхол, эрх мэдлээ хувийн эдийн засгийн ашиг сонирхолдоо зориулан ашиглахыг эрмэлзэнэ. Ийм үйлдэл явдал гаргаагүй давхраа гэж түүхэнд байгаагүй. Нөгөөтэйгүүр ерөөс чинээлэг хүн өөрийн аж амьдралын эдийн засгийн “аюулгүй байдал”-ын төлөө анхаарал тавих нь санаатай ч бай, санамсаргүй ч бай түүний бүхий л амьдралын амин чухал зүйл байдаг. Эдийн засгийн урамшуулал, ашиг орлого горьдохгүйгээр улс төрийн идеализмыг баримталж улс төрийн төлөө зүтгэх явдал тухайн нийгмийн байгууллыг өөрчлөх сонирхолтой давхраанд хувьсгалын үед голлож тохиолддог, өөрөөр хэлбэл хувьсгалчид л тийнхүү зүтгэдэг.

Улс төрийн удирдлагад хөрөнгө зоорьгүй хүмүүс орж ажиллан улс төрийн “хишиг ивээлээр” аж төрдөг мэргэжлийн улс төрч болж болно. Энэ нь тэрбээр ердөө л хөрөнгө ологч (“Pfrunder”) буюу цалин авдаг түшмэл байна гэсэн үг. Ингэхэд тэрбээр нэг бол албан ёсоор гүйцэтгэсэн ажил үйлийнхээ төлөө гааль ба төлбөрөөс орлого олно, бас энэ төрлийн орлогын зөвхөн нэг хэсэг болгож тогтмол бус, далд байдлаар гар цайлгасан шан харамж, хахууль авна, эсвэл баттай биет урамшуулал, мөнгөн шан, аль эсвэл эдгээрийг зэрэг олж авна.

XI

М.Вебер улс төрч хүн албан тушаал ахих нь түүнд ямар баяр бахдал авчрах вэ, энэ замд хөл тавьж буй хүн хувийн ямар угтвар нөхцөл, бэлтгэл хангах хэрэгтэй вэ гэдгийг чухалчлан авч үзжээ. Улс төрийн албан тушаал ахих явдал юуны өмнө эрх мэдлийн мэдрэмж өгнө. Ердийн даруухан албан тушаалд ч гэсэн хүмүүст нөлөөтэйгээ, тэднийг захирахад оролцож байгаагаа ухамсарлах, тэгэхдээ юуны өмнө түүхэн чухал үйл явцын судсыг барьж байгаагаа мэдрэх нь мэргэжлийн улс төрчийг өдөр тутмын жирийн байдлаас суга татан дээш гаргана. Гэвч эрх мэдлийг эдлэн хэрэгжүүлэхэд улс төрчийн ямар чанар нэн чухал болдог вэ, тэрбээр ямар хариуцлагыг яаж үүрэх вэ гэсэн асуулт хамгийн чухлаар тавигдана.

М.Вебер үүний дагуу улс төрч хүнд чин эрмэлзэл, хариуцлагын мэдрэмж, нүдэн баримжаа гэсэн гурван чанар шийдвэрлэгч үүрэгтэй гэжээ(2,65). Чин эрмэлзэл нь үйл хэргийн мөн чанарт баримжаалах учиртай бөгөөд үйл хэрэгт хичээн зүтгэж өөрийгөө зориулах явдал болно. Гэвч улс төрч “үйл хэрэгт” зүтгэхдээ хариуцлагыг энэхүү үйл ажиллагааныхаа чигийг заагч од болгохгүй бол дан ганц чин эрмэлзэл хүнийг улс төрч болгохгүй. Үүний тулд улс төрчид нүдэн баримжаа шаардагдах бөгөөд тэр нь улс төрч хүн бодит байдлын нөлөөг дотоод төвлөрөлтэйгээр, тайван хүлээж авах чадвар бүхий сэтгэл зүйн шийдвэрлэгч чанар болно. Нүдэн баримжаатай байна гэдэг бол юмс ба хүмүүстэй харилцахдаа зай барина гэсэн үг юм. “Зай барихгүй байх” нь аливаа улс төрчийн үхлийн аюултай нүглийн нэг мөн

Тэгвэл нэг хүнд халуун чин эрмэлзэл ба хүйтэн нүдэн баримжаа хоёрыг хэрхэн яаж хослон багтаах вэ ? Улс төрийг чухам толгойгоор “хийдэг”, тэгэхдээ улс төрд өөрийгөө зориулах явдал нь зөвхөн чин эрмэлзлээс ургаж гарсан, бас түүгээр тэжээгдсэн байх ёстой. Гэвч чин эрмэлзэлтэй улс төрч сэтгэлээ бүрэн барих хэрэгтэй бөгөөд энэ нь чухам зай барих дадлын ачаар л бололцоотой болдог. Улс төрч бие хүний “хүч” гэдэг нь юуны өмнө түүнд эдгээр чанар бүрэлдсэн байна гэсэн үг юм. Улс төрч хүн үүний зэрэгцээ хүнд байдаг хамгийн бүдүүлэг муу чанар бүхий дайсан болох ихэмсэг занг гаргахгүй байхын төлөө өдөр тутам, цаг тутам тэмцэх ёстой.

Ихэмсэг зан бол ер хэн ч ангижирч чадаагүй үлэмж дэлгэрсэн чанар юм. Тэр нь академийн болон эрдэмтдийн хүрээнд мэргэжлийн өвчний нэг төрөл бүхий дургүйцэм шинж байдаг боловч эрдмийн ажилд саад болдоггүй утгаараа харьцангуй гэм хоргүй байдаг бол харин улс төрчийн хувьд заналт дайсан болно. Яагаад вэ гэвэл, улс төрийн хүрээнд эцсийн эцэст ажил хэргийн голоос зайлах, хариуцлагагүй явдал гэсэн хоёрхон төрлийн аюулт хар нүгэл байдаг бөгөөд ихэмсэг зан улс төрчийг эдгээр нүглийн аль нэгийг, эсвэл хоёуланг үйлдэхэд хүргэнэ.

М.Вебер тийнхүү улс төрч нь дээр дурдсан чухал чанаруудыг өөртөө бүрдүүлэн цогцлож байж, бас тэдгээрийн ачаар мөн дурдсан гэм буруу, алдаа дутагдлаас ангид байж сая мэргэжлийн жинхэнэ улс төрч болж чадна гэсэн үзэл санааг гол болгож өгүүлжээ.

XII

Улс төрийг мэргэжлээ болгосон улс төрч нь улс төрийн зорилго, зорилт, үүрэг ба хариуцлага, тэдгээрийн цогц нийлбэр бүхий улс төрийн ёс зүйтэй байнгын уяатай байдаг тухай асуудлыг, нэг үгээр хэлбэл ёс зүй ба улс төр хоёрын харилцааг М.Вебер бүтээлийнхээ төгсгөл хэсэгт чухалчлан авч үзсэн байна. Түүний логикийг товч өгүүлье.

Нэн түрүүнд ёс зүй ба улс төр хоёр хоорондоо нягт харилцаатай гэдгийг хүлээн зөвшөөрөх, тэгэхдээ түүнд тодорхой хандах хэрэгтэй. Гэр бүлийн амьдрал, албан болон аж ахуйн харилцаа, нөхөрлөл, өрсөлдөөн, улс төрийг зохицуулдаг түгээмэл, нэгдмэл нэг ёс зүй байх аргагүй. Улс төр бол хүчирхийллийг гол хэрэгсэл болгосон нэн нарийн ээдрээтэй үйл ажиллагаа бөгөөд ер түүний зорилго ба түүндээ ашигладаг хэрэгсэл хоёрын харьцаа ихээхэн зөрчилтэй, бүр эсрэг тэсрэг ч байдаг. Тиймээс улс төрд тавигдах ёс зүйн шаардлага буюу улс төрийн ёс зүй өвөрмөц онцлогтой болно.

Ёс зүйн баримжаатай аливаа үйлдэл нэг бол “итгэл үнэмшлийн ёс зүйд”, аль эсвэл “хариуцлагын ёс зүйд” захирагддаг. Үүнийг итгэл үнэмшлийн ёс зүй хариуцлагагүйтэй адил, харин хариуцлагын ёс зүй зарчимгүйтэй адил гэсэн утгаар ойлгож болохгүй. Гэвч тэдгээрийн зарчмыг хэт туйлшруулан баримталбал, тухайлбал итгэл үнэмшлийн ёс зүйг шашны үүднээс ойлгож “Христийн шашинтан ариун журмын дагуу үйлдэж, үйлдлийнхээ үр дүнг Бурханд даатгадаг” гэсэн зарчмаар, харин хариуцлагын ёс зүйг “үйлдлийнхээ үр дагаврын өр төлөөсийг өөрөө төлөх ёстой” гэсэн зарчмаар баримтлан үйлдвэл эдгээр ёс зүйн хооронд гүнзгий эсрэг тэсрэг чанар бий болно. Жишээлбэл, шашны, эсвэл туйлын хийсвэр ёс зүйн номлол, зарчим, аль эсвэл ямар нэгэн итгэл үнэмшлээр үйлдэл хийсэн хүн хэрэв түүнийх нь үр дагавар булай муу болбол түүний хариуцлагыг өөрөө хүлээхгүй, харин ертөнц, бусад мунхаг хүмүүс, эсвэл хүмүүсийг тийм мунхаг болгож бүтээсэн бурханд тохно. Харин хариуцлагын ёс зүйг баримтлагч хүн үүний эсрэгээр үйлдлийнхээ үр дагаврыг өөрөө хариуцна.

Итгэл үнэмшлийн болон хариуцлагын ёс зүйн хоорондын зөрчил, бүр эсрэг тэсрэг ялгаа, ер нь улс төрийн ёс зүйн асуудал улс төрийн зорилго ба түүний хэрэгсэл хоёрын харьцаанаас ургаж гарна. Итгэл үнэмшлийн ёс зүй дангаараа, ялангуяа түүнийг шашны үүднээс ойлгож туйлшруулан баримтлах явдал улс төрд нийцэхгүй. Учир нь эл ёс зүй үйл ажиллагааны зорилго ч, түүний хэрэгсэл ч буяныг эрхэмлэсэн, хүнлэг байх ёстой гэж номлодог. Тухайлбал түгээмэл хайрыг номлодог аксиоматик ёс зүй “хацар дээр чинь алгадахад чи нөгөө хацраа тавьж өг !”, эсвэл “Хор нүглийг хүчирхийллээр бүү эсэргүүц !” гэж номлодог.

Гэтэл улс төр өөрийн уг чанараараа нэг ёсны шулмын хүч болох хууль ёсны хүчирхийллийг хэрэгсэл болгохыг шаарддаг бөгөөд хэрэв улс төрч үүнийг эс хайхравал улс төр, түүний зорилго хохирно. Тиймээс өөртөө болон бусдад сэтгэлийн аврал эрэгчид буюу сүсэгтэн, лам хуврагууд улс төрийн зам дээр буяны мөр хөөх аргагүй гэдгийг ухаарвал зохино. Харин улс төр эрхлэх, түүнийг цорын ганц мэргэжлээ болгохыг хүссэн хэн хүн улс төрийн уг чанар, түүнээс ургаж гарсан улс төрийн ёс зүйн гаж мэт хачирхалтай зөрчилт чанарыг болон тэдгээртэй уялдаатай улс төрийн хариуцлагыг гүнзгий ойлгож ухамсарласан байх ёстой. М.Вебер үүнийг нэн онцлон сануулж “Тэрбээр (улс төрч.-Ж.Ж) хүчирхийллийн үйлдэл бүхэнд өөрийг нь отоож байдаг шуламын хүчтэй ширэлдэн орооцолдоно гэдгийг би дахин хэлье” гэжээ(1,703).

М.Вебер улс төрийг хариуцлагын ёс зүйгээр хийдэг гэж үзэхдээ түүнийг итгэл үнэмшлийн ёс зүйд туйлын байдлаар сөргүүлж тавиагүй, энэ хоёр нь улс төрийн бодит практик дээр бие биеэ харилцан нөхөж жинхэнэ хүнийг, “улс төрд хувь зохиолтой” байж болох хүнийг бүрдүүлнэ гэж үзсэний дээр ер нь улс төрд зүтгэсэн хүнд сэтгэлийн дотоод тулгуур, “Би үүнээс өөрөөр байж чадахгүй, ингэх л ёстой” гэж хэлэх итгэл бишрэл хэрэгтэй гэжээ.

М.Вебер энэхүү лекцээ товхимол болгож нийтлүүлсэн 1919 оны үеийг давшин ирсэн харгислалын үе бөгөөд тэр нь хэд хэдэн шалтгаанаар цөөнгүй жил ноёрхож болох юм, ер нь биднийг ойрын ирээдүйд түүхэн нөхцөл, улс төрийн амьдрал, үйл явдлын хувьд дэлгэр зун биш, харин мөсөн хучлагат хүйтэн манан, хахир хатуу туйлын шөнө угтана. Ийм нөхцөлд улс төрчдөд нэн өндөр шаардлага тавигдаж, түүхэн том үүрэг ногдно гэсэн санаа бодол хэлж түүнийгээ: “Улс төр бол чин эрмэлзэл ба хүйтэн нүдэн баримжаа хоёрыг хамтатган гүний хатуу царцдасыг хүчтэй, аажим өрөмдөх өрөмдлөг

юм. Энэ санаа ерөнхийдөө зөв бөгөөд хэрэв ертөнцөд боломжгүй зүйл өөд дахин дахин тэмүүлээгүйсэн бол боломжтой зүйлд хүрч чадахгүй байх байсныг бүхий л түүхэн туршлага баталж байна. Ингэж чадах хүн жолоодогч байх ёстой, түүгээр ч үл барам тэрбээр үгийн хамгийн жирийн утгаар басхүү баатар байх ёстой. Удирдагч ч биш, баатар ч биш байлаа гэхэд, хамаг найдвар нь нурсан ч үл дийлдэх сэтгэлийн хатаар өөрийгөө зэвсэглэх ёстой. ... Болж бүтэхгүй бүхнийг сөрөн зогсож: “Тэлээ ч гэсэн !” гэж хэлж чадах тэр хүн л улс төрд “мэргэжлийн хувь зохиотой байна” гэсэн үгээр илэрхийлэн бичиж зохиолоо төгсгөжээ.

Ашигласан ном зохиол

- Вебер.М.*, Избранные произведения. Перевод с немецкого. М., “Прогресс”, 1990
- Макс Вебер.*, Улс төр бол мэргэшил мөн. Шинжлэх ухаан бол мэргэшил мөн. Орос хэлнээс орчуулсан Ү.Нямдорж. УБ.,2000
- Макс Вебер.*, Улс төр бол хувь зохиол бөгөөд ажил мэргэшил мөн. Орос хэлнээс орчуулсан Ө.Дашлхүндэв. УБ.,2010
- Гайденок П.П., Давыдов Ю.Н.* История и рациональность: Социология М.Вебера и веберовский ренессанс. М., Политиздат, 1991
- Ожиганов Э.Н.*, Политическая теория Макса Вебера. Критический анализ. Рига “Зинатне”, 1986
- Социологийг үндэслэгч суутнууд.* Их, дээд сургуулийн оюутан, социологи эрхлэн суралцагчдад зориулсан гарын авлага. УБ.,2006.
- Bruun, Hans Henrik.*, Science, values, and politics in Max Weber's methodology. Rethinking classical sociology. 2007
- Wolfgang J. Mommsen.* The Political and Social Theory of Max Weber: Collected Essays. University of Chicago Press. 1992
- H.H. Gerth and C. Wright Mills* (Translated and edited), From Max Weber: Essays in Sociology, pp. 77-128, New York : Oxford University Press, 1946.

МОНГОЛ ДАХЬ СОЦИАЛ ДЕМОКРАТ ҮЗЭЛ СУРТЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА

Ц.ГАНБОЛД¹, Ц.БАТБОЛД²

¹МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, профессор

²МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, дэд профессор

Түлхүүр үг: Үзэл суртал, үзэл санаа, үнэт зүйлс, үйл ажиллагааны хэв маяг, үзэл суртлын спектр, социал демократ, тэгш эрх, ижил боломж, нийгмийн ардчилал, ардчилсан социализм, либерализм, таленизм.

ABSTRACT: In this article, it will consider political party's pragmatic approach, political ideology, ideal system, value system and political activities system's briefly meaning and it aims to identify Social Democratic ideology's present and future direction. In this framework, it explains and specifies the Social Democrat and its ideology and their status in the society and its reason of pragmatic approach and characteristics.

It considers the political parties' responsibility on their activity and cause of their pragmatic approach. It considers briefly and specifies Mongolian Social Democratic and its ideology and present and future situation. Finally, it aims to give an interpretation to the ideology and its future ideology.

ТОВЧ ХУРААНГУЙ: Улс төрийн намуудын прагматик хандлага, улс төрийн үзэл суртал, үзэл санааны систем, үнэт зүйлсийн систем, үйл ажиллагааны систем зэргийг тодруулан социал демократ үзэл суртлын өнөө ба ирээдүйн хандлагыг тодруулахыг зорьсон.

Өнөөгийн Монголын улс төрийн амьдралд улс төрийн намууд ба тэдгээрийн үзэл суртлын чиг баримжааны тухай асуудлууд судлаачдын төдийгүй, олон нийтийн анхаарлыг татаж байна. Өмнөх сонгуулийн үр дүнгүүд нь улс төрийн намын мөрийн хөтөлбөр, үзэл баримтлалыг сонгогчид ихээхэн анхаарах болсоныг төдийгүй, Монголын ардчилал, түүний сонгогчдын улс төрийн мэдлэг, соёл нилээд ахисаныг харуулж байна. Энэ нь улс төрийн намуудын зүгээс нийгмийн гишүүдийн үзэл санаа болон намын үзэл сурталд тулгуурлан үзэл баримтлалаа оновчтой боловсруулсан улс төр, нийгмийн хөтөлбөр гаргахыг шаардаж буй хэрэг юм. Орчин үед улс төрийн намуудын үзэл суртлын хандлага тодорхой бус байх нь түгээмэл болсон.

Улс төрийн үзэл суртал нь өмнөх болон цаг үеийн сэтгэгчдийн онол, сургаал дээр тулгуурласан ертөнцийг үзэх үзлийн систем юм. Энэ үзэл нь тодорхой эрхэмлэх үнэт зүйлс дээр тулгуурладаг. Үнэт зүйлст тулгуурласан үзлээрээ хүмүүс амьдралын үзэл баримтлалаа тодорхойлон, бодлого зорилгоо төлөвлөж үйл ажиллагааныхаа чиг хандлагыг тогтооно. Улс төрийн намын үзэл суртал нь түүний улс төрийн чиг баримжаа, бодлого зорилго, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг бий болгодог. М.Веберийн үзсэнээр “үзэл суртал бол шинжлэх ухаан дахь шинжлэх ухааны бус хандлага” юм. Өөрөөр хэлбэл, үзэл суртал нь шинжлэх ухаанаар нотлогдоогүй, батлагдаагүй мөрөөдлийн шинжтэй итгэл үнэмшлийн систем байж болох бөгөөд үл

гүйцэлдэх шинжийг агуулж байдаг. Энэ талаар З.Фрейд үзэл суртлыг төсөөлөл (трансцендент)-ийн шинжтэй хоосон зүйл гэж үзжээ. К.Мангейм түүхийн явцад хүмүүс бодит байдлын зуршмалаас илүү трансцендент хүчин зүйлийг баримжаалдаг гэж хүлээн зөвшөөрсөн байна. Гэсэн хэдий ч үзэл суртал шинжлэх ухааны онол, практикийн мэдлэгт үндсэндээ тулгуурладаг. Тухайлбал, амьдралын явцуу туршлагын хүрээнээс гарч буй өчүүхэн ч атугай үзэл санаа, төсөөллийг хүртэл үзэл сурталд хамруулан системчилсэн байдаг. Энэ утгаараа үзэл суртал нь хүний эрх, эрх чөлөө, улс төрийн эрхээс гадна, эдийн засагт тулгуурласан нийгмийн хөгжлийн ирээдүйн чиг хандлага, хүний ахуй амьдрал, ёс суртахуунт харилцааны үндсийг тодорхойлж байдаг. Аливаа үзэл суртал нь нийгмийн хөгжил, хувьслыг даган шинэчлэгдэж байх бөгөөд эс тэгвэл уг үзэл нийгмийн суртал оюун санааны хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй.

Орчин үед үзэл суртлын үнэт зүйлсийг тодруулан гаргахад хэцүү, бараг боломжгүй мэт харагддаг. Янз бүрийн элементээс бүрдсэн хоорондоо олон талаар холбогддог, тодорхой хязгаарлалтгүй, замбараагүй хэлхээ холбоотой сүлжилдсэн (ризому) тийм үнэт зүйлс шууд нарийн тодорхойлолт өгнө гэдэг бараг боломжгүй санагдана. Гэвч аливаа үзэл суртал бол тодорхой үнэт зүйлс дээр хатуу төвлөрч тулгуурласан иерархи систем байдаг. Өөрөөр хэлбэл, өмнөх үеийн сэтгэгчдийн тодорхойлон гаргасан мөнхийн асуудал мэт цөөн тооны гол үнэт зүйлсэд тулгуурлана гэсэн үг юм. Ихэнх үнэт зүйлс хувирамтгай, тогтворгүй шинж чанартай байдаг. Үүнийг туслах үнэт зүйлс гэж үзэж болно. Гол төвлөрсөн үнэт зүйлсийг тойрон олон төрлийн хувьсамтгай, тогтворгүй болон харьцангуй тогтвортой үйл ажиллагаа явагдана. Энэ нь үзэл суртал, түүний уялдаа холбоог системтэй авч үзэх боломжийг нээж өгдөг. М.Вебер, К.Мангейм, Э.Дюркгейм нар үзэл суртлыг хувь хүнийг болон нийгмийн бүлгийг үйл ажиллагаанд татан оруулах сэдэл болдог субъектив шинжтэй үнэт зүйл гэж үзсэн байна.

Плюрализмын мөн чанар болох далайн орнуудын буюу шинээр суурьшсан Атлантизмын үнэмлэхүй төв нь либерал ардчилал байх бөгөөд Евроазийг бодвол, уламжлагдаж ирсэн түүх, соёл, шашин, зан заншил, ёс суртахууны суурь үнэт зүйлс багатай, өөрчлөгдөн шинэчлэгдэгч дэвшлийн шинжтэй гэж үздэг. Евроазийн хувьд олон мянган жилээр уламжлагдаж ирсэн суурь үнэт зүйлсийн нөлөөг даван туулахад бэрхшээлтэй байдаг аж. Уламжлагдаж ирсэн консерватив үнэт зүйлс нь хүн төрөлхтний түүхэн хөгжлийн олон мянган жилийн туршлагаар баталгаажсан байдаг нь цаг үеийн хувьсал өөрчлөлтийг даван өөрийн мөн чанараа хадгалах чадвартай гэж үздэг байна. Үүний зэрэгцээ нийтийн сайн сайхныг гол үнэт зүйлээ болгосон зүүний чиглэлийн социалист чиг баримжаатай үзэл суртлын хандлага хүчтэй байдаг. Үзэл суртлын эдгээр ерөнхий чиг хандлагууд орчин үеийн нийгэмд улс төрийн намын үзэл баримтлалын олон талт хандлага, зорилгыг бүрэн илэрхийлж чадахгүй хэт прагматик байна гэж зарим судлаачид үздэг.

Орчин үеийн улс төрийн намуудын үзэл баримтлалын хандлага үзэл суртлын үнэт зүйлсийг хатуу баримтлахын оронд тухайн нөхцөлд тохируулан үзэл баримтлалаа тодорхойлох болсон байна. Г.Шелдон “Т.Жефферсоны улс төрийн философи” гэдэг номондоо Жефферсон либерал ба бүгд найрамдахчуудын үзлийн алийг нь илүү баримталж байсан бэ гэдэгт судалгаа хийжээ. Тухайн номд дурдагдсан түүхэн баримтуудад тулгуурлавал Жефферсон либерал үнэт зүйлсд илүү ханддаг байсан нь харагддаг хэдий ч тухайн нөхцөл байдалд консерватив үнэт зүйлсийг илүү баримтлан шийдвэр гаргадаг байжээ. Энэ нь үзэл суртлын үнэт зүйлс ба үзэл баримтлалын хоорондох ялгааг харуулж буй баримт юм. Өөрөөр хэлбэл, тухайн үзэл суртлын үнэт зүйлсийг дэмждэг хэдий ч нөхцөл байдалд тохируулан өөр үнэт зүйлсийг сонгон авч хэрэгжүүлэх явдал бол тодорхой цаг хугацааны хувьд үзэл баримтлал, хандлагаа тодорхойлж буй үйл явц юм.

Орчин үеийн улс төрийн намуудын үзэл баримтлалын хандлага дараах хүчин зүйлстэй илүү холбоотойгоор адилсах шинжтэй хөгжиж байна. Үүнд:

Нэг. Дундаж сонгогчдын хүсэл, сонирхлыг харгалзан үзэх. Ардчилсан дэглэмтэй ихэнх улс оронд ерөнхийдөө сонгогчдын хоёр туйл, хоёр намын ээлжилсэн ноёрхол тогтох нь түгээмэл байна. Сонгогчдын 30-40 орчим хувь нь ойролцоогоор 2-9 хувийн ялгавар, бага зэргийн хэлбэлзлэлтэйгээр хоёр туйлд тэнцүү шахуу хуваагддаг. Ийм нөхцөлд намуудын улс төрийн үзэл баримтлалын чиг баримжаа тэдгээрт үл хамаарах дундаж сонгогчдын хүсэл сонирхлыг хангахад чиглэсэн улс төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх хандлагатай байдаг нь тэдний үзэл баримтлалын ялгааг бүдгэрүүлж, хоорондоо ялгагдах шинж чанарыг нь багасгадаг байна.

Хоёр. Ардчилалын ерөнхий үнэт зүйлсийг харгалзан үзэх. Энэ хандлага аль ч улс төрийн намуудад чухлаар тавигдаж байна. Ардчилал гэдгийг А.Линкольн “Ард түмний төлөөх, ард түмний өөрийнх нь байгуулсан, ард түмний засаглал” гэж тодорхойлсон бол, М.Вебер “Ардчилал бол ард түмний засаглалыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл” гэж тодорхойлсон байдаг. Ардчилсан дэглэмтэй улс оронд ардчилсан засаглалын ерөнхий үнэт зүйлсийг улс төрийн бүх намууд хүлээн зөвшөөрч түүнийг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Гэвч ардчиллын ерөнхий үнэт зүйлсийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл, механизмын хувьд намууд өөр өөрсдийн үзэл баримтлал, хандлагаар зөрчилдөх нь зайлшгүй бөгөөд үүнд л ардчилсан улс төрийн институцийн мөн чанар оршиж, тэдний сонирхлыг хэлэлцүүлэх, тэнцвэржүүлэх, зөвшилцүүлэхэд чиглэгддэг. Ардчиллын ерөнхий үнэт зүйлсийг тойрсон тэдгээр үзэл баримтлалууд нь засаглал болон захиргааны институцийн тогтолцооны зөрчил, зөвшилцлийг иргэний нийгмийн тусламжтайгаар шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай тулгардаг байна. Гэхдээ ардчилсан засаглал болон захиргааны институцийг зохистой тогтоох зорилго нь улс төрийн намуудын үзэл баримтлалыг хоорондоо ялгаатай ч нэг чиглэлд хандуулж байна.

Гурав. Үндэсний сэргэн мандлын төлөөх зорилго. Энэ нь улс төрийн намуудыг зарим тодорхой нөхцөл байдлын хүчин зүйлсийг хүлээн зөвшөөрөхөд хүргэснээрээ хооронд нь үзэл баримтлалын хувьд тодорхой хэмжээнд адилсуулдаг байна. Даяаршил болон үндэсний эрх ашгийн хүчин зүйлсийг харгалзан үзсэнээр тодорхой асуудлуудад улс төрийн намуудын үзэл баримтлалын нэгдэл бий болж байна. Өнөөгийн ертөнцөд ямар ч улс орон, бусад улс орнуудтай нийгэм, эдийн засаг, соёл, боловсрол, байгал орчин зэрэг олон талын харилцан хамааралтайгаар оршин тогтож, хөгжих нь улам зайлшгүй болсоор байна. Ийм нөхцөлд тухайн улс орны үндэсний эрх ашиг, аюулгүй байдлын асуудлууд, тэдгээрийн улс төрийн намуудын үзэл баримтлалыг уг чиглэлд нэгдсэн байр суурь руу илүү ойртуулж байна.

Дөрөв. Олон улсын харилцааны дэг журам. Глобальчлал, мэдээллийн зууны эрин үед улс төрийн намууд олон улсын эрх зүй, түүний хууль дүрмүүд, мэдээллийн давалгааг хүлээн авах, зохицуулах, даван туулах улс, үндэстний эрх ашгаас гадна олон улсын харилцааны дэг журмыг баримтлах үүднээс нэгдмэл байр суурь баримтлахад хүргэж байна.

Тав. Дэлхийн эдийн засгийн либералчлал, чөлөөт зах зээл. Дэлхий даяарх эдийн засгийн либералчлал, зах зээлийн өрсөлдөөнд нэг хэсэг улс орнууд давуу байр сууриа хадгалах, нөгөө хэсэг нь тэдний хэмжээнд очихын тулд эрчимтэй зохицуулалт хийх, гурав дахь хэсэг нь дэлхийн зах зээлд өөрийн байр сууриа олох, тогтоох зорилго тавьж байгаа нь тэдгээр орнуудын улс төрийн намуудын үзэл баримтлалыг тодорхой нэг чиглэлд төвлөрүүлэх эдийн засгийн хэрэгцээ сонирхлыг бий болгож байна.

Бүдүүвч 1. Дэлхийн эдийн засгийн нөөц баялагийг эзэмшиж буй үзүүлэлт



Хөгжингүй капиталист орнууд: 20 гаруй улс
 Хагас хөгжилтэй орнууд: 70 гаруй улс
 Буурай хөгжилтэй орнууд: 130 гаруй улс



Эх сурвалж: Ц.Батболд. Үзэл суртал ба Улс төрийн намууд. Орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны хөгжил хандлага. №01. УБ., 2010. х 22-38.

К.Марксын “Капитал”-д даяар капитализмын мөн чанарыг дээрх байдлаар “үйлдвэрлэлийн хэрэгслэлийг өмчилсөн мөлжлөгийн хэлбэр” хэмээн тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, тэрээр иерархийн дээр буй хөгжингүй улс орнууд доод хоёр шатны улсуудыг, дунд шатных нь доод шатаа цэрэг-улс төр, эдийн засгийн аргаар мөлждөг гэж үзжээ. Тухайн цаг үед олон улсын эрх зүйн өнөөгийн түвшин байгаагүй, колонийн систем ноёрхож, “хүчтэний зөв, хүчгүйн буруу” гэдэг хууль олон улсын дэг журамд үйлчилж байсан зэрэг нь уг дүгнэлтэд хүргэхэд нөлөөлсөн. Гэвч орчин үед ийм шинж чанар харьцангуй буурсан ч бүрэн үгүй болсон гэж үзэх үндэсгүй юм. Тухайн улс орнуудын эдийн засгийн ашиг сонирхол тэдгээрийн улс төрийн намуудын үзэл баримтлалыг нэг шугаманд аваачих үндэслэл болно.

Зургаа. Үзэл суртлын давхцал болон өөрчлөлтөөс хамаарсан адилсал. 1970-аад оны нефтийн (эрчим хүчний) хямралаар неолиберал үзэл суртал төрийн оролцоог ихэсгэж, зүүний үзэл баримтлалыг авах болсон гэж шүүмжилж, үүний эсрэг сонгодог либерал үнэт зүйлсийн заримыг сэргээн авах маягаар консерватив үзэл суртал шинэчлэгдэн неоконсерватизм гарч иржээ. Неоконсерватив үзэл суртал төрийн оролцоог хязгаарлах, төрийн өмчийг хувьчлах, үр ашигтай цомхон, хүчтэй төрийн тухай үзэл баримтлалыг тунхаглан, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх болсон байна. Шүүмжлэгдсэн неолиберал үзэл сонгодог либерал үзлийн суурин дээр дахин шинэчлэгдэж, либертарианизм болон ХХ зууны эцсээр гарч иржээ.

Долоо. Ангийн ялгаа ач холбогдлоо алдсан. Нийгмийн хөгжлийн явцад анги бүлгүүдийн социал ялгаа буурч, давхраажилтын хооронд шилжих хүмүүсийн шилжилт чөлөөтэй буюу өөрсдөөс нь шалтгаалах болсноор үзэл суртлын үнэт зүйлсд шилжилт өөрчлөлт, давхцал гарах болсон байна. Үзэл суртлын давхцал болон өөрчлөлтөөс хамаарч “орчин үеийн хөгжингүй нийгэмд анги нь өөрийн учир холбогдлоо алдсан хэмээн зарим эрдэмтэд үзэж байна. Бүтэн хагас зууны тэртээ аж үйлдвэрийн капитализм үүсч байх тэр үед ангийн ялгаа онцгой утга агуулгатай байсан гэдэгтэй тэд санал нийлдэг. Түүнчлэн Марксын онолд хамгийн их шүүмжлэлтэйгээр ханддаг хүмүүс хүртэл ядуу хөдөлмөрчид болон ажил олгогч баячууд, үйлдвэрийн эздийн хооронд жигшмээр зөрчилдөөн бодитойгоор оршин байсныг хүлээн зөвшөөрдөг.

Бүдүүвч 2. Нийгмийн давхраажилт



Эх сурвалж: Ц.Ганболд, Ц.Батболд. “Нийгмийн ардчилалын үзэл баримтлал: Өнөө ба ирээдүй Монголд” ЭШ-ний бага хурлын илтгэлээс.

Гэхдээ тэр цагаас хойш үйлдвэржсэн орнуудад материаллаг тэгш бус байдал ихээхэн багассан. Баячуудын эсрэг чиглэсэн татварыг ядуу болон хөдөлмөрийн чадваргүй хүмүүст олгох тэтгэмжтэй хослуулснаар дээдэс доодсын хоорондох ялгааг багасгасан. Түүнээс гадна боловсрол нийтэд хүртээмжтэй болсноор авьяас чадвартай хэн бүхний өмнө нийгмийн болон эдийн засгийн шатлалын оргилд хүрэх зам нээлттэй болсон хэмээн нотолж байна. Үүнийг Гидденс “үнэндээ дээрх дүр зураг үнэн байдалтай огт нийцэхгүй. Ангийн ялгааны нөлөөлөл Марксын бодож байснаас арай багассан байж болох боловч, социал амьдралын тун цөөхөн хүрээ л түүнд хөндөгдөлгүй үлдсэн”¹ гэж шүүмжилсэн байдаг.

Дээрх ерөнхий долоон гол хүчин зүйлс улс төрийн намуудын үзэл баримтлалыг улс орныг удирдахад илүүтэй чиглэгдэж буйг илэрхийлж байгаа нь улс төрийн намын хөгжлийг “catch all” ба “картель” намуудын хэв маяг руу чиглүүлсэн ажээ. “Catch all” ба “картель” намууд нь нийгмийн хэсэг бүлэг, аль нэг социал давхрагын эрх ашгийг хангахыг эрмэлзэхээс татгалзаж, нийгмийн бүх давхрагын эрх ашгийг зохицуулах “өргөн хүрээтэй бодлого” (catch all намын мөн чанарын нэг)-ыг өөр өөрсдийн үзэл суртлын үнэт зүйлст тулгуурлан боловсруулахад бусад намуудын үзэл бодлыг “харгалзан үзэж зохицуулах”(картель намын мөн чанарын нэг)-ыг илүүд үзэх болжээ. Энэ хандлага нь нэг талаар орчин үеийн улс төрийн намуудын зорилгоо хэрэгжүүлэх байр суурийг илүү прагматик тал руу шилжүүлж, үзэл суртлын чиг баримжаа, хатуу үнэт зүйлс, үйл ажиллагааны хэв маягийг бүдэгрүүлэхэд хүргэжээ. Уг хандлага нь улс төрийн намуудыг үзэл сурталгүй болгоно гэсэн үг биш юм. Өөрөөр хэлбэл, улс төрийн намууд үзэл суртлын хатуу үнэт зүйлст тулгуурлан туйлшралгүйгээр бусад үнэт зүйлсийг харгалзан үзэж үзэл баримтлалаа боловсруулан хэрэгжүүлэх хандлагад шилжиж байгаа бөгөөд хэрэгжүүлж буй улс төрийн бодлого, хөтөлбөрт үзэл санааны чиг баримжаа, үнэт зүйлс, үйл ажиллагааны хэв маяг нь тод бусаар ч гэсэн хадгалагдсаар байгаа юм.

Энэ утгаар авч үзвэл, улс төрийн үзэл суртлын талаар илүү тодорхой тайлбарлах шаардлага тулгарч байгаа бөгөөд өнөө үед Монголын улс төрийн намуудын гишүүд ямар чиг баримжаа бүхий үзэл суртал, үнэт зүйлсийн систем, үйл ажиллагааны хэв маягийг баримтлаж ажиллахаа ч мэдэхээ байсан тал, гишүүд төдийгүй, лидерүүдэд нь ч ажиглагдаж байна. Энэ өгүүллийн хүрээнд социал демократ үзэл суртлыг товч тодруулан авч үзэе. Албан ёсоор социал демократ үзэл суртлыг өөрийн чиг баримжаагаа болгосон улс төрийн нам Монголд хоёр байдаг бөгөөд бусад олон намууд ч энэ чиг баримжааг удирдлага болгож байгааг үгүйсгэх аргагүй юм.

Социал демократизм гэдэг нь амьдралын бүх салбар дахь тэнцүү эрх чөлөө нь эв нэгдэл ба нийгмийн байгуулалтаар хэрэгждэг улс төр, нийгмийн хэв журмын зарчим юм. Социал демократ үзэл суртал нь ямар нэг байр суурийг ягштал догматик маягаар барьдаггүй хөгжил өөрчлөлт бүхэнд зохицуулан өөрчлөгддөг онцлогтой. Социал-демократууд эхний үед марксизмын хувьсгалт үндэслэлүүдийг баримталж байв. Социал-демократ чиглэлийн намууд парламентын намууд болж тэдгээрийн цаашдын хөгжил нь алхам алхамаар марксизмаас холдон хөндийрч хуучин байгууллыг үндсээр нь устгах, пролетарийн диктатур тогтоох, ангийн эвлэршгүй тэмцэл, хуучин дэглэмийг түлхэн унагаах хувьсгалт ганц арга замын тухай заалтуудаас татгалзах болжээ.

Нийгмийг эрх чөлөө, тэгш байдал, эв нэгдлийн үндсэн дээр өөрчлөн шинэтгэх тулгуур санааг Германы социал-демократ Э.Бернштейн санал болгожээ. Тэрээр 1899

¹ А.Гидденс. Социологи. УБ., 2006. Х 167-169.

онд хэвлүүлсэн “Социализмын асуудлууд ба социал-демократын зорилт” хэмээх номондоо К.Марксын нэмүү өртгийн онол, ангийн тэмцлийн тухай сургаал, мөн коммунист нийгэм эдийн засгийн байгууллын тухай марксист үндэслэлүүд хөгжилтэй капиталист орнууд, тухайлбал Германд болж байгаа бодит үйл явцтай зөрчилдөж, хэрэгжих чадваргүйгээ харууллаа гэж өгүүлжээ. Иймд “хөдөлгөөн л байвал боллоо, эцсийн зорилго юу ч биш” гэсэн дүгнэлт хийжээ. Гэвч энэ номлолыг социал демократчуудын цөөнх нь хүлээн зөвшөөрч, олонх нь К.Каутский, Р.Гильфердинг зэрэг онолчдын тайлбарласан хэмжээнд марксизмыг хүлээн авч баримтлах болжээ.

Улмаар XX зууны эхээр ажилчны нэгдмэл хөдөлгөөнд хагарал гарахад В.И.Лениний сургаалыг тууштай баримтлагчид нь олон улсын коммунист хөдөлгөөнд нэгдэж, харин марксизмыг шүүмжлэлтэйгээр авч үзэж Э.Бернштейн К.Каутский нарын үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрөгчид нь социал-демократ урсгалд нэгджээ. XX зууны 50-иад оноос социал-демократууд марксизмаас бүрэн татгалзсан байна. Социал-демократууд 1951 онд Майн дахь Франкфуртэд Социалист интернационалыг зохион байгуулах их хурлыг зарлан хуралдуулж тус их хурлаас “ ардчилсан социализмыг” албан ёсны үзэл суртал, улс төрийн номлолоо хэмээн тунхаглажээ.

Социализмыг хэрэгжүүлэх гол нөхцөл уг нийгмийн мөн чанар бол жинхэнэ ардчиллыг нийгмийн амьдралын бүх хүрээнд хангах явдал мөн гэж социал-демократ номлол үздэг. Социализм бол социал-демократ номлолоор улс төрийн ардчиллыг тогтоож, хөдөлмөрчин, ард түмэнд улс төрийн эрх, эрх чөлөөг баталгаатай болгон, парламентын ардчилсан систем бүхий бөгөөд нийгмийг удирдах үйл хэрэгт олон түмэн идэвхтэй оролцдог “ард түмний төлөө удирдлага нь байдаг” тийм нийгэм юм. Иймд төр нь иргэдээ биш, харин иргэд нь төрөө хянах ёстой. Социал демократизм бол өмчийн олон хэлбэрийн хөгжлийг ханган, цөөнхийн гарт эдийн засгийн эрх мэдлийг хэт төвлөрүүлэхгүй байж, эдийн засгийг удирдахад хөдөлмөрчид идэвхтэй оролцох баталгааг бий болгон, байгалийн бүх нөөц баялгийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглах чадвар бүхий эдийн засгийн ардчилал төлөвшсөн нийгэм мөн гэж тэд номлодог. Орчин үед ардчилсан социализмын хөтөлбөрүүдийн нэг чухал зорилт бол хөдөлмөрчдөд хөдөлмөрлөх, боловсрол олгох, эмчлүүлэх, амрах, орон сууц, нийгмийн хангамж эдлэх эрхийг баталгаатай болгодог нийгмийн ардчилалыг тогтоох явдал юм.

Социал демократизм нь аядуу болон реформын аргаар ардчилсан социализм тогтоохыг зорилгоо болгож, нийгмийг бүхэлд нь ардчилах үзэл санаанд тулгуурласан үзэл суртал юм. Өөрөөр хэлбэл, нийгмийн ардчилал бол капиталист эдийн засгийн хүрээнд халамжийн төр болон хамтын хэлэлцээрийн олон талт дэг журам бүхий бодлого юм. Энэ хэв маягт ихэнхдээ XX зууны сүүлийн хагасын Хойд Европ болон Баруун Европын социалист, социал демократ намууд төр барьж байсан улс орнуудын нийгмийн загвар, эдийн засгийн бодлогыг хамруулдаг.

Социал демократ намууд олон жил төр барьж байсан Скандинавын орнуудад “хөгжингүй бусад орныг бодвол бүх нийтийн сайн сайханыг бүрдүүлсэн нийгэм байгуулах зорилтыг зах зээлийн холимог эдийн засагтай зүй зохистой хослуулснаараа онцлог юм.² Ингэхдээ хүний үндсэн эрхийг хангах, хувь хүний бие даасан байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн либерал хандлагыг хүлээн зөвшөөрдөг төдийгүй эдийн засгийг тогтвортой байлгахад голлон анхаарах үүднээс өмчийн олон хэлбэрийг ч хүлээн зөвшөөрдөг байна. Тэдгээр орнуудад ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэх, хүйсийн тэгш байдлыг хангах, өргөн хүрээтэй тэтгэмжийн түвшин, дахин хуваарилалтын өндөр хэмжээ, өргөтгөсөн төсвийн бодлогын чөлөөт байдал, эрүүл мэнд, боловсролын асуудлуудыг шийдвэрлэхэд төрийн их үүрэг гүйцэтгэдэг.

Гол үр дүн нь:

1. Харьцангуй богино хугацаанд өндөр үр ашигтай эдийн засгийг бий болгосон.
2. Хөдөлмөрийн чадвартай бүх хүмүүсээ ажлаар хангасан.

² Б.Энхмандах. [Умардын загварын сул болон давуу талууд юу вэ?](#) /Хөгжлийн загварын тухай цуврал/

3. Ядуурлыг арилгаж, хүн амын социал ялгарлыг харьцангуй бууруулсан.
4. Дэлхийн хамгийн хөгжингүй нийгмийн хамгааллын систем бий болгосон.
5. Боловсрол, соёлын өндөр түвшинд хүрсэн.
6. Хүн амын эрүүл мэндийн хамгааллыг баталгаажуулсан.
7. Хүний амьдралын хамгийн тааламжтай орчныг бий болгож буй зэргээр харагддаг.³

Умардын орнуудад төр нь нийгмийн ардчилал, нийгмийн шударга байдлыг хангах зорилгоор үндэсний орлогыг дахин хуваарилах үүрэг хүлээдэг. Үүний үр дүнд олон хэвшилтэй, холимог эдийн засгийг нийгмийн баримжаа бүхий зах зээлтэй зохистой хослуулан нийгмийн тэгш бус байдал, баян ядуугийн ялгааг багасгаж чаджээ.

Шведэд 1980-аад оноос социал демократ намын хэрэгжүүлсэн орон нутгийн бие даасан эрхийг олгох үйл ажиллагаа өнөөдөр уг бүс нутгийн орнуудыг бүрэн хамарч (Нордик орнууд) улс төр, нийгэм, эдийн засгийн хамгийн тааламжтай загварыг бүрдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн юм. Өөрөөр хэлбэл, орон нутгийн нийгэм, эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэх төрийн ачаалал буурч, нутгийн өөрөө удирдах ёсны мэдэлд шилжүүлсэнээр шинэтгэл нь доороосоо аажмаар явагдах болсон байна.

“Шведийн улс төрийн соёлд прагматик шинжтэй зөвшилцөл давамгайлдаг. Уг соёл социал демократуудын манлайлалтай холбоотой. Тухайлбал, 1990-ээд оныг хүртэл бүх намууд ажлын байраар хангах бодлогыг тууштай баримталсан. Мөн тус орны улс төр, соёлд манлайлах байрыг эзэлдэг “ардын өлгий” хэмээх ойлголтын цаана өргөн хүрээтэй зөвшилцөл агуулагдаж байдаг. Нийтийн сайн сайхны төлөө олон нийтийн амьдралын төвшинг дээшлүүлэх өргөн хүрээтэй нийгмийн хөтөлбөрүүдийг нийгэм санал нэгтгэйгээр дэмжиж байдаг. Хэдийгээр Шведийн улс төрийн соёлд нийгмийн ардчиллын үзэл санааг тууштай дэмждэг уламжлал хэвээр боловч ард түмний парламентдаа итгэх итгэл буурсаар байна.”⁴

1990 оноос МАН коммунист үзэл баримтлалаас татгалзаж, үзэл баримтлалдаа өөрчлөлт оруулах зорилго тавьсан. Энэ зорилгоор 1990.IV сард МАН Онц Их хурлаараа хүнлэг ардчилсан социализмыг байгуулахыг зорьсон марксист-ленинист үзэл санаа, арга зүйг бүтээлчээр хэрэгжүүлэх үзэл баримтлалтай улс төрийн байгууллага байх болно” гэж анх тодорхойлсон. Гэвч түүнээс хойш арван сарын сарын дараа хуралдсан XX Их хурал /1991.II/ “шинжлэх ухааны социалист үзэл санааг баримталсан ардын ардчилсан нам байх болно” хэмээн заажээ. Өөрөөр хэлбэл, марксист-ленинист үзэл санаа, арга зүйг бүтээлчээр хэрэгжүүлнэ гэдгээ “шинжлэх ухааны социалист үзэл санаа” болгон өөрчилжээ. Энэ Их хурлаас хойш 5 сарын дараа болсон Намын Төв Хорооны II бүгд хурлаас “өөрчлөлт, хөгжил, хувьслын шаардлагаар манай нам ард түмнийхээ язгуур эрх ашгийг илэрхийлэн хамгаалсан үндэсний ардчилсан нам болж хөгжих нь бодит хэрэгцээ болов” гэжээ. Энэ чиг шугамыг 1992 оны II сард хуралдсан намын XXI Их хурлаар тодотгогдож “МАН үзэл бодлын хувьд үндэсний ардчилсан үзэл санааг баримтлана. Үзэл санааны онол, арга зүйн үндэс нь төв ёсны номлол юм” гэсэн томъёололыг гаргасан байна.

1997 онд хуралдсан МАН-ын XXII Их хурал “МАН бол ардчилсан социалист үзлийг онол суртахууныхаа үндэс болгосон зүүн төвийн нам мөн гэж заасан. Мөн намын XXVI Их хурлаас үүнийг тодруулж, “нийгмийн ардчилсан үзэл баримтлал бүхий зүүн төвийн нам мөн” хэмээн баталжээ. Энэ бол социал демократ үзэл гэдгийг хөрвүүлсэн агуулга бөгөөд ардчилсан социализм, социал демократ үзэл гэдгийн хооронд зарчмын ялгаа байхгүй гэдгийг илэрхийлсэн хэрэг гэж намын XXVII их хурал дээр намын дарга тайлбарлажээ. Мөн сүүлийн жилүүдэд НАМЗХ (Нийгмийн Ардчилал Монголын Залуучуудын Холбоо), НАХ (Нийгмийн Ардчиллын Хүрээлэн) зэрэг байгууллагууд байгуулагдсан буюу нэрээ сольсоноор социал демократ үзэл суртлыг нийгмийн ардчилал хэмээн орчуулан нэрлэх хандлага дэлгэрч эхэлсэн байна. Ийнхүү


³ Б.Энхмандах. [Умардын загварын сүл болон давуу талууд юу вэ?](#) /Хөгжлийн загварын тухай цуврал/

⁴ Т.Майер, Н.Врайер. Нийгмийн ардчиллын ирээдүй. УБ., 2012. х 269.

МАН Өнөөгийн ардчиллын нөхцөлд төлөвших үзэл суртлын чиг баримжаагаа тогтоосон юм. Гэвч одоогоор “социал демократ”, “ардчилсан социализм”, “нийгмийн ардчилал” гэдэг үгний хооронд төөрөлдсөн хэвээр байна.

Энэ асуудлын талаар дараах бүдүүвч 3 дээр жишээлэн тайлбарлая.

Бүдүүвч 3. Намын үзэл суртлын стратеги тактик



Нийгмийн гишүүдийн үзэл санаа - Монголын нийгмийн улс төрийн ухамсар, оюун санаанд ардчилсан үнэт зүйлс, нийгмийн ардчиллын үзэл санааны дийлэнхийг 1921-1990 онуудад коммунист засаглалын үед бүрэлдүүлжээ. Тухайлбал, үндэстэн, угсаатан, эмэгтэйчүүд болон бүх хүмүүсийн эрх чөлөө, тэгш эрх, тэгш байдал, шударга ёс, хамтын ёс (ахан дүүсийн ёс), гэр бүл, ёс суртахууны үнэт зүйлсүүд нь энэ цаг үед бий болсон бөгөөд энэ талаараа бид хөрш Хятад, Япон, Солонгосоос нилээд хол түрүүлсэн байв. Энэ үзэл санаа нь нийгмийн гишүүдэд одоо ч хадгалагдсаар байгаа бөгөөд иргэний нийгэм, иргэний хөдөлгөөний тавьж байгаа шаардлагууд ч либерал бус, нийгмийн ардчиллыг илүүтэй илэрхийлдэг. Тэд хувь хүний эрх, эрх чөлөө, явцуу эрх ашиг гэхээсээ илүүтэйгээр нийгмийн шударга ёс, нийтийн сайн сайхан амьдралыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, Монголд нийгмийн ардчиллын үзэл санааны бааз суурь сонгогчдын дунд хүчтэй хэвээр байгаа бөгөөд энэ нь ч ардчиллын жилүүдэд МАН-ыг олон жил төр барихад хүргэсэн. МАН дундаа завсартайгаар сүүлийн 16 жил эрх баригч байсан боловч, харамсалтай нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн уналт, улсын төсвөө ч бүрдүүлж чадахгүй байдал олон жил үргэлжилсэнээр нийгмийн ардчиллын зорилтуудыг хэрэгжүүлж чадаагүй. Энэ нь үзэл суртал, үнэт зүйлсийн системээ тодорхойлж чадаагүй удсантай ямар нэг хэмжээгээр холбогдоно. Олдсон жаахан боломжууд нь явцуу сонирхол, лоббигоор хэрэгжиж ирсэнээр плураль, неопатримон болон корпоратив сонирхлууд давамгайлах хандлага ихэссэн. Мөн төсөв, хөрөнгө санхүүгийн боломж нэмэгдсэн энэ цаг үед засгийн бүх эрхийг алдаж сөрөг хүчин болсоноор бүтээн байгуулалтын их ажлыг хийх боломжийг АН-д алдсан. Энэ нь нийгмийн гишүүдийн үзэл санаанд либерал үнэт зүйлсийг дэмжих хандлагыг нэмэгдүүлэх магадлалтай юм.

Намын үзэл суртал - Социал демократ үзэл суртал. Дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нэр томьёог дураар өөрчилж, орчуулж болдоггүй. Жишээлбэл социализм гэдэг нэр томьёог нийгэм журам, эсвэл эв хамт ёс гэх мэтээр орчуулах нь түүний аль нэг шинжийг илэрхийлэх төдий зүйл юм. Харин намын нэр бол хоорондоо ялгарахын тулд социал демократ, социалист, шударга ёсны гэх мэт янз бүр байж болдог. Түүнчлэн “Нийгмийн ардчилал” нэртэй янз бүрийн байгууллага ч байж болно. Эдгээр нэр томьёо нь уг үзэл суртлын агуулгад багтаж буй үзэл санаа, үнэт зүйлсийн системчлэгдсэн нэр томьёо юм. Социал демократ үзэл суртал нь ямар нийгмийн тогтолцоог бий болгох үзэл санаа, үнэт зүйлс, түүнийг хэрэгжүүлэх арга зүйн үндсэн зорилго, чиглэлийг агуулж байдаг дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн нэр томьёо юм.

Намын үзэл баримтлал - Энэ нь нийгмийн гишүүд сонгогчдын янз бүрийн (либерал, , социалист чиг баримжаатай) сонирхолыг намын үзэл сурталтай нэгтгэн тухайн сонгуулийн хугацаанд баримтлах намын нийгэм, улс төрийн үзэл баримтлалаа тодорхойлж буй хэлбэр. Өөрөөр хэлбэл, үзэл баримтлал нь зорилгодоо хүрэх стратеги, тактик юм. 1990 оны ардчиллын үйл явц улс төр, эдийн засгийн тогтолцоонд олон урьгалч үзэл, төлөөллийн засаглал, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулсан. Энэ нь Монголд олон намын тогтолцоо, олон урьгалч үзлийг бий болгосон боловч, ардчилсан намаас бусад янз бүрийн нэртэй тэдгээр намуудын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр нь ихэнхдээ социал ардчиллыг тусгасан байдаг. Энэ нь нийгмийн оюун санаанд нийгмийн ардчиллын үзэл санаа амь бөхтэй байгаатай холбоотой. Хэдийгээр эрх баригч бай, эсвэл сөрөг хүчин болсон нөхцөлд ч социал демократизмын зорилгыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах боломж өндөр байгааг уг үзэл санаа харуулж байна. Тиймээс ч одоогийн АН-ын үйл ажиллагааны хөтөлбөрт социал демократизмын чиг баримжаа багагүй (нэн ялангуяа орон нутгийн төвшинд илүү) байсаар байна.

Намын мөрийн хөтөлбөр – Улс төрийн үзэл баримтлалын дагуу намын мөрийн хөтөлбөрийг боловсруулж, сонгуулийн кампаниар сурталчилна. Өөрөөр хэлбэл, энэ нь үзэл баримтлалын стратегийн зорилгод хүрэх зорилтууд буюу улс төрийн бодлогоо тодорхойлж буй явдал юм. Өмнөх сонгуулиудын намуудын мөрийн хөтөлбөрийг ажиглахад нэг нэгнийгээ дуурайсан хоорондоо ялгарах аргагүй, хэрэгжих боломжгүй популист амлалтуудаар дүүрэн байв. МАН-ын мөрийн хөтөлбөрийн хувьд энэ шинжийг хадгалсанаас гадна, үзэл суртлын чиг баримжааг шууд тусгасан (сонгогчдын сэтгэхүйд дасал болон итгэхээ байхад нөлөөлнө), орон нутгийн төвшний асуудлуудыг шийдвэрлэхээр амалсан хөтөлбөрүүдийг тусгасан байв. Мөрийн хөтөлбөрийн сүүлийн шинж нь орон нутгийн бие даасан эрхийг үгүйсгэн бүхнийг дээрээс шийдвэрлэх гэж оролддог коммунист дэглэмийн арга барил зарим нөхцөлд хэвээр хадгалагдаж байгааг харуулж байв. Нийгмийн ардчиллын үзэл санааны нэг гол шинж нь нутгийн өөрөө удирдах ёсны асуудал байдаг бөгөөд орон нутгийн нийгмийн асуудлыг иргэд НӨУЁБ-аар дамжуулан өөрсдөө шийдвэрлэх боломжтой байхад чиглэгддэг.


Хэрэгжүүлэх тактик - Намын мөрийн хөтөлбөр болгосон зорилтуудаа хэрэгжүүлэхийн тулд засгийн эрхийг авсан эсвэл сөрөг хүчин болсон ч хэрэгжүүлэх тактик шаардлагатай. Орчин үеийн ардчилсан засаглалтай улс орнуудад эрх баригч хүчин улс төрийн бодлого зорилгоо 100 хувь хэрэгжүүлж чадсан түүх байдаггүй. Хамгийн их амжилттай хэрэгжүүлсэн лидер бол М.Тетчер гэж үздэг бөгөөд түүний зорилтууд 50 хувиас давсан гэж судлаачид дүгнэсэн байдаг. Манайхан зорилтуудаа 95 хувь, 100 хувь биелүүлсэн хэмээн өөрсдийгөө дүгнэдэг бөгөөд бодит байдал, амьдралд тулгамдсан асуудал шийдвэрлэгдээгүй хэвээр л байдаг. 2008-2012 оны сонгуулийн жилүүдэд МАН сөрөг хүчинтэйгээ хамтран ажиллах тактик хэрэгжүүлсэнээр нийгэм, эдийн засгийн хөгжилд ихээхэн амжилт олсон. Тухайлбал, улсын төсвийн орлого 2007 онд 1295,6 тэрбум төг байсан бол, хэдийгээр 2008 оны дэлхий нийтийг хамарсан санхүү эдийн засгийн хямралын нөлөө байсан ч 2012 онд 5825,7 тэрбум төг-т хүрч ⁵4,5 дахин өссөн байна. Гадаад худалдааны нийт эргэлт 2007 онд 4064.8 сая ам.доллар байсан бол, 2011 онд 11415.9 сая ам.доллар болж ⁶2,8 дахин өссөн байна.

Дараагийн сонгууль - Улс төрчид сонгуульд мөрийн хөтөлбөрөө 100 хувь хэрэгжүүлсэн, одоо тийм бодлого хэрэгжүүлнэ хэмээн өөрсдийгөө дүгнэж, сурталчилдаг бол, сонгогчид тэдэнд бодит амьдралаараа дүн тавьдаг. Сонгуулийн кампаний үед мөрийн хөтөлбөрийн биелэлт чухал хэдий ч хүний хүсэл, шунал, сонирхол дараагийн шинэ сайхан амлалтыг илүү ихээр хардаг онцлогтой. Гэхдээ сонгуулиас сонгуулийн хооронд сонгогчид улам бүр мэдлэг туршлагатай болсоор байдаг.

⁵⁵⁵ www.iltod.gov.mn

⁶ www.iltod.gov.mn

Дээрх бүдүүвчийг арай өөр хувилбараар харвал:



Нийгмийн ардчилал- МАН-ын “ард түмнээ сонсоё” аян ард түмний хүсэн хүлээж буй 10 зорилтыг тодорхойлсон байна.

Үүнд:

1. Ашиг шимийг нь хүртдэг эдийн засгийн өсөлт
2. Алагчлалгүй, авлигагүй шударга төр
3. Аюулгүй, стрессгүй, амьдрах орчин
4. Тасардаггүй эрчим хүч, тав тухтай орон гэр
5. Танил талгүй эмнэлэгийн үйлчилгээ
6. Боловсролтой, урам зоригтой шинэ монголчууд
7. Байгалиа сэргээж, баялгаа төрөлжүүлсэн уул уурхай
8. Буянт сүрэг, газрын шим монгол бренд
9. Нэр хүндээ унагадаггүй гадаад харилцаа
10. Нийгмийн тэгш боломж, эв нэгдэл хэмээн үзсэн байна.

Ард түмний хүсэж буй эдгээр зорилтууд нь Монгол дахь нийгмийн ардчиллын үзэл санааг илэрхийлж байгаа бөгөөд социал демократ үзэл суртлын хэрэгжүүлэх ардчилсан социализмын үзэл баримтлалын суурь үндэс хүчтэй хэвээр байгааг харуулж байна.

XXI зууны босгон дээр урьд нь социал-демократ, либерал, консерваторуудын хооронд ширүүн тэмцлийн шалтаг болж байсан үзэл суртал, түүний улс төрийн чиг баримжаа ч ойртжээ. Орчин үед ардчиллын “хэмжээ хязгаар” маргааны гол сэдэв болж байна. Консерваторууд, либералууд ардчилал зөвхөн улс төрийн хүрээнд л хамаатай гэж тооцдог бол, социал-демократууд ардчилал, эрх чөлөө, тэгш эрх нийгмийн бүх хүрээнд адил тархаж, нийгмийг бүхэлд нь ардчилах ёстой гэж үздэг байна.

Социал демократ болон либерал үзэл суртал удирдлагыг төвлөрсөн бус болгож, хэвтээ удирдлагад шилжүүлэх тал дээр агуулгын хувьд ижилсдэг. Социал демократууд НӨУЁБ-ын эрх зүйн хэм хэмжээг нэмэгдүүлсэнээр төвлөрлийг сааруулж, төрийн ачааллыг бууруулдаг. Өөрөөр хэлбэл, орон нутгийн нийгэм, эдийн засаг, соёлын болон социал асуудлын ихэнхийг нутгийн удирдлага бие даан шийдвэрлэдэг байна. Либералууд иргэний нийгмийн бие даасан хүрээг дэмжсэнээр төрийн оролцоог бууруулж, төвлөрлийг сааруулан, төрийн зарим үүргийг иргэний нийгмийн болон бизнесийн байгууллагад шилжүүлдэг ажээ. Энэ хандлагаараа тэдгээр үзэл суртлын бодлого ойртож, зүүн, барууны төв үзэл гэж нэрлэгддэг.

Харин консерватив болон коммунист үзэл суртлууд нь удирдлагын төвлөрөл ба хариуцлагын асуудалд байр суурь нь төсөөтэй бөгөөд коммунистууд нийтийн эрх ашгийн үүднээс “хатуу” хариуцлага хүлээхийг, консервативчууд элитийн нийгмийн хариуцлагыг тус тус төвлөрсөн удирдлагаар шийдвэрлэхийг хүсдэг. Энд удирдлагын хэт зохицуулалт ба зохицуулалтыг хязгаарлах хоёр туйл байдгийг үзэл суртлын зүүн, баруун туйл гэж үздэг.

Либерал болон консерватив намууд давамгайлсан улс орнуудад либералуудаа зүүний, зүүн төвийн гэж, консервативуудыг баруун хэмээн нэрлэдэг.

Улс төрийн үзэл суртлын спектр Зүүн ба Баруун

Зүүн жигүүр /Либерал Тэгш эрхийг дэмждэг	Асуудлын төв	Баруун жигүүр/ консерватив Тэгш эрхийг эсэргүүцдэг
Засгийн газрын бүтцийн төвд үндэсний эдийн засагт нийгмийн халамжийн үйлчилгээ	Эдийн засаг	Капитализм нь нийгэм ба эдийн засгийн иерархи, эдийн засгийн эрх чөлөө, үйлдвэрлэлийн эдийн засаг
Дэвшил+сөрөг-соёл	Нийгэм	Уламжлал+ёс суртахууны дэг журам
Өршөөл-цагаатгал	Гэмт хэрэг	Гэмт хэрэг хийх- шийтгэл
Соёл бол тулааны талбар	Соёл	Соёлоо хамгаалах
Төр ба шашин тусдаа	Шашин	Төр ба шашин бие биеэ дэмждэг
Давуу эрх	Цөөнхийн эрх	Бүгд ижил тэгш эрхтэй
Хөдөлмөрчдийн интернационализм	Үндэсний үзэл	Иргэний сонирхлыг хамгаалах
Чөлөөт зах зээл дэмждэггүй	Олон улсын худалдаа	Чөлөөт зах зээл дэмждэг

Ардчиллын онолын үндсэн урсгалууд

Өрсөлдөөнт элитийн ардчиллын онол	Либерал ардчиллын онол	Ардчилсан социализмын онол (Нийгмийг ардчилах онол)
- Хүн бол бурхны буюу байгал, нийгмийн бүтээл - Бие хүний авьяас чадвар түүний суверенитет (олонхийг дагуулах)	-Ёс суртахууны хувьд бие даасан хувь хүн -Бие хүний суверенитет (өөртөө эзэрхэх чадвар) -Нийгэм бол хувь	-Нийгмийн хүн (бие хүн) -Ард түмний суверенитет (өөртөө эзэрхэх чадвар)

- Нийгэм бол тэгш биш - Элитийн сонирхол - Элитүүдийн сонирхлын өрсөлдөөн - Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх - Цөөнхийн эрхийг хамгаалах - Төлөөллийн ардчилал - Чөлөөт мандат - Элитүүдийн засаглал - Цөөнхийн эрхийг хамгаалахын зэрэгцээ цөөнх нь олонхидоо захирагдах	хүмүүсийн нийлбэр -Бүхний сонирхол -Сонирхлын плюрализм -Эрхийг урьдал болгох -Хүний эрх чөлөө -Хүний эрхийг урьдаар тавих -Төлөөллийн ардчилал, сонгууль -Чөлөөт мандат -Засаглал хуваарилах -Цөөнхийн эрхийг хамгаалахын зэрэгцээ цөөнх нь олонхидоо захирагдах	-Органик нийгэм -Нийтлэг сонирхол -Сонирхлын нэгдэл -Нийтийн сайн сайхныг урьдал болгох -Иргэний эрх чөлөө -Эрх, эрх чөлөөний нэгдэл -Шууд ардчилал -Императив мандат -Үүргүүдийг хуваарилах -Цөөнх нь олонхидоо захирагдах
--	--	--

Социал демократ үзэл суртал нь нийгмийн оюун санааны аажим хувьслын замаар эрх чөлөө, тэгш эрх, ахан дүүсэг ёсыг тогтоосон нийгмийг байгуулахад чиглэгддэг. Эдгээр үнэт зүйлсийн хүрээнд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн ижил тэгш эрхээр хангагдах боломжтой нийгмийн тухай асуудал юм.

Либерал болон нийгмийн ардчиллын үзэл санааны философи үндэслэл

Либерал	Социал демократ
1. Хувь хүний эрх ашиг 2. Бүлгийн эрх ашиг 3. Улс үндэстний эрх ашиг	1. Улс үндэстний эрх ашиг 2. Бүлгийн эрх ашиг 3. Бие хүний эрх ашиг

Либерал болон нийгмийн ардчиллын үзэл санааны үндсэн мөн чанар

Либерал	Үндсэн асуудал	Нийгмийн ардчилал
Төрийн оролцоог хязгаарлах	Төр	Төрийн зохицуулалт
Бүлгийн сонирхлын өрсөлдөөн	Улс төр	Нийтийн сонирхлыг нэгтгэх
Чөлөөт зах зээл	Эдийн засаг	Нийгмийн зохицуулалттай зах зээл
Эмзэг бүлэг	Нийгэм	Нийгмийн хамгаалал
Хувийн соёл	Соёл	Нийгмийн соёл
Хувийн хамгаалалт	Экологи	Төрийн хамгаалалт
Мөргөлдөөний онол	Онолын чиглэл	Системийн онол

Мөргөлдөөний онол - Нийгэм цаг ямагт өөрчлөгдөн хувьсдаг, мөргөлдөөн зөрчил ч газар сайгүй байдаг гэж үздэг. Нийгмийн хэсэг нэг бүр системийг задлах, өөрчлөгдөхөд түлхэц болдог бөгөөд нийгмийн гишүүдийн нэг хэсэг нь нөгөөг захиран тушаах үндсэн дээр нийгэм оршин тогтнодог. Энэ утгаараа либералууд нийгэм бол хувь хүмүүсийн нийлбэр учраас улс төр бол бүлгүүдийн эрх ашгийн төлөөх тэмцлийн талбар юм гэж үздэг.

Системийн онол - Нийгэм харьцангуй тогтвортой, нэгдэн нягтарсан бүтэцтэй байдаг бөгөөд нийгмийг бүрдүүлэгч хэсэг бүр системийн тогтворт байдлыг хангахад ямар нэг үүрэг гүйцэтгэдэг. Мөн нийгмийн бүтэц түүний гишүүн нэг бүрийн зөвшилцөл дээр үндэслэдэг. Энэ утгаараа социал демократууд нийгэм бол органик

нэгдэл мөн бөгөөд нийгэмшил бие хүнийг төлөвшүүлдэг, улс төр бол сонирхлын нэгдэлд тулгуурласан хувийн сонирхлыг харгалзан үзсэн нийтлэг сонирхол давамгайлах ёстой гэж үздэг.

2011 оны Давосын дэлхийн эдийн засгийн форум дээр Германы эдийн засагч Клаус Шваб капитализмын сүйрэл ойртож, либерализм мухардсаныг дурдаад, социализмыг зохиомлоор унагаасныг харамсалтайгаар илэрхийлэн, социализм болоод капитализм хоёрын дундаас аль альных нь давуу талыг авч хүн төрөлхтнийг хямрал, сүйрлээс аврах гарцын тухай санал гаргасан байна. Капитализмын сүйрлийн тухай ярихдаа тэрээр либерализм энэ бүх гай гамшгийг авчирсан гэдгийг онцлон дурьджээ. Фрайбургийн эдийн засгийн онолчид Миллиониум прожект “2011 онд Ирээдүйн төлөв” гэдэг тайландаа “дэлхийн эдийн засаг ирэх 20 жилд ямар төлөв байдалд орох тухай 35 хүчин зүйлд судалгаа хийж тайлан гаргасан байна. Уг тайланд капитализм, социализм, коммунизм бол аж үйлдвэрийн эрин үеийн эхлэлийн техникүүд байсан гэж тодорхойлжээ. Одоо мэдлэгт тулгуурласан аж үйлдвэрийн шинэ техникүүд бэлэн болж байгаа бөгөөд түүнийг *talenism* гэж нэрлэсэн байна. Шинээр буй болж байгаа таленизм нь аж үйлдвэрийн эрин үеийн анхдагч техник болох капитализм, социализмыг бүрэн устгах биш эдгээрийн суурин дээр цоо шинэ агуулгатай хөгжин цэцэглэж, хүн төрөлхтний шинэ хөгжлийн эрин үеийг эхлүүлнэ гэж үзжээ. Таленизмын тавигдаж буй шаардлага, түүний 35 элемент нь нийгмийн ардчиллын үзэл санаа, ардчилсан социализмын зорилготой олон зүйлээр таарч тохирч байна.

Өнөөдөр дэлхийн эдийн засгийг хамарч буй санхүү, эдийн засгийн хямрал, түүнээс гарах гарц нь нийгмийн баялагийн ихэнхийг эзэмшиж буй цөөнхөд нийгмийн хариуцлага үүрүүлэх буюу тэднээс авах татварыг нэмэгдүүлж, социал ялгарлыг бууруулах явдал бөгөөд энэ нь ардчилсан социализмын үзэл баримтлалд нийцэж буй хэрэг юм.

Ном зүй

- М.Вебер.* Улс төр бол хувь зохиол бөгөөд мэргэшил мөн. УБ., 2010.
Ж.Волф. Улс төрийн философи. УБ., 2012.
С.Базарпүрэв. Улс төрийн системийн онол. УБ., 2006.
Т.Майер. Социал демократ үзэл санаа ба нийгмийн ардчилал. УБ., 1999.
Т.Майер, Н.Врайер. Нийгмийн ардчиллын ирээдүй. УБ., 2012.
Х. Шмидт. Улс төрчийн сэтгэл зүрх ба хариуцлага. УБ., 2013.
Ф.Бастиа. Шударга нийгэм байгуулах сонгодог хөтөлбөр. УБ., 2007.
Г.Бамана. Шударга нийгэм. УБ., 2006.

УЛС ТӨРИЙН МАРКЕТИНГИЙН ТУХАЙ ОНОЛЫН ХУРААНГУЙ

С.БАЗАРПҮРЭВ¹, Б.НАНДИН-ЭРДЭНЭ²

¹МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, доктор, профессор

²МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн докторант

Түлхүүр үг: Улс төрийн маркетинг, онол, судлагдахуун, сонгууль, нам

ABSTRACT: As political marketing has been going into independent science, numeral research subject have continuously emerged. This study examined a literature review of the political marketing science.

Эхэн үеийн улс төрийн маркетингийн үүсэл хөгжил нь эдийн засгийн хэрэглээний бараа бүтээгдэхүүний маркетингаас үүсэлтэй байсан. Цаг хугацаа өнгөрөхийн хирээр улс төрийн болон эдийн засгийн маркетингийн ялгаа тод ажиглагдах болсон. Тухайлбал, улс төрийн маркетингийн хөгжил нь илүүтэйгээр нийгмийн болоод сэтгэл судлалын практик асуудлуудад суурилах болсон ба өөрөөр хэлбэл биеэ даасан хавсарга шинжлэх ухааны хэлбэржилтийг олсон ба өөрийн гэсэн судлах зүйл, арга аргалчлалыг үүсгэн бий болгосон.

1988 онд Америкийн улс төр судлаач, эрдэмтэн Филип Ниффенжер эдийн засгийн сонгодог маркетингийн хольцуудыг улс төрийн сонгуулийн кампанит ажилд ашиглаж болохыг харуулснаар улс төрийн маркетингийн хэрэглээг хурдтай хөгжүүлэхэд ихээхэн түлхэц болсон байна.

Түүний авч үзсэнээр маркетингийн үндсэн хольцууд болох “4П”-г сонгогчдын зан төлөвт үр ашигтайгаар хандуулах боломжийг судалсан. Энэ нь улс төрийн сурталчилгааг хийхдээ бодит судалгааны үр дүнгээс зөрүүтэй байдлаар бус харин ч судалгааны асуулгуудад тулгуурлан тэдгээрийг маркетингийн хольцуудаар үр ашигтай уялдуулах хэрэгтэйг харуулсан. Өөрөөр хэлбэл, маркетингийн арга хэрэгслүүд нь сонгогчдын сегментийг илүү ихээр ойлгож, тохирсон сурталчилгаа хийх боломжийг олгодог байна.

Зурагт1-т Филип Ниффенжер-н судалгаандаа авч үзсэн Улс төрийн маркетингийн процесс




Зурагт үзүүлсэнээр зах зээлийн судалгааны үндсэн маркетингийн хэрэгсэлүүдийг сонгогчдыг сегментчилэхэд ашиглаж болохыг онцолсон. Ийм учраас улс төрийн маркетингийн талаарх ойлголт нь ихэнхдээ Котлерын маркетингийн хандлагад суурилах болсон байна. Энэхүү хандлага ёсоор улс төрийн намын хувьд бүх шатны сонгуульд оролцохдоо сонгогчдын бодит итгэл үнэмшил, сонирхлыг системтэй байдлаар бүхэлд нь судалж, тэдгээрт тохирсон сонгуулийн стратегийг зохион байгуулж оролцох хэрэгтэй. Хэрэв нэр дэвшигч нь улс орныхоо нийгэм, эдийн засаг, эдийн засгийн асуудлуудыг сайтар судлаагүй бол сонгогчдын сегментлэлийг хийж чадахгүй байх эрсдлийг бий болгодог. Тийм учраас нэр дэвшигч нь сонгогчдын сегментлэлд тохирсон стратеги, төлөвлөгөөг иж бүрэн боловсруулах шаардлагатай. Энэ стратегийг боловсруулахад маркетингийн хэрэгслийг өргөнөөр ашиглах шаардлагатай гэжээ. Филип Ниффенжер өөрийн боловсруулсан аргачлалаа АНУ-д болсон хэд хэдэн ерөнхийлөгчийн сонгуулиар жишээ аван тайлбарласан байдаг. Тухайлбал 1952 онд болсон Эйзенхаурын сонгуульд сонгогчдын зан төлвийг тандсан судалгааны санал асуулгад үндэслэн сонгуулийн стратегия боловсруулсан гэдгийг нь харуулсан бол 1968 оны Ричард Никсоны сонгуулийн зөвлөхүүд нь сонгогчдын хүсэж буй асуудлын хүрээг тодорхойлж, түүнийгээ маркетингийн хольцуудын дагуу сонгуулийн стратегия болгон ашиглаж байсан зэргийг дурдсан байдаг. Харин Рональд Рейгены хувьд бага зэрэг ялгаатай аргыг өөрийн 1984 оны сонгуульдаа ашигласан байдаг. Түүний сонгуулийн зөвлөхүүд нь сонгуулийн өмнөх санал асуулгаар нийгэм эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэхэд нэр дэвшигчийн үүрэг ролийг тодорхойлж, түүндээ тохирсон маркетингийн хэрэгсэлүүдийг ашигласан байдаг.

Давид Рэйд (Улс төрийн бүтээгдэхүүний маркетинг, 1988 он) өөрийн улс төрийн маркетингийн талаарх онолдоо сонгогчдын санал өгөх хандлагыг бүтээгдэхүүн худалдан авах процесстой адилтган үзэж тэдгээрийн элемент хоорондыг харьцуулах байдлаар авч үзсэн байдаг.

Рейдын ойлголтоор аливаа нэгэн хэрэглэгч бүтээгдэхүүн авахдаа өөрийн таашаал, дур сонирхол болон тухайн бүтээгдэхүүний маркетингт суурилан худалдан авах шийдвэрээ гаргадаг бөгөөд энэ нь “санал өгөх процесстой” ижил байдаг гэж үзжээ. Түүнийхээр худалдан авах буюу санал өгөх процесс нь дараах үе шатуудаас бүрддэг байна:

Зураг 2-т Худалдан авах шийдвэр гаргах процесс:



Хэрэглээгээ тодорхойлох буюу асуудлыг танин мэдэх: Энэхүү үе шатанд сонгогчидод ямар зүйл хамгийн их шаардлагтай байгааг таньж ойлгох тухай юм. Жишээ татан тайлбарлавал, ажилгүйдлийн асуудал нь ажил хайж буй сонгогчдын хувьд хамгийн их сонирхол татсан асуудал байх бөгөөд нэр дэвшигч, намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт ажилгүйдлийн талаар ямар ямар хөтөлбөр орсон, тэдгээр нь ажил хайж буй сонгогчдын асуудлыг хэрхэн шийдвэрлэж чадахаас хамаарна гэж үзсэн.

Тандалт: Энэ төвшинд сонгогчдын өргөнөөр ашигладаг хэвлэл мэдээлэл, телевиз, радио зэрэг мэдээллийн сангуудад хандсан хандалтыг тандан судалж сонгогчдод тулгарч буй асуудлыг ул суурьтай авч үзэх тухай юм.

Алтернатив үнэлгээ: Сонгогч нь аливаа “хуримтлагдсан мэдээлэл-”ийн эсрэг өөр өөрийн гэсэн үнэлгээний шүүлтүүртэй ханддаг. Өөрөөр хэлбэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээс авч буй аливаа нэгэн мэдээлэлтэй сонгогчийн үнэлгээний шүүлтүүр нийцтэй байвал тэрхүү мэдээллийг хүлээн авдаг бол эсрэг тохиолдолд өөрийн үнэлгээний шүүлтүүрийг дагах нь элбэг байдаг байна. Жишээлбэл: Бизнесмэн хүн аль болох татварын хувь хэмжээг бага байлгахыг дэмждэг байхад олон нийтийн зүгээс татвар нэмэхийг зүйтэй гэж үзвэл энэ тохиолдолд бизнесмэн хүн өөрийн үнэлгээний шүүлтүүр болох татвар бага байх гэдэг хувилбарыг сонгохтой жишиг юм. Энэ бүгдээс үзэхэд нэр дэвшигч, улс төрийн нам нь энэхүү алтернатив үнэлгээг заавал тооцоолох хэрэгтэй юм.

Сонголт: Сонголт бол энэхүү гинжин хэлхээний хамгийн чухал хэсэг юм. Сонголт нь алтернатив үнэлгээтэй логик холбоосоор холбогддог. Сонгогчдын санал өгөх процесст тухайн сонгогчийн үнэлгээний шүүлтүүр хамгийн их нөлөөтэй байдаг. Гэхдээ улс төрийн маркетингт эцсийн минутын нөлөөлөл буюу гэнэтийн нөлөө гэсэн ойлголт байдаг. Энэ нь сонгуулийн үед хийгдэх сурталчилгаа, мэтгэлцээн, ярилцлага зэрэг мэдээлэл нь сонгогчийн саналд нөлөөллөө олохыг хэлнэ. Хүлээгдээгүй энэхүү нөлөөллийг улс төрийн маркетингт өргөн ашиглах болсон.


Үр дүн: Энэ нь ерөнхийдөө бүтээгдэхүүн худалдан авсны дараах хэрэглэгчийн ханамжтай ижил ойлголт юм. Улс төрчдийн хувьд өөрийг нь дэмжсэн сонгогчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, сонгоогүй сонгогчдын итгэлийг олж авах үе шат юм.

Ерөнхийдөө Давид Рэйд энэхүү загвар нь улс төрийн маркетингийн үе шатуудыг энгийн байдлаар ойлгоход ихээхэн дөхөмтэй боловч хэт энгийн байдлаар зүйрлэсэн аргачлалтай байдаг нь практик амьдралын нөхцөл байдалд төдийлөн уялддаггүй гэж зарим нэг судлаачид шүүмжлэлтэй ханддаг байна.

Филип Котлер болон Нэйл Котлер (“Улс төрийн нэр дэвшигчдийн маркетинг” Сонгууль болон кампанит ажил 1981 он) нар сонгуулийн кампанит ажлын үе дэх зургаан үе шат бүхий нэр дэвшигчийн маркетингийн хандлагыг судалсан байдаг.

Тэд энэхүү хандлагад авч үзэхдээ, мэргэжлийн түвшинд төлөвлөгдсөн аливаа нэгэн сонгуулийн кампанит ажил нь 1) Хүрээлэн буй орчны судалгаа, 2) Гадаад болон дотоод нөхцөл байдлын үнэлгээ, 3) Маркетингийн стратеги, 4) Сонгуулийн стратеги болон зорилгын бэхжилт, 5) Олон нийттэй харилцах, мэдээлэл түгээх, бүтэц зохион байгуулалтын төлөвлөгөө, 6) Сонгуулийн гол зорилтот хэсгийг тодорхойлсон байх зэргийг иж бүрэн багтаасан байх шаардлагатай гэж үздэг.

Энэхүү хандлагуудыг доор харуулсан болно.



Хүрээлэн буй орчны судалгаа: Энэ хэсэгт нэр дэвшигч, улс төрийн нам нь маркетингийн төсөөлөл зураглалаа боловсруулах хэрэгтэй. Уг зураглалд нийгэм орчны үнэлгээ болон сонгуулийн кампанит ажил хоорондын уялдааг харуулахад оршино. Ерөнхийдөө энэхүү судалгаа нь өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал, түүний бодит нөхцөл байдлыг тандан таних, аливаа гэнэтийн болон тооцоологдоогүй эрсдлүүдийг бодитоор илрүүлэхэд голчлон анхаардаг.

Дотоод болон гадаад нөхцөл байдлын үнэлгээ: Улс төрийн маркетингийг оролцуулаад бүхий л төрлийн маркетингийн үйл ажиллагаанууд нь бүгд л өөрийн дотоод давуу талыг үнэлэн дүгнэх, гадаад өрсөлдөгчдийн нөхцөл байдлыг үнэлэн цэгнэдэг. Дотоод нөхцөл байдлын үнэлгээ нь ерөнхийдөө нэр дэвшигчийн давуу болон сул талууд нь сонгуулийн кампанит ажилд хэрхэн нөлөөлөхийг авч үздэг бол гадаад нөхцөл байдал нь өрсөлдөгчийн үйл хөдлөлийг тандах, үнэлэхтэй холбоотой байдаг.

Эдгээр гадаад, дотоод нөхцөл байдлын шинжилгээ нь хоёулаа нэр дэвшигч, улс төрийн намын байр суурьт чухал нөлөөтэй.

Маркетингийн стратеги: Маркетингийн стратегийг боловсруулахдаа сонгуулийн тойргуудад суурилсан шинжилгээ судалгаанд үндэслэдэг. Тухайлбал, сонгууль явуулах хот, дүүрэг, хороодыг сегментчлэн ямар хэсэг нь аль нэр дэвшигчид илүү их санал өгөх хандлагатайг судлах, энэхүү санал өгч буй шалтгааныг илрүүлж түүнд суурилсан стратегийг боловсруулахад оршино.

Сонгуулийн стратеги болон зорилгын бэхжилт: Энэ хэсэгт маркетингийн стратегийн дагуу тодорхойлогдсон зураглалыг дахин шалгаж өмнө хийсэн судалгааны үр дүнг эргэн дүгнэх, нэр дэвшигч, улс төрийн намын маркетингийн зорилго биелэлээ олсон эсэхийг давхар шалгадаг. Хэрэв нэр дэвшигч болон намын маркетинг биелэлээ олсон бол түүнийг цаашид үргэжлүүлэх эсвэл эргэн өөрчлөх бүтцийг энэ үе шатанд боловсруулдаг байна.

Олон нийттэй харилцах, мэдээлэл түгээх, бүтэц зохион байгуулалтын төлөвлөгөө: Энэ хэсэгт маркетингийн хольцуудыг түгээмэл ашиглах үе гэж Филип Котлер болон Нэйл Котлер нар үзсэн байдаг. Энэ шатанд ихэнхи нэр дэвшигчид, улс төрийн намууд ихээхэн анхаарал хандуулж өрсөлддөг бөгөөд өөрсдийн уламжлал, бүтэц зохион байгуулалтын давуу талаа ашиглан өрсөлдөөнд ялахыг эрмэлздэг байна. Сонгуулийн ажилд оролцож буй гишүүн бүр өөр өөрийн оногдсон үүргийн дагуу энэ хэсэгт хуваагдан оролцдог тул энэ хэсгийг жижиглэсэн сонгуулийн үе ч гэж нэрлэх нь бий.

Сонгуулийн гол зорилтот хэсэг: Сонгогчид, Дэмжигчид, Хэвлэл мэдээлэл

Филип Котлер болон Нэйл Котлер нарын тодорхойлсон хамгийн сүүлийн үе шат болох зорилтот хэсэгт нэр дэвшигч, улс төрийн намууд нь өөрсдийг нь баттай дэмжих хэсгийн саналыг баталгаажуулах, цаашлаад баттай дэмжих хэсгийн саналын тоог нэмэгдүүлэхэд анхаардаг бөгөөд үүндээ сонгогчид, дэмжигчид, хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөнөөр ашиглаж ухуулга сурталчилаахийдэг байна. Өөрөөр хэлбэл өөрт байгаа бүхий л нөөц боломжоо шавхан сонгогчдын саналыг авахад чиглүүлдэг байна.

Филип Котлер болон Нэйл Котлер нарын тодорхойлсон энэхүү төлөвлөлт болон хэрэгжүүлэлтийн хандлага нь Гэри Маусэрийн (Улс төрийн маркетинг: кампанит ажлын хандлага, 1983он) хандлагатай үе шатны хувьд ихээхэн төстэй хандлага юм. Гэри Маусэрийн хувьд үе шатын тоог гурван хэсэгт хуваан үзсэн бөгөөд 1) Өрсөлдөөнд бэлтгэх үе шат, 2) Сонгогчдод нөлөөлөх маркетингийн аргачлал, хольцууд 3) Стратегийг хэрэгжүүлэх үе шат хэмээн хуваасан байдаг.

Лийс-Маршментийн “Иж бүрэн улс төрийн маркетинг” хандлага

Женнифер Лийс Маршментийн (Улс төр судлал ба маркетингийн гэрлэлт: Улс төр судлал 2001 он, Улс төрийн маркетинг дахь өнөөгийн асуудлууд. 2005 он) авч үзсэн энэхүү хандлага нь таван үндсэн суурь хэсгээс бүрэлддэг. Түүний үзсэнээр нэр дэвшигч, улс төрийн намын маркетинг нь 1) улс төрийн маркетингийг энгийн нэг харилцааны аргачлалаас дээгүүр авч үзэх шаардлагатайг харуулдаг. Учир нь улс төрийн маркетинг нь зөвхөн сонгуулийн кампанит ажлын үед хийгддэг нэг удаагийн шинж чанартай үйл ажиллагаа биш. Харин байнгын эргэх орчилд байх процесс гэж үзсэн, 2) улс төрийн маркетингт ямар нэгэн төрлийн техник аргачлал байх ёсгүй. Түүний үзэж буйгаар улс төрийн маркетинг нь маш уян хатан зохион байгуулагдсан арга барилуудын цогц байх ёстой бөгөөд нэгэн төрлийн хэвшмэл техник аргалчлалд баригдах ёсгүй гэж үзсэн, 3) улс төрийн маркетинг нь улс төрийн шинжлэх ухааны элемент бөгөөд улс төрийн мэдлэгийн болон онолын тоймыг улс төрийн маркетингт түгээмэл ашиглах

ёстой, 4) улс төрийн маркетинг нь бодлогын (мөрийн хөтөлбөрийн) үндсэн суурьт уягдсан байх учиртай, 5) улс төрийн маркетинг хийхдээ хэвлэл мэдээлэл, социал медиа, орон нутгийн сонин сэтгүүл, телевиз, радио, нутгийн өөрөө удирдах байгууллагын санал, сонирхолын бүлгүүд, байгууллагын зан төлөв, олон нийтийн дуу хоолой зэрэг бүхий л талуудын оролцоог хангасан иж бүрэн зохион байгуулагдах гэсэн үндсэн таван суурь зарчмыг тодорхойлсон байдаг.

Фил Харрисийн орчин үеийн улс төрийн маркетинг хандлага


2001 онд хийсэн Фил Харрисийн орчин үеийн улс төрийн маркетингийн хандлага нь ерөнхийдөө орчин үеийн техник технологийн дэвшил, орчин үеийн ардчиллын хөгжил, иргэдийн улс төрийн идэвхи оролцоо зэрэг нь маш хүчтэй нөлөөг улс төрийн хөгжилд авч ирж буйг харуулсан хандлага юм. Эдгээр бүх орчин үеийн өөрчлөлт шинэчлэл нь сонгуулийн кампанит ажлын үед шууд тусгалаа олж байна гэж Харрис үзсэн. Улс төрчид бүхний өмнө, яг л тайзан дээр байх жүжигчин шиг л болсон гэж Харрис өөрийн хандлагын гол суурийг авч тайлбарласан. Жишээлбэл: 2005 оны Польш улсын ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж байсан хоёр нэр дэвшигчид болох Лэч Казинский болон Дональд Так нарын халз мэтгэлцээний өдрийн хуваарь нь тэр өдөр олон нийтийн телевизээр гарах “ододтой бүжиглэе” тэмцээнтэй давхацсанаас болж солигдож байсан. Өөрөөр хэлбэл үзэгчид тэдгээрийн мэтгэлцээнээс илүүтэй телевизийн шоу нэвтрүүлэгийг үзэх нь илүү таашаалтай гэж үзсэн хэрэг. Эндээс дүгнэхэд орчин үеийн улс төрийн маркетинг нь маш ихээр хувьсаж байгаа нь харагдаж байна. Фил Харрис энэхүү хувьслын үед улс төрийн маркетинг нь дөрвөн үндсэн хүчин зүйлийг тооцоолох нь зүйтэй гэж үзсэн байдаг.

- 1) Хувийн шинж голлосон улс төр: Энэ нь сонгогчид ихэвчлэн нам эсхүл улс төрийн хандлага гэхээсээ илүүтэйгээр хувь нэр дэвшигчийн зан чанар, харилцааг илүүд үзэх болсонтой холбоотой
- 2) Дүр төрх, Имиж: Фил Харрисийн тодорхойлсоноор маш үр нөлөөтэй хэсэг бөгөөд магадгүй тухайн нэр дэвшигчийн улс төрийн маркетингийн цөм хэсэг байхыг ч үгүйсгэхгүй гэж үзжээ.
- 3) Олон нийттэй харилцах ур чадвар: Нэр дэвшигчид, улс төрийн намуудын хувьд дүр төрх, имиджийг гаргах гол талбар нь олон нийттэй харилцах ур чадвар бөгөөд өрсөлдөөнд ялах, өрсөлдөгчийн эсрэг барих бодлогын гол цөмийг агуулдаг.
- 4) Шинжлэх ухааныг чадмаг ашигласан улс төр: Шинжлэх ухааны судалгаа, ололт амжилтад суурилсан улс төрийн маркетингийн шийдэл нь сонгуулийн үйл явцад эерэг нөлөөтэй байх боломжтой.

Фил Харрисийн авч үзсэн орчин үеийн улс төрийн маркетинг хандлага нь өмнөх үеийн Филип Ниффенжер, Давид Рэйд, Нэйл Котлер, Лийс-Маршментийн нарын хандлагуудын суурь нөхцөлд тулгуурласан ба уламжлалт эдийн засгийн маркетингийн хандлагыг орчин үеийн техник, шинжлэх ухаан, ардчиллын хөгжилтэй хослуулан харуулсанаараа онцлог юм.

Улс төрийн маркетингийн Ньюманы загвар

Ньюманы загварыг улс төрийн маркетингийн хамгийн түгээмэл загваруудын нэг гэж үздэг. Учир нь энэхүү загварт улс төрийн маркетингийн үе шатуудыг иж бүрэн байдлаар нь харуулснаараа онцлог юм. Энэхүү загварыг 1994 онд Ньюман өөрийн судалгааны ажлаараа танилцуулсан бөгөөд энэхүү загварт маркетингийн кампанит ажил болон улс төрийн кампанит ажлын уялдаа холбоог харуулсан байдаг.



Маркетингийн кампанит ажил нь нэр дэвшигчдэд улс төрийн кампанит ажлын дөрвөн үе шатыг хэрэгжүүлэхэд чиглэгддэг. Улс төрийн маркетингийн кампанит ажлын гол цөм нь нэр дэвшигчийн “борлогдох” үйл ажиллагаа гэж үзсэн байна.

Улс төрийн маркетинг нь эдийн засгийн маркетингаас үүдэлтэй боловч орчин үед тусдаа бие даасан шинэжлэх ухаан болон хөгжиж маш ихээр хувьсан өөрчлөгдөж буй нь дээрх судалгаануудаас харагдаж байна.

Улс төрийн маркетинг нь зөвхөн сонгуулийн кампанит ажлын үед хийгддэг буасд үед байдаггүй нэг удаагийн шинж чанартай үйл ажиллагаа биш. Харин байнгын эргэх орчилд байх процесс юм. Улс төрийн маркетингт ямар нэгэн төрлийн техник аргачлал байх ёсгүй ба маш уян хатан зохион байгуулагдсан арга барилуудын цогц байх ёстой, нэгэн төрлийн хэвшмэл техник аргалчалд баригдах ёсгүй.

Улс төрийн намын хувьд бүх шатны сонгуульд оролцохдоо сонгогчдын бодит итгэл үнэмшил, сонирхлыг системтэй байдлаар бүхэлд нь судалж, тэдгээрт тохирсон сонгуулийн стратегийг зохион байгуулж оролцох хэрэгтэй. Хэрэв нэр дэвшигч нь улс орныхоо нийгэм, эдийн засаг, эдийн засгийн асуудлуудыг сайтар судлаагүй бол сонгогчдын сегментлэлийг хийж чадахгүй байх эрсдлийг бий болгодог. Тийм учраас нэр дэвшигч нь сонгогчдын сегментлэлд тохирсон стратеги, төлөвлөгөөг иж бүрэн боловсруулах шаардлагатай. Энэ стратегийг боловсруулахад маркетингийн хэрэгслийг өргөнөөр ашиглах шаардлагатай.

Улс төрийн маркетинг хийхдээ хэвлэл мэдээлэл, социал медиа, орон нутгийн сонин сэтгүүл, телевиз, радио, нутгийн өөрөө удирдах байгууллагын санал, сонирхлын бүлгүүд, байгууллагын зан төлөв, олон нийтийн дуу хоолой зэрэг бүхий л талын оролцоог хангаж ажиллах хэрэгтэй.

Ашигласан эх сурвалж

AvrahamShama, An Analysis of Political Marketing, 2003, USA

BojciechCwalina, AndrzejFalkovski, Bruce I Newman, Political marketing: Theoretical and Strategic Foundation, 2011 New York

Stephan C.M. Henneberg, Political Marketing Theory, 2004, USA

МОНГОЛЧУУДЫН УЛС ТӨРИЙН ФИЛОСОФИ: УЛАМЖЛАЛТ ҮЗЭЛ САНАА

Д.БОЛД-ЭРДЭНЭ

ФСЭХ-ийн улс төр судлалын салбарын тэргүүлэх ажилтан,

доктор, профессор

Түлхүүр үг: Улс төр, монголын улс төр, философи, натурфилософи, монгол уламжлалт нийгэм, уламжлалт үзэл, домог зүй, шашин-ёс суртахуун, оюунлаг үзэл, улс төрийн философийн тулгуур зонхилогч үзэл санаа

ABSTRACT: *The Mongols had traditional concept of political philosophy but some researchers hesitate that. The Mongols had a hundred years custom of state and tactics to govern wisely. This tactics was their basis of political philosophy.*

Философич Освальд Шпенглер иргэншил тус бүр соёл, сэтгэлгээний янз бүрийн хүрээгээр хосгүй тухай үзэл санааг дэвшүүлсэн байдаг. Тэрээр иргэншил бүр зөвхөн өөрт нь зуршмал ёс зүйн үнэт чанартай, гоо зүйн онцгой хараатай, сэтгэхүйн өвөрмөц тогтолцоотой байдаг гэж бичсэн байдаг. Тэгвэл иргэншлийн философийн үүднээс Монгол нүүдлийн иргэншилд энэхүү нийтлэг жам ёс бодитой оршин үйлчилж байсан нь эргэлзээгүй хэрэг. Энэ нөхцөлд Монголчуудад оршин ахуй, хүрээлэн байгаа байгаль ертөнцөө танин барих философи сэтгэлээ тэр дундаа улс төрийн философи сэтгэлгээний уламжлал гэхээр зүйл байсан нь маргаангүй.

Энэ тохиолдолд Монголчуудын улс төрийн философийн бодит түүхэн болон оюунлаг үндэс, илрэх хэлбэр, ялгаа, онцлог, үзэл санааны оюунлаг тогтолцооны тухай асуудал судлал шинжлэлийн сонирхолтой бөгөөд төвөгтэй тэгэхдээ тулгамдсан асуудал болон тавигдаж байна. Харин энэ удаад Монголчуудын улс төрийн философи мэдлэгийн тогтолцооны асуудалтай холбогдсон зарим зүйлийг тодруулан үзэхийг оролдох болно. Гэхдээ үндсэн асуудлаа авч үзэхийн өмнө эхлээд орчин үед улс төрийн философи тойрсон маргааны тухайд товч боловч тодруулан үзэх нь зүйтэй байх.

Улс төрийн философи тойрсон маргааны тухайд

Орчин үед философчдын дотор өрнөж байгаа маргааны томоохон сэдэв нь улс төрийн философитой холбоотой байна. Хэдийгээр хүн төрөлхтөний сонгодог болон орчин үеийн философи сэтгэгчид улс төрийн философийн оюунлаг суурь үндсийг хэдийнээ баттай тавьсан боловч түүний цаашдын хөгжлийн явцад түүнийг тойрсон маргаан мэтгэлцээн тасралтгүй үргэлжилж буй болно. Энэхүү маргааны явцад хамгийн их хөндөгддөг асуудал бол *улс төрийн философи хэмээх тусгай тодорхой философи салбар байдаггүй, харин үүний оронд гагцхүү ерөнхий философи хэмээх л байдаг тухай сэдэв* юм. Энэхүү үзэл байр суурийг баримтлагч философчид нэг л философи байдаг бөгөөд энэ нь ерөнхий философи юм. Харин “улс төрийн философи” гэгчийн тухайд

бол энэ нь тусгай тодорхой бие даасан философи биш, зөвхөн ерөнхий философийн хийх ёстой ажлын нэг л тодорхой чиглэл юм гэж үздэг.*

Тэд үүнтэй холбоотой нэг бүхэл цул философийг танин мэдэхүйн тодорхой салбарт хэт дэлгэрүүлэн нялцааж хэрэглэх нь зохимжгүй гэсэн байр суурийг бас илэрхийлдэг. Гэвч энэ байр суурьт шүүмжлэлтэй хандвал зохино. Учир нь ерөнхий нэг бүхэл цул философийн зэрэгцээ хүний танин мэдэхүйн тодорхой чиглэл салбарт хамаатай философийн тусгай мэдлэгийн хэлбэр яагаад байж болохгүй гэж. Философич К.Ясперс философи гэж юу вэ? гэдэг асуултанд энэ нь улс төр дэх түүний илрэл гэж хэлсэн байдаг нь санамсаргүй хэрэг биш юм. Ер нь хүний ертөнц, амьдралаас ангид оршдог “цэвэр” философи гэж байдаггүй, харин тэр нь байдаг гэвэл хэнд ч хэрэггүй зүйл болохсон билээ.⁷ ...Хэрэв түүнийг санаа бодолдоо хэрэглэж болдоггүй юм бол философи юмуу философи сэтгэлгээ хэнд хэрэгтэй юм вэ? гэсэн асуулт бас гарах нь дамжиггүй.⁸

Улс төрийн философи тойрсон маргааны бас нэг сэдэв нь *улс төрийн философи гэгч хэрвээ байдаг бол түүнийг мэдлэгийн чухам аль салбар чиглэлд багтааж үзэх эсэх тухай асуудал* юм. Энэ нь нэг үгээр хэлбэл улс төрийн философи мэдлэгийн онцлогийн тухай сэдэв юм. Философчдын нэг хэсэг улс төрийн философийг улс төрийн шинжлэх ухааны мэдлэгийн хүрээнд багтаан үздэг бол нөгөө хэсэг нь түүнийг философи мэдлэгийн бүл, ай салбарт хамаатуулдаг. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд улс төрийн философи нь уг язгуур чанараараа философи мэдлэгийн хүрээнд багтдаг бөгөөд улс төр дэх цэвэр философи асуудлыг хийсвэр ойлголт категорийн түвшинд авч үздэг философи мэдлэгийн бие даасан тусгай тодорхой чиглэл юм.

Улс төрийн философийг зарим философичид хийсвэр ойлголтын түвшний мэдлэг хэмээдэг бол нөгөө хэсэг нь бодит улс төртэй холбогдсон прагматик эмпирик философи хэмээдэг. Гэвч улс төрийн философи нь үндсэн шинжээрээ ойлголтын түвшний хийсвэр мэдлэг болдог. Тэгэхдээ бодит улс төрд хамаарах философи асуудлыг анхааран үздэгээрээ бас нэг талаар эмпирик мэдлэг ч болох талтай. Орчин үед Өрнөдийн улс орнуудад улс төрийн философийг чухам прагматик, эмпирик философи гэдэг талаас нь түлхүү анхааран судлах хандлагатай байдаг. Чухам энэ шинжээрээ философийн бусад салбар чиглэлтэй харьцуулахад улс төрийн философи нь бодит улс төрийн амьдралтай илүү ойр дөхүү байдаг. Тэглээ гээд түүнийг юуны түрүүнд эмпирик философи мэдлэг гэхээсээ илүү улс төрийг цэвэр философи ойлголтын түвшинд авч үздэг улс төрийн биш, харин философи мэдлэгийн бүхэл тогтолцоо гэж нэг мөр ойлгох нь зүйтэй санагдана. Ингэх нь түүний унаган суурь философи шинжтэй нь нийцэж байгаа юм.

Философичдын зарим хэсэг нь философид *үнэт зүйлс* буюу *үнэт чанар* гэж байдаггүй. Учир нь философи бол норматив биш, харин хийсвэр мэдлэг гэгцгээдэг. Тиймээс улс төрийн философид ямар нэг үнэлгээ түүний үндэс болсон үнэт зүйлс гэхээр зүйл байх боломжгүй хэмээдэг. Тэгвэл философичдын нөгөө нэг хэсэг нь улс төрийн философи нь философийн бусад салбаруудтай харьцуулбал хийсвэрийн зэрэгцээ бас норматив мэдлэг болж байдагаараа онцлог. Энэ нь түүний бодит улс төртэй илүү ойр байдагтай холбоотой. Ингэхлээр түүнд үнэлгээ түүний эцсийн хэмжүүр болсон ямар нэг үнэт зүйлс байж болох юм. Тэгээд ч үүнтэй холбогдуулан Германы философич В.Виндельбанд философи бол үнэлгээ гэсэн нь санамсаргүй зүйл бишээ гэгцгээдэг. Ингэхлээр философи тэр дундаа улс төрийн философи дахь “үнэт зүйлс”-ийн тухай асуудал маргааны чухал сэдэв болдог нь харагдаж байна.

* Энэ тухайд философич Батын Ч.Ган-Өлзийн “Хүмүүнлэгийн гурван ертөнцийн гоц чанарыг судлахуйн чандмань эрдэнэ” \УБ.,2011\ хэмээх бүтээлд тодорхой гаргаж тавьсан байдаг

⁷ Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи\ асуудал, аргачлал, ашиг тус\УБ.,2013, 6 дахь тал

⁸ Мөн тэнд 85 дахь тал

Монголчуудад улс төрийн философи байсан уу?

Манай философчид яг энэ асуудлыг өөр хоорондоо тавьж, өнөө хэр маргаж мэтгэлцсээр ирсэн. Мэтгэлцээний явцад философчдын нэг хэсэг нь Монголчуудад улс төрийн философи сэтгэлгээний түүхэн уламжлал ямар нэг байдлаар байсан хэмээн итгэлтэй хариулдаг бол нөгөө хэсэг нь энэ нь сэтгэл хөдлөлд суурилсан “эдүгээчилсэн хэтрүүлэл” төдий зүйл хэмээн үл итгэх байдлаар ханддаг.

Тэгвэл Монголчуудын улс төрийн философи сэтгэлгээ нь тэдний олон зууны тэртээгээс боловсрон хөгжсөн төр, төр ёсны философиос эх ундрагатай гэдэг нь баттай зүйл. Монголчууд Хүннүгийн үеэс тооцвол 2220 жил, харин түүнээс өмнөх *угтал төрийн** үеийг тооцвол нийтдээ бараг 4000 орчим жилийн төр, төр ёсны түүхэн уламжлалтай. Гэтэл Монголчуудыг улс төрийн үзэл сэтгэлгээ тэр дундаа улс төрийн философи мэдлэгийн ямар нэг тогтолцоо гэхээр юм байхгүй “бүдүүлэг” “зэрлэгүүд” байсан гэж үзэх үзэл хандлага нилээдгүй дайралддаг. Тэгвэл энэ үзэл байр суурь өрөөсгөл болох нь илэрхий. Үүний учир гэвэл хүмүүсийн төрөлхийн мөн чанараас үүдсэн тэдгээрийн хоорондын улс төрийн харилцаа байгаа газарт тэдний хамтын зохион байгуулалтын хэлбэр болох *төр* оршин байх нь гарцаагүй. Төр байгаа бол түүний үйл ажиллагааны дэг ёс, хэм хэмжээ буюу *төр ёс* байх нь эргэлзээгүй. Хэрвээ *төр ёс* байгаа бол түүний оюунлаг тусгал болох *төр ёсны философи, сэтгэлгээ, бодлого, зарчим* байх нь жам ёсны зүйл. Харин төр ёсны философи байсан л бол улс төрийн бүхэл философи сэтгэлгээ оршин үйлчлэх нь зайлшгүй. Тэгэхдээ энэ бол энгийн л логик баталгаанаас үүдсэн хийсвэр бодол санаа. Асуудлын гол нь энэ бүхнийг баримттайгаар буйртай нягтлан судлах үндсэн дээр философи талаас нь хөтөлбөргүй үндэслэж, нотлоход л оршиж байгаа юм. Үүнтэй холбогдуулан философич Д.Дашпүрэв “Монголын философийн товч түүх” бүтээлдээ: “Монголын философи гэдэг түүхэн үзэгдэл ер нь байсан юмуу гэж зарим хүн асууж болох байх гэж би боддог юм. <...>...бид Италийн, Грекийн, Хятадын, Энэтхэгийн бас Оросын философи гэх мэтээр хэлдэгчлэнгээ Монголын философи гэж хэлж болох байлгүй. Гэвч түүнийг философийн үүднээс үндэслэж өгөх нь зүй ёсны гэж үзэж байна. Тухайлбал Монголын философи бусдынхаас юугаараа ялгаатай вэ, үгүйдээ л тэр нь чухамдаа тэгээд юу юм бэ гэдэг асуултанд хариулах ёстой”⁹ гэж бичсэнийг онцолмоор санагдлаа.

Үнэхээр ч Монголчуудад улс төрийн философи мэдлэгийн уламжлал хэрвээ байсан л гэж үзэж байгаа юм бол тэр нь ямар философи байсан, түүнчлэн түүний бусдаас ялгарах ялгаа, онцлог, нь юу байж болох вэ? гэсэн зүй ёсны асуудал гарч ирэх нь дамжиггүй. Гэвч харамсалтай нь бид энэ талаар одоогоор тоймтой хэлчих зүйлээр баруухан л байгааг нуух хэрэггүй. Гэвч бид Монголчуудын улс төрийн философи уламжлалын асуудлыг одооноос л сонирхож эхэлж байна. Хэдийгээр эл сэдэв төвөгтэй боловч судлал шинжлэлийн нэн сонирхолтой томоохон суурь асуудал болж буйг дахин онцлон тэмдэглэхийг хүсч байна.

Монголчууд өөрсдийн амьдралын хэв маяг, иргэншлийн онцлог, байгаль, цаг уур, нутаг дэвсгэрийн өвөрмөц байдал, хүн ам, тэдний нийгэм-сэтгэл зүй, сэтгэх арга, хэв шинжийн онцлогоор нөхцөлдсөн философи тэр дундаа улс төрийн философи мэдлэгийн үндэсний уламжлалт хэв маягийг бүтээн бий болгосон байдаг. Энэ нь тэдний оршин тогтнож ирсэн түүхэн цаг үе, хөгжлийн бүхий л явцад тухайн үеийн оюунлаг тусгал болон бүрэлдэн төлөвшиж иржээ. Монголчуудын олон зууны тэртээгээс бүтээн туурвиж, тэдний үе үеийн сор болсон ухаант сэтгэгч мэргэдийн оюун ухаанаар

* *Угтал төр* бол жинхэнэ төрийн өмнөх үед хамаарах төр болж хараахан амьжаагүй, сонгодог төрийн зарим нэг шинж түүний элементгй ямар нэг хэмжээгээр урьдчилсан байдлаар өөртөө агуулсан *төрийн өмнөх бүрдэл*

⁹ Д.Дашпүрэв. Монголын философийн товч түүх. УБ.,2013, 10, 11 дахь тал

боловсрогдон томьёологдож, хуримтлагдсан улс төрийн үзэл сургаал, номлолын түүхэн тодорхой хэв маягийг үндсэнд нь тэдний *улс төрийн философи сэтгэлгээ* гэж оноон ойлгож болох юм.

Тэгэхдээ Монголчуудын эрт үеэс уламжилсан улс төрийн философи сэтгэлгээ нь эхнээсээ л бүрэн боловсорсон бүхэл тогтолцоот логик цогц үзэл төсөөлөл байсан гэж нотлоход хүрвэл энэ нь дэндүү гэнэн хэрэг болохсон билээ. Мэдээж хэрэг энэ нь үүсэл төлөвшлийн амаргүй урт замналыг туулсан нь тодорхой. Энэ нь Монголчуудын улс төрийн ахуйг ойлгон баримжаалах ердийн ухамсарын философлог гэнэн төсөөлөл бүхий угтал философи хэлбэрээр эхэн үедээ илэрч, домог, домог зүй, шашин-ёс зүйн хэв шинжээр нөхцөлдсөн уламжлалт философитой шүтэлцэн хөгжиж улмаар төр, төр ёсны философи төсөөлөлөөр баяжин нарийвчлагдсан байдаг. Үүнтэй холбогдуулан манай зарим философчид Монголчуудын улс төрийн философи үзэл санаа юуны түрүүнд төр, төр ёсны философиор дамжин их төлөв илэрч байсан гэж үздэг нь тохиолдлын хэрэг биш юм. Гэхдээ Монголчуудын төр, төр ёсны философи тэдний улс төрийн философийг бүхэлд нь төлөөлж чадахгүй гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Харин энэ тохиолдолд төр, төр ёсны философийг Монголчуудын улс төрийн бүхэл философи үзэл санааны эх авах суурь үндэс, оюунлаг нэгэн тулгуур бүрдэл гэж үзэх нь зохистой байна. Монголчуудын төр, төр ёсны философи түүхэн хөгжлийнхөө явцад агуулгын хүрээ багтаамжийн хувьд өргөжин тэлж, улс төрийн бүхэл философи тогтолцоот үзэл санааны хэлбэрийг олсон байдаг. Тэгэхдээ энэ хувьсал төлөвшлийн энгийнээс нарийнд шилжих нэн урт удаан төвөгтэй үйл явц байсан гэдгийг дахин онцлоё.

Ингэхлээр дээр тэмдэглэсэн бүхнийг нэгтгэн дүгнэж үзвэл Монголчууд түүхийн сорилтыг даван туулж, шалгарсан улс төрийн философийн арвин баян уламжлалтай байсан нь илэрхий байна. Энэ нь тэдний 3000 гаруй жилийн түүхтэй* төр ёсны философийн суурь үндэс болж байлаа. Монголчуудын улс төр, төр ёсны философийн онол суртахууны тулгуур үндэс нь олон талтай, өргөн агуулгатай байжээ. Энэ нь юуны түрүүнд *хоосон чанар; төв ёсны болон арга, билгийн шүтэлцлийн философи; гурвал сэтгэлгээ, хос ёсны онол; мөнх тэнгэрийн философи* зэрэг Монголчуудын уламжлалт язгуурын философийн онол, үзэл баримтлалын үнэт зүйлсээс үндэс улбаатай юм. Энэ бүгдээс үзвэл Монголчууд өвөг дээдсээс залгамжлан авсан улс төрийн философи үзэл санааны түүхэн уламжлалтай байсан гэдэгтэй маргах бараг хэрэггүй бизээ. Тэгвэл Монголчуудын *улс төрийн философи мэдлэгийн тогтолцоо* нь юу байж болох вэ? гэсэн асуудал эндээс зүй ёсоор гарч ирж байна.

Монголчуудын улс төрийн философийн тулгуур үзэл санааны тухайд

Алив философи өөрийн язгуур ойлголт, тулгуур болох үзэл санаанд суурилж байдаг нь жам юм. Энэ тухайн философи сургаалийн дотоод гүнд оршигч эх авах үнэ цэнэтэй санаа үндэслэл, суурь ойлголт томьёолол гэсэн агуулгаар их төлөв ойлгогддог. Миний санахад философийн суурь голлох үзэл санаа нь илрэх хэлбэр, хүрээ, түвшний хувьд олон талтай өргөн юм. Тэгэхлээр түүнийг илрэх хэв маяг, агуулгын хувьд өргөн багтаамжтай ойлгох гэж оролдох нь зүйтэй санагдана. Нэг ёсондоо түүнийг бүхэл тогтолцоо гэдэг агуулгаар цогц байдлаар авч үзнэ гэсэн үг.

Философи бүхэл оюунлаг мэдлэгийн тогтолцоо нь зөвхөн тухайн философи үзлийн суурь тулгуур болох үнэ цэнэтэй рациональ үндэслэл дүгнэлт ойлголт, санаа

* Монголчуудыг 2220 жилийн төр ёсны түүхтэй хэмээдэг. Тэгвэл зарим судлаач мэргэд Монголчууд бараг 4000 гаруй жилийн төр ёсны түүхтэй байсан гэж үздэг. Монголын төр ёсны түүхийг Хүннүгийн үеэс эхлүүлэх нь зүйтэй боловч Хүннүгийн төрийн бүтэц гэнэтхэн бий болчихоогүй, харин энэ нь хэлбэршил төлөвшлийн түүхэн урт үеийг туулсан нь эргэлзээгүй. Энэ хугацаанд бидний өмнө онцолсон төрийн өмнөх үеийн бүтцийн шилжилтийн гэж хэлж болох *угтал төр \ протогосударство * -ийн бүтцийн хэлбэр оршин байсан нь ноттой билээ. Гэвч Хүннүгийн өмнөх үеийн Монгол угсаатны угтал төрийн бүрдлийн талаар өнөө хэр ноттой судалсан судалгаа алга байгаа нь харамсалтай юм.

төдийгөөр хязгаарлагдахгүй. Хэрвээ түүнийг бүхэл тогтолцоот зүйл гэж үзэх тохиолдолд энэ нь тухайн философийн тулгуур болох эх авах оюунлаг хөрс суурь, бүхэл үзэл санаа, ард түмний уламжлал, ёс зан заншил, соёл, угсаатны онцлог болон түүхэн эх сурвалж бичиг шашдирт шингэсэн үнэт чанар, эрхэмлэлтэй бас холбогдох юм. Ингэхлээр философи мэдлэгийн бүхэл тогтолцооны илрэх хэлбэрийн түвшинг *нэгд* тухайн философийн уламжлалт эх тулгуур болох бүхэл оюунлаг хөрс сууртай холбоотой, *хоёрт* эх авах суурь үзэл санаа, цөм ойлголт, томъёолол үндэслэлтэй холбоотой, *гуравт* тухайн философийг бүтээгч ард түмний ёс заншил, хэл, соёл, уламжлалтай холбоотой, *дөрөвт* философи үзэл санааны үндсийг агуулагч эх бичиг, шашдир сурвалжтай холбогдон гарч ирдэг хэмээн үзэх нь зүйтэй санагдана.* Тэгэхдээ ингэлээ гээд алив философийн суурь голлох үзэл санаа хэмээхийг түүний гүнд оршигч үндсэн язгуур санаа үндэслэл, эх авах томъёоллын тогтвортой цогц илэрхийлэл гэдэгтэй нэг их санал зөрөөд байгаа хэрэг биш юм. Монголчуудын улс төрийн философи үзэл санааны тогтолцоо өргөн юм. Энэ чанараараа түүнийг бүхэл тогтолцоо болгож буй бүрдэл элемент олон талт шинжтэй байна гэсэн үг.

Монголчуудын улс төрийн философийн суурь тулгуур болох оюунлаг уламжлалтай холбоотой үзэл санаа. Монголчуудын улс төрийн философи сэтгэлгээ тэдний өөрсдийнх нь *язгуурын уламжлалт философи* түүний угтвар хэлбэр болох домог, домог зүй; шашин- философи, ёс зүйн үзлийн үнэ цэнэт зүйлст суурилж байсан. Энэ агуулгаар авч үзвэл Монголчуудын улс төрийн философи үзэл санааны тогтолцооны эх авах суурь үндэс нь тэдний уламжлалт философи байжээ. Монголчуудын “*уламжлалт философи*” хэмээх ойлголтын тухайд философичид өөрсдийн байр сууриа гаргаж тавьдаг. Тухайлбал үүнтэй холбогдуулан философич Д.Дашпүрэв “... “монголын уламжлалт” гэвэл үндсэндээ буддист философи байх бололтой....Чингэвэл, миний бодож байгаагаар монголын сэтгэгчид буддизм буюу буддын шашны философи ба түүний үндэслүүдэд тайлбар хийх замаар өөрсдийн философийн ном зохиол бичиж түүндээ өөрсдийн өвөрмөц буддист философийн онол, сургаалийг томъёолон тодорхойлсон байна. Иймд буддизмын “хоосон чанарын”, логикийн сургаалууд, психологийн ухааны хүрээнд бие ба сэтгэлийн харилцааны онолын асуудлыг авч үзсэн сургаал, мөн буддын дундад ёсны философитой холбогдуулан нэн үлэмж нарийн тоосны тэгш ба тэгш биш хэм хийгээд, цаг хугацаа болон чиг зүгийн асуудалд зориулсан онолын судалгаанууд бол монголын уламжлалт буддын философийн бүтээлд зүй ёсоор орно гэж бодож байна. Харин чингэхдээ “монголын уламжлалт” философи нь бүхэлдээ буддизмын философи сургаалийн хүрээнд л багтаж байсаныг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болов уу” гэсэн саналтай байна¹⁰ гэж бичсэн байна.

Харин Монголчуудын “уламжлалт философи” нь миний санахад зөвхөн буддийн шашин-философийн уламжлалаар хязгаарлагдахгүй байх гэж бодож байна. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд Монголчууд нүүдлийн иргэншлийн өвөрмөц ахуйгаа дагасан байгальтайгаа нягт уялдсан аж ахуй эрхлэх ёс, ёс заншил, амьдралын хэв маягийн онцлог хэлбэрийг бий болгосон байдаг. Ингэхдээ түүн лугаа зохицсон байгаль эх дэлхий, тэнгэр, газартаа суурилсан гүн ухааны сэтгэлгээний олон зууны өв уламжлалыг давхар бүтээн туурвижээ. Монголчуудын философи сэтгэлгээний онцлогийн тухай академич Г.Лувсанцэрэн бичихдээ: “Байгалтай зохицсон аж төрөх ёсны нэг илрэл нь Тэнгэр, Газрын нэгдлийг голчоор баримтлах үзэл, дадал болно. Газар дэлхий, Агаар тэнгэр хоёр үзэгдэл, үйлчлэлийн нягт уялдаатай, байгалийн нэгдмэл цогц болох нь ойлгомжтой. Түүгээр зогсохгүй байгалын бүрдэл хэсэг болсон хүн, түүний үйл

* Энэ удаад эхний хоёрынх нь талаар л товч боловч зарим зүйлийг тодруулан авч үзэх болно.

¹⁰ Д.Дашпүрэв. Монголын философийн товч түүх. Уб.,2013, 14-15 дахь тал

ажиллагааг ч уг нэгдэлтэй холбон үздэг байв."¹¹ гэсэн сонирхолтой дүгнэлтийг дэвшүүлсэн байна. Хүн төрлөхтөний философи сэтгэлгээний түүхэнд байгаль түүний тодорхой бодит үзэгдэл, үйл явцтай нягт холбоотой байж, тэдгээрийг номлол үндэслэлийнхээ гол чиг баримтлалаа болгодог философи сэтгэлгээний хэлбэрийг *бодит үзэгдлийн оршихуйн философи* буюу *натурфилософи** хэмээн оноон томьёолдог. Чухамдаа *натурфилософийн Монгол маягийн хэлбэр* нь Монголчуудын философи сэтгэлгээний ерөнхий дүр төрх, хэв загвар нь болж байжээ гэж үзэж болохоор байдаг.

Монголчуудын натурфилософи философийн үзэл нь хөгжлийн урт замналыг туулжээ. Энэ нь философийн дуализмаас философийн монизмын арга зарчимд суурилах болсон түүний түүхэн хувьсал өөрчлөлтийн үйл явцаас тодорхой харагддаг. Эхэн үедээ монголчууд ертөнц, ахуйн үүсэл, мөн чанарыг тайлбарлахдаа оюун ухаан болох тэнгэр, бодит материаллаг юмс үзэгдэл болох газар хэмээх харилцан хамаарал бүхий хоёр эхлэлтэй хэмээсэн философийн үзлийг номлож байснаа аажимдаа тэдгээрээс илүү гарсан, тэдгээрийг нөхцөлдүүлэгч цорын ганц эхлэл болох мөнх тэнгэрийн тухай философийн цогц баримтлалыг гаргаж ирсэн байдаг. Энэ бүхнээс үзвэл Монголчуудын онтологи философийн ерөнхий хэв шинж нь бодит үзэгдлийн оршихуйн философи буюу натурфилософи, харин түүнд суурилсан философи үзлийнх нь онол, номлолын суурь үндэс, гол хэлбэр нь тэнгэр шүтлэгийн философи байжээ гэж үзэх үндэстэй байж болох юм. Энэ нь уг чанартаа онол, хийсвэрлэлийн түвшинд системчлэгдсэн өөрийн өвөрмөц ойлголтын тогтолцоо бүхий философийн бие даасан ерөнхий сургаал, үзэл юм гэж хэлж болохоор байна. Энэ агуулгаараа мөнх тэнгэрийн философи нь шашнаас дээш гарсан философийн гүн гүнзгий хийсвэрлэл болж байдаг. Монголчуудын мөнх тэнгэрийн үзэл бол ямар нэг далдын хүч, эзэн тэнгэр хэмээгч шашны агуулгатай ойлголт бус, харин монголчуудын хүрээлэн байгаа байгаль, ертөнц, нийгэм, ахуйгаа ойлгон ухаарах философи үзэл, төсөөллийн цогц оюунлаг тусгал, тэдний аливааг танин барих онол, сэтгэлгээний гол суурь үзэл санаа **юм**. Энэ нь монголчуудын философийн ертөнцийг үзэх үзлийн нийтлэг илэрхийлэл мөнийн хувьд оршин буй бүхний үндэс суурь болж, юунаас ч үл хамаарах, бүхнийг нөхцөлдүүлэгч, тэтгэн дэмжигч субстанцлаг, туйлын шинж бүхий түгээмэл, харьцангуй ойлголт юм гэж үзэж байна.¹² Харин энэ нь монголчуудын язгуурын шүтлэг болох бөө мөргөлийн шашин философийн үзэлтэй нягт холбоотой хөгжиж ирсэн нь тодорхой. Үүний учир нь бөө мөргөлийн гол шүтээн нь онгод, онгон сахиус бөгөөд тэрхүү онгодын гол илэрхийлэл нь тэнгэр болж байсан билээ. Үүнтэй холбогдуулан академич Г.Лувсанцэрэн "Мөнх тэнгэрийн үзэл бөө мөргөлтэй огт холбоогүй биш, харин бөө мөргөлөөс улбаалсан түүнээс дээш гарсан гүнзгий хийсвэрлэл юм хэмээн ойлгогдож байна."¹³ гэж тэмдэглэсэн нь анхаарал татаж байна. Эндээс үзвэл Монголчуудын уламжлалт философи үзэл нь бөө мөргөлийн шашин-философийн үзлээс өвөрмөц ялгаатай харьцангуй бие даасан шинжтэй байсан нь ойлгогдож байна.*

Монголчуудын улс төрийн философийн тогтолцоо нь тэдний ерөнхий язгуурын философид суурилахаас гадна бас төр, төр ёсны философиор дамжин хөгжсөн нь үнэнтэй билээ. Ингэхлээр Монголчуудын төр, төр ёсны философи буюу зарим

¹¹ Г.Лувсанцэрэн. "Монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний онцлогоос". Олон улсын Монголч эрдэмтэдийн VII их хурал. \ 1997-8-12-16 \ УБ., 1999, 262 дахь тал.

*"Натурфилософи" хэмээх нэр томъёо нь үгийн гарал зүйн хувьд *natura*- байгаль ,байгалийн философи гэсэн латин үг ажээ. Энэ нь ертөнц, нийгмийн юмс үзэгдлийн анхдагч үндэс, учир шалтгаал түүний мөн чанарыг тайлбарлахдаа байгалийн тодорхой биет юмс үзэгдэл лугаа шүтэлцүүлэн түүгээр дамжуулан хийсвэрлэх философи арга, сэтгэлгээний нилээд эртний анхдагч хэлбэр мөн билээ. Тиймээс ч түүний энэ агуулгыг үндэс болгон өнөөгийн зарим философчид натурфилософийг байгалийн философийн хэлбэр хэмээх нь бий.

¹² Д.Болд-Эрдэнэ. "Мөнх тэнгэр"-ийн гүн ухаан ба төр ёс" Эрдмийн ертөнц" сэтгүүл. 2012 № 1 (06)

¹³ Монголын философийн түүх. (XIII-XVIII) II-дэвтэр. УБ., 2000, 127 дахь тал.

* Монголчуудын философи, бөө мөргөлийн хоорондын харилцан хамаарал, зарим ялгаа онцлогийн тухайд илтгэгчийн бичсэн "Их Монгол улсын улс төрийн сэтгэлгээ" УБ., 2005 номоос дэлгэрүүлэн үзэж болно.

судлаачдын оноон нэрлэдэг шиг “хаан философи” нь тэдний улс төрийн философийн эх авах суурь хөрс нь бас мөн билээ. Монголчууд бараг 4000 гаруй жилийн төр ёсны түүхэн уламжлалтай байжээ. Монголчууд эрт үеэс хүн төрөөс гадна орших боломжгүй “хүн ахтай, дээл захтай”, “хүн тэнгэрийн дор төрж, төрийн дор амьдрана” хэмээн үзэж, хүчэрхэг төрийг тогтоон хэрэгжүүлж, төр засахуйн ухааныг хөгжүүлж ирсэн байна.

Монголчуудын улс төр, төр, төр ёсны философид тэнгэр шүтлэгийн философийн нөлөөлсөн гол нөлөө гэвэл энэ нь хаан эзнээ “тэнгэрийн хүү”, “тэнгэр заяат” хэмээж, төрийн хийморь сүлдийг тэнгэртэй холбон ойлгон төсөөлөж байсан болон төр, төр ёсны тэнгэр шүтлэгтэй холбоотой билэгдэл, ёс журам, хэм хэмжээ, зан үйлийн ёс горимоор тод томруун илэрч байжээ.

Монголчуудын улс төрийн философийн эх авах үндсэн ойлголт, томъёололоор дамжин илрэх суурь үзэл санаа. Монголчуудын улс төрийн философи мэдлэгийн тогтолцооны гол агуулга нь тэдний нүүдлийн иргэншлийн онцлог, амьдралын хэв маяг, сэтгэх өвөрмөц арга, хэв шинжтэй холбогдсон улс төр, төрийг ойлгох үзэл сэтгэлгээний суурь үндэслэл, томъёололоор тодорхойлогддог. Тэгэхдээ Монголчуудын улс төрийн философийн суурь голлох үзэл санаа нь *эрх чөлөө, шударга ёс, эв нэгдэл, үүрэг хариуцлага* түүний философи мөн чанарын тухай сэдэв юм. Дээр онцолсон асуудлыг Монголчууд оршин ахуйн түүхийн явцад Өрнөдийн улс төрийн философийн тайлбараас онцлог ялгаатайгаар тэгэхдээ монгол улс төрийн ахуй, ухамсартай шүтэлцүүлсэн хэлбэрээр авч үзэж байсанаараа онцлог юм.*

Монголчуудын улс төрийн бүхэл философи сэтгэлгээ юуны түрүүнд төр, төр ёсны үзлээс эх авсан гэдгийг өмнө нэгэнтээ онцолсон. Тэгвэл тэдний улс төрийн философи ойлголтын тогтолцоонд төр, төр ёстой холбогдсон олон суурь ойлголт, үндэслэл түүнд хамаарах тулгуур үзэл санаа байдаг. Тэдгээрийн заримаас энд онцолвол дараах зүйлсийг дурьдаж болох байна. Үүнд:

- ✚ Тэнгэр шүтлэг
- ✚ Төрийг хүндэтгэн шүтэх үзэл,
- ✚ Хаан эзнээ хүндэтгэн дээдлэх үзэл санаа
- ✚ Захирах захирагдах ёсны үзэл санаа
- ✚ Шударга төв голч байх чанар
- ✚ Хууль дээдлэх үзэл
- ✚ Эрхийг биш үүргийг ухамсарлах сэтгэлгээ
- ✚ Эв нэгдэл, эв эеийн үзэл философи
- ✚ Хүнлэг нийгүүлсэнгүй үзэл сэтгэл зэргийг дурьдаж болох байна.*

Тэгэхдээ Монголчуудын улс төрийн философи нь дээр онцолсон төр, төр ёстой холбогдсон тулгуур үзэл санааг зүгээр л улс төрийн амьдрал, төр ёсны үйл ажиллагаатай холбон эмпирик түвшинд тайлбарлах биш, харин түүний дотоод метафизик үндэс, учир зүй, утга чанар, шалтгаант хамаарал, хувьсал өөрчлөлт түүний Монголчуудтай холбогдох давтагдашгүй ялгаа онцлогийн агуулгыг хийсвэр дотоод оюунлаг талаас нь философи гүнзгий үндэстэйгээр эрэгцүүлэн бясалгаж, ерөнхийлөн ойлгоход чиглэгдэж байсаныг зайлшгүй онцлох хэрэгтэй юм.

* Энэ удаад энэ бүхний тухайд философи дэлгэрэнгүй тайлбар хийх зорилго тавьсангүй. Энэ нь өгүүлэлд тавигдах үндсэн шаардлагаас хамааран товчлох болсонтой холбоотой болно.

* Энэ удаад энэ бүхнийг философи агуулгаар нь тус бүрд нь дэлгэрэнгүй тайлбарлах гэсэнгүй. Харин үүнтэй холбоотой дэлгэрэнгүй зүйлийг Ч.Жүгдэр. “Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил” \Уб., 2006\, илтгэгчийн “Их монгол улсын улс төрийн сэтгэлгээ” \Уб., 2005\; илтгэгчийн оролцож бүтээлцсэн “XIII-XIV зууны Монголын улс төрийн сэтгэлгээний зарим асуудал” \Уб., 2006\ түүнчлэн “Монголын төр ёс, эрх зүйн сэтгэлгээний зарим асуудал” \Уб., 2002\ хамтын бүтээлээс үзэж болно.

Харин энэ удаад Монголчуудын *төрийг шүтэх үзлийн* тухайд тойм төдий зүйлийг тодруулан үзье. Төрийн тухай асуудал бол философи, улс төр, эрх зүй, төрийн онол зэрэг олон мэдлэгийн зааг уулзвар дээр судлагдаж байдаг өргөн агуулга бүхий судлагдахуун юм. Үүний нэг адил энэ асуудал нь мөн улс төрийн философийн чухал сэдэв болдог. Монголчуудын төр, төр ёсны философи XIII зууны үеэс бүрэн агуулгаараа цэгцрэн боловсорсон гэж үздэг. Төрийг Монголчууд хүний өөрийнх нь бусдыг удирдан зохицуулах, эрх мэдлийг хэрэгжүүлэх гэсэн төрлөхийн зөн совин, мөн чанараас үүдсэн зүй ёсны үзэгдэл гэж байсан төдийгүй энэ нь хүн хоорондын улс төрийн харилцааны хүрээнд зайлшгүй байж байх ёстой институт гэж үзэж байв. Монголын төр, эрх зүйн сэтгэлгээний тулгуур эх сурвалжийг нягтлан үзвээс “*төр*” гэдэг ойлголт орчин цагийн агуулгаар хэрэглэгдэж байгаагүй бололтой. Тэр үед төрийг “*ёс*”, “*улс*”, “*хаан*” хэмээх ойлголттой хамаатуулан үзэж байжээ. Монголчууд төрийг нэгдүгээрт ёс журмын илэрхийлэл; хоёрдугаарт улсын хууль ёсны илэрхийлэл; гуравдугаарт эзэн хааны *эрх мэдлийн илэрхийлэл* хэмээн ойлгон төсөөлж байжээ.

Хэдий тийм боловч “Монголын нууц товчоо” \ МНТ-254 \ болон “Хөх судар”-т “Эрхэм өршөөлт сайн эзэн улсын эрдэнэ. Эрх ухаант сайн түшмэл төрийн эрдэнэ”¹⁴ зэргээс үзвэл XIII зууны үед “*улс*” гэдгийг хүн ард, нутаг дэвсгэр, засаг эрх мэдэл хэмээх 3 гол ойлголттой холбон үзэж байсан бөгөөд *засаг эрх мэдэл* гэдгийг ерөнхийд нь “*төр*” гэдэгтэй, харин “*хаан*”-ыг төрийг төлөөлөн, түүний эрх мэдлийг хэрэгжүүлэгч гол хүн гэдэг агуулгаар ойлгож байсан нь тодорхой байна. Эндээс үзвэл монголчууд “*төр*”, “*улс*”, “*хаан*” хэмээх гурван ойлголтыг ялган үзэж байжээ гэдэг нь ойлгогдож байна. Тиймдээ ч Монголчууд “улсын дотор төр буй, төрийн дотор ёс буй” хэмээхийн дээр төр ёсыг баригчийг улсын эзэн \хаан\ хэмээн ойлгож байсан байна. Эндээс үзвэл *ёс журам, улс орон, эзэн хааны сүр хүч* зэрэг нь Монголын нэгдмэл төрийн цогц чанарыг бүрдүүлэгч тодорхой бүрдэл шинжүүд нь болж байсан гэж үзэх үндэстэй байна. Харин Монголчууд XIII зуунд төрийг дарангуйлагч хэрэгсэл, хүнд суртлын аппарат гэж хэзээ ч үзэж байгаагүй бөгөөд түүнийг *мөнх тэнгэрийн хүчинд оршигч зохицуулан, зохион байгуулж, ард олныг амаржуулагч үүрэг бүхий хамтын зохион байгуулалтын хэлбэр* гэж үзэж байсан нь ноттой юм. Монголчууд эрт үеэс төрийн тухай бүхэл цэгц үзлийг дагасан төр ёсны олон үеийн түүхэн ёс журам, уламжлалыг бүтээн бий болгосон байдаг. Төр ёс гэдэг нь тэдний үзэж байсанаар төрийн үйл ажиллагааны хэлбэршин тогтсон хэм хэмжээ, ёс горим журам, арга зарчим, соёл, үнэт чанарын цогц илэрхийлэл болж байжээ. Энэ агуулгаар нягтлан үзвээс төр ёс гэдэг нь Монголчууд *төрийг засах ухаан* гэсэн агуулгаар ерөнхийлөн ойлгож байсан бололтой.

Энэ бүхнээс үзвэл Дорно дахин тэр дундаа Монголчуудын төрийг үзэж хандах философи үзэл хандлага Өрнөдийнхөөс онцлог ялгаатай байсан нь харагдаж байна. Энэ нь юуны түрүүнд өргөн уудам газар нутаг, хүн ардын сийрэг тархан суурьшсан байдал тэдний нүүдлийн амьдралын хэв маягтай холбоотойн зэрэгцээ нийгмийн улс төрийн амьдралд төрийн үүрэг оролцоо өндөр байсантай бас хамаарч байгаа юм. Үүнтэй холбоотойгоор Өрнийн зарим судлаачид төрийг үзэх Дорнын үзэл сэтгэлгээг “Дорнын деспотизм”^{*} хэмээн нэрлэх нь байдаг. Гэтэл Монголчууд үүнийг деспотизм гэж үздэггүй, харин тэдний “хүн ахтай, дээл захтай, тэнгэрийн дор төрж, төрийн дор амьдрана” гэж үзэж ирсэн төр хүндэтгэх өвөрмөц сэтгэлгээтэй нь холбоотой байна. Ер нь Ази, Дорно дахинд төрийн үүрэг өндөр байдагийг нягталбал, дан ганц хоцрогдол, эсвэл ардчилал, зах зээлийн харилцааг ойлгож хэрэгжүүлж чаддаггүй гэсэн учир холбогдлоор биш, харин энэ нь байгаль, түүх, аж төрөх ёс, нийгэм-сэтгэл зүй,

¹⁴ В.Инжиннаш. Хөх судар. Хөх хот 1957, 594 дахь тал

* *Деспотия* \грек. Despoteia-хэмжээгүй засаг\ - төр баригч нь дураар авирладаг, албатууд нь өчүүхэн ч мэдэлгүй хэмжээлшгүй эрхт засаглалын хэлбэр.

уламжлал, зан заншил, сэтгэх хэв шинжийн онцлогоор нөхцөлдсөн жам ёсны объектив үзэгдэл юм. Ийм нөхцөлд юуны өмнө төрийн өмчлөлд буй өргөн уудам газар нутаг нь төвлөрсөн удирдлага зохион байгуулалт, хүчтэй тэгэхдээ ухаалаг төрийн оролцоо, зохицуулалтыг хүссэн хүсээгүй шаарддаг байна.

Ашигласан бүтээл

Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ. \хоёр дахь хэвлэл\ Уб.,2002

Б. Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи: \ асуудал, аргачлал, ашиг тус\ Уб.,2013

Д.Дашпүрэв. Монголын философийн товч түүх. Уб.,2013

Батын Ч.Ган-Өлзийн “Хүмүүнлэгийн гурван ертөнцийн гоц чанарыг судлахуйн чандмань эрдэнэ”. Уб.,2011

Ричард Поупкин, Аврум Стролл. Гүн ухаан. Уб.,1998

Б.Батчулуун. Пост-коммунист нийгэм дэх төр, иргэний харилцаа. Уб.,2003

Гаджиев К.С. Политическая философия. М.,1999

History of Political philosophy. Chicago. 1987

Г.Лувсанцэрэн. “Монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний онцлогоос”. Олон улсын Монголч эрдэмтэдийн VII их хурал. \ 1997-8-12-16 \ Уб.,1999

Д.Содномгомбо. Улс төрийн философийг тоймлох нь. Политологи. 2007 № 281

Д.Болд-Эрдэнэ. “Мөнх тэнгэр”-ийн гүн ухаан ба төр ёс” Эрдмийн ертөнц” сэтгүүл. 2012 № 1 (06)

ФЕМИНИЗМ БА ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭЛ

Ё.ДОВЧИН¹, Б.ОДГЭРЭЛ²

¹МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, доктор

²МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, докторант

Түлхүүр үг: Эмэгтэйчүүд, тэгш эрх, эмэгтэйчүүдийн санал өгөх эрх, эцгийн эрхт ёс, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо

ABSTRACT: *In the beginning of XIX century, women have no right to participate in politics. And they have passed long way to obtain equal right to vote in politics. Since XV century "Ideology women equality in social life" has come up. But we considering in this context only since XIX century. In this context all about feminist wave in political right.*

Эмэгтэйчүүдийн эрхийн тухай асуудал харьцангуй хожуу үед буюу XIX зууны эхэн үеэс эхлэлтэй юм. Чухам энэ үеэс эмэгтэйчүүд нийгмийн амьдралд татагдан орох эхлэл тавигдсан байдаг. Энэ үед эрэгтэй эмэгтэй хүйсийн тэгш байдлын тухай нийгмийн шинэ онол феминизмын үзэл санаа бий болж эмэгтэйчүүд эдийн засаг, нийгмийн амьдралд тэгш оролцох суурь тавигдсан байна. Феминист үзэл нь эмэгтэйчүүдийг эрчүүдтэй адил тэгш эрхтэй байх улс төр ба эрх зүйн нөхцөл бололцоо олгохыг шаарддаг. Феминизмийн онол сургаал нь харьцангуй хожим үүссэн гэдэг нь эмэгтэйчүүдийг анхаарч авч үзсэн улс төрийн сургаал номлол XV-р зуун хүртэл байгаагүйтэй холбоотой. Улс орноо удирдаж байсан эмэгтэйчүүд түүхэн тэмдэглэгдсэн байдаг ч энэ нь угсаа залгамжлах ёсонд суурилсан байснаас хэтэрсэнгүй.

Феминизм гэдэг үгийг Кэмбриж болон Вебстерийн толь бичигт “Эмэгтэйчүүдийн эдийн засаг, улс төр, нийгмийн тэгш эрхийн хамгаалах, түүнийг бий болгоход чиглэгдсэн үзэл санаа болон хөдөлгөөнүүдийн нийлбэр цогц юм”.^{15,16} гэжээ. Үүнд мөн эмэгтэйчүүдийн боловсрол эзэмжих болон ажил эрхлэлтийн тэгш бололцоо хамаарна. Феминизм гэсэн нэр томъёо 1890-ээд оноос Франц хэлнээс Англи хэлэнд орчуулаагүйгээр шууд хэрэглэгдсэн байна.¹⁷ Өнөөдөр феминизм нь нэг талаас эмэгтэйчүүдийн тэгш эрхийн төлөөх хөдөлгөөн, нөгөө талаас улс төрийн үзэл онол, мөн нийгмийн шинжлэх ухааны арга зүйн хандлага гэдэг утгаар хэрэглэгдэж байна.

XIX-XX зуунд эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх үзэл санаа эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх хөдөлгөөн болон өрнөж феминизмийн үзэл санааны баттай суурь тавигдсан байна. Энэ үед АНУ-д болон Европын цөөнгүй улс орнуудад либерал үзэл санааны нөлөөгөөр эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, санал өгөх эрхийг хүлээн зөвшөөрчээ. Энэ үед орчин үеийн феминизмийн 3 давалгаа өрнөсөн гэж жендер судлаач Шарлотт Кролокк үзсэн байна.¹⁸

1. Феминизмийн I давалгаа: /XIX- XX зууны эхэн үе/
2. Феминизмийн II давалгаа: /1960-1990 он/
3. Феминизмийн III давалгаа: /1990-оноос одоог хүртэл/

¹⁵ [Feminism –Webster Dictionary](http://Merriam-Webster.com). merriam-webster.com. Retrieved 12 June 2011.

¹⁶ [Feminism-Cambridge Dictionary Online: Free English Dictionary and Thesaurus](http://Dictionary.Cambridge.org). Dictionary.Cambridge.org. Retrieved 12 June 2011.

¹⁷ Margaret walters. *Feminism: A very short introduction*. Oxford press. 2006.,pp-1

¹⁸ Charlotte Krolokke. *Gender communication theories and analyses from: Silence to performance*. Sage publication. 2006pp-4

Феминизмийн I давалгаа: Эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх үзэл санаа бэхжин тогтож АНУ болон Европд феминизм зэрэгцэн хөгжиж голчлон олон нийтийг хамарсан хөдөлгөөний шинж чанартайгаар XX зууны эхний хагас хүртэл үргэлжилжээ. XIX-р зууны эцэс гэхэд эмэгтэйчүүд гэр бүлийн хувьд өмчийн эрхтэй, хүүхдээ асран халамжлахад нь зориулагдсан нийгмийн бодлоготой, биеийн хүчирхийлэлийн хувьд хамгаалагдсан, нөхрөөсөө салах эрхтэй болсон байсан боловч нөхөр нь эхнэрээ хүчирхийлэх бүхий л хэлбэр нь хуулиар хориглогдоогүй байсан юм. Боловсрол эзэмших эрхийг хүлээн зөвшөөрсөн ч эрчүүдийн адил дээд боловсрол эзэмших эрхтэй болж чадаагүй. Харин чухам энэ үед эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн төлөөх хөдөлгөөн үүсэн бий болжээ.

АНУ-ын феминизмийн эхний давалгаа дараах байдлаар Европын феминизмээс ялгардаг.

1. Өргөн цар хүрээ бүхий хөдөлгөөний шинж чанартай.
2. Дараа үеийнхээ феминист хөдөлгөөнийг бэхжилтэд шууд нөлөөлсөн шинжтэй байв.

АНУ дахь феминизмийн эхний давалгааны эхэн үеийн онцлог нь феминист хөдөлгөөн болон феминизмийн онол нэг утгатай байсанд оршино. Эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурь, үүрэг болон хүйсийн ялгаатай байдлыг өөрчлөн шинэчлэхээр феминист хөдөлгөөн өрнөж байсан байдаг. Энэ үед мөн өнгөт арьст эмэгтэйчүүд болон ажилчин ангийн эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах тухай анхны үзэл санаа үүсэн бий болж 1868 он гэхэд эмэгтэйчүүдийн асуудлаар тусгайлан ажиллах үйлдвэрчний эвлэл байгуулагдсан юм. Хэдий тийм боловч феминизмийн эхний давалгааны үед эмэгтэйчүүдийн эрхийн тухай асуудал зөвхөн цагаан арьстай, боловсролтой, дундаж давхаргын эмэгтэйчүүдэд л хамаарагдаж байлаа. 1848 онд Нью-Йорк хотноо 300 төлөөлөгчид Сенека Фаллын конвенц¹⁹-ийг баталсан юм. Энэ үеээс АНУ-д эмэгтэйчүүдийн санал өгөх эрхийг төлөөх хүчтэй тэмцэл өрнөж эхэлсэн гэж үзэж болно. Энэ конвенцид эмэгтэйчүүдийн тэгш эрх болон улс төрийн тэгш оролцооны тухай анхлан тусгах асуудлыг санаачлан амжилтад хүрсэн байна.

Английн эмэгтэйчүүдийн санал өгөх эрхийн төлөө тэмцэгч Миллисент Гаррет Павсетт (1847-1929) 1919 он хүртэл Их Британи дахь “Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн төлөөх нийгэмлэг”-ийг удирдаж байсан бөгөөд Миллийн адил утлитари хандлагаар “Common Cause”-өгүүлэлээ бичсэн бөгөөд тухайн өгүүлэлдээ “Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийг олж авах нь эрчүүдийн хувьд улс төрийн аливаа асуудлыг эмэгтэйчүүд, хүүхдүүдийн байр сууринаас харахад туслана.”²⁰ гэжээ. Англид эмэгтэйчүүдийн санал өгөх эрхийг эрчүүд ихээр эсэргүүцэж байсан бөгөөд харин эмэгтэйчүүдтэй зэрэгцэн ажиллаж байсан дундаж давхрагын эрчүүдийн санаа бодол удалгүй өөрчлөгдөж анги давхарга дээр суурилан нийгмийн зарим хэсэг эмэгтэйчүүдийн санал өгөх эрхийг хүлээн зөвшөөрөх болсон байна.

Эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгчдийг тухайн үед нийгэмд хамгийн “эмэгтэйлэг бус эмэгтэйчүүд” гэж үзэж байсан бөгөөд нийгмийн чиглүүлэгч нь хэзээ ч эмэгтэй хүн байж таарахгүй гэсэн тогтсон үзлийн эсрэг тэмцэлд нь ямагт эсэргүүцэн хандаж байлаа. Энэ үед гэрийн ажил бол зөвхөн эмэгтэй хүний ажил гэсэн үзэл санаа дэлхий даяар тогтож байлаа. Феминизмийн хөдөлгөөн эмэгтэйчүүдийг үг хэлж үзэл санаагаа илэрхийлэх боломж олгож, ингэснээр удирдагч эмэгтэйчүүдийн шинж чанар бий болжээ. Энэ нь эмэгтэйчүүдийн биологийн сул талуудыг үгүйсгэх үндэслэл гарч ирэх эхлэл болжээ. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүд хэдийгээр өөр өөр биеийн бүтэцтэй боловч нийгэмд эзлэх байр суурь үүнээс хамаарах ёсгүй юм.

¹⁹Тайлбар: Сенека Фаллын конвенц нь өрнөдийн ертөнц дэх хамгийн анхны нөлөө бүхий эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх конвенц гэж тооцогддог бөгөөд Нью-Йорк хотод 2 өдөр, 6 салбар хуралдаантай хуралсан байна.

Эмэгтэйчүүд улс төрийн амьдралд оролцсоноор гэрийн эзэгтэй нарын болон хүүхдээ асран хамгаалж байгаа эмэгтэйчүүдийн нөхцөл байдал мөн сайжирах бөгөөд эмэгтэйчүүд нийгмийн баялаг бүтээхэд нөлөө үзүүлэнэ. Нэн ялангуяа эмэгтэйчүүд санал өгөх эрхтэй болсоноор эмэгтэйчүүдийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдал мэдэгдэхүйц сайжирч, ардчиллын зарчмууд бүрэн биелэх бололцоо бүрэлдэх юм. Үүнд хүрэх цорын ганц арга зам бол эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулсан хууль юм. Хууль нь утгаа эмэгтэй хүнд эс үйлчилбээс бүгдэд үйлчлэхгүй гэсэн үг гэж анхны феминист давалгааны тэмцэгчид үзэж байв.²¹

Эмэгтэй хүний биологийн ялгаа нийгмийн болон жендэрийн байр суурьт нөлөөлөх ёсгүй ба хэдийгээр хүйсийн ялгаатай байдал нь гарцаагүй боловч улс төрийн болон нийгмийн амьдралын үйл явцад оролцох ялгаатай байдлын шалтгаан гэж үзэж болохгүй юм. Улс төрийн хувьд феминизм эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүд ижил тэгш эрхтэй гэсэн гол зарчимтай бөгөөд эрэгтэйчүүдэд байгаа өрсөлдөх чадвар, эрх мэдэл, тэдэнд давуу олгогддог мэдээллийг эмэгтэйчүүдэд тэгш нөөцтэйгөөр өгөх учиртай гэдэг үзэл гарч цаашид тэгш бололцооны феминизм гэж нэрлэгдэх болсон юм.

Эмэгтэйчүүдийн санал өгөх эрхийг хамгийн анх хүлээн зөвшөөрсөн улс бол өрнөдийн орнуудаас Шинэ Зеланд бөгөөд 1894 онд анх энэ эрхийг хуульчилсан байдаг. Үүний дараахан Австрали, Европд Финланд, Норвеги 1914 он гэхэд эмэгтэйчүүдийн санал өгөх эрхийг хүлээн зөвшөөрсөн байлаа. Ихэнх улс орнууд дэлхийн 2-р дайны дараа эмэгтэйчүүдийн сонгох эрхийг хүлээн зөвшөөрсөн. Харин Их Британид 1918 онд эмэгтэйчүүдийн санал өгөх эрхийг хязгаартайгаар баталсан бөгөөд их сургууль төгссөн, орон нутагтаа татвар төлөгч, эсвэл татвар төлөлгчийн эхнэр, 30 нас хүрсэн эмэгтэй санал өгч болно гэж хуульчилжээ. Энэ нь насанд хүрсэн эмэгтэйчүүдийн 50 хүрэхгүй хувь нь болж байжээ. Харин АНУ-ын хувьд 1920 онд 19-р нэмэлт өөрчлөлтөөр АНУ-д эмэгтэйчүүдийн санал өгөх эрхийг тунхагласан юм. Улс орон бүрт эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь, улс төрийн нөлөөлөл харилцан адилгүй байсан нь тухайн улсад байгаа уламжлал, феминист хөдөлгөөний нөлөөллөөс ихээхэн хамаарсан байна.

Феминизмийн I давалгааны энэ үед мөн европын аж үйлдвэржсэн нийгэмүүдэд социалист болон марксист феминизм үүсэн бий болжээ.

Анхны феминизмийн давалгааны гол зорилго бол эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хүлээн зөвшөөрүүлэх арга замыг тодорхойлох явдал байжээ. Энэ гол гаргалгаа нь хууль гэдэгт бүгд санал нийлж байв. Энэ үйл явц АНУ болон Европд зэрэг явдагсан байна. Энэ нь либерал үзэл санааны түгээмэл үсрэнгүй хөгжилтэй холбоотой юм. Хэдийгээр либерал үзэл баримтлалын суурь дээр эмэгтэйчүүдийн тэгш эрхийг тунхаглах нь илүү хялбар болж байсан боловч энэ үеийн хамгийн том ахиц дэвшил бол шашны зарим урсгал эмэгтэйчүүдийн эрхийг хүлээн зөвшөөрсөн явдал байв.

АНУ болон Их Британийн арал дээр эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалсан хөдөлгөөнүүд үүсэн бий болж улс төрийн эрх, өмчийн эрх, боловсрол олж авах бололцоог эмэгтэйчүүдэд олгохыг шаардаж тодорхой амжилтад хүрсэн байна. Энэ үед Их Британид “Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн төлөөх нийгэмлэг”, АНУ-д “Үндэсний эмэгтэйчүүдийн нам”, “Нэгдсэн улсын эмэгтэйчүүдийн санал өгөх эрхийн ассиоцаци” байгуулагдсан. Энэ нь эмэгтэйчүүд феминизмийн I давалгааны хугацаанд эрхийн төлөөх тэмцэлдээ тодорхой амжилт гаргаад зогсохгүй эмэгтэйчүүдийн хөдөлгөөн институтжиж эхлэсэн гэж дүгнэхэд хүргэнэ.

Феминизмийн II давалгаа: /1960-1990 он/

1945 он гэхэд эмэгтэйчүүд барууны ертөнцийн ихэнх орнуудад улс төрийн эрхээ баталгаажуулж эрэгтэйчүүдтэй ижил тэгш боломжтой болжээ. Франц хэдийгээр феминизмийн үзэл санаа анхлан бий болсон улс орнуудын тоонд орж байсан ч 1944 онд

²¹Charlotte Krolokke. Gender communication theories and analyses from: Silence to performance. Sage publication. 2006pp-20

л эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийг хүлээн зөвшөөрчээ. Нийгмийн бодлогод ихээхэн анхаардаг бүх нийтийн сайн сайхны төр үүсэн бий болж, энэ хандлага баруун европын улс орнуудад дэлгэрчээ. Их Британи 1942 онд Бевриджийн тайлан гэх баримт бичгээр 2 ба түүнээс дээш хүүхэдтэй эмэгтэйчүүдэд төрөөс халамжийн мөнгө олгож байхаар шийдвэрлэсэн байдаг. Ихэнх улс орнууд өндөр насны тэтгэвэр, эрүүл мэнд, боловсролын хүртээмжээр нийгмийн бодлогыг хүртээмжтэй болгож байлаа. Дайн үед эмэгтэйчүүд нийгмийн бүхий л салбарт ажиллах болж, дээд шатны албан тушаалуудыг мөн хаших болжээ. Гэсэн хэдий ч энэ нь дайны дараах хандлагыг өөрчилсөнгүй, эмэгтэйчүүдийн байр суурь дахин эрчүүдийнхээс доогуур тооцогдох болж ажил эрхлэдэг эхнэрүүдийн тоо нэмэгджээ. Энэ хугацаанд феминист хөдөлгөөнүүдийн эрчим суларсан байдаг. 1950-1970 оны хооронд феминизмийн тухай Симон ДеБоувэрийн “Дайвар хүйстэн”-ээс өөр доривтой бүтээл гараагүй юм.

Феминизмийн II давалгаа нь эмэгтэйчүүдийн эрхийн төлөө өрнөсөн радикал феминизмийн үзэл санаатай нягт холбогдож байв. Дайны дараа Европд зүүний чиглэлтэй хөдөлгөөнүүд хүчээ авч мөн эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх хөдөлгөөнд оюутнууд нэгдэх болсон юм. Зүүний үзэл баримтлалаар эмэгтэйчүүд социалист нийгэм байгуулах хувьсгалд ялалт байгуулсан боловч бодитой улс төрийн эрх мэдэлд бас л хүрч чадаагүй байв. Феминизмийн II давалгааны үндсэн суурь нь марксизм болон психоанализм дээр суурилсан шинж чанартай байсан ба Симон ДеБоувэрийн “Дайвар хүйстэн”, Жулиет Митчелл “Эмэгтэйчүүдийн тухай асуудал”, Шуламит Пайрстоны “Хүйсийн диалектик”, Кейти Милетийн “Хүйсийн улс төр” гэх мэт бүтээлүүд голлох байр суурь эзлэж байв. Эдгээр судлаачдын бүтээлд эцгийн эрхт ёсны үндэс нь хөрөнгөтөн нийгмийн үндсэн шинж бөгөөд хүйсийн ялгаа нь ангийн ялгаа болон арьс өнгөний ялгаварлалаас ч илүү суурь шинжтэй гэсэн нийтлэг санаа харагддаг. Эмэгтэйчүүд гэртээ үнэлгээгүй хөдөлмөр эрхлэж, үр удмаа тээж ингэснээр ажиллах хүчнээс хасагдсан байна гэж үзэж байв. Францын экзистенциалист философич, зохиогч Симон ДеБоувэр (1908-1986) Дайвар хүйстэн зохиолоо 1949 онд анхлан хэвлүүлжээ. Гарсан ариудаа нийгэмд ихээхэн шуугиан тарьсан энэ бүтээлдээ эдийн засгийн хувьд эмэгтэй эрэгтэй хүн бараг л хоёр ангид хуваагдсан байна гэж үзсэн бөгөөд эмэгтэй хүнийг “нөгөөх” хэмээн нэрлэсэн байдаг. Эмэгтэйчүүдийн биологийн ялгаатай байдал нь нийгмийн ялгавартай байр суурийг бий болгох ёсгүй бөгөөд ямар ч нөхцөлд нийгмийн ижил байр суурийг бий болгох ёстой. Энэ ертөнцөд эмэгтэй хүнийг объект хэмээн тодорхойлохыг зорьдог. Мөн эмэгтэйчүүд өөрийгөө субъект хэмээн хүлээн зөвшөөрөхийг шаарддаггүй аж. Өнөөдөр эмэгтэйчүүдийн байдал өөрчлөгдөж байгаа ч тэдэнд маш ашиггүй хэвээр байна. Хуулиндаа эмэгтэйчүүдийн эрхийг хийсвэрээр хүлээн зөвшөөрсөн боловч амьдралын дадал зуршилаас болон хэрэгжих боломжгүй байсаар байна.²² Гэжээ.

1970 оны эхээр Кэйти Миллетийн “Хүйсийн улс төр” бүтээл хэвлэгдсэн. Кэйти Миллетийн “Хүйсийн улстөр” бүтээлийн 2-р бүлэгт феминист сургаалийн эцгийн эрхт ёсны гол концепци тусгагдсан гэж үздэг. Эцгийн эрхт ёсны тухай асуудал нь улс төрийн шинжлэх ухааны салбарт шинэ ойлголт огт биш боловч Кэйти үүнийг феминизмийн хандлагаар тайлбарласанаараа онцлог юм. Тэрээр эцгийн эрхт ёсыг 2 үндсэн зарчимтай гэж үзээд “Нэгд, эрэгтэй хүн эмэгтэй хүнийг захирана. Хоёрт, эрчүүд насны ялгаанаасаа хамаарч бие биедээ захирагдана.” гэж тодорхойлсон байна.²³ Үүгээрээ тэрээр нийгмийн харилцаа болон гэр бүлийн харилцаанд эрэгтэй хүн давамгайл эрхтэй болохыг илэрхийлж харин эмэгтэй хүн дагавар, туслах үүрэгтэйг харуулахаар зорьжээ. Тэрээр нийгмийн бүхий л харилцаа засаглал дээр үндэслэдэг бөгөөд тэр засаглалын эрх мэдэл нь эрчүүдэд хамаарагдаж байна гэж үзжээ. Тэрээр эмэгтэй хүний хүйсийн онцлог нь гэрлэлт болон эх болох үүрэгтэй нь ямар ч хамааралгүй гэж үзэв.

²²С.ДеБоувер. Дайвар хүйстэн. УБ., 2010. 16 Орчуулагч М.Отгонбаяр

²³<http://www.marxists.org/subject/women/authors/millett-kate/sexual-politics.htm>

1960 он гэхэд АНУ-д үр хөндөлтөөс болсон эхийн эндэгдэл буураагүй бөгөөд энэтхэгийн нөхөртэй нь хамт оршуулдаг уламжлал, хятадад охидын хөлийн хатааж боох уламжлал, африкийн охидын бэлгэ эрхтэнийг зэрэмдэглэх ёслол зэрэг нь түүхийн хугацаан дахь эрэгтэйчүүдийн хүмүүнлэг бус үйлийн илрэл юм. Бүхий л эцгийн эрхт ёс давамгайлж ирсэн нийгэмд эмэгтэйчүүд хүчирхийлэл, бэлгийн дарамтад амьдарсаар ирсэн. Хэдийгээр байгалийн хүчин зүйл болон хөдөлмөрийн хуваарийг үгүйсгээгүй боловч эрх мэдлийн хуваарилалт өнөөдөр ч эрэгтэйчүүдийн давамгайлалд байгааг тэрээр онцгойлон авч үзсэн байна.

Эцгийн эрхт ёсны үлдэгдэлтэй тэмцэж байж ирээдүйг өөрчлөх боломжтой юм. Кэйти Миллет “эрэгтэй хүйсийн давамгайлал засгийн эрх мэдэлд ноёрхож байгаа цагт хүйсийн зөрчил, дарангуйлал байсаар байна, хүн төрөлхний энэхүү 2 хүйс нь гэр бүл ба нийгмийн гэсэн хоёр хэсэгт амьдарч, засгийн эрх баригчид энэ ялгааг олон нийтэд үл мэдэгдэх зорилготой байдаг.”²⁴ Гэжээ. Тийм ч учраас радикал феминистүүд бусад феминистүүдээсээ анхлан улс төрийн тавцан дахь эмэгтэйчүүдийн өнөөгийн нөхцөл байдал, нийгмийн болон соёлын нөлөөллийн тухай гарган тавьсан гэж үзэж болно. Эмэгтэйчүүд улс төрийн үйл явцад оролцох нь эцгийн эрхт ёс давамгайлсан нийгэмд соёлын хүндхэн шалгуурыг давж гарах шаардлагатай болох нь гарцаагүй юм.

1980 он хүртэл эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо тэр тусмаа шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо нь судлаачдын огтхон ч сонирхдоггүй сэдэв байсан байна.²⁵ Зөвхөн өнгөрсөн түүхийн хугацаанд түүхэн үүрэг гүйцэтгэж байсан эмэгтэйчүүдийн тухай дурьдаж байсан нь ихэвчлэн эмэгтэйчүүд нийгэмд 2-р зэргийн үүрэг гүйцэтгэж байсантай холбоотой. Феминист хөдөлгөөн идэвхижиж эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх тэмцэл энэ тогтсон ойлголтыг өөрчлөж, судлаачдын анхаарлыг татаж чаджээ.

Феминизмийн II давалгааны үед эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх тэмцлийн хөдөлгөөний шинж чанар нь эгч дүүс, эв санааны нэгдэл хэлбэртэй болов. Радикал феминизм эрчтэй хөгжиж “Эмэгтэйчүүдийн тэмцэл бол ангийн тэмцэл”, “Эмэгтэйчүүд улс төрд оролцох эрхтэй” гэх зэрэг нийгмийн хүйсийн ялгаатай байдлын эсрэг уриатайгаар тэмцэж байв. Энэ үед эмэгтэйчүүдийн тэмцэл зүүний үзэл баримтлалтай улс орнуудын хувьд ихээхэн амжилттай байсан бөгөөд социалист, марксист феминизм эмэгтэйчүүд гэртээ яаж ажиллаж байгаа шигээ нийгмийн хөдөлмөрт ч мөн адил ажиллах боломжтой гэж үзээд ижил хөдөлмөрт, ижил цалин гэсэн шаардлагыг тавьж хөдөлмөрийн зах зээл болон боловсролын системд хүйсээс хамаарсан ялгааг устгахаар тэмцэв. Зөвхөн социализм байгуулсанаар эмэгтэйчүүдийн оролцоо, тэмцэл зогсох биш харин хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийн оролцох хувь нэмэрийг нэмэгдүүлэх ёстой гэж үзэх болсон байна. Социалист болон Марксист феминизм хүйсийн дүр, гоо сайхны бэлгэдэл гэх мэт ойлголтуудад шүүмжлэлтэй хандаж байсан юм.

Феминизмийн III давалгаа: /1990-оноос одоог хүртэл/: 1990-ээд оноос эхлэн эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай феминизмийн сургаал глобаль шинжтэй болж цар хүрээ нь өргөжиж эхэлсэн байна. Эмэгтэйчүүдийн тухай нэг улс орны эмэгтэйчүүд тэмцэх бус харин дэлхийн хэмжээнд эмэгтэйчүүдийн төлөө дуу хоолойгоо нэгтгэх болж улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, дэлхий нийтээрээ эмэгтэйчүүдийн эрхийн зөрчлийг арилгах, нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг нь сайжруулахад голлон анхаарах болжээ. Энэ давалгаа өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байна.

Эмэгтэйчүүдийг байгалаас төрсөн тэр хэвээр нь хүлээн зөвшөөрөх, эмэгтэйчүүдэд хандсан хавчлага дарамт агуулсан хэвшмэл ойлголтуудыг өөрчлөх гэсэн уриатай феминизмийн олон урсгал бий болжээ. Эмэгтэйчүүдийн давуу тал, нийгэм улс төрийн

²⁴Irina Chicalova women in political theory <http://giacgender.narod.ru/n4t2.htm>

амьдралд нөлөөлөх цар хүрээг нь илүү өргөн хүрээтэйгээр тайлбарлах байгалийн төрөлх шинж чанарт нь нөлөөлөхгүйгээр эрхээ эдлэх, нийгэмд байр сууриа эзлэх боломж олгох нь чухал гэж үзэж байна.

Жендэр судлаач Жудит Батлер “Жендэрийн асуудал” бүтээлдээ “Феминизмийн III давалгаа бол өмнөх үедээ тэмцэж олсон амжилтуудаа бодит амьдрал хэрэгжүүлэх үе”²⁶ гэж тэмдэглэжээ. Энэ үе дэх хамгийн анхаарал татсан болон чухал үзэл бол судлаач Нира Ювал Дэвисийн “Огтлолцсон улс төрийн бодлого” гэх ойлголт юм. Тэрээр “Жендэр ба үндэстэнүүд” бүтээлээ 1997 онд хэвлүүлсэн бөгөөд эмэгтэйчүүдийн хил хязгааргүй шашин шүтлэг, ёс заншил, үндэстнүүдийн онцлог хоорондын харилцаанд тулгуурлан бүтээлээ тууригдсан байна. Түүний тодорхойлж байгаа “Огтлолцсон улс төрийн бодлого” нь өөрийн улс орны соёл, уламжлал, шашны нөлөөлөлд байгаа эмэгтэйчүүдийн үзэл санаа ч өөрчлөгдөж байгааг тэмдэглээд үүнийг идэвхижүүлэхдээ олон улсын түвшинд хүчээр болон шууд тулгах бус ойлгуулах, тайлбарлах, нөлөөлөх ёстой үзсэн байна.²⁷

Феминизмийн III давалгааг өнөөдрийг хүртэл үргэлжилсэн байдлаар нь авч үзвэл феминизмийн үзэл санаа эмэгтэйчүүдийн улс төрийн эрх эрх чөлөөний ололтуудын үр дүн дээшлүүлэх, дэлхийн хэмжээнд ижил тэгш ажилтад хүрэхийг чухалчлан авч үзэх, эмэгтэйчүүдийн эрх өнөөдрийг хүртэл зөрчигдсөөр байгааг шийдвэрлэх эрэл хайгуул хийж байгаа үе гэж дүгнэж болох юм. Энэ давалгааны дараа эмэгтэй ба эрэгтэй хүйсийн эрх тэгш огтлолцол үүснэ гэж зарим судлаач үздэг билээ.

Ашигласан материал

Дебоувер.С., Орчуулагч Отгонбаяр.М., 2010. Дайвар хүйстэн. Улаанбаатар, 16-р тал.

Charlotte Kroløkke., 2006. Gender communication theories and analyses from: Silence to performance.

Sage publication, pp-4,20.

Margaret Walters., 2006. Feminism: A Very short introduction. Oxford press, pp-1.

NiraYuyal Davis., 1997. Gender and Nation, Sage, London, pp. 4-6.

[Feminism –Webster Dictionary](#)., Retrieved 12 June 2011, merriam-webster.com.

[Feminism-Cambridge Dictionary Online](#): Retrieved 12 June 2011., [Free English Dictionary and](#)

Thesaurus” dictionary.cambridge.org.

Irina Chicalova., Women in political theory <http://giacgender.narod.ru/n4t2.htm>

<http://www.marxists.org/subject/women/authors/millett-kate/sexual-politics.htm>

<http://autof.files.wordpress.com/2010/02/butler-judith-gender-trouble-feminism-and-the-subversion-of-identity-1990.pdf>

²⁶<http://autof.files.wordpress.com/2010/02/butler-judith-gender-trouble-feminism-and-the-subversion-of-identity-1990.pdf>

²⁷NiraYuyal Davis. Gender and Nation, Sage, London 1997, pp. 4-6

МОНГОЛ ТӨРИЙН ТҮШМЭЛ

Ц.ГАНБОЛД

МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, профессор

/Энэхүү өгүүллийг МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг.1992.№1./107/ дугаарт одоогоос 21 жилийн өмнө нийтэлжээ. Зарим шавь нарынхаа хүсэлтээр ПОЛИТОЛОГИ сэтгүүлээр дамжуулж дахин толилуулж байна./

Түлхүүр үг: Төрт ёс, төрийн түшмэл, эзэн дээдэс, ард түмэн, уламжлал

ABSTRACT: *Mongolians' are a nation with a hundreds of years' culture of statecraft tradition and a rich source of wisdom inherited from its' ancestry. In ancient Mongolian teaching on statecraft of "Арван буянт номын цагаан түүх", literally translated as "The White History", there are plenty of well described features of nobleman which still keeps its' importance on how to select statesman and public officials in contemporary political life.*

Хүн төрөлхтөн төрт ёсыг түвшитгэх гэж түмэн жил бэдрэхдээ төр улс болгонд таарах төгс шалгарсан аргыг эдүгээ хүртэл олоогүй л бололтой. Зарим улс оронд төрийн эрх барих дээд байгууллагын төлөөлөгчдөө ард нийтийн сонгуулиар тодорхой хугацаагаар сонгож шалгаруулдаг байхад, зарим улс оронд бүх насаар нь сонгох, томилох, үе залгамжлах олон хэлбэртэй байх юм.

Ардчилал гэдгийг гол шалгуур болгосон бүх нийтийн сонгуулиар төрийн түшмэлээ сонгох нь одоогоор нийт хүн төрөлхтөний улс төрийн соёлд олсон томоохон ололтын нэг мөн. Гэхдээ энэхүү ардчилсан сонгууль гэгч нь их нарийн утга учиртай, олон хэлбэртэй зөв зохистой механизмыг бүрдүүлж, таарах тохирох тунгаар хэрэглэхгүй бол эерэг сөрөг үр дагавартай, эмзэг нарийн асуудал ажээ.

Алсын хараа, уужим ухаан, амьдралын туршлага, өршөөнгүй сэтгэлтэй, чин шударга, төв түвшин төрийн түшмэлийг олж сонгох гэдэг тийм ч амархан зүйл биш юм. Энэ нь тухайн улс орны нийгэм эдийн засгийн хөгжил, нийгмийн ухамсрын түвшин, уламжлал шинэчлэл, тухайн цаг үеийн хийсвэр ба бодит хэрэгцээ, улс төрийн хүчнүүдийн харьцаа зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалах ээдрээтэй асуудал ажээ.

Ард түмэн сонгуульд тэгш эрхтэй оролцоно, төр засгаа өөрсдөө байгуулна гэдэг, сонсоход таатай ч цаг үеийн салхи, цаг бусын шалтгаанаар олон түмэн сонгогчид маань төр түшилцэх албанд зарим үед хөдөлмөрийн сайчууд, гавъяат, баатруудаа, зарим үед урлаг соёлын зүтгэлтнүүд, яруу найрагч, дархан аваргуудаа, зарим үед "хуучин сэтгэлгээтэй", "хашруудаа" зарим үед "шинэ сэтгэлгээтэй банди нараа" сонгочихсон байх ба нийгэм хямарч, амьдрал донсолсон үед дарангуйлагчид фашистуудыг хүртэл олон түмэн өөрсдөө сонгож эцэст нь тэдний үйлдсэн гэм нүгэлийг ард түмэн өөрсдөө үүрдэг түүхэн сургамж байх юм. Үүнээс үзэхэд ард түмэн гэдэг аугаа их ч, цагийн салхинд сэтгэл хөдлөлөөр дарвихдаа нүүрэндээ "сайхан" баг зүүсэн цөөнхийн тоглоом болж үлддэг өрөвдөлтэй гашуун түүхийг мартах ёсгүй.

Өрнөдийн хэмээгдэх улс орнуудад эзэн дээдэс, элит, лидерүүдээ хэрхэн шилж сонгох, тэд ямар шинж төрхтэй байх талаар янз бүрээр л бичсэн байх юм. Үүнийг бид

үзэж судлахын зэрэгцээ, үлгэр домогт нь хүртэл нэвт шингэсэн өтгөс дээдсийнхээ сургаалаас санаж сэрвэл бас л нэгийг бодох учиртай.

Монголчууд бид төрт ёсны олон зуун жилийн уламжлалт соёлтой, өвөг дээдсээс минь үлдээж хайрласан билэг сургаал арвинтай, эртний сурвалжит ард түмэн билээ.

Монголын төрт ёсны сургаал “Арван буянт номын цагаан түүх” хэмээх сударт хаан хүмүүний гурван их үйл, дөрвөн их төр, зургаан үлгэр, долоон их бин, есөн их бэлгэ, гучин таван эрдэм, түшмэл хүний 9 шинж гэх мэт иж бүрдлийг онцлон үзэж “эрдэм өршөөлт эзэн улсын эрдэнэ, эрх ухаант сайн түшмэл төрийн эрдэнэ” гэж төрийн алтан баганыг түших эрдэм ухаант ихэс дээдсээ шилж сонгоход үлэмж анхаарч иржээ.

Тийм учраас дээдсээ эс шилж чадваас улс орон хямарч зон олон зүдэрдгийг үеэс үед сэрэмжлүүлж байлаа. “Дээдэс суудлаа олохгүй бол доодос гүйдлээ олохгүй” гэж ард нийтээрээ хэлэлцдэг. “Эзнийхээ хийсэн алдааг ард түмэн амсдаг жамтай” гэж Чингис хаан сургаж байсан тухай Е. Д. Филиппс “Чингис хаан хийгээд түүнийг залгамжлагчид” бүтээлдээ тэмдэглэжээ. Энэ тухай Дарав бандид “Ертөнцийн зовлон их хүнээс гардаг” гэж бас л сануулсан байх юм. Иймд бид төрийн түшмэлээ сонгоход тоомсоргүй хандах, сэтгэл хөдлөлөөр улс төрийн хийрхэлд автахаас зайлсхийж, буурьтай бодож, хариуцлагатай хандах ёстой ажээ. Төрт ёсны сургаалд:

“Биеэ засаад гэрээ зас

Гэрээ засаад төрөө зас” гэх буюу

“Эр түвшин бол гэр төвшин

Гэр төвшин бол төр төвшин” гэсэн мэргэн үг байдаг.

Хал үзсэн өтгөс буурлууд маань төр төвшин байхын эх үндсийг эр төвшин байж, биеэ засах явдалтай холбож үзсэн нь санамсаргүй хэрэг огт бус, үндэс нь самуун болбоос үзүүр нь засагдах нь үгүй хэмээсэн гүн ухаанаараа сийлсэн хэрэг ээ. Дээрх мэргэн сургаалийн гүнзгий агуулгыг эрдэмт мэргэдүүд үе үедээ тайлж тайлбарлаж байснаас зөвхөн “биеэ засах” гэдгийн учрыг тунгааж үзье.

Эрдэнэ сайн ерөөлт, номч мэргэн хамба цэцэн ширээт Бандида Агваанчойжирдондов “. . . бичиг эрдмийг хичээнгүйлэн сурваас дотрын харанхуй арилан, гэгээн ухаант болон өөрийн биеийг засах, түүн дор гэрийг засаж, түүнээс дэвшиж улс төрийг засахад хүрдэг ” хэмээн эрдэм ухаан гэгээн оюуныг ихэд эрхэмлэжээ.

Судар бичгийн хүрээлэнгийн жинхэнэ гишүүн Чулууны Бат-Очир агсан дээрхи сургаалыг тайлбарлаж “Эртний гэгээн эрдмийг дэлхий дахинд гийгүүлсүгэй хэмээгч урьдаар улсыг засмуй, улсыг зассугай хэмээгч урьдаар гэрийг тэгшилмуй. Гэрийг тэгшилсүгэй хэмээгч урьдаар биеийг залруулмуй. Биеийг залруулсугай хэмээгч урьдаар сэтгэлийг төв болгомуй. Сэтгэлийг төв болгосугай хэмээгч урьдаар санааг үнэнхүү болгомуй. Санааг үнэнхүү болгосугай хэмээгч урьдаар мэдэлд хүрүүлмуй. Мэдэлд хүрүүлэх нь юмыг тоолохуйд буй. Юмыг тоолсны хойно мэдэлд хүрмуй. Мэдэлд хүрсний хойно санаа үнэнхүү болмуй. Санаа үнэнхүү болсны хойно сэтгэл төв болмой. Сэтгэл төв болсны хойно бие залрагдана. Бие залрагдсаны хойно гэр тэгширмуй. Гэр тэгширсний хойно улс засагдмуй. Улс засагдсаны хойно дэлхий дахин төвшин болмуй ” хэмээжээ.

Ийнхүү төр төвшин болохын эх үндэс нь аливаа хүмүүн түүний дотор төрийн түшмэл хүмүүн биеэ засах учиртай агаад, энэ нь давтан тэмдэглэхэд их эрдэм сураад зогсохгүй, түүний дараа санааг үнэнхүү болгож, улмаар сэтгэлийг төв болгох ажээ. Үүнээс гадна биеийг засах гэдэгт бас “цээрлэн ариутгаж, цэвэр байж, ёсон бусад хөдлөхгүй ” байхыг дашрамд тэмдэглэсэн байдаг.

Зарим судлаачид түшмэл хүмүүний 9 шинж дотор хамгийн чухал нь "төвшин сэтгэл" хэмээн онцолсон байх ба энэ нь дээр өгүүлсэн "сэтгэлийг төв болгох"-той дүйж байна.

Монголчууд төрийн түшмэл гэж ямар хүнийг ойлгож байсан бэ? Манай УИХ-ын зарим гишүүд өөрсдийгөө "төрийн түшээ" гэж хэлэх дуртай. Би Монгол төрийн түшмэлийн тухай, монгол хүн болж төлөвших тухай залуучууддаа зориулж бичээд байгаа юм. Түшээ, түшээ гүн гэдэг нь манжийн үеийн дөрвөн хэргэмийн дөрөвдүгээр зэрэг, түшмэл гэдэг нь монгол төрийн албаны үүргийн талаар таслах тогтоох явдалд оролцох эрх тушаал бүхий хүн. Нижгээд нь биеэ зассан, нилээд нь гэрээ зассан, нийтдээ төрөө засна гэж боддог бололтой. Нидэр дээрээ нилэнхүйдээ биеэ засаагүй л байдаг аж. Биеэ засна гэдэг гурван төгрөгтэй болохоос илүү гүн агуулгатайг мэргэд ийнхүү тайлбарлажээ. Болгоон соёрхоно уу.

Монголын төрт ёсны сургаалд төрийн түшмэл гэдэг нь улс төрийн дам нуруу / ноён нуруу / амьдрах иргэний хутгийг барих нь буюу хэмээн үзэж улс орны хувь заяа, үр хүүхдийн ирээдүй хойч төрийн түшмэлийн мэргэн бодлогоос ихэд шалтгаална гэж өндөр шаардлага тавьдаг байжээ. Тийм ч учраас монголын төрт ёсонд төрийн түшмэлийг бэлтгэх "хар хайрцгийн" бодлого гэж байсан тухай судлаачид тэмдэглэсэн байдаг. Английн түүхч Г. Ховорс "Монгол татарчууд Ази Европод" номондоо шударга ёс, хүлцэнгүй чанар, дэг журам зэрэг нандин чанарыг Монголын хаад өөрийн ордонд эрхэмлэдэг байсан гэжээ. Энэ бол тэр үеийн төрийн сайд түшмэлийн эрхэм чанарын салшгүй хэсэг болж байв. Хуучны түүх шашдирт "Аяа түшмэл нь шударга, гэгээн, цэвэр голч хэмээх гурван үсгийг сахиж чадваас тушаалын доторхи аливаа явдал өөрөө тодорхой болж засагдмуй" ард түмнээ асрах, нигүүлсэхгүйг гол болгосон, шударга, ариун гэхийг бат нот агуулсан түшмэл нь улс төрд онц их эрдэнэ буй заа" хэмээжээ.

Дээр өгүүлснээс нэгтгэн үзвэл монголын төрт ёсны сургаалд төрийн түшмэл хүмүүний үндсэн гол шинжүүдэд нэгдүгээрт, "Эрдэм ухаант", "мэдэлд хүрсэн", хоёрдугаарт "шударга ариун", "төвшин сэтгэл", "цэвэр голч", "санааг үнэхүү болгох", гуравдугаарт "төв төвшин", "голч мэргэн", сэтгэлийг төв болгосон" хэмээх утга ойролцоо гурван санаа олонтаа тааралдаж байгаа нь төрийн түшмэлийн үндсэн шалгуурууд болж байсан бололтой. Тэдгээрийн дотроос эхнийх нь / эрдэм мэдлэг / дараагийн хоёр гол шинжгүйгээр нэгэн хүмүүнд цогцолж болох боловч, гуравдахь нь голч мэргэн, сэтгэлийг төв болгох / эхний хоёр шинжийг бүрдүүлэхгүйгээр төлөвших боломжгүй ба тийм учраас түшмэл хүмүүний 9 шинж дотор гол шалгуур болдог байжээ.

Түүнчлэн төрийн түшмэлийн шинжид алсын хараа, уужим ухаан, өршөөнгүй сэтгэл, эв найр, эрхэм ёслол хэмээх 5 эрдмийг хамааруулж үзэхийн зэрэгцээ эрдэм сахилга бүрнээ үлэмж, хүнд ихэмсэг, хичээнгүй болгоомжтой, найртай, жич будлианыг засах эрдмийг олсон байх ёстой гэсэн зарим сонирхолтой шинжийг дурьдсан байх юм. Үүнд ч бас анхаарууштай санаа бий. Будлианыг засахдаа өнгөрснөө хараан зүхэж, өнөө маргаашаа үл ухаж, бусдад бурууг тохож, биесээ магтан сайрхаж, өрөөлтэй арцалдан тэмцэлдэх ёсгүй аж.

Монголын төрт ёсны сургаалд мэргэд чуулан зөвлөвөөс анхан дор тэмцлийг тэвчин эцэс дор улс төрийг бататгасан гэдэг. Мунхаг дээрэнгүйчүүд анхан дор тэмцэлдэн эцэс дор бусдад автав гэдэг. Мандах төрийн сайд түшмэл өөрийн ялаа илэрхийлж үзүүлнэ, муудах төрийн эзэн түшмэл бие биеийн андууг баллаж арилгана гэжээ. Аяа эцэг өвгөдийн мэргэн сургаалд бишэрмүй.

ОРЧИН ҮЕИЙН УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ЧУХАЛ АСУУДАЛ: АРДЧИЛЛЫН ЧАНАР

Б.ЭРДЭНЭДАЛАЙ

СЭЗДС-ийн багш, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн докторант

Түлхүүр үг: Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоо, хурлууд, ардчиллын чанар, ардчиллын индексүүд

ABSTRACT: *In this article has taken contemporary political science's important issue is quality of democracy. Last years scientist are noted and researched this issue. Because democracy has spread and taken root in many parts of the world in the past three decades. A crucial element in mapping, explaining and encouraging this growth in democracy has been the need for valid, meaningful and reliable ways to measure and assess democratic progress and the quality of democracy itself.*

Оршил

Улс төрийн шинжлэх ухааны салбаруудад өнөөдөр нэрд гарсан эрдэмтэд онолын болон эмпирик судалгаа шинжилгээний ажил эрхэлж, олон зуун мэргэжилтнүүдийг их дээд сургуулиуд бэлтгэж байна. Улс төрийн шинжлэх ухааны онол арга зүй, судалгааны арга хэрэгсэл нь нарийсан хөгжихийн зэрэгцээ улам бүр олон улсчлагдаж, мэргэших үйл явц эрчимжиж байгааг судлаачид тэмдэглэж байна.

Улс төрийн шинжлэх ухааныг судалдаг эрдэмтдийн холбоо харилцааг бэхжүүлэх, санал солилцох, хамтарсан төсөл хөтөлбөрүүд зохион байгуулах, уг шинжлэх ухааны судлах зүйл, судалгааны арга, арга зүйг хөгжүүлэхэд, мөн залуу судлаачдад судалгаа шинжилгээний ажлаа үргэлжлүүлэхэд туслалцаа үзүүлж тэтгэлэг олгодог гэх мэтээр Улс төрийн шинжлэх ухааны хөгжилд хамгийн чухал хувь нэмэр оруулж буй байгууллага бол Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоо юм.

Олон улсын улс төр судлаачдын тэргүүлэх байгууллага болох Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоо 1949 онд ЮНЕСКО-гийн ивээл дор Парист байгуулагдсаны ачаар улс төр судлалын хөгжлийг чанарын шинэ шатанд гаргаж, улмаар дэлхийн хамтын нийгэмлэгт хүлээн зөвшөөрөгдөж, дэмжигдсэн шинжлэх ухаан болж чадсан юм.

Тиймээс энэхүү өгүүллийн хүрээнд тус холбооны үйл ажиллагааны чиглэл, дүрэм, зорилго, бүтэц бүрэлдэхүүнийг судалсан. Хамгийн гол нь тус холбооноос гурван жил тутам зохион байгуулдаг Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны сүүлийн Их хурлуудын сэдвүүд, хэлэлцсэн асуудлуудыг судлахад, улс төрийн шинжлэх ухааны хамгийн чухал асуудлуудын нэг бол ардчиллын чанарын тухай асуудал байв. Иймээс өгүүлэлдээ ардчиллын чанар, бэхжилтийн асуудалтай холбоотой бичигдсэн судалгааны материалууд, эрдэм шинжилгээний өгүүлэл зэргийг судлах, ялангуяа энэ асуудлаар дагнан судалгаа хийсэн гол гол төлөөлөгчдийн бүтээлийг судлах үндсэн дээр ардчиллын чанарын тухай ойлголт, улс орнуудад тогтоод буй ардчиллуудыг хэмжих, бэхжилтийг тодорхойлох хэмжүүрүүдийг судлахыг зорилоо.

Орчин үеийн Улс төрийн шинжлэх ухааны чухал асуудлууд

Дэлхийн хоёрдугаар дайны дараа Америкийн улс төрийн шинжлэх ухааны жишиг, зарчмуудыг европын хөрсөнд буулгах ажлууд хийгдэж, 1960-аад он гэхэд хуучин европын их сургуулиуд бүрэн сэргэж, олон тооны улс төрийн сургалт судалгааны төвүүд байгуулагдах болжээ. Энэ үеэс европын улс төр судлаачдын тоо байнга өсч 1980-аад оны дунд гэхэд европын улс төрийн шинжлэх ухааны эрдэмтдийн тоо 2500-аас давж, тэдний улс төрийн шинжлэх ухаанд оруулах хувь нэмэр улам бүр жинтэй болсоор байгаа нь илэрхий байна. Өнөөдрийн байдлаар Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны 3700 гаруй гишүүд байна²⁸.

Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны үндсэн дүрэмд тусгаснаар үндсэн зорилго нь үйл ажиллагааны дараах чиглэлээр дамжуулан дэлхий дахинд улс төрийн шинжлэх ухааны хөгжлийг хангах явдал юм. Үүнд:

- Бүс нутгийн ба үндэсний хэмжээний улс төрийн шинжлэх ухааны нийгэмлэг, холбооны хөгжил төлөвшлийг хангах
- Улс төрийн шинжлэх ухаанд гарсан амжилт ололтын тухай мэдээллийг түгээхэд туслах
- Улс төр судлаач эрдэмтдийн харилцааг өргөжүүлэхийн тулд улс төр судлалын “дугуй ширээ”-ний маргаан мэтгэлцээн явуулах буюу Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны Дэлхийн конгрессыг зохион байгуулах
- Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны гишүүдэд зориулан улс төр судлалын ном зохиол, шинжлэх ухааны сэтгүүл, албан ёсны мэдээ мэдээлэл хэвлэн нийтлэх
- Улс төрийн шинжлэх ухааны олон улсын хамтарсан судалгаа явуулах зэрэгт үндсэн зорилго оршино.

Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулахад улс төрийн шинжлэх ухааны тулгамдсан асуудлаарх олон улсын судалгааны байнгын хороо чухал үүрэг гүйцэтгэдэг. Хороо бүр Дэлхийн конгрессын салбаруудад зориулсан зохих баримт материалыг бэлтгэх, конгрессын завсарт дор хаяж нэг удаа “дугуй ширээ”-ний буюу олон улсын бага хурал зохион байгуулах үүрэгтэй. Өнөөдрийн байдлаар нийт 52 судалгааны байнгын хороо²⁹ ажиллаж байна.

Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны үйл ажиллагаанд гурван жилд нэг удаа хуралдах Дэлхийн конгресс буюу Их хурал чухал үүрэгтэй. Дэлхийн конгресс улс төрийн шинжлэх ухааны зангилаа асуудлуудыг авч хэлэлцдэг. ОУУТШУ-ны холбооны хурлуудын хэлэлцсэн асуудлын ерөнхий сэдвүүд нь тухайн цаг үетэйгээ их холбоотойгоор дэвшигддэг байна. Сүүлийн хэдэн удаагийн хурлуудыг ажиглахад улс төр судлаачид эрдэмтдийн тавьж буй илтгэлүүд нь ардчиллын хэрэгжих хэлбэр, механизмууд төгөлдөржин тодорхой болж, ардчиллын замаар хөгжиж буй олон улс оронд ардчилал, ардчилсан засаглалынхаа байдалд үнэлгээ өгч, түүний хүрсэн түвшин, чанарыг тодорхойлоход гол анхаарлаа хандуулж байна.

1970-аад оноос нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэд тодорхой нэг асуудлыг дагнан судлах, эсвэл улсуудыг харьцуулан судлахдаа эмпирик судалгаануудыг ихээр хийж эхэлсэн. Үүнээс эхлэлтэйгээр тухайн улс орнуудад ардчилал хэрхэн бэхжиж байгааг гаргах, мөн ардчиллын чанарыг хэмжих гол шалгуур болох сонгууль судлал эрчимтэй хөгжиж 1990-ээд оноос Европын сонгууль судлалын нийгэмлэгээс Европын холбооны гишүүн улсуудын төлөөллийн судалгааг гаргадаг Евробарометрын судалгааг

²⁸ Ё.Довчин. “Улс төрийн шинжлэх ухаан: зохион байгуулалт, онол, арга зүй”. МУИС. Политологи сэтгүүл. УБ.,2011. №348 (61). 5 дахь тал

²⁹ www.ipsa.org

гаргаж ирсэн. Энэхүү судалгаагаар гол нь Европын холбооны гишүүн улсуудад ардчилал амжилттай хэрэгжиж байгаа эсэх, ардчиллын гол үнэт зүйлсийн талаарх үнэлэмжид өөрчлөлт гарч байгаа эсэх гэх мэт чухал асуудлуудыг авч үздэг. Евробарометрийн судалгаа удалгүй араасаа дэлхийн өнцөг булан бүрийг хамарч Латин Америкийн улсуудын Латинбарометр, Африкийн улсуудыг хамарч Афробарометр, Зүүн, Зүүн Өмнөд, Өмнөд, Төв Азийн улсуудыг хамарсан Азийнбарометр, Арабын улсуудыг хамарсан Арабын барометруудыг гаргаж ирсэн³⁰ байна.

Ардчилал судлаачид өмнө нь ардчиллын онолын судалгааны асуудалд анхаарлаа хандуулж байсан бол сүүлийн үед эмпирик талын судалгаануудад анхаарлаа хандуулцгааж байгаа нь харагдаж байна. Үүнд: Ванханены ардчилах үйл явцын индекс, Катрайтын улс төрийн хөгжлийн индекс, Нейбауэрын ардчилсан үйл ажиллагааны индекс, Гаррын институциональ ардчиллын индекс, Боллены улс төрийн ардчиллын индекс, Фрийдом хаусын эрх чөлөөний индекс, Кауфманны оролцоо ба хариуцлагын индекс, Хуулийг дээдлэх байдлын индекс, Бертелсманны трансформацийн индекс гэх мэт олон хэмжилтүүд хийгдсэн. Дээрх барометрууд болон индексүүдийн үзүүлэлтүүдээс харахад ардчилал тийм ч их бэхжиж байгаа нь ажиглагдахгүй байна³¹.

Японы Фукуока хотод 2006 онд болсон Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны XX их хурал “Ардчилал хэрэгжиж байна уу?” хэмээх сэдвийн дор ардчилагдах үйл явц, ард иргэд өөрийн биеэр болон өөрсдийн төлөөлөгчөөрөө дамжуулан улс төрийн бодлогыг боловсруулах үйл явцад хэрхэн оролцож байна вэ? гэсэн асуудлыг онцлон авч үзсэн.

Ардчилал улс төрийн систем болохын хувьд урьд өмнөхөөсөө илүү түгээмэл болж байгаа бөгөөд энэ нь хуучин ардчилсан орнуудад уламжлагдан тархаж байна. Шинээр ардчилагдсан орнууд ардчиллын үндсийг шинэ бордоо ашиглан суулгахдаа сорилт бэрхшээлтэй тулгараад байна. Ардчилал өнөөдөр хэрхэн ажиллаж байгааг тодруулах нь энэ хурлын тавьсан зорилт байв. Ардчиллыг яаж дэмжиж, сайжруулах вэ?, Юу нь сайн ажиллаж байна вэ?, Ардчилал судлаач эрдэмтэд, шийдвэр гаргагчид, олон түмний анхаарлыг татсан ямар зүйл байна вэ? зэрэг асуудлууд XX их хурал дээр хурцаар тавигдсан³².

Дэлхийн бүх орон, бүх шатан дахь улс төрийн харилцаанд гарсан гол тулгуур өөрчлөлт болон хөгжлүүд нь ардчиллын талаар дахин нэг сайтар бодож үзэхэд хүргэсэн.

Төлөөллийн бөгөөд хариуцлагатай засгийг бий болгохын төлөө ямагт тэмүүлж байдагт ардчиллын үнэ цэнэ оршино³³. Гэтэл өнөөдөр олон хүмүүс төлөөллийн ардчилал хямралд орсон мөн олон нийтийн байгууллагуудад итгэх итгэл алдарсан гэж үзэж байна. Улс төрд итгэх олон нийтийн итгэл алдрахад нөлөөлсөн олон хүчин зүйлүүд байна. Тэдгээрт улс төрийн өрсөлдөөний үргэлж өсөн нэмэгддэг зардлууд, шийдвэр гаргахад оролцох, оролцооны асуудал засгийн газрын төвлөрөл, улс төрийн лидерүүд ард түмнээсээ холдож байгаа зэрэг олон асуудлууд хурцаар тавигдсаар байгаа.

Өнөөдөр ашиг сонирхлын илэрхийлэл өөрийнхөө хүрэнээс илүү гарсан ба бусад иргэний нийгмийн байгууллагууд шийдвэр гаргах үйл явцад хагас нөлөөлсөн байдалтай оршиж байна. Олон нийтийн удирдлага нь ардчилсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд чухал байдаг ба бүхий л ардчилсан үйл ажиллагаа нь хүнд суртлын асуудалтай

³⁰ Max Kaase. “Democracy and Political Action”. International Political Science Review. 2010. 31 (5). p.543-544

³¹ Ц.Ганболд. “Ардчиллын хөгжил ба Монголын улс төр”. МУИС. Политологи сэтгүүл. УБ.,2009. №297 (50). 113 дахь тал

³² Ц.Ганболд. “Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны Дэлхийн XX их хурал”. МУИС. Политологи сэтгүүл. УБ.,2007. №281 (40). 177 дахь тал

³³ Др.Найжель Ашфорд. Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд. УБ.,2007. 22 дахь тал

холбогдож байна. Ийм нөхцөлд иргэний нийгэм нь бодлого боловсруулах үйл явцад аль түвшин хүртэл оролцдог вэ?, Ямар боломж арга зам байна вэ? гэх мэтчилэн ардчилалтай холбоотой маш олон асуулт гарч болох ба ОУУТШУ-ны холбооны ХХ их хурал дараах гол дэд сэдвүүдэд анхаарлаа хандуулсан байна³⁴. Үүнд:

1. Ардчиллын хямрал ба чадамж, үндэсний болон олон улсын хэтийн төлөв
2. Ардчилал ба дэлхийн шинэ дэг журам
3. Байгууллагын хууль ёс, сонирхлын төлөөлөл ба ардчилсан үйл явц
4. Иргэдийн оролцоо, үнэлэмж
5. Төрийн бодлого, хүнд суртал болон ардчиллын чанар
6. Сайн ардчиллын онол, мэдлэг зэрэг болно.

ОУУТШУ-ны сүүлийн ХХI их хурал 2009 оны 6-р сарын 12-оос 16-ний өдрүүдэд Чили улсын Сантиэго хотод болсон. Уг хурал дээр тус холбооны ерөнхийлөгч профессор Л.Морлино ардчиллын чанар олон орны судлаачдын хамгийн их анхаарал татсан асуудал болсныг онцлон сануулсан. Ардчиллын чанарыг юуны өмнө улс төрийн оролцоо, улс төрийн өрсөлдөөн илтгэдэг.

2012 оны 7-р сард Мадрид хотод болох ОУУТШУ-ы ХХII их хурлын үеэр хэлэлцэгдэх материалыг хүлээн авч буй салбар хорооны эрдэмтэд болох Фернандо Валеспин, Елена Гарсиа нарын үзэж байгаагаар³⁵, өдөр ирэх тусам өөрлөгдөж буй дэлхий дээрх улс төрийн шинжлэх ухааныг дахин харах нь зүйтэй. Ингэхдээ тус хуралд хэлэлцүүлэхээр ирүүлж буй илтгэлүүддээ улс төрийн шинжлэх ухааны олон янзын үзэл баримтлал, эмпирик судалгаануудыг тусгахаас гадна ардчиллын чанарын хэмжилтийн асуудлуудыг авч үзэх нь сүүлийн үед их чухал болж байна гэж үзэж байна.

Ардчиллын чанарын талаар дорвитой судалгаа хийсэн эрдэмтэд бол Л.Диамонд болон Л.Морлино нар юм. Сүүлийн үед улс төрийн шинжлэх ухааны судлах ёстой чухал асуудлуудын нэг болсон ардчиллын чанарын асуудлаар судалгаа хийж байгаа эрдэмтэд Л.Диамонд болон Л.Морлино нарын хамтран 2005 онд гаргасан “Ардчиллын чанарыг тодорхойлох нь” бүтээлийг судалгааныхаа гол эх сурвалжаа болгон ашиглаж байна. Мөн Германы Берн болон Цюрихийн их сургуулийн профессор Марк Буэлман ардчиллын чанарын асуудлаар судалгааны ажлуудыг хийж байна.

Орчин үед нийгмийн ухааны эрдэмтэд, улс төрчид, идэвхтнүүд, тусламжийн агентуудад ардчиллын чанарын асуудал, ялангуяа түүнийг хэрхэн хөгжүүлэх вэ гэсэн асуулт тавигдсаар байна. Энэхүү онолын шинэ урсгал, арга, арга зүйн шинэчлэл, эмпирик судалгаа нь дараах гурван ойлголтуудаас үүдэн гардаг. Үүнд:

1. ардчиллыг цааш гүнзгийрүүлэх нь ёс суртахууны хувьд сайн үйл, магадгүй зайлшгүй хийх зүйл юм.
2. хэрвээ ардчилал нь өргөн цар хүрээтэй бөгөөд урт хугацаанд үргэлжлэх хууль ёсыг бий болгохыг эрмэлзэж байвал ардчиллын чанарыг сайжруулах шинэчлэл хийх нь их чухал юм.
3. хэрвээ олон нийтийн сэтгэл хангалуун бус байдал, бодит үнэний тухай гайхшрал зэрэг хуримтлагдсан асуудлуудаа шийдвэрлэхийг хүсч байгаа тохиолдолд урт удаан хугацаанд оршин тогтнож буй ардчиллуудад ч шинэчлэл хэрэгтэй.

Хууль дээдлэх ёс, хариуцлагын босоо тогтолцоо, хариуцлагын хэвтээ тогтолцоо, хариу өгөх үүрэг, эрх чөлөө, тэгш эрх, оролцоо, өрсөлдөөн гэсэн ардчиллын чанарын найман хэмжүүр³⁶-ийг судлаач Л.Диамонд болон Л.Морлино нар авч үзжээ. Мөн Германы Берн болон Цюрихийн их сургуулийн профессор Марк Буэлман 1990-2007

³⁴ Ц.Ганболд. “Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны Дэлхийн ХХ их хурал”. МУИС. Политологи сэтгүүл. УБ.,2007. №281 (40). 178-179 дэх тал

³⁵ Fernando Vallespin, Elena Garcia. Rethinking Political Science for a Changing World. www.ipsa.org

³⁶ Larry Diamond, Leonardo Morlino. Assessing the Quality of Democracy. The John Hopkins University Press., 2005. p.10

оны хоорондох засгийн газруудаас 50 ардчилсан засгийн газрыг сонгон авч ардчиллын чанар, бэхжилтийг гаргаж ирэх дараах шалгууруудыг ашиглан харьцуулсан судалгаа хийсэн байна. Тэрээр ардчиллын чанарыг судлахдаа эрх чөлөө, эрх тэгш байдал, хяналт, хувь хүний бие даасан байдал, хууль дээдлэх ёс, төрийн хүрээ, өрсөлдөөн, харилцан шахалт, засгийн газрын чадамж, ил тод нээлттэй байдал, оролцоо, төлөөлөл³⁷ зэрэг нийт 12 шалгуурыг авч үзсэн байна.

Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэн (IDEA)-ээс 2008 онд “Ардчиллын чанарыг тодорхойлох нь” судалгааг явуулсан бөгөөд уг судалгаандаа ардчилал аль хэдийн тогтоод хэвшсэн улсууд (Итали, Кени, Австрали) болон ардчиллыг шинээр тогтоогоод явж байгаа улсууд (Монгол, Банладеш, Перу)-ыг харьцуулан судалжээ. Ингэхдээ оролцоо, зөвшөөрөл олгох, төлөөлөл, хариуцлага хүлээх байдал, ил тод байдал, итгэл даах байдал, санал бодлын нэгдэл гэсэн найман хэмжүүр³⁸-ийг судалгаандаа ашиглажээ.

Ардчиллын чанар нь улс төрийн эрхийг хязгаарласан “хязгаарлагдмал” ардчиллын нөхцөлд доогуур түвшинд байдаг буюу хүчирхэг хэсэг бүлэг хүмүүс “давамгайлан” сонгогдсон удирдагчдын биеэ даасан байдлыг хаах, мөн иргэний эрхийг хамгаалах, хуулийг дээдлэх ёсыг хэрэгжүүлэхдээ “либерал бус” байдал гаргах явдал гардаг байна³⁹. Сонгуулийн өрсөлдөөнийг бодитой байлган, иргэний ба улс төрийн эрхийг тунхагласан төлөөллийн ардчиллын нөхцөлд ардчиллын чанар өндөр байгаа хэдий ч албан тушаалтнууд сонгогдсоныхоо дараа иргэдийн өмнө хүлээх үүргээ умартан, төрийн бусад байгуулалд садаа болдог тал ажиглагддаг.

Судлаачдын үзэж байгаагаар сүүлийн үед дэлхий нийтээр яригдаж буй глобальчлалын асуудал болон хэвлэл мэдээллийн чөлөөт байдал зэрэг нь ардчиллын чанарыг сорих сорилтуудыг бий болгож байна⁴⁰. Ардчиллын гурван давалгаа явагдаж дэлхий дээр ардчилсан улсууд бий болсоор байгаа ч эдгээр ардчилсан улсуудад маань ардчилал жинхэнэ уг чанараараа хэрэгжиж чадаж байгаа эсэх, эсвэл ардчиллыг нэр төдий байлгаж байна уу гэх мэт асуултуудыг олон улсын байгууллагуудаас судалж байна. Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэн (IDEA)-ээс улс орнуудын засгийн газар, иргэний нийгэм, шинжлэх ухааны институтуудын үйл ажиллагаа зэргийг үндэсний хэмжээний судалгааны багуудын хийсэн судалгаанууд дээр үндэслэн ардчиллын зэрэглэлийг гаргадаг. Ингэхдээ ардчиллын суурь зарчмуудтай үүргийг хослуулах, эдгээр зарчмууддаа үндэслэн үнэлэмжүүдийг гаргаж ирэх, тэгээд ардчиллын биелэлтийн талаарх бүх талын асуултуудын хүрээг тогтоодог⁴¹.

Тод Лэндмэний үзэж байгаагаар⁴², олон улсын харилцаанд оролцож буй ардчилагдаж байгаа болон ардчилсан улсуудын хувьд ардчиллын онолын асуудал, ардчиллын чанарын асуудлуудтай холбоотойгоор өнөөгийн байдлаар судлах шаардлагатай зүйлс их байна.

Чанартай ардчилал

³⁷ Marc Buhlman. “The Quality of Democracy: Crises and Success Stories”. IPSA. Sao Paolo, February 16-19, 2011. p.1-2

³⁸ Todd Landman. Assessing the Quality of Democracy. An Overview of the International IDEA Framework. Sweden.,2008. p.11

³⁹ Larry Diamond. Elections without Democracy: Thinking About Hybrid Regimes. *Journal of Democracy* 13 (April 2002). p.21-35.

Andreas Schedler. Elections without Democracy: The Menu of Manipulation. *Journal of Democracy* 13 (April 2002). p.36-50.

⁴⁰ Marc Buhlman, Wolfgang Merkel, Lisa Muller. “The Quality of Democracy. Democracy Barometer for Established Democracies”. National Centre for Competence in Research: Challenges to Democracy in the 21st Century. Working paper.,2008. No.10a. p.23-26

⁴¹ Todd Landman. Assessing the Quality of Democracy. An Overview of the International IDEA Framework. Sweden.,2008. p.7-8

⁴² Todd Landman. “Democracy Analysis”. Ten Years of Supporting Democracy Worldwile. The International IDEA. Sweden.,2005. p.19-26

Сайн ардчилал нь иргэддээ хангалттай эрх чөлөө, улс төрийн эрх тэгш боломж өгч, үндэслэл сайтай, хууль ёсны үйл ажиллагаа явуулдаг, тогтвор сайтай байгууллагуудаараа дамжуулан олон нийтийн зүгээс төрийн бодлого болон бодлого боловсруулагчдыг хянадаг юм. Ийнхүү чанартай ардчилал гэдэг нь засаг төрийнхөө үйл ажиллагаанд олон нийт сэтгэл ханамжтай байх явдал мөн. Хоёрт, иргэд, нэгдэл холбоод болон олон нийт эрх чөлөө, улс төрийн эрх тэгш байдлыг эдлэх боломжтой бол үүнийг чанартай ардчилал гэнэ. Гуравт, хуулийг дээдлэх ёсны дагуу төрөөс эрх чөлөө, тэгш эрхийг хэрхэн хангаж байгаад ард олны зүгээс үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой байх ёстой. Ард иргэд, олон нийтийн байгууллагууд, улс төрийн намуудын зүгээс сонгогдсон төрийн түшээдийг амлалтаа биелүүлэхийн төлөө ажиллахад нь хяналт тавина. Сонгогдсон төрийн түшээд нь хуулийг шударга хэрэгжүүлж байгаа эсэх, засгийн газраас гаргаж буй шийдвэрүүд нийгэмд хэр зэрэг үр өгөөжтэй байна гэх зэргийг хянадаг⁴³.

Ардчиллын чанарын судалгааны үндсэн объект нь төлөөллийн ардчиллын институтууд болон механизм юм. Энэ нь ардчиллын чанарын илрэл болсон цэвэр ардчиллыг үгүйсгэж байгаа хэрэг биш, харин ч төлөөллийн ардчиллын бодит туршлага, цаашид сайжруулах боломжийг хүлээн зөвшөөрч байгаа явдал юм.

Хууль дээдлэх ёс

Гуилермо О’Даниэлийн тайлбарлаж байгаагаар бол хуулийг дээдлэх ёсны дагуу бүх иргэд хуулийн өмнө тэгш эрхтэй байх ба бие даасан шүүх байгууллагаараа дамжуулан шударга байх гэсэн чухал зарчмыг хэрэгжүүлдэг бөгөөд бүх иргэдэд ойлгомжтой, хүн бүхэнд адил тэгш үйлчилдэг, тогтвортой, эргэлт буцалтгүй, тогтмол байх ёстой. Үүнийг арай илүү дэлгэрэнгүй авч үзвэл, “сайн” ардчилал буюу либерал ардчилал нь хуулийг дээдлэх ёсыг хатуу чанд сахихын тулд дараах зүйлсийг гол болгодог⁴⁴. Үүнд:

1. Хуулийг ард иргэд, төрийн албан тушаалтнууд гэж ялгахгүйгээр хүн бүр дагаж мөрдөх ёстой. Нэг ч хүний эрх ашиг хуулиас дээгүүр байх ёсгүй.
2. Нарийн зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд, төрийн эрхэнд гарсан олигархиуд, улс төрийн том боссууд зэргийн хэн нь ч хуулиас дээгүүр тавигдах ёсгүй.
3. Авлига хээл хахууль багатай, түүнийг илрүүлэн шийтгэх ажиллагааг улс төрийн, захиргааны, шүүхийн хүрээнд шийдэж чаддаг байх.
4. Төрийн албыг бүх шатанд мэргэшсэн, үр өгөөжтэй байдлаар явуулдаг, хуулийг сахидаг, алдаагаа засах үүргийг хүлээдэг байх.
5. Цагдаагийн байгууллага нь мэргэшсэн, үр өгөөжтэй ажилладаг, хувь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэдэг байх.
6. Шүүх байгууллага бүх хүнд хүртээмжтэй байж, иргэд нь өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалах, хувь хүмүүсийн хооронд, хувь хүн төрийн байгууллагын хооронд үүссэн асуудлыг шийдэхэд эрхээ эдэлдэг байх.
7. Эрүүгийн, иргэний ба захиргааны хэргүүдийг шуурхай шийддэг байх.
8. Шүүх засаглал бүх шатанд дундыг баримталсан байж, улс төрийн нөлөөнөөс ангид байх.
9. Шүүхийн дүрмийг хүндэтгэн, төрийн бусад байгууллагад даган мөрддөг байх.
10. Үндсэн хууль бол хамгийн гол зүйл бөгөөд Үндсэн хуулийн цэцээс тайлбар өгч, хамгаалдаг байх.

Хуулийг дээдлэх ёс нь ардчиллын чанарыг хэмжих бусад бүх хэмжүүрийн суурь нь болж өгдөг. Хуулийн дээдлэх ёс султай байвал ядуучууд болон нийгмийн эмзэг

⁴³ Larry Diamond, Leonardo Morlino. Assessing the Quality of Democracy. The John Hopkins University Press., 2005. p.12

⁴⁴ Larry Diamond, Leonardo Morlino. Assessing the Quality of Democracy. The John Hopkins University Press., 2005. p.14

хэсгийн оролцоо хязгаарлагдмал, хувь хүний эрх чөлөө найдваргүй, эргэлзээтэй байдалд орж, иргэний нийгмийн байгууллагууд нэгдэж, үзэл бодлоо хамгаалах боломжгүй болж, овсгоо самбаа, харилцаа холбоо сайтай нэг нь шүүх эрх мэдлийг гартаа авах боломж нээгдэн, авлига, эрх мэдлээ урвуулан ашиглах явдал газар аван, хариуцлагын босоо тогтолцооны байгууллагууд үйл ажиллагаа явуулах боломжоо алдан, улс төрийн өрсөлдөөн шударга бус явагдаж, сонгогчид эрх баригчидтай тооцоо хийж чадахгүйд хүрч, ардчиллын хариуцан тооцох байдал мэдэгдэхүйц суларна гэсэн үг юм.

Оролцоо

Хэрвээ насанд хүрсэн бүх иргэддээ улс төрийн оролцооны албан ёсны эрх, тухайлбал, сонгуульд оролцох эрхийг нь олгохгүй бол ямар ч дэглэм нь ардчилсан байж чадахгүй. Гэхдээ сайн ардчилал нь иргэн бүр сонгуульд оролцох, эвлэлдэн нэгдэх, сонирхлоо хамгаалан лобби хийх зэрэг албан ёсны эрхүүдээ эдэлж, шийдвэр гаргах үйл явцад нөлөөлж чаддаг байх ёстой. Иргэдийн оролцоог зөвхөн сонгуульд оролцож байгаа байдлаар нь ч бус, харин улс төрийн намын, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаанд оролцож байгаа байдлаар нь, олон нийтийн бодлогын хэлэлцүүлэгт оролцож байгаа байдлаар нь, сонгогдсон төлөөлөгчдөөсөө хариуцлага тооцон харилцаж байгаа байдал, төрийн эрх баригчдын үйл ажиллагаанд хяналт тавих, орон нутгийн хэмжээнд шийдвэр гаргах хэлэлцээрт шууд оролцож байгаа зэрэг нь өндөр түвшинд байгаа тохиолдолд энэхүү ардчиллыг чанартай байна гэж хэлж болно.

Ойролцоогоор 1950-иад оноос эхлэн бүх ардчилсан орнуудад олон нийтийн санал бодлын асуулга, иргэний идэвхийн мониторинг байнга явуулах болсон юм. Тун өчүүхэн тооны иргэд л улс төрийг үнэхээрийн сонирхдог аж. Хэрэв санал өгөх тэдгээрийн оролцоог хасчих юм бол, өөрөөр хэлбэл сонгуулийн кампани идэвхитэй явуулдаг, улс төрийн ямар нэг намд ажилладаг, улс төрийн жагсаал, цуглаанд оролцох буюу улс төрийн ямар нэг байгууллагын гишүүн байж улс төрийн амьдралд оролцдог иргэдийн тоо бүр ч илүү цөөн болно гэж хэлж болно⁴⁵.

Дэлхий нийтийн хэмжээнд ардчиллын нөхцөлд оролцоог олон янзын хэлбэрээр хязгаарлаж байгаа жишээ олон байдаг. Ардчилсан механизмын үр өгөөжийг сулруулан иргэдийг улс төр, ардчиллаас холдуулж байгаа нь ардчиллын чанар доогуур байгаатай холбоотой. Ардчиллын чанар бусад олон үзүүлэлт болох авлига, эрх мэдлээ урвуулан ашиглах, өрсөлдөөн бага зэргээс үүдэлтэй юм. Гэхдээ нийтийн хүчин чармайлт, иргэдийн хүчийг дайчлах замаар үүнийг өөрчлөн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломжтой, гэхдээ өөрчлөн байгуулалтын зөв хувилбарыг гаргахгүй бол уналтад орж мэднэ. Иргэдийн оролцог боож байгаа өөр зүйлүүд нь хууль бус байдал, хүчирхийлэл бөгөөд үүнээс болоод иргэд эвлэлдэн нэгдэх, саналаа өгөхөд аюул учирч болзошгүй. Өөрсдийн эрх мэдэл, эрх ямбаа хадгалахын тулд эрх мэдэлтэй хэсгийнхний зүгээс ядуучууд, газаргүйчүүд, нийгмийн, бүсийн ба шашны цөөнх бүлгийг хэлмэгдүүлэх, тэдний улс төрд нөлөөлөх боломжийг хаадаг. Мөн оролцоог хэмжих нэг хэмжүүр бол сонгуульд санал өгсөн хүмүүсийн хувь юм. Өөр нэг чухал үзүүлэлт нь улс төрийн нам, нийгмийн хөдөлгөөн, төрийн бус байгууллагад нэгдэн идэвхитэй үйл ажиллагаа явуулах, сонгогдсон төрийн түшээдтэй байнгын харилцаатай байх, иргэд нь төрийн асуудлыг шийдэхэд дуу хоолойгоо хүргэх явдал⁴⁶.

Өрсөлдөөн

⁴⁵ Sydney Verba, Norman H. Nie, and Jae-on Kim. *Participation and Political Equality: A Seven-Nation Comparison*. Cambridge University Press, 1978, p.58-59

⁴⁶ Larry Diamond, Leonardo Morlino. *Assessing the Quality of Democracy*. The John Hopkins University Press., 2005. p.16-17

Улс төрийн систем нь бүрэн ардчилсан байхын тулд улс төрийн намуудын хооронд тогтмол, чөлөөт, шударга сонгуулийн өрсөлдөөнийг бий болгох ёстой. Гэхдээ ардчилсан дэглэмүүд нь өрсөлдөөнийхөө цар хэмжээгээр өөр хоорондоо ялгаатай байдаг. Өөрөөр хэлбэл, улс төрийн шинэ хүчнүүд сонгуулийн тавцанд гарах боломж нээлттэй эсэх, үүрэг хариуцлагыг хялбархан үгүй болгох байдал, өрсөлдөгч улс төрийн намууд бүгд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах боломж нээлттэй байх байдал, сонгуулийн кампанийн санхүүжилт авах эрх нь тэгш байгаа зэргээрээ ялгаатай байдаг. Сонгуулийн тогтолцооны хэлбэрээс хамааран ардчилсан дэглэмүүд нь арай илүү, эсвэл арай бага шийдвэрлэх үүрэгтэй сонгуулийн хувилбаруудыг бий болгох боломж олгодог. Аренд Лийпхартын үзсэнээр пропорциональ систем нь эмэгтэйчүүд, цөөнхийн төлөөллийг хангах гэсэн ардчиллын чанарын бусад хэмжүүрийг хангаж байгаагаараа давуу талтай юм.

Хүчтэй өрсөлдөөний бас нэг нөхцөл нь хуулийн болон үндсэн хуулийн журам юм. Орчин үеийн ардчилалд намуудын, сонгуулийн кампанит ажлын санхүүжилт нь сонгуулийн ажиллагаа амжилттай явагдахад амин чухал бөгөөд шинэ намууд, нэр дэвшигчид нь энэ талаар тогтоосон тодорхой доод хэмжээгүйгээр бодитой өрсөлдөж чадахгүй. Сонгуулийн кампанийн зардлыг хязгаарлах хуулийн үйлчлэлийн талаар нилээд эргэлзээ төрж байгаа үед намуудад, кампанит ажилд зориулан хандивласан бүр хандиваа бүрэн, шуурхай мэдээлэхийг хүчтэй шаардах нь сонгуульд шударгаар өрсөлдөх байдлыг нэмэгдүүлдэг. Сонгуулийн тойрог бүр дээр хамгийн олон санал авсан нэр дэвшигч парламентад сонгогддог системд сонгуулийн тойргийг хуваадаг арга нь өрсөлдөөний хэлбэрийг нарийн тогтоож өгдөг. Сонгууль өрсөлдөөн ихтэй байх нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах шударга, эрх тэгш боломж, мэдээллийн хэрэгслийг олон нийтийн байлгах, нийгэмд эдийн засгийн нөөцийг хуваарилах байдал, улс төрийн эрхийг бие даасан шүүх байгууллагаар дамжуулан хангуулах зэргээс бас хамаардаг. Мөн хариуцлагын босоо тогтолцоотой харилцан хамаарал их байна, яагаад гэвэл, сонгуулийн тэгш эрх, шударга ёсны ганц бөгөөд хамгийн чухал баталгаа нь бие даасан, эрх мэдэл бүхий сонгуулийн комисс байдаг.

Сонгуулийн үр дүн бүтэлгүйтэх нэг нөхцөл нь тухайн сонгуулийн удирдах байгууллагуудад нэг талын хүмүүс давамгайлан сонгуулийн тойргийг хуваахад сонгуулийн зохион байгуулалт, кампанийн санхүүжилт, санал хураалтыг зохион байгуулахад хяналт тавьдаг тал байдаг. Мөн янз бүрийн бүлэг, нам, төлөөллийг сонгуульд шударгаар өрсөлдөхөд нь зарим нам, улс төрийн бус бүлгүүдийн хууль бус үйл ажиллагаа саад болдог. Энэ мэт асуудлуудаас болоод сонгуулийн дүн буруу гарч, ард түмний хүсэл зоригийг төлөөлж чадахгүй нам эрх барих тохиолдолд ардчилал сүйрч, сонгуулийн дарангуйллын тогтолцоо ноёлсон гэж болно.

Хариуцлагын босоо тогтолцоо

Хариуцлагын босоо тогтолцоо нь дээшээ буюу иргэдээс удирдлагууд руугаа чиглэсэн байдаг. Босоо тогтолцоог хэрэгжүүлэх нь цаг зуурын шинжтэй, учир нь орон нутгийн, парламентын сонгуулийн үеэр хэрэгждэг. Хариуцлагын босоо тогтолцооны үр дүн зөвхөн сонгуулийн үеэр хязгаарлагдах ёсгүй, сонгогчид, төрийн түшээдийн хоорондын хамтын ажиллагаагаар илрэх ёстой. Төрийн бус байгууллагууд, нийгмийн бүлгүүд, хөдөлгөөн, хэвлэл мэдээллийн хэрэгслийн зүгээс түшээдийг хариуцлагатай байхыг шаардах ёстой.

Улс төрийн өрсөлдөөн, оролцоо нь хариуцлагын босоо тогтолцоог хэрэгжүүлэх чухал нөхцөл юм. Сонгогчдын зүгээс төрийн түшээд, эрх баригч намын үйл ажиллагааны төлөө тэдэнтэй хариуцлага тооцож чаддаг байхын тулд мэдээлэлтэй байж, тэдний талаар мэдэж байх нь зайлшгүй чухал бөгөөд ингэхэд сонгогчдын санал өгөлт ч өндөр байна.

Хариуцлагын босоо тогтолцоо нь уналтад орох тохиолдол байх ба эрх баригчид эрх мэдлээ урвуулан ашиглах, улс төрийн сөрөг хүчийг мөхөс болгох, хэвлэл мэдээллийг хяналтандаа байлгах, иргэний нийгмийн байгууллагуудыг тэдний урдаас үг хэлэх боломжийг нь хаан, хяналтандаа оруулах зэрэг явдал гардаг. Орчин үед телевизийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь улс төрийн нөлөөллийг бэхжүүлэхэд туйлын чухал учраас эрх баригчид телевизийн бие даасан байдлыг эвдэх оролдлого ихээр гарч байна.

Хариуцлагын хэвтээ тогтолцоо

Ардчиллын чанартай холбоотой нэг зүйл бол томилогдсон албан тушаалтнууд хуулийн дагуу ажиллаж, зөвхөн сонгогчиддоо бус сөрөг талдаа, бусад мрэгэжилтэн хуулийн эрх мэдэлтнүүдийн өмнө хариуцлагаа тайлагнадаг байх ёстой. Нэгэн албан тушаалтан, эсвэл засгийн газрын хариуцлагатай хүмүүс бусад хүмүүст “тушаал-гүйцэтгэл” гэсэн харилцаагаар биш, харин зэрэгцсэн байдлаар хандаж байвал үүнийг хариуцлагын хэвтээ тогтолцоо гэнэ. Хариуцлагын хэвтээ тогтолцоотой байгууллагуудын тоонд хуулийн дагуу байгуулсан сөрөг хүчин, тусгай судалгааны зөвлөлүүд, шүүх, аудитын байгууллагууд, авлига эсэргүүцэх комисс, төв банк, биеэ даасан сонгуулийн захиргаа, төрийн албан хаагч зэрэг удирдлагуудын эрх мэдлийг хязгаарлаж, нарийн хяналт тавих үүрэгтэй бусад олон янзын этгээд орно.

Эрх тэгш байдал

Эрх тэгш байдал бол ардчилсан засаг төрийн хөгжлийн хамгийн чухал сэдэв, асуудал юм⁴⁷. Сайн ардчилал нь иргэд, бүлэг хэсэг бүр адил эрх эдэлж, хуулиар адил хамгаалагдаж, шүүх, захиргаанд нилээд хурдан шуурхай хандаж болох боломжийг баталгаажуулах ёстой. Шударга бус байдлыг идэвхитэй хориглохдоо яс үндэс, хүйс, гарал, шашин шүтлэг, улс төрийн баримжаа, бусад гадаад нөхцлийн үндсэн дээр ялгаварлан гадуурхах бүхий л оролдлогыг сайтар шалгах ёстой⁴⁸. Эрх тэгш байдал нь ардчиллын үндсэн хэсэг бөгөөд ёс зүйн хувьд орчин үеийн нийгмүүдэд тухайн нэг иргэний амьдрал, эрх чөлөөт байдал зэрэг нь бусад иргэдийнхээ эрхүүдээс доогуур тавигдахгүй байх юм⁴⁹.

2012 оны 7-р сарын 8-аас 12-нд Мадрид хотод болсон Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны XXII их хурал “Засаглалын хил хязгаарыг шинэчлэж шинэ хэлбэртэй болгох нь” нэрийн дор явагдсан. Уг хурлаар судлаачдын анхаарлаа хандуулах дэд сэдвүүд бол⁵⁰:

1. Харьцуулсан улс төр ба улс төрийн институтүүд
2. Жендер, харилцаа, соёлын бие даасан байдал
3. Олон улсын улс төрийн эдийн засгийн асуудал
4. Олон улсын харилцаа
5. Улс төрийн бихевиораль байдал
6. Улс төрийн онолын асуудал
7. Төрийн нийгмийн бодлого зэрэг юм.

⁴⁷ Marc Buhlman, Wolfgang Merkel, Lisa Muller. “The Quality of Democracy. Democracy Barometer for Established Democracies”. National Centre for Competence in Research: Challenges to Democracy in the 21st Century. Working paper.,2008. No.10a. p.8

⁴⁸ Larry Diamond, Leonardo Morlino. Assessing the Quality of Democracy. The John Hopkins University Press., 2005. p.26-27

⁴⁹ Robert A.Dahl. On Political Equality. New Haven, CT: Yale University Press.,2006

⁵⁰ www.ipso.org

ДҮГНЭЛТ

Энэхүү өгүүллийн хүрээнд Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны сүүлийн Их хурлуудын сэдвүүд, хэлэлцсэн асуудлуудтай танилцаад, улс төрийн шинжлэх ухааны хамгийн чухал асуудлуудын нэг болох ардчиллын чанар, бэхжилтийн асуудалтай холбоотой бичигдсэн судалгааны материалууд, эрдэм шинжилгээний өгүүлэл зэргийг судлах үндсэн дээр ардчиллын чанарын тухай ойлголт, улс орнуудад тогтоод буй ардчиллуудыг хэмжих, бэхжилтийг тодорхойлох хэмжүүрүүдийг судаллаа.

Ардчиллын давалгаанууд явагдаж дэлхий дээр ардчилсан улсууд бий болсоор байна. Гэсэн хэдий ч ардчиллын хэрэгжих хэлбэр, механизмууд төгөлдөржин тодорхой болж, ардчиллын замаар хөгжиж буй олон улс оронд ардчилал, ардчилсан засаглалынхаа байдалд үнэлгээ өгч, түүний хүрсэн түвшин, чанарыг тодорхойлоход гол анхаарлаа хандуулж байна.

Судлаачдын үзэж байгаагаар, ардчиллыг тогтоосон ихэнх орнуудад ардчиллын наад захын зарчмууд хэрэгжихгүй байна, зарим орнуудад улс төрийн хязгаарлагдмал өрсөлдөөн бий болж улс төрийн болон иргэний эрхийг зөрчих, орлогын тэгш бус хуваарилалт, ядуурал, ажилгүйдэл, хууль бус үйл ажиллагаанууд үргэлжилсээр байна. Орчин үед иргэд мэдээлэл сайтай болсон төдийгүй, тэд идэвхитэй оролцоо, өндөр хариуцлага, ил тод байдал, өрсөлдөөн, хуулийг дээдлэх ёс, эрх чөлөө, тэгш эрх, эцэст нь иргэддээ хариу тайлангаа өгч байдаг засгийн газрыг хүсч байдаг болсон. Гэхдээ ардчилал сайн хөгжсөн орнуудад ч гэсэн нийгмийн шударга ёс, улс төрийн бүх талын оролцоо зэргийг дэмждэг ард түмэн тухайн орныхоо эдийн засгийн болон нийгмийн үр дагаварт сэтгэл дундуур байх болжээ. Үнэн хэрэгтээ ардчиллын урт түүхэн хөгжлийн нэгэн сургамж бол иргэдийн идэвх оролцоо өндөр байх тусам ардчиллын чанар аажмаар сайжран, зорилгодоо хүрдэг байна.

Цаашлаад, олон улсын харилцаанд оролцож буй ардчилагдаж байгаа болон ардчилсан улсуудын хувьд ардчиллын онолын асуудал, ардчиллын чанарын асуудлуудтай холбоотойгоор өнөөгийн байдлаар судлах шаардлагатай зүйлс их байгааг ч судлаачид тэмдэглэж байна.

Ном зүй

Ганболд.Ц., “Ардчиллын хөгжил ба Монголын улс төр”. МУИС. Политологи сэтгүүл.

УБ.,2009. №297 (50)

Ганболд.Ц., “Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны Дэлхийн XX их хурал”.

МУИС. Политологи сэтгүүл. УБ.,2007. №281 (40)

Довчин.Ё., “Улс төрийн шинжлэх ухаан: зохион байгуулалт, онол, арга зүй”. МУИС.

Политологи сэтгүүл. УБ.,2011. №348 (61)

Др.Найжель Ашфорд., Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд. УБ.,2007

Dahl, Robert A. On Political Equality. New Haven. CT: Yale University Press.,2006

Larry Diamond, Leonardo Morlino., Assessing the Quality of Democracy. The John Hopkins

University Press., 2005

Larry Diamond., Elections without Democracy: Thinking About Hybrid Regimes. Journal of

Democracy 13 (April 2002)

Max Kaase., “Democracy and Political Action”. International Political Science Review. 2010. 31

(5)

Marc Buhlman., “The Quality of Democracy: Crises and Success Stories”. IPSA. Sao Paulo,

February 16-19, 2011

Marc Buhlman., Wolfgang Merkel, Lisa Muller. “The Quality of Democracy. Democracy Barometer for Established Democracies”. National Centre for Competence in Research:

Callenges to Democracy in the 21st Century. Working paper.,2008. No.10a.

Schedler Andreas., Elections without Democracy: The Menu of Manipulation. Journal of Democracy 13 (April 2002)

Sydney Verba., Norman H. Nie, and Jae-on Kim. *Participation and Political Equality: A Seven-*

Nation Comparison. Cambridge University Press, 1978

Todd Landman., Assessing the Quality of Democracy. An Overview of the International IDEA


Framework. Sweden.,2008

Todd Landman., “Democracy Analysis”. Ten Years of Supporting Democracy Worldwide. The


International IDEA. Sweden.,2005

Fernando Vallespin., Elena Garcia. Rethinking Political Science for a Changing World. www.ipso.org


Хавсралт. 1



Хавсралт. 2



Хавсралт.3



Хавсралт. 4

Ардчиллын ахицын зэрэглэл	Ардчиллын өсөлт/бууралтын өөрчлөлтийн зэрэглэл 2006-2010	Ардчиллын өсөлт/бууралтын оноо 2006-2010
1 Bangladesh	+11	6.3
2 Serbia	+9	4.7
3 Pakistan	+5	4.4
4 Togo	+2	4.4
5 Paraguay	+11	3.5
6 Malawi	+6	3.1
7 Macedonia, FYR	+10	3.0
8 Poland	+6	2.6
9 Thailand	+10	2.6
10 Nepal	+4	2.5
11 Liberia	+3	2.4
12 Albania	+3	2.3
13 Uruguay	+7	2.3
14 Romania	+1	2.1
15 Moldova	+5	2.1
16 Trinidad and Tobago	+2	2.1
17 Mongolia	+2	2.0
18 Lesotho	+6	2.0
19 Costa Rica	+2	2.0
20 Indonesia	+4	1.9
21 Panama	+1	1.8
22 Cyprus	+5	1.6
23 Mauritius	+1	1.6
24 Uganda	+2	1.5
25 Guatemala	+4	1.4
26 Burkina Faso	+2	1.4
27 Ghana	-1	1.4
28 Chile	+2	1.3
29 Switzerland	0	1.3
30 Belgium	+1	1.3
31 Dominican Republic	+2	1.3
32 China	+2	1.3
33 Zambia	+3	1.2
34 Mozambique	+4	1.2
35 Slovenia	0	1.2
36 Singapore	-1	1.1
37 Norway	+1	1.1
38 Argentina	0	1.1
39 United States	0	1.0
40 Malaysia	+1	1.0
41 India	+3	1.0
42 Croatia	0	1.0

43 El Salvador	+1	1.0
44 Lebanon	-1	1.0
45 Tanzania	+1	1.0
46 Brazil	0	0.9
47 Korea, Rep.	+2	0.9
48 Germany	+1	0.8
49 Ireland	+1	0.8
50 Canada	0	0.7
51 Peru	-1	0.7
52 New Zealand	0	0.6
53 Australia	-1	0.6
54 Libya	+1	0.6
55 Benin	0	0.6
56 Czech Republic	-1	0.5
57 Bosnia and Herzegovina	+2	0.5
58 Egypt, Arab Rep.	+1	0.5
59 Finland	0	0.5
60 Netherlands	0	0.5
61 Ecuador	-1	0.4
62 Israel	0	0.4
63 Portugal	0	0.4
64 South Africa	0	0.3
65 Namibia	0	0.3
66 Tunisia	0	0.3
67 Japan	0	0.3
68 Slovak Republic	0	0.3
69 Austria	0	0.2
70 Spain	0	0.1
71 Denmark	0	0.1
72 Russian Federation	-1	0.0
73 Bolivia	-4	0.0
74 Estonia	-1	0.0
75 Botswana	-2	-0.1
76 Turkey	-1	-0.1
77 Morocco	-2	-0.1
78 Syrian Arab Republic	-1	-0.2
79 Georgia	-2	-0.2
80 Kuwait	-2	-0.2
81 Colombia	-3	-0.3
82 Jamaica	-3	-0.3
83 Sweden	-1	-0.3
84 Kenya	-2	-0.3
85 Ukraine	-2	-0.3
86 Greece	-4	-0.4
87 Bulgaria	-2	-0.5
88 Armenia	-3	-0.5
89 Yemen, Rep.	-1	-0.5
90 Bahrain	-3	-0.5
91 United Kingdom	-2	-0.6
92 Mali	-4	-0.6
93 Nigeria	-2	-0.7

94 Lithuania	-5	-0.8
95 Central African Republic	-1	-0.8
96 Nicaragua	-7	-0.8
97 Gambia, The	-2	-0.8
98 Senegal	-4	-1.0
99 Philippines	-6	-1.1
100 France	0	-1.1
101 Italy	-4	-1.1
102 Hungary	-3	-1.3
103 Burundi	-2	-1.4
104 Venezuela, RB	-8	-1.5
105 Latvia	-6	-1.8
106 Sri Lanka	-5	-1.8
107 Mexico	-5	-1.9
108 Honduras	-10	-2.4
109 Madagascar	-16	-5.4
110 Niger	-14	-7.3
Ногоон: Эдгээр улсууд өмнөх зэрэглэлээсээ ахисан байгаа. Ногоон: Ардчиллын онооны ахиц		
Цагаан: Эдгээр улсуудын зэрэглэл өмнөх хоёр үеэсээ ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.		
Улаан: Эдгээр улсууд өмнөх үеэсээ зэрэглэл буурсан байгаа. Улаан: Ардчиллын онооны бууралт		
Саарал: Эдгээр улсуудын “боломжит оноо”-г 2009, 2010 онуудад Фрийдом Хаусын зүгээс “чөлөөт биш” гэсэн ангилалд оруулсан.		

ХӨГЖИЛД ХҮРСЭН ТУРШЛАГА БА МОНГОЛЫН АРДЧИЛАЛ

Ч.ӨЛЗИЙСАЙХАН¹, Д.УНДРАХ²

¹МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, доктор, дэд профессор

²МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, докторант

Түлхүүр үг: Олон улсын харилцаа, байгалийн баялаг, нөөц, уул уурхай, ашигт малтмал, дэлхийн улс орнууд, эдийн засаг, засгий газар, гадаад бодлого

ABSTRACT: As Mongolia has gained a specific role in global economic relations and keeps its geopolitical peculiarity, it has become vital to define its secure existence in international arena and to determine future perspectives and development tendency neatly. In the article, comparative analysis had been done between those countries with the history of failure and success on the way of exploring and circulating their rich source of natural wealth.

ТОВЧ АГУУЛГА: Баялагаа дагаж хөгжсөн орнууд нэг бол баяжсан, эсвэл баларсан байгаагын шалтгаан нь тухайн улс баялагтаа эзэн болж чадсан уу, төрийн бодлого нь энэ том эдийн засагт тохирсон алсын хараатай байж чадсан байна уу гэдгээр тайлбарлагдах боломжтой ажээ. Байгалийн баялгаараа дэлхийн нийтэд танигдсан улс орнуудын өнөөгийн байдлыг зэрэгцүүлэн харж, Монголчууд бид хаашаа хандаж, юунд зорьж буйг зураглахыг оролдлоо.

Олон улсын харилцааны онолын томоохон төлөөлөгч Ганс Моргентуа олон улсын бодлого нь бусад ямар ч улс төрийн бодлогын нэгэн адил нөлөөлөө тогтоохын төлөөх тэмцэл юм гэж өгүүлсэн байдаг билээ. Монгол улс олон улсын эдийн засгийн харилцаанд томоохон байр суурь эзэлсэн, геополитикийн хувьд нилээд онцлогтой улс болж байгаа бөгөөд олон улсын харилцааны өвөрмөц орчинд хэрхэн оршин тогтнож, хөгжлийн бодлогоо тодорхойлж, ирээдүйн хэтийн төлөвөө зөв урьдчилан харах нь нэн ойрын тулгамдсан асуудал болж байна. Бид энэхүү өгүүллийг бэлтгэхээр материал судлаж эмхэлж цэгцлэх явцдаа манай Монгол улс шиг баялагаа дагаж хөгжсөн орнууд нэг бол баяжсан, эсвэл баларсан байгаад үнэлэлт дүгнэлт өгөхийг хичээсэн билээ. Баяжих, балрахын гол учир шалтгааныг тухайн улс баялагтаа эзэн болж чадсан уу, төрийн бодлого нь энэ том эдийн засагт тохирсон алсын хараатай байж чадсан байна уу гэдгээр тайлбарлах боломжтой болох нь илт харагдаж байсан билээ. Бид энэхүү судалгаагаараа байгалийн баялагаараа дэлхийн нийтэд танигдсан улс орнуудын өнөөгийн байдлыг зэрэгцүүлэн харж, баялгыг хэн хянаж байна гэдгийг улс орнуудын түүхийн зам мөртэй нь уялдаа холбоотой болохыг гаргахыг зорьсон. Судалгааны ажлын гол үр дүнг эхэнд нь харуулах нь улс орнуудын түүхийг харьцуулж, үнэлж дүгнэхэд илүү дөхөмтэй болов уу гэж үзсэнээс дараахь хүснэгтийг толилуулъя.

Байгалийн баялагтай орнууд

Улс нь байгалийн баялагынхаа дийлэнхи хувийг хянадаг орнууд	Улс нь байгалийн баялагынхаа дийлэнхи хувийг хянаж чаддаггүй орнууд
• Австрали • Хятад • Чили • Алжир • Канад • Катар • Кувейт • Ливи • Саудын Араб • Хятад	• Нигерия • Боливи • Монгол

Энэ жагсаалтыг цааш үргэлжлүүлэх боломжтой боловч ерөнхийдөө ашигт малтмалын нөөцөөрөө дэлхийд томоохонд тооцогдох орнууд энд хамрагдсан тул тоог хязгаарласан болно.

Австрали улс нь газар зүйн байрлалын хувьд алслагдмал, бусад улс орнууд байгалийн баялагыг нь цөлмөх аюул харьцангуй багатай, эртнээс зах зээлийн эдийн засаг хөгжиж ирсэн учраас улс нь өөрийнхөө жам ёсоор хөгжих таатай нөхцөлтэй байсан орон. Харин дотооддоо бол уул уурхайн лицензтэй холбоотой бослого тэмцэл дээр үеэс гарч байсан. Жишээлбэл, 1854 онд уул уурхайн үйлдвэрлэлийн лиценз олголттой холбоотой “Эврикийн бослого” гарч энэ бослогын дараа Их Британы импери нь Австралид гадаад хэрэг, батлан хамгаалалт, олон улсын усан тээврийн асуудал гэсэн хязгаарлагдмал хүрээнд өөрийн хяналтаа хадгалж үлдэхээр болсон байдаг. Өөрөөр хэлбэл, хэдийгээр колоничлолд байсан ч эдийн засаг, байгалийн баялаг дээр Австраличууд өөрсдөө эзэн байх эх суурь эртнээс тавигджээ. 2006 онд Тиморын тэнгисийн нефть, байгалийн хийн ордтой холбоотой маргаантай байсан асуудлаа шийдэж хийн болон нефтийн олборлолтоо “50:50” байх тохиролцоонд хүрчээ. Австралийн байгалийн баялагын нөөц нь дэлхийн дунджаас 20 дахин их юм.

Хятад. Catalogue of Industries for Guiding Foreign Investment (2011 Revision)[现行有]

【法规标题】外商投资产业指导目录(2011年修订) [Effective]

II. Mining Industry

1. Exploration and exploitation of coal-bed gas and utilization of mine gas (limited to Chinese-foreign equity or contractual joint ventures)
2. Risk exploration and exploitation of oil and natural gas (limited to Chinese-foreign equity or contractual joint ventures)
3. Exploitation of low permeability oil or gas reservoirs (fields) (limited to Chinese-foreign equity or contractual joint ventures)
4. Development and application of enhanced oil recovery and relevant new technologies (limited to Chinese-foreign equity or contractual joint ventures)
5. Development and application of new technologies for oil exploration and exploitation in areas such as geophysical prospecting, drilling, well logging, mud logging, and down-hole operation (limited to Chinese-foreign equity or contractual joint ventures)

6. Exploration and exploitation of unconventional oil resources, such as oil shale, oil sand, heavy crude oil, and extra-heavy crude oil (limited to Chinese-foreign equity or contractual joint ventures)
7. Exploration, exploitation and ore dressing of iron and manganese minerals
8. Development and application of new technologies for enhancing utilization rate of mine tailings and the comprehensive application of ecological restoration technology in mining areas
9. Exploration and exploitation of unconventional natural gas resources, such as shale gas and marine gas hydrate (limited to Chinese-foreign equity or contractual joint ventures)

Энэ катологи бол Хятадын засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримтлаж байгаа бодлогыг тодорхой харуулж байгаа бөгөөд бид судалгааныхаа зорилгод нийцүүлэн зөвхөн ашигт малтмалтай холбоотой хэсгийг таслан авсан болно. Энэ жагсаалтанд байгалийн хий, нефть, төмөр, мангани зэрэг ашигт малтмалын олон салбар дээр Хятад болон гадаадын хөрөнгө оруулалт шударга ёсны үндсэн дээр эсвэл гэрээгээр зохицуулсан хамтарсан үйлдвэрлэл байж болно гэж заасан байна. Өөрөөр хэлбэл, Хятадын тал шударга ёс гэдэг дээр өөрийн газар нутаг дээр байгаа баялгийг олборлож байгаа тул эзэн нь юмаа мэдэх гэсэн энгийн зарчмыг мөрдлөг болгохоо төрийн бодлогоор зааж өгсөн байгаа бөгөөд амьдрал дээр ч энэ бодлого бодитой хэрэгждэг байна.

Чили нь дэлхийн зэсийн гол экспортлогч орны нэг. Зэсийн олборлолт хийдэг Коделко нь - төрийн өмчит байгууллага бөгөөд зэс үйлдвэрлэлээр дэлхийд томд тооцогдох корпораци. Чилийн зэсийн томоохон ордуудыг 1900-аад оны үеэс АНУ-ын 100% хөрөнгө оруулалттай компани эзэмшиж байсан ба 1971 онд ерөнхийлөгч Сальвадор Альендегийн 17450 тоот тогтоолоор бүх зэсийн ордуудыг Коделкод шилжүүлж авсан. Өөрөөр хэлбэл, гадаадын эзэмшигчдийн өмчийг национализаци хийх замаар өнөөгийн зэсийн дэлхийд нөлөө бүхий том корпораци эх орныхоо баялгийн эзэн болж байгуулагдсан түүхтэй. 1973 онд болсон төрийн эргэлтээр зэсийн том ордуудаа Чилид нь буцаан авчирсан ерөнхийлөгч Сальвадор Альенде алагджээ. 1970-1973 оны хооронд АНУ төмөр зам, цахилгаан станц замын сүлжээг нь зорилготойгоор эвдэж улс оронд эмх замбараагүй байдал бий болгож төрийн ердийн үйл ажиллагаа явуулах боломжгүй болгосон гэж үздэг хүмүүс бас байдаг байна. Хэдийгээр олон хүний амь нас, эрх чөлөөг зольж олж авсан ч Коделько корпорацийн мэдлийн зэсийн том ордууд Чилийн ард түмний өмч болон хоцорчээ. Одоогийн дүр төрхөө 1976 онд ерөнхийлөгч Аугусто Пиночетийн үед олсон байна. Коделкогийн захиралыг Чилийн Ерөнхийлөгч томилдог. Чили улс зэсийн том ордуудаа өөрсдийн талд шилжүүлэн авснаас хойш 4-5-хан жилийн дараа гэхэд улс орныхоо хөгжлийн эрчимтэй хөгжлийн зам дээр нэгэнт зогсч чадсан байсан гэж үздэг ажээ. Үүнийг дараах хэдхэн үзүүлэлтээс харья: Ерөнхийлөгчийн засаглалтай. 16,928 873 хүн амтай. ҮНБ нь 243 044 тэрбум доллар, үүнээс нэг хүнд оногдох хувь 14 510 \$.

Алжирийн эдийн засгийн гол салбар нь нефть, шатдаг хийн олборлолт юм. Шатдаг хийн нөөцөөрөө дэлхийд 5-д, шатдаг хийн экспортын хэмжээгээрээ дэлхийд 4-т ордог. Нефтийн нөөцөөрөө дэлхийд 15-д, нефтийн экспортоороо дэлхийд 11-д ордог. Хүн амд оногдох дотоодын нийт бүтээгдхүүн 6,9 мянган доллар, дэлхийд 126-д ордог. Хүн амын ядуурал 26%.

1962 оны Ү сарын 5-нд Францын колониос гарсан. 37 100 000 хүн амтай. ДНБ нийт 255 012 миллиард. Францын колончлолын эсрэг цус урсгасан дайн 1954 онд эхэлж 1962 онд эрх чөлөөгөө олж авсанаар дууссан. Энэ дайнд 300 000-1 000 000 гол төлөв энгийн ард иргэд нас барсан гэж янз бүрийн эх сурвалж өөр өөрөөр тайлбарладаг юм байна. 1957 онд Франц улс Алжирт цөмийн бөмбөг турших полигоноо байгуулж, 1960-

оы II сарын 13-нд анхны атомын бөмбөгийн туршилтаа хийсэн бөгөөд албан ёсны тоогоор 17 удаа туршилт хийсэн гэгддэг. Хирошимад 13 килотонн, Нагасакид 21 килотонн тротилийн эквиваленттай тэнцэх атомын бөмбөг хэрэглэсэн байдаг бол 1961-1966 онд Алжирт 70 килотонн бөмбөг туршсан байдаг ажээ. Алжир Францаас чөлөөлөгдсөний дараа ч энэ туршилт үргэлжилсэн бөгөөд 1960-1995 онд Франц улс нийт 210 цөмийн зэвсгийн туршилт хийсэн байна

Сайд нарын Зөвлөлийн дарга байсан Д.Содном гуай Газрын тосны газрын даргаар 1992 онд ажиллаж байхдаа Алжирт очиж газрын тосны талаар баримтлах бодлогын талаар туршлага судлаж явахад "...газрын тосны бодлогоо эхнээсээ буруу тавибал засахад маш хэцүү, манай орон их удаан хугацааны тэмцлийн дүнд өөрийн талд ашигтай байхаар зохицуулж чадлаа. Өмнө нь бол Алжирын талд ямарч ашиггүй, Францын талд дэндүү ашигтай байхаар гэрээ хийгдсэн байсан. Манай энэ алдааг та нар давтаж болохгүй..." гэж анхааруулж байсан гэж бичсэн байдаг. Харамсалтай нь Д.Содном гуай энэ талаар хичээн ажилласан ч үр дүнд хүрээгүй болохоо бас бичиж тэмдэглэсэн байдаг юм.⁵¹

Канад нь дэлхийн хамгийн баян орнуудын нэг. Ойн аж ахуй, нефть олборлолт нь хамгийн чухал салбаруудад тооцогдоно. Байгалийн хийн арвин нөөцтэй. Нефтийн нөөцөөрөө Саудын Арабын дараа 2-рт ордог.

Дэлхийн II дайны дараа Канадын националистууд америкийн бараа таваар, бүтээгдхүүн, мэдээллийн хэрэгсэл газар сайгүй бий болсонтой холбогдуулан үр тариа болон эдийн засгийн бие даасан байдлынхаа төлөө санаа зовинож эхэлсэн байна. 1970-аад оны үед эрчим хүчний хангамжийн асуудал, боловсруулах үйлдвэр дэх гадаадын капиталын эзлэх хувь хэмжээтэй холбогдуулан либерал бодлого баримтлаж байсан ерөнхий сайд Пьер Трюдогийн засгийн газар нь бодлоготоо өөрчлөлт оруулж Үндэсний эрчим хүчний программ ба гадаадын хөрөнгө оруулалтыг хянах шийдвэр гаргахад хүргэжээ. 1960-д онд гадаадын хөрөнгө оруулагчдыг радио телевиз, банк, санхүүгийн компани нээх, тэрчлэн газрын тосны хайгуул хийх, ураны ордуудыг эзэмшихийг хориглосон. Гадаадын капиталуудын хөрөнгийг дахин шалгах агентлаг байгуулж тэднийг Канадаас ашиг олох явдлыг багасгах бодлого баримтлажээ. Нефтийн олборлолт, боловсруулалтанд 1979 оноос гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан байна.


Дэлхийн хамгийн баян орнуудын нэг Катар нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдхүүн нь 88222 \$. Шатдаг хийн нөөцөөрөө дэлхийд III-т ордог. Нүүрс ус төрөгчийн нэгдэл бүхий түүхий эдээсээ хараат бус байхын тулд гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого явуулдаг. 800 000 хүн амтай. 1935 онд Катар Их Британитай "Петролеум девелопмент оф Катар" компанийг концессийн гэрээгээр байгуулсан. Энэ гэрээгээр 75 жил бараг ямар нэг хяналт, хязгаарлалтгүйгээр нефть болон шатдаг хий хайх, олборлох, худалдах, аж үйлдвэрийн барилга байгууламж барих, гадаадын ажилчдыг оруулах болсон байв. Энэ нь улс орны эдийн засгийн уламжлалт бүх харилцааг эвдсэн, уугуул оршин суугчдын нөхцөл байдлыг эрс дордуулсан гэрээ байв. 1960 оны сүүлчээр Их Британийн колоничлох бодлогын эсрэг хямрал илт болж 1961-ҮИ-19-нд Их Британийн колониос гарсан. Дэлхийд III-т орох нефть, шатдаг хийн том компани болох The Golden Pass Pipeline-д Qatar Petroleum (70%), ExxonMobil (17.6%) and ConocoPhillips (12.4%) хувийг эзэмшиж байна. Өөрөөр хэлбэл нефтийн бүтээгдхүүнийхээ 70%-ийг өөрсдөө хянах бололцоотой болсон.

Кувейтийн хүн ам 3,566 000 атал дэлхийн нефтийн нөөцийн 9 % нь энэ улсад байдаг бөгөөд энэ нь дэлхийд YII байрт орох хэмжээний их нөөц юм. Нэг хүнд оногдох

⁵¹ Алтан Чой овогт Думаагийн Содном, Амьдрал бодол, УБ.2003 он, 138 дахь тал

ДНБ нь 54100 ам.долларт хүрсэн. 1913 онд шейх Мубарак Их Британи улс Кувейтийн нефтийн боловсруулалтанд монополь эрх тогтоохоор гарын үсэг зурсан. Гэвч 1961 оны YI сарын 19-нд тусгаар тогтнолоо олж авснаар байгалийн асар их баялгаа өөрсдөө захиран зарцуулах боломжоо олж авчээ.

Нигерия улсын нефть олборлолт



Kuwait Oil Company (KOC), Kuwait Petroleum Corporation (KPT) зэрэг төрийн эзэмшлийн том компаниуд нь Кувейтийн нефтийн баялгыг хянаж байна. КОС бол дэлхийд IY-т орох том экспортлогч компани юм. 1960 онд энэ компанийг төр ба хувийн секторын оролцоотой хамтарсан хэлбэрээр

байгуулж байсан боловч 1975 оноос 100% төрийн өмчийн компани болж өөрчилжээ.

Нигерия улс нь хуучин Их Британий колони байсан, 152 217 341 хүн амтай, ДНБ 206,7 миллиард, нэг хүнд оногдох ДНБ нь 2009 оны байдлаар 2400\$ байв. Энэ үзүүлэлтээрээ Африктаа 13-т, дэлхийд 177-д орох бөгөөд ядуурал 70%-д хүрчээ. Тропикийн дулаан уур амьсгал, саванна, хүрхрээ ихтэй тул туризм хөгжсөн ч бохирдол, цэвэр усны асуудал нь энэ улсад ихээхэн хүндрэл учруулдаг. 1966 онд цэргийнхэн төрийн эргэлт хийсэн нь нь шашин угсаатны мөргөлдөөн болтлоо даамжирсан. 1967-1970 онд иргэний дайн болсон. 1966-1978, 1984-1989, 1993-1998 онуудад улс төрийн намуудын үйл ажиллагааг хориглож байсан. Одоог хүртэл шашин угсаатны мөргөлдөөн гарч олон зуун хүн үрэгдсээр байна. Хүүхдийн эндэгдлээр дэлхийд 11-д ордог бол, бичиг үсэг мэдэх хүмүүс нийт хүн амын 68%-г эзлэнэ. Улс төрийн хувьд тогтворгүй, авилга ихтэй.

1901 онд нефтийн орд нээж илрүүлсэн, нефтийн их нөөцтэй. 1956 оноос нефть боловсруулж эхэлсэн ба 1971 оноос ОПЕК-ийн гишүүн орон болсон. Дэлхийд нефтийн экспортоороо 2007 онд 8-р байранд орж байсан бөгөөд 2008 онд л гэхэд өдөрт 2,17 сая баррель нефть олборлож байв. Нефтийн нөөц нь 25-36 миллиард баррель гэж тооцогддог. Нефть олборлолтыг Nigerian National Petroleum Company (NNPC) болон үндэстэн дамнасан корпораци Shell, Exxon Mobil, Chevron, ConocoPhillips, Eni, Total, Addax-ын хамтарсан байгууллага эрхэлдэг. Shell хэмээх Дани улсын компани 52%-ийг дангаараа хянаж байдаг. 2003 онд нефть олборлолт 22 миллиард доллар хүрсэн ба энэ үед нефть олборлолтоороо дэлхийд 6-д орж байжээ. АНУ, Европын орнуудад бүтээгдхүүнээ экспортлодог. XXI зууны эхэн үеэс гадаадын компаниудын үйл ажиллагаанд засгийн газрын бус зэвсэгт хүчнүүд саад учруулах болсон ба МЕНД, Бакасын залуус, Африкийн Эгбес залуус, Нигерийн ард түмний сайн дурын Дельта отряд зэрэг байгууллагууд гадаадын иргэдийг барьцаалах, дэлбэлэх гэх мэт үйл ажиллагаа явуулдаг болжээ. Нигери улсыг өмнөх байгалийн баялаг дээрээ түшиглэн амжилттай хөгжсөн орнуудтай харьцуулбал өөрсдийн баялагтаа хяналтаа тавьж чадаагүйгээс ард олон нь ядуурсан, энэ байдалд сэтгэл дундуур хэсэг нь янз бүрийн үймээн, тэмцэл, аллага хядлагад автдаг нь тодорхой харагдаж байна. Олон түмний сэтгэл дундуур байдлаас үүдэлтэй иргэний дайн Нигеричуудын амьдралын салшгүй хэсэг болж байжээ гэж үзэж болох юм.

Афганистан улс нь 1978 оноос хойш дайны байдалд байна. Өрнө Дорныг холбосон худалдааны зам дагуу байрладаг, ашигт малтмал ихтэй ч нутаг орны уулархаг тогтоц нь ашиглахад бэрхшээл учруулдаг. Нүүрс, үнэт металл, гантиг, лазурит, байгалийн хий, зэс төмөр, маргенц ихтэй. Айнак хэмээх Кабулд ойрхон Евроазид хамгийн томд тооцогдох зэсийн ордтой. Хаджигекийн төмрийн орд нь Өмнөд Азид

хамгийн томд тооцогдоно. Газарзүйн чухал байрлал, байгалийн арвин баялаг нь нь энэ орныг их гүрнүүдийн тэмцлийн талбар болгож “Их тоглоом” гэгдэх дэлхийн хүчирхэг гүрнүүдийн тоглоомын талбарт аваачсан.

1973 онд хаант засаглалаа унагааж бүгд найрамдах засаглал тогтоосон. 1978 онд хувьсгал эхэлсэн. Энэ үед ерөнхийлөгч Мухаммед Дауд гэр бүлийнхнийхээ хамт алагдаж Хафизулла Амин төрийн тэргүүнээр гарч ирсэн бөгөөд тухайн үеийн ЗХУ Аминыг Барууны талд ороход бэлэн этгээд гэж үзсэн тул Афган руу цэргээ оруулж иргэний дайн, үймээн самууныг даамжруулсан нь өнөөг хүртэл үргэлжилж байна.

1992 оноос хойш хар тамхины үйлдвэрлэл эрчимтэй хөгжсөн ба 1999 онд 4000 тонн хар тамхины ургац хурааж дэлхийн рекорд тогтоож байв.

2001 оны IX сарын 11-ны үйл ажиллагааг зохион байгуулагч, алан хядагч Осама Бин Ладен Афганистанд орогнож байсан нь АНУ цэргээ Афганистанд оруулах шалтаг болж өгсөн. Нэлээд судлаачид үүнийг Туркменстан-Афганистан-Пакистан-Энэтхэгийг дамжсан шатдаг хий дамжуулах хоолойд АНУ-ын оролцоог хассантай холбож тайлбарладаг байна. Нэг хүнд оногдох ДНБ 800\$. Экспорт нь хар тамхи, үр тариа, жимс, самар, арьс шир. 28 сая хүнтэй. Эрэгтэйчүүдийн 43%, эмэгтэйчүүдийн 12% нь бичиг үсэгтэй.

Ливи улс нь 1951 онд Италийн колониос гарсан. 6 365 563 хүн амтай. ДНБ нь 88 133 миллиард, нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдхүүн нь 14 192\$ байдаг нь дэлхийд 55-д орно. 2011 оны II сарын 5-нд Ливийн боомт хот Бенгазид “шашны зүтгэлтнийг” цагдаа болон засгийн газрын зүгээс баривчилсантай холбоотойгоор 500-600 хүн Бенгазийн төв талбайд жагсч цагдаа нартай мөргөлдсөн. Хоёр зэвсэггүй цагдааг жагсагчид дүүжилж алсан байна. Ливийн засгийн газар олон арван арабын бусад орноос ирсэн хүмүүсийг баривчилсан бөгөөд “гадаадынхны сүлжээнд орсон” гэж буруутгасан байна. Босогчид 1969 оноос хойш засгийн эрхэнд байсан Муаммар Каддафийг огцрохыг шаардаж тэмцсэнээр олон зуун хүн амий алдсан.

Өрнөдийн орнуудтай цэрэг зэвсгийн асуудлаар маш их асуудал үүсгэж байсан нь Пан-африкан үзлийг их дэмждэг бодлого баримталж байсантай нэг талаараа холбогдоно.


Нефть газрын нөөц их. Нефтьхими, нефть боловсруулах, баяжуулах, хөнгөн цагааны үйлдвэрлэл их хөгжсөн. 1970 оны үеэс нефтийн компаниуд дээр национализаци хийж олборлолт, тээвэрлэлт зэрэг үйл ажиллагаанд нь хяналт тавьж эхэлсэн. Энэ бодлогын хүрээнд Conoco Phillips, British Petroleum болон Amoco зэрэг гадаадын компаниудын эзэмшилд байсан хэд хэдэн ордуудыг өөрийн орондоо шилжүүлэх үйл ажиллагаа явагдсан. 1973 онд Ливи болон Арабын орнууд Израйлийг дэмжиж байгаа Европын орнуудыг эсэргүүцэж эмбарго буюу нефть нийлүүлэлтдээ хязгаарлалт хийсэн. Хэдийгээр эмбарго цуцлагдсан ч олон орон *British Petroleum*-д тохиолдсон таагүй туршлагатай холбоотойгоор Ливийн удирдагчидтай ямар нэг бизнес хийхээс болгоомжилж байв. Гэсэн хэдий ч 1974 оноос Франц, Аргентин улсуудтай бартерийн гэрээ хийж чаджээ. Харамсалтай нь эмбарго АНУ-тай өнөөг хүртэл үргэлжилсээр байгаа бөгөөд магадгүй энэ нь бие биенийгээ хардах сэрдэх нөхцлийг бий болгож өнөөдөр Ливийн ард түмэнд учирч байгаа гай зовлонгийн учир шалтгаан болж байж болох юм.

Саудын Арабын хүн ам нь 28 686 633. ДНБ нь 622,0 млрд \$ нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдхүүн нь 25 338\$. 2009 онд нефть олборлолтоор Оросын дараа 2-рт орж байсан. Нефть нь экспортын бүтээгдхүүний 95%, нийт орлогын 75%-ийг бүрдүүлдэг. Энэ баялагаа нийтийн сайн сайхны төлөө зарцуулах боломж олгодог.

1938 онд Саудын Араб нефтийн том орд нээж, 1946 оноос нефть боловсруулах үйлдвэр барих ажил эхэлсэн нь энэ улсын баяжих эх үүсвэр тавигдсан гэж болно. Тус улсад улс төрийн намыг хориглодог. Гүйцэтгэх засаглал, сайдуудад зөвлөх ассамблейг 4 жилийн хугацаатайгаар эзэн хаан томилдог.

Давуу тал нь асар их нефть, байгалын хийн баялаг, түүнд зохицсон боловсруулах үйлдвэртэй. Нефтиэс олох ашиг орлого дээр маш сайн хяналт тавьдаг. Илрүүлсэн нефтийн нөөц нь 260 миллиард баррель бөгөөд дэлхийн илрүүлсэн нефтийн нөөцийн 24% болно. Бусад орнуудтай харьцуулбал энэ тоо нь байнга өсч байдаг. Учир нь шинэ ордууд нээгдсээр байна. ОПЕК-ийн орнууд дотроо гол үүрэгтэй, дэлхийн нефтийн үнийг тогтоож өгч байдаг. Улс орондоо нефтиэс гадна үндэсний үйлдвэрлэл бий болгоход анхаарч төмөрлөг, нефтьхими, эмийн үйлдвэрүүдийг хөгжүүлсэн.

1945 оны II сард АНУ-ын ерөнхийлөгч Франклин Рузвельт Саудын Арабын хаан Ибн Сау нар АНУ-д хайгуулын ажил хийх монополь эрхийг олгосон гэрээнд гарын үсэг зуржээ. 1951 онд Arabian-American Oil Company (ARAMCO) компани байгуулж концессийн гэрээ байгуулсан. Энэ компани нь нефтийн орлогоо 50:50 хувиар хуваана гэсэн зарчимд тулгуурлажээ. 1980 оноос ARAMCO 100% өөрсдийн хяналтаа тавих, эзэмших болсон.



Боливи улс нь цагаан тугалга, газрын тос, цайр, гянт болд, мөнгө, төмөр, алтны нөөц ихтэй. Байгалийн хийн нөөцөөрөө Өмнөд Америктаа 2-рт ордог. 500 жилийн өмнөөс Испаничууд Потосийн мөнгөний асар их нөөцтэй уурхайг ашиглаж эхэлсэн. Дэд бүтэц хөгжөөгүй. Хэдийгээр асар их байгалийн баялагтай боловч хүн ард нь туйлын ядуу амьдардаг, хүн амын 70% нь ядуучууд байдаг. Улсын төсөвөө ядууралтай тэмцэхэд голлон зарцуулдаг. Далд эдийн засаг ДНБ-

ний 68.1% хүрдэг. 1952 оноос хойш бараг жил бүр хувьсгал болж байгаа ба иргэний хөдөлгөөнүүд нь сүүлийн үед байгалийн хийн салбараа төрийн мэдэлд авахыг эрх баригчдаасаа шаардаж эхэлсэн.

Ерөнхийлөгч Эво Моралес нь 2009 онд байгалийн хийн үйлдвэрлэлийг төрийн мэдэлд авч Америкийн “Exxon Mobil”, Испанийн “Repsol”, Бразилийн “Petrobras”, Францын “Total”, Их Британийн “British gas” зэрэг олон улсын томоохон корпорацитай хийсэн бүх гэрээг хүчингүй болгоно гэдэг амлалт өгч байлаа. 2009 онд Эво Моралес шинэ үндсэн хууль санаачлан батлуулж, эдийн засгийн тулгуур салбаруудаа төр хянадаг байхаар зааж өгчээ. Өөрөөр хэлбэл Боливи улс нь ашигт малтмалын асар их нөөцтэй, түүнийгээ олборлох талаар олон зуун жилийн туршлагатай боловч энэ их баялаг дээрээ төрийн буруу бодлого явуулж өөрийн эх орондоо үлдээх, өөрсдөө хяналт тавих талаар бодлого явуулаагүй нь энэ орныг ядуурлын туйл руу түлхжээ.

Дээр дурдсан зүйлүүд бол эдгээр улсуудын талаархи, тэдний туулж өнгөрүүлсэн түүхийн талаархи хамгийн энгийн мэдээлэл юм. Хэдийгээр хамгийн энгийн, хэний ч олж авч чадах мэдээллүүд боловч эдгээрийг харьцуулж харвал ихээхэн нарийн учир шалтгааныг хэлж өгч байна. Тухайлбал:

1-рт, Байгалийн баялаг их байна гэдэг нь тэр орон хөгжин цэцэглэж, иргэдийн амьдрал нь элбэг баян байна гэсэн баталгаа огт биш ажээ.

2-рт, Байгалийн баялаг ихтэй орнуудын төрөөс үндэснийхээ эрх ашгийг зөв тооцоолоогүй, харалган бодлого явуулах нь тэр орныг хөгжлийн зам руу биш харин сүйрэл мөхөл, иргэний дайн, улс хоорондын мөргөлдөөн, үгүйрэл хоосрол руу түлхэх ноцтой шалтгаан болж мэднэ.

3-рт, Баялгийн шударга бус хуваарилалт хийгдсэн тохиолдолд ард олны эсэргүүцэл тэмцэл гарах магадлал өндөр, тэр нь ч ноцтой үр дагаварт хүргэсэн түүх их бий.


4-рт, Ихэнх тохиолдолд байгалийн баялаг эхэндээ гадаадын эдийн засгийн чадавхи сайтай улс орон, компаниудын мэдэлд шилжсэн байдаг.

5-рт, Гадаадын улс орнууд болон компаниудын мэдэлд шилжсэн баялагаа буцаан авч өөрийн орны төр засаг эсвэл үндэсний компаниудын мэдэлд шилжүүлж авч чадсан орнууд л хөгжилд хүрч чадсан жишээ элбэг.

6-рт, Гадаадын улс орон, компаниудын мэдэлд байгалийн баялагаа алдсан улс орнуудад төр, засгийн эрх мэдэлтнүүд нь авилга хээл хахуульд идэгдэж, төрийн зөв бодлого явуулах нөхцөлгүй болдог.

7-рт, Нэгэнт төрийн өндөр албан тушаалтнууд авилгын сүлжээнд орсон бол ийм бодлого дараа дараагийн үеүдэд ч үргэлжлэх магадлал их учраас баялагын хараалаасаа гарч чадахгүй доройтон мөхөхөд хүрч болох юм.

Улс орон хөгжлийн замаа хэрхэн сонгох вэ гэсэн эгзэгтэй цаг мөчид тулж ирсэн манай орны хувьд төрийн бодлого тодорхойлж буй улс төрийн зүтгэлтнүүд олон улсын харилцаанд үйлчилж байгаа, улс орнуудын түүхэнд харагдаж байдаг тэр зүй тогтол, хуулиудыг ойлгох хэрэгтэй. Ингэснээр улс хоорондын харилцааны суурь болж өгдөг учир шалтгаан, үйл явцын мөн чанарыг ойлгох боломжийг олж харна.



Улс орон бүр өөрийн ашиг сонирхолтой байдаг бөгөөд, энэ ашиг сонирхлоо хэрэгжүүлэхийг хичээх бүртээ хүч хэрэглэх боломжтой байдаг. Тухайлбал олон улсын харилцааны онолын реалист чиглэлийн том төлөөлөгч Ганс Моргантау “загалмайтнууд ариун газруудыг буруу номтнуудаас чөлөөлөх гэж, Вудро Вильсон ардчиллын төлөө дэлхий дахиныг аюулгүй болгох гэж, нацистууд Германы колоничлолын төлөө, Европ болон дэлхийд ноёрхлоо тогтоох гэж хүчирхийлэл хэрэглэсэн” тухай жишээ дурдсан байдаг.

Дэлхийн түүхийн аль ч үед ноёрхлоо тогтоохын төлөө улс орнууд сэргөлдөн тэмцэлдэж байсан. Харилцагч орнуудын ашиг сонирхлыг эхнээсээ зөв тооцоолоогүй, аль нэг талд хохиролтой шийдвэр гаргаж хэрэгжүүлэх нь ийм сэргөлдөөний үр хөврөлийг ямагт агуулсаар байх болно. Өнөөдөр өндөр хөгжилд хүрсэн, байгалийн баялаг бүхий орнуудыг аль аль талын ашиг сонирхлыг зөв хослуулсан бодлого явуулж чадсан гэж үзэж болно.

“Хэн ч өөрийн зүрх сэтгэлд үнэ цэнэтэй зүйлээр наймаалцдаггүй”⁵² гэж нэгэнтээ Английн нэрт улс төрч, улс төрийн философич Эдмунд Берк бичиж байв. Өөрсдийн ард

⁵² Burke Ed. “Speech on the Conciliation with America”. Loc.cit., Vol.II.p.169

түмний баялаг хэмээн нандигнаж, өвөг дээдсээсээ үлдээсэн газар шороо хэмээн хайрлаж явдаг хэмжээлшгүй их баялагаа “буруу бодлогоор явж байгаа, бидний зүйлийг хулгайлж байгаа” гэж үзэж буй ард түмэнд эсэргүүцэн тэмцэх зүрх сэтгэл хэзээд бэлэн байх нь дамжиггүй. Энэ энгийн сэтгэл зүйн ач холбогдлыг эдийн засгийн амьдрал руу буулгаж Адам Смит “ухаалаг арилжаагаар наймаачин, худалдан авагчын аль аль нь хожихоос бус, нэг нь нөгөөгөө хохироох ёсгүй” гэж тэмдэглэсэн байдаг.

Ашигт малтмалын талаар төрөөс зөв бодлого явуулж хөгжилд хүрсэн орнуудын баялагын талаар авч хэрэгжүүлсэн бодлого нь хамгийн энгийн нэгэнд ч ойлгомжтой ерөнхий дүрмийг баримтласан байх бөгөөд энэ нь ямар ч “40000 хувьсагчгүй”, харин иргэн бүр ойлгож болохоор, хүн бүр хүлээн зөвшөөрч болмоор, жирийн айл гэрийн ухаалаг хэрэгцээтэй жишиж болмоор, Адам Смитийн хэлсэн “Айл бүрийн хувьд ухаалаг, зөв алхам нь эзэнт гүрний хувьд тэнэг хэрэг байх нь бараг үгүй” гэсэн зарчимтай нийцэхээр байгааг дээрхи хэдэн улсын баримтаас харж болохоор байгаа билээ. Харин манай улс стратегийн ач холбогдолтой том орд болох Оюу толгой дээр хийсэн гэрээг бараг айл бүрт хамгийн хүлээн зөвшөөрч боломгүй гэрээ гэж үзсэн байдаг бөгөөд энэ гэрээний талаар хийсэн халз мэтгэлцээний талаар 8666 хүнээс санал асуулга явуулахад С.Баярцогтыг 18.57% буюу 1609 хүн, харин С.Ганбаатарыг 81.43% буюу 7057 хүн дэмжиж санал өгсөн байдаг билээ. Өөрөөр хэлбэл энэ гэрээний талаар төрөөс баримталсан бодлогыг 81.43% нь эсэргүүцэж байгаа юм. Энэ гэрээ дээр дурдсан улсуудын жагсаалтын аль талд нь манай улсыг чирч оруулж байна вэ... Баялагын хараалд нэрвэгдэн, зовлон зүдгүүр амсч буй тэр цөөхөн оронтой илүү адил харагдуулж байх шиг.

“Хувиа хичээсэн байдал, бусдын бодит айдас болон итгэл найдварыг анхаарч үзэх ямар ч хүсэлгүй байх явдал нь үндэстний хувьд юунаас ч илүү хөнөөлтэй юм”. “Хүн төрөлхтөний өөрсдөө үйлдвэрлэж чадах зүйлээ хийхийг, эсвэл өөрсдийн хөрөнгө, үйлдвэрлэлийг өөрсдөдөө хамгийн ашигтай гэж үзэж буй байдлаар ашиглахыг хориглох нь хүн төрөлхтөний хамгийн ариун нандин эрхийг илэрхий зөрчсөн хэрэг мөн” гэсэн Ганс Моргентаугийн үгээр энэхүү ажлаа төгсгөхийг хүсч байна. Монголчууд бид өөрсдийн баялагаа хамгийн ашигтай гэж үзсэн, хоёр тал хоёулаа хүлээн зөвшөөрч болохуйц нөхцлөөр арилжих хүсэлтэй байна. Энэ хүсэл зоригийг үл ойшоон, боомилж байгаа нь бидний хамгийн ариун нандин эрхийг зөрчиж байгаа хэрэг бус уу. Үүнд хэн буруутан вэ? гэсэн асуулт гарч ирж л таарна. Оросын түүхэнд Распутин, Германы түүхэнд Гитлер зэрэг ард түмэн бүхэлдээ үзэн ядмаар улс төрчид хүн төрөлхтний түүхэнд цөөн боловч гарч л байсан. Түүн шиг Монгол Улсын ард иргэдийн баялагыг үрэн таран хийсэн хариуцлагыг хүлээх эзний нэрийг тодорхой хэлэх цаг яг одоо биш ч гэсэн хэсэг цаг хугацааны дараа ил болох нь гарцаагүй.

Ном зүй

Думаагийн Содном, “Амьдрал бодол” УБ.2003 он

Burke Ed, “Speech on the Conciliation with America”. Loc.cit., Vol.II.p.169

Адам Смит, “Үндэстний баялаг” УБ

Марк Скаузен, “Эдийн засгийн ухаан эдүгээчилэгдсэн замнал” УБ. 2003

Милтон Фрийдман & Роуз Фрийдман, “Хувь заяагаа сонгох нь” УБ. 2001

УТШУ Дээж бичиг-XX зуун, УБ. 2001

Эрнандо Д.Сото, “Капиталийн нууц: Өрнөдийн ялгуусан капитализм өөр газар өөдөлдөггүйн

учир” УБ. 2004

Людвиг фон Мизес, “Либерализм” УБ. 2004

ОРЧИН ҮЕИЙН УЛС ТӨРИЙН НАМЫН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА: ПАРТИЗАНЫ УЛС ТӨРӨӨС АЛЬТЕРНАТИВ КОММУНИКАЦИ ТИЙШ⁵³

Ж.ТӨРТОГТОХ

Доктор, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн профессор

Keywords: *partisan politics, non-partisan politics, alternative communication*

ABSTRACT: *In this article, contemporary political party development tendencies are reviewed. First of all, nowadays research methodologies on political party are considered. Then the paper divided by the parts as partisan politics, non-partisan politics, institutional development of political party, a basis of mature democracy, party as an alternative institutional form of political communication as well as a bridge between public and government. As concluding remarks, further research discussions are put in frame of how to institutionalize political parties.*

Удиртгал

Улс төрийн намын хөгжлийн хандлагыг тоймлон нэгтгэн авч үзсэн тус өгүүлэл нь юуны өмнө, улс төрийн намын судалгаанд хандаж буй орчин үеийн судалгааны арга зүй, хандлагыг тодотгон, улмаар судалгаагаар дэвшүүлсэн асуудлуудыг авч үзсэн. Улмаар тэдгээр асуудлыг тус бүрд нь партизаны улс төр, партизаны улс төрийн түүхэн зайлшгүй, партизаны бус улс төр, намын институцсэн хөгжил, хашир ардчиллын үндэс: нам - коммуникацийн альтернатив институцсэн хэлбэр, төр, ард түмнийг холбогч болох нь гэсэн хэсгүүдэд авч үзсэн.

Улс төрийн намд, гадаад болон дотоод институцийн үүднээс, түүнчлэн улс төрийн намыг улс төрийн болон иргэний нийгмийн бусад институцтэй холбон авч үздэг, эсхүл тэдгээр институцтэй холбоо бүхий процесст нь авч үздэг нийтлэг буюу уламжлалт шинжтэй судалгааны арга барил ба үр дүн, ололтын тогтсон хэв маягаас ялгагдах энэхүү товч өгүүллийн онцлог нь зөвхөн тэдгээр судалгааны арга зүйн хандлагатай уялдахаар хязгаарлагдахгүй болно. Энэ нь өгүүллийн удаахь хэсэгт судалгааны асуулт болгон тавьж буй улс төрийн намыг үүсэл хөгжлийн түүхэн нөхцөл байдлын ялгаатай түвшинд харьцуулан авч үзэх талаар дэвшүүлсэн санаагаар илэрхийлэгдэнэ.

Өгүүллийн гутгаар хэсэгт авч үзсэн намын институтжилтийн асуудал нь намыг зохион байгуулалтын түвшинд өмнө ба эдүгээ (үнэн хэрэгтээ аль аль нь уламжлалт буюу хуучин гэж болох юм) үед ангилж, хэв маягчилж ирсэн судалгааны арга зүйд үл ялиг шүүмжлэлтэй хандсаныг зэрэгцээ, намын институтжилт нь зөвхөн зохион байгуулалт, эсхүл гишүүнчлэлийн аливаа процессоор хязгаарлагдахгүй болохыг илэрхийлэхийг оролдсон.

Өгүүллийн дараах хэсгээр намын хөгжлийн хандлагыг хашир ардчиллын хүлээлт ба түүний талаарх судалгааны шаардлагад нийцүүлэх үүднээс улс төрийн коммуникацийн альтернатив хэлбэр нь намын институтжилтийн орчин үеийн дүр төрх болж буйг намын үүсэл хөгжлийн ялгаатай байдлын философийг өнөөгийн ардчилалд улс төрийн намын зайлшгүй хүлээж буй функцийн үл ялгаатай байдалд холбож үзэхийг

⁵³ Монголын Улс Төр Судлаачдын Нэгдсэн Холбооноос 2013.12.10-нд зохион байгуулсан “Улс төрийн нам: асуудал, эрэл, шийдэл” – эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн үндсэн илтгэл

тус тус зорьсон болно. Өгүүллээр дэвшүүлж буй дээрх өөр хоорондоо учир холбоо бүхий хэсгүүдийг уншигчийн цаашдын судалгааны сонирхол, сэдлийг төрүүлэх үүднээс тоочих матрицийг тус бүрд нь харьцуулах, эргэн нэгтгэх байдлаар илэрхийлэв. Өгүүллийн төгсгөлд дүгнэлт хэсэг болгон судалгааны хэлэлцүүлгийг намыг хэрхэн институтжуулах вэ гэсэн асуудлын хүрээнд тавьсан болно.

Судалгааны арга зүй

Орчин үеийн улс төрийн намын хөгжлийн хандлагыг авч үзсэн тус өгүүллэд дараах судалгааны арга зүйг удирдлага болгов. Тэдгээр арга зүй нь улс төрийн намыг судалж буй өнөөгийн судалгааны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эх сурвалж болон судалгааны хандлагыг илэрхийлсэн болно. Үүнд:

1. Намууд ардчиллын чухал багаж болох нь. Улс төрийн намууд ардчиллыг бүтээдэг [Schattschneider E.E. 2008]. Өнөө цагт ардчилал, ардчилсан дэглэм, ардчилсан улс төрийн системийг улс төрийн намуудгүйгээр төсөөлөхөөргүй болжээ. Ардчиллыг хэрэв олон ургальч үзлийн талбар, өрсөлдөөн, сөргөлдөөн, маргаан, мэтгэлцээн, зөвшилцөл, шийдлийн талбар гэж үзэх юм бол тэдгээр процессыг институтжуулж буй хүлээн зөвшөөрөгдсөн, хамгийн нийтлэг хэлбэр нь улс төрийн нам, бүр тодруулбал намууд болж байна. Иймээс улс төрийн намыг олон тоон дээр авч үзэж буй Шатцшнайдерын санаа улс төрийн намын хөгжлийг ардчиллын хөгжлийн түвшинд холбож авч үзэх арга зүйн гол чухал чиг баримжаа болж буйг өнөөгийн улс төр судлаачид бүтээл, судалгаагаараа дэвшүүлж, басхүү нотолж байна.
2. Улс төрийн намын институтжсэн түвшин - хашир ардчиллын гол шинж чанарын нэг [Jungbok Lee 2008]. Улс төрийн намын институтжсэн түвшинг зохион байгуулалтын түвшин хэлбэр болон гишүүнчлэлийн зааг ялгаа, хэлбэрээс салган авч үзэх хандлага ердөө саяхны хэрэг биш юм. Улс төрийн намын хөгжлийн түвшинг харьцуулан үзэхэд жижиг болох арга зүйн ач холбогдол бүхий тэдгээр институциональ ба функциональ судалгаа, харьцуулалтын нийтлэг арга зүй нь дээрх холбоогоор илэрч байна. Орчин үед намыг хашир ардчиллын мөн чанартай зайлшгүй холбоотойн тухай тэдгээр судалгаа ба дэвшүүлдэг аргументын нийтлэг тал энэхүү өгүүллийн чухал арга зүйн нэг болов.
3. Партизангүй улс төрийн нам – хашир ардчиллын өөрчлөлтүүд [Russell J. Dalton & Martin P. Wattenberg 2002]. Партизаны улс төр бол улс төрийн намын түүхэн хөгжлийн онцлогийг танин мэдэх гол чухал хандлагын нэг юм. Улс төрийн намыг партизанаас буюу улс төрийн нам оршин буй систем, дэглэмд альтернатив нь эсхүл сөргөлдөгч нь болж гарч ирсэн түүхэн нөхцлийн онцлогийг ялган салгаж танин мэдэх нь хашир ардчилалд гарч буй өөрчлөлтүүд, тухайлбал ардчилал улам бүр туршлагажиж, батжиж, бэхжихэд тулгардаг, тулгарч болох саад бэрхшээлүүдийг улс төрийн намын түүхэн үүслийн нөхцөл байдалтай холбож ба салгаж судлан үзэхэд тус санаа оршдог ажээ.
4. Улс төрийн нам – төр, иргэдийг холбох гүүр [Robert L. Cord & Michael G. Roskin 2008]. Энэхүү судалгааны хамгийн чухал санаа нь улс төрийн намыг төр ба иргэнийг холбох харилцааны гүүр болохыг авч үзсэн санааг арга зүй болгосонтой холбогдоно. Түүхэнд улс төрийн нам анх үүсэж гарсан, бэхжсэн нөхцөл партизаны улс төр, эсхүл улс төрийн нам үүсгэн байгуулагчдаас шууд хамааралтай байсан нь намыг ойлгох танин мэдэх олон нийт, улс төрчдийн ойлголт, мэдлэг, хандлагад төдийгүй ерөөс энэ талаарх судалгааны хандлагад нөлөөлж ирсэн билээ. Тэгвэл намыг төр, иргэнийг холбох гүүр буюу иргэд төртэй холбогдох сонирхлыг нэгтгэн төвлөрүүлэх ба зохион байгуулан илэрхийлж дамжуулах чөлөөт, сайн дурын суваг болох талаас судлах хандлага орчин үеийн улс төрийн намын хөгжлийг авч үзэх чухал арга зүйн нэг болжээ.

Судалгааны асуудлууд

Улс төрийн намын хөгжлийн талаарх орчин үеийн хандлагад тулгуурласан энэхүү судалгаагаар дараах үндсэн асуудлуудыг дэвшүүлсэн тавьсан болно. Үүнд:

- Партизаны улс төр ба партизаны бус ардчиллын өрсөлдөөн
- Сонирхлын агрегаци ба интеграцийн оновчтой зохион байгуулалт
- Нам - Коммуникацийн альтернатив хэлбэр болох боломж

Партизаны улс төр

Партизаны улс төрийн талаар буюу улс төрд улс төрийн намыг партизанчилж авч үзэх хандлагыг ердийн уншигчдад эсхүл улс төрийн салбарын бус мэргэжил бүхий улс төрчдөд нэг үгээр тайлбарлан ойлгуулахад маш төвөгтэй юм. Энэ нь наад зах нь эгдүүцэл эсэргүүцэл, цаад зах нь гуйвуулга, хэтрүүлэгээр илэрхийлэгдэх эрсдэлтэй. Гэвч партизан буюу partisan – улс төрийн намын гишүүн, эсхүл парламент дахь аливаа улс төрийн нам ба намын бүлэгт харьяалагдах гишүүнийг тийнхүү нэрлэдэг тийм ч түгээмэл биш боловч хүлээн зөвшөөрөгдсөн нэршил, ойлголт орчин үеийн парламентад эс, улс орнуудын парламентын түвшинд хэрэглэгдэж байгаа утга агуулгаар дамжуулан тайлбарлавал ойлгоход тийм ч төвөгтэй бус.

Үүнд, юуны өмнө партизан бол ердөө парламентад суудал бүхий намд харьяалагддаг парламентын гишүүнийг хэлж буйг дурдах нь зүйтэй.

Энэ агуулгаараа, намын гишүүн ба партизан гэсэн ойлголт нь нэг зүйлийг илэрхийлж байна гэсэн үг. Зэрэгцүүлж хэлбэл, партизан бус буюу non-partisan гэсэн үг нь бие даагч буюу independent гэсэн ойлголттой утгай агуулга ижил юм. Өөрөөр хэлбэл, бие даана гэдэг нь аливаа институтчлэгдсэн намын харьяалал, намын бүлгийн эрх ашиг, сонирхлоос тусдаа улс төр хийнэ гэсэн үг. Нам-бус байна гэсэн үг, non-partisan байна гэсэн үг.

Цаашилбал, партизаны нэршил нь тухайн нам үүсэн байгуулагдсан түүхэн шаардлага, нөхцөл байдлаасаа ямар нэг хэмжээгээр хамааралтай, үүсгэн санаачлагдаасаа оюун санааны болон эдийн засаг, үзэл суртлын талаар ямар нэг байдлаар хамааралтай тохиолдолд утга санаа нь илүү холбогдож байна.

Улс төрийн нам түүхэндээ, баруун, зүүн Европод ч, өмнөд, умард хөршид ч, Ази дахинд ч, Монголд ч бараг нийтлэг шинж чанартайгаар, зорилготойгоор, эрх ашигтайгаар үүсэж тогтсон байна. Үүнийг маш хураангуйлж хэлбэл, оршин буй дэглэм, систем, улс төр, нийгмийн байгуулалт, засаглалын хэлбэрт сэргэлдүүлэн гарч ирсэн улс төрийн зохион байгуулагдсан хэлбэр болсон байна.

Тэгвэл партизаны нам үүсэн байгуулагдсан түүхэн нөхцөл гэж чухам юуг энд дахин давтан дурдаж байна вэ? Партизаны улс төрийн буюу партизаны улс төрийн намын түүхэн зайлшгүй нвч чухам юунд оршиж байна вэ? (Угтаа бол оршин байсан бэ?)

Партизаны улс төрийн түүхэн зайлшгүй

Анти- / Про- засаглалын систем

Партизаны улс төрийн түүхэн зайлшгүй нэгэн зүйл бол энэ нь оршин буй засаглалын системийн эсрэг, зарим хязгаарлагдмал тохиолдолд түүний төлөө зорьж, тэмүүлж байгуулагддагт /байгуулагддаг байсанд/ оршино. Тийм ямар засаглалын системийн тухай энд өгүүлж байна гэхээр хаант засаглал, авторитар засаглал, товчдоо

бол нэг хүний, цөөн хүний эсхүл нөөцийн хязгаарлагдмал хуваарилалт учир зүй нь болсон засаглал, түүний системийн тухайд юм.

Анти- / Про- улс төрийн дэглэм

Партизаны улс төрийн түүхэн зайлшгүйн удаахь илэрхийлэл нь оршин буй улс төрийн дэглэм буюу төрийн засаглалыг хэрэгжүүлэх арга барил, механизмын эсрэг зорьж, тэмүүлж, мөн зарим хязгаарлагдмал тохиолдолд түүний төлөө хамгаалсан шинжтэй байгуулагддагт оршино. Өргөн хүрээгээр нь авч үзвэл энэ шинж нь засаглалын системтэй процесс болон процедурын хувьд давхцаж буй мэт ойлголт боловч, нарийн утгаараа засаглалыг системчилж болон процессчилж үзэж буй арга зүйн ялгааг давхар илэрхийлнэ.

Төрийн эргэлт / Хувьсгал

Партизаны улс төрийг илэрхийлж болох гуравдахь нөхцөл бол энэ нь төрийн эргэлт, хувьсгалт арга барилд тулгуурлан институциональ амжилтаа олсонд байдаг. Учир нь оршин буй хэм хэмжээ, тогтсон дэг ёсын хүрээнд хүлээн зөвшөөрөгдөхгүй байсан түүхэн нөхцөлд улс төрийн нам нь нууц, далд байдлаар зохион байгуулагдах, үйл ажиллагаагаа явуулах нь зүй ёсны юм. Энэ тохиолдолд дэвшүүлсэн улс төрийн зорилгод хүрэх, улмаар амжилт олох үндсэн арга нь төрийн эргэлт хийх, хувьсгалт тэмцэл явуулах, нэлээдгүй тохиолдолд зэвсэгт мөргөлдөөн дэгдээх зэрэг байсан нь учир зүйн шалтгаантай билээ.

Үндэсний хэмжээний альтернатив-төрийн институтын тогтолцоо

Сүүлийн боловч, үүгээр хязгаарлагдахгүй нэг нөхцөл нь партизаны улс төр бэхжих, өөрөөр хэлбэл үүсэн байгуулагдаж, улмаар төрийн эрх мэдэл авсан, эсхүл авах гэж буй оролдлогын хамгийн чухал тулгуур нь түүний үндэсний хэмжээнд зохион байгуулагдах зайлшгүй учир шалтгаан ба нөхцөл бололцоо, хэрэгцээ шаардлагад оршино. Улмаар энэ нь хатуу буюу албажсан гишүүнчлэл, харьяалалын тогтолцоо, мехнаизмаар нөхцөлдөхөд чиглэгдэнэ.

Партизаны бус улс төр

Өгүүлэлд авч үзэж буй асуудалд хандах арга зүйн өөр нэгэн хандлага нь партизаны улс төрийг партизаны бус улс төрөөс, улс төрийн намын үүсэн байгуулагдсан түүхэн онцлогийг орчин үеийн улс төрийн намын функцтэй харьцуулан авч үзэхэд чиглэгдэх юм. Асуудлыг өөр өнцгөөс авч үзвэл, “Партизаны улс төр” гэсэн ойлголтод эмзэг хандаж буй тохиолдолд партизаны бус байдлыг партизаны бус улс төр хэмээн тодорхойлж түүний дүр төрхийг тодорхойлж болох уу. Үүнд үндэслэлтэй хандах наад зах нь дараах гурван учир байна. Улс төрийн намын нэгэн чухал эрх ашиг хэвээр байсаар байгаа зүйлд бол нийгэмд өргөн хүрээний дэмжлэг авах явдал юм. Үүнийг дан ганц гишүүнчлэл, эсхүл сонгуульд ялах, төр засгийн эрх мэдлийг авах зэргээр хязгаарлавал өрөөсгөл. Тийм өргөн хүрээний дэмжлэгт шаардагдах чхуал нөхцөл нь нэгд, үндэсний хэмжээнд сонгогчдын саналыг зохион байгуулалттайгаар авах, дэмжлэгийг улам өсөн нэмэгдэх хандлагаар тогтмол барьж байх явдал юм. Хоёрт, энэ нь хандив цуглуулах, улмаар намын санхүүжилтийг тогтмол, найдвартай, хууль ёсны эх үүсвэрээр хангах нэг хэлбэр болох учиртай байна. Гурав дахь учир нь,

чухамдаа, орчин үеийн нам “партизаны бус” болох чухаг зүйл нь, сонирхлыг агрегацлах ба интеграцчлахад оршино.

Намын институтжсэн хөгжил

Намын институтжсэн хөгжлийн асуудал орчин үеийн улс төрийн намын судалгаанд хэрхэн холбогдож байна вэ? Намын институтжилтийг гишүүнчлэлийн хэлбэрээр хязгаарлан ойлгох, санхүү ба нийгмийн бааз суурийн баталгаатай байдлаар хязгаарлан ойлгохоос тус тус зааглаж авч үзэхэд арга зүйн ач холбогдолтой юм. Үүнийг өрнөдийн улс төрийн шинжлэх ухаанд high degree of institutionalization буюу институтжилтийн дээд түвшин хэмээн үзэж тухайлбал, Америкийн хоёр намын 200 орчим жилийн, Баруун Европын улс төрийн намуудын 50-100 жилийн түүхэн хөгжилд тулгарч байсан даваа бэрхшээлүүд болон түүнийг гэтлэн давсан буюу намын чийрэгжсэн, хатуужсан байдлыг ойлгож байна. Сонгуулиас сонгуульд /дэглэмээс дэглэмд, зарим тохиолдолд/ туршлагажиж, бидний хэвшсэнээр төлөвшиж ирсэн байдал бол чухамдаа гишүүнчлэл ба бааз сууринаас ялгагдах институтжилтийн түвшний гол үзүүлэлт юм. Эсрэг тохиолдолд үүнийг “нялцгай намууд”- fluid parties хэмээж буй нэр томъёоноос гадарлаж болно.

Хашир ардчиллын үндэс: Нам - коммуникацийн альтернатив институтжсэн хэлбэр, төр, ард түмнийг холбогч болох нь

Хашир ардчиллын тулгуур үндэс болох урьдаас мэдэхүйц улс төр, хараат бус /улс төрөөс болон бизнесээс/ хэвлэл мэдээлэл, нутгархах үзлээс /regionalism/ ангижрах, тогтвортой эдийн засгийн хөгжилийн зэрэгцээ улс төрийн намын институтжсэн хөгжлийн түвшинг холбон авч үздэг нь дээрх үндэслэлтэй байна.

Намууд төрийн эрх барих альтернатив институтууд уу? Иргэд төрийн эрх барих сонирхлын институтжсэн коммуникацийн нэг нь нам уу?

Төрийн үйл хэрэгт оролцох, өргөн утгаараа улс төрд оролцох, цаашилбал улс төрийн шийдвэр гаргахад оролцох төртэй харилцан холбогдох дундын коммуникацийн нийгэмд ба хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн, түүнчлэн оновчтой хэлбэрүүдийн нэг нь улс төрийн нам болон хөгжих өнөө цагийн бодит нөхцөл байна. Үүнийг коммуникацийн альтернатив хэлбэр хэмээн илэрхийлж байна. Арга зүйн хувьд цаашид хэлэлцэгдэх, шүүн тунгаагдах нь зайлшгүй энэ илэрхийллийг орчин үеийн улс төрийн намын хөгжлийг авч үзэж буй өгүүллийн эхэнд дурдагдсан арга зүйтэй холбон авч үзсэн болно.

Иргэдийн ашиг сонирхол, хэрэгцээг төр засагт уламжлах институтжсэн зохион байгуулалт бол орчин намын үндсэн мөн чанарын гол илэрхийлэл болж байна. Намд болон намын үүсэл ба зохион байгуулалтанд хандах, улмаар түүнийг судлах арга зүй нь намыг холбогч-link, network гэдэг үүднээс харахад оршино. Ингэснээр иргэд улс төрийн шийдвэрт нөлөөлөхөд үйлчлэх намын чиг үүрэг тодорхой болох юм.

ДҮГНЭЛТ - Судалгааны хэлэлцүүлэг: Намыг хэрхэн институтжүүлэх вэ?

Улс төрийн намын олигархчлал, түүнчлэн улам бүр хүнийсгэгдэж байгаа иргэд ба улс төрийн институтын харилцаа зэрэг нь улс төрийн хөгжлийн хувьд ээдрээтэй үзэгдэл болохын зэрэгцээ улс төрийг буюу улс төрийн бодлогыг судалгаа шинжилгээний үндсэн объектоо болгон авч үздэг улс төрийн шинжлэх ухааны хувьд судалгааны шинэ эрэл хайгуул болон орон зай, мэдээллийн уламжлалт бус эх үүсвэр болон судалгааны аналитик бус арга зэргийг зайлшгүй нөхцөлдүүлж байна.

Намыг институтжүүлэхэд даван туулах хэд хэдэн сорилт аль ч нийгмийн улс төрд байсан, одоо ч байна. Тэдгээр нь:

- Партизаны улс төр намаас дайжихад хүргэж байгаа эсэх. Тийм бол үүнийг шийдвэрлэх арга замыг олох.
- Төрийн алба ба намын гишүүнчлэлийн харьяалалыг хэрхэн салгаж ойлгох ба зохион байгуулж, уялдуулах.
- Парламентын суудал ба намын харьяалалын асуудлын учир зүйг олох. Улс төрийн намын талаарх судалгаанд түлхүү авч үзэж буй асуудлын нэг нь улс төрийн намын өөрийн удирдлагын хоёрдмол орчинг улс төрийн олон намын чөлөөт өрсөлдөөн бүхий сонгуулийн дүнд бүрэлдэхүүн нь бүрддэг төрийн засаглалын институтын бие даасан байдал ба улс төрийн систем дэх легитим чанар ба олон нийтийн итгэл даах байдал зэрэгтэй холбон авч үзэх явдал болж байна.

Ашигласан эх сурвалж, бүтээл

Gettell, Raymond Garfield (1922), *Introduction to Political Science*, revised edition, Boston: Ginn and Company

Gunther, Richard and Diamond, Larry (2003), 'Species of Political Parties: A New Typology', *Party Politics*, 9, 167-99

Lee, Jung-bock (2008) Korea on Path to Mature Liberal Democracy, in The Korea Herald and The Korean Political Science Association (eds) *Political Change in Korea*, Korea: Jimoondang, 331-340

Luther, Kurt, eds. (2005). *Political Parties in the New Europe: Political and Analytical Challenges*, NY: Oxford University Press

Malbin, Michael J. (2003), *Life after Reform: When the Bipartisan Campaign Reform Act Meets Politics*, Lanham

Randall, Vicky (2005) Case Study One: Political Parties, Their Social Ties and Role in Political Change, in Burnell & Randall (eds) *Politics in Developing World*, Oxford University Press

Roskin, Michael G., Robert L. Cord, James A. Medeiros, Walter S. Jones (2008), *Political Science: An Introduction*, Tenth Edition, Pearson Prentice Hall

Russell J. Dalton & Martin P. Wattenberg eds. (2002), *Parties without Partisans: Political Change in Advanced Industrial Democracies (Comparative Politics)*, Oxford University Press, USA

Schattschneider, Elmer Eric (2008), *The Struggle for Party Government*. Program in American Civilization, University of Maryland.

Schattschneider, Elmer Eric (2009), *Party Government: American Government in Action*, Transaction Publishers. New Brunswick (U.S.A.) and London (U.K.)

Shively, W. Phillips (2007), *Power & Choice: An Introduction to Political Science*, Tenth Edition, NY: McGraw-Hill

Stokes, Susan C. (1999), "Political Parties and Democracy," *Annual Review of Political Science* 2: 243-267

УЛС ТӨРИЙН НАМУУДЫН НИЙГЭМ – УЛС ТӨРИЙН ХАРИЛЦААН ДАХЬ ҮҮРЭГ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

С.ЗҮЛЬФИКАР

УА-ийн Улс төр судлал, нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор

Түлхүүр үг: улс төрийн нам, нийгэм-улс төрийн харилцаа, улс төрийн намын үүрэг

ABSTRACT: Although political parties are defined by a central function (the filling of political office and wielding of government power), their impact on the political system is substantially broader and more complex. A number of general functions of parties can nevertheless be defined. The main functions are as follows: organizational right for declaring and implementing social and political right, representation; power holding, interest articulation, elite formulation. These functions are clearly defined relevant law and legal documents as in both national legal system and party legal relations.

Parties draw together people who have similar political and social philosophies and ideas. Representation is often seen as the primary functions of parties. It refers to the capacity of parties to respond and articulate the views of both members and the voters. Parties of all kinds are responsible for providing states with their political leaders. In most cases, parties therefore provide a training ground for politicians, and equipping them with skills, knowledge and experience, and offering them some form of career structure. In the process of developing collective goals, parties also help to articulate and aggregate the various interests found in society. The fact that national parties invariably articulate the demands of a multitude of groups forces them to aggregate these interests by drawing them together into a coherent whole, balancing competing interests against each other. Final goal for political parties is defined by competing for the government or state power. Parties are the chief means by which political power is exercised in Mongolia. Parties help with formation of governments, in parliamentary systems to the extent that is possible to talk of “party government”.

Улс төрийн тогтолцооны салшгүй хийгээд дийлэнх тохиолдод улс төрийн үйл явцын цөм нь болж байдаг институт(улс төрийн байгууллага)-ууд бий. Үүний нэг нь улс төрийн нам юм. Улс төрийн намын түүхэн хөгжил нь түүний нийгэмд гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны үр дүнтэй шууд холбогддог. Нийгмийн харилцаанд тодорхой үүрэг гүйцэтгэж чадахгүй байгаа институтийг нэг бол өөрчлөгдөх эс бөгөөс нийгмийн харилцаанаас арчигдах хувь тавилан хүлээж байдаг. Улс төрийн нам нь улс төрийн харилцааны салашгүй хэсэг болоод даруй 300 гаран жил болж байгаа хэдий ч лав ойрын жилүүдэд улс төрийн тогтолцоо, үйл явцын бүрэлдэхүүн хэсэг болсоор байхаар байна. Энэ нь улс төрийн нам нийгэм-улс төрийн харилцаанд тодорхой (зарим тохиолдолд

тэргүүлэх) үүрэгтэй байгаатай холбоотой болов уу. Иймд улс төрийн намууднийгэм-улс төрийн харилцаанд ямар үүрэг хүлээж, хэрэгжүүлж байгааг хэлэлцэх шаардлага тавигдаж байна.Тусгүүлээр дамжуулан улс төрийн намын үүргийг улс төр судлалын онол, арга зүйн хандлага, ангилалын хүрээнд шинжлэн, тэдгээр үүргийг эрх зүйн харилцаагаар хэрхэн зохицуулж байгааг хэлэлцэхийг зорилоо.

Нам “party” нь латин гаралтай (pars) үг бөгөөд хуваагдах, салах гэсэн утгатай. Тухайн үед ижил утга бүхий сект “sect” (латины secare - таслах, цавчих, хайчлах, хуваах “to sever, to cut, to divide”) гэсэн үг мөн дээрх утгаар хэрэглэгдэж байжээ. XVI зуунаас улс төрийн эсрэг үзэл санаатай хүчин бий болж, хэлбэрших үед буюу нэг хүний гарт засаглал төвлөрч түүний эсрэг эрх мэдэл бүхий бүлгүүд нэгдэн гарч ирсэнээр тэдгээр бүлгүүдийг тусгайлан нэрлэхийн тулд “party” гэдэг үг улс төрийн хэрэглээнд нэвтэрсэн. Нам судлаач Ж.Сартори улс төрийн намыг “Улс төрийн үзэл санаа, үзэл баримтлал, сонирхлоороо нэгдсэн хүмүүсийн бүлэг”⁵⁴ гэж тодорхойлсон байна. Үүний зэрэгцээ нам гэсэн ойлголттой ойролцоо утгаар фракц “faction” гэсэн үг хэрэглэгдэж байжээ.Гагцхүү нам “party” болонфракци “faction” гэсэн үг яг ижилутгайлэрхийлдэггүй. Фракцньулстөрийнсэтгэлгээнийтүүхэндудаанхэрэглэгдэжирсэннэртомьёобөгөөдлатины “facere (to do, to act- хийх, үйлдэх)” гэсэнүгнээсгаралтайюм. Хожим энэ үг латин хэлнээ “factio” хэмээн бичигдэх болж улстөрийн бүлгийн эмх журамгүй байдал, зохион байгуулалтыг сулруулах үйлдэл, нийгмийг хагаралд хүргэх гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ.Энэ үгний ерөнхий утга нь латин хэлээр бие даасан байх, сэхүүн зан, харгис, хэрцгий гэсэн утгы гилэрхийлдэг байна.

Хуульч Б.Чимид улс төрийн намыг дараах байдлаар энгийнээр тодорхойлсон байна. “Аливаа нам нь засаг төрийн эрх мэдлийн төлөөчдвал олонх, ядвал цөөнх, гацвал ганц суудалтай болохын төлөө ажилладаг”. Төр барихад оролцох юм уу, эсвэл түүнд шууд хяналт тавьж нөлөөлөх хувь зохиолтой учраас түүнийг улс төрийн байгууллага гэнэ. Нам бол нийгмийн удирдлагын буюу нийтийн эрх зүйн субъект биш. Эрх зүйн үүднээс бол иргэний нийгмийн нэгээхэн хэсэг, хүн амын тодорхой хэсгийн ашиг сонирхлыг илэрхийлсэн байгууллага юм.⁵⁵

Дээрх тодорхойлолт улс төрийн нам бол өнөө цагт нийгэм-улс төрийн харилцаанд түлхүүр үүрэгтэй болохыг илэрхийлж байна. Харин хэд хэчнээн, ямар үүрэг гүйцэтгэж байгаа нь сонирхол татах нь дамжиггүй. Үүрэг гэсэн ойлголтын хүрээнд тухайн субъект эсвэл этгээд дааж авсан, заавал хэрэгжүүлэх ёстой үйл ажиллагаа, ажил төрлийг тодорхойлж илэрхийлсэн байдаг. Тэгвэл нийгэм-улс төрийн амьдралд улс төрийн нам өөрт олгосон эрхийн хүрээнд хэрэгжүүлэх ёстой буюу дааж авсан, эсхүл тодорхой нөхцөл байдал бүрдсэн үед хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааг улс төрийн намын нийгэм-улс төрийн харилцаан дахь үүрэг гэж ойлгож болохоор байна. Улс төрий нам нь нийгэм- улс төрийн харилцаанд буюу бүхэлдээ улс орны амьдралд тав эсхүл дөрвөн үндсэн үүрэгтэй болохыг барууны улс төр судлаачид тэмдэглэжээ. Зарим тохиолдолд зургаа, долоон үүргийн талаар ч хэлэлцсэн байна. Нөгөө талаар улс төрийн намын үүргийг тодорхой тоондхязгаарлах боломжгүй гэж үзэх хэсэгч бий. Харин улс төрийннамын үүргийг улс төр судлалын тодорхой судлагдахуун болгон авч үзэннийгмийн бүхий л хүрээн дэх оролцоо, түүнээс үүдэлтэй үүргийг дараах байдлаар бүлэглэн тодорхойлж болохоор байна. Үүнд:

- Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн баталгаа, зохион байгуулалтын хэлбэр болно;
- Төлөөлөх – нийгмийн тодорхой хэсгийн ашиг сонирхол, хүсэл эрмэлзэлийг төлөөлнө;

⁵⁴Sartori G. Parties and Party System. London. 1976. p.23

⁵⁵Чимид Б. Өнөөгийнулстөрхуулчийннүдээр. УБ., 2006 97 дахьтал

- Засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх улс төрийн өрсөлдөөнд идэвхтэй оролцогч байна;
- Нийгмийн олон талт ашиг сонирхлыг нэгтгэн, төрийн бодлого болгоно;
- Улс төрийн манлайлагчид, элит хэсгийг сонгох, бэлтгэх, байршуулахээр болно.

Анхны ардчилсан сонгуулийн дараа 1992 оны 1 дүгээр сард Монгол улсын шинэ Үндсэн Хуулийг баталж түүнд “Монгол улсын иргэд нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, эвлэлдэн нэгдэх эрхтэй”-г бататгаж намуудаас засаг төрийн сонгууль, үйл ажиллагаанд оролцох эрх зүйн үндсийг тогтоосон байдаг. Түүнээс хойш улс төрийн намууд шинээр үүсэх, өөрчлөн байгуулагдах (нийлэх, нэгдэх, тусгаарлах, салах), сонгуульд дангаар болон эвсэн оролцох зэргээр улс төрийн амьдралын мөнхийн хөдөлгөөнд байсаар иржээ.⁵⁶ Тухайлбал, 2006 онд Улсын Дээд Шүүхэд бүтгэлтэй 27 улс төрийн нам байсан бөгөөд Улсын Дээд Шүүхэд шинэчлэн бүртгүүлээгүй 7 намыг татан буугдсанд тооцсон байна. Одоогийн байдлаар Монгол улсад дээд шүүхэд бүртгэлтэй 22⁵⁷ улс төрийн нам байна. 2012 оны 10 сарын 23-ны өдөр 22 дахь улс төрийн нам (Монголын Консерватив Нам)-ыг Улсын Дээд Шүүх бүртгэжээ. Монголын улс төрийн намууд нийгэм-улс төрийн амьдралд ямар үүрэг гүйцэтгэж байгааг дээрх таван ангилалын хүрээнд төсөөлж эсхүл тайлбарлаж болох хэдий ч улс төрийн намуудын эрх үүргийг тодорхойлсон эрх зүйн баримт бичиг, түүнтэй уялдсан харилцааг тулгуур болгон дүн шинжилгээ хийх нь илүү зохимжтой гэж судлаачын зүгээс үзэж байгаа болно.

Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх нь ардчилсан төр-улс, үндсэн хуульт бүгд найрамдах улсын зайлшгүй шинж чанар болдог. Улс төрийн намуудыг зохион байгуулалтын бүлэг, үзэл санааны бүлэг, нийгмийн бүлэг гэж үздэг билээ. Нөгөө талаар улс төрийн зорилго, түүнийг хэрэгжүүлэх тодорхой чиг үүрэг бүхий бүлэг ч гэж үзэх нь бий.⁵⁸ Өөрөөр хэлбэл нийгмийн харилцаан дахь олон урьгалч үзлийг тодорхой үзэл санааны хүрээнд нэгтгэх зохион байгуулалт нь улс төрийн намаар дамжин бодит биелэл болж байдаг. Үүний тулд иргэд эвлэлдэн нэгдэж, тодорхой улс төрийн үзэл санаа, үзэл баримтлалыг суурь болгосон улс төрийн нам байгуулдаг байна. XX зууны 90-ээд оны эхэнд пост-коммунист орнуудад өрнөсөн улс төрийн үйл явцын нэгэн адил Монгол улсад олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрснөөр барууны болон зүүний чиг баримжаатай улс төрийн хүчнүүд шинээр бий болсон. Ийм ч учраас иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, улс төрийн олон ургальч үзлийн үндсийг тавьж, нийгмийн харилцаанд төлөвшүүлэхэд улс төрийн намуудын үүрэг зайлшгүй байсан гэдэгтэй санал нэгдэж байна.

Иргэдийн эвлэлдэн нэгдэх зохион байгуулалтын нэг хэлбэр нь улс төрийн нам мөн гэдгийг Монгол улсын Үндсэн Хуулийн хүний эрх, эрх чөлөөг тунхагласан 12 дугаар бүлгийн 13.10 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. “Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.”⁵⁹ Улс төрийн намын тухай хуульд улс төрийн намын тухай ойлголтыг тодорхойлохдоо түүний нийгмийн гишүүдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангах үүргийг тодорхой зааж өгчээ. Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх зүйлд “Нам нь Монгол улсын Үндсэн Хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол улсын иргэдийн нэгдэл мөн.” гэсэн байна. Монгол улсын Үндсэн Хууль, Улс төрийн намын тухай хуульд улс төрийн намыг тодорхойлсон байдал нь улс төрийн нам бол тодорхой үзэл бодол, ашиг

⁵⁶Чимид Б. Өнөөгийн улс төр хуулчийн нүдээр. УБ., 2006 41 дэх тал

⁵⁷Улсын Дээд Шүүхийн цахим хуудас (www.supremecourt.mn)-д тавигдсан албан ёсны мэдээллийг эш үндэс болгов.

⁵⁸ Giovanni Sartori. Party Types, Organization and Functions. West European Politics Journal, September. 2010. p.5

⁵⁹Монгол улсын Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 13.10 дугаар зүйл

сонирхлын хүрээнд иргэдийн сайн дураараа эвлэлдэн нэгдсэн улс төрийн зохион байгуулалт болохыг бүрэн илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэх улс төрийн зорилго бүхий зохион байгуулалт гэж ойлгогдож байгаа юм.

Иргэд улс төрийн намын зохион байгуулалтаар эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэхдээ ардчилсан төр-улсын үнэт зүйлийг хүндэтгэх, Үндсэн Хуулийн зарчмыг баримтлал болгохыг мөн адил хуульчилсан. Энэ нь улс төрийн нам иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хангахдаа хувь хүн, төр, нийгмийн ямар үнэт зүйлийг хүлээн зөвшөөрч, ямар үнэт зүйлийг зөрчихгүй байхыг хуульчилсан зохицуулалт болжээ. Үндсэн хуульд “Нам, олон нийтийн бусад бүх байгууллага төр, нийгмийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ.”⁶⁰ гэсэн бол Улс төрийн намын тухай хуульд “Монгол улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн Хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмнийг үймүүлэх, айлган сүрдүүлэх, аллага, хядлага үйлдэх, яс үндэс, арьсны өнгөөр ялгаврлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулах зорилгоор, түүнчлэн шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист нам байгуулахыг хориглоно” гэж маш тодорхой зааж өгчээ. Монгол улс ардчилсан дэглэмтэй, хүний эрх, эрх чөлөөг бүхий л талаар дээдлэсэн улс болохын хувьд улс төрийн нам байгуулах замаар иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хуульчилсан бөгөөд нөгөө талаар улс орны бүрэн эрхт байдал, иргэдийн эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй аливаа үзэл санаа, зорилго бүхий улс төрийн зохион байгуулалт, эвлэлдэн нэгдэх үйл ажиллагаа, оролдлогыг хориглосон байна.

Төлөөллийн үүрэг - ардчиллыг өргөжүүлэх, төрийн үйл ажиллагаанд иргэд, сонгогчдын төлөөллийг хангах үүргийг улс төрийн тодорхой зохион байгуулалтаар дамжуулан хэрэгжүүлэхийг улс төрийн практик нэгэнтээ хүлээн зөвшөөрсөн байдаг. Иргэд тодорхой төлөөллийн байгууллага, этгээдээр дамжуулан улс төр, төрийн захиргааны түвшинд бодлого тодорхойлж, шийдвэр гаргах үйл явцад оролцох хэлбэрийг шууд бус ардчилал⁶¹ гэж нэрийдэх нь бий. Иргэд тэдний нэрийн өмнөөс бодлого тодорхойлж, шийдвэр гаргах этгээдийг сонгож, түүгээр дамжуулан өөрсдийн ашиг сонирхлыг хамгаалах, асуудлаа шийдвэрлүүлэх боломжтой байдаг. Иргэд сонгууль өгсөний дараа хууль тогтоох, шийдвэр гаргах улс төрийн институтын үйл ажиллагаанд шууд оролцох боломжгүй. Орчин үед үндэсний түвшинд улс төрийн үйл явцад иргэдийг татан орлцуулж байгаа зохион байгуулалт нь шууд бус буюу төлөөллийн ардчиллын хэлбэр юм. Учир нь үндэсний түвшинд бодлого тодорхойлж, шийдвэр гаргахад иргэдийг шууд оролцуулах цаг хугацаа, орон зай, зохион байгуулалтын боломж хязгаарлагдмал байдаг нь шууд бус ардчиллыг өргөжүүлсэн. Нөгөө талаар улс төрийн бодлого, шийдвэрийг мэргэшсэн, чадварлаг, тогтвортой хэрэгжүүлэхийн тулд мэргэшсэн улс төрийн институтууд бий болсон байна. Тухайлбал, парламент, засгийн газар, орон нутгийн засаг захиргаа нь бодлого тодорхойлж, шийдвэр гаргах улс төрийн мэргэшсэн, тодорхой эрх, чиг үүрэг бүхий институтууд юм.

Төлөөллийн ардчиллын бодит илрэл нь хууль тогтоох, улмаар гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх институт, субъектийг сонгох, томилох явдал юм. Монгол улсад хууль тогтоох байгууллага нь төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлэх улс төрийн институт болох бөгөөд түүний гишүүдийг сонгох сонгуулийн үйл ажиллагаанд улс төрийн намууд голлох үүрэгтэй оролцдог. Үүнээс үзвэл улс төрийн нам нь иргэдийн хүсэл сонирхлыг улс төрийн үйл явцад төлөөлөх үүрэг хүлээсэн улс төрийн байгууллага

⁶⁰ Монгол улсын Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 13.10 дугаар зүйл

⁶¹ Зүлфикар С нар. Монгол улсын улс төр, эдийн засаг, нийгэм (гарын авлага). Фредрих Эбертийн Сан. УБ., 2013. 45 дахь тал

буюу зохион байгуулалт болж байна. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд “Энэ хуулийн 27.1⁶² дэх зүйлд заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.1.6 дахь зүйлд заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл /цаашид нам, эвсэл гэх/-ийн жагсаалтаас тус тус сонгоно” гэжээ. Өөрөөр хэлбэл УИХ буюу хууль тогтоох, төлөөллийн эрх үүрэг бүхий улс төрийн институтыг бүрдүүлэх сонгуульд улс төрийн нам тэдгээрийн бүрдүүлсэн эвслийн үүрэг зайлшгүй болохыг хуульчилжээ. Тус хуулийн 27.4 дэх зүйлд “Намаас нэр дэвшүүлэх тухай асуудлыг Улс төрийн намын тухай хуулийн 13.7⁶³ дахь зүйлд заасны дагуу тухайн намын Их Хурал, эсхүл төлөөллийн төв байгууллагын хуралдаанаар хэлэлцэж, нууцаар санал хурааж, ардчилсан зарчмыг баримтлан олонхийн саналаар шийдвэрлэнэ” гэжээ.

Улс төрийн нам төлөөллийн үүргээ үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх бөгөөд үүнд чиглэгдсэн эрх үүрэг, зохион байгуулалтыг шат шатны төлөөллийн байгууллагын сонгуулийн тухай хуулиар зохицуулсан байна. Монгол улсад засаг захиргааны нэгжийн бие даасан байдлыг хангаж, тухайн орон нутгийн иргэд өөрт хамаатай асуудлаар бодлого тодорхойлж, шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх боломжийг нутгийн өөрөө удирдах байгууллага (нийсэл, аймаг, дүүрэг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал)-д олгосон байдаг. Орон нутгийн Хурлын Төлөөлөгч нь юуны өмнө тухайн орон нутгийн иргэдийг төлөөлөх үүрэгтэй. Орон нутгийн хэмжээний бодлого, шийдвэрт иргэдийн санаа бодлыг тусгах, тэдний эрх ашгийг хамгаалах ажлыг төлөөлөлж гүйцэтгэнэ. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн дагуу төлөөлөгч нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд улс төрийн тодорхой намыг төлөөлөх боловч үндсэн үүрэг нь өөрийг нь сонгосон нутгийн иргэдийг төлөөлөх явдал юм. Нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулан ажиллах тухай энэхүү заалтыг улам гүнзгийрүүлэн Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн наймдугаар зүйлийн 2-т “Нутгийн өөрөө удирдах ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар” гэж тодорхойлсон байна.

Засгийн эрхийг мэдлийг хэрэгжүүлэх улс төрийн өрсөлдөөнд идэвхтэй оролцогч тал байх үүргийг улс төрийн намууд хэрхэн хэрэгжүүлдэг вэ? гэсэн асуулт бас тавигдах нь зайлшгүй. Улс төрийн намыг хүнээр орлуулан төсөөлөх аваас улс төрийн намзасгийн эрх мэдлийг хэрэгжүүлэхийн төлөөх өрсөлдөөнд идэвхтэй оролцогч байх явдал нь түүний жам ёсны, зүй ёсны эрх нь болно. Учир нь улс төрийн нам нь засгийн эрхийн төлөөх шууд, чөлөөт, ардчилсан өрсөлдөөнд оролцогч улс төрийн гол байгууллага юм. Улс төрийн намууд сонгуульд оролцохдоо ялалт байгуулж, өөрийн намын үзэл санаа, үзэл баримтлалын хүрээнд дэвшүүлсэн улс төр-эдийн засаг-нийгмийн зорилт бүхий бодлогыг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байдаг. Ямартай ч улс төрийн намууд засгийн эрхийг дангаар болон бусад улс төрийн нам, хүчинтэй эвсэх замаар авах, хэрэгжүүлэх зорилго тавьдаг. Манайх шиг парламентын байгуулалтай улсад хууль тогтоох институтыг сонгох сонгуулийн үр дүн нь ямар нам, хүчин, эвсэл засгийн эрхийг авч, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхийг тогтоох арга хэрэгсэл болдог. Өөрөөр хэлбэл парламентад олонх болж чадсан нам ерөнхий сайдад нэр дэвшүүлж, засгийн газар

⁶²Нам, эвсэл Улсын Их Хурлын сонгуульд 76-аас илүүгүй хүнийг тухайн нам, эвслийн гаргасан дарааллын дагуу нэрийн нэг жагсаалтаар дэвшүүлнэ.

⁶³Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр болон нэр дэвшүүлэх асуудлыг намын Их Хурал эсхүл Их Хурлаас сонгож байгуулсан төлөөллийн төв байгууллага шийдвэрлэнэ. Нэр дэвшүүлэх асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

байгуулах боломжтой болно. Харин ерөнхийлөгчийн байгуулалтай улсад төр, засгийн тэргүүнийг шууд буюу бүх нийтийн сонгуулиар сонгодог.

Сонгуулийн үр дүнгээр Улсын Их Хуралд 39 ба түүнээс дээш суудал авсан нам, эвслийг Улсын Их Хурал дахь олонх гэнэ.⁶⁴ Улсын Их Хурлын Сонгуульд олонх болсон нам, эвсэл Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлэхийн зэрэгцээ Ерөнхий сайдаар томилуулах хүний нэрийг дэвшүүлэн ерөнхийлөгчид өргөн барьж улмаар ерөнхийлөгч тухайн хүний нэрийг Улсын Их Хуралд оруулж батлуулна. Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг, аль ч нам эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн дэвшүүлсэн хүнийг, хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хурал дахь нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна⁶⁵ гэжээ. Үүнээс үзвэл сонгуулийн үр дүнд олонх болж чадсан нам, эвсэл хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх улс төрийн институтын аль алинд нь тэргүүлэх үүрэгтэй байхаар байна.

Сонгуульд амжилттай оролцож, засгийн эрх авч чадаагүй нөхцөлд ч улс төрийн намууд засаглалын үйл явцад идэвхтэй оролцогч байдаг. Сонгуулийн үр дүнд цөөнх болсон нам засгийн газрын үйл ажиллагаанд сөрөг хүчний байр сууринаас хяналт тавьж, төрийн бодлогод нөлөөлөх улс төрийн үйл ажиллагаа явуулдаг. Парламентын байгуулалтай орнуудад засгийн газар байгуулж эсвэл бүрэлдэхүүнд нь багтаж чадаагүй улс төрийн намууд сөрөг хүчний байр сууринд байж сүүдрийн засгийн газар (хяналтын танхим ч гэж нэрлэх нь бий) байгуулж, хяналт тавигч - хөтөч нохойн (watchdog) үүрэг хүлээнэ. Энэ нь нам улс төрийн үйл явц, засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа бас нэг хэлбэр болно.

Нийгмийн олон талт ашиг сонирхлыг нэгтгэн, төрийн бодлого болгох. Нийгмийн олон талт ашиг сонирхол нь нийгмийн бүхий л бүлэг, давхрааны хүсэл сонирхол, нөхцөл байдлаас шалтгаалж байдаг. Улс төрийн тогтолцоонд улс төрийн намуудын үүргийг тодорхой хүрээнд хязгаарлаж болох хэдий ч зарим тохиолдолд нийгмийн харилцааны бүхий л хүрээнд улс төрийн намын оролцоотой хэрэгжсэн үйл ажиллагаа, түүний шууд үр дүн, үр дагавар гарч байдаг. Иймд судлаачид улс төрийн намыг ашиг сонирхлын агергаци(ашиг сонирхлыг системчлэн нэгтгэх)-ийг хэрэгжүүлэх суваг гэдэгтэй санал нэгддэг. Улс төрийн тогтолцооны тухай онолын гол төлөөлөгч Давид Истон улс төрийн үйл явцад талуудын ашиг сонирхлыг нэгтгэн, системчлэх үүргийг улс төрийн нам хэрэгжүүлж байгааг шинжилж, тодорхойлсон. Хүмүүс улс төрийн чиг хандлагаараа ялгарах нь бий. Үүнийг иргэд тодорхой үзэл санааны хүрээнд нэгдэн зүүний эсвэл барууны чиг баримжаатай намын гишүүн, дэмжигч болж байгаагаар тайлбарлаж болно. Түүнчлэн улс төрийн намуудын дүрэмд улс төрийн ямар чиг баримжаатай хүчин болохыг тодорхойлсон байдаг. Иймд иргэд ямар улс төрийн нам тэдний нийгмийг ойлгох, хүлээн зөвшөөрөх үзэл, үнэт зүйлтэй ойр байгаас шалтгаалж улс төрийн сонголтоо хийдэг. Ямартай ч тухайн улс төрийн намыг тодорхой ашиг сонирхол бүхий хүн амын бүлэг тойрон хүрээлдэг. Тухайлбал, Их Британид Хөдөлмөрийн Намыг нийгмийн дунд болон доод давхрааны төлөөлөл түлхүү дэмждэг бол Бүгд Найрамдах Намыг дундаас дээш болон дээд давхрааны төлөөлөл дэмждэг байна.

Монголын улс төрийн намуудыг нийгмийн ямар давхараа, бүлэг хэрхэн дэмжиж байгааг шууд тодорхойлох судалгаа хараахан байхгүй боловч улс төрийн намуудын дүрэмд тодорхойлсон үзэл баримтлал нь нийгмийн ямар хэсэг тэднийг хүрээлж

⁶⁴Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх зүйл

⁶⁵Монгол улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн 33 дүгээр зүйлийн 33.2 дахь зүйл

болохыг илэрхийлнэ. Учир нь намын дүрэм нь тухайн улс төрийн хүчний үзэл баримтлал, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон эрх зүйн баримт бичиг юм. Ардчилсан намын Үндсэн Дүрэмд “Ардчилсан нам нь Монгол улсын язгуур эрх ашгийг дээдлэн улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдлийг бататган бэхжүүлэх, эрх зүйт төр, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хөгжлийг эрхэмлэж, түүний бүтээлч чадавхид тулгуурлан нийгмийн дэвшлийг хангах эрмэлзэл бүхий иргэдийн сайн дураараа эвлэлдэн нэгдсэн, *чөлөөт ардчилсан үзэл баримтлалыг онол суртахуун*, үйл ажиллагааны үндэс болгосон улс төрийн байгууллага мөн” гэсэн байна. Ардчилсан Намын Үндсэн дүрэм буюу эрх зүйн үндсэн баримт бичигт ардчилсан нам нь чөлөөт ардчилсан (либерал ардчилсан) үзэл санааг үнэт зүйлээ болгохыг тодотгожээ. Иймд чөлөөт ардчилсан үзэл санааг дэмжигч нийгмийн ямар ч гишүүнд ардчилсан нам нээлттэй болохыг тус дүрмээс ойлгож болохоор байна. Үүний нэгэн адил Монгол Ардын Намын дүрэмд “Монгол Ардын нам нь Монгол Ардын хувьсгалт Намын зүй ёсны эхлэл ба үргэлжлэл бөгөөд Монгол улсын тусгаар тогтнол, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдэл, үдэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдлэсэн, *нийгмийн ардчиллын үзэл баримтлал* бүхий улс төрийн байгууллага, хуулийн этгээд мөн” гэсэн байна. Иймд социал демократ буюу нийгмийн чиг баримжаатай үзэл баримтлалыг улс орны хөгжлийн бодлого болгох аливаа үйл ажиллагааг өөриймссөн нийгмийн хэсэг Монгол Ардын Намыг дэмжих боломжтой юм.

Ийнхүү бодлого тодорхойлж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцогч байх үүргийг улс төрийн нам хүлээдэг нь тодорхой байна. Нийгмийн бүлгийн ялгарал, давхраажилт хүчтэй явагдахын хэрээр нийгмийн тодорхой хэсгийн ашиг сонирхлыг илэрхийлсэн, улс төрийн намууд бий болдог. Үүнийг *олонтүмний нам (mass political party)* гэж нэрийдсэн байна.⁶⁶ Ихэнх тохиолдолд улс төрийн намууд сонгуульд тодорхой бодлогын хувилбар санал болгож оролцдог бөгөөд сонгогчдын олон талт ашиг сонирхлыг нэгтгэх (агрегаци хийх) замаар засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх өрсөлдөөнд оролцогдог. Үүнтэй уялдан улс төрийн намын хэв маягт мөн адил өөрчлөлт гарч байна. XX зууны хоёрдугаар хагаст олон намын тогтолцоо, түүнтэй уялдсан сонгуулийн тогтолцоо төлөвшиж, улмаар улс төрийн нөхцөл байдалд нийцүүлэн хүн амын бүхий л хэсгийн дэмжлэгийг авах шаардлага улс төрийн намуудад тавигдсан. Нийгмийн бүхий л хүрээний ашиг сонирхлыг илэрхийлэгч улс төрийн намыг *өргөн хүрээний*⁶⁷ (бүхнийг шүүрэгч гэж ч орчуулж болох) нам (catch all party) гэдэг. Өргөн хүрээний намууд нийгмийн бүхий л хүрээний ашиг сонирхлыг багтаасан мөрийн хөтөлбөр боловсруулж, сонгогчдын саналыг авах зорилт тавьж байдаг. Үүнтэй уялдан сүүлийн жилүүдэд улс төрийн намуудын бодлогод ижилсэх хандлага ажиглагдах болсон. Түүгээр зогсохгүй бодлого хэрэгжүүлэх арга замыг нялгах аргагүй болж байна.⁶⁸

Улсын Их Хуралд суудалтай намуудын төрийн бодлого тодорхойлж, түүнтэй уялдсан шийдвэр гаргах, гаргуулах эрх зүйн боломж парламентад суудалгүй намуудтай харьцуулахад давуу байдаг. Үүний нэг илрэл нь УИХ-д 8-аас доошгүй суудал авсан нам, эвсэл өөрийн нам, эвслийн бүлэг⁶⁹ байгуулах, тухайн намын гишүүд Байнгын хороодод орж ажиллах боломж юм. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, Байнгын болон дэд, түр хороо, нам, эвслийн бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр

⁶⁶Зүлфикар С. Орчин үеийн улс төрийн намуудын хөгжлийн хандлага. Төрийн захиргаа сэтгүүл.

⁶⁷МУИС-ын Улс төр судлалын тэнхимийн багш нар өргөн хүрээний нам нэгж орчуулж, томьёолсон байна.

⁶⁸Хэдийгээр Ардчилсан Нам чөлөөт ардчилсан үзэл санааг үнэт зүйлээ болгосон улс төрийн хүчин боловч 2008 оны УИХ-ын сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөртөө “Иргэдийг орон сууцаар хангах хөтөлбөрийг бодит ажил болгож, залуу гэр бүл болон орлого багатай гэр бүлд зориулсан орон сууцны зээлийн бодлого хэрэгжүүлнэ” гэж зүүний болон зүүн төвийн улс төрийн намын онцлогт нийцсэн нийгмийн чиг баримжаатай зорилт дэвшүүлсэн байна.

⁶⁹УИХ дахь улс төрийн намын бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс нэр нь албан ёсоор нэр дэвшиж сонгогдсон гишүүд орно.

хэрэгжүүлнэ.⁷⁰ Намын бүлэг, Байнгын хороод нь хуулийн төсөл, бодлогын баримт бичгийг хэлэлцэж, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд оруулж хэлэлцүүлэх эсэх, нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх шийдвэрийг гаргана. Үүнээс үзвэл Улсын Их Хурал дахь улс төрийн намын бүлэг нь сонгогчдын ашиг сонирхлыг нэгтгэн бодлого тодорхойлох, шийдвэр гаргуулах үүрэг хүлээж байна. Үүний тулд Улсын Их Хурлын Чуулганы хуралдааны өмнө тухайн эрх зүйн баримт бичгийг хэлэлцэх Байнгын хороодын бүрэлдэхүүнд багтах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу холбогдох байнгын хороо, шаардлагатай гэж үзвэл нам, эвслийн бүлэг хуулийн төслийг урьдчилан хэлэлцэж чуулганаар хэлэлцэх эсэх тухай санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.⁷¹ Дээрх хуулийн заалтууд нь улс төрийн намууд иргэдийн ашиг сонирхлыг нэгтгэх, бодлого болгон хэлэлцүүлж, шийдвэр гаргуулах үйл ажиллагаанд тэргүүлэх үүрэгтэй болохыг харуулж байна.

Улс төрийн манлайлагчид, элит хэсгийг сонгох, бэлтгэх, байршуулах- улс төрийн манлайлагчдыг бэлтгэх, хөгжүүлэх үүргийг нам хэрэгжүүлдэг. Өнөө цагт улс орны бодлогыг тодорхойлж, хүмүүсийг араасаа дагуулах авьяас чадвартай манлайлагчид (удирдагчид) улс төрийн нам дотор бэлтгэгдэж, сонгогдож, шилэгдэх⁷² улс төрийн соёл төлөвшөөд байна. Улс төрийн намын хүний нөөцийн бодлого нь улс төрийн албан тушаалд томилогдох хүмүүсийг сонгон шалгаруулах, бэлтгэж хөгжүүлэх, тохоон томилох, дэвшүүлэх тогтолцоо юм. Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшүүлэх хүмүүсийг намын анхан, дунд, дээд шатны байгууллагаар хэлэлцүүлж тогтооох практик Монголын улс төрийн намуудад тогтсон байдаг. Зарим нам сонгуулийн өмнө нийгэм-эдийн засгийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн олны танил хүмүүсийг өөрийн намд элсүүлэн улмаар улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулах бодлого баримталдаг. Ардчилсан намын үндсэн дүрэмд намын төлөөллийн төв байгууллага болох Үндэсний Зөвлөлдөх Хорооны⁷³ эрх үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд: Намын Үндсэн дүрмийн 6.4.9.15 дахь зүйлд УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг батлах; 6.4.9.16 дахь зүйлд Ерөнхийлөгчийн сонгуульд намаас нэр дэвшигчийг тодруулах; 6.4.9.17 дахь зүйлд намаас Ерөнхий сайдад нэр дэвшигчийг тодруулах; 6.4.9.21 дахь зүйлд Намын даргыг Үндсэн дүрэмд зааснаар чөлөөлөх үндэслэл үүсвэл асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх зэрэг болно. Үүнээс үзвэл үндэсний түвшинд улс төрийн сонгуульт албан тушаалд тодорхой улс төрчийг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэх үүргийг улс төрийн намын удирдах төв байгууллага хэрэгжүүлж байна. Түүгээр зогсохгүй намын дарга, намын удирдах төв байгууллагын гишүүдийг мөн адил намын удирдах төв байгууллага нь сонгож байна. Улс төрийн практикт намын удирдах төв байгууллагад нэр дэвшиж, батлагдсан намын гишүүд сонгуулийн үр дүнгээс хамаарч улс төрийн болон зарим төрийн захиргааны⁷⁴ албан тушаалд томилогдож байна.

Монгол Ардын Намын дүрэмд мөн адил улс төрийн албан тушаалд намын гишүүдийг нэр дэвшүүлж, томилох харилцааг зохицуулжээ. Намын анхан шатны

⁷⁰Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх зүйл.

⁷¹Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн гуравдугаар бүлэгт Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэлэлцэх үе шатыг тодорхойлохдоо Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн үүргийг дээрх байдлаар тухайлан заажээ.

⁷²Энэ үйл явц зарим талаар шүүмжлэлд өртдөг. Улс төрийн намыг амьдралын зорилго, арга хэрэгслээ болгосон хэсэг бүлэг хүмүүс өөрсдийгөө улс төрийн элит хэсэг гэж зарлан, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан, олон нийттэй харилцах арга замаар улс төрийн нам, улс төрийн үйл явцыг бохирдуулдаг гэж үзэх хандлага бий. Хэдий энэ мэт шүүмжлэл байдаг боловч улс төрийн нам нь нийгмийн тэргүүлэх хэсэг болж, олон түмнийг араасаа дагуулах замаар улс орны бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга зам болсоор байна.

⁷³Ардчилсан Намын Үндсэн дүрмийн намын бүтэц, удирдлага, зохион байгуулалт гэсэн 4 бүлгийн 4.1.2 дахь зүйлд "Их Хурлын чөлөө цагт ажиллах төлөөллийн төв байгууллага нь Үндэсний Зөвлөлдөх Хороо /ҮЗХ/ мөн гэжээ.

⁷⁴Төрийн албаны хуулиар төрийн захиргааны албан тушаалтын сонгон шалгаруулалтаар авах зохицуулалт байдаг хэдий ч манайд хэвшээд байгаа практикт улс төрийн нам тодорхой төрийн захиргааны албан тушаалд томилох үйл ажиллагаанд тухайлан оролцож байгааг харуулж байна.

байгууллага нь “Намын дээд байгууллагад сонгогдох, түүнчлэн харьяалах нуаг дэвсгэрт УИХ болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгууль, ИТХ болон Засаг даргад нэр дэвшүүлэх хүмүүсийн талаар саналаа илэрхийлэх”⁷⁵ эрхтэй. Харин УИХ, ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх эцсийн шийдвэр гаргах эрхийг Намын Бага Хуралд үлдээжээ.

Улс төрийн намуудын хүний нөөцийн бодлого нь намын дотоод ардчиллыг илэрхийлэх шалгуур болдог. Улс төрийн манлайлагчдыг орон нутгийн, бүсийн, үндэсний гэж ангилдаг бөгөөд аль ч тохиолдолд намын анхан, дунд, дээд шатны байгууллагууд манлайлагчдыг сонгон шалгаруулах, хөгжүүлэх, нэр дэвшүүлэх,⁷⁶ томилох үйл ажиллагаанд өөр өөрийн эрх үүргийн дагуу оролцдог. Тухайлбал, Монгол улсын төрийн тэргүүн буюу ерөнхийлөгчийг сонгох сонгуульд өрсөлдүүлэх хүний нэрийг дэвшүүлэх эрх үүргийг парламентад суудалтай намуудад олгосон байдаг. Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ.⁷⁷ Парламентын байгуулалтай улсад төрийн тэргүүнийг парламент нь сонгох зохицуулалт үйлчилдэг бөгөөд Монгол улсад хоёр шаттай буюу эхлээд бүх нийтийн шууд сонгууль явуулж, улмаар ерөнхийлөгчөөр сонгогдсон хүнийг УИХ-аар батлах зохицуулалт үйлчилдэг. Үүнээс үзвэл Монгол улсад ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх болон сонгуулийн хоёр дахь шатанд УИХ-аар ерөнхийлөгчийг батлах үйл ажиллагаанд улс төрийн намууд голлох үүрэгтэй оролцож байна.

Эцэст нь улс төрийн намуудын нийгэм-улс төрийн харилцаан дахь үүргийг хэрхэн дүгнэж болох вэ? Ямартай ч улс төрийн намуудын нийгэм-улс төрийн харилцаанд дахь үүргийг эрх зүйн тодорхой баримт бичгүүдээр зохицуулсан байна. Энэ түрүүнд улс төрийн нам нь тодорхой үзэл санаа, үзэл баримтлалын хүрээнд иргэд эвлэлдэн нэгдэх улс төрийн зохион байгуулалтын үндсэн хэлбэр болж байна. Ардчилсан дэглэмтэй улсад иргэд нь улс төрийн үйл явцад байнга оролцох боломжийг өргөжүүлэх зохион байгуулалт мөн адил улс төрийн нам болжээ. Учир нь төлөөллийн ардчиллын сонгодог арга хэлбэр нь улс төрийн сонгууль бөгөөд улс төрийн намууд сонгуульд өрсөлдөж, нийгмийн тодорхой хэсгийн ашиг сонирхлыг төлөөлөх үүрэг хүлээдэг ажээ.

Нэгэнтээ улс төрийн нам нь сонгуульд оролцох улс төрийн гол субъект болж байх тул засгийн эрх мэдлийг дангаар болон эвсэл байгуулах замаар хэрэгжүүлэх, нэг бол сөрөг хүчний байр сууринаас хяналт тавих үүрэгтэй. Улс төрийн нам нь нийгмийн олон талт ашиг сонирхлыг агрегацчилах буюу системчлэн бодлого болгох үүргийг зайлшгүй хэрэгжүүлнэ. Энэ бүгдийг улс төрийн харилцаанд бодитой хэрэгжүүлэхийн тулд улс төрийн нам нийгмийн элит хэсгийг эгнээндээ нэгтгэж, улс төрийн мэдлэг туршлага суулгах, өрсөлдүүлэх, тодорхой албан тушаалд томилох үүрэг хүлээдэг гэсэн дүгнэлтэд хүрч байна.

⁷⁵Монгол Ардын Намын дүрмийн 3 дугаар бүлгийн 9 дүгээр зүйлийн 9.1.8 дэх зүйл

⁷⁶Намын анхан болон дунд шатны байгууллага УИХ-д тухайн тойргоос нэр дэвшүүлэх хүний талаар санал оруулах эрхтэй байдаг бол намын Удирдах төв байгууллага (Үндэсний Зөвлөлдөх Хороо, Намын Бага Хурал гэх мэт) нь нэр дэвшүүлэх эрх үүрэг хэрэгжүүлж байна. Харин орон нутгийн ИТХ-д намын анхан болон дунд шатны байгууллага бие даан нэр дэвшүүлэх эрх үүрэг хэрэгжүүлж байна. Дүрмийн хүрээнд намын дотоод ардчилал, шат шатны намын байгууллагын бие даасан байдлыг хангах харилцааг ийнхүү зохицуулсан байна.

⁷⁷Үндсэн Хуулийн 2 дугаар бүлгийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь зүйл

МОНГОЛ ДАХЬ ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ҮЙЛ ЯВЦ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Д.ОЮУНЧИМЭГ

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, докторант

Түлхүүр үг: Сонгуулийн тогтолцоо, сонгох, сонгогдох эрх, сонгуулийн байгууллагын хараат бус байдал, сонгуулийн санхүүжилт.

ABSTRACT: *Impact of election system into political party system, Parliament, Government, electoral psychology and political stability has been revised in the article. Ascertainment of issues raised around the actualization of Parliamentary election system has crucial importance of investigation.*

Монгол дахь улс төрийн бодит үйл явцыг харах хамгийн тод цонх бол яах аргагүй энэ улсын төр улсаа төвхнүүлж ирсэн сонгуулийн үйл явц юм.

Монгол улсад сонгох ёсон XX зууны хориод онд нэвтэрч, улс төрийн харилцааны өөрчлөлтийг даган хөгжлийн хэд хэдэн үеийг дамжин өнөөгийн хэв шинжийг олжээ. Тухайлбал: 1923 оноос нутгийн ардын хурлуудыг, 1924 оноос Улсын Их хурлыг сонгох ёс журмыг хуульчлан хэрэгжүүлж эхэлснээр Монгол оронд сонгох, сонгогдох ёсон эхлэлээ тавьжээ. 1921 онд Түр засгийн газраас гаргасан тунхаглан зарлах тогтоол бичигт “Монгол улс ...үндсэн цааз дүрмийг тогтоож, сонгуулийг эрхэлсэн гүрэн байгуулна” гэсэн байдаг нь Монголд сонгуулийн тухай үзэл санаа нэвтэрч байсны илрэл юм. 1923 оны 3-р сард баталсан Монгол улсын нутгийн захиргааны дүрэм, 1924 онд баталсан УИХ-ын сонгох дүрэм, улмаар анхны Үндсэн хуулиар иргэдийн сонгох, сонгогдох эрх хийгээд сонгуулийн зарчим, журмыг анхлан тогтоожээ. 1923 онд нутгийн захиргааны дүрэм ёсоор орон нутагт 10-н гэр, баг, сум, хошуу, аймгийн хурал бий болов. Тэр үед 10 өрхөөс багийн хурлын төлөөлөгчийг, сумын хурлаас хошууны хурлын төлөөлөгчийг, хошууны хурлаас аймгийн хурлын төлөөлөгчдийг, аймгийн хурлаас УИХ-ын төлөөлөгчдийг саналаа илээр гаргаж сонгодог болжээ. Энэ нь иргэд зөвхөн 10-н өрх, багийн хурлаа шууд сонгодог, бусад хурлын хувьд доод шатны хурлын төлөөлөгчид дээд шатны хурлын төлөөлөгчдөө сонгодог байсныг шууд бус олон шаттай гэж үздэг. Ийнхүү 1923-1951 он бол анхдугаар үе буюу сонгуулийн тухай үзэл санаа нэвтэрч байсан үе юм. Энэ үеийн сонгуулийн тогтолцооны онцлог гэвэл: саналаа ил гаргадаг, шууд бус буюу олон шаттай, бүх нийтийн биш, (нийгмийн зарим давхрааны сонгох эрхийг хассан байсан), нэг нам жолоодон чиглүүлдэг зэрэг онцлогийг хадгалж байв.

1951-1990 оныг хоёрдугаар үе буюу хэлбэрдсэн, сонголтгүй сонгуулийн үе хэмээн нэрлэж болно. Монгол улс 1944 онд бүх нийтийн сонгуулийн эрх олгосон бөгөөд 1949 онд Улсын IX их хурлаас насанд хүрсэн нийт иргэн засаг төрийн төлөөлөгчдийг нийт, шууд, тэгш эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гарган сонгох шинэ тогтолцоог хуульчлан батлав. Энэ зарчмаар 1951 онд Улсын Их хурлыг, 1952 онд орон нутгийн хурлыг бүх нийтээр сонгов. Тухайн сонгуулиуд бүх нийтийн, шууд, тэгш, саналаа нууцаар гаргах журмаараа өмнөх сонгуулиудаасаа дэвшилттэй байсан нь маргаангүй юм. Энэ үеэс 1980 оны дунд үе хүртэл Ардын Их хурлын сонгууль 3-5 жилд нэг удаа болж, Хувьсгалт намаас шат шатанд нэр заан албан ёсоор дэвшүүлсэн нэг хүний төлөө саналын хуудсыг хайрцагт хийж заншсан байсан бөгөөд нэр дэвшигчид өрсөлдөх, мэтгэлцэх, маргах, өөр хүний нэр дэвшүүлэх зэрэг ойлголт байсангүй. Тэр

үеийн сонгууль 75 хоногийн турш улс орны хэмжээнд улс төрийн томоохон кампанит ажил болон өрнөж, жишээ нь 1970 –аад оны байдлаар гэхэд улс орны хэмжээнд жараад мянган хүн дайчлагдан ажилладаг байжээ. Гэвч тэр нь тухайн үеийн улс төрийн дэглэмээс шууд хамааран нэг намын дохио заавраар хийгддэг, хэлбэрдэлт төдий, ямар нэгэн сонголтгүй сонгууль байв.

Гуравдугаар үе бол 1990 оноос өнөөг хүртэл үргэлжилж байгаа ардчилсан сонгуулийн тогтолцооны үе юм. “1990 онд Ардын депутатуудын хурлын сонгуулийн хууль батлагдсанаар анх удаа парламентын чөлөөт сонгуульд олон нам оролцож, Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаа сонгосон нь ардчилсан сонгуулийн үндсийг тавьсан анхны том алхам болсон юм⁷⁸”

1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Монгол Улсад УИХ-ын сонгууль 6 удаа явагджээ. Үүнд 1992 оноос 2004 онд явагдсан УИХ-ын 4 удаагийн сонгуулийг 1992 онд баталсан “Монгол Улсын Их Хурлын сонгуулын тухай хуул”-иар, 2008 онд явагдсан УИХ-ын сонгуулийг 2005 онд баталсан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуул”-иар, 2012 онд явагдсан УИХ-ын сонгуулийг 2011 онд баталсан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуул”-иар тус тус зохион байгуулж явуулжээ.

Сонгуулийн тогтолцооны үйлчлэлийг авч үзэхийн тулд нэг талаас улс төрийн орчноос сонгуульд нөлөөлөх нөлөөллийг, нөгөө талаас сонгуулийн тогтолцооны улс төрийн орчинд үзүүлэх нөлөөлөл буюу үйлчлэлийг авч үзэх нь зүйтэй юм. Эндээс сонгуулийн тогтолцооны үйлчлэлийн орчил хэмээх ойлголт гарч ирнэ. Энэ бол сонгуулийн хэлбэрүүдийн болон улс төрийн орчны харилцан хамаарал, харилцан үйлчлэлийн бүхэл орчил юм.

Улс төрийн орчноос сонгуулийн тогтолцоонд үзүүлэх үйлчлэлийн системд ардчиллын хөгжил, төлөвшил, хэв загвар, нийгэм дэхь ашиг сонирхлын ялгарлын үйл явцын шинж байдал, намуудын төлөвшил, лидерүүдийн улс төрийн соёл, олон түмний нийгмийн сэтгэл зүй, сонгуулийн эрх зүйн орчин зэрэг хүчин зүйлсийг багтаан үздэг бол харин сонгуулийн тогтолцооны үйлчлэл нь шууд утгаараа тэдгээрийн зүгээс улс төрийн “макро”орчинд үзүүлэх нөлөөлөл юм. Улс төрийн орчны энэхүү “макро”төвшний хүрээнд: намын систем, парламент, засгийн газар, сонгогчдын сэтгэл зүй, нийгмийн улс төрийн тогтвортой байдал зэргийг хамруулан үзнэ. Өгүүллэг чухам энэ талаас асуудалд хандаж байна.

Сонгуулийн нэг мандаттай мажоритар тогтолцоо нь сонгогчдод ойлгомжтой, сонсогч болон нэр дэвшигч нүүр тулан уулздаг сайн талтай боловч багагүй сөрөг үр дагавартай болох нь сонгуулиудын явцад ажиглагдсан болно. Тухайлбал сонгогчдын санал гээгдэх, өөрөөр хэлбэл 40 гаруй хувийн санал авсан нэр дэвшигч ялагдаж байхад өөр нэг тойрогт 30 гаруй хувийн санал авсан нэр дэвшигч сонгогдож байсан тохиолдол олон байлаа. Мөн нийслэлийн тойргуудад нэр дэвшигч нь аймгуудын тойрогт нэр дэвшигчээс хэд дахин олон сонгогчдын санал авч сонгогдож байжээ.

Олон мандаттай томсгосон тойргоор явуулдаг мажоритар тогтолцооны хувьд сонгогчийн тэгш эрхийн зарчим алдагдахад хүргэдэг үр дагавар ажиглагдаж байлаа. Тухайлбал зарим тойрогт сонгогч 3-4 нэр дэвшигчийн төлөө санал өгч байхад өөр нэг тойрогт сонгогч 1-2 нэр дэвшигчийн төлөө санал өгч байх жишээтэй.

Харин 2011 онд батлагдсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар Улсын Их Хурлын сонгуулийг мажоритар тогтолцоогоор 48, хувь тэнцүүлэх

⁷⁸ Ч.Содномцэрэн. “Сонгуулийн зохион байгуулалт, тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох нь” Монгол улс дахь Үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс. Э.Ш-ний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2013. 76–р тал.

тогтолцоогоор 28 суудал бүхий сонгуулийн хосолсон тогтолцоотойгоор зохион байгуулж явуулахаар хуульчилснаар 2012 оны УИХ-ын сонгууль холимог тогтолцоогоор явагдлаа.

Монгол улс 1990 оноос хойш нийтдээ парламентын 6 удаагийн сонгууль (1992, 1996, 2000, 2004, 2008, 2012) зохион явуулснаас 2012 оны сонгууль холимог тогтолцоогоор явагдсаныг эс тооцвол бусад бүх сонгууль олонхийн буюу мажоритар тогтолцоогоор явагджээ. Тиймээс Монгол дахь сонгуулийн тогтолцооны үйлчлэлийн асуудал үнэн хэрэгтээ сонгуулийн мажоритар тогтолцооны үйлчлэлийн тухай асуудал дээр илүү төвлөрч байна.

Сонгуулийн тогтолцоо, намын тогтолцоо хоорондоо нягт холбоо хамааралтай. Сонгуулийн мажоритар тогтолцоотой улс оронд хоёр намын тогтолцоо бүрэлдэн тогтдог зүй тогтол (Дювержегийн хууль) манай оронд болж өнгөрсөн парламентын бүх сонгуулийн үр дүнгээр давтагдсан юм.

Парламентын сонгууль бүрт дунджаар улс төрийн 10 гаруй нам оролцож ирсэн ч Монголд хоёр намын тогтолцоо үйлчилж ирснийг Монголын судлаачид тэмдэглэдэг⁷⁹. Үүндээ судлаач Лийпхартын Patterns of Democracy бүтээлд “тогтмол нягт эвсдэг намыг нэг нам хэмээн тоолон хэрэглэсэн арга зүйг” үндэслэсэн байна. Энэхүү аргачлалаар авч үзвэл Монголд МАХН (МАН) ба Ардчилсан эвсэл гэсэн хоёр намын тогтолцоо хэрхэн оршин үйлчилж ирснийг дараахи хүснэгтээс харж болно.

Сонгуулийн жил	МАХН		Ардчилсан эвсэл	
	Нийт саналаас тухайн намд ноогдож буй хувь	Парламент дахь суудлын тоо	Нийт саналаас тухайн эвсэлд ноогдож буй хувь	Парламент дахь суудлын тоо
1992	59,6 %	71	40,0 %	4
1996	40,5 %	25	47,0 %	50
2000	51,6 %	72	13,4 %	1
2004	48,3 %	37	44,3 %	35
2008	51,3 %	39	34,2 %	26
2012	32,8 %	25	57,8 %	44

Мөн үүний зэрэгцээгээр сонгуулийн тогтолцоо бүр намын тогтолцоонд өөр өөрөөр үйлчилдэгч эцсийн дүндээ тэдгээр нь нөлөө бүхий томоохон намуудад ашигтай, жижиг намуудад ашиггүй байдаг нийтлэг жам ёс ч⁸⁰ үйлчилж ирсэн байна. Энэ нь намын тогтолцоонд сонгуулийн хэлбэрээс гадна өөр бусад хүчин зүйлс чухал нөлөөтэй байдгийг харуулж байна. Харин 2012 оноос сонгон хэрэглэж байгаа сонгуулийн холимог тогтолцооны хувьд олонхи дийлэнхийн болон хувь тэнцүүлсэн хэлбэрийн хослол байдаг болохоор уг тогтолцооны намын тогтолцоонд үзүүлэх нөлөөлөл нь сонгуулийн тогтолцооны аль хэлбэр нь илүү давамгайлж байна гэдгээс ихээхэн шалтгаална.

Өнөөдөр Монголд сонгуулийн холимог тогтолцооны параллель хэлбэрийн үйлчлэлээс үүдэн хоёр хагас намын тогтолцоо оршин үйлчилж байна гэж дүгнэж болохоор байна.

⁷⁹ Э.Гэрэлт-Од, О.Машбат. “Монгол дахь сонгуулийн систем улс төрийн намын төлөвшилд нөлөөлөх нь” Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик Э.Ш-ний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2009.87-р тал.

⁸⁰ Дуглас.В.Рай “Сонгуулийн эрхийн улс төрийн нөхцөл”, (Rae, 1967) үз.

Сонгуулийн тогтолцооны парламентын тогтолцоон дахь үйлчлэл нь парламентын намуудын тоо, парламентын гишүүдийн ашиг сонирхлын агрегацийн үйл явц, парламентын бүтэц, зохион байгуулалтад үзүүлж буй нөлөөллөөр дамжин илэрдэг.

Тухайн сонгуулийн тогтолцооны парламент дахь намын тоонд нөлөөлөх нөлөөллийн үр дүнг хэмжих гол хэмжүүр нь парламент дахь намуудын “үр ашигтай тоо” болох нь харагдаж байна. Манай орны хувьд сонгуулийн мажоритар тогтолцоо зонхилон үйлчилж байсантай уялдан парламентад гол төлөв бодит болон бүтээмэл олонхи (1992, 2000, 2008 онуудад бодит олонхи, 1996 онд бүтээмэл олонхи) бүрэлдэж байсан бөгөөд харин 2004, 2012 онуудад бодит цөөнхи бүрэлдэж байсан байна.

Сонгуулийн тогтолцоо	Сонгуулийн жил	Парламент дахь намуудын үр ашигтай тоо
Олон мандаттай мажоритар	1992	Бодит олонхи
Нэг мандаттай мажоритар	1996	Бүтээмэл олонхи
Нэг мандаттай мажоритар	2000	Бодит олонхи
Нэг мандаттай мажоритар	2004	Бодит цөөнхи
Олон мандаттай мажоритар	2008	Бодит олонхи
Холимог тогтолцоо	2012	Бодит цөөнхи

АНУ-ын судлаач Аренд Лийпхарт засгийн газрын танхимыг “ялимгүй олонхийн”, “хэт олонхийн”, “цөөнхийн буюу олонхи болж чадаагүй” танхим гэж ангилж үзсэн нь сонирхолтой юм.⁸¹

Монголд явагдсан парламентын 6 удаагийн сонгуулийн үр дүнд “нэг намын олонхийн танхим хоёр удаа (1992, 2000), “эвслийн танхим 5 удаа (1996, 2004, 2008, 2012) бүрэлдэж байсан нь нэг намын олонхийн засгийн газар голчлон бүрэлдэх хандлагаас эвслийн засгийн газар бүрэлдэх хандлага руу өөрчлөлт орж байгаа нь ажиглагдаж байна.

№	Сонгуулийн хэлбэр	Сонгуулийн жил	Засгийн газрын танхим
1	Олон мандаттай мажоритар	1992	Нэг намын олонхийн танхим
2	Нэг мандаттай мажоритар	1996	Олон намын эвслийн танхим
3	Нэг мандаттай мажоритар	2000	Нэг намын олонхийн танхим
4	Нэг мандаттай мажоритар	2004	Хамгийн ойр байр суурьтай намын эвсэл
5	Олон мандаттай мажоритар	2008	Хамгийн цөөн намуудын эвсэл
6	Холимог тогтолцоо	2012	Хамгийн цөөн намуудын эвсэл

Сонгуулийн тогтолцоо парламент дахь ашиг сонирхлын агрегацид янз бүрийн байдлаар нөлөөлж байна. Г.Алмондын тодорхойлсноор “ашиг сонирхлын агрегаци бол иргэд, бүлгүүдийн улс төрийн шаардлага нэгтгэгдэж улс төрийн бодлогын хөтөлбөр болох үйл ажиллагаа юм”⁸² Сонгуулийн мажоритар тогтолцоогоор сонгогдсон манай парламентын гишүүдийн хувьд ашиг сонирхлын агрегаци хийхэд зарим нэг бэрхшээл үүсдэг байна. Тухайлбал тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүдийн хувьд парламентад нийт улс орны ашиг сонирхлыг төлөөлөхийн зэрэгцээ орон нутаг, тойргийн сонгогчдын эрх ашиг, хүсэл сонирхол, мөн өөрийн намын сонирхлыг төлөөлөх, нэгтгэх шаардлага тулгардаг. Ийм нөхцөлд тэдгээр гишүүдийн хувьд зарим үед улс орны нийтлэг

⁸¹ А.Лийпхарт. Ардчиллын хэв загвар, УБ., 2008, 113-р тал.

⁸² Г.Алмонд ба бусад “Харьцуулсан улс төр: онолын хүрээ” УБ., 2005, 112-р тал.

сонирхол, төлөөлж буй намынхаа байр суурийг гол болгох эсвэл орон нутаг, тойргийн сонгогчдын хүсэл сонирхлыг илүүтэйд үзэхийн аль нэгийг сонгоход хүрдэг тохиолдол гардаг. Ялангуяа төсөв хэлэлцэх явцад манай гишүүдийн тойргийн сонирхол хүчтэй илэрдэг

2011 оны 12-р сарын 15-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль”-ийг шинэчлэн баталсан. Өөрөөр хэлбэл 1992-2008 оны хооронд УИХ-ын ээлжит сонгуулийг зохион байгуулсан “мажоритар” тогтолцоог өөрчлөх нь зүйтэй гэж үзэж “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль”-ийн 4.9-д “Энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл /цаашид “нам, эвсэл” гэх/ -ийн жагсаалтаас тус тус сонгоно”⁸³ хэмээн хуульчилснаар УИХ-ын сонгуулийн дүнг холимог системээр, “параллель” хувилбараар тооцох хувилбарыг сонгон 2012 оны УИХ-ын ээлжит сонгуулийг зохион байгуулсан.

Ингэснээр парламентын гишүүдийн нэг хэсэг нь тойргоос нөгөө хэсэг нь намын нэрсийн жагсаалтаар сонгогдох болсон юм. Энэ нь олонхи сонгогчдын дунд парламентын гишүүдийг хоёр өөрөөр ялган харах хандлагыг төрүүлсэн төдийгүй төсөв хэлэлцэх үед тойргоос сонгогдсон гишүүд “намын жагсаалтаар сонгогдсон гишүүдэд тойрог гэж байхгүй учир тэдэнд тойрогт ажиллах мөнгө болон бие төлөөлөгч шаардлагагүй “ гэх зэргээр гишүүний төсөв, цалин, бусад хангамжийн талаархи асуудалд хоёр өөрөөр хандаж байгаа нь парламентын хуралдаан дээр харагддаг.

Өнөөдөр манай улсын хувьд парламентын “хууль тогтоох” болон “гүйцэтгэх засаглалд хяналт тавих” чиг үүрэг төдийлөн маргаан үүсгэдэггүй бол харин “төлөөлөх” чиг үүрэг зарим нэг тохиолдолд ташаа ойлгогдсоны улмаас парламентад ёсны төлөвшилд сөргөөр нөлөөлөх хандлага ажиглагдаж байна.

Үнэн хэрэгтээ Монголын парламентын гишүүд “императив” мандаттай бус харин “чөлөөт” мандаттай болох нь Үндсэн хуулийн 23-р зүйлийн 1-д “Улсын Их Хурлын гишүүн нь ард түмний элч бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” хэмээн зааснаас харж болно. Манай улсын адил парламентын сонгуулиа холимог системийн “параллель” хувилбараар явуулдаг улсын парламентын гишүүд тухайн сонгогдсон “тойрогтоо ажиллах” хэмээх албан ёсны ойлголт байдаггүй байна.

“Манай улстай адил парламентын сонгуулийг параллель хувилбараар явуулдаг 20 гаруй улсын Үндсэн хууль болон холбогдох хуулиудыг авч үзвэл парламентын гишүүдийн нэг хэсэг нь намын жагсаалтаар, нөгөө хэсэг нь орон нутаг буюу мужуудын төлөөллөөс парламентыг бүрдүүлж байгаа боловч бүх гишүүд адил тэгш эрхтэй байдаг. Өөрөөр хэлбэл гишүүдийн эрх зүйн байдал нь ялгаваргүй байдаг байна. Эндээс дүгнэж үзвэл сонгуулийн холимог системийн “параллель” хувилбар нь парламентын гишүүний эрх зүйн байдалд нөлөөлдөггүй болох нь нотлогдож байна” Гагцхүү манай улсын улс төрчид болон сонгогчид “империад мандат”-ын сэтгэхүйгээсээ салаагүй, парламентын үзэл хандлага ташаа ойлголтоор төлөвшиж буйн илрэл юм. Иймд: парламентад ёсыг төлөвшүүлэх, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн холбогдох заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах, сонгогчийн боловсролыг дээшлүүлэх нь зүйтэй юм.⁸⁴

⁸³ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2011)

⁸⁴ Д.Солонго. “Сонгуулийн холимог системийн параллель хувилбар ба парламентын гишүүний эрх зүйн байдлын харилцан хамаарал” Монгол улс дахь Үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс. Э.Ш-ний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2013. 83-99-р талд үз.

Сонгуулийн үйл явцыг судлахад улс төрийн намуудын төлөвшил, парламент, засгийн газрын бүтэц хэв маягийн өөрчлөлтийг авч үзэхээр хязгаарлагдахгүй бөгөөд сонгогчдын нийгэм сэтгэл зүй, сонгуулийн кампанит ажил болон сонгуулийн зохион байгуулалтад гарч буй өөрчлөлтийг авч үзэх шаардлагатай.

Өнөөдрийг хүртэлх хугацаанд Монголын сонгогчдын сэтгэл зүйн төлөв байдал нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, улс төрийн үзэгдэл, үйл явцыг даган хувьсан өөрчлөгдөж ирсэн чиг хандлагыг тодорхойлохын тулд ардчилсан сонгуулийн мөчлөгтэй уялдуулан авч үзэж болох юм.

Нэг. Сонгогчдын сэтгэл зүйн “савалгаат” буюу тээнэгэлзлийн үе. (1990-1992 он)

Нийгмийн харилцаа, улс төрийн тогтолцоо өөрчлөгдөж, олон ургальч үзэл төлөвшин тогтож байсан энэ зурвас үед нийгмийн сэтгэл зүй олон талын хүчин зүйлийн гэнэтийн өөрчлөлтийн нөлөөлөлд автан шинэ соргог зүйлээрээ савалж хошуурч байсны зэрэгцээ мөн өөрчлөлт шинэчлэлд эргэлзэж тээнэгэлзсэн, хуучин нийгмийн тогтолцооны сайн сайхныг “үгүйлэх” хандлага түгээмэл байсан учир нийгмийн сэтгэл зүйн “савалгаат” буюу тээнэгэлзлийн үе байсан гэж үзэж болох юм.

Хоёр. Сонгогчдын сэтгэл зүйн эрэл, хайгуул, ардчиллын ололт, үнэт зүйлст суралцаж эхэлсэн үе. (1992-1996 он) Энэ үеийн онцлог шинж нь Монгол Улс онд шинэ Үндсэн хуулиа баталсан явдал байлаа. Шинэ Үндсэн хуулийн дагуу УИХ-ын анхны сонгуулийг явуулж тухайн сонгуульд улс төрийн 10 гаруй нам, эвсэл, холбоод оролцож, харьцангуй олон ургальч, чөлөөт сонгууль болсон боловч сонгуулийн мажоритар тогтолцооноос үүдэн сонгогчдын саналын 56,9 хувийн санал авсан МАХН парламентын 76 суудлын нь 70 суудлыг, МҮАН 6 суудлыг авсан нь анхаарал татсан үйл явдал болсон юм. Тухайн цаг үед хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Эстонд гэхэд л сонгуулийн дүн яг эсрэгээр буюу парламентын суудлын 90 гаруй хувийг улс төрийн шинэ хүчнүүдэд итгэл хүлээлгэж, коммунист, социалист намуудад маш цөөн суудал өгсөн байсан. Харин Монголын сонгогчид “танихгүй бурханаас таньдаг чөтгөр дээр” гэсэн сэтгэл зүйгээр, өөрчлөлт, шинэчлэлтийг болгоомжлон хүлээж авсан нь сонгуулийн дүнгээс харагддаг. Энэ нь тэдний ази сэтгэлгээтэй нь ч холбоотой байж болох юм. Энэ үед ганзагын наймааны “алтан үе” дуусаж, иргэдийн дунд хувийн хэвшлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх сонирхол давамгайлах болсон. Гэвч энэ ололттой тал удаан үргэлжлээгүй төдийгүй 1996 оноос эрчимжсэн эмх замбараагүй өмч хувьчлалын үйл явцад шахагдсанаар эрч нь суларсан.

Гурав. Хувийн өмчийн сэтгэлгээ төлөвшиж, шинэчлэл, өөрчлөлтийг хүсэн хүлээсэн үе: (1996-2000 он) Энэ үе бол “ардчилсан хүчний эвсэл” анх удаа төрийн эрх барьсан үе. 1996 оны сонгууль өмнөх сонгуулийн нэгэн адил нэг мандаттай тойргоор явагдсан хэдий ч Монголын сонгогчдын олонхийн сэтгэлзүйд “солиод үзье”, “итгээд үзье” гэсэн хандлага давамгайлсан бөгөөд сонгуулийн дүн төдийлөн төсөөлөөгүй үр дүн авчирч парламентын 76 суудлын нь 50 суудлыг, “Ардчилсан хүчний эвсэл” авч засгийн эрх барих эрхтэй болсон нь анхаарал татсан үйл явдал болсон юм. Сонгуулийн үр дүн эрх баригчдад “сөрөг хүчин” байх чадвар, ардчилсан хүчнийхэнд төр барих хариуцлагыг мэдрүүлсэн, шинэ улс төрийн хүчнүүдээс ихээхэн үр дүн хүсэн хүлээсэн үе.

Дөрөв. Зах зээлийн сэтгэлгээний төлөвшлийн эхэн үе: (2000-2004 он)

“Ардчилсан хүчний эвсэл”-ийн төр барьсан дөрвөн жилийн ажлын үр дүнд сонгогчид сэтгэл дундуур байсан бөгөөд 2000 оны УИХын сонгуулиар МАХН нийт сонгогчдын 51,6 хувийн санал авч ялалт байгуулсан байна. Сонгогчдын сэтгэл зүйн зах зээлийн сэтгэлгээний төлөвшлийн эхэн үе. Үүний зэрэгцээгээр өмч хувьчлалын сөрөг үр дагавраас үүдэн өмнөх нийгмийн зарим үнэт зүйлсийг санагалзах хандлага ажиглагдаж байсан үе.

Тав. Сонгогчдын сэтгэл зүйд парламент дахь улс төрийн хүчнүүдийг тэнцвэржүүлэх утгатай уриа лозун маш их таалагдаж байсан үе: (2004-2008)

2004 оны сонгууль нэг мандат бүхий мажоритар тогтолцоогоор, 76 тойргоор явагдсан ч улс төрийн аль ч нам олонхи болж чадаагүй бөгөөд гол хоёр нам ойролцоо санал авсан нь сонгогчдын “төрөө тэнцвэржүүлэх” хүслийн илрэл гэж болохоор байв.

Парламентын дөрвөн удаагийн сонгуулийг нэг мандаттай мажоритар тогтолцоогоор явуулж, сонгогчдод танил болсон хэдий ч нөгөө талаас тухайн тогтолцооны дутагдалтай талыг гүнзгий мэдрэх болсноос 2004 оны сонгуулийн дараа сонгуулийн тогтолцоогоо өөрчлөх шаардлагатай гэдэгтэй улс төрийн хүчнүүд төдийгүй иргэд сонгогчид ч санал нэгтэй болоод байв.

2003-2004 онд МУИС, МУБИС, ШУТИС-ийн эрдэмтэн судлаачдын хамтарсан баг УИХ-ын ажлын хэсгийн захиалга, UNDP-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр сонгуулийн тогтолцооны хэв маягууд, тэдгээрийг Монголд хэрэгжүүлэхэд үүсэх нөхцөлийн талаар нарийвчилсан судалгаа хийсэн. Тухайн судалгааны нэгээхэн хэсэгт: “мажоритар тогтолцооны олон мандаттай томсгосон тойрог бүхий хувилбар хамгийн тохиромжгүй хувилбар болохыг тодорхойлсон байдаг. Гэвч УИХ-аас чухамхүү энэ хувилбарыг сонгон авснаар 2008 оны УИХ-ын сонгууль “олон мандаттай томсгосон тойрог бүхий мажоритар тогтолцоогоор явагдсан юм.

Зургаа. Сонгогчдын сэтгэл зүйд сонгуулийн тогтолцоогоо өөрчилсөн ч ахиц гарахгүй байна, сонгууль булхай луйвраар явагдаж байна гэсэн хардлага давамгайлж байсан үе:(2008-2012 он)

2008 оны сонгуульд өмнөх дөрвөн удаагийн сонгуульд хэрэглэж байсан “ялагч бүхнийг авна” гэдэг зарчимтай уламжлалт мажоритар тогтолцоогоо томсгосон тойрог, олон мандаттай болгон хэрэгжүүлсэн нь намууд хоорондын төдийгүй, нам доторх өрсөлдөөнийг бий болгосон бөгөөд энэ бүхэн олон сайн, муу үр дагаврыг авчирсан. Тэдгээрийн нэг том илрэл нь 2008 оны 7-р сарын 1-ний хэрэг явдал. Уг хэрэг явдал “Сонгуулийн булхай луйврыг эсэргүүцсэн” жагсаалаар эхэлсэн боловч эцэст нь хүний аминд хүрсэн үймээн самуун болж, онц байдал тогтоож, 200 гаруй иргэн шоронд орсон харамсалтай явдлаар дууссан. Үүний үр дагавраас үүдэн Монголын сонгогчид, иргэдийн улс төрийн идэвхийн харьцангуй уналтын үе үргэлжилсэн юм. Улс төрийн намууд, судлаачид өмнөх алдаанууд дээр дүгнэлт хийх, оновчтой гарц олох эрэл хайгуулд идэвхийлэн орсон үе байлаа. Улмаар 2010 онд иргэний шинэчилсэн бүртгэл явуулан цахим элбэрт оруулж, 2011 онд “УИХ-ын сонгуулийн тухай хууль”-нд өөрчлөлт оруулан “сонгуулийн холимог тогтолцоо”-г сонгон авч, санал тоолох ажиллагааг бүрэн автоматжуулах шийдвэр гаргав.

Долоо. Ардчилсан нам буюу “ардчилсан хүчний эвсэл” 2 дахь удаагаа төрийн эрх барьж буй үе: (2012 оноос хойших үе) 2012 оны парламентын сонгууль сонгуулийн шинэчилсэн хуулиар, холимог тогтолцоогоор явагдлаа. Санал тоолох үйл ажиллагааг бүрэн автомат машинаар явуулав. “УИХ-ын сонгуулийн тухай хууль”-нд оруулсан шинэчилсэн өөрчлөлтөд сонгуульд өрсөлдөгчид, сонгууль зохион байгуулагчид төдийгүй иргэдэд ч хариуцлага тооцох заалт орсон хийгээд нилээд олон өөрчлөлтийг тусгасан, сонгуулийн зохион байгуулалтыг төрийн албан хаагчид дангаар гардан хэрэгжүүлсэн зэрэг нь парламентын сонгуульд олон ахиц дэвшлийг авчирсан. Өмнөх сонгуультай харьцуулахад тайван, дэвшилттэй сонгууль болсон ч иргэдийн улс төрийн намд итгэх итгэл, сонгуулиас гарах үр дүнд итгэх итгэл эрс суларсан үе.

Сонгогчдын идэвх, оролцоо хэрхэн явж ирснийг хүснэгтээс харвал:

№	Сонгуулийн тогтолцоо	Сонгуулийн жил	Сонгогчдын оролцоо
1	Олон мандаттай мажоритар	1992	95,6 %
2	Нэг мандаттай мажоритар	1996	92,1 %

3	Нэг мандаттай мажоритар	2000	82,5 %
4	Нэг мандаттай мажоритар	2004	82,2 %
5	Олон мандаттай мажоритар	2008	76,46 %
6	Холимог тогтолцоо	2012	67,28 %

Сонгуульд оролцогсдын хувь жил дараалан буурч байгаа дүн гарч байна. 2012 оны парламентын сонгуулийг ажлын өдөр явуулсан, тэр ч бүү хэл ажмахуйн нэгжээс санаачлан сонгуульд оролцсон сонгогчдод гар утасны нэгж үнэгүй тараасан зэрэг сонгогчдын ирцийг нэмэгдүүлэх янз бүрийн арга хэрэглэсэн. Гэвч төдийлөн үр дүн өгөөгүй юм.

Энэ бүхнээс дүгнэж үзвэл хууль журмаар албадах, эсвэл эдийн засгийн аргаар татахын аль нь ч алсаа харсан оновчтой арга биш бөгөөд алсдаа сонгогчдын боловсрол, улс төрийн соёлд сөргөөр нөлөөлөх болно. Гагцхүү сонгогчдын оролцоо, идэвх буурч буйн учир шалтгааныг нарийвчлан олж тогтоох явдал нэн чухал байна. Манайд сонгуулийн өмнөх долоо хоногт сонгогчдын дунд ямар нэг судалгаа, санал асуулга явуулахыг хориглодог нь байж болох хэдий ч саналаа өгсөн сонгогчдоос судалгаа авахыг хориглодог нь сонгогчдын үйл байдалтай холбоо бүхий аливаа судалгааны чанарт ихээхэн сөргөөр нөлөөлж байна.

Сонгуулийн тогтолцооны төлөвшилтийн өөр нэг чухал асуудал нь сонгуулийн зохион байгуулалт юм. Улсын бага хурлын 1992 оны 4-р сарын 10-ны өдрийн тогтоолоор Сонгуулийн Ерөнхий Хороог УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгууль, Ард нийтийн санал асуулгыг улсын хэмжээнд зохион байгуулж явуулах бүрэн эрхтэйгээр 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. 1992 онд батлагдсан “УИХ-ын сонгуулийн тухай хууль”-д зааснаар Сонгуулийн байгууллагын тогтолцоо нь “УИХ-ын дэргэдэх “Сонгуулийн Ерөнхий Хороо”, “тойргийн хороо”, “хэсгийн хороо” гэсэн бүтэцтэй байв.

Харин 1993 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг баталж Монгол улс анх удаа төрийн тэргүүнээ сонгох сонгуулийг явуулахдаа УИХ-ын дэргэдэх “Сонгуулийн Ерөнхий Хороо”, “нутаг дэвсгэрийн хороо”, “хэсгийн хороо”-оос бүрдсэн зохион байгуулалттайгаар явуулсан байна.

УИХ-аас 2006 онд Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийг баталж Сонгуулийн Ерөнхий Хорооны хараат бус, бие даасан байдлын эрх зүйн баталгааг хуульчилсан. Уг хуульд заасны дагуу Ард нийтийн санал асуулга, УИХ-ын сонгууль, МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах бүрэн эрхтэй, хараат бус бие даасан 9 гишүүнтэй байгууллага хэрэгжүүлэхээр болсон нь сонгуулийн байгууллагын хараат бус байдлыг хангах үндэс тавигдсан байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооны 9 гишүүний хоёрыг нь Ерөнхийлөгч, тавыг нь УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, хоёрыг нь Улсын Дээд шүүхээс санал оруулж, УИХ зургаан жилийн хугацаагаар томилох бөгөөд хороо, түүний гишүүн хууль ёсны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглосон зэрэг нь хорооны гишүүд хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн хамгаалалтыг бий болгосон байна.

Гэвч “сонгууль зохион байгуулах явцад, улс төрийн нам эвсэл, нэр дэвшигчдээс сонгуулийн төв байгууллагын ажил үүрэгт хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг оролдох, саад учруулах, дарамт, шахалт үзүүлэх тохиолдол цөөнгүй гардаг”⁸⁵ хэмээн СЕХ-ны даргын илтгэлд дурьдагдаж байсныг тэмдэглэх нь зүйтэй.

⁸⁵ Ч.Содномцэрэн. “Сонгуулийн зохион байгуулалт, тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох нь” Монгол улс дахь Үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс. Э.Ш-ний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. УБ., 2013. 78-р тал.

Сонгуулийн Ерөнхий Хорооны бие даасан хараат бус байдлыг хангах асуудал одоо хүртэл шийдвэрлэгдэж чадаагүй хүндрэлтэй асуудлын нэг байсаар байна. Аль ч улс орон сонгуулийг удирдан явуулдаг байгууллагыг аль болохоор улс төрийн сонирхол, нөлөөллөөс ангид байлгахыг чармайдаг. Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад сонгуулийг зохион байгуулж явуулах байгууллага нь “бие даасан”, “төрийн”, “холимог” гэсэн гурван үндсэн хэлбэрт хувааж үзэж болох юм. Улс төрийн болон төрийн албан тушаал нь салангид, төрийн алба нь улс төрөөс хараат бус соёл төлөвшсөн, ардчилал өндөр хөгжсөн зарим улсад төрийн байгууллага сонгуулийг зохион байгуулдаг загварыг хэрэглэдэг бол харин ардчилалд шилжиж байгаа улс орнуудад ийм загвар төдийлөн тохиромжгүй гэж үзэж төрөөс аль болох тусдаа бие даасан байгууллага сонгуулийн үйл явцыг эрхлэн зохион байгуулах ёстой гэсэн хандлага олон улсад давамгайлж байна. Харин холимог хувилбар гэдэг бол төрийн байгууллагад сонгууль зохион байгуулах эрхийг олгоод тэдний үйл ажиллагаанд сонгуулийн бие даасан байгууллага нь хяналт тавьдаг хувилбар юм. Энэхүү холимог загвар харьцангуй түгээмэл хэрэглэгддэг бол харин хамгийн түгээмэл загвар нь төрөөс аль болох тусдаа бие даасан байгууллагад сонгуулийн удирдлага, зохион байгуулалтыг хариуцуулж байгаа загвар бөгөөд бүтэц болон бүрэлдэхүүнээсээ хамааран “улс төрийн намын төлөөллөөс бүрдсэн”, эсвэл “мэргэжилтнүүдээс бүрдсэн” гэсэн хоёр хэлбэртэй байна. Манайхтай төстэй хуучин социалист орнуудад ихэвчлэн “улс төрийн намын төлөөллөөс бүрдсэн” хэлбэрээс аажмаар “мэргэжилтнүүдээс бүрдсэн” байгууллага болгон өөрчлөх хандлага түлхүү ажиглагдаж байна.

Сонгуулийн байгууллага нь нэгдүгээрт бүрэлдэхүүний хувьд, хоёрдугаарт төсөв санхүүгийн хувьд хараат бус байх шаардлагатай. Гэтэл манай Сонгуулийн Ерөнхий Хороо анхнаасаа л нэг намын төлөөлөл давамгайлсан бүтэцтэй явж ирсэн байдаг. Мөн СЕХ-ны дарга, нарийн бичгийн даргыг хорооны гишүүд дотроосоо өөрсдөө сонгох биш харин УИХ-ын дарга санал болгохоор зохицуулсан байгаа нь эрх барьж буй намын зүгээс СЕХ-ны хараат бус байдалд нь нөлөөлөх боломжтой байна. Төсвийн хувьд ч УИХ-аас бүрэн хараат байдалтай байна. СЕХ-ны гишүүд намаасаа “түдгэлздэг” ч сонгуулийн дараа гишүүнчлэлээ сэргээх боломжтой учир намаасаа хараат байдал хадгалагдаж байдаг, түүнчлэн СЕХ-ны гишүүдийг УИХ-ын гишүүд, байнгын хороод дуртай цагтаа дууддаг зэрэг зөрчилтэй хэм хэмжээнүүдийг өөрчлөх нь зүйтэй байна.

УИХ-ын 2012 оны сонгуулиас өмнөх сонгуулиудад түгээмэл ажиглагдаж байсан алдаа бол санал тоолох ажиллагаанд цаг хугацаа алддагаас сонгуулийн дүнг зарлах хугацаа удааширдаг, сонгуулийн доод шатны хороод нь дээд шатны сонгуулийн хорооноос гаргасан шийдвэр болон үүрэг даалгаврыг биелүүлдэггүй, сонгуулийн хороодын бүрэлдэхүүн улс төрийн намуудын төлөөллөөс бүрддэг зэргээс үүдэлтэй зөрчил, дутагдлууд нь сонгуулийн тогтолцооноос гадна сонгуулийн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөн шинэчлэх зайлшгүй шаардлагатайг харуулсан. Тухайлбал Улсын Их Хурлын 2008 оны ээлжит сонгуулийн үеэр сонгуулийн тойрог, хэсгийн хороодын үйл ажиллагаанд улс төржиж талцах, санал хураалтын дүн гаргахгүй удах зэрэг алдаа дутагдал гарч улмаар иргэдийн хардлага, эсэргүүцэл даамжирч тэр нь нийтийг хамарсан үймээн болсон явдал томоохон сургамж болсон юм.

Иймээс бүх шатны сонгуулийн байгууллагыг улс төрийн талцлын талбар болгохгүй, зөвхөн хуульд захирагдан үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд зөвхөн төрийн захиргаа болон үйлчилгээний албан хаагчдыг томилж, тэдгээрт ноогдуулах хариуцлагыг чангатгаж өгсөн. Энэ нь өмнөх сонгуулиудаар гарч байсан намын төлөөллөөс бүрдсэн сонгуулийн хороодын гишүүдийн ашиг сонирхлын зөрчлөөс үүдэлтэй маргааныг хааж, сонгуулийг хууль дүрмийн дагуу сахилга баттайгаар зохион байгуулж явуулах үр дүнтэй зохицуулалт болсон гэж Сонгуулийн ерөнхий хорооноос дүгнэсэн. Судлаачийн зүгээс

үүнийг дэвшилтэт алхам болохыг хүлээн зөвшөөрч байгаа ч эцсийн зөв шийдвэр гэж үзэхгүй байна.

Монгол Улсад 2010 онд явагдсан иргэний шинэчилсэн бүртгэлийн мэдээллийн сан, иргэний цахим үнэмлэхийг үндэслэн сонгогчдын нэрсийн жагсаалтыг үйлдэж давхардлыг арилгасан нь томоохон эерэг өөрчлөлт болсон.

УИХ-аас 2011 онд Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийг баталж, сонгуулийн үйл ажиллагаанд хүнээс хамаарах сөрөг үр дагавруудыг арилгах зорилгоор сонгогчийг бүртгэх, сонгуулийн санал авах, тоолох, дүн гаргах, дамжуулах үйл ажиллагаанд автомат техник хэрэгсэл ашигласан нь сонгуулийн зохион байгуулалтад шинэлэг зүйл болсон хэдий ч ээдрээтэй олон асуудлыг бидэнд авчирсан нь үнэн юм.

Шударга сонгуулийг зохион байгуулах өөр нэгэн нэн чухал хүчин зүйл бол иргэний нийгмийн хяналт, сонгогчдын боловсролын асуудал байдаг. Цаашид сонгуулийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах, сонгогчдын боловсролд чиглэсэн далайцтай ажлуудыг хийх нь зүйтэй байна. Сонгуулийн хороод сонгуулийг хуулийн дагуу үр дүнтэй зохион байгуулах, сонгогчдын боловсролын асуудалд анхаарал хандуулж, хангалттай мэдээлэл олгохын тулд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах зэрэг эрх зүйн өөрчлөлтийг боломжит цаг хугацаанд буюу ээлжит сонгууль болохоос нэгээс доошгүй жилийн өмнө хийж байх нь цаашид анхаарах асуудлын нэг юм.

Сонгууль бол тодорхой тогтоосон хугацаанд явагдаад өнгөрдөг онцлогтой. Энэ онцлогт нь тохируулан сонгуулийн аливаа маргааныг түргэн, шуурхай шийдвэрлэх оновчтой зөв процесс шаардлагатай байна. Өмнө нь сонгуулийн үед гарсан гомдол маргааныг тухайн шат шатны сонгуулийн хороод харъяалан шийдвэрлэхээр зохицуулж байжээ. Сонгуулийн хууль зөрчсөн зөрчил мөн эсэхийг тогтоох, хуулийг нэг мөр зөв ойлгож хэрэглэх зэрэг олон зүйл дээр дутагдалтай байдлууд гарч байлаа.

Харин УИХ-аас 2011 онд батлагдсан сонгуулийн тухай хуульд зааснаар сонгуулийн хороодын бүрэлдэхүүн, үйл ажиллагаатай холбоотой гомдлоос бусад гомдол маргааныг тухайн нутаг дэвсгэрийн харъяа захиргааны хэргийн шүүх шийдвэрлэхээр хуульчилсан зохицуулалт нь харьцангуй оновчтой болсон гэж СЕХ дүгнэсэн.

Гэвч сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх талаар шүүх байгууллагын эрх мэдэл тодорхой бус, хуулийн хэрэгжилт, холбогдох дүрэм, журмын талаарх олон нийтийн мэдлэг, мэдээлэл ч дутмаг байна. Цаашилбал сонгуулийн хороодын шийдвэрийг шүүх түдгэлзүүлэх нь иргэний сонгох, сонгогдох эрхийн зарчимд нийцэж буй эсэхийг нухацтайгаар авч үзэх шаардлагатай.

2011 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд сонгогчдын саналыг татах зорилгоор бэлэн мөнгө, эд бараа тараах зэрэг хууль бус үйлдлийг хориглож, хариуцлагыг чангатгасан. Гэсэн хэдий ч нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах үндэслэлүүдийг ялгамжтай байдлаар нарийвчлан зохицуулж, тодорхой болгох шаардлага байгаа нь өнгөрсөн сонгуулийн үеэр харагдаж байлаа.

Мөн дахин санал хураалт нь иргэдийн сонгуульд оролцох идэвх болон түүнд итгэх итгэлийг буруулдаг, үргүй зардал, үр дүнгүй улс төржилт, хоосон хардалт төрүүлдэг, сонгуулийг сунжруулсан зэрэг олон сөрөг үр дагавар гарч байсан тул цаашид дахин санал хураалтад оролцож буй сонгогчдын ирцэд босго хувь тогтоохгүй байх асуудлыг хуульчлах шаардлагатай байна гэсэн хүсэлтийг сонгууль зохион байгуулсан байгууллагын зүгээс гаргаад байгаа билээ.

Сонгуулийн төгс тогтолцоог хүн төрөлхтөн одоог хүртэл эрж хайсаар байна. Монгол Улсын хувьд өөрийн орны онцлог, улс төрийн намуудын төлөвшил, чиг хандлага, сонгогчдын боловсрол зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан сонгуулийн тогтолцоог цаашид боловсронгуй болгох нь чухал юм.

Сонгуулийн санхүүжилт, түүний ил тод байдал гэдэг Монгол дахь “сонгууль” хэмээх цогц үйл явцын хамгийн ээдрээтэй, нууцлагдмал, араасаа хэл ам дагуулсан сэдэв. Монголд аль ч шатны сонгуульд нэр дэвшигчдэд өгөх хандвийн дээд хэмжээг иргэн 1 сая, хуулийн этгээд 3 сая, харин Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид иргэн 10 сая, хуулийн этгээд 50 сая төгрөг хүртэл байхаар хуульчилж өгчээ. Мөн бэлэн мөнгөөр хандив өгөхийг хориглосон, нам, эвсэл, нэр дэвшигчдээс зарцуулах зардлын дээд хэмжээг тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, хүн амын тоо зэргийг харгалзан ялгавартай тогтоохоор хуульчилсан нь сайшаалтай.⁸⁶ Харин энэхүү асуудлыг хэрхэн ил тод байлгахаар тусгасан бэ?

Монгол улсын тухайд сонгуулийн санхүүжилттэй холбоотой мэдээлэлд: “Сонгуулийн зардлын санд тухайн намаас оруулах хөрөнгийн хувь хэмжээ”, “Аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан сонгуулийн зардлын тайлан”, “Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данс байршсан банк дахь сонгуулийн зардлын дансны гүйлгээг нэгтгэсэн тайлан”-г тус тус тусгасан бөгөөд нам, эвсэл, нэр дэвшигч, банкны захирал зэрэг субъектын зүгээс тодорхой хугацаанд багтаан холбогдох сонгуулийн байгууллагад гаргаж өгөхөөр хуульчилсан байна.

Харин улс төрийн нам, хандивлагч сонгуулийн санхүүжилттэй холбоотой мэдээллээ олон нийтэд ил тод болгох талаар сонгуулийн хууль тогтоомжид тусгаагүй байна. Гагцхүү сонгуулийн зардлын тайлан, банкны захирлын гүйлгээг нэгтгэсэн тайланг хүлээн авсан холбогдох шатны сонгуулийн байгууллага тайланг хянаж, сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 45 хоногийн дотор “Сонгуулийн зардлын тайланг хянаж нэгтгэсэн дүн”, “Тодорхой үнийн дүнгээс дээш хандив өргөсөн иргэн, хуулийн этгээдийн нэр, хандивын хэмжээ”-г тус тус иргэд сонгогчдод нээлттэй болгохоор заажээ.

Бодит байдал дээр сонгуулийн санхүүжилттэй холбоотой мэдээллийг олж авах арга зам төдий л хүртээмжтэй бус, нөгөөтэйгүүр энэ бүх мэдээлэл олдлоо ч сонгуулиас хойш 45 хоногийн дараа л олдох боломжтой болж байгаа нь сонгогчдод сонголтлоо хийхэд ямар ч нөлөөгүй, нам, эвсэл, нэр дэвшигчдэд тооцох хариуцлагыг сулруулж байна. Эцэст нь “Сонгуулийн зардлын тайлан”-гаа гаргаж өгөөгүй хариуцлагатанд багахан хэмжээний торгууль ноогдуулахаар заасан нь хэтэрхий хөнгөн шийтгэл юм.

Иймд нам, эвсэл, нэр дэвшигчид, хандивлагчдад сонгуулийн санхүүжилттэй холбоотой мэдээллээ нээлттэй болгох үүргийг хуульчлах, сонгуулийн санхүүжилттэй холбоотой мэдээллүүдийг сонгуулийн кампанит ажлын хугацаанд 7 хоног тутам цахим хуудаст байршуулж байх, тайланг хөндлөнгийн итгэмжлэгдсэн аудиторчдоор шалгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж байх зэргийг нарийвчлан зохицуулж хуулинд тусгах шаардлагатай байна.

Энэ бүхний цаана байгаа суурь асуудал болох сонгуульд нэр дэвшигчид, улс төрийн намуудын сонгуулийн зардлын хэмжээг хэрхэн багасгах вэ гэдэг асуудал улс төр судлаачдын нэн даруй анхаарлаа хандуулах шаардлагатай сэдвийн нэг. Уг асуудал нааштайгаар шийдвэрлэгдэхгүйгээр, сонгууль мөнгөний уралдаан болсоор байвал сонгуулийн шударга, чөлөөт өрсөлдөөн, бодлогын уралдаан, олон намын тогтолцоо, эмэгтэйчүүдийн оролцоо зэрэг тулгамдсан асуудлууд нааштайгаар шийдвэрлэгдэх боломж хомс юм.

Улс төрийн зарим намыг татан буулгах тухай яриа маргаан дагуулав. Аль нэг намын санаачилгаар бусад намуудыг татан буулгах нь юу л бол харин ийм яриа гарахад хүргэж буй учир шалтгааныг өөрөөсөө олж харах явдал “жигжиг” гэгддэг намуудад нэн чухал.

⁸⁶ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2011), Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (2012)

Сонгуулийн кампанит ажлын арга, хэлбэр, технологид сонгуулийн хуульд оруулсан өөрчлөлтүүд, техник, технологи, цахим ертөнцийн хөгжил зэргээс үүдэн олон өөрчлөлт орж байна. Сонгуулийн хууль энэ бүх өөрчлөлтийн хурдыг гүйцэж, улмаар оновчтой зохицуулж байх шаардлагатай.

Сонгуулийн булхай луйвар гэсэн сөрөг үзэгдлийн тухай яригдах үед түүний ихэнх нь сонгуулийн кампанит ажлын хүрээнд болсон байдаг. Улс төрийн намууд болон нэр дэвшигчдийн сонгуулийн кампанит ажлын үе дэх ёс зүйн болон эрх зүйн хариуцлагыг дээшлүүлж, хариуцлага тооцох арга механизмыг тодорхой болгох нь сонгууль шударга явагдах нэг үндсэн нөхцөл юм.

Сонгуулийн кампанит ажлыг шударга явуулахад дан ганц эрх зүйн хариуцлага хангалтгүй бөгөөд гагцхүү ёс зүйн хариуцлага хүлээлгэх арга механизмтай хамт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын хяналттай хамт байж гэмээнэ үр дүнгээ өгнө.

Дэлхий даяар сонгууль явуулдаг, ардчилсан гэх тогтолцоотой 130-аад орон байна. Ардчилсан гэж өөрийгөө үздэг, тийм байхыг хичээдэг бүх л орны Үндсэн хуульд улс төрийн засаглалын үндэс нь ард түмний хүсэл зориг гэсэн зарчим тунхаглагдсан байдаг. Тиймээс Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөө бүлэгт байгаа сонгох, сонгогдох эрх бүрэн утгаараа хэрэгжихэд сонгуулийн үед улс төрийн намуудаас гаргаж буй сонгуульд нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт, түүний эрэмбэд сонгогчид ямар ч нөлөө үзүүлэх боломжгүй байгаа явдал ардчиллын зарчимд хэрхэн нийцэж байгаа зэрэг нь асуудал дагуулсаар байна.

Сонгуулийн хууль хэнд зориулагдсан хууль вэ? Энэ хууль улс төрийн намуудад бус сонгогчдод зориулсан хууль. Нэг талаас Монголын сонгогчдын тодорхой хэсэг хувь тэнцүүлэх тогтолцооны давуу талыг сайн мэддэг ч харьцангуй хол хөндий санагддаг бөгөөд улс төрийн намын санхүүжилтийн асуудал ил тод болж чадаагүй, намын дотоод ардчилал сул байгаа өнөөгийн нөхцөлд улс төрийн намын төлөвшилтөд сөргөөр нөлөөлнө гэж үзэх хандлага хадгалагдаж байна. Нөгөө талаас улс төрийн намын удирдлагууд болон намын нэр нөлөөгөөр улс төрийн алба хаших сонирхолтой хэсэгт өнөөгийн сонгуулийн холимог тогтолцоо дахь хувь тэнцүүлэх тогтолцооны эзлэх хувийг нэмэгдүүлэх, улмаар хувь тэнцүүлэх тогтолцоог дэмжих сонирхол байх нь тодорхой. Гэвч эцэст нь Америкийн эрдэмтэн Ж.Коломерын “улс төрийн намууд сонгуулийн системээ сонгодог” хэмээсэн үзэл баримтлал хэрэгжих нь дамжиггүй.

Ном зүй

Алмонд Г ба бусад Харьцуулсан улс төр: онолын хүрээ УБ.,

Лийпхарт А. Ардчиллын хэв загвар. УБ., 2008

Чимид Б. Сонгуульд суралцахуй. УБ., 2012

Монгол дахь ардчиллын хөгжил: сорилт, боломж үндэсний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2005

Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2009

Монгол улс дахь Үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2013

Р.Даль. Ардчиллын тухай. УБ., 2004

Монгол Улсын Үндсэн хууль. (1992)

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. (2005)

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. (2011)

<http://www.1212.mn/>

МОНГОЛЫН СОНГОГЧДЫН УЛС ТӨРИЙН ҮЙЛ БАЙДАЛ БА НАМУУД

С.МӨНХБАТ

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, доктор(Ph.D), дэд профессор

Илтгэлийн агуулга

1. Сонгогчдын улс төрийн үйл байдал, түүнийг судлах арга зүйн асуудал
2. Монголын сонгогчдын улс төрийн үйл байдал, гарч буй өөрчлөлт
3. Сонгогчдын улс төрийн үйл байдалд намуудын нөлөө /ерэг, сөрөг/
4. Дүгнэлт

Нэг. Сонгогчийн улс төрийн үйл байдал, судлах арга зүйн асуудал

Төлөөллийн ардчиллын суурь, амин чухал асуудал нь иргэд өөрийн ирээдүйн төлөө шийдвэр гаргах үйл явцад шууд оролцож санал өгөх, төрийг байгуулах үйл хэрэгт сонгуулиар дамжуулж оролцох явдал байдаг. Сонгууль улс төрийн үйл явц учраас түүнд оролцох, хандах иргэдийн үнэлэмжийг судалж шинжлэх буюу сонгогчийн улс төрийн үйл байдлын судалгаа бол улс төрийн шинжлэх ухаан дахь судалгаа, шинжилгээний бие даасан хүрээ юм.

Англи хэлний “*behavior*”⁸⁷, Орос хэлний “*поведение*”⁸⁸ гэдэг үгийг “үйл байдал” гэдэг утгаар ХХ зууны эхээр социологи, сэтгэл судлал, улс төрийн шинжлэх ухаанд хэрэглэж байсан бөгөөд хожмоо улс төрийн шинжлэх ухаанд иргэд, сонгогчдын үйл байдлыг илэрхийлэх утгаар хэвшин тогтож энэ чиглэлийн дагнасан судалгаанууд өрнөдийн орнуудад тухайлбал, АНУ-д их хийгдсэн байдаг. Улс төрийн шинжлэх ухаанд энэ чиглэлээр бие даасан судалгааны чиглэл ч (бихевиоризм) хөгжиж байгаа бөгөөд энэ чиглэлийн судалгааны гол объект нь шалгаж болохуйц бодитой мэдээлэлд үндэслэсэн сонгогчдын улс төрийн үйл байдал⁸⁹ юм.

Үйл байдал хэмээх үгийг монгол хэлэнд янз бүрийн утгаар хэрэглэж ойлгодог байдал байсаар байна. Улс төр судлал, эдийн засаг, кибернетик, философи, сэтгэл судлал зэрэг шинжлэх ухаанд үйл байдал гэсэн ойлголтыг өөр хоорондоо ялгаатайгаар хэрэглэдэг. Үүнийг тухайн шинжлэх ухааны аспекттай, цаашилбал судлаачдын өөрсдийн үзэл баримтлалын ялгаатай байдалтай холбон тайлбарлаж байна. Жишээлбэл кибернетикийн шинжлэх ухаанд үйл байдал гэдэг үг нь системүүдийн хандлага, төлөв байдал гэсэн утгыг илэрхийлдэг бол сэтгэл судлалд зан төрх, авир гэсэн агуулгаар, харин улс төр судлалд “сонгогчийн үйл байдал, үйл хөдлөл” гэсэн утгаар судалж, хэрэглэсэн байдаг.

Эдгээр асуултуудад өгч буй хариултууд олон янз бөгөөд асуудлын аль нэг талыг голлосон судалгааны олон хандлагууд бий болж байна. Гэвч иргэдийн улс төрийн үйл байдлын асуудал нь төсөөлж байгаагаас ч илүү нарийн төвөгтэй юм. Энэ нь уг

⁸⁷ International Encyclopedia of Political Science. IPSA., 2012.

⁸⁸ Политическая энциклопедия. Москва., 1999. стр. 146

⁸⁹ Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2011. 379 дахь тал

үзэгдлийн өөрийн нь нарийн нийлмэл шинж, түүнийг судлахад хэрэглэж буй аргазүйн олон янз хандлагууд, түүнчлэн үндсэн ойлголтын нэр томьёоны тодорхой бус байдалтай холбоотой байна. Ялангуяа улс төрийн шинжлэх ухааны уламжлалт нэр томьёоны тодорхойгүй байдал онцгой хүндрэл учруулж байгаа юм. Учир нь иргэдийн улс төрд хандах үйл байдлыг тодорхойлохдоо улс төрийн оролцоо, улс төрийн идэвхи, санаачилга, улс төрийн үйл ажиллагаа гэсэн ойлголтуудтай хольж хутгах, тэдгээрийн агуулгын ялгааг тодорхой болгох зэрэг цаашид анхаарууштай асуудлууд байсаар байгааг энд дурьдая.

Улс төрд хандах иргэдийн үйл байдал, улс төрийн идэвхийн тухай асуудал эртнээс олон орны судлаачдын анхаарлыг татсаар ирсэн байна. Өргөн утгаар нь авч үзвэл сонгогчийн үйл байдлын судалгаа ардчилсан нийгэм, түүний системүүд үүргээ хэрхэн биелүүлж, иргэд тэдгээрийг юу гэж ойлгож, тэдгээрт хэрхэн хандаж буйг харуулдаг. Тиймээс сонгогчийн үйл байдлыг судалгаа дараах асуултад хариулахаас эхэлдэг. Үүнд Хүмүүс хэнийг сонгодог вэ?, Тэд яагаад сонгодог вэ?, Юуг хүсэж, бодож тэд сонголт хийдэг вэ? гэсэн асуултауд юм. Сонгогчдын санал өгч сонголт хийх чадварын тухай асуудал псефологчдын (хүмүүс сонгуульд саналаа хэрхэн өгдгийг судалдаг салбар) анхаарлыг ямагт татсаар ирсэн асуудлын нэг юм.

Сонгогчийн үйл байдлын судалгаа олон жил хөгжихдөө *социологийн, нийгэм-сэтгэл зүйн болон рациональ (ухаалаг) сонголтын*⁹⁰ гэсэн 3 гол хандлагаар явж иржээ. Социологийн хандлага (С.Липсет, С.Роккан, Пауэль Ф.Лазерфельд, Ч.Э.Мерриам, Г.Ф.Госнем)-ын чармайлтын үр дүнд сонгогч хувь хүний улс төрийн үйл байдлыг түүний харьяалагдаж буй нийгмийн бүлэг, болон нийгэмд эзэлж буй байр суурийнх нь онцлогоор гаргаж ирэхэд анхаардаг. Энэ судалгаа сонгогчдын санал өгөлтөд нийгмийн хамаарал шууд нөлөөтэй байдгийг харуулдаг. Сонгогчийн үйл байдлыг судлах социологийн чиг хандлага нь өнгөрсөн зууны 50-иад оноос хөгжсөн бөгөөд сонгогчдын дунд санал асуулга авах замаар социологийн судалгаа явуулж сонгогчийн үйл байдлын төлөвийг судалж гаргадаг онцлогтой. Тоон судалгаан дээр суурилан бие хүний нийгмийн шинж онцлогууд болон түүн дээр үндэслэн сонгогчдын санал өгөх сэдлийн харилцан хамаарлын гаргах замаар шинжилгээ хийнэ гэсэн үг. Ингэхдээ нийгэм, ангийн байдал (зүүн чигийн нам- ажилчин анги, баруун чигийн нам-дунд анги), шашин, үзэл суртал, нийгмийн хувьсагч хүчин зүйлүүд (хүйс, нас, ажил мэргэжил, боловсрол, нийгмийн гарал, арьс өнгө, намын харьяалал, орлого, амьжиргааны түвшин гэх мэт)-ийг суурь болгон ашигладаг. Сонгогчийн үйл байдлыг судлах социологийн арга, хандлага нь дотроо микро, макро гэсэн 2 түвшинд хуваагддаг. Микро түвшний арга, хандлагын гол санаа нь тухайн сонгогчийн хамаарах бүлгийн сонгуулийн оролцооны хэм хэмжээ нь жигд болох тусам тус бүлэгт хамаарах сонгогчийн гаргасан шийдвэр бүлгийнхээсээ ялгарах магадлал бага байна. Хоорондоо зөрчилтэй хүчин зүйлс нэмэгдэж бүлгийн доторх сонгогчдын байр суурь зөрөх үед тэдний улс төрийн шийдвэр гаргах байдал эрс ялгаатай болох магадлал ихэсдэг гэж үздэг байна. Иймээс ч сонгогчийн улс төрд хандах хандлага, санал бодол төлөвших хийгээд сонгуульд оролцож санал өгөхөд социал хүрээний үзүүлэх нөлөө хүчтэй гэдгийг тэд гол болгодог юм. Харин макро түвшний арга, хандлага нь төр, улс төрийн намуудын тогтвортой дэмжигчдийн хүрээ, өөрчлөлтийг тандахад чиглэдэг. Энд нийгэм дэх үнэт зүйлсийн эрхэмлэл, намуудад өөрийгөө адилсуулах үйл явц зэрэг хамаардаг.

Харин нийгэм-сэтгэл зүйн хандлага (А.Кемпбелл, Ф.Конверс, В.Миллер, Д.Стоке⁹¹, Ж.Еванс⁹², Х.Вейсберг⁹³)-ын шинжилгээ нь бие хүний сэтгэл зүйн хандлага

⁹⁰ International Encyclopedia of Political Science. IPSA., 2012. p. 738

⁹¹ Campbell, A., Converse, P.E., Miller, W.E., & Stoke, D.E. The American voter. New York., 1960

⁹² Evans, J. Voters and Voting; An Introduction. London., 2004

⁹³ Lewis-Beck, M., Jacoby, W. G., Norpoth, H., & Weisberg, H. The American voter revisited. University of Michigan Press., 2008

нь сонгогчийн сонгуульд сонголт хийж санал өгөх гол үндэс нь болдог талаар дүгнэдэг. Нийгэм-сэтгэл зүйн хандлага нь сонгогчид руу хандсан улс төрийн нарийн бодлого болон сонгогчдын санаа бодлын тогтворгүй байдлын хоорондын асуудал дээр төвлөрч сонгогчдын сэтгэл зүйн тогтсон хандлага болон ухамсарлагдаагүй харилцаа тэдний сонголт хийх шийдвэрт хэрхэн нөлөөлдөг болохыг тодруулахад чиглэдэг. Тухайлбал, сонгогчдын олонхи нь яагаад нэг нам руу хошуурч саналаа өгдөг вэ?, сонголт хийхэд цаг үеийн нөхцөл, нийгмээс үзүүлж буй дарамт, шахалт эсвэл дэмжлэг хүний сэтгэл зүйд хэрхэн нөлөөлдөг вэ? зэрэг асуултуудад хариулт өгөхөд чиглэдэг. Гэхдээ энэ хандлагын суурь нь улс төрийн нийгэмшилт байдаг. Энд мөн улс төрийн нам, улс төрчдийг тууштай дэмжигчдийн идэвхтэй үйл ажиллагаа чухал нөлөө үзүүлдэг.

Рациональ сонголтын хандлагын шинжилгээ нь эдийн засгийн үр ашигтай, оновчтой байх онолоос хөгжиж гарч ирсэн. Сонгогчид улс төрийн нам, нэр дэвшигчдээс сонголт хийх эцсийн мөчид саналынхаа өөрт ирэх ашиг тус, үнэ цэнийг бодож сонголтоо хийдэгт оршино. Рациональ сонголтын хандлага (А. Даунс⁹⁴, Р.Далтон⁹⁵) нь АНУ-ын судлаач Э.Даунсын “Ардчиллын эдийн засгийн онол⁹⁶” хэмээх бүтээлд тусгалаа олсон байдаг. Энэхүү арга зам, хандлагаар сонгогч нь сонгуульд санал өгөхдөө үр ашгийн тооцоонд суурилдаг аж. Ингэхдээ тэрээр засгийн газрын өнгөрсөн бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагаанд үнэлэлт өгч одоогийн сөрөг хүчин засгийн эрхэнд байсан бол юу хийж чадах байсан гэдэгт харьцуулж үздэг. Үүний үндсэн дээр тэрээр өөрийнх нь хувийн зорилтуудыг хамгийн түрүүнд хэрэгжүүлж чадна гэж үзсэн намын төлөө саналаа өгдөг. Ийнхүү энэхүү хандлагаар сонгогчийн шийдвэр эцсийн бүлэгт улс төрийн тулгамдсан асуудал, эрх баригч болон сөрөг хүчний дүр төрх, инфляцийн түвшин, ажилгүйчүүдийн тоо, эдийн засгийн өсөлт зэрэг үзүүлэлтээс хамаардаг бөгөөд нийгмийн байдал болон урт хугацааны турш өөрчлөгдөөгүй байсан намын талаарх байр суурь нь гол бус үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл улс төрийн болон эдийн засгийн шийдвэрийг үндсэндээ ижил зарчмаар гаргадаг гэж үздэг. Энэ хандлагыг богино хугацааны элемент гэж нэрлэх тал ч бий. Энэ хандлага дээр нэг шүүмжлэл явдаг нь сонгогчид тухайн үеийнхээ ашгийг харснаас цаг хугацаагаар алслагдсан хүсээгүй зүйлийг тооцоогүй байж болох бөгөөд үүгээрээ өөрийн харалган байдлыг харуулдаг⁹⁷ гэжээ.

Хоёр. Монголын сонгогчдын улс төрийн үйл байдал, гарч буй өөрчлөлт

Монгол улс ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжээд даруй 23 жилийн нүүрийг үзжээ. Энэ хугацаанд манай сонгогчид УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн Төлөөлөгчдийн хурлын гээд нийт 17 удаагийн (дахин болон нөхөн сонгуулийг оруулахгүйгээр) сонгуульд оролцож саналаа өгсөн байна. Өөрөөр хэлбэл Монголын сонгогчид энэ бүхий л хугацаанд ардчилсан сонгуулийн зарчим, шаардлага, дэг жаяг, ёс зүйгээс суралцаар ирсний зэрэгцээ тэдний нийгэм сэтгэл зүйн хандлага, улс төрийн үйл байдал хувьсан өөрчлөгдөж ирсэн байна. Монголын сонгогчдын үйл байдлын шинж, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулан гаргахын тулд миний бие энэ талаар хийгдсэн эрдэмтэн судлаачдын судалгаа, сонгогчдын дунд хийгдсэн тоон болон чанарын судалгаанууд дээр үндэслэн анализ хийхийг оролдов.

Сонгогчдын улс төрийн үйл байдал нь *сонгуулийн бус үед болон сонгуулийн кампанийн үед төлөв байдлын хувьд нэлээдгүй ялгаатай болдог*. Сонгуулийн кампанийн үеэр сонгогчдын үйл байдлын өөрчлөлт, хувирал нь “их хөөсрөлт”-тэй

⁹⁴ A.Downs. An Ecomomic theory of democracy. New York.,1957

⁹⁵ Dalton. R. Citizen politics: Public opinion and political parties in advanced industrial democracies. Washington., 2008

⁹⁶ A.Downs. An Ecomomic theory of democracy. New York., 1957

⁹⁷ Улс төрийн шинжлэх ухаан. МУИС. Улс төр судлалын тэнхим., 2010. 389 дахь тал

байдаг бол сонгуулийн бус үед энэ хөөсрөлт буурч улс төрд хандах иргэдийн үйл байдал энгийн горимд шилжиж байдаг.

Өнөөдрийг хүртэлх хугацаанд Монголын сонгогчдын улс төрийн байдал нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, улс төрийн үзэгдэл, үйл явцыг даган хувьсан өөрчлөгдөж ирсэн бөгөөд энэхүү чиг хандлагыг тодорхойлохын тулд цаг хугацааны хувьд сонгуулийн мөчлөгтэй нь уялдуулан авч үзэх⁹⁸ нь арга зүйн хувьд оновчтой байж болох талаар зарим судлаачид, судалгааны бүтээлд бичсэн байгааг хүлээн зөвшөөрч болох юм. Гэхдээ миний бие сонгуулийн бус үед сонгогчдын улс төрийн үйл байдалд гарч буй өөрчлөлт, шилжилтийг сонгуулийн мөчлөг гэхээсээ илүүтэй нийгэм, эдийн засаг, оюун санаа, социаль хүрээнд өрнөж буй өөрчлөлттэй уялдуулан авч үзэх нь чигийг барьж энэхүү илтгэлээ бэлдлээ. Учир нь сонгогчдын улс төрийн үйл байдалд шууд нөлөө үзүүлэгч үндсэн суурь хүчин зүйлс бол нийгэм, ахуйн (эдийн засгийн) өөрчлөлтүүд байдаг.

Монгол улс ардчилалд шилжээд 23 жилийн нүүрийг үзэхдээ улс төрийн ардчиллын зарчмууд, үнэт зүйлсийг өөрийн орны хөрсөнд нутагшуулан соёолуулах талаар чамлахааргүй амжилт гаргасныг тэмдэглэх хэрэгтэй. Энэ хугацаанд хүний эрх, эрх чөлөөний тухай үзэл баримтлалд тулгуурласан ардчилсан Үндсэн хуультай боллоо. Эрх зүйт төр, иргэний нийгмийг бэхжүүлэх зүгт шийдвэртэй алхамуудыг хийв. Чөлөөт бүх нийтийн сонгуулиар УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн ИТХ-ыг сонгодог болов. Парламентад ёс, түүний институт бүрэлдэн тогтож засаглалыг хуваах зарчим зохих хэмжээгээр биеллээ оллоо. Олон намын систем тогтож, олон ургальч үзэл дэлгэрэв. Иргэний ба улс төрийн эрх, эрх чөлөөг иргэд бодитой эдлэх улс төр, эрх зүйн үндэс тавигдлаа. Иргэдээс улс төр, улс төрийн систем дэглэмд хандах хандлага, чиг баримжаа өөрчлөгдөж Монголын улс төрийн соёлд гүнзгий өөрчлөлт гарлаа⁹⁹.

Энэ бүхний үр дүнд Монголд ардчилал цаашид бэхжих хөрс суурь бэхжиж байна. Монголын ард иргэдийн сэтгэл зүйд ардчиллыг хөгжүүлэх хүсэл эрмэлзэл баттай бий болсныг манай байгууллагуудын хийсэн судалгааны дүнгээс харж болно. Ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжиж цаашид энэ замаар замнах нь зайлшгүй гэдэг дээр манай иргэдийн дийлэнх нь (85%)¹⁰⁰ санал нэгтэй байна. Мөн гадаадын судлаачид ч өөр өөрсдийн үнэлэлт дүгнэлтээ өгсөөр байна. Тухайлбал Азийн барометр судалгааны эмхэтгэлд Монгол нь Зүүн Европоос гадна коммунизмаас чөлөөт өрсөлдөөнт олон намын систем бүхий капиталист ардчилалд амжилттай шилжсэн цорын ганц орон гэдгийг тэмдэглэх хэрэгтэй¹⁰¹ гэсэн байна.

Ийнхүү ололт амжилтууд байгаа хэдий ч ардчилсан нийгмийн тогтолцоонд бүрэн шилжиж ардчиллыг бэхжүүлэх үйл явцад эргэлт буцалтгүй орлоо гэж дүгнэхэд хараахан эрт байна. Бид сүүлийн 23 жил нийгмийн бүх хүрээг хамарсан өөрчлөлтийн үйл явц, тэр дундаа ардчиллын хөгжлийг судлахдаа хэт ерөнхийлсөн, танин мэдэж суралцахуйн шинж давамгайлсан байдлаар хандаж ирснээс үүдээд түүнд эерэг болон сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлүүдийн талаар нарийвчлан задлан шинжилсэн судалгаа орхигдож ирсэн. Үүнээс үүдэн нийгэмд хуримтлагдан буй бэрхшээлтэй асуудлуудын гүнд, мөн чанарт нэвтэрч чадахгүйд хүрэх, шийдвэрлэх зөв гарц, шийдлийг олох эрэл хайгуулд мухардалд орох явдал цөөнгүй тохиолдох болов. Ардчиллын хөгжилд тохиолдож буй зарим хүндрэл, бэрхшээлүүд нь манай иргэдийн

⁹⁸ С.Одхүү, Ц.Заяхүү. Сонгогчдын нийгэм, сэтгэл зүйн төлөв байдал. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик. ЭШ-ний бага хурлын эмхэтгэл. УБ., 2009. 27 дахь тал

⁹⁹ Ш.Содном, Ц.Ганболд, Ё.Довчин. Монгол дахь ардчилах үйл явц ба сонгууль. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик. ЭШ-ний бага хурлын эмхэтгэл. УБ., 2009. 6 дахь тал

¹⁰⁰ Хүмүүс: улс төр-нийгмийн амьдрал сэдэвт суурь судалгаа. Нийгмийн Ардчиллын хүрээлэн. 2012 оны IX сар.

¹⁰¹ До Чүл Шин. Зүүн Ази дахь гуравдугаар давалгаа: Харьцуулсан ба динамик төлөв. Азийн барометр. УБ., 2008. 14 дэх тал.

ардчиллыг ойлгох хэт ерөнхий хийсвэр ойлголт, төсөөлөл, улс төрийн ухамсар, соёлын доогуур түвшинтэй холбоотой байгааг ч судалгааны байгууллагуудын хийсэн судалгаанууд нотлон дүгнэсэн байна. Тухайлбал Нийгмийн Ардчиллын хүрээлэн, Максима, Сант марал болон ШУА-ийн ФСЭХ зэрэг байгууллагуудаас хийсэн судалгаагаар манай иргэд сонгогчид ардчиллыг эрх чөлөө, чөлөөт байдал, ил тод шударга зарчим, хувийн өмч зэрэг ардчиллыг үнэлэх ерөнхий ойлголт талаас нь үнэлж, иргэдийн оролцоо, ард түмний засаглал, чөлөөт сонгууль, тайлагнах, хариуцлага хүлээх зарчим зэрэг ардчиллыг үнэлдэг чанарын талын асуудлуудыг орхигдуулах, мэдэхгүй байх зэрэг байдлууд түгээмэл байгаа талаар ижил, ойролцоо дүгнэлтүүдийг гаргасан байна. Сант Марал судалгааны байгууллагаас хийсэн судалгаагаар¹⁰² Монголын ардчилал таны сэтгэлд хэр нийцдэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогсдын 24.3% нь нийцдэг, 41.3% нь бага зэрэг нийцдэг, 18.1% нь бараг нийцдэггүй, 9.3% нь нийцдэггүй, 7% нь мэдэхгүй гэж хариулснаас үзвэл ардчилал манай нийгмийн хөрсөнд бат сууж, сонгогчдын сэтгэлд гүн шингэсэн гэх хэлэх аргагүй байна. Энэ нь ардчилал Монголын хөрсөнд бодит агуулгаараа, тохирсон хэв загвараараа бууж чадаагүйн үр дүн мөн. Өөрөө хэлбэл иргэд ардчиллын “гол тоглогч” болох үйл явц явагдахгүй байгаагийн тод илрэл. Тийм учраас ардчиллын төлөвшилтөд суурь нөлөө үзүүлэгч хүчин зүйлсийн судалгааг нарийвчилж хийх зайлшгүй шаардлага тулгарч байна. Үүний нэг бол Монголын сонгогчдын үйл байдал, түүнд гарч буй өөрчлөлтийн асуудал мөн. Өөрөөр хэлбэл сонгогчийн улс төрийн үйл байдлыг улс төр, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөллөөр судлах явдал чухал байна. Өнөөдөр манай сонгогчдын улс төрийн үйл байдал улс төр, нийгмийн олон хүчин зүйлсээс хамааран тогтворт бус динамик шинж давамгайлсан төлөв байдалд байна.

Үүнийг би дараах хэдэн хүчин зүйлээр тайлбарлая.

1. Сонгогчийн улс төрийн үйл байдалд үзүүлэх социаль өөрчлөлтийн нөлөө.

Өнөөдөр Монголчуудын амьдралын хэв маяг материаллаг талаасаа их өөрчлөгдөж байна. Сүүлийн жилүүдэд нэн ялангуяа байгалийн баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулж эхэлснээр нийгэмд баян хоосны ялгаа улам нэмэгдэж энэ нь нийгмийн гишүүдийн сэтгэл зүй, тэдний улс төрийн үйл байдалд чухал нөлөө үзүүлж эхэллээ. Зэх зээл хөгжих тусам эдийн засгийн мэдлэг, мэргэшил, удирдлага, санхүү менежментийн арга барил өөрчлөгдөн хэн овсгоотой, хөрөнгө мөнгөтэй нь, хэн мэдлэг боловсролтой нь цаашид хол явахыг энэ үед хүчтэй мэдэрч эхэлж байна. Өмчийн харилцаан дээр суурилсан либераль ардчиллын үнэт зүйлс хүчтэй нэвтэрч байгаатай холбогдон Монголчуудын хамтач, нийтэч зан үйлийн уламжлал эвдэрч түүний оронд амиа хичээх, хувиа бодох үзэл, сэтгэлгээ манай иргэдэд (ялангуяа залуучуудад) төлөвшиж байна. Энэ байдлыг академич Г.Чулуунбаатар “Эх орон, ард түмэн, нийгмийн дэвшлийн эрх ашгийг илүү дээдлэх нийгэм, хүмүүнлэгийн итгэл үнэмшлээс хувийн эрх чөлөө, хангалуун тансаг амьдралын төлөө хүсэл эрмэлзэлд шилжиж байна”¹⁰³ гэж дүгнэсэнтэй санал нэг байгаа юм. Энэхүү “зэрлэг капитализм”-ын хөгжлийн зүй тогтол нь нэг талаар хувь хүний хөгжил, дэвшлийг хангадаг сайн талтай ч нөгөө талдаа баян хоосны ялгарлыг нэмэгдүүлж, нийгмийн олонхийг ядуурал руу хөтөлдөг сөрөг талтай. Өнөөдөр Монгол улс хүний хөгжлийн үзүүлэлтээр 186 орноос 108, амьдралын чанарын үзүүлэлтээр 192 орноос 107, эдийн засгийн өрсөлдөх чадвараар 144 орноос 93-т тус тус жагсаж байна. Энэ бол тийм ч таатай үзүүлэлтүүд биш бөгөөд бид Африкийн хөгжил буурай орнуудын түвшинд л байна гэсэн үг. Нийгмийн Ардчиллын Хүрээлэнгийн

¹⁰² Улс төрийн барометр. Сант Марал судалгааны төвийн судалгаа. УБ., 2009 оны 4-р сар

¹⁰³ Г.Чулуунбаатар. Олон нийтийн санаа бодол дахь сэтгэл зүйн зөрчлүүд. ХХ, ХХI зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт. УБ., 2008. 114 дэх тал

хийсэн цуврал судалгаануудаар¹⁰⁴ хүн амын дунд хамгийн тулгамдаж буй асуудлуудад дараах асуудлууд орсон байна. Үүнд,

- | | |
|-----------------------------------|---------|
| - Ажилгүйдэл, ядуурал | - 20.5% |
| - Архидалт, архичид | - 20.3% |
| - Авилга, хээл хахууль | - 18.5% |
| - Орлогын хомсдол | - 15.1% |
| - Улс төрийн хариуцлагагүй байдал | - 10.2% |
| - Байгаль орчны бохирдол | - 9.2% |

Судалгааны дүнгээс харахад иргэдийн ахуй амьдрал сайнгүй байгаа бөгөөд ядуурлын түвшин 36%, баян хоосны ялгааг хэмждэг жиний коэффициент 0.36% байгаа нь өндөр үзүүлэлт юм. Учир нь энэ процент 0.40%-иас дээш гарвал тухайн улсад мөргөлдөөн тэмцэл бий болох хөрс суурь бий болдог гэж үздэг. Нийгэм- эдийн засгийн энэ сул дорой байдал нь манай сонгогчдын улс төрийн үйл байдлын тогтворт байдал, улс төрийн оролцоо идэвхд сөргөөр нөлөөлж байна. Судалгаагаар ажилгүйчүүд, ядуучууд, орлогын хомсдолтой нийгмийн бүлэг, сонгогчдын улс төрийн идэвх муу, сонгуулийн оролцоо эрс сул байгаагийн дээр тэдний улс төрийн үйл байдалд гадны хүчин зүйлийн нөлөө их (70-80%) байгаа нь тогтоогдсон байна.

Ажил мэргэжил, боловсрол, нас, орлогын хэмжээ зэрэг нь сонгогчдын үйл байдалд шууд нөлөө үзүүлдэг социаль хүчин зүйлүүд юм. Судалгааны дүнгүүдээс үзэхэд өндөр боловсролтой, ажил мэргэжилтэй, орлого сайтай сонгогчдын улс төрд хандах хандлага тогтвортой, сонголт хийхдээ гадны нөлөөнд автах байдал нь бага байна. Тухайлбал, энэ бүлгийн сонгогчдоос сонгуульд оролцох сонирхол, сонголтоо хийх цаг хугацаа зэргийг тандахад тэдний дийлэнх нь (70%) сонгууль болохоос хэдэн сарын өмнө сонголтоо хийсэн байдаг. Энэ бүлгийн сонгогчдын улс төрд хандах хандлага, сонгуульд оролцох оролцоо рациональ шинжтэй байх нь түгээмэл үзэгдэл юм.

Харин мэргэжил ажилгүй, орлогын тогтсон эх үүсвэргүй, боловсролгүй сонгогчдын хувьд тэдний улс төрд хандах хандлага, сонгуульд оролцох оролцооны сэдэл харилцан адилгүй байгаа нь судалгаанаас харагддаг. Тэдний нэг хэсэг нь улс төрийн идэвхтэй байр сууринд байхад нөгөө хэсэг нь идэвхгүй “хөвөгч” заримдаа бүр “хүнийссэн” үйл байдалтай байна. Улс төрд хандах хандлага, сонгуульд оролцож саналаа өгөхдөө идэвхтэй байр сууринд байдаг бүлгийн хүмүүсд нөлөөлдөг гол хүчин зүйл нь эдийн засгийн хөшүүрэг (нам, улс төрчдийн амлалт, сонгуулийн амлалт) юм. Улс төрөөс хүнийссэн хэсгийнхний улс төрийн идэвхгүй байдалд нөлөөлөгч гол хүчин зүйл нь мөн л эдийн засгийн нөхцөл, амьжиргааны түвшний доройтол зэргээсээ үүдэн төр, улс төрийн нам, улс төрчдөд итгэх итгэл алдарсан байдагтай шууд холбоотой. Судалгаагаар Энэ бүлэгт багтах сонгогчдын дунд *Таны оролцоо улс төрийн шийдвэрт хэр зэрэг нөлөөтэй байж чадна гэж та бодож байна вэ?* гэсэн асуултад судлагаанд оролцогчдын 34.9% нь огт үгүй, 18.5% нь бага, 16.5% дунд зэрэг, 14.4% нь мэдэхгүй, 8.2% нь их гэж тус тус хариулсан байна¹⁰⁵. Эндээс үзвэл энэ бүлгийн сонгогчдын улс төрийн байр суурь, үйл байдал нь өөртөө итгэлгүй, тэдний улс төрийн шийдвэр гаргалтад хөндлөнгийн хамаарал ихтэй өөрөөр хэлбэл “хөвөгч сонгогч”-дын цөмийг (20-25%) энэ бүлэг бүрдүүлдэг гэж үзэж болохоор байна.

Монголын сонгогчдын үйл байдалд нөлөөлөгч социаль өөрчлөлтийн хүрээнд гарч буй өөр нэг томоохон үзэгдэл бол сонгогчдын насны бүтцэд гарч буй өөрчлөлт юм. Өнөөдөр сонгуулийн насанд хүрсэн нийт 1 сая 800 мянган сонгогчийн 60% буюу 1 сая 100 мянган сонгогч нь 18-35 хүртэлх насны залуучууд байна. 1990 онд төрсөн хүүхэд

¹⁰⁴ Нийгмийн Ардчиллын Хүрээлэнгээс 2011, 2012, 2013 онуудад хийсэн Хүмүүс: Улс төр-нийгмийн амьдрал сэдэвт суурь судалгаануудын дүн мэдээ.

¹⁰⁵ Улс төрийн барометр. Сант Марал судалгааны төвийн судалгаа. УБ., 2009 оны 4-р сар

өнөөдөр 23 настай бөгөөд тэд ардчилсан нийгмийн тогтолцоонд хүмүүжин төлөвшсөн иргэд. Тиймээс тэдэнд өмнөх нийгмийн талаар ойлголт, төсөөлөл хомс зөвхөн ардчиллын тухай, ардчилсан нийгмийн тухай л ойлголт төсөөлөл тэдний улс төрийн үйл байдлын үндсэн шинжийг нь бүрдүүлж байна. Энэ нь тэдний хувьд ардчиллыг дэмжих үндсэн үйл байдал нь болдог. Үүнийг доорх хүснэгтэй харна уу?

Та аль намын нэр дэвшигчийг дэмжих вэ? Насны бүлгээр¹⁰⁶.
Хүснэгт.1

		МАН	АН	МАХН
Насны бүлэг	18-35	34.0%	50.0%	15.6%
	35-45	33.9%	41.0%	16.3%
	46-60	40.1%	38.0%	17.6%
	61-ээс дээш	45.7%	35.5%	16.7%

Дээрх хүснэгтээс харахад сонгогчдын насны бүтцэд гарч буй өөрчлөлт сонгогчийн үйл байдлыг төлөвийг тодорхойлоход чухал ач холбогдолтой гэдэг нь харагдаж байна.

2. Сонгогчийн улс төрийн үйл байдалд үзүүлэх оюун санаа, ёс суртахууны өөрчлөлтийн нөлөө.

Нийгмийн тогтолцооны мөн чанар үндсээрээ өөрчлөгдөх үйл явцтай давхцаж Монгол хүний сэтгэл зүйн ертөнц шинэчлэгдэж байна. Бид нийгэм, эдийн засгийн хүрээнд бий болсон материаллаг шинжтэй прагматик зөрчлүүдийг шийдвэрлэхийн төлөө чармайж байгаа билээ. Харин сэтгэл зүй, ёс суртахууны хүрээнд үүсч хуримтлагдсаар байгаа зөрчлүүдийг нэг их анзаарахгүй байгааг нуух хэрэггүй. Үүнийг академич Г.Чулуунбаатар “нэг талаас төрөө дээдэлж төр, улсын гар харж амьдарч ирсэн нийгмийн сэтгэл зүйн инерци маш хүчтэй хадгалагдсаар байхад, нөгөө талаас хүн өөртөө найдаж өөрийн хүчээр амьдрах нийгмийн шаардлага бодит хүчин зүйл, амьдралын хэм хэмжээ болон төлөвших боллоо. Үүнийг хүний сэтгэл зүйн зохицон дасахуйн үндсэн зөрчил гэж үзнэ”¹⁰⁷ гэж дүгнэсэн байна.

Сүүлийн 20 гаран жилийн хугацаанд Монголын нийгмийн харилцаанд гарч буй зөрчил, дутагдал доголдлыг зөвхөн хуулиар зохицуулах гэж оролдож ирсэн нь өнөөдөр хуулиар зохицуулж болдоггүй нийгмийн харилцааны зарим шинж, агуулга, мөн чанар гажуудаж түүнийг гүйцээж ирсэн ёс суртахууны эрхэм нандин чанарууд Монгол хүнээс улам бүр алсарсаар байгаа билээ.

Оюун санаа, ёс суртахууны энэхүү өөрчлөлтүүд нь төр, иргэний харилцаанд онцгой сөргөөр нөлөөлж байна. Энд юуны урьд төр бүхнийг хийх ёстой, төр л ажиллахгүй байна гэсэн бэлэнчлэх, төрөөс ивээл хүсэх гэсэн үнэлэмж, нөгөө талаас

¹⁰⁶ Нийгэм, улс төрийн цаг үеийн судалгаа. Нийгмийн Ардчиллын Хүрээлэн. УБ., 2013 оны 5-р сар

¹⁰⁷ Г.Чулуунбаатар. Олон нийтийн санаа бодол дахь сэтгэл зүйн зөрчлүүд. XX, XXI зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт. УБ., 2008. 118 дах тал

төрөөс иргэдийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлахгүй олонхийн бус цөөнхийн төр болон хувирч буй үзэгдэлүүд нь энэ бүхний тод илрэл болон гарч ирж байна. Үр дүн нь сонгогчдын улс төрөөс хүнийсэх, улс төрийг үзэн ядах, намууд, улс төрчдийг үгүйсгэх, төргүй, намгүй нийгэм байгуулах тухай ярих зэрэг массын түвшин дэх улс төрийн сөрөг үнэлгээ газар авсаар байгаа нь сонгогчдын үйл байдалд сөргөөр нөлөөлж байна. Улмаар энэ байдал сонгогчдоос улс төрийн намуудад итгэх итгэл, сонгуулийн оролцоог ч бууруулсаар байна. Төр, улс төрийн намууд, улс төрчдөд итгэх итгэл улам бүр буурсаар байгааг судалгааны дүн ч харуулж байна.

УИХ-ын сонгуулийн оролцоо./1992-2012/

Хүснэгт. 2

№	Үзүүлэлт	1992 он	1996 он	2000 он	2004 он	2008 он	2012 он
1	Хүн амын тоо	2,154646	2,231363	2,382525	2,407568	2,564285	2,854203
2	Сонгуулийн насны хүний тоо	1,202704	1,218549	1,364862	1,472372	1,607825	1,878432
3	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогч	1,085129	1,147260	1,247033	1,279516	1,542617	1,836548
4	Санал өгсөн сонгогчийн	Тоо	1,037392	1,057182	1,027985	1,051812	1,179448
		Хувь	95,6	92,1	82,4	82,2	76,46
			67,29				

Гэтэл манай зарим улс төрчид сонгуулийн ирц, оролцоо буурч байгаа үзэгдэл ганц Монголын үзэгдэл биш. Барууны орнуудад ч энэ хандлага хүчтэй өрнөж байна гэж ярьж, бичиж байна. Бодит байдал дээр Монголын сонгогчдын улс төрийн үйл байдал, Өрнөдийн сонгогчдын улс төрийн үйл байдал хоёрын хооронд зарчмын том зөрүү байх шиг байна. Манай сонгогчдын улс төрөөс хүнийсэх, улс төрийн институт байгууллагад хандах, үнэлэх үнэлгээний бууралт нь сонгогчдын нийгэм ахуйн шалтгаан /ядуурал, ажилгүйдэл, баян хоосны ялгарал, боловсрол, уламжлалт менталитет гэх мэт/-тай холбоотой бол хөгжингүй орнуудын сонгогчдын сонгуулийн оролцооны бууралт нь тэдний улс төрөөс үл хамаарах амьдралын баталгаа, ажил мэргэжил, орлого эдгээрийн цаана амьдралын чанарын ахицтай шууд холбоотой гэдгийг бид ойлгох ёстой юм.

3. Сонгогчдын улс төрийн үйл байдалд намуудын нөлөө.


Нийгмийн шударга ёс, эрх чөлөө бол хүний нийгэмшсэн хөгжлийн үр дүн мөн. Нийгэмд шударга бус явдал, тэгш бус харилцаа үүссэн тэр цагаас хүн төрөлхтөн нийгмийн шударга ёс, эрх чөлөөний ноёрхол бүхий нийгмийг мөрөөдөж, түүний төлөө янз бүрийн аргаар тэмцэж ирсэн боловч тийм нийгмийн тогтолцоог нэг ч улс бий болгоогүй байна. Улс төр өөрөө тэгш бус хэмтэй харилцаа учраас тэгш байдал, шударга ёсыг улс төрд бий болгоно гэдэг өөрөө “үл гүйцэлдэх” шинжтэй ч энэ нь холбоотой. Харин тэгш байдал, шударга ёсыг нийгмийн харилцаанд хэрэгжүүлж, хэвшүүлэх тал дээр улс төр чухал үүрэгтэй. Гэвч бодит амьдрал дээр улс төрийн (төр, нам, улс төрчид, шийдвэр гаргагчид) нийгмийн хариуцлага алдагдсанаар жирийн иргэд, сонгогчдын зүгээс түүнийг үнэлэх үнэлэмж, хандах хандлагад ихээхэн өөрчлөлт ордог байна. Өнөөдөр Монголын нийгэмд энэ үйл явц эрчимтэй явагдаж байна. Төр, улс төрийн намуудаас явуулж буй бодлого, үйл ажиллагаа түүний нийгмийн үр өгөөжийн талаар анхаарах цаг болсон байна. Намын нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхгүйгээр улс төрийн итгэлцэл, иргэд сонгогчдын улс төрд итгэх итгэлийг дээшлүүлэх аргагүй.

Намын нийгмийн хариуцлагын механизм нь улс төрийн нам, улс төрийн элит, лидерүүдээс олон нийттэй харилцах харилцааг илэрхийлэх ба энд ард түмэн гол хянагч нь байна. Нөхцөл байдал, цаг хугацаа, эдийн засгийн боломжоо бодитой үнэлж чадалгүй дан ганц улс төрийн зорилгоор нийгмийн амлалт өгч, төлөөллийн эрх олж аван улмаар түүнийгээ хэрэгжүүлж чадахгүй байх нь иргэд сонгогчдын зүгээс улс төрийн намуудад итгэх итгэл сулрах, тэднийг сөргөөр үнэлэх байдалд хүргэдэг. Цаашдаа улс төрд хандах сонгогчийн үйл байдлын шинжид ч сөргөөр нөлөөлдөг.

Судалгаагаар намуудын нэр хүнд жилээс жилд буурч байна. Сонгуулийн кампанийн үеийг эс тооцвол намуудын нэр хүнд сонгогчдын дунд төдийлөн сайнгүй байна. Үүнийг сүүлийн хэд хэдэн цуврал судалгааны дүнгээс харья.

Улс төрийн намуудын рейтингийн судалгаа¹⁰⁸

График.1



Сүүлийн намуудаас төрийн өндөр албан тушаалд томилогдсон хүмүүс өөрийн багаа бүрдүүлэх нэрийдлээр хувь хүний боловсрол, мэдлэг, ажлын туршлагыг бус намыг хөрөнгө санхүү, бусад хэлбэрээр дэмжсэн, улс төрчдөд үнэнч зүтгэсэн, нутаг ус, садан төрлийн болон нэг ангид суралцаж байсан зэрэг албан бус шалгуурыг урьтал болгодог практикыг улс төрд тогтоогоод байна. Энэ байдлаас болж өнөөгийн “Монголын төрд цаашибал улс төрийн хүрээний лидерүүдийг улс төр-эдийн засгийн бүлэглэлүүд бүрэлдүүлсэн”¹⁰⁹ гэсэн ойлголт, үнэлгээ сонгогчдын дунд бий болж нам, цаашлаад төрийн нэр хүнд нийгэмд унаж байна.

Улс төрийн өндөр мэдлэг чадвар, туршлагатай, хүний нөөц бүрдүүлэх, тэднийг улс төр, төрийн албанд байршуулах нь улс төрийн намын хүний нөөцийн төдийгүй нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн чухал бодлого байдаг. Хүний нөөцийн бодлого нь дан ганц чадварлаг улс төрчдийг бэлтгэх, сонгох, томилох үйл ажиллагаа байгаад зогсохгүй намын бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нийгмийн

¹⁰⁸ Нийгмийн Ардчиллын Хүрээлэнгээс 2011, 2012, 2013 онуудад хийсэн “Хүмүүс: Улс төр-нийгмийн амьдрал” сэдэвт суурь судалгаануудын дүнгээс.

¹⁰⁹ АЗШҮБТ: Монгол дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ. УБ., 2006. 62 дахь тал

хариуцлагатай улс төрийн хүчин байх нөхцөл мөн билээ. Намын хүний нөөцийн алдаатай бодлого төрийн ажил, үйлчилгээний чанар хүртээмжид сөргөөр нөлөөлдөг нь сүүлийн жилүүдэд төрийн ажил, үйлчилгээнд иргэдээс ирүүлж байгаа шүүмжлэл, өгч байгаа таагүй үнэлгээ зэргээс илэрхий байгаа бөгөөд ийм байдал нь намын нэр хүндийг ихээр унагаж, түүнд хандах иргэд сонгогчдын улс төрийн үйл байдалд сөргөөр нөлөөлж байна.

Зүүн Азийн Барометр судалгаанд Монголд ардчиллын тулгуур институт дотроос хамгийн бага үнэлгээтэй буюу олон нийтийн дунд итгэл даадаггүй институцээр намыг нэрлэжээ¹¹⁰. Түүнчлэн АЗШҮБТ-ийн судалгаагаар судалгаанд оролцогсодын 35.4 хувь нь намуудад итгэх итгэл буурсан, 55.2 хувь нь намуудад итгэх итгэлд өөрчлөлт ороогүй гэж, харин зөвхөн 9.1 хувь итгэл нэмэгдсэн¹¹¹ гэж тус тус хариулсанаас үзэхэд намуудыг үнэлэх сонгогчдын үнэлгээ доогуур байгаа нь харагдаж байна. Энэ нь сонгогчдын үйл байдалд намуудын нөлөө эерэг гэхээсээ сөрөг шинжтэй байгаагийн нотолгоо юм.

Мөн сонгуулийн кампанит ажил шударга, ил тод, хуулийн хүрээнд явагдах зарчим ихээхэн гажуудаж байгаа нь намаас сонгогчдын улс төрийн үйл байдалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг улам бүр нэмэгдүүлж, тэр хэмжээгээр сонгогчдын үйл байдлын төлөвшилт хангагдаж чадахгүй байна. Сонгууль намуудын улс төрийн хариуцлагыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй боловч нөгөө талаар намууд сонгуулийн кампанийн үеэр явуулж буй хариуцлагагүй үйл ажиллагаа, үйлдлүүд нь сонгогчдийн улс төрийн үйл байдлыг гажуудуулах, үйл байдлын гажуудсан хэм хэмжээ, дадал, зуршил бий болоход түлхэж байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Ийм байдлын тодорхой жишээ бол сонгуульд бие биетэйгээ “мөнгө”-өөр өрсөлддөг жишиг тогтож, “намууд хамаагүй юм амлаж өр тавьчхаад салам нэхэгддэг, сонгогчдыг буруу зуршилд дасгаж, сонгуулийг нэг нь мөнгө салгах, нөгөө нь өр тавьж хахуульдаж байгаад ч хамаагүй өндөр албан тушаалд хүрдэг”¹¹² арга болтол нь гажуудуулсан явдал бол намаас иргэд сонгогчдын улс төрийн үйл байдлыг өөрчлөх, гажуудсан үйл байдал (сонгогчдыг буруу дадал, зуршилд хөтлөх, материаллаг амлалт, мөнгөөр саналаа худалдах, сонгуулийн хар технологийг бусдад дэлгэрүүлж түгээдэг сонгогчдын бүлэг бий болсон) хэм хэмжээ төлөвшихөд хүргэж байна. Судалгааны байгууллагаас явуулсан санал асуулгаар эрх барьж буй хоёр намаас иргэд юу хүлээж байгааг тодруулж, ач холбогдлоор нь эрэмбэлэхэд эхний гуравт а/ амлалтаа биелүүлж мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх, б/ шударга байх, в/ хариуцлагатай байх, иргэдийнхээ төлөө байх¹¹³ гэсэн гурван асуудал оржээ.

Өнөөдөр Монголын нийгмийн харилцааг 400 гаран хууль зохицуулж байгаа гэх боловч хуулиас гадуур амьдрал “цэцэглэсэн” хэвээр байна. Хуулиас дээгүүр эсвэл хууль зөрчсөн аргаар хэрэгцээгээ хангаж, ажил хэргээ бүтээдэг ёс тогтсон нь нийгмийн шударга ёсыг үгүйсгэж, олон нийтийн дургүйцлийг нэмэгдүүлж байна. Үүнтэй шууд холбоотой асуудал бол авилгал юм. Авилгалтай хамгийн их нэр холбогддог институт бол улс төрийн нам. Сонгуульд нэр дэвших, улс төрийн өндөр албан тушаалд томилогдох зэрэг намаас гардаг улс төрийн шийдвэрүүд ямагт авилгалтай холбоотой хардалт сэрдэлтийг дагуулдаг нь нам авилгад өртөмтгий байгууллага гэдэг нийтлэг үнэлэмж сонгогчдын дунд аль хэдийн бий болсон байна.

Энэ мэтчилэн намын зүгээс сонгогчдын улс төрийн үйл байдалд нөлөөлөгч суурь хүчин зүйлээс гадна яг сонгуулийн кампанит ажлын явцад нөлөө үзүүлэгч хүчин зүйлүүд нэлээдгүй бий. Эдгээр хүчин зүйлүүд нь тодорхой хугацаанд сонгогчдын улс

¹¹⁰ Зүүн Азийн Барометр судалгаа. УТБА. УБ., 2005

¹¹¹ АЗШҮБТ: Монгол дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ. УБ., 2006.70 дахь тал

¹¹² Б.Чимид. Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. УБ., 2006. 63 дахь тал

¹¹³ ММСГ-ээс явуулсан “Монголын улс төрийн өнөөгийн нөхцөл, байдал” сэдэвт социологийн судалгаа. УБ., 2009. 8 сар

төрийн үйл байдалд маш хүчтэй нөлөөг үзүүлж зарим тохиолдолд сонгогчийн үйл байдлыг үндсээр нь өөрчлөх тохиолдол ч гардаг байна. Сонгуулийн кампанийн үеэр сонгогчдын улс төрийн үйл байдалд дараах хүчин зүйлүүд хүчтэй нөлөө үзүүлдэг. Үүнд,

- Сонгуулийн сурталчилгаа, түүний хэлбэрүүд
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөө, ОНХ коммуникаци
- Намуудын нэр хүнд, нэр дэвшигчийн намын харьяалал
- Намаас нэр дэвшсэн нэр дэвшигчийн боловсрол, ажлын туршлага, нас хүйс, угсаа гарвал
- Намаас нэр дэвшсэн нэр дэвшигчийн бэл бэнчин гэх мэт хүчин зүйлс чухал нөлөө үзүүлдэг.

Энэ бүгдийг тухайн нам зөв тооцоолж сонгуульд ордог бөгөөд сонгогчдын хувьд дээрх хүчин зүйлсийн нөлөөлөлд байнга автаж байдаг байна.

Дөрөв. Дүгнэлт.

Нам бол төлөөллийн ардчиллын төлөвшүүлж, хөгжүүлэхэд онцгой үүрэгтэй улс төрийн институци. Ийм учраас сонгогчдын улс төрийн үйл байдлыг төлөвшүүлэхэд намын үүрэг роль асар их юм. Учир нь төр болон улс төрийн хүчнүүдийн бодлого, үйл ажиллагааны үр дүн нь сонгогчийн улс төрийн ямар үйл байдал төлөвшин бий болохыг тодорхойлдог. Өнөөдөр Монголд сонгогчдын үйл байдалд олон хүчин зүйлсийн нөлөөлж байгааг дээр дурьдсан бөгөөд тэдгээрийг нэгтгэн дүгнэвэл дараах тогтсон хандлага, ж хэлвэл,

- Төрийг бодлого, үйл ажиллагааны үр дүн, иргэд сонгогчдын хүлээлтийн зөрүүтэй байдал дунд үүсэн сонгогчдын улс төрд хандах сэтгэл ханамжгүй үйл байдал
- Намын ойлгох орчин үеийн ойлголт хандлага, намуудын өнөөгийн бодлого, үйл ажиллагааны эрс зөрүүтэй байдал дунд бий болсон гибрид шинж бүхий сонгогчдын үйл байдал
- Нийгэм ахуйн нөхцөлдөө баригдсан сонгогчид, тэдний нийцтэй бус оролцоонд суурилсан сонгогчдын улс төрийн үйл байдал. Иргэд, сонгогчдоос бус цөөнхөөс хамаарсан улс төрийн үйл байдал.
- Ардчиллын үнэт зүйлсийг бэхжүүлэхэд чиглэсэн, нийгэмд шинэ үнэлэмж, стандарт тогтоохыг зорьсон сонгогчдын үйл байдал. Үүнд ихэнхдээ залуучуудын улс төрийн үйл байдал хамаарна.
- Улс төрийн институцид итгэхээсээ илүү бие хүн, лидерт итгэсэн улс төрийн үйл байдал. Ардчиллын институциуд (төр, улс төрийн нам, иргэний нийгэм гэх мэт) бэхжээгүй байгаатай холбоотой.
- Альтернативгүй улс төрийн үйл байдал. Хоёр том намаас өөр сонголт байхгүй. МАН, АН хоёр төлөвшилт сул байгаа нь сонгогчдын үйл байдлыг гуравдагч улс төрийн хүчин рүү чиглүүлэхэд хүргэх магадлалтай. Үүний жишээ бол 2012 оны УИХ-ын сонгуулиар МАХН нийт сонгогчдын 22%-ийн санал авсан явдал юм.
- Сонгогчдын улс төрийн боловсрол доогуур байгаа явдал нь улс төрийг үнэн зөв дүгнэн цэгнэж ухаалаг сонголт хийдэг, нийцтэй оролцоонд суурилсан сонгогчийн үйл байдал бүрэлдэхэд тээг болж байна.
- Сонгуулийн тогтолцооны тогтвортой бус байдал, сонгуулийн кампанийн үйл ажиллагаа, улс төрийн коммуникаци, хэвлэл мэдээллийн нөлөө сонгогчдын улс төрийн үйл байдлыг өөрчлөхөд онцгой үүрэг гүйцэтгэж байна.

Энэ мэтчилэн олон хүчин зүйлсийн нөлөөгөөр Монголын сонгогчдын улс төрийн үйл байдал нь улс төрөөс хүнийссэн, улс төрийн институци байгууллагуудад итгэх итгэл буурсан, улс төрийн оролцооны нийцтэй бус байдал давамгайлсан зэрэг шинж

байдалтайгаар оршиж байна. Монголын сонгогчдын үйл байдлыг цаашид оролцоо талаас нь тухайлан нарийвчлан судалж шинжлэх нь сонгогчдын үйл байдлыг төлөвийг бүрэн дүүрэн гаргахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Миний энэхүү илтгэл Монголын сонгогчдын улс төрийн үйл байдлын шинж онцлогийг гаргахдаа түүнд нөлөө үзүүлэгч хүчин зүйлсийн хүрээгээр хязгаарлагдсан байгааг минь та бүхэн болгооно биз ээ.

Ашигласан материал

- Азийн барометр. Ред Д.Ганбат. У., 2008
А.Лийпхарт. Ардчиллын хэв загвар. УБ., 2007
 Ардчилал ба улс төрийн нам. Онол, практикийн бага хурлын эмхэтгэл. МАН. УБ., 2009
Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи. Асуудал, аргачлал, ашиг тус. УБ., 2013
Д.Ганхуяг. Хошуучлагчийн улс төрийн имиж, түүнийг бүрдүүлэхүй. УБ., 2004
 Е.Малькин, Ё.Сучков. Сонгуулийн технологийн үндэс. I, II. Орчуулсан. Б.Наранцогт. УБ., 2012
 Монгол улсын Үндсэн хууль., 1992
 Монгол улс дахь сонгууль, сонгуулийн шинэ тогтолцоо. ШУА.ФСЭХ. УБ., 2000
 Монголын ардчиллын төлөвшил. ШУА. ФСЭХ хамтын бүтээл. УБ., 2011
 Монгол дахь ардчиллын хөгжил: сорилт, боломж. Үндэсний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. УБ., 2005
 Монгол улсын төрийн байгуулалтыг төгөлдөржүүлэх боломж, арга зам. Судалгааны тайлан. Удирдлагын Академи., УБ., 2010
 Монголын засаглалын үзүүлэлтүүд. ШУА.ФСЭХ. УБ., 2013
 Хүмүүс: улс төр-нийгмийн амьдрал сэдэвт суурь судалгаанууд. Нийгмийн Ардчиллын Хүрээлэн. 2011, 2012, 2013
Д.Түмэнжаргал. Монголын сонгуулийн систем: эрэл шийдэл. УБ., 2012
 Улс төрийн шинжлэх ухаан. МУИС. УБ., 2010
 Улс төрийн барометр. Социологийн судалгаа. Сант Марал судалгааны төв. УБ., 2008 оны 4-р сар
Г.Чулуунбаатар. XIX, XX зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт. УБ., 2008
 Эрх зүй сэтгүүл. МУИС. ХЗС. №2-3/2007 (16-17)
 International Encyclopedia of Political Science. Sage., 2012
Prohl W, Sumati L. Voter's Voices. UB., 2008
Roskin C. Political Science an Introduction. Pearson Education, Inc., 2012

ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО: МОНГОЛ ДАХЬ ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ УЛС ТӨРИЙН ЧИГ ХАНДЛАГА

Ц.БАТБОЛД¹, Б.БАТБААТАР²

¹МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, доктор, дэд профессор

²МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, докторант

***Түлхүүр үг:** Оролцооны онол, иргэний нийгэм, иргэний хөдөлгөөн, шаардлага, нөлөөлөл, өрнөл, идэвхжил, намжмал байдал, чиг хандлага*

ABSTRACT: *In this article, it clarifies authority of theory in citizenship's participation and it mentions briefly the process of civil movement that has activated after 2005. It has set a goal to make a conclusion in democratic decades' civil movement activity and their purpose direction and effect. It aims to identify the direction of their political requirement and purpose.*

ТОВЧ ХУРААНГУЙ: Уг өгүүлэлд иргэдийн оролцооны онолын үндэслэлийг тодруулж, Монгол оронд 2005 оноос идэвхжсэн иргэний хөдөлгөөний үйл явцыг товч дурьдан 1990 он хойших ардчиллын жилүүдэд гарсан иргэний хөдөлгөөнүүдийн үйл ажиллагаа тэдгээрийн тэмцлийн зорилго чиглэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөх, тэдгээрийн улс төрийн шаардлага, зорилго чиглэл нь ямар чиг хандлагатай байгааг тодорхойлохыг зорьсон болно.

Улс, үндэстний хэмжээнд төлөөллийн засаглал, түүний институтууд байгааг ардчиллыг бүрэн хангасан, ард түмний өөрийнх нь ардчилсан засаглал тогтсон гэж үзэхэд хангалтгүй зүйл юм. Өөрөөр хэлбэл, улс төрчид сонгогчид, ард түмний хүсэл зоригийг бүрэн төлөөлөх боломжгүй гэж үзэх хандлага бий. Й.Шумпетер “Капитализм, социализм ба ардчилал” номондоо “Ард түмэн аливаа асуудлын талаар тодорхой бөгөөд рационал санал бодолтой байдаг бөгөөд ардчилсан оронд энэхүү санал бодлоо баталгаажуулахын тулд түүнийг хэрэгжүүлэхээр ажиллах “төлөөлөгчдөө” сонгодог гэдэгт ардчиллын сонгодог онолын талаарх бидний гол эргэлзээ төвлөрч байдаг” гэжээ. Тухайлбал, Англи шиг парламентат хаант улс ардчилсан аргын шаардлагыг хангана. Учир нь засгийн газрын албан тушаалд парламентаас нэрийг нь санал болгосон тэр хүмүүсийг л хаан/хатан нь томилохоор чөдөрлөгдсөн практик тэнд үйлчилдэг гэж үздэг. Гэвч, “үндсэн хуульт” хаант засаглал нь ардчилсан гэж нэрлэгдэх боломжгүй. Учир нь сонгогчид болон парламент нь парламентын засаглалтай улсад байдагтай ижил эрхтэй боловч сонголтоо засаглалын байгууллагад уламжлан зөвшөөрүүлэх эрх мэдэлгүй байдаг. Ингэснээр засгийн газрын гишүүд агуулгаараа ч, хэлбэрээрээ ч хаанд үйлчлэгчид байх бөгөөд зарчмын хувьд хаан тэднийг томилж ч, халж ч чадна. Ийм журам ард түмний таашаалд нийцэх нь бий ч жинхэнэ утгаараа энэ нь ард түмний засаглал биш юм” гэжээ.

Энэ нь төлөөлөгчдийг шилж сонгох нь улс төрийн асуудлыг шийдвэрлэх эрх мэдлийг сонгогчдод хадгалуулах ардчиллын анхдагч зорилгын дараа орж, хоёрдогч шинжтэй болж байгаа юм. Тэгвэл энэ хоёр бүрдлийн байрыг сольж, сонгогчид шийдвэр гаргадаг гэдгийг хоёрдогч болгож, анхдагч нь шийдвэр гаргах хүмүүсийг сонгох явдал гэж үзье. Өөрөөр хэлбэл, ард түмний гол үүрэг нь төр засаг буюу гүйцэтгэх засаглалыг бүрдүүлэх эсвэл түүний үүргийг хэрэгжүүлэх завсрын нэгэн байгууламжийг

бүрдүүлэхэд оршино гэдгийг бид иш үндэс болгож буй. Ингээд тодорхойлбол: ардчилсан арга гэдэг нь хувь хүмүүс ард олны саналын төлөөх өрсөлдөөнт тэмцлээр шийдвэр гаргах эрх мэдлийг олж авдаг явдлаар илэрхийлэгдсэн улс төрийн шийдвэр гаргах тэрхүү институционал журам юм.¹¹⁴

Ж.Ж.Руссог оролцооны талын онолч гэж судлаачдын олонх нь үздэг бөгөөд, тэрээр “Нийгмийн Гэрээ” бүтээлдээ улс төрийн тогтолцооны мөн чанарыг ойлгоход оролцоот ардчилал нэн чухал хэмээн бичсэн. Руссогийн онол нь бүхэлдээ, улс төрийн шийдвэр гаргах түвшинд болон өөрийн онолын хүрээнд ч хувь хүний, иргэн бүрийн оролцоог чухалчилсан байдаг. Энэ нь ердөө институцийн байгуулал дээр хавсаргасан нэмэлт биш бөгөөд, институциудын үйл ажиллагаа болон түүнд оролцож байгаа хувь хүмүүсийн сэтгэл зүйн чанар, хандлагын хооронд харилцан хамаарал байгаа гэдгийг баталсан төдийгүй, улс төрд оролцогч этгээдүүдэд сэтгэл зүйн нөлөөтэй юм.¹¹⁵

Руссогийн онолд оролцооны үүргийг өөр хоорондоо ялгаатай тайлбарлагдах, түүний үзэл санаа ба оролцоот төрийн тогтолцооны талаар сайтар тайлбарласан байдаг. Руссо улс төрийн систем дэх оролцооны асуудалд тодорхой эдийн засгийн нөхцөл байх тухай санал дэвшүүлсэн. Руссо нийгмийг жижиг фермийн эздээс бүтэх ёстой төдийгүй, эдийн засгийн хувьд эрх тэгш, бусдаас үл хамаарсан байхыг зөвлөсөн. Түүний систем нь туйлын тэгш байдлыг шаарддаггүй бөгөөд ялгаатай байдал байх авч, тэр нь улс төрийн тэгш бус байдалд хүргэхгүй байх ёстойг сануулж байдаг. Ухаандаа, ямар ч хүн хэн нэгнийг худалдаж авахаар баян биш, ямар ч хүн өөрийгөө худалдахаар ядуу тартагтаа тулсан биш байх ёстой бөгөөд иргэний хамгийн ариун эрх нь ямар нэгэн зүйлийг эзэмшдэг байх явдал гэсэн ойлголттой байх ёстой. Улс төрийн тэгш байдал, улс төрийн хараат бус байдал нь үүнээс хамаарах тул тэр нь иргэдийн аюулгүй, бие даасан байдлын баталгаа болно.¹¹⁶

Энэ нөхцөлд л хувь хүмүүсийн зохих хандлага, сэтгэл зүйн шинж чанарууд төлөвшлөө олно. Тэрхүү төлөвшилт нь чухамдаа оролцооны үйл явцаар дамжин хэрэгжинэ. Тийм учраас ардчиллын онолд оролцооны гүйцэтгэх үүрэг нь иргэдийн сэтгэл зүйн бэлтгэл болон ардчиллын чадамж, процедурыг эзэмшихүйц практик мэдлэг олгохын аль алийг багтаасан өргөн утга бүхий боловсруулан гэгээрүүлэх чадвартай юм. Тиймээс ч оролцоот системийн тогтвортой оршихын тухайд онцгой асуудал байдаггүй. Энэхүү систем нь оролцооны үйл явцын боловсруулан гэгээрүүлэх үр нөлөөгөөр дамжин өөрөө өөрийгөө тэтгэж байдаг онцлогтой. Оролцоот үйл явц нь оролцоонд шаардагдах шинж чанаруудыг өөрөө хөгжүүлэн тэтгэж байдаг. Өөрөөр хэлбэл, хүмүүс хэдий чинээ оролцоотой байна төдий чинээ оролцоонд хамрагдах чадамжаа сайжруулж байдаг. Иргэдийн оролцоо нь хамтын шийдвэрийг хүлээн авахад дэм болдог бөгөөд үйл ажиллагааг нэгтгэн нийлүүлэх ач холбогдолтой байдаг.

Ардчилал нь үндэсний хэмжээнд нийт ард түмэн дээд зэргийн оролцоотой байхын тулд нийгмийн бусад хүрээ ардчилагдаж, улмаар нийгэмшилт буюу “нийгмийн дадлагажилт” явагдах учиртай.¹¹⁷ Ардчилсан нийгэм оршин тогтнож буй нөхцөлд иргэдийн оролцооны механизм оршин байх нь оролцоогоор дамжсан нийгэмшилт бүх хүрээнд хэрэгжих бололцоотой тийм нийгэм орших боломжийг бүрдүүлдэг. Хувь хүмүүс өөрсдийнхөө амьдрал, орчинг аль болох захирах бололцоотой байя гэвэл эдгээр хүрээн дэх эрх мэдлийн бүтцүүд нь шийдвэр гаргах үйл явцад хүмүүс оролцох бололцоотой байхаар зохион байгуулагдсан байх учиртай. Үйлдвэрийн хүрээ чухал ач холбогдолтой байдгийн бас нэг учир нь (тэгш) оролцоонд шаардагдах хувь хүний

¹¹⁴ УТБА. Ред Д.Ганбат. “Капитализм, социализм ба ардчилал”/Ардчиллын тухай түүвэр/ Орч Н.Туяа. УБ., 2006. Х 9-12.

¹¹⁵ К.Пейтман. “Ж.Ж.Руссо, Ж.С.Милл. Ж.Б.Х.Коул: Ардчиллын оролцооны онол”/Улс төрийн шинжлэх ухааны дээж бичиг/ Орч Ц.Батболд. УБ., 2012. Х 180-185.

¹¹⁶ J.J. Rousseau. The Social Contract. M.Cranston (trans), 1968. P-ninguin Books. 1968, 11-р тал, мөн (1913), 254-р тал.

¹¹⁷ К.Пейтман. Participation and Democratic Theory. L., 1970. P 22-24.

хараат бус болон амгалан байдлыг хангагч бодитоор хэмжигдэхуйц эдийн засгийн тэгш байдалтай холбоотой; үйлдвэрийн хүрээний бүтцүүдийг ардчилах, “менежерүүд” ба “ажиллагсад”-ын хоорондох байнгын ялгааг халах нь энэхүү тэгш байдлыг бий болгох нь чухал.

Оролцооны онолд “улс төрийн” асуудал нь үндэсний болон орон нутгийн засаглалын хүрээгээр хязгаарлагддаггүй. Оролцооны онолд “оролцоо” гэдгээр шийдвэр гаргах үйл явцад (тэгш) оролцохыг хэлдэг. “Улс төрийн тэгш байдал” гэдгээр шийдвэрийн үр дүнг тодорхойлоход ижил эрх мэдэлтэй байхыг ойлгодог. Оролцооны онолд ардчилсан системийг зөв хэмээн үзэхдээ оролцооны үйл явцын хүнд тусах үр дүнг гол тулгуур болгодог. Оролцооны загварыг дээд зэргийн оролт (оролцоо) шаардсан бөгөөд гаралт нь зөвхөн бодлого (шийдвэрүүд) төдий бус хүн бүрийн нийгэм, улс төрийн чадварын хөгжлийг өөртөө агуулсан, улмаар гаралтаас оролт уруу “эргэх холбоо” өгч байдаг тийм загвар гэж ойлгож болох юм.

Оролцоот ардчиллын онолын судалгааны нэг томоохон чиглэл нь иргэний нийгмийн асуудлууд байдаг бөгөөд түүн дотроо иргэний хөдөлгөөний үйл ажиллагаа, тэдгээрийн идэвхжилт ба сулрал, оролцооны зорилго, чиг хандлага нийгэмд нөлөөлөх нөлөөллийг судлах нь чухал юм. Энэ нь улс орны хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлоход чухал улс төрийн чухал ач холбогдолтой.

Иргэний хөдөлгөөний үүсэл хөгжлийг нийгэм, төрийн харилцаа үүссэн үеэс эхлэлтэй гэж үзвэл, нийгэмшилтийн үйл явц дахь хэн нь захирах ёстой вэ гэдэгт гол асуудал бус, харин захирагч нь ямар шийдвэр гаргаж тэр нь нийгмийн олонхид хэрхэн эерэг болон сөрөг нөлөө үзүүлж буйн нөлөөллийн тусгал юм. Өнөө үед ихэвчлэн нийгмийн олонх, дунд болон доод давхарга дахь иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлөх шийдвэр, суурь үнэ болох цахилгаан, шатахуун, нийтийн тээврийн үнэ нэмэх, өргөн хэрэгцээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, байгалийн баялгийг зүй зохисгүйгээр ашиглах, экологийн тэнцвэрийг алдагдуулах, үндэсний эрх ашгийг хохироох зэргээр эрх баригчдад ашигтай тусах шийдвэрийг эсэргүүцсэн иргэний хөдөлгөөнүүдийн үйл ажиллагаа 2005 оноос идэвхжсэн байна.

Монгол дахь иргэний хөдөлгөөний үйл явцыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд хэрхэн тэмдэглэснийг товч авч үзье. Үүнд:

2005.02.03 “Эрүүл нийгэм иргэний хөдөлгөөн” Ялалтын талбайд цуглаан хийж, дараа нь улсын прокурорын газраас засгийн газрын ордон хүртэл жагсаал хийжээ. Тус хөдөлгөөний залуу удирдагч Батзандан, Ичинноров нар 2-р сарын 2-нд (1895 оны энэ өдөр МАН-г үндэслэн байгуулагчдын нэг Д.Сүхбаатар мэндэлсэн өдрийг сонгосон) урьдчилан хэвлэлийн бага хурал хийн өөрсдийн зорилгоо танилцуулсан. Уг хэвлэлийн бага хуралд Сүхбаатарын талбайд цуглаан зохион байгуулах зөвшөөрөл олгохыг хүссэн болон их хурлын гишүүдийг огцруулах, улс төрийн намын тухай хуулийг өөрчлөх шаардлага тавьжээ.

2005.02.23 “Эрүүл нийгэм иргэний хөдөлгөөн” хоёр дахь жагсаал цуглааныг өдрийн 12 цагт Ялалтын талбайд хийсэн бөгөөд цуглаанд 400 орчим хүн оролцсон. Цуглааны дараа Жуулчны гудамжаар дайран улсын их дэлгүүрийн өмнүүр явж, төв шуудангийн өмнө хүртэл жагсаал хийв. Тэд “Энхбаяр бол Сталин мөн”, “Энхбаяр огцор”, “Хариуцлагатай ёс суртахуунтай улс төрчийг хүсч байна”, “Авилгад идэгдсэн эх орноо аваръя” гэсэн лоозунгууд барьсан байлаа. (“Өнөөдөр” 2005.02.24) Эдгээр хоёр жагсаалын шаардлагыг эрх баригчид төдийлөн ойшоогүй бөгөөд ямарч хариу өгсөнгүй.

2005.03.11 Малчид ба алт олборлогч компаниудын тэмцэл: Алт олборлогч компаниуд нь орон нутгийн төсөвт ашгийн татвар төлснөөр (Татварын тухай хуулиар эрдэс баялгаас олсон ашигт ноогдох татвараа тухайн уурхай байгаа орон нутагт төлөхөөр заагдсан) тухайн нутгийн мөнгөн санхүүд тус нэмэр болж байдаг.

Гэвч үүний нөгөө талд ашигт малтмал олборлосноор байгаль орчин бохирдох аюул аюул улам их болж, алт олборлохдоо мөнгөн ус ашигласнаас хүний эрүүл мэндэд

хортой нөлөө үзүүлж байгааг зогсоох шаардлага тавьсан. Архангай аймгийн Цэнхэр сумын иргэд алт олборлохыг зогсоохыг шаардсан хөдөлгөөн хүч улам хүчтэй болж, тэмцэл ширүүсэх хандлагатай болов. Тэмцэл шаардлагын эцэст сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Нарийн Хамар” гэдэг газрыг байгалийн тусгай хамгаалалтын бүс болгох шийдвэр гаргасан байна.

2006.01.02 Улаанбаатар хотод автобусны үнийг нэмэхийг эсэргүүцсэн хөдөлгөөн: Энэ өдөр 200 төгрөг байсан автобусны үнэ 300 болов. Энэ үед төрийн албаны шинэ ажилтны цалин 60 орчим мянган төгрөг байв. Энэ нь ажилгүй орлогогүй иргэдэд төдийгүй орлоготой төрийн албан хаагчдад ч нэлээдгүй дарамт болж байв. Уг шийдвэрийг эсэргүүцэн “Эрс Шинэчлэл”, “Эрүүл Нийгэм Иргэний Хөдөлгөөн”, Чөлөөт Үйлдвэрчний Эвлэлийн “Эв Нэгдэл” зэрэг хөдөлгөөнүүд

2006.01.12-нд хотын захиргааны өмнө гэр барин Сүхбаатарын талбайд эсэргүүцлийн цуглаан хийв. 2006.01.12-нд МАХН-ын байр уруу “Эрүүл Нийгэм Иргэний Хөдөлгөөн”, “Эрс Шинэчлэл” хөдөлгөөн болон жагсаал цуглаанд оролцсон иргэд дайрч орсон хэрэг гарав. Үүний үр дүнд 2006 оны 01.13 нд хотын захирагч автобусны үнийг хуучин хэвээр байлгахаар шийдвэр гаргав.

2006.02.08-нд “Эрүүл Нийгэм Иргэний Хөдөлгөөний” удирдагч Ж.Батзандан, О.Магнай нарт 1-р сарын 12-ны өдөр МАХН-ын төв байранд дайрч орсныг буруутган эрүүгийн хуулийн 179-р зүйл (Жич: Нийгмийн хэв журам зорчих үйлдэл хийсэн)-ийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэв. (“Өнөөдөр” 2006.02.09)

2006.04.05 УИХ-ын чуулган эхэлсэнтэй холбогдуулан “Эрс Шинэчлэл”, “Эрүүл Нийгэм Иргэний Хөдөлгөөн”-үүд засгийн газрын ордны өмнө цуглаан хийж, дараа нь Сүхбаатарын талбайд гэр барин “улс төрийн суулт” хийсэн байна. Уг суултын шаардлага нь “Монголын газар шороог гадаадынханд бүү худалд” гэсэн үндсэн агуулгатай байв.

2006.04.11 “Эрс Шинэчлэл”, “Эрүүл Нийгэм Иргэний Хөдөлгөөн”- үүд Сүхбаатарын талбайд гэр барьж суултаа үргэлжлүүлэв. Улс төрийн суултын шаардлага нь “Ашигт малтмалын тухай хуулийг өөрчлөх”, Айвенхо Майнз компанитай “Тогтвортой байдлын гэрээ” хийхийг эсэргүүцсэн ажээ. Тэд өмнө нь манай улс “Бороо Гоульд” компанитай тогтвортой байдлын гэрээ байгуулаад 50 тн алтаа гэрээний нөхцөлөөр алдаж байсныг жишээ болгон шаардлага тавьжээ.

2006.04.13 Дээрх хөдөлгөөнүүд дээр “Ахмадын чөлөөт холбоо” нэмэгдэн “Оюу Толгой”, “Таван Толгой”-н ордыг яаралтай хааж, ашиглалтын лицензийг нь хурааж авахыг шаардав. Уг шаардлагыг хүлээж авахгүй бол засгийн газрыг огцруулах тухай шаардаж байв.

Үүнтэй холбогдуулан “Эв нэгдэл”, “Оюутаны чөлөөт холбоо”, “Хөх монгол” бүлэг Эрх чөлөөний талбайд иргэний хөдөлгөөнүүдийн эсрэг жагсаалыг зохион байгуулав. Иргэний хөдөлгөөний эсрэг жагсаалыг МАХН-аас зохион байгуулсан гэсэн хардлага тархав.

2006.04.18 Иргэний хөдөлгөөнүүдийн зохион байгуулсан жагсаал цуглаан улам эрчимжиж, олон хүмүүс тэдний тавьсан шаардлагыг зөв хэмээн дэмжиж байсан. Энэ өдрийн жагсаал олон хүнийг хамарсан бөгөөд зохион байгуулагчид нь МАХН-ын төв байр уруу очин намын нарийн бичгийн даргад шаардах бичгээ гардуулав. Уг шаардлага нь М.Энхболдыг ерөнхий сайдаас огцруулахыг шаардсаны зэрэгцээ МАХН-ыг шүүмжилсэн агуулгатай байв. Шаардах бичгийг намын нарийн бичгийн дарга С.Баяр хүлээж аван намынхаа удирдах зөвлөлөөр ярилцахаа илэрхийлсэн байна.

2006.04.23 Улс төрийн шаардлага тавигчид Ерөнхий Сайд М.Энхболдтой уулзаж “Оюутолгой, Таван толгой, Бороо гоульд компаний асуудал”-аар ажиллаж байгаа ажлын хэсэгт иргэний хөдөлгөөний төлөөллийг оролцуулах, мөн Улсын Их Хурал, Засгийн Газар, Иргэний хөдөлгөөнд оролцогчид адил тэгш эрхтэйгээр гэрээг шүүн хэлэлцэх санал тавьжээ.

2006.06.14 “Эрүүл Нийгэм Иргэний Хөдөлгөөн” болон “Ард Түмний Нам” Сүхбаатарын талбайд цуглаан хийж, Канадын “Централь Гоульд” компаний хөрөнгө оруулалттай “Бороо гоульд” компаний уул, уурхайн ажиллагааг зогсоох, “тогтвортой байдлын гэрээ”-г цуцлах, 50 сая долларын хөрөнгө оруулалтын мөнгө хэний гараар орсныг тодруулахыг Засгийн Газраас шаардав. (“Өнөөдөр” 2006.06.14)

2006.09.11 “Монголын оюутны хөдөлгөөн”-ий залуучууд МУИС-ийн 2-р байрны өмнөх талбайд цуглаан хийв. Тэд “Боловсролоор бизнес хийхээ боль”, “Төрийн өмчийн барилгыг бидний мөнгөөр барихыг эсэргүүцэж байна”, “Авилга хээл хахууль авсан захирлыг зайлуул”, “Бид мөнгөний машин биш”, “Эрдэнэбаатар сайд аа оюутнууд цуглардаг газрыг бүү булааж ав” (Жич: ШУТИС-д орон нутгаас ирж суралцаж байгаа оюутнуудад зориулж барих гэж байсан байрны газрыг их хэмжээний мөнгө амласан Хятадын компанид зарсныг эсэргүүцэж Байгаль Орчны Яамны сайд Эрдэнэбаатарт шаардлага хүргүүлсэн), “З.Энхболд боловсролд оролцохоо боль” (Жич: АН-аас их хурлын гишүүн болсон, одоо ШУТИС-ын ТУЗ-ийн даргаар ажиллаж байгаа, Төрийн Өмчийн Хорооны дарга байхдаа тус сургуулийн захирлыг өөрчилж, одоогийн захирлыг томилсон бөгөөд энэ удаад сургалтын төлбөрийг 700-800 мянган төгрөг болгож нэмэх асуудлыг удирдаж байгаа), “Боловсрол,соёл, шинжлэх ухааны яам ажлаа хий” гэсэн лозунг барьсан байв. Тус цуглаанд МУИС, ШУТИС, ХААИС болон зарим хувийн дээд сургуулийн оюутнууд оролцсон байна. (“Өнөөдөр” 2006.09.12)

2006.11.6-8 “Эрс шинэчлэл”, “Эрүүл нийгэм иргэний хөдөлгөөн”, “Миний Монголын газар шороо”, “Даяар Монгол”, “Ахмадын чөлөөт холбоо зэрэг хөдөлгөөнүүд Сүхбаатарын талбайд “Бүх ард түмний хуралдай”-г хуралдуулах шийдвэр гаргав. Энэ үеэр “Ашигт Малтмалын Тухай Хууль”-ийн хэрэгжилтийг зогсоох, УИХ-ыг тарааж, ерөнхийлөгчийг огцруулах, “Бүх ард түмний онц их хурал” хуралдуулах гэсэн шаардлага бүхий гурван мянга гаруй асуулгын хуудас тараасан байна.

2007.04.27 Монголын ардчилсан холбоо 18 жилийн өмнөх шигээ олон хүн оролцсон цуглаан хийж, “Хоёрдугаар ардчилсан хувьсгалыг өрнүүлнэ” гэсэн мэдээлэл суртчилгаа цацан, “Чин шударга хүчирхэг улс төр, чинээлэг иргэний нийгмийн төлөө нэгдэцгээе!” гэсэн ухуулах хуудсыг хотоор нэг наасан байв. Тэд: “Ард түмнээ сонсдоггүй УИХ-ыг тараая”, “Авилгач М.Энхболдыг огцруулъя”, “Уул уурхай болон засгийн эрхийг ард түмэнд” гэсэн лозун барьсан байлаа.

Иргэний хөдөлгөөнүүд 2008 оны УИХ-ын сонгууль болон орон нутгийн сонгуульд нэр дэвшихээ илэрхийлэв. (“Өнөөдөр”. 2007.04.24)

2007.05.01 “Монголын иргэний холбоо” Сүхбаатарын талбайд цуглаан хийж “Авилгын эсрэг” гарын үсэг цуглуулав. (Жич:Тэр “Өнөөдөр” сонины 2007 оны 5-р сарын 2-ны дугаарт цуглаан зохион байгуулсан тухай өгүүлэл бичсэн)

Хүснэгт 1. Иргэний хөдөлгөөнүүдийн тавьсан шаардлага түүний чиг хандлага

	он	Хувь хүний эрх чөлөө	Бүлгийн сонирхол	Амжиргааны түвшин	Байгаль орчин, уул уурхай	Нийгмийн шудрага ёс	Социал сонирхол	үндэсний эрх ашиг	нийт тоо
1	2004 он	3	3	1	3	5			15
2	2005 он	1	1	11	3	8	3	3	30
3	2006	1	2	3	6	8		5	25

	он								
4	2007 он	2	5	6	8	11	2	9	43
5	2008 он	3	6	3	9	13	1	18	53
	дүн	10	17	24	29	45	6	35	166
	Эзлэх хувь	6	10,2	14,4	17,5	27,1	3,6	21	100

Дээрх хүснэгтээс ажиглахад нийгмийн шударга ёсыг сэргээхийг шаардсан шаардлага хамгийн их буюу 27,1 хувийг эзэлж байна. Энэ нь сүүлийн хориод жилд нийгмийн тэгш бус байдал, социал ялгарал ихэссэнтэй холбоотой бөгөөд нэн ялангуяа баян ядуугийн зааг ялгаа эрс нэмэгдэж, нийгмийн баялгийн ойролцоогоор 80 хувийг хүн амын цөөнх болох 10 хүрэхгүй хувь нь эзэмшиж байгаатай холбоотой байна. 2013 онд засгийн газар улсын төсөв бүрдүүлэхтэй холбоотой “иргэдийн хадгаламжийн мөнгөнөөс татвар авах” шинэ санал гаргасан бөгөөд уг саналтай холбоотой тойм судалгаа хийснийг телевизүүд болон мэдээллийн хэрэгслээр цацжээ. Уг мэдээлэлд иргэдийн хадгаламжийн 90 хувийг арван мянга гаруйхан хүн эзэмшиж байна гэж дурьдсан байв. Хүн амын олонх болох 90 хувийн төлөөллүүд өөрсдийн эзэмшиж буй өчүүхэн арван хувиас татвар авах нь тэдэнд их дарамт учруулах учраас эрс эсэргүүцсэн ярилцлагыг өгч байсан. Ингэснээр тэд нийгмийн баялгийн 90 хувийг эзэмшигч цөөнхийг цээжээрээ хамгаалсан бөгөөд үүнийгээ ойлгох чадваргүй байгаа нь харагдаж байв.

Дүнгийн жагсаалтын хоёрдугаарт 21 хувийг эзэлсэн улс, үндэсний эрх ашгийг хамгаалсан шаардлага орж байна. Уг шаардлагууд нь монгол төрийн үндсэн ажлын нэг болох төр үндэсний эрх ашгийг хамгаалах үүргээ муу гүйцэтгэж байгааг харуулж байна. Энэ нь монгол төрийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд плюрализм хүчтэй байгаагийн шинж юм. Өөрөөр хэлбэл, явцуу бүлэглэлүүдийн сонирхол, үндэсний эрх ашгийг зөрчсөн шийдвэр гаргаж байгаатай уг шаардлага холбоотой юм. Явцуу бүлэглэлүүд, гадны хөрөнгө оруулагчдын сонирхлыг хэт хангах нь 1979 оны Ираны исламын хувьсгалын жишээг харуулж байна. Тэнд “иран хүн, нохой хоёр орж үл болно” гэсэн хязгаарлалтуудыг эсэргүүцэж америкийн хөрөнгө оруулагчид болон Шах Пехлевийн дэглэмийн эсрэг хувьсгал гарсан билээ.

Иргэний хөдөлгөөнүүдийн тавьсан шаардлагын гуравдугаарт байгаль орчин, уул уурхай, ашигт малтмалын лицензийн асуудал 17,5 хувиар орсон байна. Төрийн зүгээс үндэсний эрх ашгийг зөрчсөн асуудлууд нь энэ салбаруудад хурцаар илэрч байсан бөгөөд “Бороо Гоульд”, “Дачин Тамсаг” зэрэг олон орд газруудын ашиглалт, мөн “Оюу Толгой”, “Таван Толгой” зэрэг стратегийн ордуудын гэрээ, алт хөтөлбөртэй холбоотой байгал орчны сүйрэл, лицензийн замбараагүй наймаа нь эх оронч, үндэсний үзэлтнүүд болон орон нутгийн оршин суугчдын үзэл бодол, эрх ашгийг илт зөрчсөн хэрэг явдлаас үүдэлтэй байна. Энэ асуудал “Үндсэн Хууль”-д тунхагласан нутгийн өөрийн удирдлагын үйл ажиллагаа уг мөн чанараараа явагдахгүй байгааг харуулсан хэрэг юм. Өөрөөр хэлбэл, орон нутгийн нийгэм, эдийн засгийн асуудлыг “Үндсэн Хууль”-д “НӨУЁБ, төрийн захиргааны байгууллагатай хослон бие даан шийдвэрлэнэ” гэсэн заалт хэрэгжихгүй байна. Энд орон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах НӨУЁБ жинхэнэ утгаараа бүрэлдэж чадаагүй бөгөөд НӨУЁБ-д улс төрийн намын гишүүд олноороо орж ирснээр орон нутгийн иргэдийн эрх ашгийг бус, намын эрх ашгийг хамгаалж байна. Хэрэв орон нутгийн иргэд өөрсдийн эрх ашгийг төлөөлөх уг орон нутагт оршин суугаа бие даагчдыг ядаж доод шатны ИТХ-д дэвшүүлэн гаргаж ирэх боломж байсан бол, мөн орон нутагт эрхийг нь тодорхой хэмжээнд шилжүүлсэн бол энэ асуудал үүсэхгүй байсан.

Дөрөв дэх гол шаардлага бол иргэдийн амьжиргааны төвшний доройтол юм. Энэ нь уг жагсаалтад 14,4 хувийг эзэлж байгаа нь дээрх нийгмийн шударга ёс, үндэсний эрх ашигтай ихээхэн холбоотой юм. Учир нь иргэдийн ихэнх нь амьдралаа сайжруулахын тулд хөрөнгө мөнгө нэхэхээс илүүтэйгээр нийгмийн шударга ёсыг шаардаж байна. Нийгмийн шударга ёсыг тогтооно гэдэг нь хүнд суртал, авлигал, хээл хахуулийг устгах, шударга шүүхийн тогтолцоог бий болгоно гэсэн үг юм. Төр үүссэн үеэс, одоо ч, мөн цаашид төр байх юм бол ирээдүйд ч төр оршин байх үндсэн таван үүрэг байдаг бөгөөд үүний дөрөв дэх гол үүрэг нь нийгмийн шударга ёсыг хамгаалдаг шударга шүүхийн тогтолцоо юм.

Дараагийн 5,6, 7 дахь шаардлагууд болох бүлгийн сонирхол 10,2 хувь, хувь хүний эрх, эрх чөлөө 6 хувь, мөн 3,6 хувийг эзэлсэн социал сонирхлын шаардлагууд нь ардчилсан нийгэмд байнга байж байдаг мөнхийн шаардлагууд гэж үзэж болно.

Иргэний хөдөлгөөнүүдийн тавьсан эдгээр шаардлагуудын эхний дөрөв болох нийгмийн шударга ёс, үндэсний эрх ашиг, байгаль орчин ба уул уурхай, амьжиргааны төвшин зэрэг нь тэдний үйл ажиллагааны үндсэн чиглэл болж байгаа бөгөөд нийт шаардлагын 81 хувийг эзэлж байгаа нь төр засаг ба улс төрийн намуудад иргэд юуг шаардаж байгааг илэрхийлж байна. Үүнийг ямар нэгэн хүмүүсийн хувийн захиалга, улс төрийн амбиц хөөсөн хүмүүсийн үйл ажиллагаа хэмээн тайлбарлах нь үнэн бодит байдалд тэр бүр нийцэхгүй байна. Учир нь эдгээр шаардлагуудын хариу тэр бүр биелэгдээгүй ч тодорхой хэмжээнд монголын улс төр, нийгмийн зохион байгуулалт, оюун санаанд ихээхэн нөлөөлж, багагүй хэмжээний өөрчлөлт оруулахад шахалтын механизмын үүрэг гүйцэтгэсээр иржээ.

Иргэдийн хөдөлгөөнүүд, шахалтын бүлгийн тавьсан шаардлагууд улс төрийн ямар үзэл суртал, үзэл баримтлалд илүү их хамааралтай байна вэ? гэдгийг ангилан ялгах зорилго тавьсан. Энэ ангилан ялгалтад 2004-2008 оны хооронд Монголын улс төрийн үйл явцад иргэний хөдөлгөөнүүдийн тавьсан шаардлага ямар үнэт зүйлст илүү тулгуурлаж байгаагаар нь авч үзсэн.

Хүснэгт 2. Иргэний хөдөлгөөнүүдийн тавьсан шаардлага түүний чиг хандлага

	Нийгмийн шударга ёс, тэгш байдлыг шаардсан социал демократ хандлага	Хувь хүн ба бүлгийн эрх ашгийг дээдэлсэн либерал чиг хандлага
1	2005.02.03 “Эрүүл нийгэм иргэний хөдөлгөөн” Ялалтын талбайд цуглаан хийж, Сүхбаатарын талбайд цуглаан зохион байгуулах зөвшөөрөл олгох, их хурлын гишүүдийг огцруулах, улс төрийн намын тухай хуулийг өөрчлөх;	2004 онд Архангай аймгийн Цэнхэр сумын иргэд алт олборлохыг зогсоохыг шаардсан хөдөлгөөн хүчтэй тэмцэв.
2	2005.02.23 “Эрүүл нийгэм иргэний хөдөлгөөн”- Тэд “Энхбаяр бол Сталин мөн”, “Энхбаяр огцор”, “Хариуцлагатай ёс суртхуунтай улс төрчийг хүсч байна”, “Авилгад идэгдсэн эх орноо аварья” гэсэн лоозунгууд барьсан байлаа.	2003,12,15 “Зөөлөн эх” хоршооны хохирогчид (Удирдах зөвлөлийн дарга Цэрэндэжид нь) японы бизнесмэнтэй хамтран Япон явуулна гэж 124 хүн тус бүрээс 3500 доллар аваад буцааж өгөөгүйг эсэргүүцсэн суулт зарлаад дараа нь

		өлсгөлөн зарлав.
3	2006.01.12 МАХН-ын байранд “Эрүүл нийгэм иргэний хөдөлгөөн”, “Эрс шинэчлэл” хөдөлгөөн болон ард иргэд дайран оров. Монголд коммунистууд засгийн эрх барьж байгааг шүүмжилсэн.	2006.01.02 Улаанбаатар хотод автобусны үнийг нэмэхийг эсэргүүцсэн хөдөлгөөн. 200 төгрөг байсан 300 болов.
4	2006.04.05 “Эрс шинэчлэл”, “Эрүүл нийгэм иргэний хөдөлгөөн”-үүд засгийн газрын ордоны өмнө цуглаан хийж дараа нь Сүхбаатарын талбайд гэр барин “улс төрийн суулт” хийсэн. Уг суултын шаардлага нь “Монголын газар шороог гадаадынханд бүү худалд” гэсэн үндсэн шаардлага байсан.	2006.09.11 “Монголын оюутны хөдөлгөөн” - ий залуучууд цуглаан хийв. Тэд “Боловсролоор бизнес хийхээ боль”, “Төрийн өмчийн барилгыг бидний мөнгөөр барихыг эсэргүүцэж байна. “Авилга хээл хахууль авсан захирлыг зайлуул” гэсэн лозунг барьсан байв.
5	2006.04.11 Сүхбаатарын талбайд гэр барьж суултаа үргэлжлүүлэв. Ашигт малтмалын тухай хуулийг өөрчлөх, Айвенхо Майнз компанитай Тогтвортой байдлын гэрээ хийхийг эсэргүүцэв. “Эрс шинэчлэл хөдөлгөөний 10 хүн өлсгөлөн зарлав.	2004.04.19 Бага оврын автобусны жолооч нар замын цагдаагийн газар эсэргүүцлээ илэрхийлж 30 автобус замын цагдаагийн газрын дэргэд эгнүүлэн зогсоов. Замын цагдаагийн хүнд суртал, авилга зэргийг эсэргүүцэв.
6	2006.04.13 “Ахмадын чөлөөт холбоо” нэмэгдэн “Оюу толгой, Таван толгойн ордыг яаралтай хааж ашиглалтын лицензийг хурааж авахыг шаардав. Уг шаардлагыг хүлээж авахгүй бол засгийн газрыг огцруулах тухай шаардаж байв.	2007.06.13”Монголын олон нийтийн радио телевизийн 18 уран бүтээлч хэвлэлийн хурал хийлгэж тус байгууллага нь улс төрийн намын нөлөөнөөс салж чадахгүй байна. УИХ, Засгийн газарт тус радио телевизийн зөвлөлийн гишүүдийг огцруулах шаардлага тавив. Шаардлагыг хүлээж авахгүй тохиолдолд ажил хаяхаа мэдэгдэв.

7	2006.04.18 Энэ өдрийн жагсаал олон хүнийг хамарсан ба зохион байгуулагчид МАХН-ын төв байрлуу очин намын нарийн бичгийн даргад шаардах бичгээ гардуулав. Уг шаардлагад М.Энхболдыг ерөнхий сайдаас огцруулахын зэрэгцээ МАХН-ыг шүүмжилсэн. Шаардах бичгийг намын нарийн бичгийн дарга С.Баяр хүлээж аван намынхаа удирдах зөвлөлөөр ярилцахаа илэрхийлэв.	2008.03.03 Хэнтий аймгийн “Хөдөө арал” байгаль хамгаалах бүлэг Дэлгэрхаан суманд хийж байгаа уул уурхайн хайгуулыг зогсоохыг засгийн газраас шаардав.
8	2006.04.23 ерөнхий сайд М.Энхболдтой уулзаж “Оюутолгой, Таван толгой, Бороо гоульд компаний асуудал”-аар ажиллаж байгаа ажлын хэсэгт хөдөлгөөний төлөөллийг оролцуулан, их хурал, засгийн газар хөдөлгөөнд оролцогчид адил тэгш эрхтэйгээр шүүн хэлэлцэх санал тавив.	2008.06.05 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд автобусаар үнэтэй зорчих болсныг эсэргүүцэн Сүхбаатарын талбай, хотын захиргаа, засгийн газрын ордны үүдэнд жагсаал хийгээд МАХН, АН-ын төв байрны өмнө өлсгөлөн зарлахаа мэдэгдэв.
9	2006.06.14 “Эрүүл нийгэм иргэний хөдөлгөөн” болон” Ард түмний нам” Сүхбаатарын талбайд цуглаан хийж, Канадын “Централь гоульд” компаний хөрөнгө оруулалттай “Бороо гоульд “ компаний уул, уурхайн ажиллагааг зогсоох, тогтвортой байдлын гэрээг цуцлах, 50 сая долларын хөрөнгө оруулалтын мөнгө хэний гараар орсныг тодруулахыг засгийн газраас шаардав.	
10	2006.11.6-8 “Эрс шинэчлэл”, “Эрүүл нийгэм иргэний хөдөлгөөн”, “Миний Монголын газар шороо”, “Даяар Монгол”, “Ахмадын чөлөөт холбоо зэрэг хөдөлгөөнүүд Сүхбаатарын талбайд “Бүх ард түмний хуралдай”-г хуралдуулав. Ашигт малтмалын хуулийн хэрэгжилтийг зогсоох, УИХ-ыг тарааж, ерөнхийлөгчийг огцруулах, “Бүх ард түмний онц их хурал” хуралдуулах гэсэн асуулт бүхий 3 мянга гаруй асуулгын хуудас тараасан.	
11	2007.04.27 Монголын ардчилсан холбоо цуглаан хийж, “Хоёрдугаар ардчилсан хувьсгалыг өрнүүлнэ” “Чин шударга хүчирхэг улс төр, чинээлэг иргэний нийгмийн төлөө нэгдэцгээе!” гэсэн ухуулах хуудас нааж, “Ард түмнээ сонсдоггүй УИХ-ыг тараая”, “Авилгач М.Энхболдыг огцруулъя”, “Уул уурхай болон засгийн эрхийг ард түмэнд”	
12	Иргэний хөдөлгөөнүүд 2008 оны УИХ-ын сонгууль болон орон нутгийн сонгуульд нэр дэвшихээ илэрхийлэв. (“Өнөөдөр”. 2007.04.24)	
13	2007.05.01 “Монголын иргэний холбоо” Сүхбаатарын талбайд цуглаан хийж “Авилгын эсрэг” гарын үсэг цуглуулав.	
Дүн	13	8
Эзлэх хувь	61.9%	38.1%

Дээрх хүснэгтэд бичигдсэн санамсаргүйгээр сонгосон нийт 21 шаардлагын 13 буюу 61,9 хувь нь социал демократ, үлдсэн 8 буюу 38,1 хувь нь либерал хандлагатай байна. Эдгээр шаардлагуудаас дүгнэн үзэхэд монголчуудын нийгмийн оюун санаа, улс төрийн ухамсрын орчинд нийгмийг бүхэлд нь ардчилах үзэл санаа өндөр хувьтай байгаа нь өнөөгийн улс төрийн намуудын үзэл баримтлалын чиг баримжааг энэ чиглэл рүү хандуулах шаардлага хүссэн хүсээгүй бий болох нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, оролцоот ардчиллын загвар нийгмийн оюун санаа, улс төрийн ухамсарт бүрдэж байгаа нь иргэний нийгмийн байгууллагуудын тавьж буй шаардлагаас тодорхой харагдаж байна.

Онолын хувьд иргэдийн оролцоо ба төр, захиргааны хоорондын зохицуулалтад ялгаатай хандлагууд байдаг. Энэ нь иргэд, хувь хүмүүсийн эрх чөлөөний тухай үзэл санаанд тулгуурладагаараа ижил юм. “Хүн өөрөө өөртөө зааварчлах хуулийг үг дуугүй даган мөрдөх”, хүмүүс эрх чөлөөтэй байх “албатай” зэрэг үгс нь магадгүй Руссогийн хэрэглэсэн хамгийн зартай үгс байх.¹¹⁸ Руссогийн оролцооны тухай ойлголтын эхний бүлэгт түүний эрх чөлөөний тухай үзэл бичигдээгүй байсан бол дээрх тодорхойлолтын хээнцэр мөртлөө, хөнөөлтэй үгс байж боломгүй санагдах байсан биз. Руссогийн эрх чөлөөтэй байхыг “албадсан” нь түүний илгээмжийн нэг хэсэг бөгөөд шийдвэр гаргалтад оролцооноороо иргэд суралцаж боловсрохоос өөр аргагүй болдог аж. Бие хүн бүр нийгмийн хариуцлагатай ажил үйлд оролцохгүй бол хүн бүрийн ашиг сонирхлыг хамгаалах хууль гарч ирж чадахгүй хэмээн тэрээр үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл, хүн өөртөө захиран тушаах эрх мэдэл, нийтийн хүсэл зориг гэж байхгүй болно гэсэн үг юм. Руссогийн эрх чөлөөний тухай ойлголт дахь субъектив элемент нь тус хуулийн дор бие хүн сайн дурын байна гээд, чөлөөтэй байхыг үргэлж дурдсан байх юм. Руссо эрх чөлөө нь өөрөө захиргааны зохих түвшинг шаарддаг гэж үзсэн.¹¹⁹

Кранстон Руссогийн “Нийгмийн гэрээ”-ний сүүлийн үеийн танилцуулга дээр, түүнийг нийгмийн институцууд нь өөрөө эрх чөлөөнд заналхийлж байгааг огт дурсаагүй хэмээн шүүмжилсэн байна. (Руссо, 1968, 41-р тал) Энэ нь үнэндээ утгагүй шүүмжлэл юм гэж К.Пэйтман няцаасан байдаг. Тэрээр “Нийгмийн Гэрээ” дэх оролцооны систем нь үйл ажиллагааныхаа логик дараалал, институцийн доторх эрх мэдлийн бүтэц, сэтгэл зүйн хүрээлэл зэргээс болж эрх чөлөөнд заналхийлж байна уу гэвэл худлаа. Харин ч Руссогийн үзсэнээр оролцоогүй институциуд тийм заналхийллийг авчирдаг бөгөөд, хүмүүсийг “гинжилж” эрх чөлөөг нь боодог. Нийгмийн Гэрээнд байгаа идеал институциуд нь Руссогийнхоор бол эрх чөлөөний баталгааг хангаж байгаа учраас төгс юм. Мөн оролцоо бол хувь хүнийг өөрөө өөртөө эзэн байх боломжийг олгосноороо, эрх чөлөөний үнэ цэнийг өсгөдөг юм гэж Руссо харсан байна гэж онцлон тэмдэглэжээ.

Руссогийн онолын үлдсэн хэсэгт ч “өөрөө өөртөө эзэн байх” ойлголт нь ихээхэн зэмлэл хүлээдэг.¹²⁰ Маунтайн Руссогийн найм дахь захидалд, эрх чөлөө нь 'moins a faire sa volonte qu'a n'etre pas soumis a celle d'autrui; elle con-siste encore a ne pas soumettre la volonte d'autrui a. la notre. Quiconque est maitre ne peut etre libre'. (1965, бүлэг 11, 234-р тал)-аас бүрддэг гэжээ. Энд хүн өөрөө өөрийнхөө эзэн болох чадвар суух хүртэл захиргаан дор явснаар эрх чөлөө нь хэрэгжих тохиолдол бий ч, хэн нэгний амьдрал үзэл бодлыг өөр нэгэн хүн эзэгнэж болохгүй. Хоёрдугаарт, оролцоот үйл явц нь аливаа хүн юмуу бүлэглэл нөгөөгөө ноёрхдог байж болохгүй, бүгд хуулийн өмнө эрх тэгш байхыг

¹¹⁸ J.J.Rousseau. The Social Contract. M.Cranston (trans), 1968. P-nguin Books. P 64-65.

¹¹⁹ J.J. Rousseau. Political Writings, Watkins, F. (trans). Nelson, London., 1953(бүлэг 18, 148-р тал), (1953, 192-р тал)

¹²⁰ J.J. Rousseau. The Social Contract. M.Cranston (trans), 1968. P-nguin Books. (1968, 42-р тал). Дээрх санааны хамгийн танил шүүмжлэл нь дээрхийг либертари ч биш, тоталитаритай төстэй, мөн ардчилалд тохирох эрх чөлөөний хувилбар болох эрх чөлөөний сөрөг (негатив) ойлголттой ямар ч авцалдаагүй гэдэг байна. Гэтэл энэхүү шүүмжлэл нь эрх чөлөөний тухай хоёр өөр төрлийн ойлголт байдгийг ер тооцоогүй бөгөөд, Руссо бол эерэг (позитив) талыг төлөөлөгч юм. Тэгэхлээр дээрх шүүмжлэл нь Руссогийн онолыг бүхэлдээ алдаатай гэж үзэх гээд байгаа. Хэрэв тийм бол Руссогийн эрх чөлөөний тухай онол няцаагдах ёстой байлаа. Шүүмжилсэн тайлбаруудыг дэлгэрэнгүйгээр нь Берлин/1958/, Талмон/1952/- ийг үзнэ үү.

баталгаажуулдаг. Руссогийн, оролцоот системээр бий болсон хууль тогтоомжийг бие хүн үнэнч шударгаар даган мөрддөг гэсэн. Энэ нь хуулийн алагчлалгүй үйлчлэх зарчмыг бодит болгож чадсан зүйл мөн. Оролцоог хэрэгжүүлснээр, хувь иргэнийг өөрөө тухайн нийгэмд харьяалагддаг болохоо ойлгож ухаарахад хүргэдэг, нэгтгэгч шинж чанартай гэж Руссо үзсэн.

Эдийн засгийн үндсэн тэгш байдал гэдэг нь ядуу баяны хоорондох ялгаа хямралын түвшнээс ямагт доогуур байхыг л хэлж байна. Эдийн засгийн тэгш байдлаас илүүтэйгээр шийдвэр гаргалтанд оролцсон туршлага чухал юм. Хувь хүн бүрийн идэвхтэй оролцоо нь л Руссогийн энэхүү системийг жинхэнэ нийгэм, нийтлэг болж бүрэлдэхэд нь түлхэц болно. Руссогийн шалгуурууд нь бидэнд, институциудын засаглалын бүрэлдэхүүнүүдийн хооронд харилцан хамаарал, хүмүүсийн зан чанар, олонхийн оролцооны түвшин нь сэтгэл зүйн болоод хандлагын хувьд маш их нөлөөтэй зэрэг зүйлсийг бодолцоход хүргэсэн. Чухам энэ асуудлууд л Руссогийн оролцоот ардчиллын тухай онолынх нь суурь болдог.

Ж.С.Милл “Ардчилал дахь хамгийн том аюул бол эрх баригчдын хөнөөлтэй хүсэл зорилго байдаг. Хариулт нь нэхэгдсэн хамгийн чухал асуулт гэвэл, ийм мангасын өөдөөс ямар хамгаалалт байна вэ гэдэг л байна” гэж төлөөллийн засгийн газрын тухай яриандаа онцолсон байна.¹²¹

Миллийн хувьд ардчилсан засгийн газарт байх хоёр янз байдлыг тодотгосон. Энэ нь нэгдүгээрт сайн засаглалд шаардагдах нөхцөлтэй дотуураа холбогдох ба бизнесийн мэдрэмж нь хувь хүний зөв зан чанарыг хөхүүлэн дэмжих явдал бөгөөд үүний тулд байгууллагууд зөв байх нь нэн чухал юм. /1963, 102-р х/ Энэ шалтгаанаар засгийн газрын дээрх хэлбэр нь универсал /олон талын/ ашиг сонирхол бүхий хэлбэр бөгөөд Милл үүнийг нийтлэг, ардчилсан засгийн газрын “хамгийн сайн улс төрийн бүтэц” гэж үзсэн байна.

Ийм учраас тэрээр өөрийн тайлбарласан сайн санааны дарангуйллын эсрэг байсан ба хэрвээ далдыг урьчилан харсан бол засгийн газрын бизнес талыг зөв зохион байгуулах байсан гэдгийг батална. Учир нь тэрээр “Ямар төрлийн хүн ийм дэглэмд захирагдах вэ? Уг дэглэмийн дор тэдний үзэл бодол, идэвхтэй үйлдлийг хэрхэн хөгжүүлэх вэ?” гэсэн асуултуудыг хөндөж тавьсан юм. Тэдний ёс суртахууны ур чадвар тэгш хөгжилгүй байна. Хүн төрлөхтний оршин амьдрах нийгмийн орчин нөхцлийг хиймлээр дүрсэлж зурснаар тэдний оюун санаа, сэтгэхүйг нарийсгаж, хөгжлийг нь зогсооно. /1910, 203-4 х/

Энэ нь зөвхөн тодорхой түгээмэл сэдвүүд дотор хамаарах ба Миллийн идэвхитэй гэж үзсэн оролцогч дэг журмууд нь шинж чанарын хувьд олон нийтийг хамарсан эрч хүчтэй шинжтэй байна. Энд дотоод харилцааны ардчилсан оролцоо болон хувь хүмүүсийн хоорондын харилцаа холбоо, тэдний шинж чанар, сэтгэл зүйн зан чанарууд, дэг журмын төрөл зүйлийн талаар онолчидийн дэвшүүлсэн үзэл санааг дахин олж харна. Уг үзэл санаанд хувь хүний улс төрийн шинжтэй хийх үйлдэлтэй холбогдох дэг журмуудаас их хэмжээгээр хамааралтай нийгмийн болон улс төрийн хариуцлагатай үйл ажиллагааны талаарх үзэл санаа бас орно. Руссогийн нэгэн адил Милл бас эдгээр чанарууд нь урьдны адил оролцоог нэмэгдүүлдэг учраас улс төрийн систем нь өөрөө оршин тогтнох шинж чанартай гэж үзсэн¹²².

J.N.Burns. J.S Mill and Democracy. Political Studies. 1957. Милл (1910) Оршил ба 254-р тал. Дэлгэрэнгүйг Бүрнс (1957)-д үз. "Дункан ба Люк (1963, х. 160) Уг тогтолцооны өөрөө үлдэх чадварыг тэмдэглэнэ. Гэвч энэ бол эрчүүдийг оролцоонд сургах боломжит хууль ёсны эрхийг эзэмших эзэмшлээс үүдэн гарах учраас “ёс суртахууны шинж чанар”-ын хандлагатай байна гэж хэлнэ. Мэдээж энэ бол зөвхөн сургах асуудал болохоос эзэмших тухай бус гэсэн Миллийн дүгнэлт юм. Оролцооны дэг журам байхгүйгээр хууль ёсны эрхийг эзэмших нь шинж чанарын хувьд бага зэрэг нөлөөтэй байж болно.

¹²² К.Пейтман. Ж.Ж.Руссо, Жон Стюарт Милл, Ж.Д.Х. Коул: Ардчиллын оролцооны онол/Улс төрийн шинжлэх ухааны дээж бичиг. Орч Ц.Батболд. УБ., 2012. Х 184-185.

“Үүнээс гадна Милл иргэд логикийн ухаалаг, оновчтой тооцооллыг гаргаж хэрэгжүүлэх ёстой гэж үзсэн юм. Үүнийг Шумпетер бас чухал гэдгийг тодорхойлсон. Тэр төлөөлөх засгийн газрыг засгийн газрын оновчтой хэлбэр бус гэж тэмдэглэсэн ба эрчүүдийг идэвхжүүлэх “томоохон” хууль тогтоомж гаргах шаардлагатай гэж тайлбарласан. Мөн тэрээр энэ онолд хамаарах аль ч улсад улс төрийн голч мэргэн ухаан, олон нийтийн идэвхи чармайлтын тодорхой түвшин байна гэж баталсан. /1910, 253х/ Милл улс төрийн оролцооны боловсролын үүргийн талаар Руссотой олон талаараа адил санааг дэвшүүлсэн.

Тэрээр хувь хүн зөвхөн өөрийн хувийн асуудалдаа анхаарал хандуулан олон нийтийн үйл хэрэгт оролцохгүй байсаар “хувиа хичээгч” болж хувирах төдийгүй улмаар нийтийн үйл хэрэгт оролцох хариуцлагагүй, хөгжил хүмүүжилгүй болж үлднэ хэмээн шүүмжлэлтэй хандсан. Ийм хүн хэзээ ч олон нийттэй найрсаг нөхөрсөг байх сонирхолгүй, хамтран нэгдэж хийх аливаа зүйлд дургүй байх төдийгүй харин ч олон нийттэй өрсөлдөх, эсэргүүцэх гэх мэт санаа бодол, үйлдлийг агуулдаг. /1910, 217 х/ Хувь хүмүүс хувиараа мөнгө олохдоо ихэвчлэн өөрсдийн чадварын маш бага хэсгийг ашигладаг ба “зөвхөн өөртөө болон өөрийнхөө гэр бүлд бүх анхаарал, сонирхлоо хандуулдаг” нь түүнийг олон нийтээс огт өөр болгодог. Ингэж түүний энэ хэвийн бус сэтгэлгээ нь түүний хувийн зан чанарыг амиа бодогч, аймхай хулчгар болгоно. /1963, 230х/

Гэвч хувь хүн нь олон нийтийн үйл хэрэгт оролцож эхлэхэд бүх зүйл өөрчлөгдөж болно. Милл энэ тохиолдолд Руссогийн адил хувь хүн өөрийн хүрээлэн буй бүсийг өргөтгөхийн тулд “хүчин зүтгэл гаргах” ёстой бөгөөд олон нийтийн сонирхолтой болох явдал чухал гэж үзсэн. Энэ нь хувь хүн зөвхөн өөрийн хувийн бус ашиг сонирхлыг “жинлэж” үзэх ёстой бөгөөд ямар нэгэн шаардлагаар зөрчилдөх тохиолдолд өөрийн хувийн мөрддөгөөс өөр дүрэм журмаар шийдэх, ямар ч тохиолдолд “өөрийн оршин байгаа учир шалтгаан, түүний учир утга, дэг журманд олон нийтийн ашиг сонирхлын үүднээс хандах” явдал юм гэж хэлсэн. (1910,х. 217).

Мөн цаашилбал, Миллийн онол нь нийгмийн оролцоонд боловсролын үүргийн талаарх асуудалд Руссогийн үзэл бодлыг улам хүчирхэгжүүлсэн боловч, Миллийн онолд бас нэг өөр чанар байсан нь хэрвээ уг онол нийгэмд өргөн хүрээг хамарвал уг таамгийн ирээдүйн цар хүрээг тэлсэн чухал хэмжээс болох юм. Би Токвилийн “Америкын ардчилал” номонд хийсэн Миллийн дүгнэлтийн нэгнээс аль хэдийнэ иш татсан. Энэ бүтээл нь Миллийн улс төрийн онолд ба ялангуяа орон нутгийн улс төрийн байгууллагуудын тухай хэсэгт тодорхой нөлөөлөл үзүүлсэн.¹²³

Милл нь Токвилийн төвлөрлийн болон массын нийгмийг хөгжүүлэхэд дагалдах бэрхшээл, айдсын тухай ярьсан хэсэгт их анхаарч гүн сэтгэгдэлд оржээ. (Орчин үеийн социологчдын дунд иймэрхүү судалгаанаас цочирдсон энэ айдас одоо ч байсаар л байна.) Улс төрийн эдийн засагт Милл “ардчилсан байдал нь нарийндаа ардчилсан хууль тогтоомжоос бүтдэггүй, харин төв засгийн газраар хязгаарлагддаг, энэ бол улс төрийн эрх чөлөө гэсэн үг биш төдийгүй буцалтгүй эргэлт хийх зорилго эрч хүчийг бүтээдэг зүйл юм” гэж үзсэн.¹²⁴ Милл Токвилийн номны II бүлэгт хийсэн дүгнэлтдээ “хэрвээ хувь хүн орон нутгийн түвшинд нийгмийн оролцоонд бэлтгэгдээгүй бол үндэсний засгийн газарт өргөн хамааралттай сонгуулийн эрх, оролцоо байхын ч хэрэггүй юм гэж шүүмжилсэн. Орон нутгийн түвшин гэдэг бол хувь хүн өөрийгөө хэрхэн удирдан захирахад суралцах түвшин гэж үзсэн.

“Улс төрийн үйл ажиллагаа нь хэдэн жилд зөвхөн ганцхан удаа хийгдэх ёстой бөгөөд иргэдийн өдөр тутмын хэвшмэл үйл ажиллагаа нь тэднийг улс төрийн оролцоонд бэлтгэж тэднийг ухаалаг мөн өөрсдийгөө олох ёс суртахууны зан байдлыг

¹²³ J.S.Mill. Autobiography. World's Classics ed. 1924.Милл (1924, х. 162—4) ба Робсон (1968, х. 106) харах.

¹²⁴ J.M.Robson. Collected Works. (ed). 1965. University of Toronto Press. Бүлэг. XI, §6, х. 944.

хөгжүүлэх ёстой.” /1963, 229х/ Өөрөөр хэлбэл том улсад амьдарч байгаа иргэн, хувь хүн тэрхүү “том нийгмийн”-хээ улс төр, засаглалд идэвхитэй оролцох боломжтой байх, энэ оролцоог тодруулж буй чухал шинж чанаруудыг орон нутгийн түвшинд дэмжиж хөгжүүлэх ёстой гэсэн үг юм. Иймээс Миллийн хувьд улс төрийн оролцоонд боловсролын үр нөлөө хамгийн чухал гэж үзсэн газар нь орон нутаг юм. Энд хувь хүнд болон түүний өдөр тутмын амьдралд нөлөөлөх шууд нөлөөллийн асуудлыг шийдэх төдийгүй орон нутгийн төрийн байгууллагад ажиллахаар сонгогдох сайхан боломж ч нээлттэй байдаг газар юм. (1910, х. 347-8)

Ингэж орон нутгийн түвшинд оролцоог хөгжүүлсэнээр хувь хүн ардчилалд суралцана. “Бид хэрхэн унших, бичих, морь унах, сэлэх тухай хичнээн яриулж тайлбарлуулаад үүнийг сурч чадахгүй, харин түүнийг зөвхөн өөрсдөө хийж байж л сурна. Үүнтэй адил улс төрийн оролцоонд ч ялгаагүй тодорхой хязгаар дотор дадлагажиж сурснаар цаашдаа томоохон хүрээнд хэрхэн оролцох вэ гэдэгт суралцана. (1963, х. 186)

Өргөн хүрээтэй нийгмийн төлөөлөл бүхий засгийн газар чухал боловч түүнд хэд хэдэн хүндрэл гарна. Түүний онолд оролцооны боловсролын үүргийг суурь рольд шилжүүлсэн нийцтэй төлөөллийн тухай Миллийн практик төлөвлөгөө байдаг. Миллийн практик төлөвлөгөөнд улс төрийн оролцооны талаар их шүүмжлэлтэй авч хэлэлцээгүй байна. Учир нь энд улс төрийн болон нийгмийн онол холилдсон төр, нийгмийн “жинхэнэ” мөн чанарын тухай үзэл санаанууд дийлэнх хувийг эзэлж байсан.

Бентам болон Жеймс Милл нар боловсрол гэдэг бол явцуу хүрээнд “сургалтын” чанартай утгыг агуулах боловч, өргөн хүрээнд авч үзвэл хариуцлагатай улс төрийн оролцоог бий болгох гол тулгуур мөн гэж үзсэн. Жон Стюарт Милл энэ үзэл санааг хэзээ ч үгүйсгээгүй юм. Миллийн гол үзэл санаануудын нэг нь боловсролтой элитүүдийн гарт эрх мэдэл нь байхад /энгийн утгаар/ хэрхэн улс төрийн систем амжилтанд хүрч болох тухай асуудал л байсан юм. Сайн боловсорсон ухаантан бусадтай анхаарал болгоомжтой, зөв, үнэнч шударга, ер нь л бусадтай харилцах бидний харилцаанд чухал гэсэн бүх давуу талуудыг өөртөө шингээсэн байдаг. Миллийн үзсэнээр “хамгийн цэцэн мэргэн, хамгийн сайн” төдийгүй улс төрийн бүх түвшинд сонгогдох ёстой гэж үзсэн хүмүүс нь хамгийн сайн боловсорсон (шинжлэх ухааны явцуу хүрээнд), өндөр боловсролтой хүмүүс байна.¹²⁵

Тэрээр ардчилал бол орчин үеийн дэлхийд салшгүй чухал зүйл бөгөөд гол асуудал нь ардчилсан улс төрийн хууль журмыг нийгмийн “жинхэнэ” мөн чанартай уялдуулан, энэ дэглэмд хэрхэн “олонхийг”-ыг хамруулах ажлыг зохион байгуулах явдал юм гэж үзсэн байна.¹²⁶ Миллийн концепцид “олонх” ардчилал гэсэн энэ ойлголтыг хэрэгсэхгүй ч түүнээс өөр үзэл бодолтой байхыг хүсэхгүй байсан бөгөөд үүнийг онцлон тэмдэглэх ёстой гэж үзсэн. Үнэн хэрэгтээ тодорхой хугацаа өнгөрөхөд бүх зүйл боломжтой болно, “ядуу хүмүүс түүнийхээ учир шалтгааныг олдог болно, хэдийгээр тэдэнд заавар, зөвлөгөө, тайлбар, чиг өгөх хэрэгтэй ч тэднийг хэзээ нэгэн цагт нүдээ нээнэ” гэдэгт Милл итгэлтэй байсан. Элитүүдийг хариуцлага хүлээдэг байх ёстой бөгөөд элитүүдийн хариуцлагын дүрэм журмыг дахин гаргах нь Миллийн үзсэнээр улс төрийн хамгийн том бэрхшээл байв. Энэ бэрхшээлийг давах түүний шийдвэр нь улс төрийн оролцооны талаарх өөрийн онолд давхар санааг оруулж хөгжүүлэх явдал байв.

¹²⁵Робсонд дурдсан (1967, х. 210).

¹²⁶Милл (1963, х. 17). Милл нь энэ үзэл тайлбарыг өмнөх хувилбартай нь харьцуулсан ба хуучин сургааль, дэг жаягт бичигдсэн "шилжилт"-ийн тухай энэ тайлбарт "олонхи ямар нэгэн удирдан чиглүүлэх зүйлгүйгээр цаашдаа өөрсдийн итгэл найдварын замаа алдана" гэсэн байдаг. (х. 3).

Ном зүй

- К.Пейтман*. Participation and Democratic Theory. L., 1970.
- J.J.Rousseau*. The Social Contract. M.Cranston (trans), 1968. P-nguin Books.
- J.J.Rousseau*. Political Writings, Watkins, F. (trans). Nelson, London., 1953.
- J.J.Rousseau*. The Social Contract. M.Cranston (trans), 1968. P-nguin Books.
- J.H.Burns*. *J.S Mill* and Democracy. Political Studies. 1957.
- J.S.Mill*. Autobiography. World's Classics ed. 1924.
- J.M.Robson*. Collected Works. (ed). 1965. University of Toronto Press.
- К.Пейтман*. “*Ж.Ж.Руссо, Ж.С.Милл. Ж.Б.Х.Коул*: Ардчиллын оролцооны онол”/Улс төрийн шинжлэх ухааны дээж бичиг/ Орч Ц.Батболд. УБ., 2012.
- Д.Ганбат*. ред “Капитализм, социализм ба ардчилал”/Ардчиллын тухай түүвэр/ Орч Н.Туяа. УБ., УТБА. 2006.

ИРГЭД ТӨРИЙН ҮЙЛД ОРОЛЦОХ АСУУДАЛД

С.БАЗАРПҮРЭВ¹, Б.ЭНХБОЛД²

¹МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, доктор, дэд профессор

²МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн докторант

Түлхүүр үг: Иргэн төрийн үйл хэрэгт шууд оролцоо, төлөөний “засаглал”

РЕЗЮМЕ:

Прямая демократия форма политической организации общества при которой основные решения принимаются непосредственно гражданами; прямое осуществление власти народом в общенациональном и местных масштабах, различные формы принятия решений самим населением общего и местного характера; непосредственное правотворчество народа. Непосредственная демократия — это совокупность способов и форм, при помощи которых личность или коллектив могут самостоятельно включаться в процесс принятия общеобязательных решений, либо участвовать в формировании и функционировании представительной системы, либо оказывать влияние на выработку государственной политики.

“Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцоно” хэмээн Монгол улсын Үндсэн Хуульд тунхагласан байдаг.

Төвөгтэй захирагддаг, хавсарсан нийлмэл олон талт эд эсээс бүтсэн үйл явцыг удирдахын тулд тодорхой зорилго тавин түүнд хүрэх ёстой болдог. Иргэдийн сонирхол, нийгмийн хэрэгцээг бүхэлд нь хангах зорилго нь төр улсын үйл хэргийг удирдах явцад тавигддаг.

Иргэн өөрийгөө л хамгаалах учиртай тиймээс төлөөлөлгүй өөрөө л төрийн үйл хэрэгт шууд оролцож байж л санасан хэрэг нь бүтнэ.

Сонгууль, бүх нийтийн санал асуулгад оролцох, төрийн дээд засаглал болон өөрийн нутгийн удирдлагын байгууллага мөн төрийн алба хаших, төрд хандах зэрэг хэлбэрээр Монгол улсын Үндсэн Хуульд заасан эрхийг эдлэх боломж иргэнд байдаг.

Сонгох сонгогдох эрх нь төрийн албыг төлөвшүүлэх бүх үйл явцын цөм болж, засаглал бүтээх шинжтэй юм. Иргэд өөрсдөө засаглагчид нэр дэвшигчийг сонгож өрсөлдүүлдэг, өөрийгөө мөн санал болгох боломжтой, сонгуулийн өмнөх сурталчилгааг чөлөөтэй явуулах, хуулийн дагуу сонгуулийн комисс байгуулж, санал тоолох, өөрийн төлөөллийг “хамгаалах” зорилгоор төрийн байгууллагад нөлөөлөн төрийн үйл хэрэгт оролцож байдаг гэж үзэж болно.

Нутгийн удирдах байгууллагад оролцон шийдвэр гаргагч эсхүл түүнд нөлөөлөгч болж буй иргэд төрийн үйл хэрэгт шууд оролцох нэн чухал хэлбэрт тооцогддог. Өөрийн чадвар, мэргэжлийн бэлтгэл хангасан зэргээс шалтгаалан төрийн албанд зүтгэх тэгш боломжоор иргэд хангагдсан байдаг. Албаа хаших явцад түүнд ямар нэгэн зохиомол хязгаарлалт болон хөнгөлөлт үзүүлэхгүй байх учиртай.

Төрөөс “зохион байгуулж” буй эрх зүйн “арга хэмжээнд” иргэдийг татан оролцуулах нь төрийн үйл ажиллагааг иргэн мэдэж, зохицуулж байгаагийн илрэл юм.

Аливаа дарамтгүйгээр шүүгч хийж, тангарагтны ажиллагаа эрхлэх боломжоор иргэн бүрэн хангагдах нь төрийн үйл хэрэгт шууд оролцож байна л гэсэн үг.

Иргэдийн оролцооны нэг хэлбэр нь төрийн байгууллагад хандах явдал билээ. Агуулгаасаа хамааран өргөдөл, гомдол, санаа санаачлагыг төр засагт хаяглаж байдаг.

Төрийн үйл хэрэгт шууд оролцох ийм олон төрлийн хэлбэр байдаг ч гэсэн иргэн бүр түүнийг ашиглаж чаддаггүй. Үүний гол шалтгаан нь төрийн эрх барьж буй улс төрийн хүч, төрийн удирдах ур чадвар, сонирхол, чадавхиас хамаарахын зэрэгцээ мөн иргэдийн байр суурь санаа санаачлага, идэвхи хэр байгаатай шууд холбоотой байдаг.

Эртнээс л “Улс төр” болон “Төрийг” судлаачид хүчирхийлэл хэмээн үзэж түүнтэй ижилсүүлж иржээ. Зохион байгуулалттай хүч хэрэглэх үйл ажиллагаа ч гэж улс төрийг тодорхойлох хандлага байна. Локк хүчний эсрэг хүч хэрэглэх нь зүйтэй гэж үзжээ. Үүнээс үүдэн эцэс төгсгөлгүй улс төрийн тэмцэл өрнөж нийгмийг сульдаанд оруулдаг. Улс төрийн бий болгож буй эл хүчирхийллийг нийгмээс ангижруулах чухал арга нь иргэдийг төрийн үйл хэрэгт шууд оролцуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх явдал юм. Төрийн үйл хэрэгт шууд оролцох систем нь хүч үл хэрэглэх удирдлагын системтэй нягт холбоотой юм. Аль аль нь нэг нэгийгээ нөхцөлдүүлж байж нийгмийн зүй зохистой хэв журам тогтох боломжтой. Хүчирхийлэл, албадалгүй хүний үйл ажиллагаа, зан үйлийг удирдах үзэл, санаа өнөөдөр ч судлаачдын сонирхлыг татаж буй асуудалд зүй ёсоор багтаж байна.

Улс төрийн бодлого, төрийг хүчирхийлэгч хэмээн ойлгон, эвлэрч дүжирсэн байдал нийгэмд элбэг тохиолдож байдгаас гадна нийгмийг удирдах төрийн байгууллагыг хүчирхийлэлтэй адилтган төсөөлдөг тал ч бий. Төрийн эрх мэдлийг эзэмшиж буй улс төрийн хүчний араншин, улс төрийн үйл ажиллагаанаас төр хэрхэн “аашлах” нь шууд хамааралтай байдаг. Төрийн засаглал цөөн тооны тодорхой хүмүүсийн гарт орсноор хүчирхийлэлийн хэрэгсэл болдгийг нийгэм, төрийн түүх гэрчилдэг төдийгүй тухайн бүлэг хүмүүс төрийг өөрийн явцуу, амин хэрэгцээг хангах хэрэгсэл болгон хувиргадаг. Ийм байдал өнөөдөр ч байна.

Төлөөний “засаглагч” нь санхүүгийн болон бусад баялаг эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн, төрийн албадах хэрэгслийг ашиглан иргэдийн зан үйлийг удирдах хэвшсэн арга хэрэгсэл гэж үзэж болно. Ард түмний төлөөлөгч хэмээгч нь олон түмний нэрийн өмнөөс, тэдний сонирхол хэрэгцээнд тохируулан засаглалыг хэрэгжүүлнэ гэсэн, бидэнд аль эрт танил болсон энэхүү хэв маяг нь гурван зуун жилийн тэртээ бүрэлдэн тогтсон гэдэг ч ард түмний төлөөлөгч гэж байдаггүй, хоосон зүйл гэдгийг хүмүүний түүх харуулсан байдаг. Улс төрийн сонгууль гэсэн арга, хэрэгслээр цөөн хүмүүс төрийн хүчийг захиран зарцуулах давуу эрх олж, мөн чанартаа засгийн эрх мэдэл эзэмшигч иргэдээс хүнийсэн, хөндийрдөг нь зүй тогтол болсон байна. Сонгуулийн үйл ажиллагаанд оролцохгүй, санал өгөхгүй байгаа иргэдийн тоо сонгуулиас сонгуульд нэмэгдсээр байгаа нь төлөөний “засаглал”, улс төрийн нам, сонгуулийн кампани, парламентат ёс зэрэгт итгэхгүй болсны илэрхийлэл билээ.

Аль ч шатны хурлын гишүүн, засаглалын төлөөлөгчийн эрх мэдэл эзэмшигчийн “сэнтгийг” тодорхой үнэ ханштай болгон “арилжиж” байдаг жишиг тогтоосон явдал нь түүний мөн чанарыг илэрхийлж буй явдал юм. Мөнгөтэй, чинээлэг хүмүүст барьцаалагдсан “төлөөлөгчөөр” дамжуулан санхүүгийн капитал, нөөцтэй хүн нь өөрийн ашиг сонирхолд тааруулан нийцүүлж, нийгмийг зохицуулан түүнд тохиргоо хийдэг жишиг дэлхий нийтэд тогтсон байна. Монголд мөн адил.

Төлөөний “засаглагч” ард түмний эрх ашигт тохирсон “алба” хэзээ ч хашиж байгаагүй нь илэрхий юм. Үндсэн Хуульд “...сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ (засаглах. С.Б.) эдэлнэ. Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэсэн зүйл нь тунхаг төдий л юм. Тиймээс төлөөний “засаглал” нь хий хоосон яриа, ач холбогдолгүй болсон зүйл хэмээн үзэж болно. Энэ нь зөвхөн

оноосон нэг оронд ч бус дэлхийн бүх улсад, хөгжсөн гэх улс гүрэнд ч гэсэн хамааралтай гэж үзэхэд хэлсдэхгүй болов уу.

Төлөөний “засаглалыг” халж, иргэд төрийн хэрэгт шууд оролцох системийг тогтоох шаардлага нийгмийн зүгээс тавигдаж байна. Энд засаглалыг тээгч нь ард түмэн бус, иргэн юм.

Дэлхийн олон улс орны үндсэн хуульд улс төрийн засаглал, эрх мэдэл ард түмний гарт хэмээн тунхагласан байдаг ч ер нь ард түмэн гэсэн ойлголт байдаггүй, зөвхөн тодорхой иргэн л гэж байна. Тухайн иргэн засаглалд хэр хэмжээтэй хэрхэн оролцож байна гэдгээс засаглалын мөн чанар, утга учир ойлгогдож, тайлагдаж болно.

Байгалийн хууль гэдгийг бид ямар ч өчиггүй хэрэгжиж байдаг зүйл хэмээн ойлгодог. Үндэстэн ястны зан заншил, хорио цээрийн хэв журам нь байгалийн хуультай адилтган ойлгох хандлага түгээмэл билээ. Хүн зүй бус юм хийдэггүй нь зан заншил, соёл, ёс суртахуун, уламжлалын л ач гэлтэй. Зан заншил, зан үйлээр нь нийгэм, хүн төрөлхтний оюуны төвшинг тодорхойлж болох талтайгаас гадна хүмүүст их нөлөөлдөг хүчин зүйл гэж үзэж болно.

Үүнээс үүдэн, засаглал гэдгийг ямар ч системийн үйл ажиллагаанд дүрэм тогтоох чадвар гэж тодорхойлж болно. Иргэний нийгмийн хувьд гэвэл засаглалыг хүмүүсийн зан үйл, үйл ажиллагаанд дэг журам тогтоох чадвар хэмээн үзэх талтай. Хүн амын дийлэнхи хэсэг нь хүлээн зөвшөөрч дагаж мөрдөх боломж бүхий дүрэм журмыг тогтоож чадах засаглалыг л нийгмийн болон иргэний эрх ашигт нийцэж буй хэмээн үзэж болно.

Иргэний засаглал хүмүүсийн зан үйлийг зохицуулах шийдвэр болж хувирах тэр үйл явцыг ойлгоход л гол учир оршино.

Засаглагч, ард түмний хооронд нийгмийн гэрээ байгуулагдаж, эрх баригч нь ард түмний сонирхлыг төлөөлдөг гэсэн хэт хялбарчилсан тайлбар бий. Засаглагч гэрээгээ зөрчвөл, ард түмэн түүний эсрэг босох эрхтэй хэмээн номлосон байна. Иймэрхүү агуулгатай баримтлалыг Гоббс болон бусад онолчид хөгжөөсөн байдаг ч нийгмийн гэрээ гэж зүйл байдаггүй, байх ч үндэсгүй, боломжгүй юм. Хүмүүсийн хооронд хийгдэж буй гэрээнд “турав дахь” ч этгээд буюу гэрээг гэрчлэгч түүний хэрэгжилтийг ажиглагч, хянагч байх учиртай. Нийгмийн гэрээнд тийм юм байдаггүй.

Засаглагчийн хийх ёстой үндсэн ажил нь дүрэм журмыг хэрэгжүүлэх явдал гэж үзвэл түүний хүчин чадал, үйл ажиллагааны үр дүн нь хэр албадлагын нөөцтэй байна гэдгээс бус харин тухайн дүрэм журмын талаар иргэд хэр санал нийлж түүнд “элэгтэй” байгаагаас шалтгаална. Нийгэмд тогтож байгаа эсхүл тогтоох гэсэн дүрэм журмыг хэр олон иргэн хүлээн зөвшөөрнө төдий чинээ түүний хэрэгжих магадлал өснө, засаглал чадвар, хүчтэй байна гэсэн үг.

Хүмүүний түүхэнд аль нэг улсын хүн ам тооны хувьд өсөж, төр улсын газар нутгийн хил хязгаар тодорхой болсон эсхүл тэлснээр “ардын хуралд” оролцох учиртай иргэдийн тоо нэмэгдэж, өргөжсөн ч иргэн бүр хуралд оролцох “боломж”, сэтгэл, санаа багасаж цөөн тооны идэвхтэй хэсэг хүмүүс хуралдах ажил эрхэлж, цалин пүнлүү ч авах болж “ардын хурал” гэсэн засаглалын хэв загвар нь үйл ажиллагаа явуулах боломж багасаж, хэрэгжих, үр ашгаа өгөх нь хүндрэлтэй болсноор түүний оронд төлөөний систем үүссэн түүхтэй.

Төлөөний “засаглал” сонгуулийн үйл ажиллагааны үр дүнд иргэдээс засаглалыг салган авч төлөөлөгчид шилжүүлдэг. Эрх зүйн хэм хэмжээгээр энэ нь хууль бус үйлдэл юм.

Иргэдийн хуралд иргэний сонирхлыг төлөөлөх хүнтэй гэрээ хийх нь цорын ганц хууль ёсны үйлдэл ажээ. Гэвч ийм гэрээ байгуулагддаггүй болно. Өнөөдөр байгаа бодит байдал дээр уг гэрээг сонгуулийн санал авах хуудсаар сольсон байна. Энэхүү хуудсанд гэрээнд оролцогч талуудын гарын үсэг байдаггүй, гэрээний хугацаа, гэрээг цуцлах

нөхцөл тусгагдаагүй байдаг учир эрх зүйн ямар нэгэн хариуцлага тооцох боломжгүй юм.

Төлөөний “засаглал” гэсэн байр суурь нь ард түмэн засаг барьдаг гэсэн хий хоосон зүйлд тулгуурласан, тунхаг төдий хууль бус “систем” юм. Харамсалтай нь тийм биш. Ард түмний эрх ашгийг хамгаалан төлөөл нь гэсэн хүн маань засгийн эрх мэдлийг эзэмшин төрийн нүсэр хүчийг ашиглан өөрийн сонирхолд нийцсэн асуудлыг л шийддэг.

Ийм зохисгүй дутагдалтай зүйлийг арилгаж, орлуулах арга хэрэгслийг хүмүүс эртнээс мэдэх билээ. Шавга гүйлгэх буюу шоо хаяж хурлын гишүүдийг бүрдүүлэх дадал хүний амьдралд нэвтрээд удаж байна. Тухайлбал, иргэний төлөөлөгчидтэй “тангарагтны” шүүхийг шавга орхин бүрдүүлж, сонгодог ажил өнөөдөр ч олон оронд хэрэгжиж байгаа. Тухайн шүүхийн гишүүд нь хэдий энгийн хүмүүс ч гэсэн эрх зүйн нарийн, эдрээтэй асуудлыг шийдвэрлэхэд оролцдог байна. Мэргэжлийн хуульчид болох өмгөөлөгч, ялагчид хэргийн мөн чанарыг дээрх хүмүүст таниулдаг ч гэмтэй, гэмгүйг тодорхойлж эцсийн дүгнэлтийг тэд л хийдэг. Энэ нь иргэд засаглалыг хэрэгжүүлэгч болж буй нь илэрхийлэл юм.

Төрийн үйл хэрэгт шууд оролцох системийн нэг чухал асуудал нь иргэд хуралдаа оролцох явдал юм. Ялангуяа шавга хаяж хуралд сонгогдсон иргэд хуралд зайлшгүй суух учиртай. “Хуралд мэргэшсэн”, засаглалыг тусгайлан бэлтгэгдсэн хүн хууль тогтоох байгууллагад сонгогдон сууна гэсэн ойлголт эрүүл бус эндүүрэл, ташаа ухаарал гэдгийг үл ойшоож болохгүй. Нарийн мэргэжсэн мэргэжилтэн хуралд хэлэлцэх асуудлын төслийг бэлдэж оруулах үүрэгтэй. Хурлын гишүүд үг хэлэх, асуулт тавих эрх хязгаарлагдмал, огт байхгүй бол бүүр сайн. Тэд хэлэлцэж буй асуудлаар зөвхөн шинжээчдийн дэвшүүлж байгаа нөхцөл, гарц, шийдлийг сонсож, дэнслэн өөрийн санаа, бодлоо дэвшүүлдэг. Үүний үр дүнд санал авах замаар нэгдсэн шийдвэр гаргана.

Энгийн дийлэнхийн санал авснаар эцсийн шийдвэр гаргаж болохгүй. 51 хувь нь “за” гээд 49 хувь нь “үгүй” гэсэн тохиолдолд тухайн батлах гэж буй нийтээр дагаж мөрдөх дүрэм ажиллахгүй. Төрийн үйл хэрэгт шууд оролцох системд шийдвэр гаргах үйл ажиллагаа нэн хялбар юм. Хуралдагсдын 90 гаруй хувь нь дэмжиж байж л тэр журам мөрдөгдөн, хууль биелнэ. Ийм нөхцөлд ямар ч хууль батлагдахгүй мэт сэтгэгдэл төрж магадгүй ч асуудлын гол нь хуулийн төслийг санаачлагч нь хэн бэ гэдэгт бус, харин хуулийн ач холбогдлыг судалгаа, шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж, иргэдийн эрх ашигт нийцэн тохирч буйг хурлын гишүүдэд зохистой танилцуулах, итгүүлэн үнэмшүүлэхэд оршино.

Иргэд төрийн үйл хэрэгт шууд оролцох системийн нэг гол онцлог гэвэл хурлын гишүүн шийдвэр гаргах “ажил” эрхлэхдээ ямар нэгэн бүлэгт хамрагдах ёсгүй. Аливаа бүлэглэл хүний хувь саналыг нийтлэг болгох хандлага агуулж байдаг тул улс төрийн фракцад хамрагдах нь төрийн үйл хэрэгт шууд оролцох системийн язгуур зарчмыг зөрчиж байна гэсэн үг юм.

Төлөөний “засаглалын” систем нь хууль бус, эрх зүйн үндэслэл султай юм. Тиймээс ч бүлэглэл байгуулж түүнд багтах нь зүй ёсны үзэгдэл хэмээн ташаа ойлгож үзэх чиг хандлага байдаг.

Төлөөний “засаглалаас”, төрийн үйл хэрэгт шууд оролцох системийг ялган онцлох зүйл байдаг.

Нэгд, иргэд төрийн үйл хэрэгт шууд оролцох системийг бүрдүүлэх ажил нь өртөг багатай хийгддэг байна. Хоёрт, төлөөний “засаглалын” системд сонгууль хийсний үр дүнд нам, засгийн эрхийг авч төрийг эзэмддэг байна. “Нам” гэдэг нь нэг юмны хэсэг гэсэн латин гаралтай үг билээ. Тиймээс аливаа нам хүн амын тодорхой хэсгийн эрх ашгийг хамгаалдаг байна. Нэг хэсэг иргэд нь нөгөө хэсэг иргэдийг дарангуйлан өөрийн ноёрхлоо тогтоож байна гэж ойлгож болно. Төрийн үйл хэрэгт шууд оролцох системийн үед ийм үзэгдэл гарахгүй.

Гуравт, төрийн үйл хэрэгт шууд оролцох системийн үед хурлын гишүүдийг хахууль өгч “худалдаж” авах боломжгүй. Шавга татаж ардын хурал бүрддэг учир хэн гишүүн болох нь урьдчлаж мэдэгддэггүй тул сонгуулийн үеэр гардаг бохир үйлдэл хийгдэх боломж огт байдаггүй.

Дөрөвт, хурлын гишүүд нь халдашгүй дархан эрхтэй гэх зохиомол дархлааг эдэлдэггүй, баталж байгаа хуулийн төлөө бүгдээрээ хариуцлага хүлээх ёстой болдог нь ямар нэгэн буруу шийдвэр гаргахаас сэргийлдэг.

Монтескьегийн үеэс л эхлэн засаглалыг шүүх, хууль тогтоох, гүйцэтгэх хэмээн хуваасан байдаг нь хэт зохиомол ташаа ухаарал, төөрсөн санааг төрүүлсэн ажээ. Үнэн чанартаа нийтээр дагаж, мөрдөх боломжтой мөн шаардлагатай дүрмийг батлах нэгдмэл нэг л засаглал байдаг. “Гүйцэтгэх засаглал” нь засаглал биш юм. Засаглалын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах зориулалттай байгууллага. Шүүх тогтолцоо нь засаглагчийн гаргасан шийдвэрийн зөв зохистой эсэхийг дүгнэх шинжээчийн үүргийг гүйцэтгэдэг ба мөн өөрөө шийдвэр гаргах эрх эдэлдэг тул шүүх нь засаглагчийн эд эсийг өөртөө агуулдаг тал бий.

Шавга орхин засаглагчийг тодорхойлох систем нь хэрэгжсэнээр засаглалын шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэн шууд оролцож болно гэдгээ тэд тун удахгүй ойлгон хариуцлага хүлээх чадвар нь төлөвшиж бүрэлдэнэ. Энэ нь иргэд шууд засаглагч болох үйл явцад их хувь нэмэр болох талтай юм. Дээрх систем тогтсоноор иргэн, нийгэм, засаглалд ч ач холбогдолтой шинэ улс төрийн тогтолцоо, харилцаа бий болно. Юуны өмнө сонгууль түүнтэй холбоотой асуудал, засаглалд тэмүүлэх өмчтөний хүсэл үгүй болно.

Иргэн хүн шууд засаг барих загварт дасаж ирэх цагт олон иргэн би засаг барих юм байна гэдэгт итгэлтэй болж, иргэдийн дунд өнөөдөр байгаа үл итгэлцэл, нийгмийн хүнийсэл, улс төрийн итгэлгүй байдал алга болно.

Төрийн үйл хэрэгт шууд оролцох системийн нөхцөлд иргэдийн боловсрол, эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн дотоод аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг гарцаагүй үр ашиг гарах хэлбэрээр бүрэн зохион байгуулж болдог. Багш, эмч, хууль сахиулагч нар нь иргэдийн хурлаас хамааралтай байгаа тохиолдолд зөвхөн иргэнд л үйлчилнэ.

Эдийн засгийн хувьд ч гэсэн өгөөжтэй систем юм. Тухайлбал, тэтгэврийн хангамж баталгаажих боломжтой. Иргэдийн нийгэмлэг, нэгдэл нь өөрийн тэтгэврийн сан байгуулснаар санхүүгийн баялаг нөөц бүрдүүлнэ гэсэн үг юм. Санд байгаа мөнгө нь хаана байгаа нь ойлгомжтой, хаашаа ч алга болохгүй нь тодорхой.

Мөн төрийн үйл хэрэгт шууд оролцох системийн үед төрийн эрх мэдлийг хууль бус аргаар булаан авч эзэмших боломжгүй юм.

Дээр дурьдсан эерэг талууд нь төрийн үйл хэрэгт иргэд шууд оролцох системийг бүрдүүлэн, хэрэгжүүлэх цаг нь болсон гэдгийг харуулж байна. Гэвч гүйцэтгэх засаглал тодорхой хэм хэмжээнд байнгын үйл ажиллагаа эрхэлж байх явцдаа нийгмээс тасарч, иргэдийн санаа бодлыг сонсох сонирхол бага болдог.

Төрийн дэглэгдсэн ухамсар түүний журамласан хүнд хатуу зан үйл нь иргэдийг тэдний үйл ажиллагаанаас тусгаарлаж засаглал, нийгмийн уур амьсгалыг эвдэж болох нөхцөлийг бүрдүүлдэг. Үүнийг залруулах нэг арга зам нь төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэд оролцох явдал юм.

Сүүлийн жилүүдэд нөхцөл байдал өөрчлөгдөж, тоталитар бүтэц задран унаж, хүний сэтгэлгээний болон үйлдэл хийх ажиллагаа нь чөлөөтэй болсон билээ.

Төрийн үйл ажиллагаанд иргэдийг шууд оролцуулах боломжийг бүрдүүлэх чухал алхам бол төрийн байгууллагын зүгээс идэвхи гаргаж нийгмийн гишүүдийг төрийн шийдвэр гаргахад хувь нэмэр оруулах нөхцөл бүрдүүлэх явдал юм.

Үүнийг хэрэгжүүлэхийн тулд иргэдийн оролцоотой шийдвэрлэх төрийн удирдлагын зорилтыг тодорхойлон, өргөжүүлэх.

Иргэдийг төрийн удирдлагын үйл хэрэгт татан оролцуулах албан тушаалтан, төрийн байгууллагыг өөртөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх. Тухайн чиглэлд төрийн албын хийх ажлыг үнэлэх аргачлал, шалгуур тогтоох, эрх зүйн хэм хэмжээг бүрдүүлэх.

Иргэдийн нийгмийн идэвхи санаачлагыг урамшуулах арга зүйг тодорхойлох.

Төрийн үйл ажиллагаанд тэгш бус оролцох явдлыг арилгах. Мэргэжил, боловсрол, хүн амын хүчин зүйл болон хот хөдөөгийнх гэлтгүй тэгш оролцох бололцоогоор хангах ажиллагааг хийх.

Иргэдтэй харьцах төрийн бодлгийн боловсруулж, төрийн албан хаагчийн иргэдтэй зохистой харьцах сургалт зохион байгуулах.

Олон нийтийн байгууллагыг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг хялбарчлах мөн иргэдийн эрх зүйн мэдлэгийг сайжруулах.

“Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцоно” хэмээх Монгол улсын Үндсэн Хуулийн уг заалт хэрэгжих асуудал нь бид бүхний үйл ажиллагаанаас шууд хамаарах билээ.

УЛС ТӨРИЙН ОРЧИН ДАХЬ ИМИЖИЙН НӨЛӨӨЛӨЛ

С.БАЗАРПҮРЭВ¹, У.БАТЦЭРЭН²

¹МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, доктор, профессор

²ШУА-ын ФСЭХ-ийн Улс төрийн судлалын салбарын ЭША, МУИС-ийн улс төр судлалын докторант

Түлхүүр үг: *Имиж, имижийн ангилал, имиж бүрдүүлэх зарчим, имижийн нөлөө, улс төрийн зүтгэлтэн, хошуучлагч, улс төрийн нам, имижмейкер*

THE POLITICAL INTERACTION OF THE POLITICIAN

ABSTRACT: *What is the image of the politician? What is the image of the political party that image? How was it formed?, If that formed image which has been increased and decreased, or changed into disposal?, such mentioned questions are much attracted by the politicians and political scientists and other actors.*

Politicians and political parties attempted to seek in increasing their interactions to the public views or perception which has been formed as a positive relationship and connections with them. Consequently, there are mentioned actors such as politicians, candidates, political parties are paid strongly attention their emphasis to creating images.

The personal image, personal characteristics, and factors that affects to the nominated candidate's appearance has been competed his/her political marketing code as a mirror to show up his/her whether dressing, mental thinking skills, standard of literature/speech, platforms and visional promises of the political party and party candidate, opportunities of the nominated candidates, biographies and reputation, education, business and professional skills, and demonstrate or political election.

In the modern society, that political role or interactions of community organizations are increasingly expanded in the scope of impacts and its working environment. So, the understanding of the image and its role/interactions in the society are strongly admired by the politicians to focusing on this aspect.

ТОВЧ ХУРААНГУЙ: *Имиж тэр дундаа Улс төрийн зүтгэлтэний имиж гэж юу вэ?, Улс төрийн намын имиж гэж юу вэ?, Энэ нь хэрхэн бүрэлддэг вэ?, Энэхүү бүрэлдэн бий болсон имиж нь өсөж, буурч, сарниж өөрчлөгддөг үү? зэрэг асуудлууд улс төрчид болон улс төр судлаачдын анхаарлыг ихээхэн татдаг.*

Улс төрийн зүтгэлтнүүд, улс төрийн намууд нь олон нийттэй харилцаа холбоо тогтоож тэдэнд эерэг нөлөө үзүүлэхийг эрмэлздэг. Тиймээс улс төрийн зүтгэлтнүүд, сонгуульд нэр дэвшигчид болон улс төрийн намууд өөрсдийн эерэг имижийг бүрдүүлэхэд онцгой анхаардаг.

Сонгуульд нэр дэвшигчийн имиж, түүнд нөлөөлөх хүчин зүйлс нь нэр дэвшигчийн гадаад төрх байдал, хувцаслалт, оюуны чадвар, хэл ярианы соёл, намын болон нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, амлалт, түүний хэрэгжих магадлал зэргээс ихээхэн хамаарахын зэрэгцээ нэр дэвшүүлэгч нам ямар байх, нэр дэвшигчийн замнал намтар түүх, нэр хүнд, мэдлэг боловсрол, ажил хэргийн болон мэргэжлийн ур чадвар, хувь хүний шинж чанар зэргийг цогц байдлаар илтгэн харуулах нэг ёсны “толь” нь болдог.

Өнөөгийн нийгэм, улс төрийн орчин, соёл урлаг, иргэний нийгмийн байгууллагын имижийн нөлөөлөл улам бүр нэмэгдэж байна. Иймд имижийн талаарх ойлголт, түүний нийгэмд үзүүлэх нөлөөллийн асуудлыг улс төр судлаачид ихээхэн анхааран судлах болсон.

Имиж нь улс төрч ба сонгогчдын хоёулангийнх нь ашиг сонирхлыг нэгтгэн илэрхийлэх арга хэрэгсэл болдог. Иймд улс төрийн имиж нь төрийн бодлогод нөлөөлөх эрмэлзэл нөгөө талаас түүндээ өөрсдийнхөө болон өөрсдийн хамтрагчдын эрх ашгийг нийцүүлэх, эрх мэдлийг олж авах хэрэгцээ зэрэгт тодрон илэрч байдаг.

Өнөөгийн олонхи сонгогч сонгуульд саналаа өгөхдөө нэр дэвшигч аль нам, бүлгийг төлөөлж буйг төдийгүй түүний хувийн шинж чанар, нэр хүнд, авьяас чадварыг бас харгалздаг болсон байна. Улс төрийн зүтгэлтний имиж гэдэгт тухайн зүтгэлтний талаарх сонгогчдын ойлголт төсөөллийг цогцоор нь багтаан үзэж болдог. Энэхүү улс төрчийн имижийн шинж гэдэгт: Тухайн зүтгэлтний дүр зураг, хүмүүст ойлгогдсон төсөөлөл, нэр хүнд, тэдний үнэлэмж үнэлгээ зэрэг багтдаг.

Сонгогч улс төрчдийн хэлсэн ярьсан зүйл, мөрийн хөтөлбөрийг бүрэн ойлгож ухаарсан гэдэгийнэ биш харин тухайн хүний бүрдүүлж чадсан имижийн шинж байдлыг үндэслэн тухайн нэр дэвшигч субъектэд саналаа өгдөг. Үнэн хэрэгтээ улс төрийн лидерийг зөвхөн бүрдүүлсэн имижээр нь таньж, үнэлж байдаг нь эндээс харагдаж байна.

Улс төрийн шинжлэх ухаанд имиж гэдгийг тухайн улс төрчийн гадаад шинж байдлаас гадна түүний дотоод чанарыг давхар илэрхийлж байдаг ойлголт гэж үздэг. илэрхийлэх ухагдахуун юм.

Улс төрийн имижийг үндсэн хэв шинжээр нь идеальный – үзэл санаа (үзэл төсөөллийн) болон реальный – бодит (яг байгаагаараа)

- Идеальный имиж: Энэ нь хүрэх зорилготойгоо нийцүүлэн тавигдсан имижийн дүр төрх
- Реальный имиж: Энэ нь бодит нөхцөл байдалтай уялдуулан бий болгох зорилгоос үүдэлтэй имижийн төрх юм.

Мөн улс төрийн имижийг: визуаль болон вербаль хэмээн ангилдаг. Визуаль имиж гэдэг нь – тухайн субьектийн имиж нь ТВ, видео бичлэг, хурал цуглаан гэх мэт харах суваг дүр, дүрсээр илрэх хэлбэр болж байдаг бол Вербаль имиж нь – үг яриа болон бичгээр илэрхийлэх имиж юм. Тухайлбал энэ нь хэлж ярьж буй зүйлээр өөрийн имижээ бүрдүүлнэ гэсэн үг.

Имиж ерөнхийдөө хоёр үндсэн хандлагаар бүрэлдэх бололцоотой бөгөөд энэ нь: *жам ёсны* болон *зохиомлоор* үүсэн имиж юм. Имижийг зохиомлоор бүрдүүлэхийг имижмейкерүүд гүйцэтгэдэг.

Имиж юунд хэрэгтэй байдаг вэ? Хэн нэгэнд ямар нэгэн хүний тухай эсвэл ямар нэгэн таатай зохистой зүйлийн тухай тодорхой бодол, сэтгэгдэл төрж байж хэмээн энэ нь тухайн улс төрчийн талаарх сонголт эерэг шийдвэр гарахад нөлөө үзүүлнэ.

Нэг үгээр хэлбэл ямар нэгэн хүн, объект танд таалагдаж байвал танд эерэг сэтгэгдэл, эерэг имиж төрж байна гэсэн үг. Харин танд таалагдахгүй бол эсрэгээр сөрөг имиж бүрдэнэ гэсэн үг. Ер нь аливаа хүн өөрт таалагдсан хүнтэй хамтран ажиллах, түүнийг дэмжин, сонгохыг хүсч байдаг.

Тиймээс ч улс төрийн зүтгэлтнүүд, улс төрийн намууд нь олон нийттэй харилцаа холбоо тогтоож тэдний санаа бодолд эерэгээр нөлөөлөхийг эрмэлздэг. Ийм учраас улс төрийн зүтгэлтнүүд, сонгуульд нэр дэвшигчид, улс төрийн намууд өөрсдийн имижийг бүрдүүлэхэд онцгой анхаарч байдаг нь дээрхтэй холбоотой байна.

Имиж бүрдүүлэх шаардлагатай хүмүүсийг ерөнхийд нь гурван бүлэгт хувааж болох юм. Үүнд:

- Нэгдүгээр бүлэгт: дэлхий нийтийн хэмжээнд болон олон нийтэд хэдийнээ алдартай танигдсан хүмүүс орох бөгөөд тэдэнд имиж бүрдүүлэх шаардлага бий эсэхэд зарим хүмүүс эргэлзэж байдаг. Хэдий тиймч тэд олон түмэнд танил болсон, өндөр нэр хүндтэй хүмүүс ч гэлээ аливаа үйл явдалд тэр тусмаа улс төрийн үйл ажиллагаа, улс төрийн сонгуульд оролцох шаардлага тулгарвал тэдний уламжлалт имижээс гадна улс төрийн имижийг шинээр бий болгох, олон нийтийн дунд тэднийг улс төрийн байр суурь, мэдлэг чадварыг нь таниулах шаардлага зүй ёсоор гарч ирэх юм.
- Хоёрдугаар бүлэгт: тухайн албан тушаал, эзэлж байгаа байр сууриа хадгалахыг эрмэлзсэн, шинэ өрсөлдөгчдөөс эмээн болгоомжилсон, сэтгэл зүйн хувьд түгшсэн байдалтай хүмүүсийг багтаадаг. Тэдэнд өөрсдийн имижийг өсгөн нэмэгдүүлэх, шинээр имиж нэмж бүрдүүлэх шаардлага мөн нэгдүгээр бүлгийнхний нэг адил гарч ирдэг.
- Гуравдугаар бүлэгт: имижийн талаар зохих мэдэгдэхүүн байхгүй буюу эсвэл тэдэнд имиж, имижмейкер хэрэггүй гэж үздэг хүмүүс байдаг. Энэ бүлгийн хүмүүстэй ажиллахад дээрх хоёр бүлгийн хүмүүстэй ажиллахаас илүү хүндрэл тохиолдож болох юм.

Энэ гурван бүлгийн хүмүүстэй ажиллаж, имижийг нь бүрдүүлэх нь тэдний сэтгэл зүйн онцлог, нийгэмд эзлэх байр суурь, өөрсдийнх нь сонирхол, идэвхи чармайлт, зэргээс хамааран үнэлэмж нь өөр өөр байх учир имиж бүрдүүлэх технологи нь харилцан адилгүй байдаг.

Улс төрийн имижтэй зайлшгүй холбоотой ойлголт бол *улс төрийн хошуучлал* юм. Улс төрийн хошуучлал бол улс төр судлалын шинжлэх ухааны нэг чухал судлагдахуун болдог. Хошуучлал нь хүмүүсийн хамтын үйл ажиллагааны бүхий л үед байдаг үзэгдэл. Тухайлбал: Олон нийтийн байгууллага, албан газар, шашин, гудамжны жагсаал цуглаан зэрэгт бүгдэд нь хошуучлагч байдаг.

Хошуучлалын бүх хэлбэрүүдийн дотроос улс төрийн хошуучлал нь онцгой шинжтэй. Хошуучлагч сэтгэл татам арга барилтай байгаад зогсохгүй, тавьсан зорилгодоо хүрэхийн тулд бүлгийг нягтруулах, бүрдүүлэх чадвар чухал гэсэн үзэл санаа сэргэн мандалт, хөрөнгөтний хувьсгалын үед нэлээд дэлгэрсэн байна.

Хошуучлагчид өндөр мэдлэг боловсрол, биеэ авч яваа байдал, илтгэх чадвар, зорилгод хүрэх хүсэл эрмэлзэл, ярианы соёл, хүнтэй харьцах эв дүйгээрээ хүмүүст нөлөөлж байдаг. Өнөө үед имиж бүрдүүлэх үйл ажиллагааны чухал субъект нь улс төрийн намууд болж байна.

Орчин үеийн улс төрийн намуудад “засгийн эрхийг авах, түүнийгээ тогтоон барих” гэсэн үндсэн сонирхол давамгайлдаг. Тэдний хооронд өнөө үед үзэл суртлын илэрхи ялгаа байхгүй болсон. Харин орчин үеийн улс төрийн намуудын бусдаасаа ялгарах гол ялгаа нь тэдний имиж болж байна. Улс төрийн намууд нөлөөллийн хамгийн их үр ашигтай гэсэн арга хэлбэр, сувгуудыг сонгон өөрийн мөрийн хөтөлбөрийг сонгогчдын хүсэн хүлээсэн тэр хэлбэрээр дэвшүүлэх хэрэгтэй болдог.

Улс төрийн нам бүхэн өөр өөрийн гэсэн тодорхой имижтэй байж, түүнийгээ хадгалах, мөн сонгогчдын сэтгэлд хүрэхүйц тийм имижийг бүрдүүлэхийг эрхэмлэдэг. Намууд сонгуульд оролцохын өмнө томоохон хэмжээний судалгаа явуулах хэрэгтэй. Энэ нь сонгогчдын хүсэн хүлээж, шийдвэрлэх учиртай гэсэн тулгамдсан асуудал болон үзэл бодлын хүсэн хүлээсэн үнэт зүйлийг олж тогтооход чиглэгдсэн байх ёстой.

Сонгуулиас сонгуулийн хооронд имиж бүрдүүлэхэд засгийн эрх барьж буй хүчин, сөрөг хүчин хоёрын хооронд ялгаатай тал байдаг. Энэ хугацаанд ямагт бүтэх, бүтэхгүй сөрөг зүйлийг сурталчилах нь сонгогчдыг бухимдуулдаг.

Америкийн судлаач Стив Хупер улс төрийн намын имижийг амжилттай бүрдүүлэх 4 зарчмыг тэмдэглэсэн. Үүнд:

1. Нэгдэл, нам гэдэг “ариун гэр бүл” дотор хагарал байх нь сонгогчдод сөрөг сэтгэгдэл төрүүлдэг.
2. Эдийн засгийн асуудлыг шийдэх чадвартай гэдгээ харуулах.
3. Ирээдүйг харах чадвартай гэдгээ үзүүлэхийн тулд хөгжлийн концепци боловсруулах.
4. Сөрөг хүчинд засгийн эрх шилжвэл ямар аймшигтай зүйл бий болохыг олон түмэнд ойлгуулах зэрэг багтдаг.

Хүмүүсийн хүсэл сонирхлыг өөрийн сэтгэл зүрхэндээ тээж явдаг, түүнийг хэрэгжүүлэх чадвартай гэсэн улс төрийн хүчнийг олон түмэн дэмжих болно гэсэн нэгэн суурь зарчим улс төрийн хүрээнд үйлчилдэг.

Улс төрийн намын имиж бүрдүүлэхдээ анхаарах гол зарчим бол дотоодын эв нэгдэл сайтай, эдийн засгийн аливаа асуудлыг шийдэх чадвартай, ирээдүйг харсан алсын хараатай, сөрөг хүчнийхээ алдаан дээр тоглож чаддаг байх чадвар юм.

Сонгуулийн үед хүмүүсийг яаж өөртөө татах, түүнийгээ ямар арга хэрэгслээр түргэн шуурхай гүйцэлдүүлэх өөрийн санаа бодлоо хэрхэн ойлгомжтой томъёолон сурталчлах зэрэг олон асуудлууд улс төрийн намуудад тулгардаг.

Сонгуулийн төлөвлөгөө нь тухайн нам, түүний гишүүдийн идэвхи санаачлагыг өрнүүлэхэд чиглэсэн байх ёстой.

Улс төрийн сурталчилгаа нь намын гишүүд болон сонгогчдын хооронд идэвхитэй холбоо тогтооход нөлөөлдөг ба намаас нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх итгэл үнэмшлийг сонгогчдод бүрдүүлж намын нөлөөг өсгөхөд чухал үүрэгтэй байдаг.

Түүнчлэн улс төрийн намын имижээ өсгөх, бүрдүүлэх нэг гол зүйл нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл юм. Ер нь нам “амьд” гэдгийг сонгогч олон түмэнд байнга мэдрүүлж байх ёстой. Хамгийн олон хүнд өөрийгөө хүргэх; таниулах суваг бол хэвлэл мэдээлэл байдаг тул түүгээр дамжуулж ямагт өөрийгөө олон түмэнтэй хамт байгаа гэдгээ мэдрүүлж өөрсдийн хийсэн ялимгүй зүйлийг ч бусдад хүргэж,

сонгогчдын өмнө тулгамдсан асуудлуудад хариулт өгч байнгын хөдөлгөөнтэй идэвхитэй байх хэрэгтэй.

Улс төрийн намууд өөрсдийн байр суурь, нэгэнт олсон имижээ хэвээр хадгалахыг ихээхэн эрхэмлэдэг байх ёстой. Засгийн эрх барьж буй нам, хүчний хувьд олон түмний зүгээс дэмжлэг авч, тэдний хэрэгцээг мэдэрч, хүмүүсийн амьдралд урьд хуримтлагдсан, мөн шинээр гарч ирж буй тулгамдсан болон стратегийн асуудлуудыг шийдэхийн төлөө ихээхэн үр бүтээлтэй ажиллах ёстой. Засгийн газар ийм байдлаар ажиллаад зогсохгүй, энэ тухайгаа олон түмэнд байнга мэдээлж байх, өөрийн үйл ажиллагааг ил тод байлгах нь амжилтанд хүрэхийн нэг эх үндэс болдог.

Хүмүүсийн ихэнх нь улс төр сонирхдоггүй (магадгүй бүр ч их сонирхдог байж ч болох юм), улс төрчид бидний төлөө ажилладаггүй гэж үздэг тул улс төрийн намын ухуулга сурталчилгаа нь сонгогчдын үзэл бодол, хүсэл сонирхолтой бүрэн нийцэж байх ёстой.

Нэг үгээр хэлбэл өөрийн үзэл бодлоо олон түмэнд танилцуулахдаа хэрэглэх арга хэлбэр, тактикаа зөв сонгох учиртай.

Улс төрийн намуудын сонгуулийн имиж үндсэндээ дараах 4 зарчимд тулгуурладаг. Үүнд:

1. Сонгууль хүртэл аажмаар удаан хугацааны турш имиж бүрдүүлэх.
2. Өдөр тутмын тулгамдсан асуудалд өөрийн дуу хоолойг гаргах.
3. Намын бус шинжээчдийг өөртөө татах.
4. Имиж нь улс төрийн бодлогыг орлох биш харин түүнийг нөхөн гүйцээгч гэдэг талаас нь ажиллах зэрэг юм.

Энэ бүхнийг хэрхэн ашиглаж зохицуулж байна гэдгээс улс төрийн намын имиж, түүнд хандах олон түмний үнэлэлт ихээхэн шалтгаалдаг байна.

Улс төрийн имижийг өнөө үед мэдээлэл технологийн тусламжтайгаар бүрдүүлэх явдал нэлээд түгээмэл болсон байна. Энэ нь цаг хугацаа хэмнэхээс гадна сонгогч олон түмэнд мэдээллийг үнэн бодиттойгоор хүргэх тэдэнд мөн олон талын ойлгот өгөхөд ихээхэн ач холбогдолтой юм.

Улс төрийн орчин дахь имижийн нөлөөлөл үүрэг нь сонгогч олон түмэнд тухайн субьектын талаарх төсөөлөл, мэдээлэлийг үнэн зөв хүргэхэд ихээхэн ач холбогдолтой байдаг.

Ном зүй

Батцэрэн.У. “Улс төрийн имиж бүрдүүлэлт ба манипуляци”. УБ., 2006.

Дарханбаяр.Ж. “Улс төрийн лидерийн имиж”. УБ., 2000.

Довчин.Ё. “Улс төрийн үг хэллэг нэр томьёоны толь”. УБ., 2005.

“Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил”. Ред: Амарсанаа.Ж. нар УБ., 2013.

“Улс төрийн шинжлэх ухаан”. Ред: Ганболд.Ц. УБ., 2001.

Өлзийсайхан.Ч. “Монгол дахь ардчилсан шилжилтийн үеийн улс төрийн элитийн төлөвшил”.

УБ., 2012.

Панасюк.А.Ю. “Вам нужен имиджмейкер?”. Или о том, как создавать свой имидж. Москва.

Издательство. “ДЕЛО”. 2000г.

Почетцов.Г.Г. Профессия:имиджмейкер. Киев. 2000г.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Ц.ГАНБОЛД

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, профессор

Түлхүүр үг: *Ерөнхийлөгчийн сонгууль, сонгогчид, судалгаа, нас хүйс, боловсрол,*

ABSTRACT: *The aim of the survey was to define the starting condition of Presidential election of Mongolia in 2013.*

The survey data has been collected through quantitative research basic method of questionnaire, and processed by social analysis appropriate programs as well as CS pro for survey data base and SPSS for processing and statistic analysis.

Data collection locations' has been determined by the subscriber. 18 years' old and above electorates' have been survey respondents.

Total selection was 1200 electorates. The feasible average of 1000-1500 electorates' for nation-wide survey has already been proved through last 10 years' research results in Mongolia. Moreover, in America, it has been defined that selection sampling of 957 respondents for total plurality of 1500.000 has 5 % for maximum percentage of failure and 95 % for quotient level.

1. Судалгааны зорилго:

Судалгааны үндсэн зорилго нь 2013 оны Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн гарааны байдлыг тодорхойлох явдал байлаа.

2. Судалгааны арга:

Судалгааны үндсэн мэдээллийг тоон судалгааны үндсэн арга болох анкет, /асуулга/-ын аргаар цуглуулсан болно. Судалгааны үндсэн мэдээллийг нийгмийн судалгааны мэдээлэл боловсруулах программуудаар боловсруулсан. Үүнд тоон судалгааны мэдээллийг CSpro программын тусламжтайгаар мэдээллийн бааз үүсгээд, мэдээлэл боловсруулалт, статистик шинжилгээнд SPSS программыг ашигласан. Судалгааны үр дүнг доорх нийгмийн бүлгүүд болон нийгмийн шинжүүдийн ялгаатай байдлаар нь харьцуулан судлахыг зорьсон. Үүнд:

1. Залуу, дунд, ахмад үеийнхний үзэл бодол, байр суурийн нийтлэг болон ялгаатай талууд
2. Боловсролын түвшингийн ялгаатай байдал
3. Жендерийн ялгаатай байдал
4. Эрхэлж буй ажил, мэргэжил, бизнесийн ялгаатай байдал
5. Хот, хөдөөгийн ялгаатай байдал
6. Мэдээллийн эх сурвалжийн ялгаатай байдал
7. Орон нутгийн онцлог шинжүүдийн ялгаатай байдал

Судалгааны мэдээлэл цуглуулах газруудаа захиалагчийн саналаар сонгосон. Судалгааны эх олонлог нь Монгол улсын 18-аас дээш насны сонгогчид болно.

Түүврийн нийт хэмжээг 1200 сонгогч байхаар тогтоосон. Монголд үндэсний хэмжээний томоохон олон нийтийн санаа бодлын судалгаа явуулахад 1000-1500 хүнээр тогтооход хамгийн алдаа багатай болохыг сүүлийн 10-аад жилд хийгдсэн олон судалгааны практик нотолсныг үндэслэл болгосон. Түүнчлэн Америкийн судлаачдын үзэж байгаагаар 1,500,000 хүнтэй эх олонлогт түүврийн хэмжээ 957 хүн байхад алдааны дээд хязгаар 5 хувь, итгэлцүүрийн түвшин 95 хувь байх болно гэж үзсэн байдаг.

Судалгааны түүврийн бүтцийг оновчтой байлгахын тулд дараахь шалгууруудыг харгалзсан. Үүнд:

- Нас
- Хүйс
- Боловсролын түвшин
- Ажил эрхлэлт ба амьжиргааны түвшин

Насны хувьд ангилал, хувь хэмжээг урьдчилан тогтоогүй. Гэхдээ 18-аас дээш насны хүн амыг дотор нь залуу үе, дунд үе, ахмад үе гэж ангилвал эдгээр үеүдийн тэгш төлөөллийг судалгаанд хамруулахыг зорьсон.

Боловсролын түвшингийн бүх төлөөлөл судалгаанд хамрагдсан. Гэхдээ энд нэг тайлбар хийх нь зүйтэй. Манай сонгогчдын дунд дээд боловсролтой хүмүүсийн тоо нилээд өндөр хувьтай байгаа нь анхаарал татаж байгаа юм. Үүнийг чанарын судалгааны аргаар тодруулж үзэхэд их, дээд сургууль төгссөн хүмүүсээс гадна 1990-ээд оноос өмнө техникум төгссөн хүмүүс мөн одоо их, дээд сургуульд суралцаж байгаа зарим оюутнууд өөрсдийгөө дээд боловсролтой гэж хариулж байсан нь тогтоогдсон.

Таны нас

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	18-27	247	20,5	20,8	20,8
	28-35	284	23,5	23,9	44,6
	36-45	305	25,3	25,6	70,3
	46-55	251	20,8	21,1	91,3
	56-аас дээш	103	8,5	8,7	100,0
	Total	1190	98,6	100,0	
Missing	System	17	1,4		
Total		1207	100,0		

Таны хүйс

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	эр	586	48,6	48,6	48,6
	эм	621	51,4	51,4	100,0
	Total	1207	100,0	100,0	

Боловсрол

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Дээд	545	45,2	46,0	46,0
	Тусгай	162	13,4	13,7	59,6
	дунд				
	Бурэн	418	34,6	35,2	94,9
	дунд				
	Бага	51	4,2	4,3	99,2
	Боловсро	10	,8	,8	100,0
	лгүй				
	Total	1186	98,3	100,0	
Missing	System	21	1,7		
Total		1207	100,0		

Амьжиргааны түвшний хувьд дунд зэрэг гэсэн хариулт өндөр хувьтай байгаа нь Монголчуудын “ашдын билгээс амны билэг” гэдэг ёс заншилтай холбоотой байж болох юм.

Амьдралын түвшин

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Бурэн	85	7,0	8,0	8,0
	хангалуун				
	Чинээлэгд	81	6,7	7,7	15,7
	уу				
	Дунд	756	62,6	71,5	87,1
	зэрэг				
	Ядуувтар	99	8,2	9,4	96,5
	Нэн ядуу	37	3,1	3,5	100,0
	Total	1058	87,7	100,0	
Missing	System	149	12,3		
Total		1207	100,0		

Анкетын асуултад нэгэн зүйлийн хязгаарлалт хийсэн. Энэ нь “мэдэхгүй” буюу “хариулахад хэцүү байна” гэсэн сонголтыг оруулаагүй бөгөөд энэ нь респондентууд идэвхигүй хариулт өгөх явдлыг хязгаарласан хэрэг болно. Өөрөөр хэлбэл сонгогчдыг заавал тодорхой хариулт өгөхийг шахах зорилт тавьсан. Гэхдээ зарим сонгогчид тодорхой асуултуудад хариулахгүй байх боломж олгосон бөгөөд үүнийг SPSS –д задгай орхисон нь Missing System-д тэмдэглэгдсэн. Энэ нь тухайн асуултад хариулаагүй гэсэн утгыг илэрхийлж байгаа. Судалгааны анхдагч мэдээллийг 2013 оны 5-р сарын 23-наас 31-ний хооронд багтаан цуглуулсан болно.

Судалгааны тайланд : 1.Дан тоолол

2.Давхар тоолол буюу харицуулсан шинжилгээ

- 3.Рейтингийн үзүүлэлтүүд
 4.Схем диаграмм
 5.Санал зөвлөмжийг хавсаргасан болно.

Frequency Table

Notes

Output Created		02-JUN-2013 10:12:37
Comments		
Input	Data	C:\Users\Ts.Ganbold\Desktop\ 2013.06.01.sav
	Filter	<none>
	Weight	<none>
	Split File	<none>
	N of Rows in Working Data	1207
	File	
Missing Value Handling	Definition of Missing Cases Used	User-defined missing values are treated as missing. Statistics are based on all cases with valid data.
Syntax		FREQUENCIES VARIABLES=var00001 var00002 var00003 var00004 var00005 var00006 var00007 var00008 var00009 var00010 var00011 var00012 var00013 var00014 var00015 var00016 var00017 var00018 var00019 var00020 var00021 var00022 var00023 var00024 var00025 var00026 var00027 var00028 var00029 var00030 var00031 var00032 var00033 var00034 /ORDER= ANALYSIS .
Resources	Elapsed Time	0:00:00,03
	Total Values Allowed	149796

1.Та 2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох уу?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Заавал оролцоно	833	69,0	69,8	69,8
	Тухайн үеийн байдлаас	320	26,5	26,8	96,6
	болно				
	Оролцохгү й	41	3,4	3,4	100,0
	Total	1194	98,9	100,0	

Missing	System	13	1,1		
Total		1207	100,0		

2.Ерөнхийлөгч аль нам хүчний төлөөлөгч байх нь зохистой вэ?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	АН	551	45,7	48,6	48,6
	МАН	422	35,0	37,2	85,9
	МАХН	160	13,3	14,1	100,0
	Total	1133	93,9	100,0	
Missing	System	74	6,1		
Total		1207	100,0		

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн төлөө саналаа өгөхдөө чухам юуг нь чухалд үзэх вэ?

3.Аль намаас нэр дэвшсэн нь

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Чухал	572	47,4	55,0	55,0
	Чухал биш	468	38,8	45,0	100,0
	Total	1040	86,2	100,0	
Missing	System	167	13,8		
Total		1207	100,0		

4.Мөрийн хөтөлбөр нь

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Чухал	938	77,7	86,9	86,9
	Чухал биш	141	11,7	13,1	100,0
	Total	1079	89,4	100,0	
Missing	System	128	10,6		
Total		1207	100,0		

5.Хувь хүнийх нь намба төрх

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Чухал	692	57,3	66,5	66,5
	Чухал биш	348	28,8	33,5	100,0
	Total	1040	86,2	100,0	
Missing	System	167	13,8		
Total		1207	100,0		

6.Хөрөнгө чинээнийх нь байдал

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Чухал	267	22,1	26,6	26,6
	Чухал биш	735	60,9	73,4	100,0
	Total	1002	83,0	100,0	
Missing	System	205	17,0		
Total		1207	100,0		

7.Гэр бүлийн байдал

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Чухал	469	38,9	46,9	46,9
	Чухал биш	530	43,9	53,1	100,0
	Total	999	82,8	100,0	
Missing	System	208	17,2		
Total		1207	100,0		

8.Авилгалд болон бусад хууль бус зүйлд нэр холбогдсон эсэх

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Чухал	860	71,3	81,7	81,7
	Чухал биш	192	15,9	18,3	100,0
	Total	1052	87,2	100,0	
Missing	System	155	12,8		
Total		1207	100,0		

9.Удам гарал, яс үндэс

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Чухал	665	55,1	64,5	64,5
	Чухал биш	366	30,3	35,5	100,0
	Total	1031	85,4	100,0	
Missing	System	176	14,6		
Total		1207	100,0		

10. Үндсэн захиргаа, уугуул нутаг

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Чухал	480	39,8	48,0	48,0
	Чухал биш	521	43,2	52,0	100,0
	Total	1001	82,9	100,0	
Missing	System	206	17,1		
Total		1207	100,0		

11. Хариуцлага хүлээх чадвар

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Чухал	983	81,4	91,2	91,2
	Чухал биш	95	7,9	8,8	100,0
	Total	1078	89,3	100,0	
Missing	System	129	10,7		
Total		1207	100,0		

12. Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэнийг нь дэмжиж байна вэ?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Ц.Элбэгдорж АН	525	43,5	48,1	48,1
	Б.Бат-Эрдэнэ МАН	423	35,0	38,8	86,9
	Н.Удвал МАХН	143	11,8	13,1	100,0
	Total	1091	90,4	100,0	
Missing	System	116	9,6		
Total		1207	100,0		

13. Нэр дэвшигчдийг доорхи асуултаар харьцуулвал хэн нь давуу вэ?
Улс төрийн ажлын туршлагаараа

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Ц.Элбэгдорж	774	64,1	68,7	68,7
	Б.Бат-Эрдэнэ	189	15,7	16,8	85,5
	Н.Удвал	57	4,7	5,1	90,6
	Гурвуулаа адилхан	106	8,8	9,4	100,0
	Total	1126	93,3	100,0	

Missing Total	System	81 1207	6,7 100,0		
------------------	--------	------------	--------------	--	--

14.Санаачилж, хийж бүтээсэн ажлаараа

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Ц.Элбэгдор ж	580	48,1	54,3	54,3
	Б.Бат- Эрдэнэ	269	22,3	25,2	79,5
	Н.Удвал	72	6,0	6,7	86,2
	Гурвуулаа адилхан	147	12,2	13,8	100,0
	Total	1068	88,5	100,0	
Missing Total	System	139 1207	11,5 100,0		

15.Аль нэг нам хүчний сонирхлыг илүүд тавихгүй байдлаараа

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Ц.Элбэгдор ж	322	26,7	30,3	30,3
	Б.Бат- Эрдэнэ	416	34,5	39,2	69,5
	Н.Удвал	99	8,2	9,3	78,8
	Гурвуулаа адилхан	225	18,6	21,2	100,0
	Total	1062	88,0	100,0	
Missing Total	System	145 1207	12,0 100,0		

16.Хүн чанар,ноён нуруу, ёс жудгаараа

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Ц.Элбэгдор ж	272	22,5	24,7	24,7
	Б.Бат- Эрдэнэ	607	50,3	55,1	79,8
	Н.Удвал	89	7,4	8,1	87,8
	Гурвуулаа адилхан	134	11,1	12,2	100,0
	Total	1102	91,3	100,0	
Missing Total	System	105 1207	8,7 100,0		

17.Шударга, зарчимч чанараараа

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Ц.Элбэгдорж	417	34,5	38,0	38,0
	Б.Бат-Эрдэнэ	439	36,4	40,0	78,0
	Н.Удвал	118	9,8	10,7	88,7
	Гурвуулаа адилхан	124	10,3	11,3	100,0
	Total	1098	91,0	100,0	
Missing	System	109	9,0		
Total		1207	100,0		

18.Мэдлэг боловсролоороо

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Ц.Элбэгдорж	638	52,9	58,9	58,9
	Б.Бат-Эрдэнэ	192	15,9	17,7	76,6
	Н.Удвал	92	7,6	8,5	85,1
	Гурвуулаа адилхан	162	13,4	14,9	100,0
	Total	1084	89,8	100,0	
Missing	System	123	10,2		
Total		1207	100,0		

19.Санаагаа цэгцтэй илэрхийлэх чадвараараа

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Ц.Элбэгдорж	641	53,1	59,2	59,2
	Б.Бат-Эрдэнэ	227	18,8	21,0	80,2
	Н.Удвал	80	6,6	7,4	87,6
	Гурвуулаа адилхан	134	11,1	12,4	100,0
	Total	1082	89,6	100,0	
Missing	System	125	10,4		
Total		1207	100,0		

20.Амлалтаа биелүүлэх чанараараа

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
--	-----------	---------	---------------	--------------------

Valid	Ц.Элбэгдорж	395	32,7	37,4	37,4
	Б.Бат-Эрдэнэ	367	30,4	34,8	72,2
	Н.Удвал	76	6,3	7,2	79,4
	Гурвуулаа адилхан	217	18,0	20,6	100,0
	Total	1055	87,4	100,0	
Missing	System	152	12,6		
Total		1207	100,0		

21.Гадаад намба төрхөөрөө

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Ц.Элбэгдорж	264	21,9	24,5	24,5
	Б.Бат-Эрдэнэ	542	44,9	50,2	74,7
	Н.Удвал	110	9,1	10,2	84,9
	Гурвуулаа адилхан	163	13,5	15,1	100,0
	Total	1079	89,4	100,0	
Missing	System	128	10,6		
Total		1207	100,0		

22.Олон улсад танигдсан байдлаараа

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Ц.Элбэгдорж	707	58,6	64,7	64,7
	Б.Бат-Эрдэнэ	216	17,9	19,8	84,5
	Н.Удвал	59	4,9	5,4	89,9
	Гурвуулаа адилхан	110	9,1	10,1	100,0
	Total	1092	90,5	100,0	
Missing	System	115	9,5		
Total		1207	100,0		

23. Та аль улс төрийн нам хүчнийг дэмждэг вэ?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	АН	453	37,5	39,8	39,8
	МАН	319	26,4	28,1	67,9
	МАХН	150	12,4	13,2	81,1
	МУАН	3	,2	,3	81,4
	ИЗНН	7	,6	,6	82,0

	Бусад нам	6	,5	,5	82,5
	Аль ч намыг дэмждэггүй	199	16,5	17,5	100,0
	Total	1137	94,2	100,0	
Missing	System	70	5,8		
Total		1207	100,0		

27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд та хэний төлөө саналаа өгөх вэ?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Ц.Элбэгдорж АН	531	44,0	46,1	46,1
	Б.Бат-Эрдэнэ МАН	468	38,8	40,7	86,8
	Н.Удвал МАХН	152	12,6	13,2	100,0
	Total	1151	95,4	100,0	
Missing	System	56	4,6		
Total		1207	100,0		

32.Та ямар ажил эрхэлдэг вэ?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Төрийн байгууллагад	241	20,0	20,1	20,1
	Төрийн бус байгууллагад	114	9,4	9,5	29,7
	Хувиарай аж ахуй,жижиг наймаа	311	25,8	26,0	55,6
	эрхэлдэг Хувийн компани,байг ууллагад	152	12,6	12,7	68,3
	Оюутан,сурал цагч	99	8,2	8,3	76,6
	Тэтгэвэрт	86	7,1	7,2	83,8
	Ажилгүй	175	14,5	14,6	98,4
	Бусад	19	1,6	1,6	100,0
	Total	1197	99,2	100,0	
Missing	System	10	,8		
Total		1207	100,0		

33.Таны оршин суугаа газар?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Архангай	100	8,3	8,3	8,3
	Өвөрхангай	100	8,3	8,3	16,6
	Дорноговь	104	8,6	8,6	25,2
	Хэнтий	99	8,2	8,2	33,4
	Дархан	94	7,8	7,8	41,2
	Эрдэнэт	102	8,5	8,5	49,7
	Улаанбаатар	494	40,9	41,0	90,6
	Хөвсгөл	113	9,4	9,4	100,0
	Total	1206	99,9	100,0	
Missing	System	1	,1		
Total		1207	100,0		

Crosstabs

Notes

Output Created		02-JUN-2013 09:19:38
Comments		
Input	Data	C:\Users\Ts.Ganbold\Desktop\ 2013.06.01.sav
	Filter	<none>
	Weight	<none>
	Split File	<none>
	N of Rows in Working Data File	1207
Missing Value Handling	Definition of Missing Cases Used	User-defined missing values are treated as missing. Statistics for each table are based on all the cases with valid data in the specified range(s) for all variables in each table.
Syntax		CROSSTABS /TABLES=var00029 var00030 var00031 var00033 var00034 BY var00003 var00013 var00024 var00028 /FORMAT= AVALUE TABLES /CELLS= COUNT .
Resources	Elapsed Time Dimensions Requested Cells Available	0:00:00,03 2 116508

28.Таны нас * 2.Ерөнхийлөгч аль нам хүчний төлөөлөгч байх нь зохистой вэ?
Crosstabulation

Count

		2.Ерөнхийлөгч аль нам хүчний төлөөлөгч байх нь зохистой вэ?			Total
		АН	МАН	МАХН	
28.Таны нас	18-27	128	74	25	227
	28-35	152	81	31	264
	36-45	119	113	55	287
	46-55	104	104	33	241
	56-аас дээш	39	45	14	98
Total		542	417	158	1117

28.Таны нас * 12.Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэнийг нь дэмжиж байна вэ? Crosstabulation

Count

		12.Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэнийг нь дэмжиж байна вэ?			Total
		Ц.Элбэгдорж АН	Б.Бат-Эрдэнэ МАН	Н.Удвал МАХН	
28.Таны нас	18-27	126	86	20	232
	28-35	154	73	23	250
	36-45	103	120	53	276
	46-55	95	95	35	225
	56-аас дээш	40	42	10	92
Total		518	416	141	1075

28.Таны нас * 27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ? Crosstabulation

Count

		27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ?			Total
		Ц.Элбэгдорж АН	Б.Бат-Эрдэнэ МАН	Н.Удвал МАХН	
28.Таны нас	18-27	128	87	22	237
	28-35	145	93	29	267
	36-45	113	127	51	291
	46-55	98	107	35	240
	56-аас дээш	39	48	14	101
Total		523	462	151	1136

29.Таны хүйс * 2.Ерөнхийлөгч аль нам хүчний төлөөлөгч байх нь зохистой вэ?
Crosstabulation

Count

	2.Ерөнхийлөгч аль нам хүчний төлөөлөгч байх нь зохистой вэ?			Total
	АН	МАН	МАХН	
29.Тан эр	276	207	68	551
ы хүйс эм	275	215	92	582
Total	551	422	160	1133

29.Таны хүйс * 12.Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэнийг нь дэмжиж байна вэ? Crosstabulation

Count

	12.Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэнийг нь дэмжиж байна вэ?			Total
	Ц.Элбэгдор ж АН	Б.Бат- Эрдэнэ МАН	Н.Удвал МАХН	
29.Тан эр	260	209	60	529
ы хүйс эм	265	214	83	562
Total	525	423	143	1091

29.Таны хүйс * 27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ? Crosstabulation

Count

	27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ?			Total
	Ц.Элбэгдор ж АН	Б.Бат- Эрдэнэ МАН	Н.Удвал МАХН	
29.Тан эр	261	239	66	566
ы хүйс эм	270	229	86	585
Total	531	468	152	1151

30.Боловсрол * 2.Ерөнхийлөгч аль нам хүчний төлөөлөгч байх нь зохистой вэ?
Crosstabulation

Count

	2.Ерөнхийлөгч аль нам хүчний төлөөлөгч байх нь	Total
--	---	-------

		зохистой вэ?			
		АН	МАН	МАХН	
30.Боловсрол	Дээд	282	184	46	512
	Тусгай дунд	74	54	25	153
	Бүрэн дунд	161	150	79	390
	Бага	20	21	8	49
	Боловсролгүй	4	6	0	10
Total		541	415	158	1114

30.Боловсрол * 12.Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэнийг нь дэмжиж байна вэ? Crosstabulation

Count

		12.Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэнийг нь дэмжиж байна вэ?			
		Ц.Элбэгдорж АН	Б.Бат-Эрдэнэ МАН	Н.Удвал МАХН	Total
30.Боловсрол	Дээд	258	184	41	483
	Тусгай дунд	77	56	20	153
	Бүрэн дунд	153	161	71	385
	Бага	24	13	7	44
	Боловсролгүй	4	3	1	8
Total		516	417	140	1073

30.Боловсрол * 27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ? Crosstabulation

Count

		27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ?			
		Ц.Элбэгдорж АН	Б.Бат-Эрдэнэ МАН	Н.Удвал МАХН	Total
30.Боловсрол	Дээд	267	208	42	517
	Тусгай дунд	73	61	23	157
	Бүрэн дунд	151	168	77	396
	Бага	24	20	7	51
	Боловсролгүй	4	4	2	10
Total		519	461	151	1131

31.Амьдралын түвшин * 2.Ерөнхийлөгч аль нам хүчний төлөөлөгч байх нь зохистой вэ?
Crosstabulation

Count

		2.Ерөнхийлөгч аль нам хүчний төлөөлөгч байх нь зохистой вэ?			Total
		АН	МАН	МАХН	
31.Амьдралын түвшин	Бүрэн хангалуун	44	30	6	80
	Чинээлэгдүү	34	30	11	75
	Дунд зэрэг	340	264	110	714
	Ядуувтар	57	30	4	91
	Нэн ядуу	14	10	9	33
Total		489	364	140	993

31.Амьдралын түвшин * 12.Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэнийг нь дэмжиж байна вэ? Crosstabulation

Count

		12.Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэнийг нь дэмжиж байна вэ?			Total
		Ц.Элбэгдорж АН	Б.Бат-Эрдэнэ МАН	Н.Удвал МАХН	
31.Амьдралын түвшин	Бүрэн хангалуун	42	28	6	76
	Чинээлэгдүү	28	39	8	75
	Дунд зэрэг	332	263	97	692
	Ядуувтар	53	28	9	90
	Нэн ядуу	13	14	7	34
Total		468	372	127	967

31.Амьдралын түвшин * 27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ? Crosstabulation

Count

		27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ?			Total
		Ц.Элбэгдорж АН	Б.Бат-Эрдэнэ МАН	Н.Удвал МАХН	
31.Амьдралын түвшин	Бүрэн хангалуун	41	34	6	81
	Чинээлэгдүү	24	37	11	72
	Дунд зэрэг	337	289	103	729
	Ядуувтар	55	29	7	91
	Нэн ядуу	13	15	8	36

31.Амьдралын түвшин * 27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ? Crosstabulation\

Count

		27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ?			Total
		Ц.Элбэгдорж АН	Б.Бат-Эрдэнэ МАН	Н.Удвал МАХН	
31.Амьдралын түвшин	Бүрэн хангалуун	41	34	6	81
	Чинээлэгдүү	24	37	11	72
	Дунд зэрэг	337	289	103	729
	Ядуувтар	55	29	7	91
	Нэн ядуу	13	15	8	36
Total		470	404	135	1009

32.Та ямар ажил эрхэлдэг вэ? * 2.Ерөнхийлөгч аль нам хүчний төлөөлөгч байх нь зохистой вэ? Crosstabulation

Count

		2.Ерөнхийлөгч аль нам хүчний төлөөлөгч байх нь зохистой вэ?			Total
		АН	МАН	МАХН	
32.Та ямар ажил эрхэлдэг вэ?	Төрийн байгууллагад	116	86	30	232
	Төрийн бус байгууллагад	59	32	14	105
	Хувиарай аж ахуй, жижиг наймаа эрхэлдэг	120	130	47	297
	Хувийн компани,байгууллагад	81	45	11	137
	Оюутан,суралцагч	58	22	13	93
	Тэтгэвэрт	27	40	17	84
	Ажилгүй	79	59	23	161
	Бусад	9	6	2	17
Total		549	420	157	1126

32.Та ямар ажил эрхэлдэг вэ? * 12.Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэнийг нь дэмжиж байна вэ? Crosstabulation

Count

		12.Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэнийг нь дэмжиж байна вэ?			Total
		Ц.Элбэгдорж АН	Б.Бат-Эрдэнэ МАН	Н.Удвал МАХН	
32.Та ямар ажил эрхэлдэг вэ?	Төрийн байгууллагад	106	86	20	212
	Төрийн бус байгууллагад	55	37	11	103
	Хувиарай аж ахуй,жигжиг наймаа	127	113	47	287
	эрхэлдэг Хувийн компани,байгууллагад	78	50	10	138
	Оюутан,суралцагч	52	29	9	90
	Тэтгэвэрт Ажилгүй	22	38	16	76
	Бусад	75	58	26	159
		8	9	2	19
Total		523	420	141	1084

32.Та ямар ажил эрхэлдэг вэ? * 27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ? Crosstabulation

Count

		27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ?			Total
		Ц.Элбэгдорж АН	Б.Бат-Эрдэнэ МАН	Н.Удвал МАХН	
32.Та ямар ажил эрхэлдэг вэ?	Төрийн байгууллагад	108	98	23	229
	Төрийн бус байгууллагад	61	38	12	111
	Хувиарай аж ахуй,жигжиг наймаа	117	130	49	296
	эрхэлдэг Хувийн компани,байгууллагад	78	53	11	142
	Оюутан,суралцагч	58	31	9	98
	Тэтгэвэрт Ажилгүй	21	43	20	84
	Бусад	78	63	25	166
		8	9	2	19

Total	529	465	151	1145
-------	-----	-----	-----	------

33.Таны оршин суугаа газар? * 2.Ерөнхийлөгч аль нам хүчний төлөөлөгч байх нь зохистой вэ? Crosstabulation

Count

		2.Ерөнхийлөгч аль нам хүчний төлөөлөгч байх нь зохистой вэ?			Total
		АН	МАН	МАХН	
33.Таны оршин суугаа газар?	Архангай	53	23	20	96
	Өвөрхангай	50	31	16	97
	Дорноговь	56	25	17	98
	Хэнтий	26	54	15	95
	Дархан	45	32	9	86
	Эрдэнэт	38	41	15	94
	Улаанбаатар	252	161	62	475
	Хөвсгөл	31	55	5	91
Total		551	422	159	1132

33.Таны оршин суугаа газар? * 12.Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэнийг нь дэмжиж байна вэ? Crosstabulation

Count

		12.Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэнийг нь дэмжиж байна вэ?			Total
		Ц.Элбэгдорж АН	Б.Бат-Эрдэнэ МАН	Н.Удвал МАХН	
33.Таны оршин суугаа газар?	Архангай	52	19	27	98
	Өвөрхангай	53	20	16	89
	Дорноговь	60	28	13	101
	Хэнтий	18	77	2	97
	Дархан	44	28	5	77
	Эрдэнэт	30	37	16	83
	Улаанбаатар	241	160	54	455
	Хөвсгөл	27	54	9	90
Total		525	423	142	1090

33.Таны оршин суугаа газар? * 27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн

сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ? Crosstabulation

Count

		27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ?			Total
		Ц.Элбэгдор ж АН	Б.Бат- Эрдэнэ МАН	Н.Удвал МАХН	
33.Таны оршин суугаа газар?	Архангай	52	22	25	99
	Өвөрханг ай	56	23	19	98
	Дорногов ь	56	29	13	98
	Хэнтий	19	75	3	97
	Дархан	48	38	7	93
	Эрдэнэт	34	44	14	92
	Улаанбаа тар	236	171	60	467
	Хөвсгөл	30	66	11	107
Total		531	468	152	1151

2.Ерөнхийлөгч аль нам хүчний төлөөлөгч байх нь зохистой вэ?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	АН	551	45,7	48,6	48,6
	МАН	422	35,0	37,2	85,9
	МАХН	160	13,3	14,1	100,0
	Total	1133	93,9	100,0	
Missin g	System	74	6,1		
Total		1207	100,0		

12.Та Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэнийг нь дэмжиж байна вэ?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Ц.Элбэгдор ж АН	525	43,5	48,1	48,1
	Б.Бат- Эрдэнэ МАН	423	35,0	38,8	86,9
	Н.Удвал МАХН	143	11,8	13,1	100,0
	Total	1091	90,4	100,0	
Missing	System	116	9,6		
Total		1207	100,0		


23. Та аль улс төрийн нам хүчнийг дэмждэг вэ?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	АН	453	37,5	39,8	39,8
	МАН	319	26,4	28,1	67,9
	МАХН	150	12,4	13,2	81,1
	МУАН	3	,2	,3	81,4
	ИЗНН	7	,6	,6	82,0
	Бусад нам	6	,5	,5	82,5
	Аль ч намыг дэмждэггүй	199	16,5	17,5	100,0
	Total	1137	94,2	100,0	
Missing	System	70	5,8		
Total		1207	100,0		


27.2013 оны 06-р сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд Та хэний төлөө саналаа өгөх вэ?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Ц.Элбэгдорж АН	531	44,0	46,1	46,1
	Б.Бат-Эрдэнэ МАН	468	38,8	40,7	86,8
	Н.Удвал МАХН	152	12,6	13,2	100,0
	Total	1151	95,4	100,0	
Missing	System	56	4,6		
Total		1207	100,0		


Анхны сонголт: 45,70%
МАН: 35,00%
МАХН: 13,30%
хариулаагүй: 6,10%




Та аль улс төрийн нам хүчнийг дэмждэг вэ?




2013 í í û 06-ð ñàðû í 26-í ä áí êí ò Å° í öèéè° ã-èéí ñí í ãóëüà Òà
öýí èé ò° è°° ñàì àèàà° ã° ö äý?




Òà Àǎ° í òèèè° ã-èéí ñí í ãóóèüà í ýð áýâð èã-àèéí òýí èèáí ü äýì ææ
ááéí à âý?




Òàì Ù í àñ * 27.2013 î í Ù 06-ð ñàð Ù í 26-í ä áí êî ð
 Åº° í òèèèº ã:èéí ñí í ãóóèüä Òà öýí èè òº èºº
 ñàì àèààº ãº ò äý?




30.Áí êî âñďî ě * 27.2013 î í û 06-ď ñàďû í 26-í ä áí êî ǒ
 Åđ° í ǒëëë° äüëéí ñí í äóóëüä Õà öýí ëë ǒ° ě° ñáí àëàà° ä° ǒ äý?




31.Àì uàðàèù í òóáø èí * 27.2013 í í ù 06-ð ñàðù í 26-í à áí èí ò Áð° í ðèèè° àhèéí ñí í áòóèuà Cà òyí èé ð° è° ñàí àèàà° æ ò áy?



32.Òà yì àǎ àǎǎ yǒyǒyǎyǎáy? * 27.2013 í í ù 06-ǒ ñàǒù í 26-
í á áí ēí ō Áǒ° í òēēē° ā-ēéí ñí í ǎǒǒēùǎ Òà ǒyí ēē ǒ° ē°
ñǎí àēàà° ā ō áy



33. Ɔàì ú í ðø èl nŋóààà ààçàð? * 27.2013 í í ú 06-ð nàðù í 26-
í á áí èí ò Ǻð í ðèèè° Ǻ-èéí nŋ í ǺóòèüǺ Ɔà öýí èè ò è°
nàì àèàà° Ǻ ò áý?



ГЕОПОЛИТИКИЙН ОНОЛ БА МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫГ ЗАДЛАН ШИНЖЛЭХ НЬ

Н.ГАЛИЙМАА

ШУТИС, НТС

Түлхүүр үг: Төв газар, геополитикийн бүтэц, геополитикийн код

ABSTRACT: The collapse of socialist system had opened new era of Mongolian democratic foreign policy, because of beginning of liberal multipolar policy in the world.

Thankful to the “open door” foreign policy Mongolia has receiving economic aid and political support from donor countries, which is giving little chance to play own game in the international arena. One of biggest achievement of Mongolian government during last 23 years, is Mongolia has been becoming from undeveloping country to developing country, because the country is rich in terms of mineral resources, with major coal reserves and significant deposits of copper, gold, fluorspar and tungsten. Development of the raw materials sector can lead to substantial growth and widespread prosperity for the population as a whole.

But, geopolitical interest of developed countries such as USA is focusing on neighboring countries of Mongolia; China and Russia, which have huge territory and population. There are two reasons, which are making Mongolian game in international arena vulnerable to others.

- *Mongolia is landlocked country, strategically located between China and Russia (both have regional geopolitical code and both have ambiguous goal to become super power within global code),*
- *Mongolia has no sea-outlet, therefore possibility to penetrate regional and global transportation networks is very limited.*

Therefore, Mongolia should have liberal policy for continuing economic aid and political support of developed countries, except of dominance realpolitik in international arena last decade of XXI century.

Author had attempt in her article to make analysis on geopolitical volatility of Mongolia, within few contemporary theories of geopolitics.

Оршил

ЗХУ, бусад социалист орнуудтай ах дүүгийн найрамдалт харилцаатай байх гэдгээр социалист Монголын гадаад бодлого тодорхойлогдож байлаа. Гадаад бодлогодоо баримтлах чиг шугамыг Москвагаар зааварчлуулж, МАХН-ын програмуудаараа баталдаг байв. 1960-аад оноос ЗХУ, БНХАУ-ын найрамдалт харилцаанд “цав” суун хоорондоо дайсагнах болсноор хүн ам, газар нутгаар супер том энэ хоёр гүрний дунд орших Монголын бамбай улсын үүрэг эрс нэмэгдлээ. ЗХУ-ын гадаад бодлогын чиг шугамыг хатуу баримталж, БНХАУ-тай сайн хөршийн харилцаагаа тасалсан БНМАУ-д санаачлага гарган эдийн засаг, нийгэм-соёлын хувьд илүү өндөр хөгжсөн гуравдагч орнуудтай гадаад харилцаа тогтоох боломж байгаагүй билээ. Өөрөөр хэлбэл Р. Вукадиновичийн гаргасан аюулгүй байдлаа хангах таван үндсэн үйл ажиллагаанаас “... бусад улс орныг давамгайлах хүчин чадал бүхий дэлхийн хэмжээний том улсыг дагалдан аюулгүй байдлаа хамгаалах арга зам”-ыг өөрийн хүсэл зоригоос үл хамааран БНМАУ сонгосон байлаа. Социализмийн жилүүдэд (1921-1990)

сувернитетийн шинжийг дотооддоо хадгалж чадсан нь Монголын төрийн амжилт байсан ч олон улсын тавцан дээр сувернитет болж чадаагүйгээс БНМАУ-ыг “nation state” хэмээн тодорхойлох боломжгүй байсан юм.

Төв газрын онол ба өнөөгийн Евразийн геополитикийн бүтэц

Социалист системийн уналтаар “төмөр хөшиг” нээгдэж, олон улсын тавцан дээр бүс нутаг, орон нутгийн кодтой улс дуу хоолойгоо сонсгох боломж харьцангуй нэмэгдсэн нь бүс нутгийн бүтцийн зарчмаар Еврази тивийн геополитик, гео-орон зайг харах боломжийг олгосон хэрэг юм. Геополитикч Халфорд Маккиндер, түүний өрсөлдөгч Николас Спайкман нар геополитикийн орон зайн томъёоллыг гаргахдаа Евразийн өргөн сегментийн функционал үүргийг бүс нутгийн бүтцийн хандлагаар тайлбарласан билээ.

Их Британий геополитикч Халфорд Маккиндер(1869-1947) Англо-саксон геополитикийн бодлогыг үндэслэсэн нь хагас зуун жилийн дараа АНУ, Хойд Атлантын холбоо (НАТО)-ийн баримтлах үндсэн бодлого болсон. “Өөр өөрийн бие даасан үүрэг бүхий тусгаарлагдмал газруудад дэлхий хуваагддаг. Эдгээр газрыг гүйцэтгэх үүргээр нь Төв газар, Дэлхийн арал хэмээн хоёр хуваадаг” гэсэн үзэл санаа Х.Маккиндерийн онолын тулгын чулуу болж байлаа. Азийн Төв хэсгээс ирэх шахалтыг эсэргүүцэн тэмцсэний хүчинд Европ тив техник, технологийн хувьд үсрэнгүй хөгжиснөөр дэлхийн тавцанд манлайлах үүрэгтэй болсон хэмээн Х.Маккиндер үзсэн. Евразийн төвд оршдог, хүндийн жин (татах хүч) болох Төв газар нь Европ тив юм. Төв газар хамгийн ашигтай газарзүйн байршилтай. Дэлхийн арлыг хянахын тулд геополитик, эдийн засгийн шаардлагатай чадавхийг Төв газар хуримтлуулдаг. Төв газрын цэрэг арми, улс төр, нийгэм-эдийн засгийн үйл явц Маккиндерийн буцах хуулиар геополитик, гео-эдийн засгийн бодит нэгдлийг бий болгоно. Аж үйлдвэрийг хөгжүүлэх, хүчирхэг армитай болох тогтвортой нөхцөлөөр Еврази хангагдсан. Далайд гарцгүйгээс далайн хүчирхэг флотын эсрэг зогсох хүчин мөхөс ч Волга, Енисей, Аму Дарья, Сыр Дарья голын сав, Каспи, Аралын тэнгис бүхий Төв газар морь, тэмээ хөлөглөсөн, хөдөлгөөнт чанар өндөртэй хуурай газрын их хүчийг хуримтлуулснаараа цэрэг, стратегийн хувьд хүчирхэг байлаа. Дээр дурдсан түүх, геополитикийн шалтгаанаар нөхцөлдөн Төв газар хүчний төв болсон [1,х.45].

Соёл иргэншил эрчимтэй хөгжсөн Өмнөд, Зүүн Өмнөд, Зүүн Ази буюу Евроазийн эргийн нутгийг “дотоод хүрээ”(inner crescent-дотоод хагас тойрог гэж орчуулмаар байсан ч манайд орчуулж хэвшсэнээр хүрээ гэлээ) хэмээн Х.Маккиндер нэрлэсэн. Их Британи, Өмнөд, Хойд Америк, Өмнөд Африк, Австрали, Японыг дотоод Евразийн газарзүй, соёлын холбоотны бүс нутаг буюу “гадаад хүрээ”-нд (outer crescent) хамруулсан. Төв газрыг хяналтдаа байлгах, хяналтад авахын тулд “дотоод хүрээ”-г хянах ёстой аж. Төв газрыг захирах түлхүүр зүүн Европ бөгөөд “Зүүн Европыг удирдсан нь Төв газрыг захирна. Төв газрыг удирдсан нь Дэлхийн арлыг жанжилна. Дэлхийн арлыг удирдсан нь Дэлхийг захирна” хэмээн Маккиндер номлосон юм. Төв газар, түүний орон зай-функцийн үүрэг тогтмол өөрчлөгдөх бөгөөд тухайлбал, Зүүн Европ Төв газартай функцийн нэгдэлтэй. Төв газар хяналт тогтоох нь Зүүн Европын захирангуй шинжээс бус түүний бүтцийн нэгдлээс гарч байна. Х. Маккиндер өөрчлөгдөн буй геополитикийн бодит байдлын өөрчлөлтөд зохицуулан онолоо богино хугацаанд хоёр удаа шинэчилсэн. Тухайлбал, Төв Газарт Хар тэнгис, Балтын тэнгисийн (Зүүн Европ) сав газрыг нэмж оруулжээ [1,х.54].

Дэлхийн II дайны дараа ЗХУ зүүн Европын бүсэд хяналтаа тогтоосон нь Төв газрыг захирсан хэрэг байлаа. 1990-ээд оны эхээр социалист систем задарснаар Дэлхийн аралд геополитик, гео-эдийн засгийн шинэ нөхцөл бүрэлдсэн ч зүүн Европ Төв газраас салаагүй үлджээ. Евразийн Зүүн хойд хэсэгт ОХУ геополитикийн субъект болон

тусгаарлагдсанаар Төв газар нарийсч тус тивийн төв хэсэгт Төв Европ, Төв Кавказ, Төв Ази хэмээх харьцангуй бие даасан бүс нутгийн том сегментүүд бий болсон. Тодруулан хэлбэл, шинээр тусгаар тогтносон улсуудын орон зай, түүний бүрэлдэн буй сегментэд төвлөрсөн Төв газрын функцүүдийг засах нь чухал болоод байна. Бүхэллэг организм бүрдүүлэхийн тулд шинэ төвүүдийн интеграцичлалыг бий болгох шаардлагатай. ЗХУ-ын задралаар бий болсон Варшавын гэрээний болон шинэ тусгаар тогтносон улсууд геополитикийн дарааллаар интеграцичлалд орох нь зүй тогтол юм.

Европ тивийн Зүүн хойд хэсэгт ноёлж байсан Евразийн геополитикийн сүүлчийн субъект (ЗХУ) тусгаарлагдсанаар Төв газар тивийн хойд хэсгээс төв рүү шилжсэн нь геополитикийн онолд гарсан концепцийн өөрчлөлт аж. ЗХУ-ын мэдэлд байсан орчин үеийн Төв газрыг(Төв Еврази) Төв Европын, Зүүн Европ, Хойд Азид Дэлхийн арал нөлөөгөө тогтоосныг Хойд Евразийн хүч хэмээн нэрлэдэг. Баруун Ази, Зүүн Европын өмнөд хэсэгт орших Турк Өмнөд Евроазийн хүч болно.

Евразийн Төв газрын үүрэг маш чухал гэдэгт Америкийн геополитикч Н.Спайкмэн (1843-1914) итгэж, үүнд анхаарал хандуулахыг бүтээлдээ сануулж байсан. Х.Маккиндерийн онолыг хөгжүүлэхдээ Н.Спайкмэн Төв газар хүрээ газрын энергийг өөртөө шингээдэг ч бие даасан геополитикийн үүрэггүй. Эх газрын нүүдэлчид буюу гадны шахалт бус дотоодын (өөрийн) хүчээр дотоод Хүрээ хөгжсөн нь геополитикийн түүхийн динамик юм. Тиймээс Хүрээ газар буюу Евразийн эргийн нутаг, Европ, Арабын орнууд, Энэтхэг, Хятадад хяналтаа тогтоосноор далайн орнууд болон хуурай газарт хяналтаа тогтоох ёстой байлаа. Дээрх хоёр онолоор дэлхий гурван түвшинд хуваагдах бөгөөд Х.Маккиндер Төв газар-Еврази-Дэлхий, Н.Спайкмэн Хүрээ газар-Еврази-Дэлхий хэмээн өөр өөрөөр ангилсан байна [2, х.22].

Түүхэн цаг хугацааны туршид Төв газар, Хүрээ газрын аль аль нь Евразийн геополитикийн харилцааны объект, субъект болсоор ирсэн бөгөөд даяаршлын геополитикийн үйл явцад функционал үнэт зүйл нь эрс өөрчлөгдсөн юм. Төв газар, Хүрээ газрын аль нь чухал, анхдагч болохыг өнөөдөр хэлэхэд хэцүү бөгөөд эдгээр онолоор даяаршлын геополитикийн үйл явцыг тайлбарлаж болохгүй нь харагдаж байна. Учир нь дээрх онолуудыг АНУ, Их Британи гэсэн барууны хүчний тусын тулд зохиосон аж. Гэвч “илүү дээр” зүйлийг судлаачид бодож олоогүйгээс уг онолыг өнөөдрийг хүртэл хэрэглээд зогсохгүй сайжруулан өөрчилсөөр ирсэн.

Н.Спайкмэний шавь Д.Мейнингийнхээр геополитикийн үндсэн шалгуур нь Эх газар, Далайгаар биш харин хүн ам, төрийн бодлогын үндсэн хандлагаар тодорхойлогдох аж. Евразийг Д.Мэйнинг функц-соёлын шинжээр нь Хятад, Монгол, Хойд Вьетнам, Бангладеш, Афганистан, Зүүн Европ, Балтийн орнууд, Карелийг Төв газар луу татагдагч орон зай гэсэн анхдагч, Өмнөд Солонгос, Бирм, Энэтхэг, Ирак, Сири, Югославийг геополитикийн нейтрал гэсэн хоёрдогч, Баруун Европ, Грек, Турк, Иран, Пакистан, Тайландыг талассократ (Хүрээ газар) гэсэн гуравдагч хэв маягт хуваасан. Д. Мейнингийн дээрх гурван хэв маяг олонтоо өөрчлөгдсөн бөгөөд Зүүн Европ, Балтын орнууд, Иран, Югослав, Пакистан хүрээ газраа олонтоо сольсноор геополитикийн тогтворгүй бүсэд багтаж байна. Гэвч Д.Мэйнингийн үндэслэсэн хүн ам, төрийн бодлогын үндсэн хандлага орчин үеийн геополитикийн шалгууруудын нэг байсаар. Өнөөдөр Үндэстний хүч чадлыг харуулсан доорх зургаан үзүүлэлтийг геополитикийн шалгуурт түгээмэл хэрэглэдэг [2, х.45].

1. Төрийн эзэмшлийн талбай
2. Байгалийн баялаг
3. Аж үйлдвэр, эдийн засгийн хөгжил
4. Батлан хамгаалах чадавхи
5. Нийгэм-улс төрийн бүтцийн загвар
6. Хүн ам

Монгол улсын геополитикийн кодыг тодорхойлох нь

Дээрх зургаан үзүүлэлтээр Монгол улсын геополитикийн кодыг тодорхойлохыг зохиогч хичээлээ. 1.564 мянган кв.км нутаг дээр 2.899 мянган хүн амьдарч, нутаг дэвсгэрийн талбайн хэмжээгээр Монгол улс дэлхийд 18-т бичигддэгээс үзэхэд үндэстний хүч чадлын үзүүлэлтийн 1-р хэмжүүр өндөр юм. Менделеевийн 111 элементийн 62 нь Монгол улсаас олдсон бөгөөд нөөц нь тогтоогдсон стратегийн шинж чанартай 18 орд байна. Эдгээр 18-аас эхний 10-т орох ордуудын нөөцийн үнэлгээ 1.484 \$ наяд болжээ[3]. Эндээс харахад байгалийн баялаг гэсэн үзүүлэлтээр Монгол улс дэлхийд дээгүүр байр эзлэх нь тодорхой.

2011 онд 17.5 хувьтай байсан эдийн засгийн өсөлт 2012 онд саарч, 12.3 хувь болж буурсан ч шинжээчдийн дүгнэлтээр хурдацтай өсөлтөө хадгалан үлдсэн аж. Монгол улсын эдийн засгийг 2013 онд 13 хувиар өсөхөөр Дэлхийн Банк тооцсон нь дэлхийн хэмжээнд хамгийн өндөр өсөлт хэвээр байна. Гэвч өсөлтийн гол хүчин зүйлүүдэд тодорхойгүй байдал давамгайлж байгаагаас эдийн засгийн төлөв байдал нэлээд тогтворгүй байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарснаас шалтгаалан Монгол улсын нүүрсний экспорт ихээр унаж, эдийн засгийн өсөлт тооцоолж байснаас буурсан байна[4].

2012 оны байдлаар уул уурхайн салбар Монгол улсын экспортын 91.3%, АҮНБ-ний 67.1%, ДНБ-ий 18.6%-ийг эзэлсэн нь нөөцөө түргэн дуусдаг олборлох үйлдвэрлэл зонхилсон эдийн засгийн эмзэг бүтэцтэйг харуулж байна [5]. Швейцарь дахь Олон улсын удирдлагын хөгжлийн хүрээлэнгийн дэргэдэх Дэлхийн өрсөлдөх чадварын төвийн хийсэн “Монгол улсын өрсөлдөх чадвар”-ын 2010 оны тайлангаар манай улсын өрсөлдөх чадвар сул гарсан нь гуравдугаар үзүүлэлт доогуур байгааг илэрхийлнэ. Супер том, батлан хамгаалах чадавхиараа дэлхийд 2-р, 4-р байранд явж буй хоёр гүрний дунд хавчуулагдан оршдог Монгол улсын батлан хамгаалах чадавхийн тухай дүгнэлт хийх нь илүүц гэж үзлээ.

1990 онд Монгол улсад ардчилсан хувьсгал тайван замаар ялж, парламентийн тогтолцоотой улс байгуулснаар Ази, Африкийн олон оронд үлгэр болж байсан. Гэвч “Монгол улсын өрсөлдөх чадвар”-ын 2010 оны тайлангаар тавдугаар үзүүлэлтэд шууд хамаарах эрх зүй, зохицуулалтын орчин 11, төрийн бодлогын зохицох чадвар 11, төрийн ил тод байдал 13, хүнд суртал 13, авилга хээл хахуулиар 13 (харьцуулж буй 15 улсаас)-р байр эзэлсэн нь сул үзүүлэлт билээ[6, х.23-25]. Эдгээр үзүүлэлт Монгол улсын нийгэм-улс төрийн бүтцийн мөн чанарыг харуулахад чухал байр суурь эзэлнэ.

Монгол улс эдийн засгийн өндөр өсөлтөөр сүүлийн гурван жилд дэлхийн хэмжээнд эхний 10-т тогтмол жагсаж, нэг хүнд ногдох ДНБ өсөж байгаа ч ядуурлын түвшин 2011 оны байдлаар 29,8 хувьтай байна. 837,6 мянга орчим хүн ядууралд өртсөнийг үзэхэд зуун хүн тутмын гуч нь ядуу байгаа хэрэг. Манай улсын 837,6 мянган хүн наад захын хүнсний болоод хүнсний бус хэрэглээгээ худалдан авах чадваргүй гэсэн үг. Монгол Улсын нэг хүнд ногдох сарын хэрэглээ 2011 оны байдлаар 160365 төгрөг байна. Ядуу бус хүн амын нэг хүнд ноогдох сарын хэрэглээ 197509, ядуу хүнийх 72821 төгрөг аж. Өөрөөр хэлбэл ядуу хийгээд дундаж иргэдийн хэрэглээ гурав дахин зөрүүтэй байна. Энэхүү тэгш бус байдал 2010 оноос өссөн үзүүлэлттэй байгаа юм [7]. Монголын нэг хүнд оногдох ДНБ өнөөдөр 4700 ам.доллар байгаа нь Украйныхаас даруй 1,5 дахин бага байгаа юм гэж <http://world.eizvestia.com> сайтад бичжээ.

Дээрх үзүүлэлтүүд сул учраас үндэстний хүч чадал ямар байгаа нь уншигч Танд ойлгомжтой болох биз ээ. Эдгээр зургаан үзүүлэлтээс гадна ХХI зуунд үндэстний хүч чадлыг тодорхойлоход үндэстний мэдлэг, мэдээлэл чухал баялаг, хүч болон хувирч байна. Иймээс улс орны хөгжлийг юу экспортолж байгаагаар нь ангилдаг. Хамгийн буурай орон түүхий эд, дараагийн түвшнийх бараа бүтээгдэхүүн, гуравдугаар түвшнийх техник технологи, дөрөв дэх буюу дээд түвшнийх мэдлэг экспортолдог байна.

Эндээс харахад үндэстний хүч чадал султай Монгол улс геополитикийн орон нутгийн кодтой хэрэг. 1982 онд Английн судлаач Жон Гаддис анх удаа геополитикийн код гэсэн нэр томъёог хэрэглэжээ. Энэ нь дэлхийн улсууд гадаад бодлогод хэрэглэдэг болон хэрэглэхийг хичээдэг практик геополитикийн шалтгааныг тайлбарласан ойлголт. Дэлхийн улсуудтай тухайн төрийн харилцах харилцааг тодорхойлсон газарзүйн үндсэн ойлголт бол код юм. Тухайлан авсан төрийн үндэсний ашиг сонирхлыг бусад улс дэмжин туслах, эсэргүүцэхийн аль нь болохыг тодорхойлно гэсэн үг. Дэлхийн улсуудыг геополитикийн кодоор нь:

1. Энгийн жижиг улсын орон нутгийн код
2. Дунд зэргийн хүчин чадалтай орнуудын бүс нутгийн код
3. Дэлхий дээр ноёрхох эрх бүхий глобал кодтой хэмээн ангилдаг.

Ямар ч том гүрний гадаад бодлогын суурь параметр нь тухайн цаг үеийн геополитикийн шаардлагаар тодорхойлогддог бөгөөд энэхүү шаардлага цаг үеэсээ хамаараад өөрчлөгдөж байдаг [2, х.45]. Манай хойд хөрш ЗХУ социалист системийн үед дэлхий кодтой, өмнөд хөрш БНХАУ бүс нутгийн кодтой байсан нь манай улсын олон улсын тавцан дээр тоглолт хийх боломжийг хааж байсан хэрэг. Өнөөдөр ОХУ, БНХАУ-ын аль аль нь бүс нутгийн кодтой байгаа бөгөөд эдийн засгийн өсөлт өндөртэй өмнөд хөрш бараа бүтээгдхүүн экспортлодог орноос техник, технологи үйлдвэрлэдэг түвшинд шилжихийн зэрэгцээ, техник, технологийн тэргүүн дэвшлийг батлан хамгаалах хүчээ зузаатгахад ашиглаж байна. Тухайлбал, Хятадын арми 2.28 сая байнгын, 800.000 бэлтгэл цэрэг, офицертойгоор дэлхийд 1-т, 2011 онд цэргийн зардал 2010 онтой харьцуулахад 7.5%-иар өсч, 91.5\$ их наядад хүрснээр дэлхийд 2-рт бичигдэх боллоо [8].

Хойд хөрш ОХУ цэрэг, зэвсгийн өрсөлдөөнд найр тавихыг бодохгүй байгаа бөгөөд бүс нутгийн аюулгүй байдал гэдэг нэрийн доор батлан хамгаалахад зарцуулах зардлыг эрс өсгөж байна. 2011 оны байдлаар Оросын арми 1.2 сая хүний бүрэлдхүүнтэй, батлан хамгаалахад зардалд 41.4\$ их наядыг зарцуулсан нь зардлын хэмжээгээр АНУ, Хятад, Их Британий дараа 4-т жагсжээ[9]. Түүнчлэн Ази, Номхон далайн бүс нутагт энх тайвныг тогтоох, олон улсад олон туйлт гадаад бодлогыг бий болгох “зорилгоор” хамтран ажиллахыг чармайж буй нь геополитикийн бүс нутгийн кодыг глобал код болгоход чиглэсэн алхам хэмээн тайлбарлахад болно. Ийнхүү эх газрын буюу Төв газрын хоёр том хүч эргийн бүсүүдэд өөрсдийн нөлөөгөө тэлэх бодлогыг баримталж буй бөгөөд Воллерстейны “манлайлах цикл”-ийн хуулиар олон улсын харилцаанд шийдвэрлэх үүрэгтэй болохыг хичээж байна. Тухайн улс олон улсын тавцан дээр тодорхой цаг хугацаанд нийгэм, улс төр, соёлын хувьд хүчирхэгжин гарч ирэхийг манлайлах цикл гэнэ. Энэ циклд тухайн улсын манлайлалт, бууралтын үе хоёулаа багтдаг. Аливаа улсын сэргэн мандалт аж үйлдвэрийн салбараар гараагаа эхлээд санхүү, бизнесийн салбарт нэвтэрснээр улс төр рүү аажмаар шилждэг[2, х.17].

Ийнхүү Төв газар, Хүрээ газар, үндэсний хүч чадлын үзүүлэлт, Гаддисын код, Воллерстейны манлайллын онолын алианаар нь ч дүгнэсэн геополитикийн онолд гарсан концепцийн өөрчлөлт дэлхийн улсуудын геополитикийн шаардлага өөрчлөгдөж байгаагаар харагдаж байна. Өнөөдөр Монгол улс ардчиллын замаар тууштай явж байгаа ч орон нутгийн кодтой жижиг орны хувьд үндэсний аюулгүй байдлаа хамгаалах нь амин чухал хэвээр юм. Хүн ам цөөнтэй, нэг хүнд ноогдох үндэсний орлого багатай манай орны хувьд өөрийн хүчиндээ найдаж цэрэг, зэвсгийн хүчээ зузаатгах боломж үгүй. Иймээс цэрэг, улс төр, эдийн засгийн холбоо, бүлэглэлд нэгдэх замаар аюулгүй байдлаа хангахыг хичээх болсон нь зүй ёсны хэрэг юм.

Монгол улс цэргийн аливаа нэгэн эвсэлд орж яваагүй бөгөөд гадаад бодлогын үзэл баримтлалдаа нээлттэй, эвсэлд үл нэгдэх бодлого явуулна хэмээн тодорхойлсон. Монгол улс эвсэлд үл нэгдэх бодлого явуулахын тулд хоёр хөрштэйгээ эв найртай байж, цэргийн ямарваа нэгэн эвсэлд хамрагдахаас эрс зайлсхийх хэрэгтэй.

ДҮГНЭЛТ

Дэлхийн олон улсын харилцааны систем шилжилтийн үедээ явж, либерал үзэл ноёрхсон XX зууны 90-ээд оны сүүл, 2000 оны эхэн үе нь Монгол шиг орон нутгийн кодтой оронд туйлын таатай байсныг манай улс чадварлаг ашиглан, гуравдахь хөршүүдтэй хамтын ажиллагааг хөгжүүлж чадсан билээ. Аж үйлдвэрийн салбараар гараагаа эхэлж, санхүү, бизнесийн салбарт амжилт өндөр амжилт олсон Хятад улс олон улсын тавцан дээр улс төрийн тоглоомоо эхлэн, Евразийн хүрээ газарт нөлөөгөө хүчирхэгжүүлэхээр батлан хамгаалах хүчээ эрс нэмж байна. Дэлхийн супер том гүрэн байсан ОХУ бүс нутагт нөлөөгөө алдахгүйн тулд гадаад бодлогын чиг баримжаагаа өөрчлөн Ази тивд анхаарал хандуулах болсон нь хөрш Монголыг тойрон гарсангүй. Олон улсын тавцан дээр реалист хандлага давамгайлж байгаа өнөө үед Монгол улс гадаад бодлогодоо реалист, либерал хандлагыг зөв хослуулах шаардлагатай юм. Эдийн засгийн тогтвортой өсөлт байхгүй үед (өнөөдрийн эдийн засгийн өсөлтөндөр ч гадаад хүчин зүйлээс хэтэрхий хамааралтай нь үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй) үндэсний аюулгүй байдал цаасан дээр үлдэх юм. Өндөр хөгжилтэй гуравдагч орнуудын хөрөнгө оруулалтыг зөвхөн уул уурхай төдийгүй эдийн засгийн бусад салбарт татан оруулснаар тэдний хамгаалалтанд орно. Гуравдагч хөршүүдийн хамгаалалтанд орохын тулд гадны хөрөнгө оруулалтыг татсан улс төр, эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэх ёстой ч шинэчлэлийн Засгийн газар энэ тал дээр одоо болтол ул суурьтай бодлого явуулахгүй байсаар. Түүнчлэн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх эдийн засаг, эрх зүйн орчинг бий болгож, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх нь эдийн засгийн өсөлтийг тогтвортой байлгах чухал хүчин зүйл юм.

Өнөөдөр олон улсын тавцан дээр Монгол улс прагматик шинжтэй гадаад бодлого явуулах хэрэгтэй бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хангахын тулд буулт хийж, уян хатан байснаар алдах, авахын тэнцлийг зөв хангана гэсэн үг. Энэ бодлогын үндсийн үндэс нь олон улсын аливаа үзэгдэл, үйл явдалд задлан шинжилгээ хийх, үндэсний эрх ашгийн үүднээс зөв дүгнэлт, үнэлэлт өгөх чадвар юм.

Мэдээлэл, судалгаагаа сайжруулахгүйгээр гуравдагч хөршүүдтэй харилцах харилцааны үр өгөөжийг дээшлүүлэх тухай ярих нь утгагүй бөгөөд гадаад харилцааны үйл ажиллагаа, шинжлэх ухааны холбоог сайжруулах шаардлага зайлшгүй байгааг хэлмээр байна. АНУ, бусад гуравдагч хөрштэй харилцааны эрх зүйн таатай нөхцөл бүрэлдүүлэх, гадаад харилцаанд холбогдох буюу зохицуулах дотоодын хууль тогтоомжийн тогтолцоог бүрэлдүүлэхийн тулд гадаад харилцааны бодлогод шинжлэх ухааныг өргөн ашиглах нь өнөөгийн гадаад бодлогын нэг зорилт мөн.

Ном зүй

Mackinder H. “The Round World and the Winning of the Peace.” х.45-60

Галиймаа Н. XX зууны Монгол, Америкийн харилцаа: үүсэл хөгжил, тулгамдаж байсан асуудлууд. УБ.2001, х. 136

Mineral Resources and Petroleum Authority of Mongolia, March 2008

<http://www.worldbank.org/mn/news/feature/2013/04/30/mongolia-economic-update-april-2013> retrieved 12-10-2013

www.mram.gov.mn retrieved 12-10-2013

Монгол улсын өрсөлдөх чадвар. УБ. 2011, х. 2-42

<http://news.gogo.mn/r/105393> retrieved 14-10-2013

March 4, 2011; Wikipedia “Military budget of the People's Republic of China” retrieved 14-10-2013

CRS Report RL33407, Russian Political, Economic, and Security Issues and U.S. Interests, retrieved 10-10-2013

ДЭЛХИЙН УЛСУУДЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ БА МОНГОЛ УЛС

С.МӨНХБАТ¹, Г.ЦЭНД-АЮУШ²

¹МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, (Ph.D), дэд профессор

²МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор

Түлхүүр үг: хөгжлийн бодлого, зорилт, төлөвлөлт, нийгмийн хөгжлийн онолын чиглэлүүд, эдийн засгийн хөгжил, хүний хөгжил, тогтвортой хөгжил, монголын хөгжлийн бодлого, зорилт.

ABSTRACT: In this era where globalization is pervasive in all areas and opportunities and risks for individuals, institutions, and nations increase, national Development Plan is the fundamental policy document that sets which country will realize in economic, social, and cultural areas in an integrated approach.

Within the framework of the changing economic and social conditions in the world and in Mongolia, development plans have become a much more important instrument than they were in the past and due to these conditions, redesigning of those plans has become inevitable. In this article we would like to presented about development plan of Mongolia and other countries.

Successive development plans adopted a scientific approach, making for the rational use of national resources, which enabled the Mongolia to achieve significant developments, exemplified by significant gains reflected in the various indicators of socioeconomic development. Accumulated development over the past decades has achieved significant improvement in standards of living and the quality of life.

ТОВЧ ХУРААНГУЙ: Хүн төрөлхтний хөгжлийн явцад хөгжлийг үзэх олон онол, үзэл баримтлал боловсрогдон бий болжээ. Энэхүү онол, үзэл баримтлалуудын бодит хэрэгжилт болон гарч ирсэн нийгмийн хөгжлийн загварууд нь дэлхий дахины улс орнуудын хөгжлийн агуулга, хэлбэрээрээ ижилсэх болон ялгарах шинжүүдийг бий болгосон байдаг. Иймд энэхүү нийтлэл нь дэлхий дахины улс орнуудад бодит байдлаар хэрэгжсэн хөгжлийг үзэх, онол, үзэл баримтлалуудыг судалж, Монголын нийгмийн хөгжлийн бодлого, зорилтыг боловсруулж гаргах талаар санал дэвшүүлэхэд чиглэсэн болно.

Удиртгал

XXI зуунд дэлхий дахинд глобалчлалын үйл явц улам бүр эрчимтэй өрнөж хүн төрөлхтний үнэт зүйл, хөгжлийн чиг хандлагад томоохон нөлөө үзүүлэх боллоо. Энэ үйл явц нь нэг талаас дэлхийн улс орнуудыг хөгжлийн ойролцоо түвшин, хэрэглээний нэгдсэн хэм хэмжээнд оруулах боломжуудыг олгож буй боловч нөгөө талд улс үндэстнүүдийг уламжлалт соёл, хөгжлийн онцлогоо хадгалж үндэсний онцлогтойгоор хөгжих бодлого, зорилтуудыг дэвшүүлж түүндээ хүрэх арга зам, загвараа төлөвлөж тодорхойлоход чиглэсэн шаардлагуудыг нөхцөлдүүлж байна.

Хөгжлийн хурд, далайц нэмэгдэж буй энэ зуунд дэлхийн улс орнууд хөгжлийнхөө үндэс суурийг нь бат бэх тавьж, ирээдүйд хүрэх нийгмийн хөгжлийн загвараа зөв, оновчтой сонголт хийж, шинжлэх ухаанд суурилсан, үр дүнд хүрэхүйц хөгжлийн богино, дунд, урт хугацааны бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулан гаргаж түүнийгээ мөрдөн ажилладаг жишиг тогтжээ. Тухайлбал, БНХАУ-ын XII таван жилийн төлөвлөгөө¹²⁷, Энэтхэгийн XI таван жилийн төлөвлөгөө¹²⁸, Малайзийн шинэ эдийн засгийн загвар¹²⁹, Филиппин улсын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө¹³⁰, Польш улсын үндэсний хөгжлийн стратеги¹³¹, Тайван улсын III жилийн үндэсний хөгжлийн төлөвлөгөө¹³², Бүгд Найрамдах Болгар улсын Үндэсний Хөгжлийн Төлөвлөгөө¹³³, Катар улсын Үндэсний хөгжлийн стратеги¹³⁴, Саудын Арабын IX хөгжлийн төлөвлөгөө¹³⁵, Турк улсын IX хөгжлийн төлөвлөгөө¹³⁶ гэх мэтээр дэлхийн улс орнууд өөрсдийн хөгжлийн бодлого, зорилтуудаа дэвшүүлэн түүндээ хүрч хөгжихийн төлөө зорьж байна.

1. Хөгжлийг үзэх үзэл санаа

Монгол улс ардчилал, зах зээлийн хөгжлийн замаар замнаад даруй 23 жилийн нүүрийг үзэж байна. Эл хугацаанд бид хөгжлийн тухай их ярьж, их бичиж буй боловч жирийн иргэдийн бодит амьдралд наалдацтай үр дүн төдийлөн харагдахгүй байна. Үүний учир шалтгаан юунд байна вэ? Бид үүнийг тодруулж, учир шалтгааныг олж шийдвэрлэх замаар хөгжилд хүрэх ёстой. Гэвч хөгжил гэдэг бодит үзэгдлийн хувьд ч тийм амар хялбар тодорхойлоод хэлчихэж болох зүйл биш аж. Бидний ойлгож буйгаар хөгжил гэдэг нь тухайн ард түмэн өөртөө шаардлагатай зүйлээ хийж бүтээж чаддаг, хэрэглэж ашиглаж чадах арга ухаанаа мэддэг байх ёстой гэсэн санаа болов уу.

Ялангуяа эдийн засгийн хөгжлийн нийгэм, соёлын талын эерэг болон сөрөг үр дагаврыг сайтар шинжлэн үзэх учиртай юм. Өнгөрсөн зуунд хөгжлийг хэмжих гол үзүүлэлт бол эдийн засгийн өсөлт гэж үзэж, хэмжих хандлага зонхилж байв. Ядуу буурай олон орон өрх тусгаарлаж ард иргэдийнхээ аж амьдралыг бие даан хариуцах болж ирсэн цагт юуны өмнө эдийн засгаа өсгөх нь бусад зорилтыг шийдвэрлэх суурь болж байсан болохоор эдийн засгийн өсөлтийг чухалчлах нь зүйн хэрэг байв¹³⁷. Гэвч эдийн засгийн өсөлтөөр бий болсон нөөцийг нийгмийн олон талт хэрэгцээг хангахад чиглэсэн бодлогоор хуваарилахдаа дэлхийн улс орнууд харилцан адилгүй арга механизмыг хэрэглэсэн аж. Байгалийн баялаг, газрын тосны борлуулалтаасаа асар их мөнгө олж эдийн засгийн өсөлтөө нэмэгдүүлж нэг хүнд ноогдох ДНБ нь өндөр хэрнээ, орлогын хуваарилалт шударга бусаас болж хүн ам нь ядууралд орсон орнууд нэлээдгүй байна. Харин нөгөө талд бий болсон эдийн засгийн өсөлтийг хүний хөгжлийн суурь болгон хувиргах гол хүч нь төрийн ухаалаг бодлого байгаа нь улс орнуудын туршлагаа нэгэнт тодорхой болсоор байгаа билээ. Түүнчлэн эдийн засгийн өсөлт нэмэгдэж байгаа ч ядуурал, тэгш бус байдал, гэмт хэрэг зэрэг хөгжлийн хүчин зүйлсийн хоцрогдол байсаар байгаа нь улс орны хөгжилд орлогоос гадна нийгмийн шударга ёс, тэгш

¹²⁷ China's 12th Five-Year Plan. How it actually works and what's in store for the next five years. 2010

¹²⁸ 11th Five Year Plan of India . 2007-2012. Volume. I. Inclusive Growth, Volume. II. Social Sector, Volume.III. Agriculture, rural development, industry, services, and physical infrastructure

¹²⁹ New Economic Model for Malaysia., 2011

¹³⁰ Medium-Term Philippine Development Plan. 2004-2010

¹³¹ Poland National strategic reference framework. 2007-2013. In support of growth and jobs.

¹³² Third-Term Plan for National Development in the New Century (Four-Year Plan for 2009~2012) and Plan for National Development in 2009.

¹³³ National Development Plan of the Republic of Bulgaria over the 2007-2013 period.

¹³⁴ Qatar National Development Strategy. 2011~2016.

¹³⁵ The Ninth Development Plan. 2010-2014. Kingdom of Saudi Arabia

¹³⁶ The Ninth Development Plan 2007-2013. Turkey

¹³⁷ А.Цанжид. Хөгжлийн стратегийн талаар эргэцүүлэх нь. УБ., 2008. 9 дахь тал

хуваарилалтыг хангаж, нийгмийн хүчин зүйлүүдийг тооцож, бодлого хөтөлбөрт тусгах зайлшгүй шаардлагыг бий болгож байна¹³⁸. Үүнээс үзэхэд хөгжил нь эдийн засгийг өсгөх, бууруулахаас илүү өргөн хүрээтэй ойлголт юм.

Тийм учраас хөгжил гэж юуг ойлгох талаар зарим тодорхойлолт, санал дүгнэлтийг тодруулья. Өнгөрсөн зууны 70-аад оноос хөгжлийн асуудлыг тойрсон цогц бодлогыг гаргаж хэрэгжүүлэх асуудал чухлаар тавигдаж ингэж чадсан улс орнууд эрчимтэй хөгжлийн гараанд шилжин орж байв. Дээр дурьдсанчлан эдийн засгийн өсөлтийг хөгжлийн гол хэмжүүр болгон хөгжиж ирсэн орнуудад баялагийн шударга бус хуваарилалт явагдах болсноор хөгжлийг хэмжих өөр үзүүлэлтийг эрдэмтэн судлаачид, улс төрчид, шийдвэр гаргагчид болон олон улсын байгууллагууд эрэлхийлэх болсон юм. Энд юуны урьд хөгжлийг хэмжих гол үзүүлэлт бол хүн юм гээд энэ чиглэлийн онол, үзэл баримтлалууд боловсрогдон гарч ирсэнээр хүний хөгжил, хүний хүчин зүйл дээр гол анхаарлаа хандуулах болсон юм.

Хүн бол аливаа үндэстний гол баялаг¹³⁹ юм гэсэн үндсэн концепци дээр хүний хөгжлийн үзэл баримтлал суурилж ирсэн бөгөөд энэхүү хөгжлийг үзэх үзэл баримтлал янз бүрийн тодотгол хийгдэж явсаар эдүгээ хөгжлийн онолын гол шугам болж байгааг судлаачид онцлон тэмдэглэдэг. Хөгжлийн үр шимээс энгийн иргэд хожиж, үр шимийг нь хүртэж байх ёстой. “Хүн бол бүхний хэмжүүр” гэсэн эртний ухаантнуудын үгнээс улбаалан “Хүн бол хөгжлийн хэмжүүр” гэж үзэж болно¹⁴⁰. Аливаа үндэстний баялаг нь хүн учраас хөгжлийн зорилго нь хүн ардаа эрүүл энх, бүтээлчээр урт удаан амьдрах таатай орчинг бүрдүүлэхэд оршино. Өөрөөр хэлбэл хөгжлийн үр шимээс иргэд хүртэж байх ёстой гэдэг утгаараа улс орны хөгжлийг тодорхойлогч гол хүчин зүйл нь тухайн улсын иргэдийн амьдралын чанар, боловсрол, соёлын хөгжлийн түвшин байдаг. Тэгэхээр хөгжлийн үндсэн зорилго нь зөвхөн хөгжлийн нэгэн хэрэгсэл болох эдийн засгийн өсөлтөөс ч илүү өргөн утгатай, хамгийн чухал нь хүмүүсийн сонголтыг бий болгох, өргөжүүлэхэд оршиж байдаг байна.

Манай судлаач доктор, профессор А.Цанжид энэ тухайд бичихдээ “Нэгэнт хүний хөгжлийн тухай яригдаж байгаа болохоор түүний амьдралын бүхий л талыг анхаарах нь зүйн хэрэг. Үүнээс үүдэн тал бүрийн хөгжлийн тухай үзэл баримтлал бий болов. Эл үзэл баримтлалыг оросоор “всесторонное развитие”, англиар “pluridimensional development” гэх бөгөөд эдийн засаг, нийгмийн тэгш ололтод хүрэх нь хөгжлийн эдийн засаг, нийгмийн ололтыг агуулсан хоймсон үйл явц ажээ. Эдийн засаг, нийгмийн тэгш ололтод хүрэх нь хөгжлийн эдийн засаг, нийгэм соёл, байгаль, техникийн талуудын харилцан үйлчлэлийн үр дүн байх учиртай юм”¹⁴¹ гэжээ.

Мөн судлаач доктор Б.Даш-Ёндон “Хэрэвээ хүмүүс зөв сэтгэж соёл сайтай ажиллавал эдийн засгийг нийгмийнхээ хөгжлийн баттай суурь болгож чадна, яагаад гэвэл хүн өөрөө эдийн засгийнхаа уг сурвалж, түүнээ буй болгодог хөдөлгөгч хүч нь юм. Хүнгүйгээр нийгмийн эдийн засаг бүрэлдэн тогтоно гэж үгүй. Бүх юм хүмүүнээс хамаарна. Хүн бол чухамдаа энэ ертөнц дэх хариуцлагын гав ганцхан субъект мөн”¹⁴² гэж дүгнэжээ. Үүнээс үзвэл хөгжлийн гол асуудал хүн, хүний хөгжлөөр бүхний хөгжлийг хэмжиж болно гэсэн философи санааг илэрхийлэн хэлсэн гэж үзэж болохоор байна.

1974 онд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс гаргасан “Кокайн тунхаглалд” “хөгжил гэдэг бол юмсын хөгжил бус хүний хөгжил байх ёстой”¹⁴³ гэж үзсэн байна. Ийм учраас

¹³⁸ Н.Наранчимэг нар. Хүний аюулгүй байдал. УБ., 2009. 6-7 дахь тал

¹³⁹ Human Development report. Defining and measuring Human Development.UNDP., 1990. p. 9

¹⁴⁰ УИХ-ын намрын чуулган дээр Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын хэлсэн үгнээс. 2005 оны 10-р сарын 3-ны өдөр

¹⁴¹ А.Цанжид. Хөгжлийн стратегийн талаар эргэцүүлэх нь. УБ., 2008. 10 дахь тал

¹⁴² Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи. Асуудал, аргачлал, ашиг тус. УБ., 2013. 166 дахь тал

¹⁴³ Cocoly Declaration. UN. UNEP/UNCTAD. 1974

аливаа улс орны хөгжлийн нүүр царай нь ард иргэдийнх нь яаж амьдарч байгаагаар тодорхойлогдоно. Ингэхлээр хүн ард нь сайн сайхан амьдарч байвал нийгэм нь хөгжжээ гэж ойлгож болно. Хөгжих, хөрөнгө олох, босгох нэрээр гаднынханд ашигтай гэрээ хэлцэл байгуулсны горьг монголчууд амсаж байна. “Өөрийн газар шороог сүйтгэдэг улс үндэстэн өөрийгөө егүүтгэнэ” гэж Ф. Рузвелтийн хэлсэн үг одоо цагт ач холбогдлоо алдаагүйг тэмдэглэх хэрэгтэй. “Өргүй бол баян, өвчингүй бол жаргал” гэж манай ардын зүйр үг байдаг. Тиймээс хэдэн үеэрээ төлж барахгүй өр тавьж хөгжинө гэвэл бүтэшгүй хэрэг. Нөгөө талаар Монгол орныг гадаадын илүүдэл бүтээгдэхүүнийг хүн ардаа борлуулдаг бараан зах болгох ёсгүйг профессор Б. Даш-Ёндон сануулж хэлсэн байдаг. Иймд ХХI зуунд Монголчууд бид гаднынханд найр тавьж найдах аргагүй. Энэхүү Монгол үндэстний хөгжлийн тухай асуудал дээр гагцхүү нарийвчлан боловсруулсан шинжлэх ухааны судалгаа шинжилгээнд суурилсан бодлого, үндэсний үзэл санаа, ухамсар, үнэн магад үйлдэлдээ тулгуурлах хэрэгтэй болов уу. Энэ бол ардчилсан төрийн бодлого, зохицуулалт, улс төрийн намууд болон иргэний байгууллагуудын идэвхтэй үйл ажиллагаа, оролцоонд найдна гэсэн үг. Энэ бол монгол түмэн, улс үндэстнийхээ эрх ашиг, сонирхлыг тэргүүн эгнээнд тавина гэсэн үг. Үндэсний үзэл санаа дэлхийн үндэстэн бүхэнд өөр өөрийн өнгө аястайгаар үйлчилж, улс орноо хөгжүүлэх, тусгаар тогтнол, хараат бус байдлаа хадгалан бэхжүүлэх хэрэгт нь туслах зэвсэг болсоор ирсэн байна¹. “Төр алдаанаасаа болж солигдож болно, харин түүнээс болж улс орон “солигдож” мөхөж болохгүй гэж Платон сургасан байдаг. Ингэхлээр улс төрийн бодлогын хөдөлгөгч хүч нь үндэсний эрх ашиг, сонирхол байдаг ажгуу. Монголчууд эрт үеэс төрийн минь сүлд өршөө хэмээн сүү цацлаа өргөн залбирч ирсэн. Энэ бол Монголын төр улс, монгол үндэстэн үүрд мөнхрөн оршиг хэмээсэн үндэсний үзэл санаа мөн болой.

Өнгөрсөн ХХ зууны хөгжлийг үзэх үзлүүдийг судалж үзвэл ихэнхдээ эдийн засаг, техник технологийн дэвшилээрээ тэргүүлэх асуудлуудыг тойрч тэдгээрийг хэрхэн бий болгох талаар онол боловсрогдож нийгмийн амьдралд хэрэгжүүлэх замаар явж ирсэн байна. Үүний нэг жишээ бол судлаач У.Ростоугийн нийгмийн хөгжлийн үе шатны тухай онол юм. Дэлхийн улс орнуудыг хөгжлийн дээд шатанд явж байгаа, дунд шатанд явж байгаа, хоцрогдсон гэсэн хөгжлийн гурван шатанд хувааж аажимдаа хоцрогдсон орнууд технологийн дэвшилд суурилан эдийн засгийн өсөлтөө бий болгох замаар бусдыгаа гүйцэж түрүүлнэ гэсэн үзэл санааг дэвшүүлж байв.

ХХ зууны 70-аад оноос дан эдийн засгийн өсөлтөөр нийгмийн хөгжлийг хангах явдал учир дутагдалтай гэдэг нь амьдралд тодорхой болж эхэлсэн байна. Энэ үед эдийн засаг нь өсч байвч энэ өсөлтийн үр шимийг нийгмийн олонх хүртэх боломж улам бүр хумигдаж байсантай холбоотойгоор энэ байдалд шүүмжлэлтэй хандах замаар бий болсон үзэл баримтлал бол “бүх нийтийн үндсэн хэрэгцээг хангах” үзэл санаа байв. Энэхүү үзэл санааны гол агуулга нь хүнд хоол хүнс, орон гэр, эрүүл мэндийн анхан шатны туслалцаа авах боломж бий болгох болон боловсрол зэрэг нь зайлшгүй хэрэгтэй. Үүнийг хангахад чиглээгүй тэр тусмаа тасалдуулахад хүргэдэг ямар үзэл санаа, хөгжлийн тухай яриа байж болохгүй гэж үзэж байв. Гэвч энэ үзэл санаа дэлхийн улсуудад хүний анхдагч наад захын хэрэгцээг хангах суурь нөхцөл өөр өөр байсан болон уг хэрэгцээг яаж хэмжих вэ гэх зэргээс үүдсэн ойлголтын зөрүүг арилгаж чадаагүй байдлаас болж энэхүү үзэл санаа хөгжлийн практик биеллээ олоогүй явсаар өнөөг хүрсэн юм. Нөгөө талаар хүн амын ядуу хэсгийн наад захын хэрэгцээг хангах үүднээс эдийн засгийн өсөлт, технологийн дэвшилд анхаарал хандуулахгүйгээр бий болсон баялаг, нөөцийг шууд хуваарилалтад оруулах замаар асуудлыг шийдэх гэсэн алдаатай бодлого явсан нь нэлээдгүй орныг туйлдуулахад хүргэсэн билээ. Энэ нь нөөцөд суурилсан эдийн засагтай, түүнээс үүдэн нэмүү өртөг бүтээх эдийн засгийн чадавхи муу байхад нийгмийн зардлыг өсгөснөөс эдийн засагт хүндрэл гарах, бэлэнчлэх сэтгэлгээг дэврээх зэрэг олон сөрөг талтай байсан нь ойлгомжтой билээ. Ийм

байдал өнөөгийн Монголын нийгэмд бий болсон дүр төрх, “мулгуу” практик ажиглагддаг. Үүнийг засч залруулах ёстой.

Дэлхийн улсуудын хөгжил дэвшилд хүрэх арга зам, тэдгээрийг тодорхойлох эрэл хайгуулын явцад хөгжлийг үзэх хэд хэдэн үзэл санаа цаашид боловсрогдон хөгжсөн байдаг. Үүний нэг нь улс орнууд дотоодын хүч нөөц, боломжоо дайчлан үндэсний онцлогтойгоор хөгжих тухай эндоген үзэл санаа юм. Эндоген шинжтэй хөгжил гэдэг нь нийгмийн дотоод бүтэц, шинж чанаруудыг харгалзан хөгжлийн загвар, арга хэрэгслийг сонгосны үндсэн дээр бий болох хөгжил аж¹⁴⁴. Энэ үзэл санаа ихэнхдээ хөгжиж буй орнууд болон жижиг, хөгжил буурай орнуудын зүгээс хүчтэй илэрч тэдгээр орнууд тусгаар тогтнол, үндэсний онцлог, соёл иргэншлийн өвөрмөц байдлаа хадгалж хөгжихөд чиглэсэн бодлогоор энэ санаагаа дэвшүүлж байдаг. Энэ үзэл санаанд үндэсний хэл, соёлоо хадгалж үлдэх, ард түмний бүтээлч идэвхд суурилж дотоод нөөц боломжоо бүрэн дүүрэн ашиглах явдлыг чухалчлан үздэг. Эндоген хөгжлийн үзэл санааны бас нэг онцлог нь гадаад хөрөнгө оруулалт тэр дундаа техник, технологийн дэвшлийн нөлөөллийн асуудалд онцгой анхаардаг байна. Гадны техник технологийн хөгжлийн нөлөөлөл тухайн улс орны соёл, хөгжилд хүчтэй нөлөөлснөөр өөрийн өвөрмөц онцлог, уламжлалт хөгжлийн хэв шинжээ улс орнууд алдахад хүргэдэг. Тиймээс аль болох өөрийн дотоод хүч, техник технологийн хөгжилд анхаарахын чухлыг онцолдог байна.

Энэхүү үзэл санаатай зэрэгцэн шахуу гарч ирсэн хөгжлийн тухай өөр нэг үзэл санаа бол “хараат байдлын тухай” Латин Америкийн орнуудад бий болсон үзэл чиглэлүүд юм. Хөгжингүй орнуудын эдийн засаг, технологийн нэвтрэлт нь хөгжиж буй болон хөгжлөөр буурай орнуудын хараат бус бие даасан байдалд шууд нөлөөлж яваандаа дэлхий дахин хүчирхэг хэдэн орнуудын нөлөөлөлд орно гэж үздэг. Тиймээс хөгжлийн нэг ижил түвшний тухай ойлголт, тийм бодит байдал дэлхий дахины хэмжээнд хэзээ ч бүтэшгүй зүйл болж хувирах аж.

Эдүгээ дэлхий дахинд нэлээдгүй яригдаж улс орнууд хийгээд олон улсын байгууллагуудын бодлого, баримт бичгүүдэд тусгалаа олсон хөгжлийн тухай яриа бол глобаль болон тогтвортой хөгжлийн тухай үзэл санаанууд юм. Глобаль хөгжлийн гол үзэл санаа нь дэлхий дахины өмнө тулгарч буй асуудлуудыг хамтын хүчээр шийдэх, хүн төрөлхтөн улс орнуудын бие биеэсээ хамаарах хамаарал улам бүр өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан хамтын хөгжлийн шинэ үзэл санааг гаргаж ирэхэд чиглэгдсэн байдаг.

Тогтвортой хөгжлийн тухай сүүлийн үед ихээхэн ярьж, бичих болсон. Дэлхий ертөнцийг зөвхөн одоогийн хүмүүс төдийгүй ирээдүй үеийнхэн амьдрахад тохиромжтой газар байлгахын тулд юу хийх вэ? гэсэн асуудлыг хөндөж XX зууны сүүлийн 30-аад жилийн турш хэлэлцэж Стокгольмд (1972), Рио-Де Жанейрод (1992), Иоханнесбургт (2002) хуралдаж дэлхийн хөгжлийн загварыг тогтвортой хөгжил¹⁴⁵ гэж тогтоосон байна. Мөн “1983 онд тусгайлан байгуулагдсан хүрээлэн буй орчны болон хөгжлийн асуудлархи Олон улсын комисс НҮБ-д зориулж бэлтгэсэн “Бид нийтийн ирээдүй” хэмээх илтгэлээ 1987 онд хэвлүүлж түүнд “тогтвортой хөгжил” гэсэн нэр томъёо анх орсон байна. Тогтвортой хөгжил гэдэг бол эдүгээ цагийн хэрэгцээг хангаж буй боловч ирээдүй үеийнхэн хэрэгцээгээ хангах чадварыг нь сүйрэлд оруулахгүй тийм хөгжил юм гээд хүний хэрэгцээ, эрмэлзлийг хангах нь хөгжлийн үндсэн зорилт мөн”¹⁴⁶ хэмээн тодорхойлжээ.

Түүнчлэн Рио-Де Жанейрогийн уулзалтаар тогтвортой хөгжлийн 3 тулгуур баганыг эдийн засаг, хүрээлэн буй орчин ба нийгэм гэж тодорхойлсон. Эдийн засаг нь

¹⁴⁴ А.Цанжид. Хөгжлийн стратегийн талаар эргэцүүлэх нь. УБ., 2008. 17-18 дахь тал

¹⁴⁵ Тогтвортой хөгжлийн боловсрол. УБ., 2004. Ред. Д.Дагвадорж. 7 дахь тал

¹⁴⁶ Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи. Асуудал, аргачлал, ашиг тус номоос дам ишлэв. 95 дахь тал

бараа үйлчилгээгээр зах зээлийг хангаж эрүүл эдийн засгийг дэлхий дахинд бүрдүүлснээр тэр нь эргээд нийгэм болоод хүрээлэн буй орчинд үйлчлэх сан болно гэж үзсэн бол хүрээлэн буй орчин тогтвортой хөгжлийн үндсэн тулгуур болохыг хүлээн зөвшөөрч амьдралыг хангах системийг хамгаалах, нөхөн сэргээх, шинэ нөөцийг ашиглах, хог хаягдлыг шингээх экосистемийн боломжоос хэтрүүлэхгүй байх зарчмыг хүлээн зөвшөөрсөн¹⁴⁷. Тогтвортой хөгжлийн гурав дахь тулгуур багана нийгмийн хөгжилд сүүлийн жилүүдэд маш их өөрчлөлтүүд гарсаар байна. Ядуурлыг эдийн засгийн өсөлтөөр бууруулах оролдлого барууны орнуудын эдийн засгийн хямрал, уналттай давхцсан. Энэ үе нь ардчилал, зах зээлд шилжих үйл явцын их өрнөлт, улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцоогоо өөрчилж хувь хүмүүс, төрийн бус байгууллага, нийгмийн бүлэглэлүүдийн дуу хоолой улам хүчтэй болж нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тэдний оролцоо улам бүр нэмэгдэх болсон зэргээр тайлбарлагдаж байна.

2. Дэлхийн улсуудын хөгжлийн бодлого, зорилтын тухайд

XXI зуунд хөгжлийн сайн засаглалын бодлого гаргаж түүнийгээ дэмжсэн хөгжлийн зөв зөв, өөрийн загварыг бий болгосон улс орнууд илүү хурдтай хөгжих нь нэгэнт тодорхой боллоо. Энэ байдлыг дэлхийн улс орнууд соргоогоор мэдэрч хөгжлийнхөө бодлого төлөвлөлтийг богино, дунд, урт хугацааны мөчлөгтэйгээр гаргаж түүндээ хүрэхийн төлөө чармайцгааж байна. Үүнийг өмнө дурьдсан зарим орнуудын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зарим жишээн дээр авч үзье. БНХАУ-ын XII таван жилийн төлөвлөгөө бол ирэх 5 жил тус улсыг хөгжүүлэх бодлогын зорилт бөгөөд заавал хэрэгжих ёстой хууль болж мөрдөгдөг. БНХАУ-ыг хөгжүүлэх энэхүү 5 жилийн төлөвлөгөөний голт зорилтууд нь БНХАУ ирэх 5 жилд өөрчлөн байгуулалт, шинэчлэлтийн нээлттэй бодлогыг үргэлжлүүлэн гүнзгийрүүлж, эдийн засгийн хөгжлийн одоогийн хэлбэрийг өөрчилж, шинжлэх ухааны үндэстэй хөгжлийн шинэ хэв загвараар улс орныг улам хөгжүүлнэ. Улс, нийгмийг шинжлэх ухааны үндэстэй хөгжүүлэх явцдаа олж авсан туршлага, ололт амжилтаа улам баталгаажуулж, чанартай хөгжлийн бааз суурийг бэхжүүлэх замаар эдийн засгийн бүтцэд стратегийн зохицуулалт хийж, нийгмийн түргэн хөгжлөөс чанартай хөгжлийн түвшинд хүргэнэ. Ард иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, тэдний нийгмийн баталгааг хангах асуудлыг эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг өөрчлөх үндсэн суурь нөхцөл болгоно. Байгалийн баялгийг хэмнэх, зүй зохистой ашиглах, байгаль орчинд ээлтэй элэгсэг нийгэм бий болгох асуудлыг эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг өөрчлөх үндсэн хүчин зүйлс болгоно. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шинжлэх ухааны хөгжлийг түргэтгэх асуудалтай хамт авч үзнэ¹⁴⁸ гэсэн хэдэн зорилтын хүрээнд тодорхойлсон байна.

Харин ОХУ-ын хөгжлийн стратеги нь “ОХУ-ын Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн хөгжлийн стратегийн тухай” болон “2020 он хүртэлх ОХУ-ын нийгэм, эдийн засгийн урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын тухай” гэсэн бодлогын хоёр гол баримт бичиг дээр тулгуурлаж байна. Ерөнхийлөгч В.Путины дэвшүүлээд буй хөгжлийн стратегийн бодлогын гол агуулга нь хүний хөгжлийг хангах асуудал руу чиглэсэн бөгөөд “Хүний хөгжил нь орчин цагийн нийгмийн дэвшлийн зайлшгүй шаардлагатай нөхцөл бөгөөд өнөөгийн төдийгүй урт хугацаан дахь ОХУ-ын эн тэргүүний зорилт байна” хэмээн тодорхойлсон байна. Харин 2020 он хүртэлх ОХУ-ын нийгэм-эдийн засгийн хөгжлийг үзэл баримтлалд иргэдийн амьжиргааны тогтвортой өсөлтийг бий болгох замаар үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн эрчимтэй хөгжлийг хангах, олон улсын хамтын нийгэмлэг дэх ОХУ-ын байр суурийг бэхжүүлэх, 2015-2020 онд

¹⁴⁷ Мөн тэнд

¹⁴⁸ China's 12th Five-Year Plan. How it actually works and what's in store for the next five years. 2010

ДНБ-ний хэмжээгээр дэлхийд тэргүүлэгч эхний 5 улсын нэг болох гэсэн гол зорилтуудыг тусгасан байна.

Катар улс Үндэсний хөгжлийн стратегиа¹⁴⁹ 2011 онд боловсруулан түүнийгээ 2016 он хүртэл мөрдөж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Тэрээр улс орныхоо хөгжлийн алсын харааг 2030 он хүртэл тодорхойлж түүндээ хүрэх суурь нөхцөлийг бүрдүүлэх хугацаагаа 2016 оноор тогтоожээ. 2030 он хүртэлх хөгжлийн алсын хараагаа тодорхойлохдоо “амьдралын чанарын өндөр стантдартыг хүн ардынхаа амьдралд буй болгосон, эдийн засаг, нийгмийн шударга ёсыг бүрэн тогтоосон, Исламын болон дэлхий дахинаа өөрийн байр суурийг бүрэн эзэлсэн хөгжингүй орон болно”¹⁵⁰ гэжээ. Тэрээр 2016 он хүртэлх хөгжлийн бодлого, зорилтоо хүний хөгжил, нийгмийн хөгжил, эдийн засгийн хөгжил, хүрээлэн буй орчны хөгжил гэсэн 4 гол чиглэлээр тодорхойлж эдгээр тус бүрийг хөгжүүлэх тооцоо судалгааг маш нарийн гаргаж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Энэ мэтчилэн Болгар¹⁵¹, Польш¹⁵², Турк¹⁵³, Малайзи¹⁵⁴, Филиппин¹⁵⁵, Тайван¹⁵⁶, Саудын Араб¹⁵⁷ зэрэг орнууд өөр өөрсдийн хөгжлийн ирээдүйг зураглан тооцоолсон хөтөлбөр зорилтуудыг боловсруулан хэрэгжүүлж байна.

3. Монголын хөгжлийн бодлого, зорилтын тухайд

Манай улсад хөгжлийн үзэл баримтлал, стратегийн шинжтэй баримт бичгүүд боловсруулж ирсэн уламжлал бий. Судлаач профессор Б.Даш-Ёндон энэ талаар нэлээдгүй судалж хөгжлийн талаарх бодлогын баримт бичгүүдийг боловсрогдсон он цаг болон нийгэм түүхийн нөхцөл байдалд нь уялдуулан дараах ангиллыг хийсэн нь сонирхол татаж байгаа юм. Үүнд,

Нэгдүгээр үе: 1921-1924 он. Энэ үеийн хөгжлийн бодлого нь улс орныхоо тусгаар тогтнолыг байлдан олж засгийн эрхийг ард түмнийхээ гарт шилжүүлж төр улсынхаа олсон бүрэн эрхэт байдлаа тунхаглан зарлаж цаашдын ардач замаа тодорхойлоход оршиж байсан гэж дүгнэжээ. Анхдугаар хөтөлбөрийн үзэл санаа буюу хөгжлийн эл бодлого үндэсний ардчилсан хувьсгалыг ялуулж, гадны шахалтын эсрэг хийсэн хэцүү бэрх тэмцлийн дүнд 1924 онд хуралдсан МАН-ыг III их хурлын шийдвэрт тодорхой томъёологдон, мөн онд батлагдсан анхдугаар Үндсэн хуулиар баталгаажсан юм¹⁵⁸.

Хоёрдугаар үе: 1925-1940 он. Энэ үеийн Монгол улсын хөгжлийн бодлого, зорилтууд нь 1925 онд батлагдсан МАН-ын хоёрдугаар хөтөлбөрт тусгагдсан батлагджээ. Тус хөтөлбөрийн агуулга нь “ардчилсан хувьсгалыг туйлд нь хүртэл өрнүүлж, улс орны нийт амьдралыг ардчилан өөрчлөх, улс орны эдийн засгийн тусгаар тогтнолыг байлдан олж, улс төрийн тусгаар тогтносон байдлаа эдийн засгийн талаар бататгах зорилтыг дэвшүүлж тавьжээ.”¹⁵⁹ Ингэхлээр энэ үеийн хөгжлийн бодлого нь хөрөнгөтний биш хөгжлийн зам дээр баттай гарах бэлтгэлийг бүрэн хангахад оршиж

¹⁴⁹ Qatar National Development Strategy.2011-2016. Towards Qatar National Vision 2030

¹⁵⁰ Qatar National Development Strategy.2011-2016. Towards Qatar National Vision 2030.p. 17

¹⁵¹ National Development Plan of the Republic of Bulgaria over the 2007-2013 period

¹⁵² Poland National strategic reference framework. 2007-2013. In support of growth and jobs.

¹⁵³ The Ninth Development Plan 2007-2013. Turkey

¹⁵⁴ New Economic Model for Malaysia., 2011

¹⁵⁵ Medium-Term Philippine Development Plan. 2004-2010

¹⁵⁶ Third-Term Plan for National Development in the New Century (Four-Year Plan for 2009~2012) and Plan for National Development in 2009.

¹⁵⁷ The Ninth Development Plan. 2010-2014. Kingdom of Saudi Arabia

¹⁵⁸ Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи. Асуудал, аргачлал, ашиг тус. УБ., 2013. 56 дахь тал

¹⁵⁹ Монгол Ардын Хувьсгалт Намын программ, дүрэм. 12 дахь тал

байсан нь харагддаг. Гэхдээ энэ үе шатанд Монгол улс Швейцарь лугаа хөгжих бодлогыг зарим тэргүүний сэхээтнүүд дэвшүүлж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Гуравдугаар үе: 1940-1966 он. Энэ үеийн хөгжлийн бодлого, зорилтын гол агуулга нь социализмын материал-техникийн баазыг зүйл зүйлээр хөгжүүлэн байгуулж дуусгах, БНМАУ-ыг хөдөө аж ахуй- аж үйлдвэрийн орноос аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болгох явдал мөн¹⁶⁰ гэж үзэж болно хэмээн дүгнэсэн байна.

Дөрөвдүгээр үе: 1966-1990 он. 1966 онд батлагдсан МАХН-ын дөрөвдүгээр программ чухал ач холбогдолтой. Уг программд “Улс ардын аж ахуйн салбар хооронд, үйлдвэрлэл хэрэглээний хооронд зөв тэнцвэр баримтлах, улс орны үйлдвэрлэх хүчнийг хамгийн зүй зохистой байрлуулах, хөдөлмөр, эд материал, санхүүгийн нөөцийг үр бүтээлтэй ашиглах, дотоодын бүх нөөц бололцоог дээд хэмжээгээр дайчлах, хоорондоо авцалдаа холбоотой, бие биенээ нөхөн хангадаг эдийн засгийн салбар бий болгох зорилтуудыг дэвшүүлсэн байна.”¹⁶¹ Тухайн үед МАХН улс орноо хөгжүүлэх хөтөлбөр, зорилтоо программ гэж нэрлэсэн байна.

Тав дугаар үе: 1990-2013 он. Энэ үе үндсэндээ ардчилал, зах зээлийн харилцаанд нийгмийн бүх хүрээг оруулах, тэдгээрийн хөгжил, төлөвшилтийн шинэ хэв маягуудыг тодорхойлох зэрэг олон шинэтгэлийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх амаргүй үе юм. Олон намын тогтолцоо бүрэлдэн бий болж төр засгийн эрхийг дангаар болон хамтарч барьж ирсэн бөгөөд намууд хөгжлийн бодлогын нэгдсэн үзэл санаа, философитой байгаагүй нь өнөөг хүртэл нийгмийн хөгжлийн цаашдын ирээдүйг тодорхойлоход бэрхшээл учруулж буй нэг хүчин зүйл болсоор байгаа билээ.

1990-ээд оны дунд үеэс эл асуудалд улс төрчид, эрдэмтэн мэргэд, улс төрийн нам хүчнүүд ихээхэн анхаарал хандуулж зохих түвшинд хөгжлийн бодлогыг тодорхойлсон баримт бичигтэй болох талаар ярилцаж эхэлсэн юм. 1996 онд Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал, 1998 онд Монгол улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2005 онд Монгол улсын үндэсний хөгжлийн хөтөлбөр, 2008 онд Мянган хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого зэрэг хөгжлийн бодлого зорилтоо тодорхойлсон баримт бичгүүдийг гаргасан байна. Хэдийгээр ийм олон баримт бичиг боловсрогдон гарсан боловч тэдгээр нь хөгжлийн тодорхой удирдамж болж чадахгүй өнөөг хүрсэн билээ. Улс төрийн намууд сонгуулиас сонгуулийн хооронд дөрвөн жилийн мөчлөгтэй хөтөлбөр дэвшүүлж ажиллах зарчмаар явж ирсэн нь онохоосоо алдах нь их, хугацаа богино, мөн тэр нь улс орны хөгжлийн нэгдсэн хөтөлбөр гэхээсээ аль нэг намын улс төрийн бодлогын хөтөлбөр маягтай байгаа нь цаашид энэ асуудалд анхаарал хандуулахаас өөр аргагүй байдалд хүргэж байгаа юм. Үүнийг дараах гурван шалтгаанаар тайлбарлаж байна. Үүнд,

1. Нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал, ард иргэдийн ахуй амьдрал төдийлөн сайн биш байна. Үүнийг зарим баримтаар тодруулья. Хөгжиж буй орон гэсэн зэрэглэлд ордог манай орны хувьд энэ асуудал амин чухал ач холбогдолтой билээ. Бид өнөөдөр дэлхийн бусад орнуудтай харьцуулахад хөгжлийн үзүүлэлтээрээ хаана явна вэ?

Дэлхийд өрсөлдөх чадварын төв, Монгол дахь өрсөлдөх чадварын судалгааны байгууллагуудын 2012 онд гаргасан 329 шалгуураар 14 /Катар, Сингапур, Малайз, Мексик, Тайланд, Солонгос, Чили, Перу, Казахстан, Орос, Словени, Болгар, Украин, Словак /оронтой харьцуулж дүгнэсэн судалгаагаар эдийн засгаар 38 оноотойгоор 13 дугаар байрт байна. Уг нь 100 оноо руу ойр байвал их сайн. Засаглалаар Монгол Улс 31 оноо буюу 13 дугаар байрт орсон байхад энэ хоёр үзүүлэлтийн дундаж нь 56 оноо байна. 1 хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнээр 4745 доллар /дундаж нь 24204 доллар/ буюу 15 дугаар байр, эдийн засгийн төрөлжилтөөр 2 оноо /дундаж нь 5 оноо/ буюу 15 дугаар байр, дотоодын нийт хуримтлалаар 3 тэрбум доллар /дундаж нь 126 тэрбум доллар/ буюу 15 дугаар байр, жилд нэг хүнд ногдох хуримтлалаар 1191 доллар

¹⁶⁰ Ю.Цэдэнбал. Социалист Монголын хөгжил дэвшлийн түүхэн замнал. УБ., 1976. 254 дахь тал

¹⁶¹Монгол Ардын Хувьсгалт Намын программ, дүрэм. 91-92 дахь тал

/дундаж нь 8229 доллар/ буюу 14 дүгээр байр, улсын зээлжих чадвараар 34 оноо /дундаж нь 66 оноо/ буюу 15 дугаар байр, хувьцаагаар орж ирсэн шууд хөрөнгө оруулалтаар 4 тэрбум ам доллар /дундаж нь 137 тэрбум доллар/ буюу 15 дугаар байр, төрийн бодлого шийдвэрийн хэрэгжилтээр 2 оноо /дундаж нь 4 оноо/ буюу 15 дугаар байр, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн муу нөлөөллөөр 3 оноо /дундаж нь 5 оноо/ буюу 15 дугаар байр, хүний нөөцийн чанараар /мэргэшсэн ажиллах хүчнийг олж ажиллуулахад бэрхшээлтэй байдлаар/ 2 оноо /дундаж нь 5 оноо/ буюу 15 дугаар байр, технологийн хөгжлөөр /эрх зүйн орчин нь технологийн хөгжлийг чөдөрлөж буй байдлаар/ 4 оноо /дундаж нь 6 оноо/ буюу 15 дугаар байр, эрчим хүчний дэд бүтцээр 2 оноо /дундаж нь 6 оноо/ буюу 15 дугаар байр, агаарын тээврийн хүн тээврээр 398 мянган хүн /дундаж нь 15117 хүн/ буюу 15 дугаар байр, төрөөс боловсролд зарцуулсан нэг хүнд ногдох зардлаар 140 ам доллар /дундаж нь 655 доллар/ буюу 15 дугаар байр, сурагч багшийн харьцаа /нэг багшид ногдох сурагчийн тоогоор /30 сурагч/дундаж нь 19 хүүхэд/ буюу 15 дугаар байр эзэлжээ¹⁶². Эндээс харахад бид бүхэн хөгжлийн түвшинг хэмждэг гол гол үзүүлэлтээр дээрх 14 орнуудтай харьцуулах ихэнхи үзүүлэлтээр сүүл мушгиж байна.

2. Байгалийн асар их нөөц баялагтай Монгол улс энэхүү баялагаа ашиглаж цаашид хөгжих үү эс хөгжих үү гэдэг гараан дээр байгаа энэ үед хөгжлийн зөв бодлого, зорилт үгүйлэгдэж байна. Хөгжих, хөрөнгө олох, босгох нэрээр гаднынханд ашигтай гэрээ хэлцэл байгуулсны горьг монголчууд амсаж эхлээд байх шиг байна. “Өөрийн газар шороог сүйтгэдэг улс үндэстэн өөрийгөө өгүүтгэнэ” гэж Ф. Рузвелтийн хэлсэн үг одоо цагт ач холбогдлоо алдаагүйг тэмдэглэх хэрэгтэй. “Өргүй бол баян, өвчингүй бол жаргал” гэж манай ардын зүйр үг байдаг. Тиймээс хэдэн үеэрээ төлж барахгүй өр тавьж хөгжинө гэвэл бүтэшгүй хэрэг. Нөгөө талаар Монгол орныг гадаадын илүүдэл бүтээгдэхүүнийг хүн ардаа борлуулдаг бараан зах болгох ёсгүйг профессор Б. Даш-Ёндон сануулж хэлсэн байдаг. Иймд XXI зуунд Монголчууд бид гаднынханд найр тавьж найдах аргагүй.

3. Хөгжлийн бодлого, зорилтыг зөв тодорхойлж цаашид улс үндэстнээрээ урагшаа алхахад намуудын нэгдсэн ойлголцол, үндэсний зөвшилцөл юу юунаас чухал байгаа билээ. Монголын хөгжлийн бодлого, ирээдүйн дүр зургийг судалсан гадаад, дотоодын судлаачид, олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын судалгааны дүгнэлт, зөвлөмжөөс үзвэл бид уул уурхайн баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулж түүнээс олох үр өгөөжийг нэмэгдүүлж, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг хурдацтай өсгөх боломж нээгдэж буй хэдий ч эдгээрийг бодлого болгон хэрэгжүүлж үр дүнд хүрэхэд гагцхүү засаглалын чадамж, улс төрийн намуудын ойлголцол, үндэсний хэмжээний зөвшилцөл хамгийн чухал байна гэдгийг цохон тэмдэглэсэн байгааг анхаарах ёстой. Нөгөө талаар бид ардчилсан нийгэмд аж төрж байгаа, үе үе улс төрийн сонгууль болж төр засгийн жолоо барьж буй улс төрийн хүчин солигдож байдаг нөхцөл байдлыг ч харалзах учиртай. Улс орноо хөгжүүлэх үндэсний нэгдсэн бодлоготой байна гэдэг нь хөгжлийн бодлого, зорилтын тухай ерөнхий төслөөлөл дээр намууд санал нэгдэхийг хэлэх болов уу. Нэг намын улс төрийн байр суурийг тусгасан нарийвчилсан хөтөлбөрийн ийм үндэсний хэмжээний нэгдмэл бодлогыг бий болгож чадахгүй юм. Харин тэрхүү төсөөллийг хэрэгжүүлэх талаар яг тодорхой юу хийх вэ гэдэг нь намуудын янз бүрийн мөрийн хөтөлбөрт тусч ард түмний шүүлтээр орж шилэгдвэл төрийн бодлого болон хэрэгждэг¹⁶³ гэж судлаач доктор А.Цанжидын хийсэн дүгнэлттэй санал нэг байна. Өөрөөр хэлбэл улс орны хөгжлийн ерөнхий төсөөлөл нь дотроо намуудын ухаалаг сэтгэлгээ, бүтээлч үйл ажиллагааны

¹⁶² Ц.Элбэгдорж. “Ухаалаг хүн ёс зүйтэй байдаг, ухаалаг төр хариуцлагатай байдаг”. Том төрөөс ухаалаг төр лүү үндэсний зөвлөлдөх уулзалтад тавьсан илтгэл. УБ., 2013

¹⁶³ А.Цанжид. Хөгжлийн стратегийн талаар эргэцүүлэх нь. УБ., 2008. 32 дахь тал

орон зайг агуулж байх учиртай гэсэн үг юм. Ингэж чадвал үндэсний хөгжлийн нэгдмэл бодлого бий болж тогтвортой хөгжлийн суурь тавигдах юм.

Энэхүү Монгол үндэстний хөгжлийн тухай асуудал дээр гагцхүү нарийвчлан боловсруулсан шинжлэх ухааны судалгаа шинжилгээнд суурилсан бодлого, үндэсний үзэл санаа, ухамсар, үнэн магад үйлдэлдээ тулгуурлах хэрэгтэй болов уу. Энэ бол ардчилсан төрийн бодлого, зохицуулалт, улс төрийн намууд болон иргэний байгууллагуудын идэвхтэй үйл ажиллагаа, оролцоонд найд гэсэн үг. Энэ бол монгол түмэн, улс үндэстнийхээ сонирхлыг тэргүүн эгнээнд тавина гэсэн үг. Үндэсний үзэл санаа дэлхийн үндэстэн бүхэнд өөр өөрийн өнгө аястайгаар үйлчилж, улс орноо хөгжүүлэх, тусгаар тогтнол, үл хамаарах байдлаа хадгалан бэхжүүлэх хэрэгт нь туслах зэвсэг болсоор ирсэн байнаⁱⁱ. “Төр алдаанаасаа болж солигдож болно, харин түүнээс болж улс орон “солигдож” мөхөж болохгүй гэж Платон сургасан байдаг. Ингэхлээр улс төрийн бодлогын хөдөлгөгч хүч нь үндэсний сонирхол байдаг ажгуу. Монголчууд эрт үеэс төрийн минь сүлд өршөө хэмээн сүү цацлаа өргөн залбирч ирсэн. Энэ бол Монголын төр улс, монгол үндэстэн үүрд мөнхрөн оршиг хэмээсэн үндэсний үзэл санаа мөн болой.

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолын 3-т “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тусгасан стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулан Улсын Их Хурлаар батлуулж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Засгийн газарт зөвлөсүгэй” гэж заасан.

“Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг баталснаас хойш Хөгжлийн дунд хугацааны нэгдсэн бодлогын баримт бичиг эдүгээ хүртэл гарсангүй. Харин салбарын шинжтэй дунд хугацааны бодлогын баримт бичгийг баталж, тус тусд нь хэрэгжүүлж байна. Сүүлийн 40-50 жилийн хугацаанд эрчимтэй хөгжсөн Япон, БНСУ, Сингапур, Тайван зэрэг орнууд хөгжлийн эхний үе шатандаа улс орныхоо хэмжээнд маш сайн уялдуулсан, нэгдсэн төлөвлөлтийг төрөөс зохион байгуулан, хөгжлийн бодлогоо 4, 5 түүнээс дээш жилийн хугацаагаар нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөртэйгөөр амжилттай хэрэгжүүлж чадсан нь тэдний хурдтай хөгжлийн үндсэн хөшүүрэг байв. Мөн эдийн засгийн цар хүрээ, өсөлтийн хэмжээгээрээ дэлхийн эдийн засагт хүч түрэн орж ирж байгаа БНХАУ, БНЭУ зэрэг улс ч эдийн засаг, нийгмээ маш сайн төлөвлөж хөгжүүлэх төрийн тогтолцоотой нь энэхүү амжилтын үндэс болсоор байна. Чөлөөт зах зээлийн эдийн засгийг эрхэмлэдэг Европын Холбооны улсууд дунд хугацааны хөгжлийн стратегийн баримт бичгүүдийг боловсруулж, тэдгээрийг 5 жил тутам тодотгон хэрэгжүүлж байгаа нь дунд хугацааны стратеги, төлөвлөлт зайлшгүй хэрэгцээтэйг нотлон харуулж байна. Манай улсын хувьд дээр дурдсан орнуудтай жишвэл эдийн засаг, нийгмийн төлөвлөлтийн төрийн тогтолцоо хараахан бүрэлдээгүй, өөр хоорондоо уялдаагүй, эрэмбэ дараалал нь алдагдсан олон бодлого, хөтөлбөртэй байгаа явдал үндэсний хөгжлийн суурь төдийгүй, хөгжлийн бүхий л асуудлыг шийдвэрлэхэд ноцтой саад тотгор болж байна. Эдгээр асуудлыг цаг хугацаа, хөрөнгө мөнгө, техник технологи, хүний болон байгалийн нөөц, орон нутгийн онцлог, гадаад нөхцөл зэрэг олон асуудлын уялдаанд авч үзэн шийдвэрлэж чадвал нийгэм, эдийн засгийн хөгжлийг шинэ шатанд гаргаж улмаар иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэх боломж бидний өмнө нээлттэй байна.

Чухамдаа ингэж байж сая улс орондоо цэвэр нандин улс төрийг төлөвшүүлж чадна. Дээр дурьдсан хөгжлийн бодлогоо өөр өөрийн үндэсний онцлогт түшиглэсэн алсын хараатай бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлж байгаа улс орнуудын туршлагыг жишиж үзэхэд Монгол улсад өөрийн гэсэн хөгжлийн бодлогын загвар, арга зам хэрэгтэй болж буйг энэхүү өгүүлэлдээ бид тэмдэглэн дурьдаж байна.

Ашигласан материал

- Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992
- Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого. УБ., 2008
- А.Цанжид. Хөгжлийн стратегийн талаар эргэцүүлэх нь. УБ., 2008
- Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи. УБ., 2013
- Н.Наранчимэг нар. Хүний аюулгүй байдал. УБ., 2009
- П.Очирбат нар. Тогтвортой хөгжлийн боловсрол. УБ., 2004
- Мэри Хилсон. Нордик загвар. 1945 оноос хойшхи Скандинавын орнууд. Орч. М. Билгүүндарь. УБ., 2013
- Ард түмний хөгжлийн хөтөлбөр. 2012-2031. МАН-ын бодлогын баримт. УБ., 2012
- George Friedman. The Next 100 years. A Forecast for the 21st century. NY., 2009
- James M. Cypher and James L. Dietz. The Process of Economic Development. NY., 2004
- China's 12th Five-Year Plan. How it actually works and what's in store for the next five years. 2010
- 11th Five Year Plan of India . 2007-2012. Volume. I.
Inclusive Growth, Volume. II.
Social Sector, Volume.III.
Agriculture, rural development, industry, services, and physical infrastructure
- New Economic Model for Malaysia., 2011
- Medium-Term Philippine Development Plan. 2004-2010
- Poland National strategic reference framework. 2007-2013. In support of growth and jobs.
- Third-Term Plan for National Development in the New Century (Four-Year Plan for 2009~2012) and
Plan for National Development in 2009.
- National Development Plan of the Republic of Bulgaria over the 2007-2013 period.
- Qatar National Development Strategy. 2011~2016.
- The Ninth Development Plan. 2010-2014. Kingdom of Saudi Arabia
- The Ninth Development Plan 2007-2013. Turkey

ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ОНОЛ, ҮЗЭЛ ХАНДЛАГА

Ж.ТӨРТОГТОХ¹, С.МЯГМАРСҮРЭН²

¹МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, доктор, профессор

²ШУТИС, докторант

Түлхүүр үг: Олон улсын эрчим хүчний харилцаа, реалист онол парадигм, либерал хандлага, олон улсын харилцааны радикал үзэл баримтлал, эрчим хүчний тоглогч

ABSTRACT: Nowadays energy has become the essential part of geopolitics and international relations as energy resource and energy security issues dictate international relations and international security agenda. This interdependence has been studied on number of classic theories of international relations. Moreover, not only international relations study but also geopolitical paradigm, security studies have been trying to define world energy policy from their specific angles. However, the most useful theory to study international energy cooperation, energy conflicts and develop alternative scenarios for international energy perspective is fundamental theories of international relations. In particular, realist, liberal, Marxist or radical currents of international relations' theory have developed their own definition of international energy relations.

Оршил

Аливаа улс орны хөгжлийн гол тулгуурын нэг бол эрчим хүчний салбар юм. Эрчим хүч нь үйлдвэрлэх хүчний хөгжлийн үндэс бөгөөд аж үйлдвэр, ХАА, тээвэр, харилцаа холбооны салбарын тасралтгүй ажиллагааг хангаж байдаг. Улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг эрчим хүчний байнгын хангамжгүйгээр хэрэгжүүлэх боломжгүй.

Эрчим хүчний асуудал нь улс үндэсний хөгжлийн чухал нөхцөл болохын зэрэгцээ олон улсын харилцаа хандлагыг тодорхойлж байдаг. Орчин үеийн дэлхий дахины харилцаа, хамтын ажиллагааг хангахад эрчим хүч шийдвэрлэх нөлөө үзүүлэх болсон. Эрчим хүчний нөөц, эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэхээс дэлхийн эдийн засгийн хөгжил, олон улсын харилцааны төлөв байдал шалтгаалах болжээ.

Дэлхий дахин, бүс нутгийг хамарсан улс төр, эдийн засгийн хямрал сөргөлдөөн хийгээд хамтын ажиллагаа, бүс нутаг, даяар харилцаанд хүчний тэнцвэрийг хангахад эрчим хүч шийдвэрлэх нөлөө үзүүлэх хэрэгсэл гэж тооцогдох болов. Иймээс эрчим хүчний бодлогын судалгаа нь улс төр, олон улсын харилцааны хувьд шинэ тутам салбар бөгөөд орчин үед эрчим хүчний бодлогын судалгаанд улс орнууд төдийгүй олон улсын байгууллагууд багагүй хүчин чармайлт тавьж байна. Эрчим хүчний нөөц, аюулгүй байдлын асуудал нь олон улсын харилцааны чухал чиглэл болсноос үүдэж эрчим хүчний улс төр судлал (energy politics), эрчим хүчний аюулгүй байдал, эрчим хүчний дипломати, эрчим хүчний геополитик зэрэг судалгааны хийгээд бодлогын стратегийн шинэ тутам салбарууд хөгжих болов[1].

Олон улсын харилцаа, дэлхийн бодлогод эрчим хүчний эзлэх байр суурь улам бүр өсч, эрчим хүчийг улс төр, гадаад бодлогын гол арга хэрэгсэл гэж тооцох болсон өнөө үед дэлхий дахины чиг хандлага, эрчим хүчний талаар олон улсын харилцааны онол, үзэл баримтлалыг судлах үндсэн дээр онолын үндэстэй, судалгаа шинжилгээний суурьтай хандах нь чухал учир холбогдолтой асуудал болжээ.

Олон улсын эрчим хүчний аюулгүй байдал, эрчим хүчний дипломат харилцааг онолын үндэс суурьтай судлахгүйгээр түүний өнөө нөхцөл байдлыг задлан шинжилж, ирээдүйн чиг хандлагыг таамаглах бодит үндэслэл, дүгнэлт гаргахад бэрхшээлтэй юм. Дэлхийн эрчим хүчний бодлогын асуудлыг олон улсын харилцааны онол, геополитикийн парадигм, аюулгүй байдлын үзэл баримтлалууд өөр өөрийн өнцгөөр авч үзэж, тодорхойлсон байдаг. Олон улсын эрчим хүчний салбарын хамтын ажиллагаа, зөрчил мөргөлдөөний шалтгааныг авч үзэх, альтернатив хувилбаруудыг дэвшүүлэхэд олон улсын харилцааны суурь онолууд чухал ач холбогдолтой. Олон улсын харилцааны реалист, либерал-идеалист болон радикал онол нь олон улсын эрчим хүчний харилцааг өөр өөрийн үзэл хандлагаар тайлбарлаж ирсэн байна.

Олон улсын эрчим хүчний харилцааны талаарреалист парадигм

Байгалийн нөөц баялаг тэр дундаа эрчим хүч бол үндэсний ашиг сонирхол, улс орны хүч чадлын гол бүрдэл хэсэг болж байдаг. Олон улсын реалист онолын төлөөлөгч Х.Моргентау “газар зүй, байгалийн баялаг, аж үйлдвэрийн нөөц потенциал, цэрэг армийн бэлтгэл, хүн амын тоо, үндэсний онцлог, ёс суртахуун, дипломати ур чадвар, засаг захиргаа зэрэг нь улс орны хүчний бүрдэл элемент [2]” гэж тооцсон байдаг. Эрчим хүчний нөөц нь төр улсын хяналтад байдаг биет объект, улс орны аж үйлдвэрийн потенциал, улс орнуудад материаллаг шахалт нөлөө үзүүлэх хүчин зүйл гэдэг утгаараа “хатуу хүч”-ний нэг чухал элемент гэж тооцож болно. Иймээс түүнд хяналт тогтоох явдал томоохон гүрнүүдийн хувьд чухал ач холбогдолтой үйл явц юм.

Улс орнуудын хүч нөлөөг илтгэх чухал үзүүлэлт бол эрчим хүчний нөөцийг хянах чадвар хийгээд түүнийг ашиглан дэлхий дахинд нөлөөгөө тогтоох бололцоогоор илэрнэ. Орчин үед дэлхийн эрчим хүчний нөөц улам бүр хомсдож төдий хэрээр аюул эрсдлийг байнга дагуулах болсон. Реалист онолчдын үзэж буйгаар энэхүү хомс бөгөөд үнэ цэнтэй нөөцийг олж авах, хяналт тогтоохын тулд улс орнуудын өрсөлдөөн улам бүр хурдцажумлаар нөөцийн төлөөх дайн, зөрчил мөргөлдөөн зайлшгүй биш ч магадлал нь улам бүр өсч байгаа аж. Шинэ зуун гарснаар АНУ, Орос, Европын холбоо, Япон, Энэтхэг зэрэг хүчирхэг гүрнүүдийн хооронд эрчим хүчний нөөц мөргөлдөөний гол субъект болох хандлагатай байна.

Дэлхий дахины эрчим хүчний харилцаанд хэд хэдэн субъект оролцдог ч уг харилцааны гол тоглогч бол төр улс юм. Улс гүрнүүд эрчим хүчний корпораци, үндэстэн дамнасан байгууллага, чөлөөт зах зээлийн механизмаар дамжуулан эрчим хүчний нөөцийг хянаж байдаг. Судлаач Антонио Маркина, Б.Шэффер нар төрийн мэдлийн эрчим хүчнийкомпаниуд нь дэлхийн газрын тосны нөөцийн 85%, байгалийн хийн 70-80%-ийг тус тус хянаж байдаг гэж нотолсон байна [3]. Эрчим хүч экспортлогч улс орнууд эрчим хүчний нөөцөд хяналт тавих дамжуулан байр сууриа бэхжүүлэх, дэлхийн эрчим хүчний зах зээл дээр тоглолт хийхийг эрмэлздэг [4]. Үүний тулд эрчим хүчний салбарыг стратегийн салбар хэмээн тооцож, төрийн мэдэлд авч, гадаад бодлогын хэрэгсэл болгохыг зорих нь олонтаа.

Олон улсын эрчим хүчний улс төр судлалаар дагнасан америкийн судлаач Майкл Кларын үзэж буйгаар газрын тос бол үндэсний улс төрийн бодлогын гол арга хэрэгсэл юм. Түүний зохиомжоор бүтээсэн “Цус ба газрын тос” кинонд эрчим хүчний өөр бусад эх сурвалжийг ашиглах явдал ойрын 100 жилд бололцоогүй бөгөөд Ойрхи дорнодод Америкийн явуулсан цэргийн ажиллагаа чухамдаа нефтийн шалтгаантай

байсныг дэвшүүлсэн байна. Америкийн сүүлийн 60 гаран жилийн хугацаанд хэрэгжүүлсэн гадаад бодлого чухамдаа нефтээс үүдэлтэй агаад орчин үеийн улс төр-цэргийн хийгээд эрчим хүчний бодлого харилцан хамааралтай явагдаж иржээ. Тэрээр ойрын ирээдүйн “гео-эрчим хүчний эрин”(Geo-energy era)-д эрчим хүчний нөөц баялаг ихтэй болон стратегийн учир холбогдолтой Хойд мөсөн далай, Каспийн тэнгис, Өмнөд хятадын тэнгис, Ормузын хоолой зэрэг бүс нутаг мөргөлдөөний эмзэг талбарболно гэж таамагласан байна.

Асуудлыг хүчээр шийдвэрлэх нь зүй ёсных бөгөөд аль хүч чадалтай нь дэлхийн эрчим хүчний бодлогод зонхилох үүрэг гүйцэтгэж, улмаар эрчим хүчний сонирхлоос шалтгаалж мөргөлдөөн зөрчил үүсэх хандлагыг баримталдаг нь реалистуудын нийтлэг онцлог юм. Гэвч дэлхийн эрчим хүчний улс төрийн бодлогод реалист хандлагаар дүн шинжилгээ хийх явдлыг учир дутагдалтай хэмээн шүүмжилсэн байр суурь ч бий.

Олон улсын эрчим хүчний бодлогын талаар реалист парадигм нь төр улс хийгээд улс үндэсний хоорондын өрсөлдөөнд хэтэрхий анхаарал хандуулж, төдий хэмжээгээр үндэстэн дамнасан тоглогч (жишээ нь, эрчим хүч, уул уурхайн компаниуд) болон орон нутгийн тоглогчдын (уул уурхайн үйл ажиллагаанд хяналт тавихыг эрмэлзэх, нөлөөлөх сонирхол бүхий орон нутгийн шинжтэй бүлэглэл болон угсаатны бүлэг) үүрэг ролийг багаар үнэлдэг. Улмаар үндэстэн дамнасан болон үндэсний, орон нутгийн чанартай тоглогчдын хоорондын нарийн төвөгтэй харилцан үйлдлийг орхигдуулан, олон улсын харилцааны бодит үр дагаврыг тооцоход алдаа гаргадаг байна.

Сонгодог реалист онолчид нөөц баялаг хязгаарлагдмалаас шалтгаалан улс үндэсний хооронд зөрчил мөргөлдөөн гарцаагүй гэж тооцдог. Энэ нь хомсдолыг технологийн дэвшлээр зохицуулах, өөр бусад нөөцийн хэлбэрийг нээж ашиглах замаар шийдвэрлэх үйл явцыг харгалздаггүй талтай. Тэрчлэн зөрчил мөргөлдөөнийг саармагжуулах, зохицуулахад нийтлэг үнэт зүйл, зарчим, олон улсын гэрээ хэлэлцээр, олон улсын болон бүс нутгийн байгууллагууд, дэлхийн зах зээлийн үүрэг ролийг авч үздэггүй байна. Орчин үед улс орнууд аль болох дайн сөргөлдөөнөөс зайлсхийх эрмэлзэлтэй болсон. Мөргөлдөөн гарцаагүй, гадны халдлага гарах нь зайлшгүй байлаа ч “аюулгүй байдлын дилемма” тооцоогоор аль аль талдаа гарах сөрөг үр дагаврыг урьдчилан тооцоод талууд хурц зөрчлөөс урьдаас цуцлагдах нь тодорхой юм.

Олон улсын эрчим хүчний харилцааг зохицуулах либерал-идеалист хандлага

Дэлхийн эрчим хүчний салбар дахь олон улсын оролцоог нээлттэй, хамтын зарчим бүхий зохицуулалт, менежментийг төлөвшүүлэн хөгжүүлэх нь либерал парадигмын үндсэн зарчим гэж болно. Үүний тулд нэн тэргүүнд бугшмал асуудлыг нээж, илрүүлэх замаар олон улсын харилцаан дахь эрчим хүчний улс төрийн үйл явц, эдийн засгийн гажуудал, тогтсон либерал бус практикийг тайлбарласан онол, үзэл баримтлалыг судлах хэрэгцээ аяндаа үүсдэг байна.

Нөөц баялаг ихтэй хөгжиж буй орнууд чухам энэхүү хүчин зүйлийнхээ улмаас ерөнхий хөгжлийн үзүүлэлт хурдац нь буурахад хүрдгийг “баялгийн хараал” гэх ойлголтын хүрээнд авч үзсэн байх нь нийтлэг. Африкийн бүс нутагт газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлээр тэргүүлэгч орнууд улс төрийн хувьд хамгийн тогтворгүйд тооцогддог. Хэдийгээр олборлох нөөц баялгийн ирээдүй сайн байсан ч их хэмжээний газрын тос, ашигт малтмалын нөөц нь эдийн засгийн сул хөгжил, дарангуйллын дэглэм тогтох магадлал, түүнчлэн зарим тохиолдолд зэвсэгт мөргөлдөөнд хүргэдэг[5]. Эрчим хүчний нөөц арвинтай ч эмзэг, сул дорой засаглалтай Төв ази, Африкийн орнууд нь хөрш улсуудтайгаа байнгын зөрчил маргаан тасардаггүй, улс төр, пашны хэт үзэлд автагдсан байдал бүс нутагт төдийгүй дэлхий дахинд бэрхшээл учруулахад хүргэдэг. Эдгээр орнууд стратегийн нөөцийн эзэд, олон улсын хүчирхэг тоглогчид байдаг хэдий ч авторитар засаглалтай, Өрнөдийн эсрэг хөдөлгөөн,

ревизионист хандлага өргөн хүрээтэй, нийгмийн “сэтгэл ханамжгүй байдал” зонхилсон байдаг. Өөрөөр хэлбэл, байгалийн баялаг ба олон улсын терроризмын аюул занал, лалын суурь үзлийн хооронд тодорхой хамаарал шалтгаантай юм [6].

Нөөц баялагтай орнуудын нэг том бэрхшээл бол ашиг малтмалаас бусад эдийн засгийн салбарууд нь хөгжих чадваргүй болдог үзэгдэл юм. Ашигт малтмал, нүүрс устөрөгчийн нөөцийн орлогын дотогш урсгал валютын бодит ханшийг чангаруулж, дотооддоо бүтээгдэхүүн үйлдвэрлэснээс гадаадаас импортоор авах нь хямд болгосны улмаас олборлох үйл ажиллагаанд эдийн засагхэт төвлөрдөг үйл явцыг “голланд өвчин” гэж нэрлэдэг. Тэрчлэн үнэ ханшийн ороо бусгаа байдал нь бараа, түүхий эдийн үнийн хэлбэлзэлтэй нягт уялдуулан төсвөө боловсруулдаг орнуудын хувьд томоохон сорилт болдог бөгөөд тэдний төсвийн орлого унасны улмаасмаш хүнд байдалд ороход хүргэдэг ажээ.

Аливаа орны нөөц баялгаар баян байдал нь эдийн засгийг гажуудуулж, улмаар нөөц баялгийн ашиглалт үр ашиг багатай болж, хөрөнгө оруулалт бууран, өсөлтийн чиг хандлага алдагдахад (ялангуяа, үйлдвэрлэл болон бусад худалдааны бараа, бүтээгдэхүүний салбарт) хүргэж улмаар авилгал, хэт чангарсан валютын ханш, гадаад зээлийн хэтрэлт, тогтвортой бус өндөр цалин хөлс, засгийн газрын үрэлгэн зарцуулалт зэрэг хэлбэрээр газар авч болно [7]. Эдгээр улс орнуудад иргэний нийгэм сул хөгжсөн, гүйцэтгэх эрх мэдлийг үндсэн хуулийн хязгаарласан ардчилсан хөгжлийн загварыг хориглодог, төрийн залхаан цээрлүүлэх үйлдэлд ач холбогдол өгдөг зэрэг шинж чанар ажиглагддаг.

Судлаач Томас Фридманы “Газрын тосны улс төрийн нэгдүгээр хууль” (First law of petropolitics) гэх ойлголтоор газрын тосны үнэ хэдий чинээ өсөх тусам үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, шударга сонгууль, бие даасан шүүх, хууль ёсыг дээдлэх, улс төрийн намын бие даасан байдал төдий хэрээр уруудан доройтдог. Өөрөөр хэлбэл, газрын тосны баялаг ба либерал бус хандлага харилцан хамааралтай болохыг нотлохыг эрмэлзсэн. Дэлхийн банкнаас 2007 онд явуулсан газрын тосны салбар дахь авилгын судалгаанд эрчим хүчний нөөц ихтэй улс орнуудыг нөөц хомс орнуудтай харьцуулахад хүний хөгжлийн үзүүлэлт доогуур, нийгэм улс төрийн эмх замбараагүй байдал хийгээд зэвсэгт мөргөлдөөний түвшин нилээн өндөр гарсан байна. Газрын тос нь авилгыг татах соронз болж, төрийн удирдлагын чанарт авилга бугших үндэс болдог байна. Өөрөөр хэлбэл, газрын тосны нөөц, түүнээс олсон орлого авилгатай нягт холбогддог [8].

Байгалийн нөөц баялгийн сүүдэр, нөөцийн нийлүүлэлтийн хөшигний арын тоглолт, газрын тос, байгалийн хийтэй холбоотой “бохир улс төр”, импортлогч, экспортлогч нарын далд тохиролцоо, “онцгой харилцаа, хэлхээ холбоо”-ны бодит үйл явдал, баримтын талаар судлаач, сэтгүүлчид олон нийтлэл өгүүллээ зориулсан байдаг. “Олон Улсын Хямралын Групп”-ээс боловсруулсан эрчим хүчний аюулгүй байдлын хөтөлбөрт “Латин америкаас Кавказ хүртэл, Африкаас Ойрх Дорнод хүртэл бүхий л бүс нутагт эрчим хүчний асуудал нь иргэний төдийгүй улс хоорондын мөргөлдөөн зөрчлийн үндсэн шалтгаан болж байна” гэж дүгнэсэн байна. Өрнөдийн гүрнүүд нүүрэн дээрээ тухайн тогтолцоо, эрх баригчдын үйлдлийг буруушаах хэрнээ далдуур сүлбэлдсэн “хэлхээ холбоо”, сүүдэртэй харилцаагаа либерал интернационализмын үйл явц мэтээр тайлбарладаг.

Эдийн засгийн шинэ сонгодог онолчид болон судлаачид, олон улсын санхүүгийн байгууллага, бусад төрийн бус байгууллагуудаас нөөц баялгийг тойрсон дэлхий дахинд тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд дараах либерал хандлагыг төлөвшүүлэх шаардлагатай аж.

Нөөц баялгийн ашиглалтын тунгалаг, ил тод байдлыг хөгжүүлэх. Байгалийн баялгийн орлогыг ил тод, хариуцлагатайгаар удирдах нь газрын тос, байгалийн хий, эрдэс баялаг үйлдвэрлэгч орнуудын хөгжил, тогтвортой байдлын авчирна. Олон нийтийн мэдээлэл авах эрхийг хэдий чинээ сайн хангана, засаглалын үнэлгээ, эдийн

засгийн өсөлт нь төдий чинээ өндөр байдаг байна. Түүнчлэн, улс орон ил тод байх тусам зээлжих зэрэглэл өндөртэй, төсвийн сахилга бат сайтай, авлига багатай байдгийг судалгаа харуулж байна. Цаашилбал, ил тод байдал багатай орнууд ил тод байдал сайтай орнуудыг бодвол нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) болон гадаадын шууд хөрөнгө оруулалт нь бага, капиталын зардал өндөртэй байдаг байна. Улс төрийн амьдралд оролцох оролцоог хангах суурь нөхцөл болох мэдээллийг нээлттэй ил тод байдал нь либерализмын үндсэн зарчим юм. Тухайлбал, “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага”, “Төлснөө нийтэл” дэлхий нийтийн иргэний нийгмийн хөдөлгөөн, “Нөөц баялгийн орлогын ил тод байдлын тухай ОУВС-гийн удирдамж”, “Байгалийн нөөцийн тунхаглал” болон НҮБ, Дэлхийн Банк, Африкийн эвлэл зэрэг байгууллагууд эрчим хүч, уул уурхайн компаниудын төлбөр болон төрийн орлогыг ил тод болгох чиглэлээр шинэ хөтөлбөрүүдийг санаачлан ажиллаж байна.

Зөрчил мөргөлдөөнийг хурцатгахад нөлөөлж буй хууль бус худалдаа, нөхцөл байдлыг хязгаарласан олон улсын зохицуулалт хийх. Тухайлбал, Африкт зөрчил мөргөлдөөн, хүчирхийллийн нэг шалтгаан болсон алмазын далд худалдааг хязгаарлах зорилготой, алзамын албан ёсны бүртгэлжүүлэлтийг зохицуулахад чиглэсэн “Кимберлийн үйл явц” (Kimberley Process)-ыг хэлж болно.

Корпорацийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх. Нийгэмд болон хүрээлэн буй орчинд үзүүлсэн нөлөөллийнхөө төлөө компаниуд хариуцлага хүлээх, хууль дүрмийг мөрдөх шаардлагатай гэсэн үг. Зөвхөн өөрсдийн төлөө хариуцлага хүлээх төдийгүй хамтран ажиллаж буй этгээдийн үйлдлийн өмнөөс хариуцлага хүлээх чадвартай байх хэрэгтэй. Олон улсын эрчим хүчний болон уул уурхайн компаниуд нь хүрээлэн буй орчинд үзүүлсэн нөлөөллөөс болж олон улсын хамтын нийгэмлэгийн шахалт орсон, мөргөлдөөн, тогтворгүй байдал газар авсан бүс нутагт байнга ажиллаж, үндэсний засгийн газар болон орон нутгийн нийтлэгтэй мөргөлдсөний улмаас тухайн нутаг оронд хүний эрх байнга зөрчигдөхөд хүрсний уршгаар, ашигт малтмалын олборлолтоос олохоор тооцсон ашгаа алдах нь олшрох болжээ. Олон улсын төдийгүй үндэсний нефтийн компаниуд корпоратив үйл ажиллагааны кодекс болон нийгмийн тайлагналыг хэрэгжүүлэх болсон байна. Тухайлбал, Энэтхэгийн газрын тосны Петробэс, Кувейтийн Петролеум зэрэг компаниуд хүрээлэн буй орчин, хүний эрх, хөдөлмөрийн аюулгүй байдал, авилгатай тэмцэх зэрэг нийгмийн хариуцлагын 10 зарчмаас бүрдсэн НҮБ-ын “Даян дэлхийн гэрээ”-нд санаачлагаараа нэгдэн орсон байна.

Сайн засаглал. Легетим чанартай, сайн засаглалыг зарчмыг хэрэгжүүлж чаддаггүй бол компаний нийгмийн хариуцлага, ил тод үйл ажиллагааг хөгжүүлэхийг дэмжсэн олон улсын бүхий л хүчин чармайлт, дэмжлэг ямар ч хэрэггүй зүйл болж хувирна. Сайн засаглалыг дэмжих бодлогын зөвлөмж нь хэт хийсвэр буюу идеалист шинжтэй байх магадлалтай. Нилээн бодиттой, практик саналууд ч бий. Жишээ нь: түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзлийг зохицуулахын тулд тогтвортой байдлыг сан байгуулах замаар нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг сайжруулж болох тухай зөвлөмж ч бий.

Олон улсын болон бүс нутгийн эрчим хүчний институци, тогтолцоог дэмжих. “Олон улсын эрчим хүчний агентлаг”, “Эрчим хүчний харти” зэрэг нь олон улсын эрчим хүчний либерал дэглэмийг өргөтгөн хөгжүүлж, олон улсын хамтын ажиллагааг сайжруулах юм. Бүс нутгийн эрчим хүчний хамтын ажиллагааны байгууллагууд бий болгох нь дутуугүй ач холбогдолтой. Тухайлбал, эрчим хүчний төлөөх өрсөлдөөнийг биш харилцан ашигтай харилцааг дэмжихэд чиглэсэн Орос, Хятад, Япон зэрэг томоохон улсуудыг багтаасан Зүүн Хойд Ази, Өмнөд Азийн эрчим хүчний институци байгуулах бололцоо бий. Эрчим хүчний зах зээлийг либералчлах, эрчим хүчний аюулгүй байдлын асуудлыг хамтын хүчин чармайлтаар шийдвэрлэхэд Европын холбоо зэрэг байгууллагын оролцоо маш чухал юм.

Эдийн засгийг либералчлах. Олон улсын эрчим хүчний харилцаа либералчлагдан, эрчим хүч, эрдсийн салбарыг либерал зарчимд суурилсан зөв гольдролоор төлөвшүүлбэл нийгэм эдийн засгийн хувьд үр нөлөөтэй арга зам болох төдийгүй түүнээс үүдсэн дайн мөргөлдөөн, геополитикийн өрсөлдөөн шаардлагагүй болох юм. Андреас Голдтау, Ян Мартин Витте нар “Даян дэлхийн эрчим хүчний удирдлага: Тоглоомын шинэ дүрэм” бүтээлд эрчим хүчний аюулгүй байдлын явцуу төлөв хандлагаас институци, дүрэм журмыг удирдлага болгосон эрчим хүчний нийтлэг засаглал руу шилжих шаардлагатайг авч үзсэн. Өөрөөр хэлбэл, даян дэлхийн эрчим хүчний үр нөлөөтэй удирдлагыг бий болгох замаар нөөцийг зохистой хуваарилах бодлогыг төлөвшүүлэх бололцоо бүхий тоглоомын шинэ дүрмийг санал болгосон байна [9].

Радикал парадигм дахь улс гүрнүүдийн эрчим хүчний нөөцийн харилцааны талаарх үзэл санаа

И.Валлерстайн, А.Франк зэрэг неомарксизмын төлөөлөгчид улс төр, эдийн засаг, нийгэм, үзэл суртал, соёлын олон талт глобал тогтолцоогоор олон улсын харилцааг тайлбарласан байдаг. Олон улсын харилцаа гэдгийг “дэлхий тогтолцоо”, “дэлхий-эдийн засаг” гэсэн ойлголтоор тэмдэглэсэн байдаг. “Дэлхий тогтолцоо”-ны онолыг санаачлагч, Америкийн социологич И.Валлерстайны тодорхойлсноор “дэлхий тогтолцоо” гэдэг нь 3 ертөнцөөс бүрдэнэ. Нэг дэх нь цөм буюу хөгжингүй улсууд ялангуяа өрнөдийн капиталист орнууд багтана. Хоёрдугаар эгнээнд завсрын зах хязгаар буюу дундаж хөгжилтэй, хуучнаар социалист лагерын орнууд орно. Харин зах хязгаарт хөгжил сул дорой хөгжилтэй гуравдагч ертөнцийн улс орнууд багтах юм. Дэлхий тогтолцооноос хараат байдал нь явцдаа төвийн эсрэг босох байсан сул дорой хөгжилтэй орнуудыг улам бүр төвд мөлжигдөх нөхцөл рүү түлхэх юм. Дэлхий дахины түүхэн тэгш бус, хараат байдал ирээдүйд ч улс хоорондын харилцаанд хадгалагдсан хэвээр байх магадлалтай ажээ. Хөгжиж буй орнууд дахь “хоёрдмол эдийн засаг” гэх ойлголтоор бол эдийн засгийн амьдралын эрт балрын хэлбэртэй зэрэгцэн төв буюу “цөм” улс гүрнүүдэд бүтээгдэхүүн экспортлоход чиглэсэн харьцангуй шинэлэг секторууд хөгжиж байдаг.

Дээрх үзэл баримтлалтай “Хараат хөгжлийн онол”-ын үзэл санаа давхцдаг. Уг онолын төлөөлөгчид болох Р.Пребиша, С.Фуртадо, А. Пинто, америкийн марксист онолчид П.Барана, П.Суизи, альтернатив таксономийн төлөөлөгч А. Г.Франка, Ф.Кардозо, Э.Фалетто нарын нотолж буйгаар хөгжил сул орнуудын улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хоцрогдол нь хөгжингүй улс гүрнүүдийн системтэй дарамт шахалт, дэлхийн эдийн засагт интеграцид нэгтгэсний үр дагавар аж. Энэхүү зах хязгаарын орнуудын ядуурал, доройтол нь дараах шалтгаантай. Үүнд: 1. өөрийн байгалийн нөөц, хямд ажиллах хүч нь иргэдийнхээ амьдралын түвшнийг өсгөх нөхцлийг хангаж хүч хүрдэггүй, 2. хөгжингүй улс гүрнүүдийн зүгээс үзүүлж буй эдийн засгийн нөлөөлөл (банк, санхүү), ОНМХ-д хяналт тавих, улс төрийн шууд оролцоо, 3. эдийн засгийн хориг, цэргийн хүчээр хараат байдлаас чөлөөлөгдөх оролдлогыг таслан зогсоохыг эрмэлздгээс үүдэлтэй [10].

Ойрхи дорнод болон Латин америкийн эдийн засаг цөөн хэдэн экспортын бүтээгдэхүүн, нэн тэргүүнд газрын тосноос хараат байх нь түгээмэл. Өндөр чанарын бэлэн бүтээгдэхүүн гаргахад зориулсан түүхий эдийн нийлүүлэлтийн улмаас тэрхүү орнуудын эдийг засаг яах аргагүй “Төв”-өөс хамааралтай болгодог. Улмаар үндэсний эдийн засгийн хөгжил удааширдаг байна. Орон нутгийн ноёлогч анги хийгээд “цөм” хоорондох нягт харилцааны улс төрийн учир шалтгаанаас үүдэн олон нутгийн хүн амаас элит хэсэг нь холдон тусгаарлагдаж эхэлдэг. Энэ нь империализмын эсрэг үндсэрхэг хөдөлгөөнүүд, уугуул нутгийн тулгуур үзэл бүхий босогчид ба энэхүү үндэсний хараат бус байх оролдлогыг нухчин дарах сонирхолтой өрнөдийн орнууд, ҮДК-иудын хооронд үл дуусах тэмцэл мөргөлдөөн лүү түлхдэг байна. Эцэст нь өрнөдийн санхүүжилт, дэмжлэгт тулгуурласан цэрэг аюулгүй байдлын бүтэц тогтолцоо

төв ба зах хязгаарын энэхүү хамааралт байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн ажиллагааг байнга хэрэгжүүлж эхэлдэг ажээ. Ялангуяа Ойрхи Дорнод, Латин америкт тодорхой нөлөөтэй байсан ЗХУ 1990-ээд оноос бүрэн задарснаар тухайн бүс нутагт АНУ дангаар ноёрхогч болсон юм.

1960-1970-аад оны үед дэлхий дахинаа газрын тос, олборлох үйлдвэрлэлийг тойрсон асуудлаас үүдэн үндсэрхэг бодлого, нөөц баялгийн национализм газар авч, ОПЕК болон эрдэс баялгийн бусад картелиуд хүчээ авсантай холбоотойгоор “Олон улсын эдийн засгийн шинэ дэг журам” (New International Economic Order), “Брандтын тайлан” (Brandt Report) зэрэг судалгаа дүгнэлт хэрэгжүүлдэг институциуд шинэ тутам байгуулагдаж эхэлжээ. “Олон улсын эдийн засгийн шинэ дэг журам” нь хөгжингүй орнуудын зээлийн нөхцөлийг хөнгөлөх, буурай хөгжилтэй орнуудтай хийх худалдааны нөхцөлийг өөрчлөх замаар буурай хөгжилтэй орнуудын төлөв байдлыг сайжруулах санал зөвлөмжийг боловсруулах зорилготой санаачлага юм. Анх 1974 онд НҮБ-аас үүсгэн санаачилсан. “Брандтын тайлан” нь дэлхийн хөгжлийн асуудал болон ялангуяа Умард, Өмнөдийн онцлог ялгаа, эдийн засгийн хамтын ажиллагааны боломж нөхцөлийн талаар дүгнэлт тайлан гаргадаг бие даасан комисс юм.

21-р зууны эхээр олон улсын үйл явц марксист буюу социалист радикал хандлага бус капиталист авторитар төрийн тогтолцоог хамгаалах хандлага руу орох болсон. Дэлхийн газрын тос, эрдэс баялгийн компаниуд ажиллаж буй улс орныхоо үндэсний хөгжлийн зорилго зорилтоос илүүтэй “Төв”-ийн (компаний улсын харъяалал болон тэдгээрийн хөрөнгө оруулалтаас хамаарч) ашиг сонирхлыг түлхүү харгалзаж иржээ. 1990-ээд онд Орост газрын тос, хийн үйлдвэрүүдийг хувьчлах ажиллагаа өрнөж, засгийн эрхэнд Өрнөдийн дэмжлэгтэй либерал олигархиуд гарч ирснээр төрийн нэр хүнд, бүс нутаг, олон улсын бодлогод орос улсын эзэлж ирсэн уламжлалт томоохон байр суурь сулрахад нөлөөлсөн байна. Үүнээс шалтгаалан төрийн засаглалыг бэхжүүлэх, шинэчлэх тухай үндэсний үзэл санаа оросын нийгэмд эргэн сэргэж эхэлжээ. Мөн Хятадын эрчим хүч болон бусад ажил үйлдвэрийн чиглэлээр Өрнөдийн орнуудад хөрөнгө оруулалт хийх сонирхлыг хязгаарлах зэргээр Өрнөдийн улс төр, эдийн засгийн ноёрхлоо хэвээр хадгалахыг эрмэлзсээр байна[11].

Бүхэлдээ “Төв”-ийн улс гүрнүүдээс өмнөдийн хөгжиж буй орнуудтай харилцах харилцаандаа давуу талаа хадгалахын тулд империалист хандлага, колонийн нөхцөл, улс төр, эдийн засгийн бодлого арга хэрэгслээ ашигласан хэвээрээ байна. Нөгөө талаас олон улсын харилцаан дахь өрнөдийн эсрэг радикал байр суурь эрчим хүчний нөөц баялагтай орнуудын бие даасан, хараат бус байдлыг эрмэлзсэн нийгмийн бүлгүүдийн хүчтэй үзэл суртал болон газар авч байна.

Америкийн улс төр судлаач Майкл Росс 113 орны 1971-1997 оны хоорондох хийсэн статистик судалгаанд үндэслэн газрын тос, ашигт малтмалын экспортод тулгуурласан эдийн засаг тухайн орнуудын ардчилах үйл явцад саад учруулдаг бөгөөд ийм нөлөөлөл бусад төрлийн бүтээгдэхүүний экспортын хувьд ажиглагддаггүй болохыг илрүүлжээ. Уг үзэгдэл Арабын хойг, Ойрхи дорнод төдийгүй Африк, өмнөд Сахар жижиг орнуудад түгээмэл байдаг аж. Үүний учир шалтгааныг ардчилах үйл явцад газрын тос, байгалийн баялгаас олж буй орлогын сөрөг нөлөөлөлтэй холбож тайлбарлажээ. Эрчим хүчний баялагтай орнуудад ажиллаж буй компаниуд олборлолтын болон дамжуулах хоолойн үйл ажиллагаагаа хамгаалах хууль ёсны эрх ашигтай байхын хажуугаар тус салбар эдгээр орнууд дахь хүний эрхийн тухай ойлголт муутай зэвсэгт хүчнийхэнтэй хамтран ажиллах нь олонтаа. Олон тохиолдолд компаниуд ба засгийн газар, аюулгүйн хүчнийхний хооронд гэрээний зохицуулалтаар дамжуулан ойр дотно харилцаа тогтоодгоос болж нилээд олон газрын тосны компаниуд хүний эрх зөрчигчдийн үйл ажиллагаанд холбогддог.

Эрдэс баялгийн харилцаанаас үүдэлтэй хэд хэдэн сөрөг үзэгдэл бий болдог. Үүнд, “татварын нөлөө”, “төрийн зарлагын нөлөө”, “социал бүлгийн эффект”, “залхаан

цээрлүүлэлтийн нөлөө”, “модернизацийн эсрэг нөлөө” зэрэг улс орны тогтвортой хөгжилд сөрөг үр дагавартай үйл явцыг авч үзсэн байна. Ийнхүү газрын тос, нөөц баялгийн салбарын эзэрхэл нь хөгжлийн хэвийн явцыг гуйвуулж, нийгэм улс төрийн харилцаанд хүчтэй нөлөө үзүүлдэг [12].

Радикал үзэл хандлага нь эрчим хүч, ашигт малтмалын салбарын бодлогын орчин үеийн нөлөөлөл, төлөв байдлыг улс төр, эдийн засгийн газарзүйн үүднээс авч үзсэнээс гадна постструктурализм, Фукогийн анализ, шүүмжлэлийн онол, үйл ажиллагаа-сүлжээний онол (action-network theory), үйлдвэрлэлийн глобал сүлжээний дүн шинжилгээ (global production network – үндэсний хил хязгаараас хальсан харилцан хамаарал бүхий үйлдвэрлэл, аж ахуйн глобал зохион байгуулалтын хэлбэр, дэлхийн хэмжээнд бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хуваарилахад зорилго бүхий арилжааны болон арилжааны бус институцийн харилцан үйлдлийн тогтолцоо) зэрэг янз бүрийн онол, арга зүйг ашиглан дүн шинжилгээ хийсэн нь бий [13]. Эдгээр арга хандлага нь өргөн утгаараа “радикал” хандлагын хүрээнд багтдаг ч “дэлхий тогтолцоо” болон харилцан хамаарлын талаарх уламжлалт үзэл баримтлалаас ялгаатай санаа оноог дэвшүүлсэн байдаг. Мөн дэлхийн эрчим хүчний салбар дахь зөрчил мөргөлдөөний уг сурвалжийг либерал хандлагатай адилаар “баялгийн хараал”, “баялгийн хараат байдал” гэх хандлагын хүрээнд тайлбарлах нь бий. Гэхдээ нөөц баялгийн мөргөлдөөн зөрчлийн бүхий л шалтгааныг “нөөц баялгийн хараат байдал” гэх ойлголтын хүрээнд авч үзэх нь явцуу хэрэг болохыг шүүмжилдэг.

ДҮГНЭЛТ

Эрчим хүч нь дэлхий дахины тогтвортой байдал, харилцан хамтын ажиллагаа, геополитикийн нөхцөл байдал хийгээд мөргөлдөөн тэмцлийн чухал нэг учир шалтгаан болох болжээ. Дээрх онолын үзэл хандлагууд нь дэлхийн эрчим хүчний тулгамдсан асуудлыг ойлгох, өнөөгийн нөхцөл байдлыг тайлбарлан тодорхойлох, цаашдын хэтийн төлөвийг таамаглахад чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн дэлхийн эрчим хүч тойрсон асуудлыг эдгээр онолуудын зааг дээр нэгтгэн дүгнэж авч үзэх боломжтой эсэх асуудал ч дэвшигддэг. Гэхдээ онолын нэгдмэл хандлага, цогц концепци боловсруулах нь амаргүй бөгөөд тийнхүү нийлэгжүүлэх зайлшгүй учир шалтгаан өнөөгийн байдлаар алга байна. Энэ нь ирээдүйд тийм нэгдмэл онол хандлага гарахыг үгүйсгэсэн хэрэг биш юм.

Олон улсын харилцааны суурь онол парадигмууд нь эрчим хүч, түүнээс шалтгаалсан олон улсын төдийгүй орон нутгийн шинжтэй зөрчил мөргөлдөөн, хамтын ажиллагааны нөхцөл байдал, хөгжлийн төлөв хандлагыг янз бүрийн хувьсагч хэмжигдэхүүнийг ашиглан өөр өөрийн онцлог үзэл хандлагаар тайлбарлан авч үзэж иржээ.

Реалист онол нь геополитикийн хуваарилалтын онцлог, нөөц баялгийн газарзүйн байршил, түүний үнэлэмж, үнэ өртөг зэргийг нэн тэргүүнд авч үздэг бөгөөд төр засаг ба компанийн хоорондын харилцаа, төр улсын хүч чадавхид бага анхаарал хандуулдаг. Харин завсрын хувьсагчийн үүднээс тодорхойлбол бүс нутгийн болон олон улсын байгууллага зэрэг хувьсамтгай хүч нөлөө бүхий тоглогчдоос илүү бүтэц тогтолцоонд ач холбогдол өгдөг байна. Харин хамаарагч хувьсагч хэмжигдэхүүнээр бол ерөнхийдөө бүс нутгийн болон глобал геостратегийн зөрчил сөргөлдөөн, түүнээс үүдсэн улс үндэсний хоорондын мөргөлдөөнд анхаарал төвлөрүүлдэг хэдий ч орон нутгийн түвшний эдийн засаг, худалдаа арилжааны зөрчил хийгээд мөргөлдөөнийг шийдвэрлэх хамтын хүчин чармайлтыг харгалзан үздэггүй талтай.

Идеалист онол нь реалист хандлагын эсрэг үзэл баримтлалыг дэвшүүлдэг. Өөрөөр хэлбэл, бүс нутгийн ба олон улсын байгууллагуудын жин нөлөө, үүрэг роль хийгээд захиргааны болон зах зээлийн арга хэмжээ, хууль эрх зүйн хэм хэмжээ, ил тод

байдал зэрэг завсрын хувьсагчаар тодорхойлогдсон хувьсамтгай нөөц бололцоонд нилээн ач холбогдол өгдөг. Үл хамааралт хувьсагчийн ойлголтоор төр ба компаний харилцаа, төрийн хүч нөлөөнд багагүй учир холбогдол өгч харин нөөц баялгийн газар зүйн байршил, хүчний геополитикийн хуваарилалт, нөөцийн үнэлэмж, үнэ өртгийн асуудлыг 2-рт тавьдаг. Хамааралт хувьсагчийн үүднээс авч үзвэл, глобал болон бүс нутгийн түвшний улс үндэсний хоорондын зөрчил мөргөлдөөнөөс илүү дотоодын буюу орон нутгийн шинжтэй нөхцөл байдал (баялгийн хараал гэх мэт)-аас үүдэлтэй зөрчилдөөн, түүнийг шийдвэрлэх хамтын ажиллагааны бололцоог чухалд тооцдог юм.

Радикал үзэл хандлага нь өргөн утгаараа реалист онолтой нилээн ойролцоо гэж дүгнэж болно. Тухайлбал, субъектэд биш бүтэц тогтолцоонд илүү анхаарч, хүчний геополитикийн хуваарилалт, нөөцийн газар зүйн байршилд ач холбогдол өгөхийн зэрэгцээ бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагааны хэтийн төлөвийг судлан шинжилдгээрээ реализмтай адил юм. Гэхдээ төрийн дэглэм ба орон нутгийн фирмийн хэлхээ холбоог чухалчилж, бүхий л түвшний зөрчил мөргөлдөөнийг судлан тодорхойлохыг хичээдэг.

Идеалист парадигм нь эрчим хүчний нөөцийг улс төр, эдийн засгийн сонирхлоор нөхцөлдсөн төр хэмээх тоглогчийн үүрэг ролийг хязгаарлаж тооцохын зэрэгцээ тухай эрчим хүчний нөөцийг стратегийн учир холбогдолтой гэх хандлагыг бууруулж үнэлдэг. Харин реалист хандлагын үүднээс эрчим хүчний нөөц бол аливаа төр улсын хувьд нөлөөллөө өргөжүүлэх зорилготой гадаад бодлогын чухал бүрдэл хэсэг юм. Иймээс хэдий чинээ нөөц баялаг арвинтай байна төдий хэрээр улс орон хүчирхэг байна гэж тооцдог. Эрчим хүч нь улс орны эрх ашгаа хангах, хамгаалах, хүч нөлөөгөө тэлэх чухал нөөц юм. Уг онолын бусад урсгал чиглэл нь улс орны бодлогод эзлэх эрчим хүчний нөөцийн үүрэг ролийг өргөжүүлэх асуудалд дүн шинжилгээ хийхэд бүхэлдээ чиглэдэг. Өөрөөр хэлбэл, реалист онолоор бол эрчим хүчний нөөц нь үндэсний болон олон улсын аюулгүй байдлыг хангах “хатуу хүч” (hard power) гэж тооцогддог байхад идеалист буюу либерал хандлагаар “зөөлөн хүч” (soft power)-ний үүрэг гүйцэтгэдэг байна.

Дээрх суурь онол, үзэл хандлагын орчин үеийн урсгалууд болох неолиберал институционализм болон неореалист хандлага нь олон улсын тогтолцооны анархи байдлыг хүлээн зөвшөөрдөг ч Европын холбоо, Дэлхийн худалдааны байгууллага, Олон улсын эрчим хүчний агентлаг зэрэг олон улсын институциудаас олон улсын харилцаанд үзүүлэх үүрэг нөлөөнд ялгаатай ханддаг. Неореалистууд улс орнуудын үл итгэлцэл, айдас болгоомжлолоос үүдэлтэй эмх замбараагүй байдлыг зөвхөн төр улсуудын үйл ажиллагаагаар эрс хязгаарлаж болно гэж тооцдог бол неолиберал институционалист хандлагыг баримтлагчид олон улсын анархи эмх замбараагүй тогтолцооноос шалтгаалсан нөхцөл байдлыг зохицуулахад чиглэсэн хамтын ажиллагааг чухамдаа олон улсын институциудын хүчин чармайлтаар бүрдүүлэх бололцоотой гэж үздэг байна.

Ашигласан материал

- [1] *Giedrius Česnakas*, Energy resources in foreign policy: a theoretical approach //Cit.: Baltic Journal of Law & Politics 3:1 (2010): 30-52
- [2] *Peter Sutch and Juanita Elias*, International Relations: The Basics(New York: Routledge, 2007), p. 49.
- [3] *Antonio Marquina*, On the Deceit of Globalization, Energy Security and Challenges to European Foreign Policy Brenda Shaffer, supra note 12, p. 3.
- [4] *Gal Luft and Anne Korin*, “Realism and Idealism in the energy security debate”: 335; in: *Gal Luft and Anne Korin*, eds. Energy Security Callanges for the 21st Century. A Reference Handbook(United States of America: ABC-CLIO, 2009).
- [5] Орлогын ажиглагч индекс/Ил тод байдал: Засгийн газрууд ба газрын тос, байгалийн хий, уул уурхайн үйлдвэрлэл/ ННФ, УБ., 2011. х-10.
- [6] *Roland Dannreuther*,“International Relations Theories: Energy, Minerals and Conflict”. POLINARES working paper n. 8 September 2010.p. 4.
- [7] *Светлана Цалик, Аня Шиффрин*, Газрын тосны тухай бичихүй. ННФ, УБ., 2011. х-103.
- [8] Многоликая коррупция: Выявление уязвимых мест на уровне секторовэкономики и государственного управления / Под ред. Э. Кампоса и С. Прадхана; Пер. с англ. — М.: Альпина Пабlishерз, 2010. — 551 с.//Чарльз Макферсон и Стивен МаксиррейКоррупция в нефтяном секторе стр-247
- [9] *Andreas Goldthau and Jan Martin Witte* Global Energy Governance. The New Rules of the Game, Washington DC: Brookings Institution Press, 2010.
- [10] *Sanjaya Lall*, Is 'Dependence' a Useful Concept in Analysing Underdevelopment? World Development, 1975, Vol. 3, Nos. 11 & 12, pp. 799-810. Pergamon Press. Printed in Great Britain. pp. 799-810.
- [11] *Д.Мягмарсүрэн* Улс төрд нөөц баялгийн үзүүлэх нөлөөлөл //Политологи, 10 (388), 2013, МУИС Пресс. х. 147-155.
- [12] *Т.Фридман*,Первый закон петрополитики: Уровень демократии обратно пропорционален уровню цен на нефть.
<http://www.inosmi.ru/world/20060503/227213.html>
- [13] *Coe N. M., Hess M., Yeung H. W.-C., Dicken P., Henderson J.* ‘Globalizing’ regional development: a global production networks perspective// Transactions of the Institute of British Geographers, Vol. 29, No 4 (2004).p.471.

ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ЯВУУЛЖ БАЙГАА МОНГОЛД ЧИГЛЭСЭН ГАДААД БОДЛОГО

日本政府の対モンゴル外交」

IKEDA Sogo

Professor (Ph.D, Political Science)

Key words: Монгол-Японы харилцаа, Шинзо Абе, Либераль ардчилсан нам, “Абэномикс”, Стратегийн түншилэл

要旨

本研究発表は、「日本政府の対モンゴル外交」をテーマとして考察しています。昨年12月、自由民主党は総選挙において圧倒的な勝利を収め、安倍晋三内閣を発足させた。安倍政権は「日本の復活」を目指し「危機突破内閣」と命名し、まず日本経済を「アベノミクス」によって復活させ、世界平和の先導的役割を果たす「安倍外交」を展開しています。アベノミクスは、「①大胆な金融緩和、②機動的な財政政策、③民間投資を喚起する成長戦略」の三つの矢によって順調な軌道に乗りつつある。8月22日日本政府発表の第2四半期成長率は、年率換算2.6%に当たり、ウォール・ストリート・ジャーナルは「世界経済の牽引」になりえると評価しています。

ここでは、日本政府の外交政策について論じ、特に対モンゴル政策に焦点を当てて述べることにします。

Оршил

Өнгөрсөн жилийн 12 дугаар сард Японы Либерал Ардчилсан нам парламентийн дээд танхимын сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулж Шинзо Абэ-гийн толгойлсон засгийн газар байгуулагдсан.

Абэ-гийн Засгийн Газар нь “Японы дахин сэргэлт”-ийг зорилгоо болгож, өөрийн кабинетаа “хүндрэл бэрхшээлийг ялан дийлэгч засгийн газар байх болно” хэмээгээд, Японы эдийн засгийг “Абэномикс” бодлогын тусламжтайгаар сэргээн хөгжүүлж, дэлхий нийтийн энх тайвны тусын тулд тэргүүлэхүйц “Абэ-гийн гадаад бодлого”-ыг хэрэгжүүлж байна.

“Абэномикс” нь:

- 1) Эдийн засгийг сэргээх, санхүүгийн тааламжтай нөхцөл бүрдүүлэх;

- 2) Хүчирхэг, эрчимтэй эдийн засгийн бодлого явуулах;
- 3) Хувийн хэвшлийн үйлдвэрлэлд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, өсөлт хөгжлийг нь тууштай дэмжих гэсэн 3 тулгуурт бодлого юм.

Япон улсын эдийн засгийн өсөлт нь 2013 оны II улирлын байдлаар 2.6 хувьтай байна. Үүнийг “Уол стрит” сэтгүүл “*дэлхийн эдийн засгийг өөд татахуйц түвшиний үзүүлэлт*” гэж үнэлжээ.

Би өнөөдөр энд Япон улсын засгийн газраас явуулж буй гадаад бодлого, ялангуяа Монгол улсад чиглэсэн бодлогын талаар ярьяа.

Нэг. Ерөнхий сайд Абэ Монгол улсад айлчилсан нь

Ерөнхий сайд Абэ энэ оны 3 дугаар сард Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод айлчилал хийсэн. Уг айлчлалын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайд Алтанхуяг, Япон улсын Ерөнхий сайд Абэ нарын уулзалт хэлэлцээр хийсэн билээ.

Уг хэлэлцээрээр: Япон-Монголын стратегийн түншлэлийг улам эрчимтэй хөгжүүлэхийн тулд хоёр тал улстөр, эдийн засаг, гадаад харилцааны салбарт *идэвхитэй, нягт хамтарч* ажиллахаар санал нэгтэй тохиролцсон.

Ялангуяа, эдийн засгийн хамтын ажиллагааны салбарт Абэ ерөнхий сайд “Эрч” нэртэй санаачлагыг дэвшүүлж, түүндээ:

- Япон улсаас Монголд оруулж байгаа *хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах*,
- Эдийн засгийн *зогсолтгүй хөгжлийг хангах* гэсэн 2 том асуудлыг хөндөж тавьсан юм.

Үүний дотор Монгол улсын цаашдын хөгжилд нэн шаардлагатай техник-технологийн болон анагаах ухааны салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг Япон улсын сургуулиудад сургаж бэлтгэх, мэргэжил дээшлүүлэхээр тохиролцож төлөвлөсөн.

Энэхүү төлөвлөгөөний хүрээнд “*Монгол-Японы боловсролын эмнэлэг*” нэртэй хөтөлбөрөөр дээрх мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх юм.

Мөн Япон улсаас шилдэг технологи, ноу-хауг ашиглан, Улаанбаатар хотын ойролцоо дэлхийн жишигт нийцсэн, аюулгүй, итгэл хүлээхүйц онгоцны олон улсын шинэ буудал барьж өгөхөөр эцэслэн тохиролцсон билээ.

Үүний зэрэгцээ Ерөнхий сайд Абэ Ерөнхийлөгч Элбэгдоржид бараалхаж, улс төр, аюулгүй байдлын салбарт стратегийн түвшиндэхь хамтын ажиллагаагаа улам эрчимжүүлэхээ илэрхийлсэн. Тухайлбал, эдийн засгийн салбарт Японы компаниудаас оруулах хөрөнгө оруулалтыг эрчимжүүлж, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, нийгэм, соёлын салбарын харилцааг улам идэвхжүүлэхээр болсон.

Хоёр. Ерөнхий сайд Абэ хэвлэл мэдээллийн хэрэгслээр

монголын ард түмэнд дамжуулсан мэндчилгээ, Япон – Монголын харилцаа

Ерөнхий сайд Абэ Монголд хийх айлчлалынхаа өмнөх өдөр “Өдрийн сонин”, “Өнөөдөр сонин”, “Үндэсний шуудан”, “Зууны мэдээ” зэрэг өдөр тутмын хэвлэлээр дамжуулан Монголын ард түмэнд мэндчилгээ хүргэсэн. Энэхүү мэндчилгээндээ ерөнхий сайд Абэ эрх чөлөө, ардчиллын үнэт зүйл, энх тайваны үнэт зүйл, бие биендээ харилцан туслах элгэн халуун сэтгэл гурвыг өвөртлөж, Япон-Монголын стратегийн

түншлэлд өөрийн бүх хүч чадлаа зориулж ажиллахаа Монголын ард түмэнд илэрхийлсэн билээ.

Энэ бол Ази болон дэлхий дахинд Монгол улсыг өндрөөр үнэлж, Монгол улсад том ач холбогдол өгсөн Япон улсын засгийн газрын найрсаг сайхан харилцааны илэрэл гэдгийг Монголын ард түмэн ойлгож халуунаар хүлээж авсан бизээ.

Монгол Улс нь 1990 оны ардчиллын жилүүдэд Япон зэрэг улсуудын тусламжтайгаар зах зээлийн тогтолцоонд шилжиж, эдийн засаг нь 2010 онд 6.4, 2011 онд 17.3, 2012 онд 12.3 хувиар өсөж, өндөр хурдтай хөгжлийг үзүүлсэн юм.

Энэхүү эдийн засгийн өсөлтийг зогсолтгүй хангахын тулд Японы улсын Засгийн газраас 2010 онд 540 сая доллар, 2011 онд 756 сая доллар-ын буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээл олгосон нь Азидаа эхний гуравт орох үзүүлэлт юм. Монгол улсад үзүүлж байгаа тусламжаараа Япон улс дэлхийд тэргүүн байранд ордог.

Үүний зэрэгцээ технологийн болон эрүүл мэндийн салбарт үзүүлсэн тусламж, хотын нийтийн тээврийг дэмжиж автобус бэлэглэсэн зэрэг нь Японы төр, засгаас Монголын ард түмэнд хандаж байгаа чин сэтгэлийн илэрхийлэл байдаг юм.

Гэхдээ газар зүйн хувьд Евро-Азийн эх газрын төв хэсэгт байрладаг, ОХУ, Хятад гэсэн 2 их гүрний дунд орших Монгол улсад геополитикийн хувьд бэрхшээлтэй асуудлууд бий. Цаашдаа Япон-Монголын стратегийн түншлэлийг Ази болон дэлхийн хэмжээнд хэрхэн яаж хөгжүүлэх вэ? гэсэн нэн чухал асуудал энд бас бий.

Гурав. Абэ-гийн засаглалыг гадаад улсууд хэрхэн үнэлж байгаа. Хятад, Өмнөд Солонгос улсуудтай харилцах харилцаа

Энэ сэдвийн хүрээнд Абэ-гийн засаглалыг гадаад орнууд хэрхэн үнэлж байгаа болон Хятад, Өмнөд Солонгос улсуудтай харилцах харилцааны талаар хөндөж ярья.

Америк улс Абэ-гийн засаглалыг найрсаг нүдээр харж байгаа. Жишээлбэл, Жон Хопкинс их сургуулийн профессор М.Деминг (АНУ-гадаад явдлын яаманд Японы газрын даргаар ажиллаж байсан): “Абэ ерөнхий сайд нь үндсэрхэг үзэлтэй гэж хэлэгддэг ч Япон, Хятадын хоорондын маргаантай “Сенгаку” аралыг хамгаалах нь үндсэрхэг үзэл биш юм, гээд Абэ ерөнхий сайдын хүчирхэг лидер чанарыг нь өндрөөр үнэлсэн.

Мөн Америкийн Гадаад явдлын Яамны дэд сайдын алба хашиж байсан Л.Амитеж хэлэхдээ: “Америк улс нь Абэ ерөнхий сайд шиг идэвхтэй, эрч хүчтэй Японыг хүсэж байсан. Гэхдээ улс төрч хүний хувьд үл ойлголцол бүхий түүхэн асуудлын талаар үг унагах хэрэггүй биз” гэсэн нь Абэ-гийн манлайлах чадварыг нь үнэлэхийн зэрэгцээ “Сэнкоку” хийдэд хүндэтгэл үзүүлсэн явдлыг нь цохон дурьдсан хэрэг юм.

Английн “Экономист” сэтгүүлийн редактороор ажиллаж байсан Билл Эрмот “газар нутгаа эзэмших, гадаад бодлогоо томъёолж явуулах эрх нь Японд өөрт нь байх ёстой. Гэвч түүхийн аливаа асуудлыг өөр өнцгөөс харах юм бол ард хоцорч сонирхол татахаа болидог тал бий” хэмээн бичсэн нь Абэ-гийн түүхэн асуудлуудад хандах хандлагад шүүмжлэлтэй өнгө аясаар хандсан хэрэг юм.

Энэ оны 7 сарын 22-ны “Интернейшнл Хералд Трибун” сонинд: Абэ-гийн засаглалын удирдах чадварыг үнэлэхийн зэрэгцээ “Сэнкоку” хийдэд үзүүлсэн хүндэтгэл болон түүхийн шийдэгдээгүй асуудлаарх өнөөгийн хандлага нь хөрш орнуудтай харилцах гадаад бодлогын “хөндүүр асуудлуудыг” улам хүндрүүлэхэд хүргэж болзошгүй гэж санаа тавьсан байдаг.

Энэ мэтээр Абэ-гийн засгийн газрыг өндөрөөр үнэлж байгаа боловч Хятад, Өмнөд Солонгос зэрэг хөрш орнуудтай харилцах харилцаа гацаанд орж болзошгүй хэмээн болгоомжилсон байна.

Хятад улстай харилцах харилцаанд 2 асуудал байдаг. Нэг нь “Сэнгаку” арал юм. Японы засгийн газар 1895 оны олон улсын конвенц болон түүх, түүхэн баримтыг эш үндэс болгон, уг арал нь Японы эзэмшилд байх газар нутаг юмгэж үздэг. Ийм учир уг аралын асуудлаар ямар нэгэн маргаан байх ёсгүй гэсэн байр суурьтай байдаг юм.

Харин 1968 онд НҮБ-ийн Ази, номхон далайн асуудал эрхэлсэн эдийн засаг, нийгмийн комиссоос “Сенгаку” аралын орчимд Саудын Арабын газрын тосны нөөцтэй эн тэнцэхүйц газрын тос байгаа гэж мэдээллэснээс хойш уг арлыг Хятад улс “манай арал” хэмээн зарлах болсон юм.

Үүнд Америкийн төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон, одоогийн төрийн нарийн бичгийн дарга Керри нар “Сенгаку” аралын талаар маргаан хурцадсан тохиолдолд Америк-Японы аюулгүй байдлыг хангах Гэрээний дагуу уг аралыг хамгаалах арга хэмжээ авах болно хэмээн мэдэгдсэн.

Хоёрдахь асуудал нь түүхэн асуудал буюу Хятад-Японы дайн болон Сенкоку хийдэд хүндэтгэл үзүүлдэг явдлыг тойрсон асуудал юм.

Өмнөд Солонгос улстай харилцах харилцаанд мөн л 2 асуудал байдаг. Нэгдэх нь, Лиан Коурт Рокс буюу Таке Шима арал юм. Уг арал 1905 онд Японы эзэмшил нутаг байсан. Гэтэл одоо Өмнөд Солонгосын армийн цэргүүд хянаж байдаг. Хоёрдахь асуудал нь, өмнөх түүхийн үл ойлголцол юм. Тухайлбал, Япон улс Солонгосыг өөртөө нэгтгэсэн болон Японы армид Солонгос эмэгтэйчүүдийн эрхийг зөрчиж байсан явдал юм.

Гэвч өнгөрсөн түүхийн маргаантай асуудлаас болоод Япон-Солонгосын хоорондахь төрийн дээд хэмжээний уулзалт хойшлогдох нь байж боломгүй зүйл юм. Хэрвээ хоёр улсын хооронд асуудал байгаа бол түүнийг хоёр орны дээд хэмжээний уулзалт, хэлэлцээрээр л шийдвэрлэнэ шүү дээ.

Эцэст нь Япон-Монголын харилцааны талаар дурьдахад хоёр орны харилцаа нэн найрсаг түвшинд явагдаж байгаа. Японы Ерөнхий сайд Абэ-гийн Монгол улсад хийсэн айлчлал, Монгол улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолд Японы дотоод хэргийн сайд оролцсон явдал, мөн Монгол улсын эдийн засгийн хөгжлийн сайд Япон улсад айлчилсэн зэрэг нь энэ харилцааны тод томруун жишээ юм.

1972 оны 2 сарын 24-нд Япон, Монгол улс дипломат харилцаа тогтоосноос хойш 41 жилийн нүүр үзэж байна. Япон, Монголын найрсаг харилцааг хоёр тал, ард түмэн бүх талаар хамтран ажиллаж улам бүр бэхжүүлж хөгжүүлнэ гэдэгт итгэл дүүрэн байна.

ENERGY SECURITY AND ROLE OF HEGEMON

PARK JUNG HOO¹, TURTOGTOKH Janar²

¹Ph.D student

²Ph.D, Professor, Department of Political Science, National University of Mongolia

Түлхүүр үг: нефть, эрчим хүч, АНУ-ын гадаад бодлого

ТОВЧ ХУРААГУЙ: Зохиогч тус өгүүлэлд Үндэсний Нефтийн Компаниуд нь нефтийн тогтсон үйлдвэрлэлийг өргөжүүлэх тал дээр илүү сайн ажиллаж буй бол, дэлхийн томоохон нефтийн компаниуд үнэ өртөгтэйгээр шийдвэр-гаргахаас зайлсхийж, өөрчлөгдөн буй улс төр, эдийн засгийн нөхцөл байдалд илүү уян хатнаар дасан зохицож хөгжих боломжтой учраас зах зээлийн хүчин зүйлээс хамааран шинэчлэлийн судалгааны ажлыг хийх илүү шаардлагатай болохыг илэрхийлэхийг зорьсон.

Түүнчлэн, АНУ-ын засгийн газар нь тэдгээр нефтийн том компаниудыг судалгааны ажлаа хийх тогтвортой илүү таатай нөхцлөөр хангах ёстой болж байгаа нь тус улс эрчим хүчээр хангагдах талаа бататгахын зэрэгцээ Ойрхи Дорнод болон ОПЕК-н бусад улсаас хамаарах хамаарлаа багасгах улс төр эдийн засгийн бодлогын илрэл болж буйг өгүүллийн үндсэн хэсэгт оруулсан болно. Эрчим хүчний боломж нөөцтэй бусад улстай холбоо тогтоож, эх үүсвэрээ олируулах нь АНУ-ын хувьд ирээдүйд удаан хугацааны турш эрчим хүчний баталгаатай байдлын гол шийдэл болоод байна.

1. Introduction

The imbalance of supply and demand of oil is derived from the finite nature of oil while the demand is still growing with the economic growth of developing countries. China is one of the critical factors behind this soaring demand. The bigger the gap between decreasing supply and higher demand, the more oil crisis is likely to happen. Thus, the key in bridging this gap is to lower the demand of oil while maximizing the supply to sustain the level of growth; the essence of the problem is how much oil reserves we have left, and how long we can sustain the production level of oil until the demand for oil decreases when China starts soft or hard landing after its economic growth. The matter is how long we can sustain or delay the oil peak while developing new technologies.

Under the conventional way of oil production and reserve exploration, NOC (National Oil Company)s might do better in maintaining or maximizing the supply. This is because they have the advantage in terms of conventional way of oil production because they have more access and control over the new reserves with the government authority. However, at some point in the future, finding new oil reserves will become more difficult due to the finite nature of oil.¹⁶⁴ Even though NOCs find large amount of new reserves around the world, no one can assert whether explosive demand for oil of the developing countries, such as China, can be met by the conventional way of oil production and supplies. After China, there is India. The scale of these two countries' development especially that of China, has been and will be unprecedentedly overwhelming due to the size of the country.¹⁶⁵ Once developed, maintaining

¹⁶⁴ Buttonwood: "Feeling Peaky," *Economist*, April 21, 2012.

¹⁶⁵ Asia's energy challenge, Asian Development Outlook 2013, ADB, www.adb.org

the heightened level of the standard of living will persist for a while thus the demand for oil will be relatively more inelastic compared to the other resources needed for life.

The key question here is whether the supply is indeed sufficient to catch up or go along with the China's demand level on the upward slope before the inflection point in the Hubbert's bell curve.¹⁶⁶ The essence of the problem is not the absolute amount of demand and supply of oil but the timing between the two factors over the inflection point; both supply and demand will pass the inflection point but there will be crisis when the demand passes the inflection point faster than supply. And the timing of demand passing the inflection point is highly likely to be consistent with the speed and path of the China's economic growth.

Thus, if China's economic development continues for a while as well as other developing countries, explosive demand for oil required for both the development and maintenance of the development will keep the consumption level of oil high. In such a situation, the supplies by NOCs, based on conventional way of oil production, have more advantages in terms of absolute amount of oil reserves. However, when conventional channels of oil supply start to face the limitation of their finite nature, the only possible instrument that can resolve the energy crisis is technology, technology is the key. And private oil companies such as supermajors can concentrate their capital and resources on the research and development of the new technology.

The nature of oil business is changing to technological development for alternative energy sources while still exploring existing oil reserves and trying to maximize the current oil sources through the development of new techniques for refineries. Many oil companies, both private and nation-owned, starts to invest their time and energy in developing alternative energies such as hydro, wind power. For example, Petrobras is one of the companies that is developing alternative energy sources. In the annual financial report of both Petrobras and Exxon-one is state-owned, the other is private company- investment in alternative energy sources are being emphasized although the proportion is not higher than conventional energy source development.¹⁶⁷

2. More incentives for the development and R&D

One example of such new technological development is the finding of shale oil. Development of the shale oil brought dramatic change in the grim picture of the supermajors' future. New technology such as horizontal drilling made the industry overcome technical obstacles in the development of shale oil. Innovation of technology has been always extending the life-span of the existing energy resources and is still continuing.¹⁶⁸ Not only in developing new energy sources but in terms of commercialization, supermajors have advantages in pursuing active R&D according to their market incentives. Private companies have a more sensitive reaction than NOCs to the cost and benefits of the market making efficient resource allocation possible.

Second, speed matters. The decision-making procedure of private oil companies is much more rapid compared to that of the NOCs. Private oil companies show more sensitivity and quick reaction to the market incentive and the level of the cost and benefit. They also quit unnecessary investment once they judge the new development cannot meet their marginal

¹⁶⁶ In Deffeyes, *Beyond Oil: The View from Hubbert's Peak* (2005), pp. 3-51

¹⁶⁷ 1Q13 Annual Financial Report (USD), Petrobras, www.petrobras.com

¹⁶⁸ Knowledge of already discovered oil resources is not static, but increases over time through the expansion of scientific understanding of the field", Misperceptions and Problems Ahead, The Inner Secrets of Oil.

cost.¹⁶⁹ Such high speed in the decision-making gave supermajors more advantages in readjusting and adapting to the changes of global oil market.¹⁷⁰ Time matters in terms of the two following aspects; fast R& D and taking advantage of the position of the frontier. First, fast R&D is the key to the oil problem because saving time before it reaches the peak is the core to resolving supply side problems of oil. Fast R&D is crucial for earning time while developing alternative energy sources to transfer the demand from conventional to the new alternative energy sources- this is the most critical factor in preventing oil peak crisis. Second, speed matters also in terms of the advantage of the frontier. If it was land that one has to rapidly occupy to monopolize the benefit in the conventional oil industry, now it is technology and intellectual property such as patents that one has to take the lead to occupy the profits.

Third, having strong ties with the government is not always advantageous in developing the oil industry. Private oil companies have more autonomy from the state pursuing the logic of the market. Supermajors can have more flexibility and freedom to adjust and implement business plans and can also insulate themselves from the political problems compared to the NOCs which are strongly fused with the government.¹⁷¹ Private oil companies have more autonomy from the state and this makes it possible for them to have higher efficiency in business. Market incentives are more effective for efficient allocation of resources. By concentrating their interest on market incentives, private oil companies can make their business planning more effective and realistic. They do not need to get involved in political issues-such as human rights, diplomatic relations- and can select the optimal business strategies for their profits decreasing transaction cost compared to the state-owned companies. This is also a critical matter of how much government intervention and back up is required- the role of a state.

Policy implication from the previously stated aspect is -Leave the supermajors to the balance of market, efficient mechanism of market incentives, but support them by minimizing the institutional restraints for their business and offering stable international environment for them not to have political obstacles.¹⁷² For example, minimize the complicated procedure of land purchase, make patent registration faster, and do not cause problem with the Middle East. The reason that such a passive government intervention can work is because the key to the changing nature of oil industry is technology and it can be done most efficiently when we leave supermajors in the domain of the market. Profits are strong drive for the research and development of new technology and also for rapid readjustment to the changing demand of market.

Lastly and once again, technology is the key to determining the fate of the supermajors. Development of new technology, capability of the new oil resources such as shale oil and tar sands and alternative energy sources will decide the landscape of the future energy industry. One dramatic example is the development of shale oil in the United States. It changed the gloomy future of the World's energy supplies. According to the estimation of IEA, the U.S. will become a potential energy exporter by 2035.¹⁷³ This is the most striking case of how

¹⁶⁹ This is due to the nature of the characteristics of the oil industry. According to the Frankel, oil industry is investment oriented, consideration of up-front fixed cost is significant, and supply and demand elasticity is small. Also they diversify the level of profit loss through various channels. Paul Frankel, "The Changing Structure of the Oil Industry," p.36-37.

¹⁷⁰ Quick calculation of investment and sunk cost as a leverage of development heightens the speed of R&D and the companies face stagnated development procedure, Frankel, p.36

¹⁷¹ Robert McNally & Michael Levi, "Volatile Oil Prices are Here to Stay, *Foreign Affairs*, July/August, 2011, pp. 100-111

¹⁷² In the initial stage of development of shale oil, rapid purchase of land became an advantage for oil companies in occupying the ground and starting development. The fact the territory was an area without many residents also contributed to the advantage of development.

¹⁷³ World energy outlook 2012, International Energy Agency, 2012.

development of new technology can determine the energy security of one country and what made this possible was incessant efforts by the supermajors. Another aspect is that government is not free from the voters. Re-election is everything in the politics and a failed investment by the mistaken energy policy cannot be excused by the voters.

The other aspect of the development of shale oil case is showing is that the technology can also offset and overcome the limitation or the side-effects from the new findings. For example, technologies are being developed to cover the defects of the shale oil such as polluted water. This was also possible because private companies are under the pressure of sunk cost and pressures from the shareholders.

3. International political environment of today

The nature of international politics of today is that the economy is more strongly fused with governance of the state and the security on a micro scale. Globalization also added linkage among countries in macro scale. Thus, the politics and economy of today's international relations is interwoven with these complicated interaction of both micro and macro scale of fusion within and outside the state between politics and economy through globalization.

Thus, rapid dissemination of economic influence from one country to the other country can spread formation of tension and economic crisis among other countries, which means there are more potential causes of conflicts and war. Oil is one of such source of intriguing conflict both in the area of economy and security because oil is, by nature, a commercial issue as well as security that are based on military equipments using oil. The problems related to security are two-fold. First, most military vehicles used in security, run on oil.¹⁷⁴ Second is that there is high military spending in countries that have large oil reserves, which shows how sensitive the flashpoints of war it could be.¹⁷⁵ Not only is oil the source in running one state's security, but the competition over the finite oil sources invite tensions and conflicts.¹⁷⁶ Thus, once problems related to oil occur, the dissemination of the shock is much faster and stronger when the characteristics of globalization are added.

Does technology strengthen or weaken the linkage between the state and the oil business? As nuclear weapons gave the power and made it possible for weak countries to go against, confront, or even threaten stronger countries, improvement of technology will make it possible for countries with scarce energy sources to rely less on countries with spare capacity, thereby shifting the center of the power from the Middle East to the other countries that develop such technology. Saudi Arabia might lose its position as a leader and its political influence and leverage and that will change the geopolitical landscape in the Middle East, which will directly affect the national interest of the United States. The Middle East has traditionally occupied one of the most critical parts in the U.S.' foreign policy but this situation might change and the U.S.' strategic partner in terms of energy security will change. It could be Asia, Europe, or somewhere else other than OPEC countries. Supermajors will have to fit themselves into these changing circumstances.

The more a country is dependent on particular business profits, such as Saudi Arabia with oil, the more the country's economic interest directly involved in the path of the industry,

¹⁷⁴ One of the strengths in the U.S. military power is its absolute capability of high technology that makes surgical strike possible minimizing the cost and casualties of the war. Such capability is based on the use of effective vehicles including fighting falcon and drones such as F-16s.

¹⁷⁵ Doran, "OPEC Structure and Cohesion: Exploring the Determinants of Cartel Policy," *Journal of Politics* 42, 1 (1980): p.93

¹⁷⁶ Doran, "OPEC Structure and Cohesion: Exploring the Determinants of Cartel Policy," *Journal of Politics* 42, 1 (1980): 82-101

which makes the success of the industry critical matter of the state. In other words, the interest of the oil business is interwoven with the critical national interest of the country - a linkage between a state and oil industry. Thus, the invention of new technology for alternative energy sources can weaken this linkage between the state and oil industry. In this sense, the new technology offered relatively more autonomous political power to the states that were so dependent on oil that they had to be tied by the political constraints such as the Middle East factors.¹⁷⁷

4. Conclusion

In sum, what determines the future landscape of oil and energy industry is technology and it can work better in the domain of private market. And this is where supermajors should find their opportunities.

Autonomy of the industry from the state gives them flexibility and freedom from the political constraints. It is especially so when the crisis of the Middle East and OPEC countries' political instability threaten the security of our energy supplies.¹⁷⁸ Supermajors have been developing their business while dealing with these constraints by offsetting some defects of their new technology and active R&D. Technology will determine the fate of supermajors.

Finally, international relations of today, interwoven with the energy security in the current of globalization, is an object like a mobile requiring delicate balance of each component's weight that any one factor that can affect the change of balance can cause damage in stabilizing the gravity of the whole. The U.S.'s role as a balancer of the complicated combination of each factor's gravity is a key to determining the future of the energy politics. Supermajor's role in that general picture should be a positive stimulant through the incessant technological development and innovation.

References

- World Energy Outlook 2012, International Energy Agency, 2012.
 World Energy Outlook 2011, International Energy Agency, 2011.
 Production and Prospects of American Shale Oil, Report on International Economic Information (Kuk-je-Kyungje-Jungbo), Bank of Korea, Department of International Economy, Nov 30th, 2012.
 Asia's energy challenge, Asian Development Outlook 2013, ADB, www.adb.org
 1Q13 Annual Financial Report (USD), Petrobras, www.petrobras.com
 2012 Summary Annual Report, Exxon, www.exxon.com
 2012 Financial statement and supplementary information, Exxon, www.exxon.com
 2012 Annual Report, company profile, Chevron, www.chevron.com
 Official website, Saudi Aramco., www.saudiaramco.com
 Official website, British Petroleum, www.bp.com
 Adelman, Morris A. "Oil Fallacies." In *Economics of Petroleum Supply: Papers by M. A. Adelman 1962-1993* (Cambridge, MA: The MIT Press, 1993), Chapter 27, 537-548. Reprinted from *Foreign Policy* (Spring 1991): 2-16
 Anthony Sampson, *The Seven Sisters: The Great Oil Companies and the World They Shaped* (1980)
 Bassam Fattouh, "OPEC Pricing Power: The Need for a New Perspective," Oxford Institute for Energy Studies, WPM 31 (March 2007)

¹⁷⁷ Paul Frankel, "The Changing Structure of the Oil Industry," p.45

¹⁷⁸ About the suggestion for the possible paths for the U.S. policy, Morse and Jaffe suggest three policies; preemptive engagement, pursuit of strength of monopsony, and trying to change the rules of game. Edward L. Morse and Amy Myers Jaffe, *OPEC in Confrontation with Globalization*, p.87.

Among those three, preemptive engagement can be the most realistic and effective answer considering the safe soft power of the U.S. Trying too active and risky policies that can cause backlash effect should be reserved.

- Brookings Institution Press, 2007), pp. 232-246.
- Buttonwood: "Feeling Peak," *Economist*, April 21, 2012, p. 86
- Chapter 5: "How Long Will Oil Last?" pp. 159-188
- Colin J. Campbell and Jean H. Laherrère, "The End of Cheap Oil," *Scientific American* (March 1998), 78-83.
- Cordesman and Al-Rodhan, *The Global Oil Market: Risks and Uncertainties* (2006): "Regional Strategic and Production Risks," pp. 60-132
- Cordesman, Anthony H. and Khalid R. Al-Rodhan. *The Global Oil Market: Risks and Uncertainties* (Significant Issues Series, Vol. 28, No. 1). Washington, D.C.: The CSIS Press, 2006.
- Daniel Yergin, *The Quest*, "Across the Caspian"; "SuperMajors"; "The Petro-State" (2011)
- Deffeyes, *Beyond Oil: The View from Hubbert's Peak* (2005), pp. 3-51
- Deffeyes, Kenneth S. *Beyond Oil: The View from Hubbert's Peak*. New York: Hill and Wang, 2005.
- Doran, "International Energy Security and North America," in Isabel Studer and Carol Wise, eds., *Requiem or Revival? The Promise of North American Integration* (Washington, DC: Doran, "OPEC Structure and Cohesion: Exploring the Determinants of Cartel Policy," *Journal of Politics* 42, 1 (1980): 82-101
- Doran, *Myth, Oil, and Politics: Introduction to the Political Economy of Petroleum* (New York: The Free Press, 1977), "Economic Theory of Cartels," 138-141
- Edward L. Morse and Amy Myers Jaffe, "OPEC in Confrontation with Globalization," 65-96.
- Griffin, "Oil Security in an Increasingly Insecure World," pp. 71-102
- Griffin, "The End of Cheap Oil?" pp. 30-70
- Griffin, James W., *Smart Energy Policy*, New Haven: Yale, 2009
- Jan H. Kalicki and David L. Goldwyn, eds., *Energy and Security: Toward a New Foreign Policy Strategy* (Baltimore: Johns Hopkins University Press, 2005):
- John M. Blair, *The Control of Oil* (New York: Pantheon Books, 1976): o Part One: "The Control of Foreign Oil," 27-120
- Kalicki and Goldwyn, eds., *Energy & Security* (2005):
- Klare, Michael T. *Rising Powers, Shrinking Planet: The New Geopolitics of Energy*. New York: Metropolitan Books, 2008.
- M. King Hubbert, "Energy Resources," in National Academy of Sciences – National Research Council, *Resources and Man: A Study and Recommendations* (San Francisco: W. H. Freeman and Company, 1969), 157-242
- Michael Levi, *The Power Surge: Energy, Opportunity and The Battle for America's Future*, Oxford: Oxford University Press, 2013.
- Øystein Noreng, "The Euro and the Oil Market: New Challenges to the Industry," *Journal of Energy Finance and Development* 4 (1999): 29-68
- Paul Frankel, "The Changing Structure of the Oil Industry," 35-45
- Recommended: Ian Skeet, *OPEC: Twenty-Five Years of Prices and Politics* (Cambridge: Cambridge University Press, 1988)
- Robert E. Mabro, "OPEC after the Oil Revolution," *Millennium* 4 (Winter 1975-76): 191-199.
- Robert G. Reed III and Fereidun Fesharaki, eds., *The Oil Market in the 1990s: Challenges for the New Era* (Boulder: Westview Press, 1989)
- Robert McNally & Michael Levi, "Volatile Oil Prices are Here to Stay, *Foreign Affairs*, July/August, 2011, pp. 100-111
- Russell Gold and Angel Gonzalez, "Exxon Struggles to find Oil," *WSJ.com*
- Steve Coll, "I'm Going to the White House on this," "It Just Happened [Gulf oil spill]," *Private Empire: Exxon-Mobil and American Power*, 2012, pp. 1-22, 601-624
- Steve Coll, "Private Empire: Exxon-Mobil and American Power, "The Cash Waterfall," "Moonshine," "Can't the CIA and the Navy Solve this Problem?" 2012, pp. 408-477

Steve Coll, *Private Empire: Exxon-Mobil and American Power*, New York: Penguin Press, 2012.

Vaclav Smil, *Oil: A Beginner's Guide* (Oxford: Oneworld Publications, 2008):

William Nordhaus, *A Question of Balance: Weighing the Options on Global Warming Policies*, New Haven: Yale Univ. Press, 2008

ТАЙВАНИЙ УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Э.САРАНЦЭЦЭГ

МУИС-ийн Улс төр судлалын докторант

Түлхүүр үг: Тайвань, улс төр, дэглэм, эдийн засаг, хөгжил, нам, намын систем, ардчилал

ABSTRACT: *During the years of attempts to make the Korean coast as the “Little Japan”, the Japanese had an Island in the Southern Chinese sea under their rule. After wards of Manchu occupation of China in the XVII century, a large population of Chinese settled down on the Island migrating from their native land. Being Landed by Portuguese and Dutch earlier, the Island was occupied by Manchu later, and attached to qing Dynasty possession. In 1895 China was defeated by Japan, and as the result of Simonosec agreement China gave the Island to Japanese rule. This small Island, which was subjugated by Japan, found a destiny to grow and to become one of the most powerful economy in Asia, is the nowadays Taiwan.*

ТОВЧ ХУРААНГУЙ: *Солонгосын хойгийг “Бага Япон” болгох гэж оролдож буй үед Япончууд Хятадын өмнөд далайд орших бас нэгэн арлыг эзэмшдэг байлаа. Манж нар Хятадыг эзэлсэн 17-р зууны дунд үеэс олон тооны Хятад иргэд энэ арал дээр дүрвэн ирж суурьших болжээ. Португальчууд, Голландчууд газардаж байсан энэ арлыг хожим манж нар эзлэн, Чин гүрний бүрэлдэхүүнд оруулж 1895 онд Хятад Японд ялагдаж, Симоносекийн гэрээгээр Хятад уг арлыг Японд өгчээ. Японы эзэмшилд орсон энэ жижиг арал бол хожим Азийн бас нэгэн том эдийн засаг болж чадсан нь одоогийн Тайвань юм.*

Коммунистуудаас зугтсан Эх газрын олон хятад Тайваний арал дээр ирж 1949 оны 10-р сард Хятадын Коммунист нам Бүгд Найрамдах Хятад Ард Улсыг тунхагласнаар эх газар болон Тайваний арал дээр Хятадын хоёр засгийн газар бий боллоо. Өмнөд Солонгостой адил Америкчууд Тайвань арал дээрх ЧанКайшигийн засгийн газрыг хүлээн зөвшөөрч байсан бөгөөд мөн Тайваний арлыг Америкийн цэрэг хамгаалж байлаа.

Япон дайнд ялагдсанаар Хятадын түүхэн дэх хамгийн хүчирхэг хоёр том нам болох Гоминдан, Хятадын Коммунист нам хоёрын хооронд Японы эзэмшилд байсан газар нутгийг нөгөөгөөсөө өрсөж гартаа оруулж авахын төлөөх тэмцэл өрнөж эхэлжээ. *Эх газрын Хятадад хэн нь эзэн суух бол? Америкчуудын дэмжлэгийг авсан, цэрэг технологийн хувьд давуу Гоминдан уу? Аль эсвэл хөдөө тосгодоод байрласан, харьцангуй хүч багатай Коммунист нам уу? 1949 оны 5-р сард коммунистууд Шанхайг эзэлж, улмаар Гоминдан*

намынхан ялагдсанаар Бүгд Найрамдах Хятад улсын Чан Кайшигийн засгийн газар үлдсэн цэргийнхээ хамт Тайвань руу зугтан гарчээ. Хоёр намын дарангуйлагч дэглэмийн хорин гурван жилийн тэмцлийн хувь заяа ингэжшийдэгдэв. Гоминдан Хятадыг ийнхүү алджээ. Гэхдээ цэргийн удирдлагынхаа чадваргүйгээс гол нь бус, харин ард түмний сэтгэлийг эзэмдэж чадаагүйн учир Гоминдан ялагджээ... “Гоминданыг дэмжигч хотын оршин суугчид коммунистуудын ялалтыг үл итгэсэн, хүлээнэсэн байдалтай угтсан бол харин Гоминданыхны хойноос лав л эхний үед нулимс унагасан хүн бараг гараагүй билээ.”¹⁷⁹

1945 онд Америкчууд Тайванийг Чан Кайшигийн засгийн газарт буцаан өгчээ. Чухам энэ арал Чан Кайшигийн засгийн газрын эцсийн найдвар болно гэж хэн санахав. 1945-1949 он хүртэлх Тайваний тухай Конрад Зайц өөрийн номондоо бичихдээ, “Гоминданы дэглэм Тайваньд мөн л эх газрынх шигээ авлигад автсан, чадваргүй гэдгээ харуулжээ. 1947 оны 2-р сард Тайваньчууд бослого гаргасанд Гоминданы цэрэг цус урсган дарахад 28 мянган Тайваньчууд, тэдний дотор мэргэжилтэн, сэхээтний нэг үе амь үрэгджээ. 1949 онд Мао Цэдунд ялагдсаныхаа дараа Чан Кайши армийнхаа үлдсэн хэсэг болон үйлдвэрийн олон эзэд, түшмэд, профессоруудын хамтаар Тайвань руу зугтан очиж Бүгд Найрамдах Хятад улсыг байгуулав. Америкийн 7-р флот тус арлыг коммунист халдлагаас хамгаалж байв”¹⁸⁰ гэжээ. Ийнхүү Хятад болон Солонгосын хойг хоёрхуваагдаж, Өмнөд Солонгос, Тайванийг Америкийн цэрэг хамгаалж байлаа.

Эх газарт байсан БНХУ-ын төрийн тогтолцоо Тайваний арал дээр шилжиж ирэв. *(Газар нутаг нь л солигдсон болохоос биш БНХУ өөрчлөгдсөнгүй).* 1988 онд авторитар дэглэмээс ардчилсан тогтолцоонд шилжих хүртэлх Тайваний эрх баригч нам бол Гоминдан юм. Гоминдан 1946 онд БНХУ-ын нийслэл байсан Нанжин хотод шинэ Үндсэн хуулийг баталжээ. Улмаар шинэ Үндсэн хуулийн дагуу 1948 онд хуралдсан анхны Үндэсний Ассемблей Гоминдан эх газар дахь хяналтаа алдсанаар 1949 онд Тайпей хот руу шилжжээ. Анхны Үндэсний Ассемблейн гишүүд 7 жилийн хугацаатайгаар сонгогдсон бөгөөд БНХУ Тайвань руу шилжсэнээр дахин сонгууль явуулах боломжгүй болсон юм. Үндсэн хуулиар БНХУ-ын Үндэсний Ассемблей нь Хятадын бүх ард түмнийг төлөөлөх учиртай байтал 1949 оноос хойш ингэх боломжгүй болов. Тиймээс Шүүх юань Үндэсний Ассемблейн анхны гишүүдийг эх газрын Хятадыг дахин хяналтандаа оруулах хүртэл албан үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн юм. Ийнхүү 1947 онд байгуулагдсан Үндэсний Ассемблей 1991 он хүртэл хэвээр үлджээ. Эх газрыг хяналтандаа авах зорилт энэ үед биелсэнгүй.

1991 оноос өмнө Үндэсний Ассемблей Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй байсан бөгөөд хамгийн гол нь БНХУ-ын ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчийг сонгодог байв. Ерөнхийлөгч нь 6 жилийн хугацаатайгаар сонгогдоно. Үндсэн хуулиар Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна гэж заажээ. Харин гүйцэтгэх эрх мэдлийг ерөнхий сайдын тэргүүлсэн Гүйцэтгэх юань хэрэгжүүлнэ. Гүйцэтгэх юань нь Хууль тогтоох юаньд хариуцлага хүлээнэ. 1947 онд байгуулагдсан анхны Хууль тогтоох юань нь 773 гишүүнээс бүрдэж байсан бөгөөд Үндэсний Ассемблейтэй адил 1991 он хүртэл тодорхойгүй суудалтайгаар хэвээр үлджээ. Гишүүдийн тоог нөхөж байхын тулд ёс төдий сонгууль явагдана.

Тэгвэл улсын хамгийн гол албан тушаалтан хэн бэ, *ерөнхийлөгч* үү, аль эсвэл *ерөнхий сайд* уу? Үнэндээ 1948 онд Чан Кайши ерөнхийлөгч бус, ерөнхий сайд болохыг зорьж байжээ. Гэсэн ч Үндэсний Ассемблейн дийлэнх гишүүдийн дэмжлэгтэйгээр Чан Кайши ерөнхийлөгчөөр сонгогджээ. Эндээс харвал ерөнхийлөгчийн албан тушаал бэлгэдлийн гэдэг нь харагдаж байв. Төрийн тогтолцооны хувьд ерөнхий сайд давуутай эрх мэдлийг эдэлж байгаа боловч бодит байдал дээр Чан Кайши гүйцэтгэх эрх мэдлийг эдэлж байлаа. Үндэсний Ассемблей 1975 онд Чан Кайшиг нас барах хүртэл түүнийг

¹⁷⁹“Хятад: Дэлхийн гүрэн эргэн ирж байна” *Конрад Зайц*, УБ., 2006 он

¹⁸⁰“Хятад: Дэлхийн гүрэн эргэн ирж байна” *Конрад Зайц*, УБ., 2006 он

ерөнхийлөгчөөр сонгосон бөгөөд түүнийг нас барсны дараа Үндсэн хуулийн дагуу дэд ерөнхийлөгч Юн Чио-кан 1978 он хүртэл ерөнхийлөгчийн албан тушаалыг хашжээ. Чан Кайшигийн үед бодит эрх мэдэл ерөнхийлөгчийн гарт байсан, энэ удаа бодит эрх мэдэл Юний гарт байсангүй. Харин Гүйцэтгэх юанийн тэргүүн Чан Кайшигийн хүү болох Чан Чин-Куо засгийн эрх мэдлийг атгаж байлаа. 1988 онд Үндэсний Ассемблей Чин-Куог ерөнхийлөгчөөр сонгож, бодит эрх мэдэл эргээд ерөнхийлөгчид шилжив. Өөрөөр хэлбэл, Тайваний авторитар дэглэмийн үед засгийн бодит эрх мэдэл Үндсэн хуулийн дагуу тогтсон нэг албан тушаалд байхаасаа илүүтэйгээр хэн ямар албан тушаалд байгаагаас ихээхэн хамаарч байв. Өмнөд Солонгост зургаан удаа Үндсэн хууль батлагдаж, мөн олон дэглэм ээлжлэн солигдон байж ардчилсан дэглэмд шилжсэн. Харин Тайваньд үүний эсрэгээр, эрх баригч нэг намын дэглэм 1949-1988 он хүртэл байсаар ардчилсан шинэчлэлтийг хийсэн билээ. Ардчиллыг хэрхэн дэмжиж байгааг (Хүснэгт 1) үзүүлвэл:

Ардчиллыг дэмжих дэмжлэг

Хүснэгт 1.

Ардчилал бол ...	Монгол	Тайвань	Өмнөд Солонгос	Япон
Манай оронд хэрэгтэй байна	91,6	72,2	95,4	87,1
Манай оронд тохиромжтой	86,3	59,0	84,2	76,3
Нийгмийн асуудлыг шийдэхэд үр дүнтэй	78,4	46,8	71,7	61,4
Засаглалын бусад хэлбэрээс илүү	57,1	40,4	49,4	67,2
Эдийн засгийн хөгжлөөс илүү чухал	26,8	10,5	18,7	31,7
Дээрхийн аль аль нь ч биш	0,2	1,4	0,1	0,2
Дээрх бүгд	16,1	3,3	9,9	18,1
Дэмжлэгийн ерөнхий үзүүлэлт	3,8	3,1	3,6	4,0


Тайваний хоёр дахь удирдагч Чан Чин-Куо 1980-аад оноос Тайваний ардчилах үйл явцыг эхлүүлжээ. Тайвань ардчилсан улс болох нь өөрсдөд нь маш ашигтай байлаа. Магадгүй Тайваний тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлж болох юм.

Авторитаризм нь Зүүн Азид ардчилалтай өрсөлдөх нэлээд хүчтэй өрсөлдөгч хэвээр байна. Тус бүс нутаг нь ардчилал руу тэмүүлэх нийт дэлхийг хамарсан хөдөлгөөнөөс олон чухал зүйлээрээ нилээд гадуур байна. “Ардчиллын гуравдахь давалгаа” эхэлсэн тэр үеэс хойших жилүүдэд энэ бүс нутгийн ихэнх оронд янз бүрийн авторитар болон хагас ардчилсан дэглэмүүд ноёрхсоор байгааг (Зураг 1) харуулж байна.

Ардчиллыг илүүд үзэж буй болон Авторитаризмаас хүнийссэн байдлын харьцаа

Зураг

1.



Чан Чин-Куог 1988 онд нас барсны дараа Гоминдан намын дарга, Тайвань гаралтай Ли Тэнхуй ерөнхийлөгч болов. Энэ оноос Тайваний ардчиллын түүх эхэлдэг. 1996 онд Ли Тэнхуй анх удаа ардчилсан чөлөөт бүх нийтийн сонгуулиар Тайваний ерөнхийлөгч болжээ. 1947 онд байгуулагдсан Үндэсний Ассемблей болон Хууль тогтоох юанийг Ли Тэнхуй 1991 онд хүчээр тарааж, тэр жилдээ 325 гишүүнээс бүрдсэн Үндэсний Ассемблейн, харин 1992 онд Хууль тогтоох юанийн сонгуулийг явуулжээ. Үндэсний Ассемблей нь өнөөдөр улам бүр бэлгэдлийн, байнгын бус шинжтэй болсон бөгөөд өөрийн гол гол эрхүүдээ Хууль тогтоох юанд шилжүүлээд байна. Хууль тогтоох юаний санаачилсан тохиолдолд Үндэсний Ассемблей хуралдах бөгөөд ерөнхийлөгчийн импичмент, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, улсын хилийн өөрчлөлт зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Ийнхүү Тайвань нь ардчилсан шинэчлэлтийг харьцангуй “тайван” замаар хийсэн юм.

Тайваний засгийн газрын бүтэц нь эрх мэдлийн хуваарилалт тэнцвэржилтийн хэвтээ тогтолцоотой. Төрийн үндсэн таван салбар нь,

- ✓ *Гүйцэтгэх юань* Ерөнхий сайд, сайдууд, хороодын дарга нараас бүрдэнэ. Ерөнхий сайдыг Ерөнхийлөгч томилно.
- ✓ *Хууль тогтоох юань* 225 гишүүнтэй (1998 оноос) 3 жилийн хугацаатайгаар сонгогдоно
- ✓ *Шүүх юань* 16 шүүгч бүхий “Дээд шүүгчдийн зөвлөл”, Дээд шүүгчдийг 9 жилийн хугацаатайгаар Хууль тогтоох юанийн зөвшөөрснөөр Ерөнхийлөгч томилно
- ✓ *Байцаан шалгах юань* Төрийн албан хаагчдын удирдлага, томилолт, шалгалт хяналтыг бие даан хариуцна. Уг юаний даргыг 6 жилийн хугацаатайгаар Ерөнхийлөгч томилно.
- ✓ *Хянах юань* Төрийн бүх шатны албан тушаалтнуудын хууль зөрчсөн үйл ажиллагааг шалгах, мөн авлигын асуудлыг хариуцдаг. Уг юаний 29 гишүүнийг Хууль тогтоох юаний зөвшөөрснөөр Ерөнхийлөгч 6 жилийн хугацаатайгаар томилдог.

Тайваний ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгч нь 4 жилийн хугацаатайгаар 2 удаа сонгогдох эрхтэй. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх бөгөөд Гүйцэтгэх юаний тэргүүн буюу ерөнхий сайдыг томилно. Ерөнхийлөгч нь бүрэн эрхийнхээ хүрээнд 5 юанийг удирдан чиглүүлэх үүрэгтэй. Тайваньд өнөөдөр 2 том эвсэл байдаг. Нэг талд нь, эх газрын Хятадыг өөртөө нэгтгэх

байр суурийг баримталдаг Гоминдан намаар удирдуулсан *Pan-blue Coalition*. Эсрэг талд нь Ардчилсан дэвшлийн намаар тэргүүлүүлсэн, Тайваний одоогийн байгаа статусыг хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө байр суурьтай *Pan-green Coalition* юм.

Ардчиллыг авторитаризмаас хэр зэрэг илүүд үзэж буй түвшинг доорх (Хүснэгт 2) судалгаагаар Зүүн Азийн орнуудыг хамруулан харуулав.

Хүснэгт 2.

	Хувь		Илүүд үзэж буй зөрүү	
	Ардчилсан дэглэм	Ардчилсан үйл явц	Ардчилсан дэглэм	Ардчилсан үйл явц
Япон	94	71	+2,2	+1,2
Солонгос	90	66	+1,9	+1,0
Тайван	83	69	+1,6	+1,0
Монгол	79	26	+1,4	-0,4

Ардчилсан бус дэглэмд хандах хандлага

Хүснэгт 3.

	Иргэний*	Нэг намын*	Цэргийн*	Огт үгүй**	Бүрэн***
Япон	14	24	2	68	1
Солонгос	15	13	10	72	1
Тайван	21	18	7	70	2
Монгол	42	27	14	43	4

*- Ардчилсан бус дэглэмийн хувилбар бүрийг зөвшөөрч буй хувь

** - Авторитар дэглэмийн дэмжлэгийн 4 балт индекс дэх 0 оноо

*** - Авторитар дэглэмийн дэмжлэгийн 4 балт индекс дэх 3 оноо

“Тайваний Хятадуудын нийгмийн хөгжил, жилд дунджаар 8-10 хувиар өсч байгаа эдийн засгийн өсөлтийг харахад сургамжтай, эрч хүч итгэл өгөх шиг болдог байлаа. Хямд ажлын хүч, биеийн хүч голлон шаардсан хөдөө аж ахуй, нэхмэл, хувцас, биеийн тамирын гутлын үйлдвэрлэлээс гараагаа эхэлсэн Тайвань улам бүр цойлон хөгжиж байна. Тайваньчууд эхэн үедээ анагаах ухаан, хууль эрх зүйн олон шинжлэх ухааны ховор нандин ном, сурах бичгийг хулгайн маягаар хэвлэж, маш хямд үнээр борлуулж байсан. Харин 1980-аад онд зохих зөвшөөрлийн дагуу, сайн цаасан дээр, хатуу хавтастай хэвлэх болсон. 1990-ээд он гэхэд микросхем, компьютерийн плат, өргөн хэрэглээний болон зөөврийн компьютер, өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болсон... Төвлөрсөн төлөвлөгөөнд тушигдаагүй Тайваний Хятадууд эрчтэй урагшлан хөгжиж байлаа. Тайвань, Хонгконг хоёрт нийгмийн халамжийн тогтолцоо бараг байгаагүй гэж хэлж болно”¹⁸¹ хэмээн Сингапурын ерөнхий сайд Ли Куан Тайваний эдийн засгийн хөгжлийг ийн тодорхойлж бичжээ. Тайвань Өмнөд Солонгостой адил эдийн засгийн хөгжлийн эхэн үедээ хямд ажиллах хүчээ өөрийн гол давуу талаа болгож чаджээ.

Тайваний эдийн засгийн хөгжлийн онцлог юунд байв?

з“Сингапур: Буурай орноос бусдын манлайд хүрсэн замнал” *Ли Гуан Яао*. УБ., 2007 он

“1990-ээд оны эцэс гэхэд Тайваньд хөдөлмөрийн насны хүн амын наян хувийг ажиллуулдаг 1.2 сая жижиг, дунд үйлдвэр байв. Хятадууд бусдын төлөө ажиллахаасаа өөрийнхөө төлөө гэр бүлийн үйлдвэртээ ажиллахыг илүүд үздэг юм. Тайваний арван найман хүний нэг нь үйлдвэрийн эзэн бизнесмен байв. Тайваньд “Хэрэв чи гудамж руу чулуу шидэх юм бол пүүсийн эзнийг л ононо шүү” гэсэн шог яриа ч байдаг. Тайваний эдийн засгийг “шоргоолжны арми” хэмээн “Экономист” сэтгүүл нэрлэсэн удаатай. Энэхүү арми нь 1990-ээд онд дэлхийн зах зээлийг компьютерийн эд ангиар байлдан дагуулсан юм.”¹⁸²

Өнөөдөр “шоргоолжны арми” дэлхийг компьютерийн тоног төхөөрөмжөөр хангаж байна гэж хэлж болно. 2000 оны байдлаар Тайвань дахь компьютерийн мониторийн үйлдвэрлэл дэлхийн зах зээлийн 58 хувийг, нөүтбүүкийнх 49 хувийг, гар сканнерийнх 91 хувийг эзэлж байна. Энэ жагсаалтыг цааш дурьдаж болно. Магадгүй таны ширээн дээрх компютер, нөүтбүүк Америкийн аль нэг брэнд байж болох ч дотор эд ангийг Тайваньд үйлдвэрлэдэг аж. Яг л театрт тавигддаг жүжгийн арын албаныхан шиг. Тайваний эрх баригчид аж үйлдвэрийг хөгжүүлэх урт хугацааны төлөвлөгөөнүүдийг гаргаж байсан бөгөөд мөн Тайваний эдийн засгийн хөгжилд Америкийн дэмжлэг ч бий. Гэхдээ Тайвань үндэстнийхээ онцлогийг харгалзан үзэж хөгжиж чадсан юм. Хятадууд бол дэлхийн хамгийн шилдэг бизнесч хэмээн ярьдгийн амьд нотолгоо нь Тайваньчууд бөгөөд үүний ганц нөхцөл нь үйлдвэр, аж ахуй эрхлэх эрх чөлөөг нь л хангаж өгөх явдал юм. Эхэндээ улсын пүүсүүдийг чухалчлан үзэж байсан Тайваний засгийн газар тэрхүү эрх чөлөөг нь хангаж өгөх ухаалаг бодлого явуулсан юм.

Засгийн газар өндөр технологийн гайхамшгийг бүтээхэд нэг л зүйлээр, чингэхдээ тун чухал зүйлээр хувь нэмэр оруулсан нь өндөр технологийн дэд бүтцийг бий болгосон явдал юм. Засгийн газар “Аж үйлдвэрийн технологийн судалгааны хүрээлэн” хэмээх үндэсний лабораторийг байгуулж, энэхүү судалгааны хүрээлэнг тойруулан Синчү Парк хэмээх өндөр технологийн томоохон паркыг байгуулжээ. Засгийн газар үйл ажиллагаагаа үүгээр хязгаарласан бөгөөд Засгийн газар өндөр технологийн үйлдвэрүүдийн дэд бүтцийг байгуулж өгөөд, харин тэдгээрийн хөгжлийг залж удирдсангүй. Энд Тайваний пүүс компаниуд Америкийн аваргуудтай өрсөлдөхийн тулд бүх талаараа дайчлан ажиллаж байлаа. Тайваний компьютерийн үйлдвэрлэлд нэгэн сонирхолтой зүйл ажиглагддаг. Тухайлбал, Тайваний хагас дамжуулагчийн үйлдвэрлэгчид компьютерийн хуваарилагчийн төслийг өөрсдөө зохиодоггүй бөгөөд харин Тайваний болон барууны орнууд, Японы пүүсүүдээс хагас дамжуулагчийн хуваарилагчийг өгсөн зааврынх нь дагуу үйлдвэрлэх захиалга авдаг байна. Ийнхүү театрын арын албаныхан даруухнаар дэлхийн компьютерийн тоног төхөөрөмжийн зах зээлийг гартаа атгаж байна.

Ийнхүү Бүгд Найрамдах Хятад Улс нь Тайвань аралд орших зүүн Азийн бүрэн эрхт бус боловч тусгаар тогтносон орон юм. Энэ улс нь Тайвань, эсвэл Хятадын Тайбэй (Chinese Taipei) гэж нэрлэгдэх нь олон.

ДҮГНЭЛТ

“Барулс” хэмээх ойлголт Зүүн Азийн хөгжлийн загвар дээр нэн ихээр яригддаг ба төрийн хатуу зохицуулалттай зах зээлийн нийгэм, түүн дээр хятадын иргэншлийн нөлөө, хятад хүмүүжил, ажилсаг чанар нэмэгдээд өвөрмөц хэв шинжийг тэр чигтээ агуулж байдаг хэмээн Тайваньчуудыг үздэг. Мөн тус улсын нутаг таван зэрэгт шатлан хуваагдана. Оройн түвшинд нутгийн ихэнх нь олон хошуу бүхий Тайвань аймагт, үлдсэн хэсэг нь жижиг арлуудын Фузянь аймаг болон хотжиж нягтарсан Тайбэй, Шиньбэй, Гаошюн, Тайжун, Тайнань гэх таван хотод хуваагдан захирагддаг байна.

⁴ “Хятад: Дэлхийн гүрэн эргэн ирж байна” *Конрад Зайц*. УБ., 2006 он

АЗИ-НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ, ТӨЛӨВ /АПЕК/

Р.ДАВААНЫМ

ШУА, ОУСХ-гийн ЭШДЭА, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн докторант

Key words: *regional corporations, regional trade, economic relations*

ABSTRACT: *Since the formation of APEC formed has been paid to the creation of free trade. As a result of the cooperation of the world's most rapidly developing economies in the region to stay. APEC policy each further expand the range of its activities and a pioneer of the Asia-Pacific Economic Cooperation have become influential the process.*

АПЕК нь 1989 онд үүсгэн байгуулагдсан. Байгууллагын гол зорилго нь Ази Номхон далайн орнуудын худалдааг хөнгөвчлөх, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг сайжруулахад, тус бүс нутгийн хөгжлийг түргэтгэхэд оршино.

АПЕК үүсэн байгуулагдсан үеэс чөлөөт худалдааг бий болгоход анхаарч ирсэн. Энэхүү хамтын ажиллагааны үр дүнд дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж байгаа эдийн засгууд тус бүс нутагт оршин байна. АПЕК нь бодлого вйл ажиллагааныхаа хүрээг улам бүр тэлж, эдүгээ Ази-номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны нөлөө бүхий вйл явц болж хувираад байна.

АПЕК-ийг үүсгэн байгуулах үзэл санааг Австралийн ерөнхий сайд асан Боб Хавке санаалчилсан байдаг. АПЕК-ийн онцлох вйл явлууд:

- ✓ 1989 онд 12 гишүүн орон Камберра хотноо Анхдугаар уулзалтаа зохион байгуулсан.
- ✓ 1991 онд БНХАУ, Хонг-Конг, Хятадын Тайпей /Тайванийн эдийн засаг/ зэрэг нь гишүүнээр элссэн.
- ✓ 1993 онд Мексик, Шинэ Гивне, 1994 онд Чили улсууд тус тус элссэн.
- ✓ Сүүлийн байдлаар 1998 онд Феру, ОХУ, Вьетнам зэрэг улсууд гишүүнээр элссэнээр нийт 21 гишүүн эдийн засагтай болоод байна.

Зарчим: Харилцан бие биенээ хүндэтгэж, эрх тэгш байдлыг хангах, харилцан ашигтай байх, харилцан туслах, бүтээлч, шударга түншлэлийг эрхэмлэх, консенсусын зарчмыг баримтлах юм.

Зорилт: Бүс нутагт худалдаа, хөрөнгө оруулалтын чөлөөт тогтолцоог үүсгэх. Гол баримтлал: Нээлттэй бүс нутагчлал нь АПЕК-ийн гол баримтлал бөгөөд АПЕК дахь чөлөөт худалдааг бий болгох, вл ялгаварлах зарчмыг баримтлана гэсэн агуулгатай. АПЕК-т вл ялгаварлах гэдэг нөхцөл болзолгүйгээр нэн тааламжтай нөхцөл олгохыг ойлгодог. Зах зээлд гарах гарц гишүүн болон гишүүн бүс оронд аль алинд нь нээлттэй байна гэсэн вг юм.

Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх чөлөөт худалдааны бодлого: Энэ нь АПЕК-ийн либералчлалын вйл явц заавал биелүүлэх шинжтэй амлалт, дүрмэнд захирагдах бүс /

ДХБ-аас ялгагдах гол ялгаа/, харилцан зөвшөөрсөн зарчмууд дээр тулгуурласан сайн дурын амлалтанд захирагдана гэсэн ойлголт юм.

АПЕК- т хамрагддаг 3 бүс нутгийн байгууллага байдаг. Үүнд:

- Зүүн Азийн улсуудын холбоо /АСЕАН/
- Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөл (РЕСС)
- Номхон далайн арлуудын чуулган зэрэг юм.

АПЕК-ийн гишүүдийг улс орны нь статусын хувьд нь биш харин эдийн засгийн нь хувьд гишүүнээр элсүүлдэг. Гишүүд нь эдийн засгийн хамтын ажиллагааг нягтруулах зорилготой. Үүний нэг илэрхийлэл нь улс төрийн статус нь тодорхой бус Тайванийг улс төрийн утгаар биш эдийн засгийн хувьд гишүүнээр элсүүлсэн явдал юм.

АПЕК-ийн тухай зарим статистикууд:¹⁸³



АПЕК нь Ази-Номхон далайн бүс нутагт байх хамгийн өргөн цар хүрээтэй эдийн засгийн интеграци юм. Тус интеграцийн гол зорилго нь бүс нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулж эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах явдал юм.

Тус интеграци нь тогтвортой эдийн засаг, техникийн харилцан хамаарлыг нөхцөлдүүлэх, худалдааг хялбарчлах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцлийг бий болгох, хүний аюулгүй байдлын баталгааг өсгөх чиглэлээр хамтын ажиллагааг Ази-Номхон далайн бүс нутгийн хэмжээнд дэмжих, хамтын удирдлагаар хангахад чиглэгдэж байна. Дараахь үндсэн чиглэлүүдэд үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд :

- Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах
- Бүс нутгийн хэмжээний эдийн засгийн интеграцийг түргэсгэх
- Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааг ахиулах, дэмжих
- Хүний аюулгүй байдлын нөхцлийг нэмэгдүүлэх
- Бизнесийн орчинг тогтвортой байлгах, сайжруулах

АПЕК-ийн бүтэц, зохион байгуулалт:

АПЕК-ийн Байнгын ажиллагаатай нарийн бичгийн дарга нарын газар Сингапурт байрладаг бөгөөд АПЕК-ийн едер тутмын үйл ажиллагааг явуулдаг. АПЕК-ийн нэг

¹⁸³ http://publications.apec.org/publication-detail.php?pub_id=1414

онцлог нь гишүүн эдийн засгуудаас бүрдэнэ гэхээс биш гишүүн орнуудаас бүрддэггүй.¹⁸⁴ АПЕК-ийн Сайд нарын бага хурал жилд нэг удаа болдог бөгөөд бага хурлыг зохион явуулах гишүүн эдийн засаг нь АПЕК-ийн даргын үүргийг гүйцэтгэдэг. Үүний зэрэгцээ хороод, ажлын хэсгүүд, экспертүүдийн хэсгийг нийтэд нь АПЕК-ийн чуулга /APEC fora/ нэрлэдэг.

Эдийн засгийн удирдагчдын уулзалт: 1993 онд АНУ-ын Сиетлд АПЕК-ийн «Эдийн засгийн удирдагчдын уулзалт» анх удаа болсон. 1996 оны 11 дүгээр сард Филиппиний Сүбик хэмээх газар АПЕК-ийн удирдагчдын уулзалтын гол үр дүн нь АПЕК-ийн үйл ажиллагааны Манилагийн төлөвлөгөөг баталсан явдал юм. Энэ төлөвлөгөөг баталсан нь АПЕК тунхаглалын чанартай үйл явцаас тодорхой үйл ажиллагаанд шилжиж байгаагаар онцлог байсан.

АПЕК-ийн хөгжлийн үе шат

- 1989-1992 Сайд нарын түвшингийн харилцан яриа хийх
- 1993 Ази-Номхон далайн бүс нутгийн тэргүүнүүдийн анхдугаар уулзалт болсон
- 1994 “Ази- Номхон далайн бүс нутгийн нээлттэй чөлөөт худалдаа хөрөнгө оруулалтыг бий болгох “Борог –ын зорилт”-ыг гаргасан.


✓ 2010 он гэхэд үйлдвэржсэн эдийн засгуудыг бий болгох

✓ 2020 он гэхэд хөгжингүй эдийн засгуудыг бий болгох зорилтуудыг тавьсан.

- 1992 он хүртэл сайд нарын болон албаны түвшингийн уулзалт хэлбэрээр,
- 1993 оноос гишүүн эдийн засгуудын эдийн засгийн тэргүүлэгчдийн жил дутмын уулзалт хэлбэрээр үйл ажиллагааг нь эрчимжүүлсэн. Тийнхүү гишүүн орнуудын тэргүүлэгчид тухайн ондоо Сеттли-д уулзалт хийсэн.
- 1994 оны Индонезийн Богор хотноо болсон АПЕК-ийн уулзалтаас өнөөдрийн байдлаар “Ази-Номхон далайн бүс нутагт чөлөөт, нээлттэй худалдаа хөрөнгө оруулалтыг бий болгох” зорилтыг бүх гишүүн орнууд хүлээн зөвшөөрч зорилго болгон тавьсан
- Бүс нутгийн хэмжээнд гишүүн орнууд бүр ялгаатай эдийн засгийн нөхцөл байдалд байгаа хэдий ч гишүүн орнуудын тэргүүлэгчид 2 хөгжлийн 2 үе шатыг зааж өгсөн. Энэ нь чөлөөт, нээлттэй эдийн засгийг бий болгосны үр дүнд 2010 он гэхэд гишүүн орнуудын эдийн засгийн түвшин оролцоо болж, 2020 он гэхэд хөгжингүй эдийн засгуудыг тус бүсэд бий болгоход чиглэнэ гэж заасан.
- Энэ бүхэн нь гишүүн эдийн засаг бүрийн сайн дураараа хүлээсэн үүрэг бөгөөд сайн сайханд хүрэх итгэл, түүнд хүрэх амлалт, хичээл зүтгэлийн үр дүнд бий болохыг заасан.

¹⁸⁴ Гонконг, Тайвань хоёр АПЕК-ийн гишүүн байгаагүй холбоотой юм. Өнөөдөр АПЕК –нь «байгууллага» гэхээсээ илүү тодорхой зорилт дээр нэгдсэн бүсийн эдийн засгуудын хамтын ажиллагааны «үйл явц» гэж үздэг юм байна.

АПЕК-ийн үйл ажиллагааны үр дүн¹⁸⁵



АПЕК-ийн бүс нутгийн гаалийн татвар хураалтын
бууралтын байдал 1989-2010 он хүртэл

Нээлттэй, чөлөөт худалдаа, хөрөнгө оруулалтыг бий болгох Богор-ын зорилтыг хэрэгжүүлэхийг 2010 он хүртэл үе шаттай зохион байгуулсан.

АПЕК-ын Богорын зорилтыг хэрэгжүүлж эхэлснээр 1989-өөс 2010 он хүртлэх хугацаанд гишүүн орнуудын эдийн засгын хоорондох худалдааны эргэлт нийт 5 дахин буюу 3,1 триллион доллароос 16,8 триллион доллар болж нэмэгдсэн байна.

Ийнхүү 2000-2010 онуудад бүс нутгийн хэмжээнд ажил эрхлэлт 10 хувиар нэмэгдсэн бол ядуурал 44 хувиар буурсан. /ядуурлын байдалтай байгаа иргэдийн хувьд өдрийн орлого нь 2 доллароос бага байна/

АПЕК-ын 3-н тулгуур

Ази-Номхон далайн бүс нутгийн байгууллагын үйл ажиллагаа дараах 3-н тулгуур үзэл санааг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Худалдаа, хөрөнгө оруулалтыг нээлттэй болгох
- Тарифийн болон тарифийн бус хүндрэлийг багасгах
- Бүс нутгийн эдийн засгийг интеграцлах бөгөөд Тус үйл ажиллагааны Бизнесийн тулгуур үйл ажиллагаанд
- Бизнес хийх боломжийг хялбарчлах
- Бүтцийн өөрчлөлтийг хийх зэрэг үйл ажиллагаа юм.

Богорын зорилтоос АПЕК нь орчинг бий болгоход анхаарч ажиллахаар заасан байдаг. Тус зорилтын гол санаа нь эдийн засаг, хөрөнгө оруулалтыг либералчилан тарифийн болон тарифийн бус саадыг багасгах, бүс нутгийн эдийн засгийн интеграцийг дэмжих бөгөөд мөн бизнес хийхэд хялбар, таатай орчинг бүрдүүлэх юм


Эдийн засаг, техникийн хамтын ажиллагаа /ECOTECH/

АПЕК-ийн гишүүн орнуудын эдийн засгийн нөөц бололцоо харилцан адилгүй байгаагаас чөлөөт худалдааны бүсийг бүх гишүүн эдийн засгуудыг хамруулах боломжгүй юм. Иймээс хөгжлийн ялгааг багасгах, хөгжингүй болон үйлдвэржиж буй эдийн засгуудын хоорондын ялгаа заагийг бууруулах зорилгоор 1993 оноос хойш хөгжингүй эдийн засгийн зүгээс хөгжиж буй эдийн засгуудад нийт 1600 орчим төсөл

¹⁸⁵ <http://apec.org/>

хөтөлбөр хэрэгжүүлсэн. Тэдгээр төсөл хөтөлбөр нь засгийн газрын байгууллага, бизнесийн байгууллагууд, хувь хүмүүсийн дунд хурал, семинарыг зохион байгуулах байдлаар хэрэгжсэн байна.

АПЕК-ийн гишүүн эдийн засгуудын үзүүлэлт¹⁸⁶



АПЕК-ийн хамтын ажиллагаа нь эдийн засгийн хамтын ажиллагаанаас гадна бүс нутгийн хэмжээний бусад асуудлуудыг хэлэлцэх болсон. Тухайлбал

- Терроризмын эсрэг хамтын ажиллагаа бүс нутгийн хэмжээнд терроризмын эсрэг хамтын үр дүнтэй үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Бүс нутагт эдийн засгийн эрчимтэй хөгжлийг хангахын хамтаар эрүүл орчинг бүрдүүлэх, SARS, H1N1 халдвараас сэргийлэх
- АПЕК-ийн онцгой үед ажиллах бэлэн байдлын хамтын ажиллагааны баг

¹⁸⁶ “APEC Summit – graphic of the day” <http://blog.thomsonreuters.com/index.php/apec-summit-graphic-of-the-day/>

нь хувь хүмүүс аж ахуйн нэгж зэрэгтэй хамтын ажиллагааг өрнүүлснээр газар хөдлөлт байгалийн гамшиг зэрэгтэй тэмцэх

- Худалдаа, хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, үйлчилгээ зэрэг үйл ажиллагаанд нөлөөлөх байгалийн өөрчлөлтийн сөрөг нөлөөг багасгах зэрэг үйл ажиллагааг багтаасан

АПЕК-ийн үйл ажиллагаа¹⁸⁷



АПЕК-ийн үйл ажиллагаа нь 2 түвшинтэй, энэ нь бодлогын болон үйл ажиллагааны түвшин юм. Эдийн засгийн тэргүүнүүд нь жилдээ нэг удаа уулздаг.

- Тэргүүн нарийн уулзалтын тайланг нь ахлах ажилтнууд хүлээн авдаг. Сайд нарын уулзалт болон АПЕК-ийн бизнесийн зөвлөхүүд нь тус тайланг тухайн жилийн үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлдэг.
- Тэргүүн нар нь тухайн хэлэлцсэн асуудлаар тунхаг гаргадаг.
- Санхүү, Худалдаа, Эрүүл мэнд, аялал, жуучлалын салбарын сайд нар тогтмол уулздаг.

- Гадаад худалдаа, эдийн засгийн сайд нарын уулзалт Тэргүүн нарын уулзалтын өмнө хуралдаж, уулзалтын бэлтгэл ажлыг хангадаг.

АПЕК-ийн нарийн бичгийн дарга нарын газар нь 1993 оны 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Тус газар нь тухайн салбар нэгжүүдийнхээ чиглэл тус бүрээр гишүүн орнуудыг удирдлага хангах зорилготой. Өнөөдөр нийт 60 албан хаагчтай бөгөөд үүгээрээ гишүүн орнуудын дунд хоёрдох дипломат үйл ажиллагааг явуулдаг. Гүйцэтгэх захирлаар нь доктор Алан Боллард ажилладаг. АПЕК-ийн нарийн бичгийн дарга нарын газар нь АПЕК-ийн үйл ажиллагааны гол цөм нь болж үйл

¹⁸⁷ <http://apec.org/Groups/Economic-Committee.aspx>

ажиллагааг нь зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажилладаг.

Байгууллагын нэгжүүдэд:

- Холбоо, харилцаа
- Санхүү
- Мэдээллийн технологи
- Төслийн менежментийн нэгж зэрэг юм.

АПЕК-ийн уулзалт зохион байгуулсан газрууд /орнууд, хотуудаар/¹⁸⁸

Он	Гишүүн орон	Тэргүүн нарын уулзалт
2013	Индонез	Бали
2012	ОХУ	Владивосток
2011	АНУ	Гонолулу
2010	Япон	Ёкохама
2009	Сингапур	Сингапур
2008	Перу	Лима
2007	Австрали	Сидней
2006	Вьетнам	Ханой
2005	БНСУ	Бусан
2004	Чили	Сантито
2003	Тайланд	Банкок
2002	Мексик	Лос Кабос
2001	БНХАУ	Шанхай
2000	Бурней Дарисалам	Бандар Сери Бенгаван
1999	Шинэ Зеланд	Аскланд
1998	Малайз	Куала Лумпур
1997	Канад	Ванкувер
1996	Филиппин	Субик
1995	Япон	Осака
1994	Индонез	Богор
1993	АНУ	Браки Исланд, Сеттли

АПЕК-ийн гишүүн эдийн засгууд/ шинэ гишүүнчлэлийн шалгуур:

Өнөөгийн байдлаар Австрали, Бруней, Канад, Чили, БНХАУ, ХонгКонг, Индонез, Япон, БНСУ, Малайз, Мексик, Шинэ Зеланд, Папуа Шинэ Гвиней, Филиппин, Сингапур, Хятадын Тайпей /Тайвань/, Тайланд, АНУ, ОХУ, Перу, Вьетнам зэрэг эдийн засгууд АПЕК-ийн гишүүн эдийн засгаар элсээд байна.

Шинэ гишүүдийн шалгуурын тухай: 1997 оны 11 дүгээр сард Канадын Ванкуверт болсон АПЕК-ийн сайд нар болон удирдагчдын уулзалтаар шинэ гишүүн элсүүлэх шалгуурыг тогтоосон. Үүнд:

- ✓ Ази-Номхон далайн бvс нутагт байрласан байх,
- ✓ Бvс нутагтай ерген хэмжээний худалдаа-эдийн засгийн харилцаатай байх,
- ✓ Зах зээлийн эдийн засгийг эрхэмлэдэг байх,
- ✓ АПЕК-ийн зорилго, зарчмыг хүлээн зөвшөөрсөн худалдаа, хөрөнгө оруулалтын либералчлалын чиглэлээр орон тус бүр өөрийн үйл ажиллагааныхаа төлөвлөгөө гаргасан байх зэргийг заасан байдаг.

¹⁸⁸ https://en.wikipedia.org/wiki/Asia-Pacific_Economic_Cooperation

ДҮГНЭЛТ

Ази-Номхон далайн хамтын ажиллагааны байгууллага нь дэлхийн худалдааны байгууллагын дараа орохуйц өрнөн хүрээтэй хамтын ажиллагааны байгууллага юм. Тус байгууллага нь байгуулагдсан цагаасаа гишүүн улс орнуудад үр өгөөжөө өгсөн ирсэн. Тухайбал гишүүн орнуудын эдийн засгийг жигд өсөлтийн байдал, гааль худалдааны татварын түвшингийн бууралт, чөлөөт худалдааны бүс байгуулагдах байдал зэрэг олон зүйлийг дурьдаж болно.

Монгол Улс нь азид эдийн засгийн харьцангуй хурдацтай өсөлт, түүхий эдийн баялаг нөөцөөрөө тус худалдаа, хамтын ажиллагааны байгууллагын гишүүн болох боломжтой бөгөөд тус байгууллагын гишүүн болсноор гуравдах эдийн засгийн түнш жинхэнэ утгаараа бий болох, газар зүйн түгжигдмэл байдлаас гарах /гишүүн орнуудын харилцан хүлээх үүрэг, татвар худалдаа, газар зүйн хүндрэл, бэрхшээлийг арилгах/ харьцангуй өргөн боломж нээгдэх юм.

Монгол Улс нь өнөөгийн эдийн засгийн харьцагуй эрчимтэй хөгжил дээрээ тулгуурлан АПЕК-ын гишүүн болсноор хөтөлгөө морьтойгоор эдийн засгийн өсөлтийн эрчимтэй нэмэгдүүлэх бүрэн боломжтой болох юм. Энэ үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын өөрийн идэвхитэй эдийн засгийн гадаад бодлого, дипломат үйл ажиллагааны үр дүнд бий болох билээ.

Ашигласан материал

Б.Балдоо, “Монгол улс ба зүүн хойт ази” УБ. 2002

“Олон улсын эдийн засгийн харилцаа” УБ. 2005

Л.Нямцэрэн, “Шинэ эриний сорилт: Монголын хөгжлийн хүчин зүйлс” УБ. 2007

Б.Санжмятав, “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт. УБ.2006

МУИС, ОУХС-ийн эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. “Орчин үеийн олон улсын харилцааны

шинэ чиг хандлага ба Монгол Улс” УБ.2011.

Үндэсний тагнуулын академи, “Жижиг улсын аюулгүй байдал оноо, ирээдүй” УБ.2010

МУИС, Азийн судалгааны төв, “Зүүн хойт азийн төлөв байдал ба Монгол Улс” УБ.2002

ШУА, ОУСХ, “Монгол Улс ба Зүүн хойт ази” УБ.2002

Я.Чимэгээ, “Ази номхон далай бүс нутгийн аюулгүй байдлын тогтолцоо ба Монгол Улсын хувь

нэмэр” УБ.2003

Д.Пүрэв, “Олон улсын эдийн засгийн харилцааны онол, практик, механизм” УБ.2003

Ази тив түүний салбар бүс нутгуудын хамтын ажиллагаанд Монгол Улсын оролцоо, хэтийн

төлөв УБ.1997

Э.Гүргэмжав, М.Амартүвшин, “Олон улсын худалдаа” УБ.2009

Интернет эх сурвалж

<http://economy.time.mn>

<http://mongoliaworld.net>

<http://www.theaustralian.com.au/national-affairs/foreign-affairs/-negotiate-mega-trade-pact>
www.asean.org/asean/external-relations/east-asia-summit-eas

WOMEN'S PARTICIPATION IN POLITICAL DECISION-MAKING: A COMPARATIVE ANALYSE (MONGOLIAN AND KOREAN CASES)

ODGEREL Batsaikhan

Ph.D Candidate of Political Science, National University of Mongolia

Key words: *Parliament, women representative, gender equality, policy making process, electoral system and public sphere*

INTRODUCTION: *In this paper, the author proposes to study and compare women's participation in political decision-making of Mongolian and Korean cases. Firstly based on cases examine women representatives in political decision-making and proposed to study election system outcomes. Secondly study role of Political parties, NGO's on increasing women's political participation.*

Women representatives in political decision-making

Until today in Mongolian and Korean cases, among all sectors in women employment of women and ensuring social position, only representatives in legislature and in political decision-making position are comparatively low.

In my research, it is no coincidence that choosing those two countries as study cases. Because in 2012, Korean first female candidate elected in Presidential election. But in 2013, Mongolian first woman ever became a candidate in Presidential Election. However it has Nomadic tradition, Mongolia has women social position is higher than any other Asian countries. (Enkhsetseg 2008, 35)

But its women participation in political decision-making level is still limited. In 1924, Mongolian women regain their right to participation in politics. First Constitution Law in 1924, Declare that "No person may be discriminated on the basis of ethnic origin, language, race, age, sex, social origin or status, property, occupation or post, religion, opinion, or education" (Constitution of Mongolian People's Republic 1924 1:11). This states no change in 1940, 1960 and 1992 of Mongolian Constitution.

In 1924, Mongolian People's Republic (Mongolia known before 1992) aiming to establish Socialism. In Socialist Culture, Considerably improving women's education and secure equality of gender.

Government responses free health and education policy. And hence care in women health service, maternity health service was free. In this historically short period, Mongolian women had much changes appeared. For women employment, preschool nursery and kindergartens were built and taking care their children free of charge. This helps women can have actively participate in politics. Unfortunately political rights for women still limited and under one-party system, single ideology women participation in politics, were only symbolic nature. (Tsetsegjargal.Ts2009, 64)

On 27th September 1999, Mongolian Government and United Nation's Women's Development Foundation have agreed and signed on Memorandum of Understanding. This was beginning of cooperation of Mongolia and other world on Women rights in Mongolia. But until now more than half of Mongolian populations were women and their influence in politics not sufficient. In 1990, Mongolian huge political and social changes make women

situation worse. And it makes gender policy failed, social care on children and mother worsened, economic circumstances deteriorated. And also because of patriarchy restored women's family liable got higher and their politics and social participation got lower.

During transition period employment degraded, had unfair equity of social wealth, political and economic circumstances deteriorated, gender equality got worse. Before 1990, women participation in legislature reached 22%, new formed parliament in 1992 women members are only 3.9%.

Since 1990, Permanent functioned parliament formed by democratic elections for 20 years. During these 20years still women members number not sufficient.

Table.1 Women representatives in the Mongolian Parliament

	Total representatives	Total women	Women %
1992-96	76	3	3.9
1996-00	76	7	9.2
2000-04	76	9	11.8
2004-08	76	5	6.6
2008-12	76	3	3.9
2012-16	76	11	14.5

Source; Mongolian National Election Commission, <http://gec.gov.mn/> various sites, author's tabulation

According to history, women's rights for vote gained 20th century in Korea. During the Japanese colonial rule, nationalism and liberation rather than women's rights dominated the agenda. After South Korea was established as the Republic of Korea in 1948, however, women achieved constitutional rights for equal opportunities to gain access to public education and to work outside the home. (Mee-Hae Kong, 2007)

In order to study Korea's political decision making level, we need to study legislature. Until today in history of Republic of Korea declared 6 Republic states.

In the constitution, the system of governing of the Republic of Korea is a presidential system based on such principles as separation of powers, and check and balances. According to the Constitution, the President is a head of state (The Constitution of Korea, Article 66:1) and executive power is vested in The Executive branch headed by the President (The Constitution of Korea, Article 66:4). The legislature called National Assembly. (Politology, 2013, 202)

However Republic of Korea became Highly Developed Country in past 60 years, Women participation in political decision-making level still not sufficient.

Women member seats in National Assembly are 15.7% in 2013, this number lower than world such numbers average 21.3%.

Today in National Assembly of Republic of Korea, there are 47 women out of 300 members.

Table.2 Women representatives in the National Assembly:

	Total representatives	Total women	Women %
1992-96	299	7	2.3
1996-00	299	11	3.6
2000-04	273	16	5.9
2004-08	299	39	13
2008-12	299	41	13.7

2012-16	300	47	15.7
---------	-----	----	------

Source; IPU. Women in national paliaments, [archive of statistical data](#)

According to Confusion's ethics influenced women role are lower in family and social life. (Lee 1996). This perspective gradually changes in contemporary world, but still in economic power position, political decision-making level there are not sufficient women representatives. In minister positions there are less number of women. Park Geun-hye's government formed in 2013, there are 3 women ministers work in government. Researcher Diamond and research Kim are considered that 6th Republic State is successful model of democracy in history of Republic of Korea. (Hermanns 2006, 4)

In mid of 1980s Republic of Korea successfully changed from Military regime to Democracy. Also Mongolia changed its Socialist regime into Democracy. Hence our 2 cases have similarities. One similarity is in all level of Elections are held by democratic principle.

Both countries have common feature, that is leaders have most influence in their parties. In Korea, leaders are mostly Conservative in 1990s, but leaders have changed and became younger in 2000s. Unfortunately, these two countries while democratic consolidation they lost attention in gender inequality.

In 6th Republic State of Korea, first 3 elections outcomes show that women members decreased. During 1948-1972, there were up to 5 woman members in National Assembly. Totally 25 women members from direct election out of 72 women members in National Assembly during 1948-2004. During these time women representatives were 2.5%.

The constitution of the 6th Republic states of Korea stipulates single-member constituencies and includes a provision for proportional representation for about 20%-25% of the National Assembly. This effect on increase women representatives number. Since using provision for proportional representation, party leaders don't want to put women members in above the list.

Gender researchers always emphasize that proportional representative system is most convenient women political participation. Based on research in 23 Democratic countries, Wilma Rule concluded main lever of increase women's participation in politics, is their election system. (Bryson.2003,77) In some countries in their proportional representation system 1 in 2 must be women.

10 countries have most women representatives in legislature in the world, 8 of them have proportional election system, 2 of them have mixed system.

But countries have no women representatives in their legislature, they are all have majority election system. They are Jordan, Kuwait, Papua, Tonga, Tuvalu, Vanuatu.

In case of one mandate in majority election system, it's difficult to win woman. It showed in Mongolian election outcome case.

Since 1st January 2012, uses mixed Majority and Proportional representation in Mongolian Parliament election. Also there is quotation, not less than 20% candidates must women. Before 2012 parliament election, securing gender equality law implemented, it much infected outcome of election in 2012.

But in late 1990s, Mongolian parties' rules have women quota, such as Mongolian People's Party has 25%, Democratic Party has 30%, Civil Will Green Party has 50%.

Mongolian Parliament election uses following 3 types of system. Those are 1 mandate in constituency, multiple mandates in bigger constituency, Proportional and Majority mixed. Among all those three, most women representatives elected in mixed system. Since 1992, most women candidates in election 2012, 174 women candidates among 544 and 11 women became Member of Parliament. Also we have 3 women ministers in government.

In parliament candidate list of proportional in 2012, women are after 20 out of 26. In MPR (Mongolian People's Party) women are 10-23. In DP (Democratic Party) women are 7-

27. In CWGP (Civil Will Green Party) women are 1-26, Fair Justice Coalition 7-25. From those women candidates on the list, 7 women became member of Parliament. This proves that if women were above in the list more would be member.

Since 1948, Republic of Korea uses several methods in its election. They used also one mandate in constituency, multiple mandates in bigger constituency, proportional and majority mixed. In 2005 according to new law of election, multiple mandates in bigger constituency used in legislature, proportional representation used in local elections. Outcome of this, before 2.2% women were reached up to 15%. From them 75% were in the list.

Since 1990s, in order to have more votes, political parties promised securing gender equality, improve women's participation in politics. In 1998 major party and minority party both promised 30%-50% women quota in the list. But in local election quota doesn't apply well. In 2000, officially women quota appeared in local election. That is parties list must have 13% are must be women. After this law implemented women representatives became from 2.3% to 5.9%.

However quota law implemented, in common sense of lower the women perspective doesn't changed much in Korea. (Chang and Bae 2012,9)

High educated women still have difficulty in getting job. Even employed women are mostly left their job after their marriage.

In Korea politicians are mostly experienced in business or state administration organization. But women have not enough experience. Since 2004, public perspective dramatically changed and hence parties increase their women members. Major parties leaders became woman politicians.

On 12th March 2004, the Political Party Law of 2000 was reformed to include a quota for women. Article 31 of the law specifies that for the list PR elections, whereby 56 deputies are elected, political parties must include 50 % women on the lists. For the majority portion of the election, whereby 243 representatives are elected in one mandate constituency, political parties are recommended to include at least 30% of women candidates in their constituencies. (Lowe-Lee, Florence. 2006)

But according to law of local election 2002, stated that in city councils the women's representation must be 50%. Women and men must be placed alternately on candidate lists (zipper-system). Considers Voluntary Political Party Quota GNP (Grand National Party) supports quotas of 30% for women candidates. GNP supports quotas of 30 % for women candidates

Republic of Korean first woman organization, Korean National Council of Women have Founded in December 1959, the Council has launched initiatives over the past 4 decades to establish gender equality society. Collaborating with numerous women's organizations, they have been urging women to take part in and join forces for promoting women's progress, and creating a more humane and fair society for all. The Council's member pool, consisting of 42 organizations and 16 cooperatives (municipal · provincial women's cooperatives), is one of Korea's largest federations of women's associations (3 million members).

Following the successful struggle for democracy in the late 1980s, women's organizations began to focus on women's individual freedom, equality and human rights. Democratic society allowed women's organizations to become more professional and to diversify to reflect various strata, concerns and interests of women. Gender-specific issues, including equal opportunities and equal employment, rape and trafficking in women, and sex slavery during World War II, have come to dominate the agenda of women's organizations. Progressive women recognized the importance of cooperation for the advancement of women's issues and founded an umbrella organization called 'Korean Women's Association United', with 28 members nationwide in early 1987. More conservative groups were assembled under the umbrella of the aforementioned 'Korean National Council

of Women' after it had gained greater independence from government influence. The two organizations cooperate to pursue their goals, unlike many other civic groups and political parties in Korea that are frequently plagued by factionalism and an inability to work together.

By the second half of the 1990s, most women's groups no longer saw the state as an antagonist, and concluded that engagement in legislative politics is a suitable means of gaining influence on politics and policies. Since the local elections of 1995, women's groups have actively supported female politicians with financial contributions, manpower and education. The Kim Dae-jung administration (1998-2003) emphasized the relationship of state and civil society and consequently, prominent NGO-leaders joined his administration, either as ministers, high-ranking officials or as advisors.

Women's organizations influence government policies not only through well-qualified and trained activists but also undertake efforts to mobilize the general public for their causes, using diverse strategies such as lobbying, signature collections, demonstrations, and issue fighting. While women's organizations are relatively well organized, groups that could present opposition are less coordinated. Political parties are also in a weak position to oppose legislative changes in favor of women. They depend on a broad basis of voters and thus aim at appealing to as many voters as possible, including women. (Hermanns 2006,13)

Major women's organizations, including 'Korean Women's Association United', became incorporated in order to secure their formal legitimacy and gain access to state funds. Other civil groups, however, have declined government support to maintain their independence (most prominently one of the biggest NGOs 'People's Solidarity for Participatory Democracy'). Since there is only finite funding available, competition for government sponsorship erupted, leading to friction within the women's movement. Government support is also targeted at certain types of projects, steering activities in one direction, so that some groups have changed their focus in order to be able to access government funds. Critics also point out that institutionalisation brought a less democratic decision-making process and increased the 'oligarchy' of a few organizations in the movement.

In 1990, Mongolian democratic revolution obtains market economic system. This system helps women express themselves freely. Property relation changed much and hence nationwide company owned women have appeared. During this time many women rights organizations are founded and still actively working today.

Firstly their main goal was increase number of women in political decision-making level as well as in political parties. During this time they consider that culture, ethics, voterspsychology are not main problem but political structure is the biggest problem for women participation. Hence their main interest was on Mongolian political structure changes.

Based on those organizations' scope, influence on political decision-making process, they can be categorized as below.

1. Women organization under Political Party. (Social Democracy Mongolian Women's Union, Democratic woman union, Civil Will Women Organization, etc.)
2. Nationwide woman organization (Mongolian women organization, Monfemnet etc.)
3. Non-Government Organization have less influences on Political decision-making process

Before 1990s, women's issues are activity under Women's Committee of the Central Council. But after 1990s, Women's Committee of the Central Council separated as small individual organizations. Inspired case of Scandinavian countries women organizations, their closely cooperative activities incredibly helpful women to increase their number in political decision-making level.

Reform in 1990, is considered as new era of women political activity. Today reform brings us following main advantages.

1. Empowering influenced gaining women experience in politics, social life.
2. Women faced problems are able reach governance by help of women rights organizations.
3. Through women organization under parties, women can participate their parties activity and involve its decision-making level

Conclusion

In Democratic strengthening, one the main expressing indicator is women participation in political decision-making level. However Mongolian and Korean cultures are different but women involvements have similarity.

In those two countries cases show that, both considered women involvement in politics and voluntarily made quotation in proportional system since 1990s. And hence both countries increase their number of women members in legislature. But in proportional representation system, we need more attention on where women in the list.

Biography

OdgerelBatsaikhan. Ph,DCandidate of Political science in Mongolian National university. Lecturer of Otgontenger University. Research topic "Women's participation in Political decision-making"

References

- Tsetsegjargal, Ts. 2009. Mongolian Women in XX century: Evolution and changes. UB
- Enkhtsetseg, D. 2008. Mongolian secret history and women. UB.
- Bryson, Valerie. 2003. Feminist political theory: An introduction. NY.
- Dukjin Chang and Young Bae. 2012. "The birth of Social Election in South Korea, 2010-2012" *Fesmedia Asia series*. Friedrich ebertstiftung. (Chang and Bae 2012, 9)
- Hermanns Heike. 2006. "Women in South Korean politics: a long road to equality" *Portal journal of multidisciplinary international studies*. Vol 3, No 2 Downloaded <http://epress.lib.uts.edu.au/journals/index.php/portal/article/view/134>
- IPU. Women in national paliaments, [archive of statistical data](#)
- Lee, M. 1996. 'Women's Education, Work, and Marriage in Korea: Women's Lives Under Institutional Conflict', PhD dsis, University of California.
- Lowe-Lee, Florence. 2006. Korean women: you have come a long way www.keia.org/sites/default/files/publications/may%2006.pdf
- Mongolian National Election Commission, Elections results of Mongolian Great State khural. Accessed Jun.3 http://gec.gov.mn/parliamentary_election
- Mee-Hae Kong. 2007. "Rethinking Women's Status and Liberation in Korea". Inter Asia Civil Society archive. Downloaded Nov.8 http://interlocal.skhu.ac.kr/home/bbs/board.php?bo_table=books&wr_id=143&page=9
- Turtogtokh, J. "The 19th National Assembly election and post-election political changes in korea" *Politology* № (10) 388: 200-212

ЯПОН УЛСЫН УЛСТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТОЙМ СУДАЛГАА

Д.БУМДАРЬ

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, доктор

Key word: Улстөрийн үйл ажиллагаа, Япон улс, Либерал Ардчилсан нам, Сонгуулийн хууль, Намын санхүү

「日本の政治資金法の成立と過程」

要旨

本研究は、「日本の政治資金法の成立と過程」というテーマを中心として考察し比較した。日本の政治資金に関する法的装置は、1948年から始まっている。戦後日本の政治史の中で政治資金に関わる疑獄事件は多数あった。その都度、政治と金の問題が国民的な議論として巻き起こり、政治資金規正法等の改正がされている。

しかし、現実には完全に政治資金問題がなくなったと言えないが透明化されていると考える。

ここで、日本の政治資金法の成立と現在までの機能を考察し明確にした。

Япон улсад улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн асуудалд дэлхийн хоёрдугаар дайны дараа үеэс анхаарал хандуулж эхэлсэн байдаг.

Сонгуулийн компанит ажлын зардлын тайланг мэдүүлж байх журмыг 1946 оны 3 сард Япон улсын Дотоод явдлын яамнаас гаргаж мөрдөж эхэлсэн байна. Уг журамд нэр дэвшигчийн зарцуулах мөнгөний хэмжээнд сонгогчдын тооноос хамааруулан хязгаар тогтоосон байна. Мөн парламентын болон орон нутгийн сонгуульд оролцох улстөрийн намууд нь сонгуулийн товыг албан ёсоор зарласан өдрөөс хойш 7 хоногийн дотор сонгуулийн компанит ажилд зарцуулах мөнгөний дүн хэмжээгээ ил тод мэдээлэх үүрэгтэй байхаар журамласан байна.

Энэхүү журам нь сонгуульд зарцуулах мөнгөний хэмжээнд ямар нэг хязгаарлалт тогтоож, ил тод болгох талаар тодорхой ахиц дэвшил авч ирсэн гэж үздэг. Гэхдээ уг журам нь сонгуулийн компанит ажлын болон өдөр тутмын улстөрийн үйл ажиллагааны бодит зардал болон орлогыг хянах боломжгүй байсан зэрэг сул талуудтай байжээ.

Иймээс 1948 оны 7 сард “Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтэд хяналт тавих тухай” хуулийг шинээр батлан гаргасан байна. Энэ хуулиар улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн орлого болон сонгуулийн компанит ажилд зарцуулах мөнгөний хэмжээг ил тод мэдээлж байх үүргийг улстөрийн байгууллагуудад оноож, хуульчилж тогтоосон¹⁸⁹.

189

日本政治資金規正法、法令番号：昭和二十三年七月二十九日法律第百九十四号、衆議院ホームページ「制定法令」、参照。

Гэхдээ энэ хууль нь улстөрийн үйл ажиллагааны зардлыг ил тод болгоход түлхүү анхаараад, орлого хэрхэн бүрдүүлж байгаа байдалд хяналт тавьж чадаагүй зэрэг сул талууд байсан учраас “цоорхой хууль” хэмээн нэрлэгдэж, шүүмжлэлд ихээхэн өртөх болсон. Уг хуулийн сул тал нь гэвэл:

- Улстөрийн үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргасан эсэхийг хянаж, шалгах эрх үүргийг тодорхой заагаагүйгээс дээрх мэдүүлгийг хэрэг дээрээ цөөхөн байгууллага гаргаж өгдөг байсан.
- Хандивлагчийн нэр, хандивласан мөнгөний хэмжээ тодорхойгүй, энэ талын мэдээллийг тайланд тусгадаггүй байсан.
- Улстөрийн үйл ажиллагааны зардлын тайлан, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргах нэгдсэн стандарт загварыг боловсруулж мөрдүүлээгүйгээс шалтгаалан ирсэн мэдээллийг шинжлэх, харьцуулан авч үзэх боломжгүй байсан.
- Уг хуульд улстөрийн нам, эвсэл, холбоо, хөдөлгөөний статусыг ялгаж, зааглаагүйгээс улстөрийн бүх байгууллагыг “улстөрийн нам” хэмээн хавтгайруулан үзэхэд хүргэсэн (тухайн үед 4000 гаруй улстөрийн байгууллага бүртгэгдсэн байсан)
- Нам, эвсэл болон нэр дэвшигчийг төлөөлж, тэдний нэрийн өмнөөс улстөрийн үйл ажиллагаанд зарцуулах мөнгөний мэдүүлгийг гаргаж өгөх этгээдийн үүрэг, хариуцлага, төлөөлөх эрх статус тодорхойгүй байсан¹⁹⁰.

Ийм учир шалтгааны улмаас уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бодит шаардлага нэгэнт үүссэн ажээ. Гэвч уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар 1961-1967 онуудад гурван удаа хуулийн төсөл өргөн барьсан боловч парламентад дэмжлэг авалгүй явсаар 1975 оныг хүрсэн байдаг.

1975 онд “Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай”¹⁹¹ 1948 оны хуульд өөрчлөлт оруулж, шинэчлэн баталсан байна. Уг хуульд: зарчмын дараах асуудлуудыг шийдвэрлэсэн байна. Тухайлбал:

- Улстөрийн байгууллагууд үйл ажиллагааны болон санхүүжилтийн тайлан, мэдүүлгээ заавал гаргах үүргийг хуульчлан тогтоосон
- Санхүүжилтийн эх үүсвэр, орлого, зарлагыг нээлттэй, ил тод байлгахыг улстөрийн байгууллага, нэр дэвшигчдэд заавал биелүүлэх үүрэг болгон заасан.
- Төрөөс улстөрийн намуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх заалтыг шинээр оруулсан.

Ийнхүү хуульд өөрчлөлт оруулж, эрх зүйн орчинг боловсронгуй болгосны үр дүнд:

- Улстөрийн байгууллагуудын (нам, эвсэл, холбоо, хөдөлгөөн гэх мэт) статусын ялгааг нэг мөр тодорхой болгосон
- Улстөрийн байгууллагуудын санхүүжилтийн болон үйл ажиллагааны тайланг хуульд зааснаар тогтмол гаргаж мэдүүлдэг болсноор тэдгээр байгууллагын бодит байдал, үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой болсон
- Улстөрийн байгууллагын санхүүгийн орлого, зарлагын тайлан гаргах нэгдмэл стандартыг боловсруулж мөрдөх нөхцөл бүрдсэн

¹⁹⁰ 谷口 将紀『21世紀のガバナンスのあり方：日本の課題とアメリカの経験「政治と金」』ブルックンクス研究所、2001年、2頁。

¹⁹¹ 日本政治資金規正法 昭和50年法律第64号

政治資金規正法の一部を改正する法律、衆議院ホームページ「制定法令」、参照。

- Хэрвээ улстөрийн байгууллага 2 дахь удаагаа алдаатай, стандартын шаардлага хангахааргүй тайлан гаргаж өгсөн тохиолдолд үйл ажиллагаа

Хандив авагч Хандив өгөгч	Улстөрийн намын санхүүжилтийн сан	Нэр дэвшигч-улстөрч	Улстөрийн бусад байгууллагууд
Хувь хүн	Хувь хүмүүсээс авах нийт хандивын дээд хэмжээ, жилд 20.000.000JPY		Жилд авч болох хандивын дээд хэмжээ 10.000.000JPY
	Нэг хүний өгч болох хандивын хэмжээ заагаагүй	Нэг хувь хүн жилд 1.500.000JPY илүүгүй хандив өгч болох	Нэг хувь хүн жилд 1.500.000JPY илүүгүй хандив өгч болох
Бизнесийн байгууллага	Бизнесийн байгууллагуудаас авч болох нийт хандивын дээд хэмжээ, жилд 7.500.000JPY - 100.000.000JPY		Жилд авч болох хандивын дээд хэмжээ 3.750.000JPY - 50.000.000JPY
	Нэг байгууллагаас өгч болох хандивын хэмжээг заагаагүй	Нэг байгууллагаас жилд 1.500.000JPY илүүгүй хандив өгч болох	Нэг байгууллага жилд 1.500.000JPY илүүгүй хандив өгч болох
Орлогыг мэдүүлэх хэмжээ	10.000JPY дээших орлогыг ил тод мэдээлэх	1.000.000JPY дээших орлогыг ил тод мэдээлэх	1.000.000JPY дээших орлогыг ил тод мэдээлэх

явуулах эрхийг нь түдгэлзүүлэхээр хуульчилж, мөрдөн ажилласан нь тайлан мэдүүлэх явдлыг 90 хувь хүртэл нэмэгдүүлсэн 1975 оны шинэчлэн баталсан хуулийн нэг чухал заалт нь улстөрийн үйл ажиллагаанд зориулж хувь хүн, бизнесийн байгууллагаас өгөх хандивын дээд хэмжээнд хязгаарлалт тогтоож өгсөн явдал юм (Хүснэгт 1).

Хүснэгт 1.

Эх сурвалж:

国立国会図書館調査及び立法考査局政治議会調査室・課「政治資金規正関係年表」

国立国会図書館、2011年3月

Япон улсын Төв номын сан Хууль зүй, улстөрийн судалгааны хүрээлэн. 2011 оны судалгааны тайлан

1975 оны шинэчлэн баталсан хуульд 1 сая 500 мянган иен хандивласан хувь хүний нэр, хаяг зэрэг мэдээлэл нь ил тод байх ёстой гэж заасан. Түүнээс бага мөнгө хандивласан хүний нэр, хаягийг ил гаргахгүй байж болохоор байгаа. Тэгвэл 1 сая ч юм уу, 100 мянга ч юм уу иен хандивласан хэдэн ч хувь хүн байж болох бөгөөд үүнийг хянаж мэдэх боломжгүй болж байна.

Мөн нэг улстөрч – хувь хүн хандив цуглуулах хэдэн сантай байж болохыг уг хуульд тодорхой заагаагүй. Үүний зэрэгцээ дээрх хуулийн нэг сул тал нь улстөрийн үйл ажиллагааны санхүүжилт бүрдүүлэх (хандив цуглуулах) үйл явцад хяналт тавих боломжийг бүрдүүлж чадаагүй явдал юм.

1975 оны хуулийн ийм тодорхой бус байдал нь улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтэд хяналт тавих боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж, улмаар улстөрчид хувийн тоглолт хийх, авлигын ноцтой хэргүүд гарахад хүргэсэн. 1988 онд Recruit компанитай холбоотой гарсан авлигын хэрэг нь үүний нэг жишээ болно.

Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тунгалаг, цэвэр байдлыг хангахад чиглэсэн хууль эрх зүйн дорвитой шинэчлэл хийх шаардлага урган гарсан байдаг.

1994 онд улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн талаар томоохон шинэчлэл хийж, түүний дотор 1975 оны хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн баталжээ. Уг хуульд улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн цэвэр, тунгалаг байдлыг хангахад чиглэгдсэн чухал өөрчлөлтүүдийг оруулсан байдаг. Тухайлбал:

- Улстөрийн намын нэрийн өмнөөс нэр дэвшиж байгаа улстөрч хувь хүнд өөрт нь хандив өгөх явдлыг хориглож, зөвхөн намын санхүүжилтийн санд хандив өгөхийг зөвшөөрсөн
- Бие даан нэр дэвшигч нь хандив цуглуулах 1 сантай байх бөгөөд, зөвхөн уг сангаар дамжуулан хандив авч байхаар тогтоосон
- Нэг удаагийн арга хэмжээгээр 200.000JPY болон түүнээс дээш хандив цуглуулсан бол, мөн нэг хандивлагчаас өгсөн 50.000JPY буюу түүнээс дээш хандивыг тус тус ил тод мэдээлж байхаар заасан
- Хандив өгөх явдлыг аль болох улстөрийн намд чиглүүлэх зохицуулалт хийсэн.
- 50.000JPY-ээс дээш хандив өгсөн хувь хүн, байгууллагын нэр, хаягийг ил тод мэдээлж байх зэрэг өөрчлөлтүүдийг оруулсан байдаг. (Хүснэгт 2).

Хүснэгт 2

Хандив авагч Хандив өгөгч	Улстөрийн намын санхүүжилтийн сан	Бие даан нэр дэвшигчийн сан	Улстөрийн бусад байгууллагууд
Хувь хүн	Хувь хүмүүсээс авах нийт хандивын дээд хэмжээ, жилд 20.000.000JPY	Хувь хүмүүсээс авах нийт хандивын дээд хэмжээ, жилд 10.000.000JPY	
	Нэг хувь хүний өгч болох хандивын дээд хэмжээг заагаагүй	Нэг хувь хүний өгч болох хандивын дээд хэмжээ жилд 1.500.000JPY	
Бизнесийн байгууллага	Бизнесийн байгууллагуудаас авч болох нийт хандивын дээд хэмжээ, жилд 7.500.000JPY- 100.000.000JPY	Бизнесийн байгууллагуудаас авч болох хандивын нийт хэмжээ жилд 3.750.000JPY- 50.000.000JPY	Хандив өгөх, авахыг хориглосон
	Бизнесийн байгууллагаас өгч болох хандивын дээд хэмжээг заагаагүй	Нэг байгууллагаас жилд 500.000JPY	Хандив өгөх, авахыг хориглосон
Орлогыг мэдүүлэх хэмжээ	50.000JPY дээших орлогыг ил тод мэдээлэх	50.000JPY дээших орлогыг ил тод мэдээлэх	50.000JPY дээших орлогыг ил тод мэдээлэх

Эх сурвалж:

国立国会図書館調査及び立法考査局政治議会調査室・課「政治資金規正関係年表」

国立国会図書館、2011年3月

Япон улсын Төв номын сан Хууль зүй, улстөрийн судалгааны хүрээлэн. 2011 оны судалгааны тайлан

Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн талаар 1994 онд хийсэн шинэчлэлийн хүрээнд шийдвэрлэсэн нэг чухал асуудал нь улстөрийн намыг төрөөс санхүүжүүлэх тухай хууль батлагдсан явдал болно. Энэ хууль нь улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтэд “бохир” мөнгө орж ирэх явдлыг хаах, бизнесийн бүлэглэлээс улстөрд үзүүлэх нөлөөллийг хязгаарлах зорилготой юм.

Улстөрийн намыг төрөөс санхүүжүүлэх хуульд зааснаар, парламентад (сенат, төлөөлөгчдийн танхимын аль нэгэнд) 5-аас доошгүй суудал авсан, эсвэл улсын хэмжээний сүүлийн сонгуульд нийт сонгогчдын 2 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх болзол (босго)-ыг хангасан нөхцөлд тухайн намд хүн амын тооллогын албан ёсны дүнг харгалзан, нэг иргэнд 250 иенээр тооцон санхүүжилт өгдөг болсон¹⁹².

Сонгуулийн хуульд зааснаар, нэр дэвшигч сонгуулийн үеэр хууль зөрчсөн үйлдэл хийсэн бол сонгогчдын санал авч сонгогдсон ч түүнийг хүчингүйд тооцох бөгөөд сонгуультай холбоотой аливаа маргааныг сунжруулахгүйгээр 100 хоногт багтаан шуурхай шийдвэрлэдэг болсон.

1994 онд батлагдсан “Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай” хууль, түүнтэй холбогдуулан гаргасан бусад хууль тогтоомж нь одоогоор хүчин төгөлдөр үйлчилж байгаа юм. Гэхдээ 1999, 2005, 2006, 2007 онуудад уг хуульд зарим нэг нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг. Тухайлбал:

- 1999 онд оруулсан өөрчлөлтөөр бие даан нэр дэвшигчид бизнесийн байгууллагаас хандив өгөх явдлыг хориглосон,
- 2005 онд оруулсан өөрчлөлтөөр улстөрийн намын сан, мөн бие даан нэр дэвшигчийн сангаас бусад улстөрийн байгууллагууд хоорондоо жилд 50 сая иенээс хэтэрсэн хандив өгч авахыг хориглосон. Үүний зэрэгцээ улстөрийн үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой бүх хандивыг зөвхөн банкаар дамжуулж өгч авч байхаар хуульчилсан.
- 2006 онд гадаадын хөрөнгө оруулалттай бизнесийн байгууллагаас улстөрийн үйл ажиллагаанд зориулж хандив өгөх явдлыг хориглосон өөрчлөлт оруулсан¹⁹³.

1994 оны хуулийн нэг чухал заалт бол бизнесийн байгууллага, холбоодоос хандив өгөх заалтыг мөрдөх хугацааг 5 жилээр тогтоосон явдал байв. Хуулийн энэ заалтын хугацаа 1999 онд дуусаж, цаашид улстөрийн намуудад бизнесийн байгууллага, холбоодоос хандив өгдөг байх эсэх талаар парламент дээр хэлэлцүүлэг өрнөсөн. 2000 оны 1 сард уг заалтын үйлчлэх хугацааг сунгахгүй байхаар шийдвэрлэсэн бөгөөд ингэснээр улстөрийн намд бизнесийн байгууллага, холбоодоос хандив өгөх явдлыг зогсоосон.

2007 онд улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, бүх хандив, орлого, зарлагыг зөвхөн дансаар шилжүүлж байхаар тогтоосон. Мөн ажилтан, албан хаагчид, гэрээгээр ажиллагсдын цалин, ажлын хөлс, унаа, хоол ундны зардал гэх мэт хүнд зориулснаас бусад зардлын зарлагын албан баримтыг бүрдүүлэх, хадгалах шаардлага тавьсан.

¹⁹² 2012 оны төлөөлөгчдийн танхимын сонгуулийн дүнгээр улстөрийн намуудад нийт 35 тэрбум иенийн санхүүжилтийг хувиаралсан байна.

¹⁹³

国立国会図書館調査及び立法考査局政治議会調査室・課「政治資金規正関係年表」国立国会図書館、2011年、4 頁

2007 оны хуульд парламентын гишүүний санхүүжилтийн сангийн 1 иенээс дээших орлого, зарлагын бүх баримтыг бүрдүүлж байхаар хуульчлан заасан. Ийнхүү сүүлийн жилүүдэд улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хууль тодорхой, нарийн чанд болсон нь улстөрийн нам хэмээх ойлголтыг хууль, эрхзүйн хүрээнд илүү ойлгомжтой болгож өгч байна.

Япон улсад улстөрийн намын эрх зүйн байдлыг Улстөрийн намын тухай хууль (Political Party Law), Сонгуулийн тухай хууль (Public Office Election Law), Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хууль (Political Fund Control Law), Улстөрийн намыг төрөөс санхүүжүүлэх тухай хууль (Act on Granting of Juridical Personality to Political Party Receiving Political Party Grants) зэрэг хуулиудад тодорхойлсон байдаг.

Эдгээр эрх зүйн баримт бичигт зааснаар, улстөрийн идэвхитэй үйл ажиллагаа өрнүүлж, парламентад 5 буюу түүнээс дээш суудал авсан байх, эсвэл улсын хэмжээний сүүлийн сонгуульд нийт сонгогчдын 2 буюу түүнээс дээш хувийн санал авах явдал нь улстөрийн намын төлөвшилийн түвшинг илэрхийлэх гол шалгуур болж байна.

**Япон улсын улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн
хууль эрх зүй орчны төлөвшилтийн үйл явц**

он	Хууль эрх зүйн орчны өөрчлөлтийн агуулга
1946 он	Сонгуулийн компани ажлын санхүүгийн тайланг мэдүүлж байх журмыг Дотоод явдлын яам батлан мөрдүүлж ажиллаж эхэлсэн.
1948 он	Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хуулийг анхлан гаргасан. (GHQ-н захирамжийн дагуу)
1950 он	Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Тухайлбал, сонгуулийн компани ажилд зориулж өгөх хандивын хэмжээг тогтоож, түүнийг Сонгуулийн тухай хуульд давхар тусгаж өгсөн.
1961 он	Сонгуулийн хяналтын хорооны Анхдугаар хурлын тайланг авч хэлэлцээд дараах шийдвэрийг гаргасан. Үүнд : – Төрийн өмчит болон төрийн хөрөнгө оруулалттай бизнесийн байгууллагаас хандив өгөхийг хориглосон – Улсын төсвөөс татаас, зээл, эрдэм шинжилгээний тэтгэлэг авдаг бизнесийн байгууллага, хувь хүн хандив өгөхийг хориглосон – Энд нэрлэсэн 2 нөхцөлд буй орон нутгийн бизнесийн байгууллага хандив өгөхийг нэгэн адил хориглосон
1962 он	Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хууль, мөн Сонгуулийн тухай хуульд дараах нэмэлт өөрчлөлт оруулсан: – Сонгуулийн хуульд: Улсын төсвөөс болон орон нутгийн холбоодоос санхүүгийн дэмжлэг авдаг бизнесийн байгууллага, хувь хүн нь сонгуулийн үйл ажиллагаанд зориулж хандив өгөхийг хориглосон заалт оруулсан – Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хуульд: Орлого зарлагын тайланд санхүүгийн баримтыг заавал хавсаргаж байх заалт оруулсан – Мөн орлого, зарлагын тайланг хадгалах хугацааг 2 жил байсныг 3 жил болгож өөрчилсөн

1963 он	Сонгуулийн хяналтын хорооны 2-дугаар хурлын тайланг авч хэлэлцээд дараах шийдвэрийг гаргасан: – Сонгуулийн болон улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн санд хувь хүнээс хандив авахыг хориглосон – Мөн бизнесийн байгууллага, үйлдвэрчний эвлэл болон бусад холбоодоос хандив авахыг хориглосон
1967 он	Сонгуулийн хяналтын хорооны 5- дугаар хурлын тайланг авч хэлэлцээд: Намын санхүү нь хувь хүний хандив, намын өөрийн санхүүжилтээс бүрдэж байгаа нь улстөрд бохир мөнгө орох, авилгад өртөх нөхцөл үүсгэж болзошгүй байгааг харгалзан дараах саналыг парламентад өргөн барьсан байна. Үүнд : – Хувь хүн жилд 1 сая иен, бизнесийн байгууллага жилд 2 сая иен (улсын хөрөнгө оруулалттай байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд оролцдог гэрээт этгээд болон засгийн газраас санхүүжилт авч байгаа этгээд энэхүү хэмжээний 1/2) -ээс хэтрэхгүй хандив өгөх – Онцгой зэрэглэлийн бизнесийн байгууллага хандив өгөхийг хориглох – Хандивлагчийн нэр, хаяг нь тодорхой бус хандивыг хориглох – Орлого, зарлагын тайлан болон ил тод зарласан мэдүүлгийн зөрөө байхгүй байх <i>Жич: Парламент энэхүү саналыг 3 удаа авч хэлэлцсэн боловч батлагдаагүй.</i>
1970 он	Дээд Шүүхийн шийдвэр: Парламентын засаглалтай улс оронд ардчиллыг бэхжүүлж баталгаажуулахад улстөрийн нам оролцохгүй байх боломжгүй. Улстөрийн намыг эрүүл, зөвөөр төлөвшин хөгжихөд туслах нь бизнесийн байгууллагын нийгмийн гишүүнийхээ хувьд хийх ёстой зүйл юм. Үүний жишээ нь улстөрийн үйл ажиллагаанд хандив өгөх явдал бөгөөд хуулийн эсрэг үйлдэл биш хэмээн үзэж, бизнесийн байгууллагаас улстөрийн намд хандив өгөхийг зөвшөөрсөн.
1975 он	Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хуульд дараах нэмэлт өөрчлөлт оруулсан: – Хандивын дээд хэмжээнд хязгаар тавьсан (Хүснэгт 1) – Орлогын ил тод байдлыг хангах, түүнд тавих хяналтыг сайжруулах заалт оруулсан
1979 он	Улстөрчийн орлого, зарлагын тайлан мэдүүлэгт цэвэр улстөрийн үйл ажиллагаанд зориулж гаргасан зардал, мөн хувь хүний амьдрал ахуйд нь зарцуулагдсан санхүүгийн ялгааг нарийвчлан гаргах журам боловсруулж мөрдүүлсэн
1980 он	Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хуульд доорх өөрчлөлт оруулсан: – Сонгуулийн тогтолцооны төлөвлөгдөж байгаа өөрчлөлт болон улстөрийн намд төрөөс санхүүжилт олгох тухай хуулийн төсөлтэй уялдуулан, аливаа холбоодоос хандивыг зөвхөн улстөрийн намд өгөх заалт оруулсан

1992 он	Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хуульд хэд хэдэн нэмэлт өөрчлөлтийг оруулсан: – Хандив цуглуулах 1 удаагийн арга хэмжээний орлого 1.500.000JPY -нээс хэтрэхгүй байх, мөн 1.000.000JPY-нээс дээших хандивыг ил тод мэдээлж байх – Хуримталсан орлогыг зөвхөн улстөрийн үйл ажиллагаанд зарцуулах – Төрийн албан хаагч улстөрийн үйл ажиллагаанд зориулж хандив өгөхийг хориглох – Хуулийн хяналтыг улам чангатгах
1994 он	Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хуулийг шинэчилж хэд хэдэн нэмэлт шинэ өөрчлөлтийг оруулсан: – Хандивын дээд хязгаарыг тогтоосон (Хүснэгт 2) – Санхүүжилтийн санг хэрхэн байгуулах тухай журам баталсан. Энэхүү журамд: санг байгуулахад хууль бус бүлэглэл, мөн банк санхүүгийн байгууллага оролцохгүй байхаар заасан
1999 он	Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд : – Хувь улстөрчийн улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн санд бизнесийн байгууллага болон холбоодоос хандив өгөхийг хориглосон
2003 он	Японы Бизнесийн Холбооноос улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтэд зориулж хандив өгөх саналаа нийтэд илэрхийлж мэдээлсэн
2005 он	Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Тухайлбал: – Улстөрийн нам болон улстөрийн намын үйл ажиллагааны санхүүжилтийн сангаас бусад улстөрийн байгууллагууд, холбоод хоорондоо өгч, авах хандив жилд 50 сая иенээс хэтрэхгүй байх – Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн хандивыг зөвхөн банкны дансаар шилжүүлж байхаар хуульчлан заасан
2006 он	Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд: – Гадаадын хөрөнгө оруулалттай бизнесийн байгууллагаас улстөрийн үйл ажиллагаанд зориулж хандив авахыг хориглосон – Орлогын мэдүүлгийг нийтэд зарлах хугацааг тодорхой заасан
2007 он 7 сар	Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хуульд дараах нэмэлт өөрчлөлт хийсэн. – Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн сангийн ажиллагчдын зардлаас бусад орлого зарлагын тайлан баримтыг заавал хавсаргах – Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн сангийн нэр дээрх үл хөдөлгөх хөрөнгийн бүртгэлийг мэдээлж байх
2007 он 12 сар	Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай хуульд дахин нэмэлт өөрчлөлт оруулсан. Тухайлбал: – Парламентын гишүүний улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн

	сангийн ажиллагчдын зардлаас бусад 1 удаадаа 10.000JPY-нээс дээш зарлагын баримтыг тайланд заавал хавсаргах, хадгалах
	– Харин 1 удаадаа 10.000JPY-нээс доош зарлагын баримтыг бүрдүүлж хадгалах
	– Парламентын гишүүний улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн санд хяналтын хорооноос ээлжит хяналт шалгалт хийдэг байх
	– Улстөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн хянан шалгах хороог байгуулах г.м

Ашигласан ном зүй

藤田博昭『日本の政治と金』勁草書房サービスセンター、1980年

岩井奉信『「政治資金」の研究

利益誘導の日本的政治風土』日本経済新聞社、1990年

佐々木毅・吉田慎一・谷口将紀・山本修嗣『代議士と金

政治資金全国調査報告書』朝日新聞社、1999年

国立国会図書館調査及び立法考査局政治議会調査室・課「政治資金規正関係年表」国立国会図書館、2011年

谷口

将紀『21世紀のガバナンスのあり方：日本の課題とアメリカの経験「政治と金」』ブルッキングス研究所、2001年

政治資金制度研究会

編『わかりやすい政治資金規正法』ぎょうせい出版、2002年

国政情報センター『政治資金規正法違反事例集』国政情報センター、2012年

—————・政治資金制度研究会『政治資金規正法要覧

第4版』国政情報センター、2009年

選挙制度研究会 編『公職選挙法令集

平成24年版』第一法規、2012年

竹中 治堅『首相支配 日本の政治変貌』中央公論新社、2006年

佐藤 幸治 編『コンサイス法律学用語辞典』三省堂、2003年

ЯПОН УЛСЫН УЛС ТӨРИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЗАРИМ ТУЛГАМДСАН АСУУДАЛ

(Парламентийн 2013 оны сонгууль, түүний үр дүн)

日本政治の現状と課題

—参議院選挙における2013年体制の成立とその政治的意味—

要旨

MIURA Nobuyuki

Professor (Ph.D, Political Science)

Key words: *Шинзо Абэ, Либераль ардчилсан нам, Economic bubble, Governability, “Гацаа”*

今回の研究発表は、「日本政治の現状と課題」という話題のもとに日本の参議院選挙における2013年体制の成立とその政治的意味を中心として考察しています。本題は、自由民主党・公明党の与党が大幅に議席を増やし圧勝していることにおいています。その意味は、参院での過半数を回復し、1995年体制によって生み出された衆参の「ねじれ」を解消したことにあります。

また、アジア太平洋地域の安定と調和に貢献されるモンゴルならびにモンゴル国立大学とのさらなる交流が深まるとともに、「アジアの心臓」たるモンゴルと日本との友好関係がさらに堅固になることを指摘しています。

Алтан намрын энэ налгар сайханөдөр, бид бүхнийг халуун дотноор угтан авч байгаад миний бие хязгааргүй ихээр талархаж байна. МУИС-ийн хүндэт докторын цол өргөмжилөл хүртээсэн явдалд зүрх сэтгэлийн угаас баярласнаа илэрхийлье.

Миний бие МУИС, Кокушикан Их Сургуулийн хамтын ажиллагааны анхны Гэрээг үзэглэсэн билээ. Энэ 2 их сургуулийг найрсаг холбоотой байхыг хэнээс ч илүү хүсэж явдаг хүний хувьд, дээрх шагнал нь надад нэр төрийн хэрэг байлаа.

Юуны өмнө МУИС-ийн эрхэм хүндэт Ректор, энд хүрэлцэн ирсэн эрдэмтэн багш, профессорууд, оюутнууд Та бүхэнд гүн хүндэтгэл илэрхийлж, амрыг эрж мэндчилье. Маш их баярлалаа.

Мөн энд хуран цугларсан эрхэм хүндэт Та бүхэнд дамжуулж хэлэх нэгэн зүйлийг сэтгэл зүрхэндээ тээж ирсэн юм. 2011 оны 3 дугаар сарын 11-нд бараг 1000 жилд нэг тохиох тийм ховор газар хөдлөлт, урьд хожид болж байгаагүй асар том цунамид Япон улсын зүүн мужууд өртөн хэмжээлшгүй их гарз хохирол амссан хүнд, хэцүү цаг үед Монголын ард түмэн халуун сэтгэлийн гараа сунгаж бидэнд тусалсан билээ.

Та нөхдийн тусламж хахир хүйтэн улиралд гэнэтийн гамшигт нэрвэгдэн, аюулд өртсөн олон япон хүмүүст халуун дотно санагдаж, тэдэнд маргаашийн амьдралд нь итгэл төрүүлснийг бид мартах учиргүй.

Маш их гарз хохирол үзсэн миний төрөлх нутаг Мияаги мужийн “Дотно холбоо” нийгэмлэгийн тэргүүн миний бие, монголчууд та бүхэнд хүндэтгэлийн хамгийн дээд талархалаа илэрхийлж байгааг минь хүлээж авна уу!

Өнгөрсөн 7 дугаар сард Японы улс төрийн ирээдүйг тодорхойлох маш чухал үйл явдал болох парламентын дээд танхимын сонгууль болж өнгөрсөн. Үр дүнг нь хэлбэл, Либераль ардчилсан нам, Комето намын эвсэл нь энэхүү сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулсан. Тус эвсэл дээд танхимын суудлын талаас илүү хувийг авснаар 1995 оноос хойших хугацаанд парламентын 2 танхимд бий болоод байсан “гацаа”-г тайлж чадсан юм.

Дээд танхимын сонгуулийн дараа, “Ёми-Ури” сонины олон нийтийн санал асуулгад хамрагдсан хүмүүсийн 53 хувь нь “гацаа” тайлагдсан явдлыг “онц чухал” гэж, 24 хувь нь “сайн үйл явдал” гэж үнэлж хариулжээ. Үүний зэрэгцээ намын харьяалалгүй сонгогчдын 66 хувь нь “сөрөг хүчинд анхаарал татах, итгэл даах ямар нэгэн зүйл байсангүй гэж хариулсан нь энэ удаагийн сонгуулийн бас нэг онцлог байв.

Энэ сонгуулийн үр дүн нь: Японы эдийн засгийн оргил үе (Economic bubble) саарч, эдийн засаг нь дефляциас гарч чадахгүй байсан цаг үед, Абеномикс-ийг гол бодлогоо болгосон Шинзо Абегийн засгийн газарт сонгогчид өндөр итгэл хүлээлгэснийг харууллаа.

Үүний зэрэгцээ сөрөг хүчний намынхан, эдийн засаг, нийгмийн хүлээлт, сонгуулийн системийн онцлогт тохирсон сайн стратеги боловсруулж чадаагүй явдал нь ялагдлынх нь томоохон шалтгаан болсон гэж дүгнэж болох юм.

2 том намын засаглалын тогтолцоо ийнхүү унаснаар, Либераль ардчилсан намыг (эвслийг)сөрөн зогсох сөрөг хүчин одоогийн нөхцөлд бараг байхгүй болсон гэж хэлж болно. Энэ явдал нь, Японы улс төрд аварга том эх баригч нам төрж гарсныг илэрхийлнэ байна.

Дүгнэж хэлбэл, “нэг намын үнэмлэхүй байр суурь, олон намын тогтолцоо зэрэгцэн орших 2013 оны улс төрийн тогтолцоо” хэмээх шинэ нөхцөл байдал бий болсныг үзүүлж байна.

Өөрөөр хэлбэл, энэ нь “шийдвэр гаргаж чаддаггүй улс төр”-өөс салж, улс орны амин чухал асуудлыг цаг алдалгүй мэдэрч, шуурхай шийдэн “улс төрийн хувьд зогсолтгүй урагшилж чадах” засаглалыг (governability) хүсэн хүлээж байсан сонгогчдын санаа бодлын илэрхийлэл гэж хэлж болох юм.

Хүйтэн дайны төгсгөлтэй зэрэгцэх үеэс Япон улсад засгийн эрхийг Либераль ардчилсан нам 2013 оны сонгуулийг хүртэл дангаар барьж ирсэн билээ. Ингэснээр парламентын доод танхимд эрх баригч нам олонх болж байсан ч, дээд танхимд нь сөрөг хүчин олонх болсноор “гацаа”-ны байдалтай парламент бүрэлдэн тогтож байсан юм.

Үүнээс шалтгаалан Японы улс төрийн намууд хамтарсан засгийн газар байгуулахаас өөр арга замгүй болсон. Үүнийг 1995 оноос хойшхи Японы засаглалын тогтолцооноос харж болно. Үүний зэрэгцээ 2009 оны сонгуульд Ардчилсан нам ялж засгийн эрхэнд гарч ирснээр Японы улс төрд 2 том намын систем бий болсон юм.

Гэвч, Ардчилсан нам олон жижиг намаас бүрэлдэн тогтож байснаас улбаалж, улс төрийн намын хувьд бодлого, улс төрийн үйл ажиллагаа нь нэгдмэл байж чадаагүй. Энэ нь засгийн эрх барьж байх үедээ, төрийн аюулгүй байдал болон нийгмийн хамгааллын тогтолцооны шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлж чадаагүйн дээр төрийн үйл хэрэгт олон тооны алдаа, дутагдал гаргаснаар 2012 оны парламентын доод танхимын сонгуульд ялагдал хүлээж, засгийн эрх барих үүргээ хүлээлгэн өгөхөд хүрсэн билээ.

Английн улс төр судлаач Эдмонд Бак (Edmond-Back) “нам гэдэг нь, нэг үзэл санаа, дүрэм журам дор нэгдсэн бүлэг хүмүүсийн нэгдэл бөгөөд тэрхүү үзэл санаа, дүрэм журмыг үндсээ болгож, ард иргэдийнхээ болон үндэснийхээ эрх ашгийг хамгаалахын тулд хамтын хүчээ зориулах үүрэгтэй нэгдмэл бүлэг юм” хэмээн тодорхойлсон байдаг. Эрдэмтний энэ үгийг тэр чигээр нь жишээ болгохгүй ч, намын хувьд улс төрийн үзэл санаа (idea of politics) нь нэн чухал үндсэн “*дүрэм нь*” байдаг гэдгийг дахин дахин санах үүднээс энэ эшлэлийг авч байна.

Өнөөгийн Японы сонгуулийн тогтолцооны дагуу, намууд эвсэл болж сонгуульд оролцохгүй бол сонгогдох боломжгүй байгаа. Дараагийн сонгуульд засгийн эрх авахын тулд намууд улс төрийн зорилгоо тодорхой томъёолж, эвсэж орохоос өөр аргагүй байдалд хүрч байгаа билээ.

Засгийн эрх барих явдал солигдох магадлалтайг урьдчилан мэдэрч, засгийн эрх баригч намын хувьд үйл ажиллагаа эрчимжүүлэн, тод томруун болгож, хариуцлага хүлээх чадвараа дээшлүүлж чадсан улс төрийн намын дахин сэргэлтийн мөчлөгийн (цикл) дагуу энэ удаагийн парламентын дээд танхимын сонгуульд Либераль ардчилсан нам ялсан нь үүний илрэл юм.

2013 оны сонгуулийн сургамж нь: “*засгийн эрх баригч нам нь улс төрийн эмх замбраагүй байдлыг бий болгох бус, төрийн үйл хэргийг авч явах хариуцлагаа ухамсарлаж, харин сөрөг хүчин нь хүчтэй сөрөг хүчин байх үүргээ мэдэрч, намаа шинэчлэн боловсронгуй болгох шаардлагатай*” гэдгийг харууллаа.

Сонгогчдын итгэх илтгэл үлэмж өндөр байгаа энэ үед Абе ерөнхий сайдын хувьд, манлайлах чадвараа бүрэн дүүрэн хэрэгжүүлж ажиллах боломжтой байгаа. Харин Ерөнхий сайдын удирдлага дор эрх барьж буй нам нь нэгдсэн бодлогоор тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадах уу, үгүй юу гэдэг нь Абегийн 2 дахь засаглалд өгөх хамгийн чухал бөгөөд сүүлчийн үнэлгээ байх болно.

Энэ удаагийн сонгуулиар “гацаа”-ны нөхцөл байдал тайлагдсаны гол ач холбогдол, утга учирын талаар авч үзье.

“Гацаа”-ны нөхцөл байдал үгүй болсон нь засгийн эрх баригч намын хувьд өөрийн зөв зүйтэй гэсэн бодлогоо цаг алдалгүй хэрэгжүүлэх боломж олгох сайн талтай юм.

Удаан хугацааны туршид эдийн засаг нь зогсонги байдалд орж, парламент нь “гацаа”-ны байдалтай байсны улмаас ерөнхий сайд нь жил болгон солигддог улс төрийн амьдралд залхсан сонгогчдын гутралын үе дуусаж байгаа юм. Нөгөөтэйгүүр, эрх баригч нам ганцаар засаглах байдлаа тогтоосон нь зарим талаар сайнгүй боловч, сөрөг хүчинтэй тохиролцож байсан үетэй харьцуулбал төрийн үйл хэргийг явуулахад саадгүй

болсон гэж дүгнэж болно. Тэр утгаараа, энэ сонгууль нь Японы улс төрийг өөрчилж чадсан сонгууль юм.

Бодит амьдрал дээр, парламентын 2 танхимтай байгаа нөхцөлд, дээд доод танхим олон бүлэглэлээс бүрэлдэж, хоорондоо зөрүүтэй үзэл санаа, бодлого баримтлах нь тийм ч муу зүйл биш юм. Харин ч, нийгэмд оршин буй олон ургалч үзлийг дэлгэн тавьж, 2 танхимын бодлого нь хоорондоо зөрөлдсөнөөр төлөөллийн засаглал бүхий ардчилсан дэглэмийн жинхэнэ мөн чанар, шударга зарчмыг улам чангатгаж өгөх сайн талтай.

Олон улсын хэмжээнд авч үзсэн ч, 50 саяас дээш хүн амтай хөгжингүй улсуудын ихэнх нь парламентын 2 танхимтай байдаг. Тэдгээрийн олонхид нь 2 танхим өөр хоорондоо адилгүй эрх ашгийг дэлгэн тавих чадвартай байхуйц тогтолцоог бодлогоор бүрдүүлсэн байдаг.

Английн Lord-н танхим нь дээрх жишээнээс өөр байдаг ч, Америк болон Герман зэрэг улсуудын дээд танхим орон нутгийн төлөөллийг шингээж чадсан нь бодит зүйл юм.

Мөн нэмж хэлэхэд, доод танхим нь илүү эрх мэдэлтэй байдаг ба, 2 танхимын хооронд үзэл бодлын зөрүү гарсан үед түүнийг шийдвэрлэх арга механизмыг ч бас бодож төлөвлөсөн байдаг.

Энэ удаагийн дээд танхимын сонгууль нь, эрх баригч намд үл итгэх байдал, “гацаа” бүхий парламент, мөн ар араасаа цувран гарч байсан улс төрийн тогтворгүй байдалд сүүлчийн цэг тавьж чадсан бөгөөд, Японы төрийн уламжлалт тогтвортой байдлыг эргүүлэн авчрах боломжийг бүрдүүлсэн юм.

Эдийн засгийн хувьд дефляциас ангижрах, даяарчлалын үеийн эдийн засаг, мөнгөний бодлогыг тодорхойлох, гүйцэтгэх засаглал, төрийн албаны тогтолцоог өөрчлөх, эрүүл мэнд болон нийгэм, хүмүүнлэгийн салбарт шинэчлэл хийх зэрэг нэг чухал бөгөөд улс төрийн хариуцлагатай шийдвэр хүлээсэн асуудлууд уул овоо шиг хуримтлагдсаар байна.

Шийдвэр гаргаж чаддаггүй улс төрөөс түргэн салж байхын тулд, мөн доод танхимыг илүү эрх мэдэлтэй болгохын тулд =парламент болон улс төрийн намуудын тогтолцоонд шинэчлэл хийх шаардлагатай байна. “Гацаа”-ны нөхцөл байдал үүссэн ч улс төрийн бодлого хэрэгжиж байхуйц тийм шинэчлэл хүлээгдэж байна.

Бэрхшээлтэй олон асуудлууд байгаа хэдий ч, эрх баригч нам нь шинэчлэлийн бодлогоо хэрэгжүүлэхдээ итгэл төгс байж, улс төрийн манлайлах үйл ажиллагаандаа бодит ажил, бодит үр дүнг үндэс болгож ажиллах нь хамгийн чухал зүйл юм.

Эцэст нь, Ази номхон далайн бүс нутгийн тогтвортой байдал, энх тайвны төлөө Монгол улс, МУИС-тай харилцах харилцаагаа гүнзгийрүүлж, “Азийн зүрх” болсон Монгол, Япон хоёр орны найрсаг харилцаа улам батжин бэхжихийг зүрх сэтгэлийн угаас хүсэхийн хамт, хүндэтгэлийн энэхүү илтгэл ээ өндөрлөе. Та бүхэнд баярлаж байгаагаа дахин илэрхийлье.

ОРОСЫН ХОЛБООТ УЛСЫН УЛС ТӨРИЙН СИСТЕМ

Ё.ДОВЧИН

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, доктор

Орос нутаг дэвсгэрээрээ (17,08 сая км.кв.) дэлхийн хамгийн том улс бөгөөд Европын тэн хагасаас илүүг, Азийн хойд, зүүн хэсгийг хамран 11 цагийн бүсийг эзлэн оршдог өргөн уудам нутагтай. Эрдэс баялаг, эрчим хүч, ой, цэнгэг усны нөөцөөрөө дэлхийд тэргүүлнэ. Байгалийн хий, газрын тос, нүүрс, үнэт металлын баялаг нөөцтэй.

Хүн амаараа (143 сая) 9-рт ордог ч суурьшил нь сийрэг (1км.кв.-д 8.3 хүн). Хүн амын 81 хувь нь оросууд байдаг ч энэ улс 160 гаруй үндэстэн ястантай. Аж үйлдвэржиж, хотжсон учраас хүн амын ердөө тавны нэг нь хөдөө оршин суудаг. Хүн амын 99,4 хувь бичиг үсэгтэй, насанд хүрсэн хүн амын талаас илүү нь дээд боловсролтой. Дээр үеэс үнэн алдартны шашин шүтэж ирсэн. Орос европын оюуны соёл, шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр оруулж Толстой, Достоевский, Чайковский, Ломоносов, Попов, Циолковский зэрэг олон суутнууд төрж гарчээ.

Орос 1917 онд дэлхийд анхны социалист хувьсгал хийж ЗСБНХУ нэртэй аварга том гүрний цөм нь болж байв. Энэ улс 70 жилийн турш коммунист дэглэмийн төв, социалист орнуудыг хошуучлагч байж, дэлхийд ноёрхохын төлөө АНУ-тай өрсөлдөж иржээ. 1991 онд ЗХУ задарснаар Оросын Холбоот Улсыг тунхаглав. ОХУ 89 субъектээс бүрдэж, тэдгээрийн тоонд 49 муж, 21 бүгд найрамдах улс, 6 хязгаар, 10 өөртөө засах тойрог, 1 өөртөө засах муж, 2 холбооны хот орно. Оросын төвлөрсөн улсын түүх Киевийн Оросоос эхтэй. Оросын төрт ёсны 200 гаруй жилийн түүхийг (1237-1480) бас монголын үе (оросуудын бичдэгээр “монголо-татарское иго” – монгол- татарын талхидал) эзэлдэг. 1547 онд Догшин хэмээх Иван IY анх “Бүх Оросын царь (хаан)” хэмээн өөрийгөө зарласнаар хаант оросын (самодержавие) 370 жилийн түүх эхэлж 1917 онд Николай II хаан ширээнээс татгалзсанаар шувтарсан юм. Энэ үеэс Оросын бүгд найрамдах улсын түүх эхэлнэ.

ОХУ НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн, хүлээн зөвшөөрөгдсөн цөмийн зэвсэгтэй 5 улсын нэг, G-8, G-20-д багтдаг. Цэргийн төсвөөр дэлхийд гуравт, зэвсгийн худалдаагаар АНУ-ын дараа ордог. Дэлхийд анх сансарт хүн нисгэсэн гүрэн. ҮНБ-ээр дэлхийн 9 дэх эдийн засаг, нэг хүнд ногдох ҮНБ 13235 доллар. ТУХН, Шанхайн Хамтын ажиллагааны байгууллагын гишүүн.

ЗХУ задарсны дараа Орос улс эдийн засаг- улстөрийн гүнзгий өөрчлөлтийг эхлүүлсэн юм. Юуны өмнө төлөвлөгөөт төвлөрсөн эдийн засгаас зах зээлийн болон дэлхийн интеграцлагдсан эдийн засагт шилжсэн. Үүний тулд макро эдийн засгийг тогтворжуулах, хувьчлал явуулах хоёр том зорилт тулгарсан. Нэгдэх зорилт нь үйлдвэрлэл, хэрэглээ хоёрын хоорондын тэнцвэрийг сэргээхэд оршиж байв. Энэ нь

санхүү, мөнгөний хатуу сахилгыг шаардсан. Төсвийн зардлыг бууруулах, татварыг нэмэх, үнийн хяналтыг хөнгөвчлөх, улсын үйлдвэрийг ивээж хамгаалах бодлогоос татгалзах замаар ханш уналтын архаг үндсүүдийг арилгаж үндэсний мөнгийг бодит үнэ өртөг дээр нь буулгахад тогтворжуулалт чиглэж байв. Энэ бол эдийн засгийн үнэхээр хатуу бодлого байсан учраас муужруулан эмчлэх (Shock therapy) ч гэж нэрлэдэг. Ийм аргаар капитализмд түргэн шилжих үйл явц 1992 оны эхээр ерөнхийлөгч Елцины хүчин чармайлтаар эхэлжээ. Төрийн зардлыг танаж, үнийг чөлөөлж, татвар нэмснээр тогтворжуулах бодлого үйлдвэрлэгчдийг бүтээгдэхүүнээ нэмэгдүүлэх хөшүүрэг болж, улмаар үүнийг дагаж үнэ буурах учиртай байв. Гэвч санаснаар болсонгүй. Худалдан авах чадвар огцом доройтсон нь нийгэмд хүнд тусав. Хүмүүс өлсөж, банкны хадгаламж алга болж улмаар эдийн засаг уналтад оржээ. Төр засагтай холбоо сүлбээтэй пүүс компаниуд хөнгөлөлттэй зээл, бүтээгдэхүүний зөвшөөрөл олж авах замаар “амь зуух” болсон нь үйлдвэрлэлийг сайжруулахын төлөө явсан хэсгийн урам зоригийг мохоов. Хаа сайгүй муужруулж эмчлэх бодлогыг муужруулаад эмчилсэнгүй гэж шүүмжлэх болж улстөр тогтворгүй байдал нүүрлэв.

Тогтворжуулалтыг дагаж улсын үйлдвэрүүдийг хувьчлах кампани өрнөсөн нь муужруулан эмчлэхтэй харьцуулахад ядаж эхний үед олон түмний дэмжлэг хүлээсэн. Учир нь улсын үйлдвэрийн газруудыг хувьчлах нь төрийн ачааллыг хөнгөлж, зах зээлд өрсөлдөөнийг нээж, иргэд өмчлөх эрхтэй болно гэдгийг олонхи нь гадарлаж байв. Оросын иргэн бүр (10000 рублийн тэр үеийн ханшаар) ваучер хүлээн авч худалдан авах, борлуулах эрхтэй болсон ч тэд голдуу хувьчлагдсан үйлдвэрийн газруудын хувьцааг авахад зарцуулсан байна. 1994 он гэхэд нийт тараасан 148 сая ваучераас 140 сая нь хөрөнгийн бирж дээр арилжаалагдсан байжээ. 40 сая иргэн хувьцаа эзэмшигчид болсон. Гэвч компаниуд хувьцааны ашиг ч өгсөнгүй, хамтын зөвлөлийн хуралд ч оролцуулсангүй. Ийм нөхцөлд хувьцаа үнэ цэнээ алдав. Хувьчлалын дараагийн шатанд улсын үйлдвэрийн газруудын үлдсэн хувьцааг дуудлагаар бэлэн мөнгөөр худалджээ. Энэ нь олигархи хэмээн нэрлэгдсэн цөөн хэдэн хүн банктай хавсарч оросын хамгийн орлоготой салбар- газрын тос, байгалийн хий, металлургын компаниудын хувьцааны багцыг хянах болжээ. Олон хүн сайхь олигархийг луйварчид гэж үзэж байв. Тэд өөрсдийн асар их баялгаараа дамжуулан улстөрийн нөлөөгөө бэхжүүлжээ.

Цаасан дээр бол хувьчлал их амжилттай болжээ гэхээр байв. 1996 он гэхэд хувьчлагдсан үйлдвэрүүд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 90 хувийг үйлдвэрлэж, том, дунд зэргийн үйлдвэрийн газруудын гуравны хоёр хувь орчим нь хувьчлагдсан тоо гарчээ. Гэвч хэрэг дээрээ өмчлөх эрхийн шилжилтийн дүн тийм ч хөөрч баярлахаар байсангүй. Улсын өмчит үйлдвэрийн газрууд хуучин боссууд буюу номенклатурын гишүүдийн гарт очиж тэд үйлдвэрийн эзэд болов. Иймд үйлдвэрүүдийн менежмент огт өөрчлөгдсөнгүй. Үүний дээр хувьчлагдсан нэртэй олон үйлдвэрийн газар улсаар тэтгүүлдэг “зангаасаа” салж чадаагүй байжээ. Хувьчлалын кампанийн үеэр гэмт бүлэглэлүүд сүрдүүлэг, хүчирхийллийн замаар улсын үйлдвэрүүдийг хяналтдаа авч байсныг дурдах хэрэгтэй. Бэлэн мөнгө, үл хөдлөх хөрөнгийг тэрбумаар нь гадагш гаргаж, төр засгийн ажилтнуудын авилгал амьдралын өдөр тутмын хэм хэмжээ болоход хүрчээ.

Засгийн газар хөрөнгө оруулагчдыг дэмжих чадваргүй байв. Банкууд хувийн хадгаламжийг оросын компаниудад хөрөнгө оруулалт болгож дайчлах талаар олигтой хөдөлсөнгүй. Бэлэн мөнгөний дутагдлаас болж үйлдвэрийн газрууд цалингаа тавьж, татвараа төлж дийлэхгүй, өөр хоорондоо бартерын худалдаа хийх болжээ. Хувьчлал хэрэг дээрээ зах зээлийн эдийн засгийн институциональ бүтэц үүсэхээс өмнө явж өнгөрсөн байна. Зах зээлийн эдийн засгийн хууль эрх зүйн үндэс дөнгөж аажмаар бий

болж байх зуур эдийн засгийн ихээхэн хэсэг нь аль хэдийнээ хувьчлагдсан байжээ. Ийнхүү яаруу сандруу явуулсан хувьчлалын үр дагавар болж гэмт хэрэг, авилгал газар авч улстөр-бизнесийн мафийн бүлэглэлүүд дураар дургих нөхцөл бүрджээ. Цөөн хэсэг баяжиж, ихэнхи нь ажилгүй, орлогогүй, цалингүй, тэтгэвэргүйгээс амьжиргаа нь нэн хүнд байдалд орж хүн амын ихээхэн хэсэг Зөвлөлтийн үеэс хамаагүй ядуу зүдүү болжээ. 2004 он гэхэд хүн амын 20 хувь буюу 30 сая хүн ядуурчээ. Ажилгүйдэл 8 хувьд хүрсэн нь Зөвлөлтийн үед бараг бүгдээрээ хөдөлмөр эрхэлж байсан орны хувьд өндөр үзүүлэлт юм. Нийгмийн тэгш бус байдал улам нэмэгдсэн. Хүн амын эрүүл мэнд ноцтой доройтсон. 2003 онд Оросын Анагаах ухааны Академи хөдөлмөрийн насны эрэгтэйчүүдийн нас баралт 10 жилд 80 хувиар өссөнийг мэдээлсэн байна. Эрэгтэйчүүдийн дундаж наслалт 58, эмэгтэйчүүдийнх 72 байгааг эрэгтэйчүүдийн дунд архи, тамхины хэрэглээ өндөр гэдгээр тайлбарлажээ. Иймээс хүн ам зүйн хямрал үндэсний аюулгүй байдалд заналхийлэх төвшинд хүрснийг улстөрчид хүлээн зөвшөөрсөн байна.

Орост 1999 оноос мэдрэгдсэн эдийн засгийн сэргэлт эдийн засгийн бүтцийн реформтой холбоогүй байв. Харин аж үйлдвэрийн зарим салбар эрч хүчээ авч эхэлсэн нь үүнд голлон нөлөөлжээ. Газрын тосны үйлдвэрлэл хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүнээ огцом нэмэгдүүлээд зогсоогүй хөдөө аж ахуй, хүнсний салбарт хөрөнгө оруулж эдгээр салбаруудад сэргэлт ажиглагдав. Эдийн засгийн гүнзгий хямралын нөхцөлд бага ч атугай бэлэн мөнгөний урсгал олон талын ашигтай нөлөө үзүүлж, юуны өмнө үйлдвэрийн газрууд цалин, татвараа төлөх боломж нээгджээ. Татвар засгийн газарт цалин, тэтгэврээ тавихад тус дөхөм болж, үүний үр дүнд үйлдвэрийн газрууд үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх хэрэгцээ аажмаар өсч эхэлжээ. Энэ хандлага амьжиргаанд нөлөөлж 1998 оны санхүүгийн хямралаас хойш анх удаа ажилгүйдэл буурч, ядуучуудын тоо гуравны нэгээр багасчээ.

Ерөнхийлөгч Путин эдийн засгийн нааштай өөрчлөлтөд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн ч энэ нь тогтвортой, тэнцвэртэй хөгжилд хүрэхэд хангалтгүй байгааг анхааруулсан. Тэрбээр 10 жилд ҮНБ-ийг 2 дахин нэмэгдүүлэхийг уриалсан нь жил бүрийн эдийн засгийн дундаж өсөлтийг 7 хувь байлгахад төлөвлөжээ. Энэ зорилт руу алхам алхмаар дөхөж Оросын эдийн засаг олон улсын хэмжээнд 22-р байрнаас 11-д ахиж чаджээ. 2007 он гэхэд Оросын эдийн засаг 90-ээд оны уналтыг давж гарч чадсан байна. Нэг хүнд ногдох ҮНБ 2009 онд 14919 долларт хүрч оросууд дэлхийн 38 дахь баян улс болжээ. Энэ үед аж үйлдвэр 75, хөрөнгө оруулалт 125 хувиар өсч хөдөө аж ахуй, барилгын салбаруудын үйлдвэрлэл нэмэгдсэн байна. Нийгмийн хүрээнд ч зарим нааштай өөрчлөлтүүд гарчээ. Бодит орлого 2 дахин нэмэгдэж, сарын дундаж цалин 80-аас 640 долларт хүрсэн. Дунд анги 8 саяас 55 сая болж, ядуучууд 2000 онд 30 хувь байсан бол 2008 онд 14 хувь болж буурчээ.

Гэвч Орост эдийн засаг өсч байгаа ч ханш уналт давтагдаж, эдийн засаг нь түүхий эдэд тулгуурласан шинжтэй хэвээр ажээ. Шатахуун, эрчим хүчний салбаруудын гаалийн хураамж, татвар нь холбооны төсвийн орлогын бараг тэн хагасыг бүрдүүлж байна. Экспортын ихээхэн хэсгийг түүхий эд, бордоо эзэлж байна. Баян, ядуугийн хоорондын зай улам холдсоор байна. 2000-2007 онд баячуудын орлого ядуучуудынхаас 14 дахин их байснаа 17 дахин өсчээ. 2008-2009 оны санхүүгийн хямрал оросын эдийн засгийн өсөлтөд бас нөлөөлөв. Газрын тосны үнэ баррель нь \$140 –оос 40 доллар болж, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 16 хувиар, хөрөнгө оруулалт 15 хувиар тус тус буурсан үзүүлэлт гарчээ.

Гэвч 2010 оны эхээр эдийн засаг 7,5 хувиар өссөн нь дахин сэргэлт эхэлснийг харуулсан. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт дэлхийн хамгийн өндөр өсөлтүүдийн нэг болж, тэрбумтнуудын тоо хурдан нэмэгдэж, Москва олон тэрбумтантай хүн амаараа Нью-Йоркын өмнө гишгэх болжээ. 16 жилийн турш хэлэлцээр хийсний эцэст Орос Дэлхийн Худалдааны байгууллагын гишүүн болов. 2012 оны эхээр ханш уналтыг хамгийн бага 4,2- 3,7 хувь төвшинд барьж чадлаа.

Оросын эдийн засаг эрчимтэй хөгжих босгон дээр тулж ирээд байна гэж болох юм. Олон улсын Валютын сангийн тооцсоноор Оросын ҮНБ (нэрлэсэн) 2013 онд 168 хувиар өсч, 3,462,998 сая долларт хүрч Европын хоёрдахь том эдийн засаг (ҮНБ-хач) болохоор байна. Аж үйлдвэрийн гол салбарууд сэргэж, микроэлектроник, сансар, иргэний агаарын болон батлан хамгаалах салбарын үйлдвэрүүд хурдтай хөгжиж байна. Орос компьютерын программ хангамжийн үйлдвэрлэлээр Хятад, Энэтхэгийн дараа дэлхийд гуравт орж байна. Нисэх онгоцны үйлдвэр оросын аж үйлдвэрийн чухал салбаруудын нэг бөгөөд олон улсад өрсөлддөг байлдааны сөнөөгч онгоцуудаараа (МиГ-29, СУ-30) алдартай. Боинг, Аэробустай өрсөлдөх “Сухой Суперджет 100” шинэ төслүүдийг хэрэгжүүлж эхэлжээ. Энэ хүрээнд 2009 онд 95 шинэ онгоц, 141 нисдэг тэрэг үйлдвэрлэж нийлүүлсэн байна. Оросын батлан хамгаалах үйлдвэрлэлийн салбарт 3 сая орчим хүн ажиллаж бүх аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 20 хувь энэ салбарт оногддог. Орос Америкийн дараа дэлхийн хоёрдахь том зэвсэг экспортлогч орон. Зөвхөн агаараас хамгаалах систем үйлдвэрлэдэг Алмаз-Антей компанийн жилийн орлого 4 тэрбум долларт хүрдэг ажээ. Дэлхийн хамгийн томд тооцогдох оросын сансрын аж үйлдвэрийг 100 компани бүрдүүлж 250 мянган хүн тус салбарт ажилладаг байна. Цөмийн эрчим хүчний үйлдвэрийн компаниуд бэхжиж Энэтхэг, Хятадад үйлдвэрүүд худалдаж, саяхан Японы Тошибатай энэ чиглэлээр хамтран ажиллахаар гарын үсэг зуржээ. Хойд мөсөн далайн цаг агаар дулаарч байгаа үед энэ бүс нутгийн газрын тос, байгалийн хийн асар их нөөцийг алсдаа ашиглахаар төлөвлөж байгаагийн тэмдэг болгож 2007.8.2-нд Оросын хайгуулчид Арктикт далайн ёроолд Оросын далбааг хатгажээ.

Ийнхүү Оросын эдийн засгийн шилжилтийн уруудалт, өгсөлттэй зэрэгцэн улстөрийн шилжилтийн үйл явц нэгэн адил давшилт, ухралт хослуулан бартаат замыг туулж байна. Өмнөх үеийн эдийн засгийн тогтолцооны өв нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг байсан бол улстөрийн өв нь нэг намын систем, “намжсан” төр юм. Оросын ХХ зууны улстөрийн түүх бүхэлдээ коммунист оросын түүх бөгөөд Ленины үед “цэргийн коммунизм”, НЭП, Сталины” нэг хүнийг тахин шүтэх ёс”, Хрущевын “дулаарал”, Брежневийн “зогсонги байдал”, Горбачевын “перестройка”, Елцины “СССР-ын задрал” гэсэн онцлог үеүдээс бүрддэг гэж болох билээ. 1920-иод онд Сталин намын “ерөнхий шугам”-аас гажсан нэрийдлээр өөрийн өрсөлдөгчдийг тухайлбал, зүүнтний Троцкий, баруутны Бухарин, төвийн Зиновьев нарыг замаасаа “цэвэрлэж”, бүх эрх мэдлийг гартаа атгасан юм. Сталин Орос орныг аж үйлдвэржүүлж, хамтралжуулж, таван жилийн төлөвлөгөө нэвтрүүлж, Эх орны дайнд ялалт байгуулж чадсан. Гэвч энэ бүхний цаана улстөрийн тоталитар дэглэмийн хатуу чанга хяналт, хэлмэгдүүлэлт (“гулаг”) далдлагдаж байв.

1954 онд коммунист намын “генсек” (ерөнхий нарийн бичгийн дарга) болсон Хрущев Сталины үеийн нэг хүнийг тахин шүтэх ёсыг социализмын “гажуудал” хэмээн шүүмжилж, хэлмэгдүүллийн хор уршигийг илчилж, Хүйтэн дайны дэлхийд хийгээд зөвлөлтийн тоталитар дэглэмд дулаан уур амьсгалыг оруулж иржээ. Гэвч түүний явуулсан хэд хэдэн хувьсгалт кампаниуд төдийлөн амжилт олоогүй бөлгөө.

1964-1982 онуудад “генсек” Брежнев зөвлөлт нийгэмд бүх зүйл сайн сайхан байгаа мэтээр дүрслэхийг оролдож тэрс үзэлтнүүд, дэглэмийг шүүмжлэгчдийг баривчилж, улам бүр цэцэглэж буй авилгал, хар захыг хараагүй дүр үзүүлж байлаа. Нам, төрийн албан тушаалтнуудын бүрэлдэхүүнийг шинэчлэх ажил зогссон. Төлөвлөгөөт систем олон түмний идэвхийг дайчлахаа больж эдийн засаг уруудаж эхэлжээ. Гадаад бодлогодоо зөвлөлтийн загварыг сонирхдог Гуравдахь ертөнцийн зүсэн бүрийн дэглэмүүдийг дэмжиж байв. 1982-1985 оны хооронд ЗХУКН-ын “генсек”-үүд Брежнев, Андропов, Черненко нар ойр ойрхон нас барав.

ЗХУКН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын албыг 54 настай Михаил Горбачев хүлээн авав. Тэрбээр зөвлөлтийн эдийн засгийг зогсонги байдалд оруулсан гол буруутан бол хээл хахуульд идэгдсэн хүнд сурталт бюрократууд гэж үзэж, эхлээд тэднээс ангижрах арга замыг сүвэгчилсэн байна. Энэ ажлыг Төв Хорооноос эхэлж, үүнээс уламжлан “перестройка” бодлогоо зарласан юм. Өөрчлөн байгуулалт нь гласность (ил тод байдал), ардчиллах үйл явц, гадаад бодлогын шинэ сэтгэлгээ гэсэн гурван хэсгээс бүрдэж байлаа. Ил тод байдал хэвлэл мэдээллийн хэрэгслээр зөвлөлтийн өнгөрсөн, одоог чөлөөтэй шүүмжлэх үүд хаалгыг нээжээ. Ардчиллах үйл явц нь Горбачевын зарласан 2250 суудалтай ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийг шинээр бүрдүүлэх 1989 оны олон мандаттай сонгуулиар илэрч байв. Шинэ сэтгэлгээ нь капиталист Өрнөдтэй сөргөлдөхийг багасгах, Гуравдагч ертөнцийн дэглэмүүдийг ивээх, коммунист эвслийн орнуудыг “захирах”-ыг зогсоох бодлогод тусгалаа олсон. Гэвч өөрчлөн байгуулалт түүнийг санаачлагчийн төсөөлснөөс тэс өөр үр дүнд гэнэт хүргэсэн юм. Ил тод байдал социалист үзэл санаанд зөвлөлтийн хүмүүсийн итгэх итгэлийг бэхжүүлэхийн оронд коммунизмын түүхийг эмгэнэл болгож хувиргасан, ардчилал нь брежневийн үеийн “ялзарсан” бюрократуудыг зайлуулахын оронд Ленины “мэргэжлийн хувьсгалчдын нам”-ыг сүйрүүлсэн, шинэ сэтгэлгээ ЗСБНХУ-ыг капитализмтай үр ашигтай өрсөлддөг болгохын оронд Зөвлөлт гүрнийг тараахад хүргэжээ. 1990 –ээд онд намын хяналт салхинд хийсэх мэт алга болсон нь эдийн засгийн хямрал, үндсэрхэг үзлийн сэргэлтэд хүчтэй нөлөөлсөн нь бодитой юм. Үйлдвэрлэгчид төлөвлөгөөний байгууллагын тушаалыг сонсохоо болив. Түүхий эд, бараа таваар зальт аргаар олж хав дарсан нэгэн тэдгээрийг хар зах дээр наймаалахад намын захиргаадальт үгүй болсон учир ямар ч шийтгэл хүлээхгүй болжээ. Үйлдвэрийн газруудын хөрөнгийг идэж завших нь хай сайгүй болж, хахуульд автсан намын албан тушаалтнууд үнэт түүхий эд, эрдэс баялгийг гадагш валютаар зарж, Швейцарын банкинд мөнгөө хийдэг болов. Дэлгүүрийн лангуунаас бүх бараа алга болжээ. Энэ үед марксизм-ленинизмыг шүүмжлэх замаар үндсэрхэг үзэлтнүүд идэвхжиж бүгд найрамдах улсууд илүү бие даасан байдлыг шаардах боллоо. Дээд Зөвлөлийн сонгууль үндэсний асуудлыг улам хурцатгав. ЗХУ задрах ноцтой аюул нүүрлэв.

Энэ үед Елцин Оросын үндэсний тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөн өрнүүлж эхэлжээ. Тэрбээр 1987 онд Улстөрийн Товчооны гишүүдтэй санал зөрөлдснөөс УТТ-оос огцорч Барилгын орлогч сайд болж албан тушаал буужээ. 1989 оны Ардын депутатуудын Их хурлын сонгууль Елцинд улстөрд дахин гарч ирэх бололцоог нээж өгсөн байна. Елцин ардчилал, зах зээлийн уриан дор мөрийн хөтөлбөрөө дэвшүүлж Москвагийн тойргийн сонгогчдын 90 хувийн санал авчээ. 1991 оны 6 –р сард Елцин ОХУ-ын ардчилсан сонгуулиар сонгогдсон анхны ерөнхийлөгч болов. Бүгд найрамдах улсууд ЗХУ-ын бүрэлдэхүүнээс гарч болзошгүй нөхцөл бүрдсэн, Елцины хүчтэй сөрөг хүч гарч ирсэн үед Горбачев дэглэмийг бүхэлд нь авч үлдэхийг чармайж байлаа. Гэвч яг энэ цаг мөчид дээд тушаалын хуучинсаг үзэлтнүүд Горбачевыг гэрийн хорионд оруулж төрийн эргэлт хийхийг оролдов. Елцин улстөрийн энэ боломжийг алдалгүй “Цагаан байшин”-гийн өмнө төрийн эргэлтийг эсэргүүцэн жагссан олон мянган

москвачуудын цуглаан дээр хүрэлцэн очиж хуйвалдааныг эрс няцааж байгаагаа мэдэгдсэн нь түүнийг Оросын шинэ лидер болоход ихээхэн түлхэц өгсөн гэдэг. Төрийн эргэлт амжилтгүй болж, Елцин Балтийн улсуудын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, ЗХУКН-ыг хоригложээ. Горбачевыг 8-р сард Москвад эргэж ирэхэд коммунист намыг хамгаалаад нэмэргүй нь нэгэнт тодорхой болсон байлаа. 12-р сард Орос, Украин, Белорусын удирдагчид СССР-ын оронд шинэ Тусгаар Улсуудын холбоо байгуулснаа зарлав. 1991.12.26-нд Горбачев Зөвлөлт улсын 75 жилийн түүхэнд цэг тавьж ЗХУ-ын удирдагчаас огцорлоо.

Елцин ЗСБНХУ-ыг хадгалж үлдэхийг санаархсан Горбачевын талынхны эсрэг тэмцэхдээ 1990 онд байгуулагдсан Ардын депутатуудын Их хурлын дэмжлэгт түшиглэж байв. Тус их хурал Орост бий болсон онцгой нөхцөл байдалтай холбогдуулж Елцинд жилийн хугацаатай “онц”эрх” олгожээ. Энэ эрхээ тэрбээр юуны өмнө “шок терапи” бодлогоо хэрэгжүүлэхдээ ашигласан юм. Гэвч нийгэмд дургүйцэл хүчтэй болж улмаар Их хурлын депутатуудын ихэнхийг Елцины эсрэг эргүүлэв. Энэ үеэс “Үндсэн хуулийнхямрал” гэж нэрлэгдсэн үйл явц эхэлсэн байна. Елцин, Их хурал хоорондын зөрчил өдрөөс өдөрт хурцдаж 1993 оны зуны турш бие даасан “хоёр засаглал” бий болж эсрэг тэсрэг хууль, зарлигууд гаргав. Москва дахь засаглалын замбараагүй байдлыг далимдуулан Холбооны субъектууд илүү их өөртөө засах эрх шаардах болж, урьдын ЗХУ –ын адил задрах аюул тулгарах нөхцөл байдал үүссэн. Энэ бүхнийг тооцон үзээд Елцин Их хурлыг тараах шийдвэр гаргав. Их хурал Елцины засаглалыг хүчингүйд тооцож, Оросын шинэ удирдагчаар Руцкойг зарлажээ. Их хурлыг дэмжигч талынхан төв телевиз, хотын даргын байрыг эзлэв. Елцин цэрэг зэвсгийн хүчээр үймээн самууныг дарж, мөргөлдөөнд 150 гаруй хүн амь үрэгдсэн байна.

Их хурал тарсан нь Елцинд шинэ Үндсэн хууль баталж хэрэгжүүлэх боломж олгожээ. Оросын Үндсэн хууль бусад ардчилсан хуулиудын нэг адил төрийн эрх мэдлийг гурван салаа мөчирт хуваарилсан, 2 танхимт парламенттай, гэхдээ ерөнхийлөгчд илүү эрх мэдэл өгсөн байлаа. 1993 онд Төрийн Думын анхны сонгууль болж, түүний дүн оросууд өмнөх 2 жилийн муужруулан эмчлэх эдийн засгийн шинэтгэлээс залхсныг нотлов. Засгаас илт дэмжсэн боловч Гайдарины (эдийн засгийн шинэтгэлийг гардан хэрэгжүүлэгч) нам дөнгөж 15 хувийн санал авч өрнөдийн загварыг эсэргүүцдэг Жириновскийн Либерал ардчилсан нам 23 хувь, Зюганов толгойлсон Оросын коммунист нам 12 хувийн санал авч, үлдсэн санал 5 хувийн босго арайхийж давсан Яблоко мэтийн жижиг намуудад хуваагджээ.

Шинэ сонгууль, Үндсэн хуулийн аль аль нь эдийн засгийн хямралыг шийдвэрлэж чадаагүй ч Үндсэн хууль Москва болон холбооны бусад бүс нутгийн засгийн газруудын хооронд зарим нааштай харилцааг бий болгоход нөлөөлсөн. Елцин 50 бүс нутгуудын амбан захирагч нартай хоёр талын гэрээ байгуулсны дотор газрын тосоор баян Татарстан, алмаз олборлогч Саха багтаж байв. Чеченийн босогчдыг дарахаар цэрэг илгээж, уг дайны хөлд олон мянган жирийн иргэд ам үрэгдэв.

Эдийн засаг, иргэдийн амьжиргаа уруудсаар байсан үед 1995 онд 43 нам оролцсон парламентын сонгууль болж сонгогчид дахин либерал бус хүчнүүдэд саналаа өгчээ. Дараа жил Зөвлөлтийн дараахь Оросын ерөнхийлөгчийн анхны сонгууль зарлагдахад санал асуулгаар Елциныг дөнгөж 6 хувь, Зюгановыг 25 хувь дэмжихээр дүн гарч байв.

Елцин хэдийгээр эрүүл мэнд нь тааруу байсан ч сонгуулийн сурталчилгааг эрчимтэй эхэлж, цалин тэтгэврийг тавьж, орон даяар энд тэндгүй явж олон хүнтэй

уулзаж рок бүжиг хүртэл хийж үзүүлэв. Елцинг ОУВ сан, мөн олигархууд санхүүжүүлээ. Хэрэв коммунист Зюганов гарвал хувьчлагдсан компаниудыг дахин улсын болгохоос тэд эмээж байв. Сонгуулийн эхний шатанд Елцин 35, Зюганов 32 хувийн санал авав. Сонгогчид хоёр өрсөлдөгчөөс дараагийн шатанд сонголт хийх хэрэгтэй болсон. Олигархууд сонгууль бол эрх чөлөө, тоталитаризм хоёроос нэгийг нь сонгох шийдвэр байх болно хэмээн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тасралтгүй сурталчилгаа явуулж байсан бол Зюганов Өрнөдийг шүүмжилж, Елцин Орос орныг сүйрүүлснийг буруутгаж, СССР-ийг дахин сэргээхийг уриалав. Сонгуулийн дүн гарч саналын 54:40 харьцаатай Елцин ялав.

Тэрбээр хэдийгээр сонгуульд ялсан ч хүчирхэг сөрөг хүчин түүний дэглэмийг үргэлжлүүлэн эсэргүүцээр байлаа. Зюгановын нам муужруулж эмчлэх бодлогоор оросын ард түмний эсрэг “геноцид” хийсэн, Чечений дайн үндсэн хууль зөрчсөн үндэслэлээр Елцины эсрэг импичмент зарласан нь ерөнхийлөгч ба парламентын хооронд ноцтой зөрчил үүсгэв. Елцин зах зээлийн шинэтгэлдээ шинэ эрч хүч өгөхийн тулд засгийн газрын тэргүүнийг 18 сарын дотор 4 удаа солив. Хамгийн сүүлд 46 настай Владимир Путиныг ерөнхий сайдаар томилж Елцин түүнийг өөрийн “залгамжлагч”-аар зарлан 2000 оны ерөнхийлөгчийн сонгуульд дэмжихийг уриалав. Ийнхүү Оросын төрийн өндөрлөгт Путин-Медведевын үе эхлэв.

Путин ерөнхий сайдын албыг хүлээн авах агшинд Оросын нутагт террорист халдлагууд тасрахгүй байв. Путин үүнд Чеченийн босогчдыг буруутгаж “дээрэмчдийг” бүрмөсөн устгахыг амлаж Чеченийн хоёрдахь дайныг эхлүүлэв. Оросын цэргүүд 2000 оны 2-р сард нийслэл Грозныйг эзлэн авснаар урьдын адил олон мянган хүн амийг авч одсон дайн дуусчээ. Энэ дайн Путиныг байр сууриа бэхжүүлэхэд нааштай нөлөөлжээ.

Кремлийн стратегичид Путины ерөнхийлөгчийн сонгуульд улстөрийн гол “унаа”-г эртнээс сойж, эхний ээлжинд парламентын сонгуульд орон даяар төрийн албан хаагчдыг нэгтгэж оролцуулах зорилгоор “Эв нэгдэл” (хожим Нэгдсэн Орос нам болсон) хөдөлгөөнийг үүсгэв. Думын сонгуульд Путины төлөө “Эв нэгдэл” 23 хувийн санал авч чадсан нь түүнийг сонгогчид дэмжиж байгааг харуулав. Олны түмний дунд Путин, түүний бодлогын нэр хүнд аажмаар дээшилж байсан нь улстөрийг амар тайван орхих итгэлийг Елцинд төрүүлж, тэрбээр 1999 онд шинэ жилийн босгон дээр ерөнхийлөгчийн албан тушаалаа хугацаанаас өмнө хүлээлгэн өгч байгаагаа зарласан нь гэнэтийн үйл явдал болсон билээ. 2000.3.26-нд товлөгдсөн Оросын ерөнхийлөгчийн сонгууль хүртэл Путин Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэхээр боллоо. Ерөнхийлөгчийн сонгуульд 11 нэр дэвшигч өрсөлдөж Путин 53,4 хувийн саналаар ялалт байгуулжээ. Путины бодлого, үйл ажил нь улс орныг хөгжүүлэх, нийгмийн өмнө тулгарсан асуудлуудыг шийдвэрлэж чадна гэсэн хүмүүсийн итгэлийг сэргээсэн юм. Засгийн эрхэнд ирснээс хойш түүний рейтинг байнга 70-80 хувьтай байсан нь үүнийг нотолно. 2004 оны сонгуулийн дараа явуулсан үндэсний хэмжээний судалгаагаар эрх мэдлийг Путины гарт өгөх нь Орост хэрэгтэй гэдгийг 68 хувь нь зөвшөөрчээ. Иймээс Путин Оросын улстөр-эдийн засгийн шилжилтийн эгзэгтэй үед ерөнхийлөгчийн эрх мэдлийг чадамгай ашигласан гэж хэлэх үндэстэй юм.

Оросын улстөрийн шинэ тогтолцоо хэдийгээр ерөнхийлөгч, парламентын засаглалын элементүүдийг хослуулсан байдаг ч Ерөнхийлөгчид илүү өргөн эрх мэдэл өгсөн байна. Ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар 4 жилийн хугацаатай сонгоно (бүрэн эрхийн хугацаа – 2 удаа). Үндсэн хуульд хэдийгээр ерөнхийлөгчийг гүйцэтгэх засаглалын тэргүүн гэж заагаагүй боловч хэрэг дээрээ ерөнхий сайд, засгийн газрын гишүүдийг томилохоос гадна *хуулийн хүчинтэй ерөнхийлөгчийн зарлиг* гаргах эрхтэй.

Ерөнхий сайдын толгойлсон засгийн газар юуны өмнө эдийн засаг, нийгмийн бодлогыг хариуцна. Ерөнхийлөгч сайдууд, “хүчний яамд”-ыг шууд хянаж байдаг. Ерөнхийлөгчийн алба гадаад, дотоод хүрээнд ерөнхий бодлогыг тодорхойлж, засгийн газар түүнийг хэрэгжүүлэх санал, заавар журмыг боловсруулна. Практик дээр засгийн газар парламентын гэхээсээ *ерөнхийлөгчийн өмнө* хариуцлага хүлээнэ. Засгийн газрын гол түшиг тулгуур нь парламент дахь нам, эвсэл гэхээсээ ерөнхийлөгч байдаг ажээ. Гэхдээ парламент нь гүйцэтгэх засаглалын тухайд зарим эрх эдэлнэ. Аливаа хуулийн төслийг хууль болгоход түүний зөвшөөрөл хэрэгтэй. Төрийн Дум ерөнхийлөгчийн санал болгосон Ерөнхий сайдыг батална. Хэрэв Дум номинацийг батлахаас 3 удаа татгалзвал Ерөнхийлөгч Думыг тарааж шинэ сонгууль зарлах ёстой. Мөн Дум засгийн газарт итгэл эс үзүүлж болно. Хэрэв итгэл эс үзүүлэх санал 2 удаа давтагдвал ерөнхийлөгч Думыг тараана, эсвэл Засгийн газрыг огцруулна. Үүнээс гадна ерөнхийлөгч “төрийн тэргүүн”, “үндсэн хуулийн баталгаа”, “зэвсэгт хүчний ерөнхий командлагч” зэрэг олон эрх эдэлж, ерөнхийлөгчийн том засаг захиргааг удирдана. Энэ алба холбооны засгийн газрыг хянаж, бүс нутгийн засгийн газруудыг “анхааралтай ажиглаж” байдаг. Мөн засаг захиргаа, парламент, шүүх, том бизнес, хэвлэл мэдээлэл, улстөрийн намууд, сонирхлын бүлгүүдтэй холбоо харилцаа барьж байдаг. Ерөнхийлөгч олон зөвлөл, комиссыг толгойлж хянана. Тухайлбал, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийг даргална. Түүнчлэн бүс нутгуудын захирагчдаас бүрддэг Төрийн зөвлөл ерөнхийлөгчийн чухал байгууллага юм.

Оросын Засгийн газрын бүтэц парламент дахь намуудын бүрэлдэхүүнээс шууд хамаардаггүй. Бодит байдал дээр Дум дахь намуудын хүчний хуваарилалт, засгийн газрын улстөрийн тэнцвэр хоёрын хоорондын харилцаа их сул гэсэн үг. Засгийн газрын бараг бүх гишүүд намын улстөрчид гэхээсээ аж ахуй, захиргааны удирдах хүмүүс байх нь олонтаа. Эл институци ерөнхийдөө намын засгийн газар биш, харин гол төлөв хувийн үнэнч байдал, мэргэжил, мэдлэг, ур чадвар, гол фракцуудын хүчний харьцаа зэргийг тооцсон ерөнхийлөгчийн “бүтээл” байдаг. 2004 оны төрийн захиргааны шинэтгэлийн дараа Кабинет 15 яам, 3 улсын хорооноос бүрдэх болсон. Тэдгээр нь цаанаа хэдэн арван хороо, агентлагуудыг хянах үүрэгтэй. Энэ шинэтгэлийн зорилго нь олон сайдын оронд өргөн чиг үүрэг бүхий цөөн тооны сайдтай бүтэц бий болгоход чиглэгдсэн ажээ.

Оросын парламент буюу Холбооны хурал нь хоёр танхимаас бүрдэнэ. Доод танхим- Төрийн Дум мажоритари ба пропорционал системийг хослуулдаг. Дээд танхим-Холбооны Зөвлөл холбооны 89 субъектыг тэгш төлөөлдөг. Төрийн Думд намын фракцууд үүрэгтэй байдаг бол Холбооны зөвлөл намын бүлгүүд байгуулахаас зайлсхийнэ.

Холбооны Зөвлөлийн мэдлийн бодлогын зэрэглэлтэй зарим асуудлаас бусад хууль тогтоомж Думээс эх үүсвэртэй байна. Төрийн Думыг “нэвтэрсэн” төслийг Холбооны зөвлөлд хянуулахаар өргөн барина. Холбооны зөвлөл эсвэл батална, эсвэл татгалзана. Хэрэв татгалзвал саналын зөрүүг арилгахаар хоёр танхимын төлөөлөгчдөөс бүрдсэн хэлэлцэх комисс байгуулахыг уриална. Хэрэв Дум дээд танхимын өөрчлөлтийг хүлээн авахаас татгалзвал Холбооны зөвлөлийн гуравны хоёрын саналаар хүчингүй болгож хуулийг шууд ерөнхийлөгчд илгээнэ. Хууль парламентаар баталагдвал ерөнхийлөгч гарын үсэг зурна. Хэрэв гарын үсэг зурахаас татгалзвал Думд эргүүлж явуулна. Дум ерөнхийлөгчийн нэмэлт засварыг ердийн олонхоор батална, эсвэл ерөнхийлөгчийн хоригийг гуравны хоёрын саналаар хүчингүй болгоно. Дараа нь Холбооны зөвлөл ерөнхийлөгчийн нэмэлт засварыг хүлээж авсан бол ердийн олонхоор баталж, хүлээж аваагүй бол гуравны хоёрын саналаар хүчингүй болгоно. Дум цөөн

тохиолдолд ерөнхийлөгчийн хorigийг хүчингүй болгодог. Харин Холбооны зөвлөлийн татгалзсан заалтуудыг хүчингүй болгох нь байнга давтагддаг.

Думын 450 суудлын 225 нь нэг мандаттай тойргоос (SMD) харьцангуй олонхийн (FPTP) саналаар, 225 нь намын нэрсийн жагсаалтаар (PR) сонгогдоно. 5 хувийн санал авсан нам Думд суудал авах боломжтой болно. 2004 онд ерөнхийлөгч Путин сонгуулийн реформ хийж нэг мандаттай тойргуудын оронд бүх 450 депутатыг намын жагсаалтаар сонгодог болжээ. Депутатууд намын фракцад нэгдэж болно, эсвэл өөрсдийн бүлгийг байгуулж болно. Думын фракци, бүлгүүд Байнгын хороодын дарга нарыг сонгох, хэлэлцүүлэгт саналаа хүлээн зөвшөөрүүлэх зэрэг эрхтэй. Фракцын ахлагч нар Думын удирдах байгууллага- Думын зөвлөлд орно. Путины Нэгдсэн Орос нам Думын суудлын гуравны хоёрыг бүрдүүлж, нэг мандаттай тойргоос сонгогдсон депутатуудын 80 хувь нь энэ намын фракцид нэгдэж, Байнгын хороодын бүх дарга нар, Думын зөвлөлийн 11 гишүүний 8 нь Нэгдсэн Орос намаас байжээ. Энэ нам санал хураалтад хатуу сахилга барьж парламентын олонхи ерөнхийлөгчийн төслийг байнга дэмждэг байна. Депутат бүр 29 байнгын хорооны аль нэгд хамаарагдаж, хуулийн төслийг Думд өргөн барихаас өмнө холбогдох Байнгын хороо хэлэлцэж санал зөвлөмж боловсруулна.

Холбооны Зөвлөл холбооны нэгж бүрийн 2 төлөөлөгчөөс бүрдэнэ. Холбооны Зөвлөл хууль батлахаас гадна Дээд шүүх, Үндсэн хуулийн шүүхэд ерөнхийлөгчийн нэр дэвшүүлсэн хүмүүсийг батална. Дайны байдал болон онц байдал зарласан ерөнхийлөгчийн зарлигууд, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хил хязгаарыг өөрчилсөн тухай актуудыг батална. Мөн татвар, төсөв, гааль, санхүүгийн бодлого, гэрээ, дайн зарлахтай холбоотой хууль тогтоомжыг нягталж үзнэ. Хоёр төлөөлөгч 2000 он хүртэл холбооны субъектүүдийн гүйцэтгэх ба хууль тогтоох хурлын тэргүүнүүд байсан бол ерөнхийлөгч Путины өөрчилснөөр Холбооны зөвлөлд байнга суух төлөөлөгчдийг холбооны нэгжийн захирагч, хууль тогтоох хурал нэр дэвшүүлдэг болжээ. Тэд төлөөлөгчдийг хэзээ ч эгүүлэн татаж болно.

Елцины үед ерөнхийлөгч ба парламентын хоорондын харилцаа хурц зөрчилтэй байсан. Думд Елцины бодлогыг эсэргүүцсэн коммунист нам болон бусад хэт зүүний хүчнүүд зонхилж байв. 1999, 2003 оны Думын сонгуулиар Ерөнхийлөгч Путиныг дэмждэг намууд олонхи болсноор түүнд ажиллах таатай нөхцөл бүрдэж, бодлогоо дэмжүүлэхийн тулд Думтэй тохиролцох гэж цаг хүч их зарах шаардлагагүй болсон байна. Ийнхүү Путины үед улстөрийн тогтолцооны эрх мэдлийн харьцаа парламентаас аажмаар ерөнхийлөгчд шилжиж байна гэж болно. Оросын хувьд төв засгийн газар ба бүс нутгуудын хоорондын харилцаа улстөр- үндэсний эмзэг асуудал байсаар ирсэн. Путин ерөнхийлөгч болмогц Чеченийн салан тусгаарлах оролдлогыг таслан зогсоох, Холбооны зөвлөлд реформ хийх, үндэс угсаатны жижиг бүс нутгийг том нутаг дэвсгэрийн нэгжтэй нийлүүлэх, ерөнхийлөгч амбан захирагчдыг томилох, огцруулах эрхтэй байх, “холбооны дүүргүүдэд” (ийм дүүрэг 7 байгаа) ерөнхийлөгчийн тусгай төлөөлөгчийг томилох зэрэг цуврал арга хэмжээнүүдийг авсан байна.

Улстөр-эдийн засгийн өөрчлөлт оросын нийгмийн ашиг сонирхолд хүчтэй нөлөөлөв. Коммунист намын хяналт алга болсноор үй олон албан бус олон нийтийн эвсэл холбоодын давлагаа нийгмийг нөмөрсөн байна. Сталины үеийн хэлмэгдэгсдийг дурсах бүлэг, хаант ёсыг сэргээх хэт үндсэрхэг үзэлтнүүд, бүгд найрамдах улсууд дахь үндэсний хөдөлгөөнүүд гээд зүсэн бүрийн эвсэл холбоод бий болжээ. Төрийн өмчийн ноёрхол задарснаар зах зээлийн эдийн засагтай холбоо бүхий шинэ ашиг сонирхлууд үүссэн бөгөөд төрөөс тэдгээрт улстөрийн талаар нөлөөлөх бололцоо нэгэнт байхгүй

болсон. Янз бүрийн ашиг сонирхлыг төлөөлсөн бүлгүүд сайн дураар байгуулагдаж улстөрийн засаглалд нөлөөлөх, нөөц баялгаас хүртэхийн төлөө өрсөлдөх болов. 2001 он гэхэд Орост 300,000 төрийн бус, ашгийн бус байгууллагууд бүртгүүлсэн бөгөөд тэдгээрээс 70,000 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ажээ. 2 сая гаруй хүн эдгээр байгууллагуудад идэвхтэн, ажилтнаар ажиллаж хүн амын 12-13 хувь тэдгээрээс ямар нэг хэлбэрээр туслалцаа авсан байна. Ашиг сонирхлын бүлгүүд төртэй янз бүрийн арга, сувгаар харилцаж байна. Зарим байгууллагууд шинэ дэглэмд зохицож төрийн “дотор” орж ажиллахыг эрмэлзэж байхад нөгөө хэсэг нь олон нийтийн анхаарал, дэмжлэгийг татах замаар хууль тогтоох, гүйцэтгэх засаглалд гаднаас нөлөөлөхийг зорьж байна. Оросын сонирхлын бүлгүүдийн зохион байгуулалтын хэв маяг нь корпоратив гэхээсээ плурал шинж зонхилдог ажээ. Сонирхлын бүлгүүд том байгууллагын шүхэр дор орох нь тэр байгууллага түүний өмнөөс дуугарах учраас түүнийг нь төр тухайн ашиг сонирхлын албан ёсны дуу хоолой гэж хүлээн авахаас болгоомжилдог байна.

Намууд ашиг сонирхлыг хэрхэн нэгтгэж, сонгогчдын сонголтыг тодорхойлж, улстөрчдөөс хариуцлага асууж байгаа нь ардчилалд шийдвэрлэх ач холбогдолтой нь тодорхой. Улстөрийн ардчилалд шилжээд багагүй хугацаа өнгөрсөн ч Оросын намын систем олигтой зүгшрээгүй гэж үздэг. Парламентын сонгуулийн өрсөлдөөний үеэр намууд дотор ийш тийш хөрвөх нь ихэсдэг. Улстөрчид сонгуулийн дараа хаяж орхиж явахын тулд л шинэ нам байгуулдаг мэт жишиг тогтжээ. Сонгогчид аль намыг талархах нь багасаж, ямар нэг үзэл суртал гэхээсээ тухайн улстөрчтэй холбоотой байхыг чухалд үздэг болов. Думд депутатууд улстөрийн үйл ажиллагаагаа намын фракцуудтай холбодог боловч тэдгээр намуудын ихэнхи нь нийгэмд бараг хөлгүй байдаг ажээ. Оросын намууд программын зорилтуудаа биелүүлэхийн төлөө дэмжигчдээ дайчлахын оронд “ачийг ачаар хариулах” харилцаанд тулгуурлах нь элбэг байна.

Ардчилсан шинэтгэлийн талынхан ба коммунизмыг хамгаалагчдын хоорондын тэмцэл 90-ээд оны дундуур намын систем бүрэлдэхэд нөлөөлжээ. Зарим нам өөрийгөө ардчилсан хөдөлгөөнтэй адилтгаж байхад нөгөө нь марксист-ленинист үзэл сурталд үнэнч хэвээр үлдсэн. Гэтэл гуравдахь намууд оросын национализмыг тугаа болгосон байх жишээтэй. Энэхүү ардчилсан, коммунист, үндэсний үзлийн гурван хандлага эдүгээ ч оросын улстөрийн намуудын солонгорсон олон өнгө дотор тод ажиглагддаг байна. Дурдсан үед үзэл суртлын халз мөргөлдөөн суларч, түүний оронд албан ёсны хүчтэй ивээн тэтгэгчтэй патронаж намууд байгуулахыг хичээх болжээ. Ийм намыг “засаглагч нам” гэнэ. Төрийн албан хаагчид ч, сонгогчид ч эрх баригчдын ач тусыг хүртэж, тэдний эрх мэдлийг хүлээн зөвшөөрдөг. Сонгогчдын хувьд ийм нам залгамж холбоо, тогтвортой байдлын дүр төрх болдог. Харин албан тушаалтнуудын хувьд тушаал дэвших арга хэрэгсэл болдог.

Парламентын сонгууль бүр улстөрийн намууд байгуулагдах шинэ давлагаа үүсгэдэг. Харин ерөнхийлөгчийн сонгууль бол өөр. Оросын ерөнхийлөгчийн тогтолцоо ерөнхийлөгчийг намуудад ая тал засах шаардлагагүй болгодог бөгөөд ерөнхийлөгчийн сонгуулийн явцад улстөрийн мөрийн хөтөлбөрөөс илүүтэй нэр дэвшигчдэд бие хүнийх нь хувьд анхаарал төвлөрүүлэх хандлага зонхилж байдаг. Өөрөөр хэлбэл хүчтэй ерөнхийлөгчийн засаглал ерөнхийлөгчид өөрийн үзэмжээр засгийн газраа бүрдүүлэх эрх өгдөг учраас сонгуулийн амжилт улстөрийн бодлого болж хувирна гэж намууд бардам амлах аргагүйд хүрдэг. Оросын хувьд Елцин, Путин хоёулаа намын харьяалалаас зайлсхийж, намуудын “зодоон”-оос аль болохоор зай барихыг илүүд үзэж ирсэн. Энэ нь бас намын хөгжилд нөлөөлсөн нь мэдээж. Парламентын сонгууль болох бүрт шинэ сонгуулийн кампани болгон намын шинэ сонголтуудыг толилуулдаг нь сонгогчдыг намын харьяалалтай байхад бэрхшээл учруулж, намуудын өнгөрсөн,

ирээдүйн талаар дүгнэлт хийх бололцоогүй болгодог байна. Иймд оросын намын системийн цаашдын төлөвшил төрийн засаглалын хэлбэртэй шууд уялдаатай нь илэрхий байна. Хэрэв цаашид оросын төрийн тогтолцоо европын ардчиллын загвараар өөрчлөгдвөөс ерөнхийлөгч засгийн газрыг байгуулахдаа парламент дахь улстөрийн хүчнүүдийн харьцааг харгалзан үзэх шаардлага тулгарах нь зайлшгүй билээ.

Посткоммунист Оросын ардчилсан шилжилт амаргүй, бартаат замаар явж байна. Энэ аварга том орны хувьд ийм байхаас ч аргагүй биз. Нэгдүгээрт, XX зуунд 75 жилийн туршид дэлхийн коммунизмын төв, өрнөдийн улстөр- үзэл суртал, цэрэг-эдийн засгийн гол өрсөлдөгч байсан; хоёрдугаарт, хэдийгээр ЗСБНХУ хэмээх том гүрний цөм нь байсан ч 1991 он хүртэл Орос дангаараа бие даасан үндэсний төр улс байгаагүй юм. Хаант Оросын үед олон үндэстний эзэнт гүрэн байсан, Зөвлөлтийн үед ч социалист бүгд найрамдах улсуудын холбоо байсан; гуравдугаарт, 1000 жилийн төрт ёсны түүхэнд нь газар нутаг, байгаль цаг уурын онцлогоосоо хамаараад дайчлах, төвлөрүүлэх уламжлал ноёрхож ирсэн; дөрөвдүгээрт, 1990 –ээд оны муужруулан эмчлэх шилжилтийн стратеги нийгэм, эдийн засагт нь хүнд цохилт болсон зэрэг хүчин зүйлстэй зарим талаар холбоотой болов уу. Хэдийгээр Оросын ардчиллыг янз бүрээр үнэлж дүгнэдэг ч хамгийн гол нь өрнөдийг сохроор хуулбарлах биш, түүний оронд оросын өөрийн гэсэн ардчиллын загварын эрэл хайгуулыг шаргуу хийж байгаа нь юуны өмнө нүдэнд тусдаг. Энэ явцад алдаа гажуудлыг тойроогүй боловч оросын ард түмэн улстөр- эдийн засгийн шинэ сонголтоосоо ямарч атугай буцаж ухралгүй урагшилж байна. Эдийн засаг нь сэргэж, ялангуяа аж үйлдвэрийн өсөлтийн хурдацаараа дэлхийд дээгүүр орох болов. Шинэ Оросын нийгмийг гуйвж дайвтал нь шавхуурдсаар байсан ядуурал буурч байна. Ашиг сонирхлын плюрал илэрхийлэл хүчээ авч, төрийн шинэ институци, олон намын систем, өрсөлдөөнт сонгууль, чөлөөт хэвлэл бодит зүйл болжээ. Гагцхүү дээр дурдсан хаант Оросын, коммунизмын Оросын улстөрийн өвийг өнөөгийн ардчилсан засаглалтай хэрхэн шүтэн барилдуулах вэ гэдэг л Оросын ардчиллын гол сорилт байх нь лавтай.

